

Монгол Улс

Монгол Улс
Аялал Жуулчлалын Тогтвортой
Хөгжлийн Талаарх Бодит Мэдээ
Мэдээлэл Тоо Баримтыг Цуглуулж,
Нөхцөл Байдлыг Нэгтгэн Дүгнэх
Судалгаа
Эцсийн тайлан

2021 он 10 дугаар сар

Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага
(ЖАЙКА)

Кинки Ниппон Турист Корпорейт Бизнес ХК
ТОО Зүүн Ази судлалын хүрээлэн
Күние ХК

3R
JR
21-006

**Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага
(ЖАЙКА)**

**Монгол Улсын Аялал Жуулчлалын
Тогтвортой Хөгжлийн Талаарх Бодит
Мэдээ Мэдээлэл Тоо Баримтыг Цуглуулж,
Нөхцөл Байдлыг Нэгтгэн Дүгнэх Судалгаа**

Эцсийн тайлан

2021 оны 10 дугаар сар

Кинки Ниппон Турист Корпорейт Бизнес ХК

ТОО Зүүн Ази судлалын хүрээлэн

Күние ХК

“Монгол Улсын Аялал Жуулчлалын Тогтвортой Хөгжлийн Талаарх Бодит Мэдээ Мэдээлэл, Тоо Баримтыг цуглуулж, Нөхцөл Байдлыг Нэгтгэн Дүгнэх Судалгаа”-ны талаарх өмнөтгөл

Судалгааны багийн ахлагч Такэнори Шимизү

(Япон Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд асан)

1. ЖАЙКА-аас хэрэгжүүлж буй аялал жуулчлалын салбарын хамтын ажиллагаа

Энэхүү судалгаа нь 1999 онд гүйцэтгэгдсэн "Монгол Улсын аялал жуулчлалыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө боловсруулах судалгаа"-наас хойш хийгдсэн аялал жуулчлалын талаарх анхны бүрэн хэмжээний судалгаа юм. 1999 оны судалгаагаар Японы талаас олон тодорхой санал зөвлөмж дэвшүүлсэн боловч харамсалтай нь Монголын Засгийн газрын удаа дараалсан бүтцийн шинэчлэлтээс үүдсэн аялал жуулчлалын салбарын хариуцах албаны өөрчлөлт, мөн санхүүгийн суурь эх үүсвэрийн асуудлыг шийдэж чадаагүй зэргээс өнөөг хүртэл ихэнх санал зөвлөмж хэрэгжээгүй байна. Гэсэн хэдий ч энэхүү судалгааны үзэл баримтлалыг өнөөг хүртэл Монголын аялал жуулчлалыг хөгжүүлэх сурах бичиг мэтээр ашиглаж байна. Улмаар 2016 онд хэрэгжиж дууссан "Монголын бүс нутгийн иж бүрэн хөгжлийн талаарх мэдээлэл цуглуулах, баталгаажуулах судалгаа"-нд Монгол дахь аялал жуулчлалын асуудал дурдагдсан хэдий ч, дан ганц аялал жуулчлалд чиглэсэн нарийвчилсан судалгааны хувьд 20 жилийн дараа хийгдэж буй нь энэ юм. Судалгааны нэр буюу сэдэвт "тогтвортой" гэдэг үг нэмэгдсэн байгаа нь энэ хутагаан дахь аялал жуулчлалын үзэл санал, баримтлалын хөгжлийг тусган харуулж байна гэж болно.

2. Япон улсаас ардчиллын дараах Монгол улсад үзүүлсэн тусламж дэмжлэг, мөн аялал жуулчлалын салбарт үзүүлэх дэмжлэгийн ач холбогдол

Монгол улс 1990 онд ардчилсан нийгэмд шилжсэнээс хойш Япон Улсын Засгийн газар дэд бүтэц, хүний нөөц (ялангуяа боловсролын салбар), төсөв санхүүгийн дэмжлэг зэрэг бүхий л салбар чиглэлээр Монгол улсын хөгжлийг дэмжиж ирсэн. Сүүлийн жилүүдэд шинэ олон улсын нисэх онгоцны буудал, АШУҮИС-ийн Монгол Японы эмнэлэг, дунд сургуулийн барилга зэрэг дэд бүтцээс гадна Японд суралцах оюутан сурагчдад чиглэсэн буцалтгүй тусламж, мөн Ковид-19 цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн хүндрэлийг даван туулахад зориулсан хөнгөлөлттэй зээл зэрэг Монгол улсын нийгмийн бүх салбарт Япон улсын дэмжлэг хүрсээр байна. Монгол Улсын Засгийн газар аялал жуулчлалын салбарыг эдийн засгийн өсөлтийн гурван тулгуур салбарын нэг болгон тодорхойлсон нь дан ганц уул уурхайн бүтээгдэхүүний экспортод тулгуурлахын аюул эрсдэл, хязгаарлагдмал байдлыг ойлгосноос үүдэлтэй хэмээн үзэж байна. Аялал жуулчлал нь маш өргөн хүрээг хамардаг салбар тул ард түмэнд өндөр үр өгөөжтэй байх боломжтой бөгөөд ядуурлын түвшин өндөртэй Монгол орны хувьд аялал жуулчлалыг тэргүүлэх чухал салбараа болгох нь зүй ёсны хэрэг юм. Харамсалтай нь Ковид-19 цар тахлын улмаас Монгол улсад ирэх гадаад жуулчдын тооны бууралт нь дэлхийд хамгийн өндөр үзүүлэлттэй байгаа ба одооноос Ковид-19 цар тахлын дараах үеийн бэлтгэлээ хангах нь чухал юм.

2022 онд Япон, Монголын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ой тохионо. Хоёр улсын хоорондын харилцан зорчигчийн тоо Японоос Монгол руу зорчигчид 25 мянга орчим байхад Монголоос Япон руу зорчигчдын тоо 30 мянга гэсэн тэнцвэргүй байдалтай байна. Монгол улс япончуудыг гайхшруулахуйц аялал жуулчлалын олон сайхан нөөц баялагтай хэдий ч тэдгээр нь хараахан бүрэн танигдаж чадаагүй байна. Мөн гадаадын жуулчдыг хүлээн авах орчин нөхцөлийг сайжруулах шаардлагатай асуудлууд ч нэлээд бий. Энэхүү судалгааны тайлан нь Монголын аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэхэд өчүүхэн ч гэсэн хувь нэмэр оруулж, Япон улстай найрсаг харилцаат орон болох Монгол улсыг зорих Япон жуулчдын тоог нэмэгдүүлэхэд багахан ч гэсэн хувь нэмэр оруулна хэмээн найдаж байна.

3. Ковид-19 цар тахлын судалгаанд үзүүлсэн нөлөө

Ковид-19 цар тахлын улмаас Монгол улсад очиж бодит газар дээрх судалгааг хийж чадалгүй байсаар энэхүү судалгааг дуусгахаас өөр аргагүй байлаа. Аялал жуулчлалын цэг болох тухайн бүс нутгуудын сэтгэл татам, сонирхолтой талууд, мөн тулгамдсан асуудлуудыг гагцхүү тухайн газарт биеэр очиж үзэж танилцаж

байж оновчтой тодорхой илэрхийлэх боломжтой байгал, энэ удаа Монгол улсад очих боломжгүй байсан нь туйлын харамсалтай. Гэсэн хэдий ч миний бие хамгийн сүүлд 2019 онд Дорноговиос бусад судалгааны зорилгот бүс нутагт очоод ирсэн байсан, мөн дээр нь энэхүү судалгаанд хамрагдсан бүс нутгуудыг ягштал сайн мэдэх монгол мэргэжилтнүүдтэй хамтран ажилласнаар энэхүү тайлангаа эмхтгэж чадсан болно. Энэ завшааныг ашиглан судалгаанд оролцон дэмжсэн бүх хамтран ажиллагчдад талархал илэрхийлье.

4. Ковид-19 цар тахлын дараах үеийн Монголын үнэ цэнэ

- (1) Монгол бол дэлхийн бөмбөрцөг, амьд биетийн үүсэл гарал, хүн төрөлхтний ирээдүй гэх мэт хүмүүний гүн ухааны үндсэн сэдвүүдийн талаар эргэцүүлэн бодоход хамгаас тохиромжтой газар орон юм. Ковид-19 цар тахлын энэ цаг үе Монгол бол "Үлэг гүрвэлийн үеэс үргэлжлэх эрт галавын түүх", "Далайн түвшнээс дээш 1000 гаруй метрийн өндөрт орших эртний далай тэнгис, их тал газар", "360 хэм төгсгөлгүй үргэлжлэх тэнгэрийн түм буман одод", "Морин хуур, монгол гэр хэмээх дэлхийг байлдан дагуулсан үндэстний нүүдэлчин соёл" гэх мэтчилэн хүмүүний амь амьдралыг үзэх үзэл бодлыг хөндөх, өдөр тутмын амьдралаас ангид "ер бусын" зүйлсээр баялаг орон болохыг дахин надад ойлгуулсан юм. Ялангуяа Ковид-19 цар тахлын дараах эсвэл Ковид-19 цар тахлын энэ эрин үед, хүн төрөлхтөн нийгмийн шинэ дүр төрхийг эрэлхийлэн хайж буй өнөө цагт, дан ганц хэрэглээний үнэлэмжид тулгуурласан аялал жуулчлалаар тогтохгүй, "хүн төрөлхтөн хаанаас ирж хаашаа чиглэж байгаа талаар бодолхийлэх", "хүн болж төрсөн утга учир, өөрийн үнэ цэнийг эрэлхийлэх" ийм утга учир бүхий аяллыг мэдрэх боломжтой Монгол орны үнэ цэнэ хойшид илүү өсөн нэмэгдэж, үнэлэгдэх болно гэдэгт итгэлтэй байна.
- (2) Монгол дахь аялал жуулчлалыг үлэг гүрвэл, аугаа их байгаль, эртний түүх, нүүдэлчдийн соёл гэх мэт түлхүүр үгсээр нэгтгэн дүгнэж болох бөгөөд хотын амьдралаас залхаж ядарсан хүмүүсийн хувьд "баян бүрд" болохуйц аялал жуулчлалын бүс юм. Дэлхийн гарал үүслийн талаар таньж мэдэж, мэдрэх боломжтой Монголын аялалд залуу үеийнхэн ч явах нь зохистой. Хотын байшин барилгаас холдон үлэг гүрвэлийн чулуужсан малтлагын газрыг өөрийн нүдээр үзэн, малын сүү сааж, тэнгэрт гялтганах одод, тал дүүрэн алаглах уулын цэцэгсийг харан баясах зэргээр дамжуулан залуу үеийнхэнд дэлхий ертөнцийн сүр жавхланг мэдрүүлэх боломжтой газар бол Монгол гэж бодож байна. Дэлхийн орон орны хүүхдүүд эх дэлхийнхээ өгөөж ивээлийг харж мэдрэх боломжтой улс бол Монгол орон бус уу. Монгол улс бол дэлхий дахины "Эх Дэлхий Хүүхдийн Хотхон" болж болохуйц орон мөн. Энэ удаа бидний санал болгож буй үлэг гүрвэлийн музей байгуулах төсөлд энэ утга санаа, хүслийг ч агуулсан болно.

5. Монголд аялал жуулчлалыг хөгжүүлэхийн ач холбогдол

Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа 2050"-д "үндэсний нэгдмэл үнэт зүйл" буюу үндэсний бахархлыг бэхжүүлэх асуудлыг зорилгын тэргүүлэх асуудалд тавьсан. Аялал жуулчлал нь Монголын ард иргэдийн өөрийн эх орноор бахархах сэтгэлийг бэхжүүлэх бол харин гадаадын жуулчид Монголын гайхамшигт байгаль, нүүдэлчин соёлыг мэдэрснээр Монголын сэтгэл татам байдлыг дахин үнэлэх гэсэн ач холбогдолтой. Орос, Хятад гэсэн том гүрнүүдийн дунд хавчуулагдсан ердөө 3.4 сая хүн амтай Монгол улс дэлхий дахинд аялал жуулчлалаар дамжуулан үүд хаалгаа нээснээр, улсынхаа хил хязгаарыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэн өргөжүүлэх боломжтой бөгөөд энэ нь "Алсын хараа 2050" -ийн зорилгыг биелүүлэхэд ч чухал ач холбогдолтой юм. 2019 онд аялал жуулчлалын салбар ДНБ -ий 7.2 хувийг эзлэх хэмжээнд хүртэл хөгжсөн байна. Монгол улсын экспортын үнийн дүнгийн 83.69 хувь нь уул уурхайн бүтээгдэхүүнээс хамаардаг эдийн засгийн бүтэцтэй (2019 он). Монгол улсын Засгийн газар аялал жуулчлалыг үндэсний хөгжлийн гурван тулгуурын нэг болгосон нь эдийн засгийн энэхүү бүтцийг өөрчлөх өндөр хүсэл эрмэлзэлтэй байгаагийн илрэл гэж үзэж байна. Яваандаа уул уурхайн нөөц баялаг дуусах болно. Харин аялал жуулчлалын нөөц баялаг нь зохих ёсоор хадгалж хамгаалж чадвал тогтвортой байх боломжтой. Тийм ч учраас Монгол дахь аялал жуулчлалын салбарын үнэ цэнэ үүнд оршино.

6. Монгол улсын аялал жуулчлалын тулгамдсан асуудлууд

- (1) Монгол улсын Засгийн газар сүүлийн жилүүдэд аялал жуулчлалтай холбоотой дэд бүтцийг идэвхтэй хөгжүүлж байгаа боловч одоогоор гадаадын жуулчдын аюулгүй, амар тайван зорчих боломжтой бүс нутгууд хязгаарлагдмал байна. Монгол улсад улс төрийн нөхцөл байдлын улмаас төрийн албан хаагчид ажил үүргээ тогтвортой үргэлжлүүлэх нөхцөл хангагдаагүй байна. Мөн аялал жуулчлалын салбарыг харахад бие даасан аялал жуулчлалыг хариуцах төрийн байгууллага байдаггүй бөгөөд аялал

жуулчлал нь бусад яам, агентлагуудын нэг бүрэлдэхүүн хэсэг байсаар ирсэн. Хариуцах ажилтнуудын тоо ч маш цөөтэй. Аялал жуулчлалыг эдийн засгийн хөгжлийн гурван тулгуурын нэг болгон шийдсэн бол түүнд тохирсон тогтолцоо зайлшгүй шаардлагатай. Одоогийн байдлаар аялал жуулчлалтай холбоотой хууль тогтоомжийг шинэчлэх бэлтгэл ажил хийгдэж байгаа бөгөөд аялал жуулчлалын салбарын хөгжилд хувь нэмэр оруулах хэлбэрээр батлагдан хэрэгжинэ хэмээн найдаж байна.

- (2) Монгол улс хэдийгээр аялал жуулчлалын олон нөөц баялагтай ч, тэдгээрийн талаарх мэдээлэл нь дотооддоо төдийгүй гадаадын орнуудад хүрдэггүй. Тухайлбал, 17-р зууны өндөр гэгээн Занабазар бол анхны богд хутагт, агуу их уран бүтээлч байсан бөгөөд олон гайхамшигт бурхны дүр бүтээсэн. Францын дуудлага худалдаагаар түүний бүтээсэн 30 см орчим хэмжээтэй, хадгалалтын байдал тийм ч сайнгүй бүтээл л гэхэд 500 гаруй сая иенээр борлуулагдсан тухай сонсвол түүнийг сонирхох хүмүүс байх магадлалтай. Гэтэл Занабазарын музейн англи хэл дээрх цахим хуудаст Занабазарын нэг ч бүтээлийн зураг байдаггүй. Үндэсний бахархал болсон ийм үнэ цэнэт зүйлсийн талаар дэлхий дахинд илүү их мэдээлэл түгээх хэрэгтэй юм шиг санагдана. Энэ нь зөвхөн жуулчдыг татахаас гадна Монголын бахархлыг дэлхийд сурталчлахад шаардлагатай юм.
- (3) Хагуу хучилттай авто замын сүлжээний өргөтгөл болон өөрийн орны түүхэн дурсгалт газруудыг сонирхох сонирхол нэмэгдэж байгаатай холбостойгоор монголчуудын дотоодын аялал жуулчлалыг сонирхох хандлага нь Ковид-19 цар тахлын үед ч буураагүй бөгөөд цаашид ч хурдацтай хөгжих төлөвтэй байна. Гэвч жуулчдыг хүлээж авах талын орчин, нөхцөл байдал бүрэн тохижуулагдсан гэж хэлэхэд хэцүү. Тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалж буй байдал, бие засах газар, автомашины зогсоол, отоглох цэг бүрэн бүрдээгүй асуудал зэрэг нь аялал жуулчлалын тогтвортой хөгжилд садаа болох эрсдэл өндөр байгаа нь Хөвсгөл нуурын жишээгээр нотлогдсон. Зөвхөн жуулчдад зориулах зорилгоор төдийгүй ховор нандин үндэсний үнэт баялгаа хамгаалах үүднээс яаралтай арга хэмжээ авахгүй бол Ковид-19 цар тахлын дараа жуулчдын тоо нэмэгдэх төлөвтэй байгаагийн улмаас аялал жуулчлалын эмзэг нөөц баялаг сүйтгэгдэх вий гэсэн болгоомжлол төрж байна.
- (4) Монгол улсад тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар судалгаа хийж, санал дэвшүүлэхдээ бид Монгол улсын төр засгийн бодлого, чиглэлд нийцүүлэхэд ихээхэн анхаарал хандуулсан. Мөн Япон улсаас авч хэрэгжүүлэх гэж буй арга хэмжээ нь Монгол улсын АХБ болон бусад олон улсын байгууллага, хандивлагч орнуудтай хийж хэлэлцэж буй арга хэмжээтэй давхцаж, дэмий эрч хүчээ үрсэн ажил болохгүй байхыг чухалчлан анхаарсан. Төслийн зорилтот бүс нутаг, сэдвийг бид ийм утгаар шүүн нарийвчилсан гэдгийг онцлон хэлмээр байна. Энэхүү тайлан нь Монгол улсын аялал жуулчлалын тогтвортой хөгжилд ямар нэгэн байдлаар хувь нэмэр оруулахыг чин сэтгэлээсээ хүсэж байна.


Газрын зураг

Монгол улсын нутаг дэвсгэр



Эх сурвалж: Google Map

Судалгааны зорилтот бүс нутаг



Эх сурвалж: Судалгааны баг

Монгол Улсын Аялал Жуулчлалын Тогтвортой Хөгжлийн Талаарх Бодит Мэдээ
Мэдээлэл, Тоо Баримтыг Цуглуулж, Нөхцөл Байдлыг Нэгтгэн Дүгнэх
Судалгааны Эцсийн Тайлан

Гарчиг

“Монгол Улсын Аялал Жуулчлалын Тогтвортой Хөгжлийн Талаарх Бодит Мэдээ Мэдээлэл, Тоо Баримтыг цуглуулж, Нөхцөл Байдлыг Нэгтгэн Дүгнэх Судалгаа”-ны талаарх өмнөтөл.....	i
Газрын зураг	iv
Гарчиг.....	v
Товчилсон үгийн тайлбар.....	xvi
1-р бүлэг Судалгааны тойм.....	3
1.1 Судалгааны үндэслэл.....	3
1.2 Судалгааны тойм.....	3
1.2.1 Судалгааны зорилго.....	3
1.2.2 Судалгааны зорилгот бүс нутаг.....	4
1.3 Судалгааны баг болон ажлын төлөвлөгөө.....	4
1.3.1 Судалгааны багийн гишүүд.....	4
1.3.2 Судалгааны ажлын төлөвлөгөө.....	5
2-р бүлэг Аялал жуулчлалын салбарын үндсэн мэдээлэл, өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлуудад хийсэн дүн шинжилгээ.....	9
2.1 Монгол улсын эдийн засгийн төлөв байдал.....	9
2.2 Бодлого, тэргүүлэх зорилт.....	10
2.3 ЖАЙКА-ийн зүгээс аялал жуулчлалын салбарт хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр.....	15
2.4 Холбогдох байгууллагууд.....	26
2.5 Хууль эрх зүйн тогтолцоо.....	31
2.6 Хүний нөөцийг хөгжүүлэх.....	47
2.7 Тээврийн салбарын дэд бүтэц.....	53
2.8 Гадаадын жуулчдын чиг хандлага.....	61
2.9 Аялал жуулчлалын салбар.....	75
2.10 Аялал жуулчлалын маркетинг сурталчилгаа.....	81
2.11 Аялал жуулчлалын гол нөөц баялаг.....	83
2.11.1 Уламжлалт соёл урлаг, гар урлал, идээ ундаа.....	85
2.11.2 Баяр наадам, эвент.....	86
2.11.3 Өвлийн аялал жуулчлалын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлууд.....	87
2.12 Аялал жуулчлалын салбарын бусад донор байгууллагуудын чиг хандлага.....	94

3-р бүлэг Зорилгот бүс нутаг болох аялал жуулчлалын маршрулын ерөнхий танилцуулга.....	101
3.1 Өмнөговийн аялал жуулчлалын маршрут.....	101
3.1.1 Үндсэн мэдээлэл, Аялал жуулчлалын нөөцийн тухай.....	101
3.1.2 Төлөвлөгөө/ Аян/ Арга хэмжээ.....	106
3.1.3 Аялал жуулчлалын салбарын холбогдох байгууллагууд.....	116
3.1.4 Аялал жуулчлалын салбарын тагварын орлого.....	117
3.1.5 Дэд бүтцийн байдал.....	118
3.1.6 Жуулчдын чиг хандлага.....	126
3.1.7 Аялал жуулчлалын салбарын чиг хандлага.....	126
3.1.8 Аялал жуулчлалын маркетинг, сурталчилгааны байдал.....	129
3.1.9 SWOT шинжилгээ.....	129
3.2 Дорноговийн аялал жуулчлалын маршрут.....	135
3.2.1 Аялал жуулчлалын нөөцийн тухай.....	135
3.2.2 Төлөвлөгөө/ Аян/ Арга хэмжээ.....	137
3.2.3 Аялал жуулчлалын салбарын холбогдох байгууллагууд.....	141
3.2.4 Дэд бүтцийн байдал.....	143
3.2.5 Жуулчдын чиг хандлага.....	150
3.2.6 Аялал жуулчлалын салбарын чиг хандлага.....	151
3.2.7 Аялал жуулчлалын маркетинг, сурталчилгааны байдал.....	151
3.2.8 SWOT шинжилгээ.....	153
3.3 Хархорины аялал жуулчлалын маршрут.....	158
3.3.1 Аялал жуулчлалын нөөцийн тухай.....	158
3.3.2 Төлөвлөгөө/ Аян/ Арга хэмжээ.....	160
3.3.3 Аялал жуулчлалын салбарын холбогдох байгууллагууд.....	166
3.3.4 Аялал жуулчлалын салбарын тагварын орлого.....	166
3.3.5 Дэд бүтцийн байдал.....	167
3.3.6 Жуулчдын чиг хандлага.....	170
3.3.7 Аялал жуулчлалын салбарын чиг хандлага.....	171
3.3.8 Аялал жуулчлалын маркетинг, сурталчилгааны байдал.....	175
3.3.9 SWOT шинжилгээ.....	177
3.4 Улаанбаатар хог орчмын аялал жуулчлалын маршрут.....	182
3.4.1 Аялал жуулчлалын нөөцийн тухай.....	182
3.4.2 Төлөвлөгөө/ Аян/ Арга хэмжээ.....	184
3.4.3 Аялал жуулчлалын салбарын холбогдох байгууллагууд.....	188

3.4.4 Аялал жуулчлалын салбарын татварын орлого	189
3.4.5 Дэд бүтэц.....	189
3.4.6 Жуулчдын чиг хандлага	193
3.4.7 Аялал жуулчлалын салбарын чиг хандлага.....	194
3.4.8 SWOT шинжилгээ.....	196
3.5 Монгол улсын аялал жуулчлалын хөгжлийн өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээ.....	202
4-р бүлэг Аялал жуулчлалыг хөгжүүлэхэд тулгарч буй асуудлууд.....	209
5-р бүлэг Маршрут тус бүрийн аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого (төсөл)	225
5.1 Монгол Улсын аялал жуулчлалыг хөгжүүлэх ерөнхий бодлого / Хэтийн төлөв.....	225
5.2 Маршрут бүрийн аялал жуулчлалын хөгжлийн алсын хараа / хэтийн төлөв	226
5.2.1 Өмнөговийн маршрут	226
5.2.2 Дорноговийн маршрут.....	228
5.2.3 Хархорины маршрут	231
5.2.4 Улаанбаатар хот орчмын маршрут	234
5.3 Үйл ажиллагааны төлөвлөгөө (Action plan) /Төсөл/.....	238
5.3.1 Үйл ажиллагааны төлөвлөгөө (Action plan) -г хэрэгжүүлэх тэргүүлэх чиглэл	238
5.3.2 Судалгааны зорилгот бүс нутгуудад нийгэд нь хамаарах үйл ажиллагааны төлөвлөгөө (Action plan).....	239
5.3.3 Маршрут тус бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөө (Action plan).....	240
6-р бүлэг Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх ЖАЙКА-ийн хамтын ажиллагааны хөтөлбөрийн санал дэвшүүлэх	251
7-р бүлэг Төслийн санал дэвшүүлэлт.....	259
8-р бүлэг Япон улсын орон нутгийн засаг захиргааны байгууллага хийгээд судалгааны зорилгот бүс нутгийн иргэд, олон нийт хоорондын хамтын ажиллагааны талаар дэвшүүлэх санал.....	277
8.1 Хамтын ажиллагааны өнөөгийн байдал.....	277
8.2 Хамтын ажиллагаанд тулгарч буй асуудлууд.....	291
8.3 Цаашдын хамтын ажиллагаа өргөжүүлэх боломж.....	293
8.4 Аялал жуулчлалын салбар дахь хамтын ажиллагаа, цаашдын төлөвлөгөө	298
8.5 Хамтын ажиллагааны талаар санал дэвшүүлэхэд анхаарах зүйлс.....	302
8.6 Японы орон нутгийн засаг захиргаа болон судалгааны зорилгот бүс дахь олон нийтийн хамтын ажиллагааны санал.....	304
9-р бүлэг Ковид-19 цар тахлын дараах үеийн аялал жуулчлалын салбарын дүн шинжилгээ, зөвлөмж.....	309
9.1 Ковид-19 цар тахлын дараах Дэлхийн аялал жуулчлалын хэтийн төлөв.....	309
9.2 Монголын аялал жуулчлалын хэтийн төлөв.....	309
9.3 Ковид-19 цар тахлын дараах Монголын аялал жуулчлалын дүн шинжилгээ, зөвлөмж.....	311
9.4 Ковид -19 цар тахлын дараах үед чиглэсэн зөвлөмж.....	312

9.5 “Монгол дахь Дэлхийн бөмбөрцөгийн ирээдүйн төлөө хүүхдүүдийн чуулга уулзалт” санаачилга.....	313
10-р бүлэг Монголын аялал жуулчлалын семинарын агуулга.....	319

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1-1: Судалгааны багийн гишүүдийн бүрэлдэхүүн.....	4
Хүснэгт 2-1: ДНБ, салбарын бүтэц, дүнд эзлэх хувиар (Улсын хэмжээнд, судалгаанд хамрагдсан бүс нутаг)	10
Хүснэгт 2-2: Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050” 8. Бүс нутгийн хөгжил (Судалгаанд хамрагдсан аймгуудыг улаанаар тэмдэглэв.).....	11
Хүснэгт 2-3: Мастер төлөвлөгөөний хэрэгжилтийн төлөв, бүс нутгаар (Улаанбаатар, Өмнөговь, Хархорин).....	16
Хүснэгт 2-4: Тэргүүлэх чиглэлийн төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн төлөв.....	17
Хүснэгт 2-5: Аялал жуулчлалын хөгжилтэй холбоотой байгууллагууд.....	26
Хүснэгт 2-6: Аймаг, орон нутаг дах аялал жуулчлалын захиргааны тогтолцоо (Улаанбаатар хотоос бусад)	28
Хүснэгт 2-7: “Гадаад иргэний эрх зүйн байдлын тухай хууль”-тай холбоотой асуудлууд.....	32
Хүснэгт 2-8: Аялал жуулчлалын тухай хуультай холбоотой асуудлууд болон бусад хуультай зөрчилдөх байдал	33
Хүснэгт 2-9: Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуультай холбоотой асуудлууд.....	38
Хүснэгт 2-10: “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төсөл.....	38
Хүснэгт 2-11: “Байгаль орчныг хамгаалах тухай хууль”- тай холбоотой асуудлууд.....	40
Хүснэгт 2-12: “Соёлын өвийг хамгаалах тухай хууль”-тай холбоотой асуудлууд.....	40
Хүснэгт 2-13: Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн ялгаа.....	41
Хүснэгт 2-14: “Хөрөнгө оруулалтын тухай хууль”-тай холбоотой асуудал.....	43
Хүснэгт 2-15: Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийн төрөл, шаардлага.....	45
Хүснэгт 2-16: Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас нэг удаа олгох зээлийн хэмжээ.....	45
Хүснэгт 2-17: Ажил олгогчийн санаачлагчаар хөдөлмөрийн гэрээг цуцлах үндэслэл.....	46
Хүснэгт 2-18: Судалгааны хамрагдсан их дээд сургуулиудын мэдээлэл, сургалтын хөтөлбөрийн онцлог.....	49
Хүснэгт 2-19: Судалгаанд хамрагдсан мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагуудын мэдээлэл болон сургалтын хөтөлбөрийн онцлог, давуу тал.....	51
Хүснэгт 2-20: Улаанбаатар хотын Буянт-Ухаа НОБ-ын олон улсын нистэгийн мэдээлэл (2019 оны байдлаар)	55
Хүснэгт 2-21: Олон улсын зорчигчийн галт тэрэгний хуваарь.....	57
Хүснэгт 2-22: Төмөр замын салбарын томоохон төсөл хөтөлбөрүүд.....	58
Хүснэгт 2-23: Одоо баригдаж байгаа болон барихаар төлөвлөж буй зам дагуух үйлчилгээний цогцолбор, отоглох цэг.....	61
Хүснэгт 2-24: Бусад орнуудын гадагш чиглэсэн аялал (outbound) болон Монгол улсад зочилсон гадаадын жуулчдын талаарх мэдээлэл.....	64
Хүснэгт 2-25: Жуулчдын аяллын дундаж хугацааны өөрчлөлт (улсаар).....	66

Хүснэгт 2-26: Аялал жуулчлалын компани, аялал жуулчлалын салбарт тулгарч буй асуудлууд.....	76
Хүснэгт 2-27: Зочид буудлын салбарын үндсэн мэдээлэл.....	77
Хүснэгт 2-28: Сүүлийн жилүүдэд зохион байгуулагдсан Олон улсын хурал, зөвлөгөөн болон МИСЕ зохион байгуулагддаг гол байгууламжуудын жагсаалт.....	78
Хүснэгт 2-29: МИСЕ жуулчдын зочилдог аялал жуулчлалын гол газрууд.....	78
Хүснэгт 2-30: Гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ/ улсаар/ (1990-2020 оны 3-р улирал).....	80
Хүснэгт 2-31: БОАЖЯ-ны холбогдох байгууллагуудын веб сайт.....	82
Хүснэгт 2-32: Монгол улс дахь дэлхийн өвийн жагсаалт.....	84
Хүснэгт 2-33: Монголын зарим биет бус соёлын өвийн танилцуулга.....	85
Хүснэгт 2-34: Аймаг орон нутгийн өвлийн баяр, арга хэмжээ.....	88
Хүснэгт 2-35: Өвлийн аялал жуулчлалын талаар салбарын холбогдох хүмүүсийн санал.....	89
Хүснэгт 2-36: Монгол улсын аялал жуулчлалын салбарын донор байгууллагуудын жагсаалт.....	94
Хүснэгт 3-1: Мандалговь хот орчмын аялал жуулчлалын гол нөөцүүд.....	102
Хүснэгт 3-2: Даланзадгад хот орчмын аялал жуулчлалын гол нөөцүүд.....	103
Хүснэгт 3-3: Өмнөговь аймгийн бүсчилсэн хөгжлийн хүрээнд хэрэгжүүлэх ажлууд (Даланзадгад хотын хэмжээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа).....	107
Хүснэгт 3-4: Өмнөговь аймгийн бүсчилсэн хөгжлийн хүрээнд хэрэгжүүлэх ажлууд (Зүүн бүсийн нутагт хэрэгжүүлэх үйл ажиллагаа).....	108
Хүснэгт 3-5: Газар зүйн байрлал, байгаль, түүх, соёлын өвд тулгуурласан аялал жуулчлалын бүс нутгийг төрөлжүүлэн хөгжүүлж, эрүүл ахуй, үйлчилгээний чанар, стандартыг сайжруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд хийх ажлууд.....	109
Хүснэгт 3-6: Аялал жуулчлалын боловсрол, сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг хөгжүүлж, хүний нөөцийн ур чадварыг дээшлүүлэх, чадавхижуулах хүрээнд хийх ажлууд.....	109
Хүснэгт 3-7: Төр, шинжлэх ухаан, бизнесийн үр ашигтай хамтын ажиллагаа, харилцан уялдаатай, нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх хүрээнд хийх ажлууд.....	110
Хүснэгт 3-8: Дорнод, Өмнөговь, Өвөрхангай, Хөвсгөл, Увс, Ховд аймгуудын нисэх онгоцны буудлыг олон улсын нисэх буудал болгон хөгжүүлж, орон нутгийн нисэх буудлуудын хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд хийх ажлууд.....	111
Хүснэгт 3-9: Аялал жуулчлалын гол чиглэл дагуу төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд үйлчилгээний цогцолбор бүхий түр буудаллах цэгүүдийг байгуулах зорилтын хүрээнд хийх ажлууд.....	111
Хүснэгт 3-10: Явган аяллын гол чиглэл болон тусгай хамгаалалттай газар нутгийн аяллын зам, жимийг тохижуулах, мэдээллийн самбар, тэмдэг, тэмдэглэгээнүүдийг байршуулах зорилтын хүрээнд хийх ажлууд.....	112
Хүснэгт 3-11: Жуулчид голлон зорих байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад отоглох цэгүүдийг байгуулах зорилтын хүрээнд хийх ажлууд.....	112
Хүснэгт 3-12: Жуулчдад шаардлагатай мэдээллээр хангах мэдээллийн төв, цэгүүдийг Монгол улсад нэвтрэх боомтуудад байрлуулах зорилтын хүрээнд хийх ажлууд.....	113
Хүснэгт 3-13: Аялал жуулчлалын гол бүс нутгуудад байгаль орчинд ээлтэй технологиор хагуу хог хаягдлыг дарж булшлах, шингэн хог хаягдлыг нөөцлөх зориулалтын цэгүүдийг байгуулах зорилтын хүрээнд хийх ажлууд.....	113

Хүснэгт 3-14: Олон улсын үзэсгэлэнд Монгол улсыг сурталчлахад төр, хувийн хэвшлийн түнштэл, салбар дундын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд хийх ажлууд.....	113
Хүснэгт 3-15: Хөрш орнуудтай хамтран аялал болон хил дамнасан аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх зорилтын хүрээнд хийх ажлууд.....	114
Хүснэгт 3-16: Торгоны зам, Цайны зам, Их Түмэн голын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөтөлбөрийн гишүүн улс орнуудтай хамтран хөгжүүлэх зорилтын хүрээнд хийх ажлууд.....	114
Хүснэгт 3-17: Говийн бүсэд байгалийн, палеонтологи, геологи, геофизикийн аялал жуулчлалыг түлхүү хөгжүүлэх чиглэлээр аялал жуулчлалын нөөц, даацын судалгаа хийж, аялал жуулчлалын бүтээгдэхүүний хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох зорилтын хүрээнд хийх ажлууд.....	114
Хүснэгт 3-18: Байгалийн унаган төрхийг хадгалах, хамгаалах чиглэлээр тогтвортой аялал жуулчлалын бүсүүдийг тогтоож, хөгжүүлэх зорилтын хүрээнд хийх ажлууд.....	114
Хүснэгт 3-19: Өмнөговь аймагт палеонтологийн аялал жуулчлалын үндэсний хүрээлэн байгуулах зорилтын хүрээнд хийх ажлууд.....	114
Хүснэгт 3-20: Хил орчмын аялал жуулчлалын хөгжлийг эрчимжүүлэх зорилтын хүрээнд хийх ажлууд.....	115
Хүснэгт 3-21: Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжлийг бодлогоор дэмжиж, аялал жуулчлалд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилтын хүрээнд хийх ажлууд.....	115
Хүснэгт 3-22: Аялал жуулчлалын зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгааг тогтмол хийж, аялал жуулчлалын сургалт, судалгаа, үйлдвэрлэлд ашиглах боломжийг бүрдүүлэх зорилтын хүрээнд хийх ажлууд.....	116
Хүснэгт 3-23: "Жуулчин Говь" ХХК -ийн 2019 онд төлсөн татварын хэмжээ.....	118
Хүснэгт 3-24: Өмнөговь аймгийн Даланзадгад хот руу хийх нислэгийн мэдээлэл (2019 оны байдлаар).....	119
Хүснэгт 3-25: Өмнөговь аймгийн аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдал (бизнесийн төрөл тус бүрээр)	127
Хүснэгт 3-26: Өмнөговь аймгийн Аялал жуулчлалын салбарын ажилтнуудын сарын дундаж цалин (ажил мэргэжил тус бүрээр).....	128
Хүснэгт 3-27: Өмнөговь аймгийн төрийн албан хаагчдын сарын дундаж цалин	128
Хүснэгт 3-28: Өмнөговийн аялал жуулчлалын маршрутын давуу болон сул талууд (SWOT шинжилгээ).....	130
Хүснэгт 3-29: Чойр хот орчмын аялал жуулчлалын гол нөөцүүд.....	136
Хүснэгт 3-30: Сайншанд хот орчмын аялал жуулчлалын гол нөөцүүд.....	137
Хүснэгт 3-31: 2019-2020 онд аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтийн байдал.....	138
Хүснэгт 3-32: Дорноговь аймгийн аялал жуулчлалын мастер төлөвлөгөө	138
Хүснэгт 3-33: Аялал жуулчлалын үйл ажиллагааны төсвийн гүйцэтгэл.....	140
Хүснэгт 3-34: Сайншанд сумын Хот тохижилтын газарт хамаардаг аялал жуулчлалын газрууд	142
Хүснэгт 3-35: Дорноговь аймгийн төв болон сумдын хоорондох зай.....	143
Хүснэгт 3-36: Дорноговь аймгийн Засаг даргын 2020-2024 оны мөрийн хөтөлбөр (Үндны усны хангамжийг сайжруулах).....	145
Хүснэгт 3-37: Зам дагуух байгууламж, үйлчилгээний төрөл.....	149
Хүснэгт 3-38: Дорноговь аймгийн аялал жуулчлалын салбарын ажилтны тоо.....	151
Хүснэгт 3-39: Дорноговийн аялал жуулчлалын маршрутын давуу болон сул талууд (SWOT шинжилгээ).....	153
Хүснэгт 3-40: Цэцэрлэг хот (аймгийн төв) орчмын аялал жуулчлалын гол нөөцүүд.....	159

Хүснэгт 3-41: Хархорин орчмын аялал жуулчлалын алдартай газрууд	159
Хүснэгт 3-42: Өвөрхангай аймгийн аялал жуулчлалын хөгжлийн бодлогын гол баримт бичиг	161
Хүснэгт 3-43: Өвөрхангай аймгийн Аялал жуулчлалын дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн байдал	162
Хүснэгт 3-44: Өвөрхангай аймгийн Аялал жуулчлалын дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ (2020 оны эцсийн байдлаар)	163
Хүснэгт 3-45: Архангай аймгийн аялал жуулчлалын хөгжлийн бодлогын баримт бичиг	165
Хүснэгт 3-46: Архангай аймгийн Аялал жуулчлалын дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн байдал.....	165
Хүснэгт 3-47: Өвөрхангай аймгийн аялал жуулчлалын салбарын орлого.....	166
Хүснэгт 3-48: Орхоны Хөндийн БЦГ-ын Хамгаалалтын захиргааны орлого.....	166
Хүснэгт 3-49: Архангай аймгийн зарим сумын татварын орлого.....	167
Хүснэгт 3-50: Архангай аймгийн зарим сумын хог хаягдлын үйлчилгээний нөхцөл байдал.....	169
Хүснэгт 3-51: Хархориныг зорьсон жуулчдын тоо (гадаадын болон дотоодын жуулчид тус бүрээр).....	170
Хүснэгт 3-52: Жуулчны баазад ажиллагсдын тоо.....	171
Хүснэгт 3-53: Жуулчны баазын ажиллагсдын сарын дундаж цалин (Хархорин, Баг-Өлзий, Хужирт, Уянга, Арвайхээр).....	172
Хүснэгт 3-54: Өвөрхангай аймгийн 5 суманд үйл ажиллагаагаа явуулж буй зочид буудлуудын ажиллагсдын тоо (Хархорин, Баг-Өлзий, Хужирт, Уянга, Арвайхээр)	173
Хүснэгт 3-55: Зочид буудлын ажиллагсдын сарын дундаж цалин (Хархорин, Баг-Өлзий, Хужирт, Уянга, Арвайхээр).....	173
Хүснэгт 3-56: Өвөрхангай аймгийн музейн ажилчдын тоо	174
Хүснэгт 3-57: Музейн ажиллагсдын сарын дундаж цалин (Хархорин, Арвайхээр)	174
Хүснэгт 3-58: Архангай аймгийн аялал жуулчлалын салбарт ажиллагсдын тоо	174
Хүснэгт 3-59: Аялал жуулчлалын газруудын видео контент.....	175
Хүснэгт 3-60: Хархорин орчмын аялал жуулчлалын маршрутын давуу ба сул талууд (SWOT шинжилгээ)....	178
Хүснэгт 3-61: Улаанбаатар хотын аялал жуулчлалын гол нөөцүүд.....	182
Хүснэгт 3-62: Улаанбаатар хот орчмын аялал жуулчлалын гол газрууд.....	183
Хүснэгт 3-63: Дэлхийн улс орнуудад Улаанбаатар хотын аялал жуулчлалын мэдээлэл түгээдэг хувийн веб сайтуудын жишээ.....	195
Хүснэгт 3-64: Улаанбаатар хотын аялал жуулчлалын давуу ба сул талууд	197
Хүснэгт 3-65: Гадаад орчны дүн шинжилгээ.....	202
Хүснэгт 3-66: Монголын аялал жуулчлалын салбарын SWOT шинжилгээ.....	203
Хүснэгт 4-1: Тусгай хамгаалалтай газар нутаг дахь дэд бүтцийн бүтээн байгуулалтад хамаарах хуулийн заалтууд	211
Хүснэгт 4-2: Бүс нутаг тус бүрийн маркетинг, сурталчилгаагай холбоотой үйл ажиллагааны төсвийн байдал..	218
Хүснэгт 5-1: Улаанбаатар хотын музейн жагсаалт	234
Хүснэгт 5-2: Нэн тэргүүнд тавигдаж буй асуудлууд, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн хамтын ажиллагааны агуулгын санал.....	239

Хүснэгт 5-3: Судалгааны зорилгот бүс нутгуудад нийтэд нь хамаарах үйл ажиллагааны төлөвлөгөө (Action plan)	240
Хүснэгт 5-4: Өмнөговийн маршрутын аялал жуулчлалыг хөгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө (Action Plan)	241
Хүснэгт 5-5: Дорноговийн маршрутын аялал жуулчлалыг хөгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө (Action Plan)	242
Хүснэгт 5-6: Хархорины маршрутын аялал жуулчлалыг хөгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө (Action Plan)	244
Хүснэгт 5-7: Улаанбаатар хот орчмын маршрутын аялал жуулчлалыг хөгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө (Action Plan)	245
Хүснэгт 6-1: ЖАЙКА-д санал болгох хамтын ажиллагааны төслийн жагсаалт	252
Хүснэгт 7-1: Төслийн санал 1	259
Хүснэгт 7-2: Төслийн санал 2	261
Хүснэгт 7-3: Төслийн санал 3	264
Хүснэгт 7-4: Төслийн санал 4	268
Хүснэгт 7-5: Төслийн санал 5	270
Хүснэгт 7-6: Төслийн санал 6	272
Хүснэгт 8-1: “Хост таун” хөтөлбөрт хамрагдсан болон эгч дүүс хотын харилцаа, найрамдалт харилцаатай орон нутгийн засаг захиргааны байгууллагууд, консулын газрын жагсаалт	278
Хүснэгт 8-2: Эгч дүүс хотын харилцаа / найрамдалт харилцаатай орон нутгийн засаг захиргааны байгууллагын жагсаалт (хамтын ажиллагааны гэрээ байгуулсан он, харилцаа тогтоох болсон шалтгаан)	279
Хүснэгт 8-3: “Хост таун” хөтөлбөрт бүртгүүлсэн орон нутгийн засаг захиргааны байгууллагын жагсаалт (Спортын төрөл, бүртгүүлсэн жил, бүртгүүлж болсон үндэслэл, шалтгаан)	280
Хүснэгт 8-4: Харилцаа тогтоох болсон шалтгаан	281
Хүснэгт 8-5: Орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын хэрэгжүүлж буй голлох хамтын ажиллагаа	281
Хүснэгт 8-6: Тоёока хотын хүүхдийн солилцооны хөтөлбөр	283
Хүснэгт 8-7: Монгол Улсын Засгийн Газар, орон нутгийн засаг захиргаанд гаргах санал хүсэлт	292
Хүснэгт 8-8: Цаашид Японы бусад орон нутгийн засаг захиргаа Монгол улстай харилцаа тогтоох, хамтын ажиллагаа хэрэгжүүлж тохиолдолд анхаарвал зохих зүйл	293
Хүснэгт 8-9: Монгол улсын орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хамтын ажиллагаагаа өргөжүүлэн хөгжүүлэх цаашдын төлөвлөгөө	294
Хүснэгт 8-10: Монгол улстай цаашид хамтран ажиллах боломж (“Хост таун” хөтөлбөр, эгч дүүс хотын харилцаа / найрамдалт харилцаанаас гадна)	296
Хүснэгт 8-11: Монгол хүн, монгол орны сайхан чанар	297
Хүснэгт 8-12: Аялал жуулчлалын салбар дахь хамтын ажиллагааны ололт амжилт, цаашдын төлөвлөгөө	299
Хүснэгт 8-13: Аялал жуулчлалын салбарт хамтран ажилласан жишээ	300
Хүснэгт 8-14: Аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах цаашдын төлөвлөгөөний агуулга	301
Хүснэгт 8-15: Монголд аялаад ирсэн хүмүүсийн санал сэтгэгдэл, зөвлөгөө (ялангуяа аялал жуулчлалын тухайд)	301

Хүснэгт 8-16: Хамтын ажиллагаа нь аялал жуулчлалын салбарт нөлөө үзүүлсэн эсэх	302
Хүснэгт 9-1: Судалгааны зорилгот бүс нутаг дахь гол аялал жуулчлалын газрын жуулчдын тооны өөрчлөлт...	310

Зургийн жагсаалт

Зураг 1-1: Судалгааны ажлын хуваарь.....	5
Зураг 2-1: ДНБ болон 1 хүнд ногдох ДНБ (Улсын хэмжээнд болон судалгаанд хамрагдсан бүс нутаг).....	9
Зураг 2-2: Нийслэлийн аялал жуулчлалын газрын бүтэц (Нийт 22 ажилтан)	29
Зураг 2-3: Тусгай хамгаалалттай газар нутгийн ангилал	35
Зураг 2-4: Тусгай хамгаалалттай газар нутгийн ангиллын газрын зураг	35
Зураг 2-5: Дархан цаазат газрын газрын зураг (Судалгааны маршрут)	36
Зураг 2-6: Байгалийн цогцолборг газрын газрын зураг (Судалгааны маршрут)	37
Зураг 2-7: Байгалийн нөөц газрын газрын зураг (Судалгааны маршрут)	37
Зураг 2-8: Дурсгалт газрын газрын зураг (Судалгааны маршрут)	38
Зураг 2-9: Семинарын үеэр.....	48
Зураг 2-10: 2015-2020 оны агаарын тээврээр зорчигчдын тоо (нислэгийн төрлөөр)	54
Зураг 2-11: Олон улсын нислэгээр зорчигчид (2019он).....	54
Зураг 2-12: Төмөр замын сүлжээ.....	56
Зураг 2-13: Төмөр замаар зорчигчдын тоо	57
Зураг 2-14: Цайны замын төмөр замын аяллын маршрут (жишээ).....	59
Зураг 2-15: Монгол улсын авто замын газрын зураг	59
Зураг 2-16: Монгол улсын авто замыг хөгжүүлэх төлөвлөгөө	60
Зураг 2-17: Монголд зочилсон гадаадын иргэдийн тоо болон түүний доторх жуулчдын тооны өөрчлөлт	62
Зураг 2-18: Монголын аялал жуулчлалын орлогын хэмжээ.....	62
Зураг 2-19: Монгол улсад зорчсон гадаадын иргэдийн тоо (хамгийн их хүн ирсэн аяллын 4 зорилго тус бүрээр).....	63
Зураг 2-20: 2019 онд Монголд ирсэн гадаадын жуулчдын тоо (улс тус бүрээр) болон Гадаадын жуулчдын тоонд гарсан өөрчлөлт (эхний 4 улс)	64
Зураг 2-21: Монгол улсад зочилсон гадаадын жуулчдын тоо (2019 оны улирал тус бүрээр), Монгол улсад зочилсон гадаадын жуулчдын тооны өөрчлөлт (улирал тус бүрээр).....	65
Зураг 2-22: Монгол улсад зочилсон гадаадын жуулчдын тоо (улсаар /улирлаар /зорилгоор).....	65
Зураг 2-23: "Аялал жуулчлалын түүвэр судалгаа 2019" -ны "Аяллаа өөрөө зохион байгуулсан уу? , аяллын тур агентаар дамжуулан зохион байгуулсан уу?" гэсэн асуулгын хариулт.....	67
Зураг 2-24: Монгол дахь аяллын сэтгэл ханамж, аяллын явцад хүндрэл учруулсан асуудлууд	68
Зураг 2-25: Монгол улсад зочлогчдын насны ангилал (улсаар).....	69

Зураг 2-26: Улс, насны бүлгээр хамгийн их хэрэг болсон мэдээллийн эх сурвалж (хариулт давхардсан)	71
Зураг 2-27: Улс / насны бүлгээр аяллаа зохион байгуулсан арга, аялал жуулчлалын компанийн байрлал (аяллаа зохион байгуулсан арга тус бүрээр)	74
Зураг 2-28: Аялал жуулчлалын зорилгоор зорчигсдын Монголд саатсан хугацаа (улс, насны бүлгээр).....	75
Зураг 2-29: Аялал жуулчлалын газрууд	84
Зураг 2-30: Монгол гэрийн дүр зураг	85
Зураг 2-31: Улсын их наадам болон орон нутгийн наадмын хурдан морины уралдааны дүр зураг	87
Зураг 3-1: Судалгааны зорилгот бүс нутаг болох аймгууд ба Улаанбаатар хот	101
Зураг 3-2: Өмнөговийн аялал жуулчлалын маршрут, аялал жуулчлалын гол нөөц.....	102
Зураг 3-3: “Баянзаг - Улалзах Цонж Хөгжлийн Төв” ТББ-ын танилцуулга.....	117
Зураг 3-4: Дотоодын нислэгийн маршрут (2019)	118
Зураг 3-5: Судалгааны зорилгот бүс нутаг болох Өмнөговь аймаг руу дотоод нислэгээр зорчигчдын тоо (2019 он)	119
Зураг 3-6: Аялал жуулчлалын гол чиглэлүүдийн авто замын зураг (хагуу хучилттай болон шороон зам) 2020 он	120
Зураг 3-7: Өмнөговийг зорьсон жуулчдын тоо	126
Зураг 3-8: Дорноговийн аялал жуулчлалын маршрут.....	135
Зураг 3-9: Сайншанд сумын ус түгээх цэг.....	144
Зураг 3-10: “Оргих Доргио”, “Үлэмж” цэвэр усны үйлдвэр.....	145
Зураг 3-11: Сайншанд сумын 4,7-р багт байрших цэвэрлэх байгууламж.....	146
Зураг 3-12: Сайншанд сумын 1,2,3,6-р багт байрших цэвэрлэх байгууламж.....	146
Зураг 3-13: Сайншанд сумын 2-р багт байрлах 3000 м ³ /хоног хүчин чадал бүхий цэвэрлэх байгууламж (Одоохондоо ашиглаагүй байгаа).....	146
Зураг 3-14: Хуванцар хог хаягдал цуллуулах сав.....	147
Зураг 3-15: "Эжо-Говь" төслийн сандал ба хайс.....	147
Зураг 3-16: Сайншанд сумын салхин парк.....	148
Зураг 3-17: Замын-үүд сумын нарын цахилгаан станц.....	148
Зураг 3-18: Сайншанд сумын төвөөс зүүн тийш орших нар салхины цахилгаан станцын байршил.....	148
Зураг 3-19: 4-р багийн нийтийн бие засах газрын жишээ	150
Зураг 3-20: (Зүүн) Хамарын хийдийн урд байрлах боловсон бие засах газар, (Баруун) Сумын төвийн боловсон бие засах газар.....	150
Зураг 3-21: Жуулчдын тоо (гадаад, дотоодын жуулчин тус бүрээр)	150
Зураг 3-22: Сайншанд сумын аялал жуулчлалын мэдээллийн төв	152
Зураг 3-23: Дорноговь аймгийн веб сайтын зураг.....	152
Зураг 3-24: Хархорины аялал жуулчлалын маршрут	158
Зураг 3-25: Хархорин орчмын бүс нутгийн авто замын сүлжээ	168

Зураг 3-26: Шинээр нээгдсэн үйлчилгээний цэг (Төв аймгийн Лүн сум Урьхан цогцолбор)	169
Зураг 3-27: Шинээр нээгдсэн үйлчилгээний цэг (Элсэн тасархай).....	170
Зураг 3-28: Үйлчилгээний цогцолборын загвар зураг	170
Зураг 3-29: 13-р зууны Монголын эзэнт гүрний нийслэл Хархорум хотыг танилцуулсан Виртуал Хархорин контент.....	176
Зураг 5-1: Аялал жуулчлалыг хөгжүүлэх схем зураг (Өмнөговийн маршрут)	228
Зураг 5-2: Аялал жуулчлалыг хөгжүүлэх схем зураг (Дорноговийн маршрут).....	231
Зураг 5-3: Аялал жуулчлалыг хөгжүүлэх схем зураг (Хархорины маршрут).....	233
Зураг 5-4: Үлэг гүрвэлийн олдворыг үзэх маршрут /төсөл/	235
Зураг 5-5: Яам дамнасан Музейн хөгжлийн хороо ба олон улсын хамтын ажиллагаа, дэмжтэгийг харуулсан схем зураг	236
Зураг 5-6: Аялал жуулчлалыг хөгжүүлэх схем зураг (Улаанбаатар болон ойрын бүс)	238
Зураг 8-1: Хамтын ажиллагаа үргэлжилж байгаа хугацаа.....	280
Зураг 8-2: Гадаад харилцааны ажилтан(CIR) /Монгол ажилтан байгаа эсэх	281
Зураг 8-3: Хамтын ажиллагаанд тулгарч буй асуудал.....	291
Зураг 8-4: Аялал жуулчлалын салбарт хамтын ажиллагаа байх эсэх.....	300
Зураг 8-5: Аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах цаашдын төлөвлөгөө.....	300
Зураг 9-1: Гадаадын жуулчдын тооны өөрчлөлт болон 2030 он хүртэлх таамаглал.....	310

Товчилсон үгийн тайлбар

Товчилсон нэр томьёо	Албан ёсны нэршил
АЖ	Аялал жуулчлал
АЖБЗ	Аялал жуулчлалын бодлого зохицуулалт
АЖХТ	Аялал Жуулчлалын Хөгжлийн Төв
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АХБ	Азийн Хөгжлийн Банк
БНГ	Байгалийн нөөц газар
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад ард Улс
БОАЖЯ	Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам
БЦГ	Байгалийн цогцолборт газар
БШУЯ	Боловсрол, Шинжлэх Ухааны Яам
ГИХГ	Гадаадын Иргэн Харьяатын Газар
ГХЯ	Гадаад Харилцааны Яам
ДАЖБ	Дэлхийн Аялал Жуулчлалын Байгууллага
ДБ	Дэлхийн Банк
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДЦГ	Дархан цаазат газар
ЕС	Ерөнхий сайд
ЖАЙКА	Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэр
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ЗТХЯ	Зам, Тээврийн Хөгжлийн Яам
ИНЕГ	Иргэний Нисэхийн Ерөнхий Газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МАЖХ	Монголын Аялал Жуулчлалын Холбоо
МИАТ	Монголын Иргэний Агаарын Тээвэр
МПОХН	Монголын Палеонтологийн Олдворыг Хамгаалах Нийгэмлэг
МСҮТ	Мэргэжлийн Сургалт Үйлвэрлэлийн Төв
МУИС	Монгол Улсын Их Сургууль
МУХАҮТ	Монголын Худалдаа Аж Үйлвэрийн Танхим
МХХТ	Мэдээлэл харилцаа холбооны технологи
МЭ	Манай эриний
МЭӨ	Манай эриний өмнөх

Товчилсон нэр томьёо	Албан ёсны нэршил
НАЖГ	Нийслэлийн Аялал Жуулчлалын Газар
НИТХ	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НОБ	Нисэх онгоцны буудал
НӨАГ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОУВС	Олон Улсын Валютын Сан
ОХУ	Оросын Холбооны Улс
ӨМӨЗО	Өвөр Монголын Өөртөө Засах Орон
ТББ	Төрийн бус байгууллага
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТҮК	Тохижилт үйлчилгээний компани
ТХГ	Тусгай хамгаалалттай газар
ТХГН	Тусгай хамгаалалттай газар нутаг
ТХГНХЗ	Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УСУГ	Ус Сувгийн Удирдах Газар
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
ХАА	Хөдөө аж ахуй
ХК	Хувьцаат компани
ХНН	Хувь нийлүүлсэн нийгэмлэг
ХХААХҮЯ	Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яам
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ШТС	Шатахуун түгээх станц
ШУА	Шинжлэх Ухааны Академи
ЭЗХАХБ	Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллага
ЭМЯ	Эрүүл Мэндийн Яам
ЭСЯ	Элчин Сайдын Яам
DMO	Destination Management Organization Аялал жуулчлалын бүс нутаг хөгжүүлэх маркетинг/менежментийн байгууллага
ITM	International Travel Mart Олон Улсын Аялал Жуулчлалын Үзэсгэлэн
MICE	Meeting, Incentive Travel, Convention, Exhibition/Event Олон улсын хэмжээний хурал, аялал, үзэсгэлэн, эвент, арга хэмжээ
SWOT	Strength, Weakness, Opportunity, Threat Давуу тал, Сул тал, Боломж, Аюул заналын талаарх дүн шинжилгээ

Тус тайланд валютыг хөрвүүлэхдээ доорх ханшийг ашигласан болно.

1 төгрөг = 0.041930 иен

1 ам доллар = 109.862 иен (2021 оны 9-р сарын ЖАЙКА-ийн албан ханш)

1-р бүлэг

Судалгааны тойм

1-р бүлэг Судалгааны тойм

1.1 Судалгааны үндэслэл

Монгол улс нь нүүдлийн өвөрмөц соёл, үзэсгэлэнт сайхан байгалийн нөөц баялагтай, аялал жуулчлал хөгжих бүрэн боломжтой орон боловч, нөгөөтэйгүүр аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэхийн тулд аялал жуулчлалын нөөц баялгаа үр дүнтэй ашиглах, маркетингийн стратегийг боловсруулан хэрэгжүүлэх, дэд бүтцийн (зам тээвэр, хоноглох буудаллах газар, үйлчилгээний газар гэх мэт) орчинг бүрдүүлэх зэрэг асуудлыг шийдвэрлэх шаардлага тулгарч байна.

Монгол улсын Засгийн газар “Алсын хараа 2050”, “Турван тулгуурт хөгжлийн бодлого (Three Pillar Development Policy)”, “Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр (Tourism Development National Program)”, “Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр баримтлах бодлого 2019-2026 (State Policy on Tourism Development)” зэрэг бодлогын баримт бичгүүдэд орон нутгийн эдийн засгийг идэвхжүүлэхэд аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх нь нэн тэргүүний чухал асуудлуудын нэг хэмээн тодорхойлсон байдаг хэдий ч, тэргүүлэх чиглэлийн эрэмбэ тодорхой бус байдаг. Мөн аялал жуулчлалын салбар нь Монгол улсын Засгийн газрын баримт бичгүүдэд чухал салбарт тооцогддог хэдий ч, “Дэлхийн Эдийн Засгийн Форум”-ын гаргасан “Аялал жуулчлалын өрсөлдөх чадварын судалгаа” (2019) -нд Монгол улсын аялал жуулчлалын хөгжлийн индекс нь 3.5 оноо буюу 140 орноос 93-р байранд жагссан байна. Өнгөрсөн хугацаанд ЖАЙКА-аас хийгдсэн аялал жуулчлалын салбарын судалгаагаар, Монгол улс нь өргөн уудам газар нутаг, үзэсгэлэнт байгаль, өвөрмөц онцлог бүхий соёл зэрэг нөөц боломжоо ашиглан аялал жуулчлалыг хөгжүүлэх бүрэн бололцоотой боловч, дэд бүтцийн асуудал болон аялал жуулчлалын нөөц баялгаа бүрэн ашиглаж чадахгүй байгаа зэргээс үүдэн эдийн засгийн өсөлтөд үзүүлэх хувь нэмэр хязгаарлагдмал байна хэмээн тодорхойлсон байдаг. Монгол улсын аялал жуулчлалын салбар нь ДНБ-ий 3.3% (2019 оны байдлаар 427 сая ам доллар)-с хэтэрдэггүй бол, нөгөөтэйгүүр ОУВС-ийн судалгааны дүн шинжилгээнээс харахад аялал жуулчлал нь аж үйлдвэрийг төрөлжүүлэхэд тэргүүлэх салбаруудын нэг хэмээн тодорхойлогддог төдийгүй, аялал жуулчлалын салбарыг хөгжүүлснээр макро эдийн засгийн тогтворжилтод хувь нэмэр оруулах боломжтой гэж үздэг байна.

Иймд Монгол улсын аялал жуулчлалын нөөц баялаг ихтэй, аялал жуулчлалын зориулалттай газар болгон илүү хөгжүүлэх боломжтой Говийн бүс нутаг, Хархорин хотын ойр орчим, мөн Дорноговь аймгийг гол зорилготой бүс нутаг болгон, аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл цуглуулж, улмаар тухайн бүс нутагт хэрэгжүүлж болох ЖАЙКА-ийн хамтын ажиллагааны саналыг боловсруулна. Монгол улс нь өөрийн орны нүүдлийн аж ахуй, түүх соёлыг чухал нөөц баялаг хэмээн үзэж, тэдгээрт түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэхээс гадна, хүрээлэн буй орчинд ээлтэй, олон нийтийн оролцоонд тулгуурласан, тогтвортой аялал жуулчлалын хөгжлийг бий болгохыг бодлогын үзэл баримтлалд тусгасан байдаг. Иймд энэхүү судалгаагаар эдгээр Монгол улсын бодлогын үзэл баримтлалд тулгуурлаж, цаашдын ЖАЙКА-ийн хамтын ажиллагааны саналыг боловсруулах болно. Говийн бүс нутаг дотроос аялал жуулчлалын нөөц баялаг арвинтай Өмнөговь аймгийн хувьд гадаадаас орж ирэх гол үүд хаалга болсон, Монгол улсын хүн амын тэн хагас нь оршин суудаг УБ хотоос 550 км зайд оршдог, мөн Дорноговь аймгийн хувьд 450 км зайтай тул, Мандалговь, Чойр зэрэг зам дагуух байрлалтай хотуудын аялал жуулчлалын хөгжлийг хамтатган судалж, улмаар Говийн бүс нутаг руу чиглэх аялал жуулчлалын үнэ цэнийг улам дээшлүүлэх зорилго бүхий хамтын ажиллагааны хөтөлбөр боловсруулж, санал болгоно.

1.2 Судалгааны тойм

1.2.1 Судалгааны зорилго

Энэхүү судалгаагаар зорилготой бүс нутгуудын аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар өмнө нь ЖАЙКА-ийн боловсруулсан Мастер төлөвлөгөө болон холбогдох судалгааны үр дүн, Монгол улсын аялал жуулчлалын салбарын өнөөгийн нөхцөл байдал болон хөгжлийн ахиц дэвшил, аялал жуулчлалтай холбоотой суурь мэдээлэл, тусламж дэмжлэгийн хэрэгцээ шаардлага, олон улсын бусад дэмжлэг үзүүлэгч байгууллагуудын хамтын ажиллагааны чиг хандлагыг тодорхойлж, сонгосон маршрут тус бүрийн аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого (төсөл)-г санал болгоно. Улмаар маршрут тус бүрийн аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого (төсөл)-д үндэслэн аялал жуулчлалын болон холбогдох бусад салбаруудыг хөгжүүлэхийн тулд цаашид ЖАЙКА-аас хэрэгжүүлж болох хамтын ажиллагааны хөтөлбөр (төсөл)-ийг санал дэвшүүлэх нь энэ судалгааны гол зорилго болно.

1.2.2 Судалгааны зорилтот бүс нутаг

Судалгааны зорилтот бүс нь дараах 4 маршрутаас бүрдэх бөгөөд нийслэл Улаанбаатар хотоос эхлэх маршрут тус бүрийн тухай мэдээлэл цуглуулж нарийвчилсан аяллын чиглэлүүд дэх аялал жуулчлалын хөгжлийн бодлого (төсөл) болон ЖАЙКА-ийн хамтын ажиллагааны хөтөлбөр (төсөл)-ийг боловсруулна.

- A) Өмнөговийн маршрут (Улаанбаатар хот~Дундговь аймгийн Мандалговь хот~Өмнөговь аймгийн Даланзадгад хотын орчим нутаг)
- B) Дорноговийн маршрут (Улаанбаатар хот~Говьсүмбэр аймгийн Чойр хот~Дорноговь аймгийн Сайншанд хот~Замын үүд хотын орчим нутаг)
- C) Хархорины маршрут (Улаанбаатар хот~Өвөрхангай аймгийн Хархорин хот~ Архангай аймгийн Цэцэрлэг хотын орчим нутаг)
- D) Улаанбаатар хот орчмын маршрут (Төв аймгийн Зуунмод хот, Шинэ Зуунмод хот, Тэрэлж)

1.3 Судалгааны баг болон ажлын төлөвлөгөө

1.3.1 Судалгааны багийн гишүүд


Судалгааны багийн гишүүдийн бүрэлдэхүүнийг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 1-1: Судалгааны багийн гишүүдийн бүрэлдэхүүн

Хариуцах салбар	Нэр	Байгууллагын нэр
Багийн ахлагч /Аялал жуулчлалын хөгжлийн төлөвлөлт	Шимизү Такэнори	Кинки Ниппон Турист Корпорейт Бизнес ХК
Аялал жуулчлалын бизнес хөгжил / Маркетинг	Хирабаяши Жюн	Күние ХК
Олон нийтийн оролцоо	Дамба Гангөмөр	ТОА Зүүн Ази судлалын хүрээлэн (МАЖХ)
Аялал жуулчлалын дэд бүтэц	Такэбэ Цүтомү	ТОА Зүүн Ази судлалын хүрээлэн
Аялал жуулчлалын статистик, дүн шинжилгээ ①	Томошигэ Косүкэ	Күние ХК
Аялал жуулчлалын статистик, дүн шинжилгээ ②	Хияма Аири	Күние ХК
Хүрээлэн буй орчин нийгэмд үзүүлэх нөлөөлөл	Дэба Хиба	Күние ХК
Аяллын бүтээгдэхүүн хөгжүүлэлт	Обү Ёшимаса	Кинки Ниппон Турист Корпорейт Бизнес ХК
Аялал жуулчлалын хөгжлийн төлөвлөлт ②	Ганбат Өсөхбаяр	ТОА Зүүн Ази судлалын хүрээлэн

1.3.2 Судалгааны ажлын төлөвлөгөө

Зураг 1-1-д судалгааны ажлын хуваарийг харуулав.



Зураг 1-1: Судалгааны ажлын хуваарь

2-р бүлэг


Аялал жуулчлалын салбарын үндсэн
мэдээлэл, өнөөгийн байдал, тулгамдаж буй
асуудлуудад хийсэн дүн шинжилгээ

2-р бүлэг Аялал жуулчлалын салбарын үндсэн мэдээлэл, өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлуудад хийсэн дүн шинжилгээ

2.1 Монгол улсын эдийн засгийн төлөв байдал

Монгол улс нь 1,564,100 км² нутаг дэвсгэртэй (Япон улсаас 4 дахин том), нийт 3.3 сая орчим хүн амтай (2019 он, ҮСХ) бөгөөд дэлхий дээрх хүн амын сийрэг суурьшилтай орнуудын 2-т ордог, БНХАУ болон ОХУ-тай хиллэдэг. 2019 оны ДНБ 37 их наяд 281 тэрбум төгрөг (14 тэрбум ам.доллар орчим (2019 он, ДБ), нэг хүнд ногдох ДНБ 11 сая 680 мянган төгрөг (4,340 ам. доллар (2019 он, ДБ) байна. ДНБ-ний 65 хувь нийслэл Улаанбаатар хотод төвлөрдөг.

Монгол улсын эдийн засгийн хувьд, экспортын 80 гаруй хувийг уул уурхайн бүтээгдэхүүн эзэлдэг, экспортын 90 гаруй хувийг БНХАУ руу гаргадаг бөгөөд түүхий эдийн үнэ болон БНХАУ-ын эдийн засгаас ихээхэн хамааралтай бүтэцтэй байна. 2011 оноос хойш Оюутолгой орд газарт оруулсан гадаадын шууд хөрөнгө оруулалтын нөлөөгөөр Монгол улсын эдийн засаг өсөлт нэмэгдэж, 2011 оноос хойш 3 жил турш ДНБ-ийн өсөлтийн хувь 2 оронтой тоонд хүрсэн боловч, удаах жилүүдэд гадаадын шууд хөрөнгө оруулалт болон 2012 оноос эхэлсэн уул уурхайн түүхий эдийн үнийн бууралт, БНХАУ-ын эдийн засаг зогсонги байдалд орсноор, ДНБ-ний өсөлт ч саарч эхэлсэн. Харин, 2017 оноос түүхий эдийн үнэ болон гадаадын шууд хөрөнгө оруулалт ч сэргэж эхэлж байна.



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хорооноос гаргасан мэдээлэлд үндэслэн судалгааны баг боловсруулав.

Зураг 2-1: ДНБ болон 1 хүнд ногдох ДНБ (Улсын хэмжээнд болон судалгаанд хамрагдсан бүс нутаг)

2019 оны нэг хүнд ногдох ДНБ-нийг салбар тус бүрээр авч үзвэл, үйлчилгээний салбар (48%) тэргүүлж, аж үйлдвэр (41%), ХАА (11%) салбар удаалжээ. Бүс нутаг болон салбар тус бүрээр задалж харвал, Монгол улсын хэмжээнд уул уурхайн салбар 1-рт, үйлчилгээний салбарын 37%-

ийг эзлэх худалдаа, зочид буудал, ресторан зоогийн газрууд 2-рт байгаа нь Улаанбаатар хотод төвлөрч үйл ажиллагаа явуулдагтай холбоотой гэж үзэж байгаа бөгөөд Оюутолгойн орд газар орших Өмнөговь аймгаас бусад орон нутгийн хувьд голлох аж үйлдвэрийн салбар нь мал аж ахуйн салбар байна.

Хүснэгт 2-1: ДНБ, салбарын бүтэц, дүнд эзлэх хувиар (Улсын хэмжээнд, судалгаанд хамрагдсан бүс нутаг)

Бүс нутгийн нэр	1-т		2-т		3-т	
	Салбарын нэр	Хувь	Салбарын нэр	Хувь	Салбар нэр	Хувь
Улсын хэмжээнд	Уул уурхай	24%	Худалдаа, зочид буудал, ресторан	18%	Санхүү, бизнес	13%
Дундговь аймаг	МАА	57%	Аж үйлдвэр	18%	Бусад үйлчилгээ	13%
Өмнөговь аймаг	Уул уурхай	24%	МАА	17%	Барилга	17%
Говьсүмбэр аймаг	МАА	20%	Бусад үйлчилгээ	19%	Уул уурхай	17%
Дорноговь аймаг	Уул уурхай	31%	Бусад үйлчилгээ	21%	Санхүү, бизнес	13%
Өвөрхангай аймаг	МАА	42%	Аж үйлдвэр	19%	Бусад үйлчилгээ	16%
Архангай аймаг	МАА	57%	Аж үйлдвэр	17%	Бусад үйлчилгээ	13%
Улаанбаатар хот	Худалдаа, зочид буудал, ресторан	24%	Уул уурхай	23%	Санхүү, бизнес	16%
Төв аймаг	МАА	38%	Бусад үйлчилгээ	13%	Уул уурхай	13%

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хорооноос гаргасан мэдээлэлд үндэслэн судалгааны баг боловсруулав.

2.2 Бодлого, тэргүүлэх зорилт

2019 оны 11 сард Монгол Улсын Үндсэн Хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр Үндсэн хуульд “Хөгжлийн бодлого төлөвлөлт тогтвортой байна” гэж заасан (25.1.7). Үүний дагуу 2015 оны 11 сард батлагдсан “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль”-ийг шинэчлэн найруулж, 2020 оны 5 сарын 7-ны өдөр “Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль” хүчин төгөлдөр болсон. Уг хуульд үндэслэн 2020 оны 5 сард УИХ-ын нэгдсэн чуулганаар Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “АЛСЫН ХАРАА-2050”-ыг баталсан бөгөөд 2021 оны 3 сарын байдлаар аялал жуулчлалын хөгжлийг тодорхойлсон төрийн дээд хэмжээний урт хугацааны хөгжлийн бодлого юм. “Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль”-д “Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын хүрээнд “Хөгжлийн зорилтот хөтөлбөр”, “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр” зэрэг баримт бичгүүдийг боловсруулахаар тодорхойлсон.

“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д тусгагдсан хөгжлийн зорилтууд нь үндсэн агуулгаараа “Алсын хараа-2050”-г хэрэгжүүлэх I шатны төлөвлөгөөнд тусгагдсан тул “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” баримт бичгийг хүчингүй болгосон. Түүнчлэн “Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүнийг удирдлагын тухай хууль” батлагдахаас өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг “Алсын хараа 2050” хөгжлийн бодлогод нийцүүлэн, 2022 оны 6 сард багтаан шинэчлэхээр төлөвлөж байна.

(1) Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”

“Алсын хараа 2050” нь өнгөрсөн 30 жилийн ололт амжилтыг дүгнэж, ирэх 30 жилийн хөгжлийн зорилтыг тодорхойлох урт хугацааны хөгжлийн бодлого юм. Бодлогын баримт бичиг нь 1. Үндэсний нэгдмэл үнэт зүйл, 2. Хүний хөгжил, 3. Амьдралын чанар ба дундаж давхарга, 4. Эдийн засаг, 5. Сайн засаглал, 6. Ногоон хөгжил, 7. Амар тайван, аюулгүй нийгэм, 8. Бүс, орон нутгийн хөгжил, 9. Улаанбаатар ба дагуул хот гэсэн 9 суурь зорилгоос бүрдэж байна. Аялал жуулчлалын хөгжлийг 8. Бүс, орон нутгийн хөгжлийн зорилгод хамруулж, Монгол улсыг 6 хэсэгт бүсчлэн хувааж, тухайн бүс нутаг бүрийн хөгжлийн зорилгыг тодорхойлсон. Зорилтот хугацааг 10 жил тутмаар тогтоож, аймаг тус бүрийн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, төсвийг тодорхой тусгаж өгснөөрөө онцлогтой бөгөөд орон нутгийн хөгжлийн бодлого нь нутгийн иргэдийн нүдэнд харагдахуйц бодитой болгосон юм.

Хүснэгт 2-2: Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050” 8. Бүс нутгийн хөгжил (Судалгаанд хамрагдсан аймгуудыг улаанаар тэмдэглэв.)

Эдийн засгийн 6 бүс	Хамруулах аймаг, хот (Улаан:Судалгаанд хамрагдсан аймаг)	Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, үйл ажиллагааны ерөнхий чиглэл		
		I үе шат (2020~2030он)	II үе шат (2031~2040он)	III үе шат (2041~2050он)
Дорнод Монголын эдийн засгийн хөгжлийн тэнхлэг, үйлдвэрлэл, аялал жуулчлал, ногоон хөгжлийн бүс	Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймаг	Дэд бүтцийн тэнхлэгийн үндсэн сүлжээг байгуулж, ХАА-н боловсруулах үйлдвэр, аялал жуулчлалыг хөгжүүлэх	Усалгаатай газар тариалан, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх	Өсөлтийн төвүүдэд түшиглэсэн үйлдвэрлэл, инновацийг хөгжүүлэх
Хариуцлагатай уул уурхай, өндөр технологид суурилсан үйлдвэрлэл, үйлчилгээ, палеонтологийн аялал жуулчлалын бүс	Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь аймаг	Говийн бүсийн хэвтээ тэнхлэгийн төмөр зам, логистикийн төв, боомтыг барьж дуусгах, байгаль орчинд ээлтэй, ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх	Бүс нутгийн хөгжлийг тэтгэх хуримтлалыг нэмэгдүүлж, эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг дэмжин хөгжүүлэх үе Нано, биотехнологийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх	Нано, биотехнологийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх
Байгалийн нөөц, аялал жуулчлал, ногоон хөгжлийн бүс	Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай аймаг	Алтайн бүсийн босоо, хэвтээ чиглэлийн дэд бүтцийн үндсэн тэнхлэгүүдийг байгуулах, бэлчээрийн мал аж ахуйг дэмжих, түүхий эдийг гүн боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлж, нэмүү өртгийн сүлжээг бүрдүүлэх	Дотоодын ба олон улсын амралт, рашаан сувилал, аялал жуулчлалын сүлжээг хөгжүүлэх	Соёлын болон зугаа, цэнгэлийн олон улсын аялал жуулчлалын цогцолборыг хөгжүүлэх
Өрнөд Монголын эдийн засгийн хөгжлийн тэнхлэг, алтайн соёл, байгалийн нөөц, ногоон хөгжлийн бүс	Ховд, Баян-Өлгий, Увс аймаг	Улсын дэд бүтцийн хөндлөн тэнхлэгийн зам, боомтыг барьж дуусгах, экосистемийн унаган төрхийг хамгаалж, экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн цогцолборыг хөгжүүлэх	Алтайн түүх, соёл, зан заншил, байгалийн өвөрмөц онцлогт түшиглэсэн экологийн аялал жуулчлалын олон улсын бүс нутаг болон хөгжих	Монгол Алтай, Их нууруудын хотгорын экосистемийн давуу талд түшиглэсэн тогтвортой хөгжлийн загвар бүс нутаг болгох
Хангайн эрчимжсэн хөдөө аж ахуй, аялал жуулчлал, ногоон хөгжлийн бүс	Сэлэнгэ, Дархан Уул, Орхон, Булган, Архангай, Хөвсгөл, Завхан аймаг	Орхон-Тамирын бэлчирт нийслэлийн баримжаатай шинэ хот, Хангай ба говийн урд бүсийг холбосон босоо тэнхлэгийг байгуулж олон улсын жишигт нийцсэн үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх	Эрчим хүчний системүүдийг холбож, нэгдсэн системийг үүсгэх, харилцаа холбооны дэд бүтцийг байгуулах	Нүүдлийн соёл иргэншил, монгол туургатны өв уламжлалыг сонирхсон жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх
Олон улсын шинжлэх ухаан, технологийн төв, тээврийн зангилаа, өндөр технологийн үйлдвэрлэл, үйлчилгээний бүс	Төв аймаг, Улаанбаатар хот	Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурласан, эрчимтэй хөгжиж буй дагуул хотуудыг үйлдвэрлэл, үйлчилгээ, логистик, хүнс, хөдөө аж ахуйн чиглэлүүдээр дагнан хөгжүүлэх	Төрөөс олон нийтэд үзүүлэх нийгмийн үйлчилгээний стандартыг олон улсын түвшинд хүргэх	Ухаалаг системд тулгуурласан, өрсөлдөх чадвартай, шинжлэх ухаан, тэргүүний технологи, инноваци нэвтрүүлсэн олон улсын худалдаа - бизнесийн төв болгон хөгжүүлэх

Эх сурвалж: ЖАЙКА-ийн материалд тулгуурлан судалгааны баг боловсруулав.

(2) Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл

2021-2025 оны хөгжлийн үндсэн чиглэлийн 4-р бүлэгт эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүдийн гуравдугаарт аялал жуулчлалын хөгжлийг дурдаж, “Үндэсний онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, олон улсын аялал жуулчлалын зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ” гэж тодорхойлжээ. Мөн 8-р бүлгийн Бүс, орон нутгийн хөгжлийн хүрээнд дэд бүтцийн хөгжлийн дараагаар аялал жуулчлалын хөгжлийг онцолсон. Доорх зорилгыг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээ, төсөв санхүү, хөрөнгө оруулалт, хариуцах байгууллагуудын талаар таван жилийн үндсэн чиглэлийн хавсралт болох “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр (PIP) ”-т тусгасан.

1. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар, стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн жуулчдын тоог нэг саяд хүргэнэ.
2. Мянганы суут хүн Чингис хаан цогцолбор” байгуулж, Монголын нууц товчооны дурсгалт газруудыг хамгаалах, олон улсад сурталчлан таниулах, дэд бүтцээр холбох ажлуудыг үе шаттай зохион байгуулж, түүхэн аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
3. Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийг Хөвсгөл, Хэнтий, Архангай, Баян-Өлгий, Увс, Ховд, Завхан зэрэг аймагт хэрэгжүүлж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын орлогыг нэмэгдүүлнэ.

(3) Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр

2020 оны Монгол Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар батлагдсан. Уг үйл ажиллагааны хөтөлбөрийг 2020 оны УИХ-ын сонгуульд ялалт байгуулсан шинэ Засгийн газраас (Ерөнхий сайд улиран ажилласан) Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”, МАН-ын 2020 оны сонгуулийн мөрийн хөтөлбөрт нийцүүлэн боловсруулсан. Үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.Хүний хөгжлийн бодлогын “Үндэсний бахархал, өв соёл” хэсэгт “Чингис хаан” хаад, язгууртны музей, байгалийн түүхийн музей; үндэсний номын сан; үндэсний урлагийн их театр; үндэсний археологи, палеонтологи, угсаатны зүйн музей, лаборатори барих зорилго дэвшүүлсэн. 3-р бүлгийн Эдийн засгийн бодлогод уул уурхай хүнд үйлдвэр, хүнс ХАА, хөнгөн үйлдвэрийн дараагаар аялал жуулчлалыг онцолж, байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогыг дэлгэрэнгүй тодорхойлж өгсөн. Үндсэндээ “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл”-д дурсан агуулгатай ижил боловч, илүү дэлгэрэнгүй зүйлийг доор дурдав.

- Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогын хүрээнд “Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл-1”-ийг Хөвсгөл, Хэнтий, “Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл-II”-ийг Архангай, Баян-Өлгий, Өвөрхангай, Увс, Ховд зэрэг аймагт хэрэгжүүлж, орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжийн орлогыг нэмэгдүүлнэ.
- Түүхэн аялал жуулчлалыг хөгжүүлэх ажлын хүрээнд “Мянганы суут хүн Чингис хаан цогцолбор”-ын ажлуудыг цогц байдлаар дуусгаж, Монголын нууц товчооны дурсгалт газруудыг хамгаалах, олон улсад сурталчлан таниулах, дэд бүтцээр холбох ажлуудыг үе шаттайгаар зохион байгуулна.
- Манзуширын түүхэн дурсгалт газрыг түшиглэн соёл, шашин, аялал жуулчлалын олон улсын цогцолбор байгуулах ажлыг эхлүүлнэ.
- Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар, стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, иргэд, жуулчдын тоог нэг саяд хүргэнэ.
- Монголын нүүдлийн соёлын онцлогт тохирсон үндэсний шинэлэг, сор бүтээл, брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэж, аялал жуулчлалыг дэмжинэ.
- Баян-Өлгий, Увс, Ховд, Өвөрхангай, Архангай, Баянхонгор, Өмнөговь, Дорнод, Завхан аймгуудад аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлж, отоглох цэг, авто зам дагуу үйлчилгээний цогцолборуудыг байгуулна. Говийн бүсийн аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
- Хил орчмын аялал жуулчлалыг дэмжиж, жуулчдын тоог нэмэгдүүлнэ.
- “Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд аялал жуулчлалын салбарт технологийн дэвшил нэвтрүүлж, гадаад сурталчилгааг өргөжүүлнэ.
- Аялал жуулчлалын сургалтын төв байгуулж, салбарын чадварлаг хүний нөөцийг бүрдүүлнэ.

(4) Гурван тулгуурт хөгжлийн бодлого

2018 оны 2 сард Монгол Улсын Их Хурлаар баталсан. 2018-2020 онд төрийн тогтолцоог бэхжүүлж, нэгдсэн бодлогоор эдийн засгийн өрсөлдөх чадвараа дээшлүүлж, иргэдийнхээ амьдралын түвшнийг сайжруулах зорилготой бодлогын баримт бичиг бөгөөд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбар, худалдаа, аялал жуулчлал, дэд бүтцийн гэсэн 3 чиглэлээр тулгуур болгож эдийн засгийн хөгжлийг хурдасгах бодлогыг

баримталсан юм. Аялал жуулчлалын салбарын хувьд “аялал жуулчлалын дэд бүтэц, өрсөлдөх чадварыг бүс нутгийн хэмжээнд дээшлүүлж, тухайн орон нутгийн онцлогт тулгуурласан иргэдийн оролцоотой тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх” зорилт дэвшүүлсэн. 2020 онд ерөнхийдөө хэрэгжээд дууссан. Байгал орчин, аялал жуулчлалын яамнаас авсан судалгаагаар аялал жуулчлалын салбарын хувьд доорх үр дүнд хүрсэн гэж дүгнэсэн байна.

- Газарзүйн онцлог, байгаль, түүх, соёлын өв, нүүдэлчин ахуйд тулгуурлан өөрийн өвөрмөц онцлог бүхий аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг бүсчлэн хөгжүүлэхэд анхаарч урт хугацааны бодлогын баримт бичиг “Алсын хараа 2050”-д бүсчлэн хөгжүүлэхээр заасан.
- Гадаадын жуулчдад үйлчилж байгаа тур оператор, жуулчны бааз, зочид буудлын үйлчилгээг экспорт, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих чиглэлд оруулж, НӨАТ-д хамруулах эрх зүйн орчныг бүрдүүлсэн.
- Дэлхийд Монгол улсын үнэлэмж, байр суурь, монгол хүний үнэ цэнийг нэмэгдүүлэх бүтээгдэхүүн, үйлчилгээг таниулах ажлыг тухайн жилийн төсвийн 30 гаруй хувийг хуваарилан, тогтмол зохион байгуулж ирсэн.
- Хөрш орнуудтай хамтран ажиллаж, Монгол, БНХАУ, ОХУ-ын аялал жуулчлалын сайд нарын уулзалтыг зохион байгуулж, хамтарсан аяллын бүтээгдэхүүн, маршрут бий болгоход санал солилцон ажиллаж байна.
- Тусгай хамгаалалттай газар нутагт тогтвортой, хариуцлагатай аялал жуулчлалыг хөгжүүлэх суурийг тавьж аяллын брэндбүүк, буудаллах зааврыг боловсруулж батлуулсан.
- Зүүн бүс түүх-аялал жуулчлалын, төвийн бүс байгаль, аялал жуулчлалын, баруун бүс угсаатан, адал явдалт аялал жуулчлалын, говийн бүсийн палеонтологи, говийн аяллын төрөл хэлбэрийг өргөжүүлэн хөгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.
- Аяллын гол чиглэлийн авто зам дагуу түр буудаллах цэг, үйлчилгээний цогцолбор байгуулах ажлыг дэмжих зохион байгуулж жил бүр тоог нэмэгдүүлж байна.
- Аялал жуулчлал хөгжүүлэх бүс нутагт олон улсын түвшинд нийцсэн аялал жуулчлалын парк, аялал жуулчлалын томоохон цогцолбор барьж байгуулах хүрээнд Хэнтийн аймгийн 6 суманд Их эзэн Чингис хааны түүх, 13-р зууны үеийн түүхийг илэрхийлсэн түүхэн аялал жуулчлалын цогцолборыг байгуулах ажил эхлүүлээд явж байна.
- Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийн хүрээнд Увс, Ховд, Хөвсгөл аймгуудад бүтээн байгуулалтын ажлууд хийгдэхээр ТЭЗҮ боловсруулагдаж байна.
- Жил бүр зохион байгуулагддаг олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн яармагт Монгол улсыг төлөөлөн аялал жуулчлалын байгууллагууд маань нэгдсэн агуулгын дор сурталчилгаа хийн оролцож байна.
- Аялал жуулчлалын үйлчилгээний ажилтан бэлтгэх мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв байгуулахыг бодлогоор дэмжиж, боловсон хүчин бэлтгэх, дадлагажуулах үйл ажиллагаанд төр хувийн хэвшлийн хамтын оролцоон нэмэгдүүлэх замаар орон нутгийн салбарын мэргэжилтнүүдийг чадавхижуулах сургалтыг дэмжин зохион байгууллаа. Цаашид төрөлжсөн байдлаар сургалтуудыг тогтмол зохион байгуулахаар ажиллаж байна.

(5) 2019-2026 онд Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого

2019 оны 8 сард батлагдсан. Засгийн газрын зүгээс Монгол улсын аялал жуулчлалын бодит байдалд дүн шинжилгээ хийж, “Монгол улс нүүдлийн соёл, түүхэн аялал жуулчлалын олон улсын төв болно” хэмээн бодлогын алсын харааг дэвшүүлж, “Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлогын зорилго нь үндэсний онцлог бүхий, хүрээлэн буй орчинд ээлтэй, нутгийн иргэдэд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлж, олон улсын аялал жуулчлалын зах зээлд Монгол улсын өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд оршино” хэмээн тусгасан. Улмаар Засгийн газрын зүгээс авч хэрэгжүүлэх бодлогын зорилтуудыг тодорхой дэвшүүлж, үүнд “аялал жуулчлалын салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох; аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэх; гадаад сурталчилгаа, маркетингийн ажлыг эрчимжүүлэх; эрүүл ахуй,

үйлчилгээний чанар, стандартыг сайжруулах; хүний нөөцийн ур чадварыг дээшлүүлж, чадавхижуулах; цахим аялал жуулчлалыг хөгжүүлэх” хэмээн тусгасан байна. Бодлогыг 2 үе шаттайгаар хэрэгжүүлэх бөгөөд, I үе шат болох 2019-2022 онд аялал жуулчлалын салбарыг хөгжлийг эрчимжүүлэх, II үе шат буюу 2023-2026 онд аялал жуулчлалын салбарын өсөлтийг баталгаажуулахаар төлөвлөсөн. Бодлогын зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд “аялал жуулчлалын тухай хуулийг шинэчлэн өөрчлөх; аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх бага хүүтэй зээл олгох; аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор “Аялал жуулчлалын сан”-г бий болгох; цахим виз нэвтрүүлэх; казино болон хурдан морины бооцоот уралдааны газар барих; орон нутгийн нисэх буудлыг олон улсын нисэх буудал болгон хөгжүүлэх; авто замын сүлжээг сайжруулж, замын тэмдэг, тэмдэглэгээг байршуулах” зэрэг 77 төрлийн зорилтыг тусгасан хэдий ч, хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн эс үүсвэрийн талаар огт дурдаагүй болно.

(6) Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр

2015 оны 8 сард Монгол Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар батлагдсан. 2015 оны 11 сараас мөрдөгдөж байсан “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль”-ийн 10-р зүйлд “Үндэсний хөтөлбөрт төрөөс баримтлах бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, арга хэмжээг нарийвчлан төлөвлөсөн байна” хэмээн тодорхойлсон, мөн “Өмнө батлагдсан ижил төстэй үндэсний хөтөлбөрийн үндсэн зорилт, агуулгын хүрээнд аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг шинэчлэн боловсруулна” хэмээн заасан хэдий ч шинэчлэгдээгүй явсаар, дээрх “2019-2026 онд Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого”-д үндсэн агуулгыг тусгаж өгсөн. 2020 оны 5 сарын 7-ны өдөр батлагдсан “Хөгжлийн бодлого, төлөвлөлт, удирдлагын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгад “Үндэсний хөтөлбөр” гэдэг нэр томъёог “Хөгжлийн зорилтот хөтөлбөр” гэж өөрчлөгдсөн бөгөөд тус хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсний дараа батлагдсан “Алсын хараа 2050” хөгжлийн бодлогод нийцүүлэн 2022 оны 6 сард багтаан уг хөгжлийн зорилтот хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж их хуралд өргөн мэдүүлэхээр төлөвлөж байна.

(7) Газрын нэгдмэл сангийн (ULTF) аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөө - Аялал жуулчлалын бүсийн төлөвлөгөө

Газрын нэгдмэл сангийн “Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө”-ний үндсэн зорилго нь газрын нөөц, нэгдмэл сангийн иж бүрэн мэдээлэл, судалгаа, шинжилгээ, нийгэм, эдийн засгийн бусад мэдээлэлд үндэслэсэн газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээнд нийцүүлэн газар ашиглалт, хамгаалалтын үр ашгийг дээшлүүлэх, газрыг иргэд болон нийгмийн хэрэгцээнд тэгш, шударга, хүртээмжтэй байдлаар хуваарилах замаар эрх зүйн болон эдийн засгийн хувьд үндэслэл сайтай, үр ашигтай, экологийн тэнцвэрт байдлыг хангасан газар зохион байгуулалт, газрын кадастрыг хөгжүүлж, газрын нөөцүүдийг оновчтой ашиглах, үйлдвэрлэлийн салбаруудыг зөв байршуулж төрөлжүүлэн хөгжүүлэх, “Монгол Улсын тогтвортой хөгжил-2030”-ийг хэрэгжүүлэхэд газрыг менежментийн бодлогоор дэмжих суурь үндэслэлийг бий болгоход оршино.

Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний нэг бүрэлдэхүүн хэсэг бол улсын хэмжээнд аялал жуулчлалын хөгжлийн чиг хандлага, аялал жуулчлалын бүс нутгийг ерөнхийд нь төлөвлөж, тэргүүлэх зорилтуудыг тодорхойлох асуудал болно. Дээрх төлөвлөгөө нь улсын хэмжээнд аялал жуулчлал хөгжүүлэхэд байгаль, газрын өөрийнх нь тогтоц, байршил, маршрут, одоогийн хөгжлийн чиг хандлагыг тооцож, газрын зурагт байршлыг тодорхойлсноороо онцлог юм. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд олон яамдын оролцоо, санхүү хөрөнгө оруулалт, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа чухал шаардлагатай. БОАЖЯ-тай хамтран аялал жуулчлалын талаар хэрэгжүүлэх бодлогыг дэмжих, газар олголт, хуваарилалт, газрыг тусгай хэрэгцээнд авах зэрэг ажлыг хамтран зохион байгуулдаг.

(8) Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого доторх аялал жуулчлалтай холбоотой салбаруудыг дэмжих арга хэмжээ (Ноос ноолуур, арьс шир, мах, мал аж ахуй, сүүн бүтээгдэхүүн, хоол хүнс, биотехнологи зэрэг)

Аж үйлдвэрийн салбар нь төр, шинжлэх ухаан, хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд түшиглэсэн, дэвшилтэт техник, технологи, өндөр бүтээмж, өрсөлдөх чадвар бүхий экспортыг дэмжих, импортыг орлох үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах салбар мөн бөгөөд төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого нь дэвшилтэт техник,

технологи, өндөр технологи, өрсөлдөх чадвар бүхий үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгож, аж үйлдвэрийн салбарыг Монгол улсын эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах тэргүүлэх салбар болгон хөгжүүлэхэд чиглэнэ.

Бодлогын хүрээнд жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийг 2019 оны 6 дугаар сард УИХ-ын нэгдсэн чуулганаар баталсан. Мөн ЗГ-ын тогтоолоор “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр”, Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих тэргүүлэх чиглэл”, “Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр”, “Ахуйн үйлчилгээний салбарыг дэмжих хөтөлбөр”-ийг батлуулж, хууль эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр тодорхой ахиц гарсан. “Бүс нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх тэргүүлэх чиглэлүүдийг тогтоон, үйлдвэрийг кластераар хөгжүүлэх стратегийг боловсруулан, үйлдвэрийн кластер, чөлөөт бүс, үйлдвэрлэл, технологийн паркийг эдийн засгийн тооцоо, үр өгөөжид үндэслэн дэд бүтцийн хамт цогцоор нь төлөвлөн хэрэгжүүлэх зорилт”-ыг хэрэгжүүлэх арга хэмжээнээс үйлдвэрийг кластераар хөгжүүлэх, түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоог бүрдүүлэх арга хэмжээ бүрэн хэрэгжсэн. Харин хөнгөн аж үйлдвэрийн үйлдвэрлэл технологийн паркийн бүтээн байгуулалтын ажил санхүү, хөрөнгө оруулалтын асуудал шийдэгдээгүйгээс ажлын явц удаашралтай байна. Аж үйлдвэрийн тээвэр, логистикийн нэгдсэн сүлжээг бүрдүүлэх арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай байна. “Үйлдвэрлэлийн хүний нөөцийн эрэлтэд суурилсан ажиллах хүч бэлтгэж, тогтвор суурьшилтай ажиллах орчин, нөхцөлийг бүрдүүлэх зорилт”-ын хүрээнд “Мэргэжилтэй ажилтан хөтөлбөр”-ийг боловсруулж, батлуулах арга хэмжээ удаашралтай байна.

2.3 ЖАЙКА-ийн зүгээс аялал жуулчлалын салбарт хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр

1998 оны 3 сараас 1999 оны 7 сар хүртэл “Монгол Улсад Үндэсний Аялал Жуулчлалыг Хөгжүүлэх Мастер Төлөвлөгөө”-г боловсруулах судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн. Судалгаанд Монгол улсыг бүхэлд нь хамруулсан бөгөөд Хархорин орчмын бүс нутгийг голчлон анхаарсан. Ерөнхийдөө Монгол улсын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд шаардлагатай төсөл хөтөлбөр, арга хэмжээ болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай өртөг төсвийн тооцоог боловсруулж, хөнгөлөлттэй зээлээр санхүүгийн гол эх үүсвэрийг бүрдүүлэх, энэхүү зээлээ жуулчдын байрласан зочид буудлынхаа үнэд төлсөн төлбөрт ногдуулах татварын орлогоос (татварын дээд хэмжээ 6.9%) төлж барагдуулах боломжтой байх саналыг дэвшүүлсэн. Уг судалгаа нь Монгол улсын аялал жуулчлалын хөгжлийг цогцоор нь судалсан анхны судалгаа бөгөөд 2005, 2015 он хүртэл хэрэгжүүлэх тэргүүлэх чиглэлийн төсөл хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөг тухайн үед аялал жуулчлалын асуудлыг хариуцаж байсан Дэд бүтцийн Хөгжлийн Яамтай зөвшилцсөний үндсэн дээр боловсруулсан.

Уг судалгааны тайлан нь Монгол улсын аялал жуулчлалын салбарын судлаачдын хувьд чухал үүрэг гүйцэтгэсээр ирснийг тэмдэглэх нь зүйтэй. Нөгөөтгээгүүр, зах зээлийн нийгэмд шилжсэний дараах нийгэм, эдийн засгийн байдал тогтворгүй үед хийгдсэн учир, төсөв санхүүгийн асуудал, боловсон хүчний хомсдол, аялал жуулчлалын асуудал хариуцсан төрийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт зэрэг хэд хэдэн хүчин зүйлийн улмаас өнөөдрийг хүртэл бүрэн хэрэгжээгүй ажлууд олон байна. Сүүлийн жилүүдэд зарим нэг ахиц гарч, тодорхой түвшинд үр дүнгээ өгч буй ажлууд ч байна. Өнөөг хүртэл хэрэгжээгүй байгаа зүйлс нь өнөөдрийн нөхцөлд ч асуудал бэрхшээл байсаар буйг илэрхийлж байгаа гэж үзвэл, уг судалгаа нь Монгол улсын аялал жуулчлалын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох чухал баримт бичиг болохыг харуулж байна.

Тэргүүлэх чиглэлийн төсөл хөтөлбөрүүдийн биелэлт ихэнх нь дутуу байгаа гол шалтгаан нь дотоодод хийгдэх ажлууд огт хийгдээгүйтэй холбоотой бас социалист нийгмээс зах зээлийн эдийн засгийн систем рүү шилжих ороо бусгаа үе давхцаж, Засгийн газар удаа дараа солигдох зэрэг төрийн тогтворгүй байдал, хөрөнгө санхүүгийн хомсдол, аялал жуулчлалын талаарх ойлголт сул зэрэг хүчин зүйлүүд ч нөлөөлсөн гэж үзэж байна. Тэр утгаараа судалгааг хэрэгжүүлэхэд цаг хугацааны хувьд эртгэдсэн гэж дүгнэж болно. Гэвч аялал жуулчлалын хөгжлийн чиг хандлагыг сайтар тодорхойлж чадсан анхны баримт бичиг болох нь гарцаагүй.

Мастер төлөвлөгөөний хүрээнд Улаанбаатар, Хархорин, Өмнөговь гэсэн 3 бүс нутгийг сонгон авч, хөгжлийн загвар боловсруулсан. Мөн 42 төрлийн тэргүүлэх төсөл хөтөлбөрийг санал болгосон байна. Энэхүү тайланд энэ удаагийн судалгаанд хамрагдах Улаанбаатар, Дорноговь, Өмнөговь, Хархорин гэсэн 4 бүс нутагт биелэлт хэр байгааг аялал жуулчлалын мэргэжилтний

саналд үндэслэн нэгтгэн боловсруулав.

Хүснэгт 2-3: Мастер төлөвлөгөөний хэрэгжилтийн төлөв, бүс нутгаар (Улаанбаатар, Өмнөговь, Хархорин)

1999 оны ЖАЙКА-ийн санал	Хэрэгжилтийн төлөв
Улаанбаатар хот	
Жуулчдын аяллын алхдаг зам байгуулах (Хотын аяллын маршрут болгож хөгжүүлэх)	Хотын аяллын маршрут болж чадаагүй.
Жуулчдын гудамж	Хэрэгжээгүй
Шувууны парк (Шувуу ажиглах байгууламж)	Хэрэгжээгүй
Морьдын хүрээлэн барих (Морин тойруулга, Морины музей)	Хэрэгжээгүй
Гар урлалын төв	Хэрэгжээгүй
Богд хааны ордон музейг засаж сайжруулах (Хотын аялал жуулчлалын төв болгох)	Дутуу хэрэгжсэн. БНХАУ-ын тусламжаар засвар хийсэн боловч, соёлын өвийг хамгаалах үүднээс учир дутагдалтай.
Монголын соёлын парк	Номадик Монголиа (хувийн хэвшил) байгуулагдсан
Экотуризм хөгжүүлэх төлөвлөгөө	Хувийн хэвшлийн санаачилга давамгайлж буй
Хөтчийн сургалт	Ихэнх их дээд сургууль, МСҮТ дээр аялал жуулчлалын чиглэлээр мэргэжилтэн бэлтгэж эхэлсэн.
Тэрэлж зэрэг АЖ цэг хүртэлх зам	Дууссан
Дээрх замын тэмдэг тэмдэглэгээ, аялал жуулчлалын газрын мэдээллийн самбар, гэрэлтүүлэг	Дутуу хэрэгжсэн
Хархорин	
Эрдэнэ Зуу хийд болон ойр орчмыг тохижуулах	Орчны тохижилт хийгдсэн
Жуулчдын мэдээллийн төв байгуулах	Хэрэгжсэн
Хархориныг Түрэгийн хөшөөтэй холбосон зам барих	Турк Улсын тусламжтайгаар хийсэн.
Хархорины нисэх буудлыг сайжруулах	Ирээдүйн төлөвлөгөө (ЗГ анхаарч буй)
Аяллын цэгүүд хүрэх замын тохижилт	Зарим хэсгийн замыг сайжруулсан.
Замын тэмдэг тэмдэглэгээ	Дутуу хэрэгжсэн
Өмнөговь	
Ёлын амын музейн тохижилт	Хэрэгжсэн
Тойрон аялал хийх аяллын отгийг сайжруулах	Хувийн хэвшлийн зүгээс заримыг нь хэрэгжүүлсэн
Аялал жуулчлалын гол газруудад амрах байр байгуулах	Дутуу хэрэгжсэн
Аймгийн төвөөс Сэврэй сум хүртэл зам барих, замын тэмдэг тэмдэглэгээ тавих	Хатуу хучилттай зам тавьсан
Гэр баазын хувийн нисэх буудлыг сайжруулах	Олон улсын нисэх буудал болгохоор ЗГ-ын төлөвлөгөөнд тусгасан
Өмнөговь аймгийн баруун бүсэд шинэ нисэх онгоцны буудал барих	Хэрэгжээгүй

Эх сурвалж : Судалгааны баг

Хүснэгт 2-4: Тэргүүлэх чиглэлийн төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн төлөв

Тэргүүлэх чиглэлийн хөтөлбөрүүд			
А ХӨТӨЛБӨРҮҮД			
1 Засаг захиргааны байгууллагуудыг бэхжүүлэх			
Хөтөлбөрийн нэрс		Хэрэгжилтийн төлөв	Экспертийн дүгнэлт (Хөндлөнгийн)
А-1	Аялал жуулчлалын үндэсний зөвлөлийг тогтмол ажиллуулах	Аялал жуулчлал хариуцсан төрийн байгууллагын бүтэц өөрчлөгдсөн	Аялал жуулчлалын газар нь 1998 онд Дэд бүтцийн хөгжлийн яамны бүтцийн хүрээнд байгуулагдсан бөгөөд одоо БОАЖЯ-ны АЖ-ын бодлого зохицуулалтын газар болсон. Үүний дүнд АЖ-ын салбарын чадавх сайжирсан гэж дүгнэхэд учир дутагдалтай. Дэд бүтэц, байгаль орчин, эдийн засгийн олон хүчин зүйлээс шалтгаалах АЖ-ыг яамны газрын хэмжээнд байх нь зүйтэй эсэх талаар анхаарах шаардлагатай. АЖ-ын тухай хуульд аялал жуулчлалын үндэсний зөвлөлийг байгуулж ажиллуулах талаар заасан. Сүүлийн жилүүдэд энэ зөвлөлийг ажилд оруулахаар хэдэн удаа оролдож, бүрэлдэхүүнийг нь хүртэл сонгож байсан ч нэг ч удаа хуралдаагүй, цаасан дээрх зөвлөл болсон.
А-2	Аялал жуулчлалын газар, Аялал жуулчлалын үндэсний зөвлөлийн хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах замаар аялал жуулчлалын удирдлагыг бэхжүүлэх	Дутуу хэрэгжсэн	Дээр дурдсаны дагуу АЖ-ыг хариуцах төрийн захиргааны төв байгууллага өөрчлөгдсөн бөгөөд өнөөдөр Аялал жуулчлалын агентлаг байхгүй. Байгаль орчин аялал жуулчлалын сайдын дэргэд “мэргэжлийн зөвлөл” байгуулагдаж яам болон ТББ-уудаас төлөөлөл оролцож, 3-4 удаагийн хурал хийсэн. Энэ нь төр ба хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хангахад чиглэгдсэн боловч байгууллагуудыг сонгох, хурлын давтамж, шийдвэр гаргах статус зэрэг асуудлыг сайжруулах шаардлагатай.
А-3	Аймгуудын АЖ-ын засаг захиргааны байгууллагуудыг бэхжүүлэх	Хэрэгжилтийн төлөв нь аймаг болгонд өөр байна. Өмнөговь, Дорноговь, Дорнод аймгууд нь сайн ажиллаж байна.	Аймаг бүрт АЖГ, эсвэл АЖ-ын хэлтэстэй байхаар санал болгосон хэдий ч, одоогоор аймгийн захиргааны нэгжид БОАЖ-ын газар байгуулагдаж, АЖ хариуцсан 1 ажилтан томилогдож ажиллаж байна. Нөгөө талаас АЖ-ын асуудлыг Засаг дарга дур мэдэж шийдвэр гаргах зэрэг, уг

			хөтөлбөрийг хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчин сул, албан ёсны бүтэц зохион байгуулалт байхгүй байна. Бүх Засаг даргын мөрийн хөтөлбөрт аялал жуулчлалыг оруулсан байдаг боловч бодит ажил болж чадахгүй байна.
2 Хүний нөөцийг хөгжүүлэх			
A-4	Аялал жуулчлалын хүний нөөцийг хөгжүүлэх сургалтыг сайжруулах	Бүрэн хэрэгжээгүй	Их дээд сургууль, МСҮТ-д аялал жуулчлалын чиглэлийн анги танхим нээгдсэн нь дэвшилттэй тал боловч, сургалтын чанарыг сайжруулах шаардлагатай. Мөн гадаадын жуулчдын эрэлт хэрэгцээг хангаж чадаж байгаа гэж хэлэхэд хэцүү. Төрөөс явуулж байгаа сургалт нь ажилгүйдлийг бууруулах ач холбогдолтой хэдий ч ажилд орсон хувь хэмжээ зэрэг үр дүнг шалгаж дүгнэх шаардлагатай. Сургалт нь салбарын ажилтны ур чадварыг дээшлүүлэх агуулгатай байвал илүү үр дүнтэй болно.
A-5	Байгаль хамгаалагчдын сургалт явуулах (БОАЖЯ)	Ахиц гарсан	1999 онд байгаль хамгаалагчдад зориулсан сургалт явуулдаггүй байсан бол одоо төрөл бүрийн сургалтыг явуулж байна. Байгаль хамгаалагч нар нь тодорхой тусгай хамгаалалттай газар нутгуудад харьяалагддаг бөгөөд Хустай, Өмнөговийн Хонгорын элс, Улаанбаатар хотын ойролцоох Тэрэлж зэрэг цөөн газруудад байгаль хамгаалагч нарт зориулсан аялал жуулчлалын шинжтэй сургалтыг үе үе зохион байгуулж, цаашид мэргэжлийн ур чадвар нь улам сайжирна гэж найдаж байна.
3 Эрх зүйн зохицуулалтыг сайжруулах			
A-6	Аялал жуулчлалын салбар дахь хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих	Хэрэгжээгүй	Аялал жуулчлалын салбарын тулгуур эрх зүй болсон Аялал жуулчлалын тухай хууль 2000 оноос хойш огт шинэчлэгдээгүй. Иймд аялал жуулчлалын тухай хуультай хамааралтай хөрөнгө оруулалт, газар ашиглалт зэрэг хууль эрх зүйн орчин сайжраагүй байна. Аялал жуулчлалын салбарт хөрөнгө оруулалтын хөнгөлөлттэй тогтолцоо нэвтрээгүй. Улирлаас хамаарахгүй аялал, экологийн буюу байгальд ээлтэй аялал гэсэн үзэл санаануудыг гаргасан боловч түүндээ тохирсон санхүүгийн

			хөшүүрэг, хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих бодлого байхгүй байна.
A-7	Газар ашиглалтад тавих хяналтын арга хэмжээнүүд	Хэрэгжээгүй	Аялал жуулчлалыг хөгжүүлэх талаас нь харвал, хөтөлбөр нь хэрэгжээгүй. Гол асуудал нь Улаанбаатар хотын Богд уулын дархан цаазат газар, Горхи Тэрэлжийн байгалийн цогцолборт газар, Хөвсгөл аймгийн баруун, зүүн эргүүд, Өвөрхангай аймгийн Хархорин, Өмнөговь аймгийн зарим хэсгүүд дэх жуулчны бааз, эко гэр, гэйст хаус, жуулчны лодж, зэрэг газруудын газар төлөвлөлт, ашиглалтад хяналт тавьж чадаагүй явдал. Одоогоор АЖ-ын зориулалтаар газар ашиглах заавар журам байхгүй учир, зориулалтын газрыг хэмжээнээс хэтрүүлэн газар авах, хашаа хайс барьж амьтдын амьдрах орчныг устгаж үгүй хийх, байгаль орчныг бохирдуулах зэрэг асуудлууд үүсэж байгаа учир АЖ-ын зориулалтаар газар ашиглах стандарт, норм норматив байх шаардлагатай.
A-8	Лицензийн журам	Хэрэгжээгүй	Мэргэжлийн багш, орчуулагч, хөтөч, бэлтгэх лицензийн журам хэрэгжээгүй.
A-9	Аюулгүй байдлыг хангах жишиг	Хэрэгжээгүй	Онцгой байдлын үед үйлчлүүлэх эмнэлэг, зөөн тээвэрлэх арга хэрэгсэл, түр орогнох газрын тухай мэдээ мэдээллийг боловсруулах, галын аюулын үед хариуцах ажилтныг томилох зэрэг ажлуудыг нэн даруй шийдвэрлэх шаардлагатай
4 Хөгжлийн хөтөлбөрүүд			
A-10	Монголын соёлын өвийг хамгаалах	Дутуу хэрэгжсэн	Биет ба биет бус соёлын өвийг хамгаалах хэд хэдэн хөтөлбөрүүд хэрэгжсэн боловч соёлын өвүүдийг аялал жуулчлалын үзмэр болгох, аялал жуулчлалын бизнес эрхлэгчдийн соёлын өвийг хамгаалахтай холбоотой үйл ажиллагаа, хөтөлбөрүүд дутмаг. Амарбаясгалангийн хийд, Чойжинлхамын сүм зэрэг соёлын өвийг хамгаалах талаар анхаарах газрууд олон байна.
A-11	Хархорины эртний түүх дурсгалт	Дутуу хэрэгжсэн	Танилцуулах самбар, үзмэрүүдэд хүрэх зам, талбай, машины зогсоол

	газруудыг олон нийтэд танилцуулах байгууламж байгуулах		зэрэг зарим ажил хэрэгжсэн. Эрдэм шинжилгээний судалгааны байгууллагуудын хийсэн судалгааны ажлууд олон байгаа ч аялал жуулчлалын салбарт авч ашиглахад хангалтгүй.
A-12	Олон улсын агаарын тээврийн үйлчилгээг сайжруулах	Дутуу хэрэгжсэн	Нислэгийн үнийг зохистой түвшинд барих, гадаадын авиа компаниудтай хамтарч ажиллах санал дэвшүүлсэн боловч, МИАТ-ын үнэ өндөр хэвээрээ байсаар л байна. МИАТ компанийн Монголын агаарын тээврийн салбар дахь монополь эрх бага багаар суларч, төрөөс агаарын тээврийг либералчлах бодлого баримталж байгаа боловч үйлчилгээний чанарыг сайжруулах, үнийг тогтоох, аялал жуулчлалын компаниудаас зарладаг багц аяллын хөтөлбөрт хамтарч оролцох зэрэг өрсөлдөөнийг бий болгох явц удаашралтай байна.
A-13	Орон нутгийн агаарын тээврийн үйлчилгээг сайжруулах	Хэрэгжээгүй	Засгийн газраас хэд хэдэн аймгийн нисэх онгоцны буудлуудыг олон улсын статустай болгохоор төлөвлөж байгаа боловч нислэгийн чиглэл болон хөрөнгө оруулалтын асуудал тодорхойгүй байна.
A-14	Төмөр замын үйлчилгээг сайжруулах	Дутуу хэрэгжсэн	Улаан Уул өртөө орчмыг хөгжүүлэх санал дэвшүүлсэн. Бүрдэнэ булагт рашаан сувиллын газар байгуулагдсан. Төмөр зам нь Монгол Оросын хамтарсан компани бөгөөд үйлчилгээний зарим нэг стандартуудыг бий болгож, аялал жуулчлалын үйлчилгээг сайжруулахаар ажиллаж байгаа боловч хангалтгүй байна.
A-15	Малчдын оролцоог дэмжих		Аялал жуулчлалаас олсон орлогыг нутгийн иргэдэд эргүүлэн оруулах тогтолцоог бүрдүүлэх талаар санал болгосон бөгөөд бэлэг дурсгалын зүйлс, гэр бааз зэрэг зарим газруудад үр дүн гарч байгаа боловч, аялал жуулчлалын салбарт малчдын оролцоог нэмэгдүүлэх талаар төрөөс нэгдсэн бодлого чиглэлээр дэмжиж, идэвх санаачилгатай ажиллах шаардлагатай байна. БОАЖЯ, Соёлын Яам, орон нутгийн засаг

			захиргааны хамтын ажиллагаа шаардагдаж байна. Хувийн хэвшлийнхэн энэ талаар идэвхтэй ажиллаж байна. БОАЖЯ-ны зүгээс “Community based tourism” буюу нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал гэсэн үзэл санааг дэвшүүлсэн боловч цаашид үргэлжлүүлэх эсэх нь тодорхойгүй.
A-16	Археологийн болон зэрлэг ан амьтан, ургамлын нөөцийн үндэсний зурагт каталог, газрын зураг бүтээх	Хэрэгжээгүй	Ургамалын нөөц, шашин, сүм хийд, ан амьтны зарим газрын зургууд бүтээгдсэн боловч соёлын аялал, байгалийн аялал, адал явдалт аяллын төрөл чиглэлүүдээр албан ёсоор аялал жуулчлалын компаниудтай хамтарсан газрын зураг хийгдээгүй. Тодорхой хэдэн компаниуд өөрсдийнхөө хэрэглээний хүрээнд хийж байгаа.
A-17	Монголд экотуризмыг хөгжүүлэх арга хэлбэрийг танилцуулах	Хэрэгжээгүй.	Экотуризмын талаарх мэдээллийг энэ чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг зарим компаниуд бие даан цуглуулж байна. БОАЖЯ-наас экотуризмын мэдээллийн санг хөгжүүлэх ажил хийгдээгүй.
A-18	Хүрээлэн буй орчны менежментийн нэгдсэн судалгаа	Дутуу хэрэгжсэн	Хүрээлэн буй орчны менежментийн талаар БОАЖЯ-наас бэлчээрийн менежмент, хүрээлэн буй орчин, уул уурхайн газар түүний нөлөөллийн судалгаа хийж тайлагнасан хэдий ч аялал жуулчлалын салбарынханд шаардлагатай мэдээлэл байхгүй.
A-19	Гадаадын зах зээлд сурталчилгаа явуулах	Дутуу хэрэгжсэн	БОАЖЯ, Монголын аялал жуулчлалын холбоо хамтран нийт 14-15 улсад болдог аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцож байгаа боловч, имиж, концепц, зах зээлийн хамрах хүрээ тодорхойгүй, маркетинг сурталчилгаа хангалтгүй байна. ГХЯ, Нийслэлийн аялал жуулчлалын газар, Үндэсний хөгжлийн газар болон бусад байгууллагуудтай хамтарч экспортын үйл ажиллагааг дэмжих хүрээнд Монгол улсыг гадаадад сурталчлах шаардлагатай байна. Монголын талаарх ерөнхий танилцуулга, ялангуяа Монголын аялал жуулчлалын давуу талыг сурталчилсан албан ёсны найдвартай ажиллагаатай цахим хуудас байхгүй байна.

A-20	Улаанбаатар хотын зочид буудлуудыг хөгжүүлэх ерөнхий чиглэл	Тоон үзүүлэлт биелсэн.	2015 он хүртэл зочид буудлын тоог 2 дахин нэмэгдүүлнэ гэсэн зорилт биелсэн. Цаашид аялал жуулчлалын салбарыг олон улсын стандарт түвшинд хүргэхийн тулд зочид буудлын зэрэглэл тогтоох, үйлчилгээний стандарт, шаардлагыг шинэчлэх шаардлагатай.
A-21	Бүс нутгуудаар гэр бааз хөгжүүлэх ерөнхий чиглэл	Хэрэгжсэн	Орон нутагт жуулчны баазын тоо хангалттай хэмжээнд хүрсэн. Гэвч Улаанбаатар хотын захаар байрлах баазуудын тоо хэт олон, даац хэтэрч байгааг анхаарах шаардлагатай. Тэрэлжийн нөхцөл байдлаас сургамж авч, цаашид бүсчилсэн төлөвлөгөөний дагуу байгуулах зохицуулалт шаардлагатай.
A-22	Улаанбаатар хотын автобусны үйлчилгээний тухай гарын авлагатанилцуулга	Хэрэгжсэн	UB bus app нэртэй дижитал гарын авлагатай болсон. 2014 оноос эхлэн JCDesuах зар сурталчилгааны байгууллагатай хамтран Улаанбаатар хотын нутаг дэвсгэр дэх автобусны буудлуудыг шинэчлэн, маршрутын зураглалыг хийсэн. Шинэ чиглэл маршрут нэмэгдэхэд мэдээлэл тогтмол шинэчлэгддэг.
A-23	Автобус болон үзвэрийн газруудад хэрэглэхэд тохиромжтой нэгдсэн тасалбар нэвтрүүлэх	Хэрэгжсэн	Хувийн хэвшлийн оролцоотойгоор автобусны карт, e-ticket хоёрыг нэгтгэсэн тасалбарыг нэвтрүүлсэн. 2016 оноос эхлэн Нийслэлийн аялал жуулчлалын газар нь Нийслэлийн Тээврийн газар, Smart UB байгууллагуудтай хамтран автобусны билетийг цахимжуулж, картаар үйлчилдэг болсон. Музейн тасалбар хараахан цахимжаагүй боловч утсаар урьдчилсан захиалга өгөх боломжтой болсон.
В УЛСЫН ӨМЧИЙН ХҮРЭЭНИЙ ТӨСЛҮҮД			
1 Соёлын аялал жуулчлалыг өргөжүүлэх			
B-1	Богд хааны музейг засаж сайжруулах	Дутуу хэрэгжсэн	Богд хааны музейг соёлын өвийн хүрээнд бүтэн утгаар нь засаж сайжруулах хөтөлбөр хэрэгжээгүй. Музейн гадна засварын ажил (будаг, дээврийг сольсон г.м) хийгдсэн.
B-2	Монголын соёлын музей байгуулах	Хэрэгжээгүй	-

В-3	Эрдэнэ Зуугийн ойр орчмыг тохижуулах	Дутуу хэрэгжсэн	Жуулчдын гудамж, зам барих зэрэг зарим нэг орчны дэд бүтцийг сайжруулах ажлыг гүйцэтгэж байна.
В-4	Хархорины Зочдыг хүлээн авах төв	Хэрэгжээгүй	Орчин үеийн зочид буудал баригдсан боловч аялал жуулчлалын мэдээллийн төв зэрэг үйлчилгээ байхгүй.
2 Улаанбаатар хотыг жуулчлалын гол төв болгон хөгжүүлэх			
В-5	Улаанбаатарт аялал жуулчлалын байнгын зам маршрут тогтоож хөгжүүлэх	Дутуу хэрэгжсэн	Аялал жуулчлалын компаниудын зүгээс Гандан, Сүхбаатарын талбай, зайсан зэргийг тойрох тодорхой маршрутыг бий болгосон. Нийслэлийн аялал жуулчлалын газар тодорхой маршрут дээр автобус явуулах оролдлогыг 2017-2019 онд хийсэн боловч санхүүгийн шалтгаанаар бүрэн хэрэгжиж чадаагүй. Нийслэлийн аялал жуулчлалын газар нь 2016 оноос эхлэн нийслэлийг тойрсон 4 хайрханд явган аяллын замыг тохижуулж эхэлсэн ба 2016 онд Богдхан уулын Зайсан- Баруун ширээт чиглэлийн 3.5км зам, 2017 онд Чингэлтэй хайрханы явган аяллын 1-р чиглэлийн 2.6км зам, 2018 онд Богдхан уулын Төр хурах-Цэцээ гүн чиглэлийн 13.8км замаас 7.8км замыг тус тус тохижуулсан. Жуулчны мэдээллийн төвийн салбарыг 2016-2020 онд Улаанбаатар хотын хамгийн их жуулчин зорчдог 4-5 хэсэгт нэмж байгуулсан бөгөөд нийт 41,000 гаруй гадаад, дотоодын жуулчдыг мэдээллээр хангажээ.
В-6	Улаанбаатарт жуулчдад зориулсан гудамж талбай байгуулах	Хэрэгжээгүй	2016-2018 онд “Шөнийн гудамж”-ыг нээсэн боловч 2 жилийн дараа зогссон. 2010-2012 онд Нийслэлийн аялал жуулчлалын газрын санаачилгаар төрийн ордны баруун талаас бөмбөгөр худалдааны төв хүртэлх жуулчны гудамжны дагуу жуулчдад зориулсан гар урлалын бүтээгдэхүүн худалдаалах төвийг байгуулан ажиллаж байсан боловч, дараа нь татан буугдсан. 2013-2014 онд жуулчны гудамжинд үнэгүй интернэт үйлчилгээ нэвтрүүлж, хогийн сав, сандал байрлуулсан.

В-7	Улаанбаатарт бэлэг дурсгалын зүйлс болон гар урлалын бүтээгдэхүүний төв байгуулах	Дутуу хэрэгжсэн	Бэлэг дурсгалын зүйлс болон гар урлалын бүтээгдэхүүний төв байгуулагдаагүй. Харин хувийн хэвшлийн байгууллагуудаас бэлэг дурсгал, гар урлалын бүтээгдэхүүний төв байгуулах оролдлого гарсан. 2016-2017 онд, жуулчны мэдээллийн төвд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гар урлалын бүтээгдэхүүнийг худалдан борлуулахад дэмжлэг үзүүлсэн. Мөн жуулчдад зориулсан эвент, арга хэмжээг зохион байгуулах үеэр иргэдийн гар урлалын бүтээгдэхүүнийг худалдан борлуулах ажлыг дэмжиж ажиллаж байна.
3 Байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх			
В-8	Тэрэлжийн Зочдыг хүлээн авах төв	Хэрэгжээгүй	-
В-9	Говь дахь Зочдыг хүлээн авах төв	Дутуу хэрэгжсэн	Аймаг, орон нутгийн санаачилгаар шинэ музей байгуулах, Баянзагт зочдыг хүлээж авах, мэдээллийн төв байгуулах ажлууд хийгдсэн.
В-10	Шувууд ажиглах газрыг бэлдэж байгуулах	Хэрэгжээгүй	-
4 Бусад хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүд			
В-11	Хархорин чиглэлийн жуулчдын зам	Хэсэгчлэн хэрэгжсэн	Хэрэгжсэн боловч аялал жуулчлалын салбарын хөгжилд замын чанар хангалтгүй. ЗТХЯ нь Хархорин-Хөшөө цайдам чиглэлийн 47км хатуу хучилттай замыг Турк улсын Засгийн газрын дэмжлэгтэйгээр барьж ашиглалтад оруулсан. Түүний үргэлжлэл болох Харбалгас чиглэлийн авто замыг хараахан бариагүй байна. УБ-аас Лүнгээр дайрч Булган аймгийн Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн авто зам нь Хар балгас Харбухын гүүртэй хатуу хучилттай авто замаар холбогдсон.
В-12	Улаанбаатар-Хархорин төв авто замыг тэмдэгжүүлэх	Хэрэгжсэн	ЗТХЯ нь Хархорин-Улаанбаатар чиглэлийн авто замд жил бүр засвар арчлалт, тэмдэг, тэмдэглэгээний ажлыг хийж ирсэн. УБ - Лүн чиглэлийн 106км, Эрдэнэсант - Арвайхээр чиглэлийн 215км, Элсэн тасархай - Хархорин чиглэлийн 77км авто замуудад улсын төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгө оруулалтаар засвар хийсэн. Харин,

			замын тээвэр, аялал жуулчлалын холбогдолтой тэмдэгжүүлэх ажил хангалтгүй байна.
В-13	Халуун рашаан, сувиллын газруудыг засаж сайжруулах	Дутуу хэрэгжсэн	Баатарван, Хужирт, Шаргалжуут, Аваргатосон зэрэг хувийн хэвшлийн цөөн хэдэн рашаан сувилал байгаа ба ерөнхийдөө засаж сайжруулж, ашиглах үйл ажиллагаа дутмаг байна.
В-14	Аялал жуулчлалын хувийн секторт хоёр шаттай зээл олгох тогтолцоо	Тодорхойгүй	Япон Улсын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт үзүүлсэн хоёр шаттай хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөр хэрэгжүүлсэн боловч аялал жуулчлалын салбарын байгууллагууд хамрагдсан эсэх нь тодорхойгүй.
С ХУВИЙН ХЭВШЛИЙН ТӨСЛҮҮД			
С-1	Улаанбаатар-Хархорин хоорондын авто замын дагуу алжаал тайлах амралтын газрууд байгуулах	Хувийн хэвшил хэрэгжүүлсэн	2020 онд “Урьхан-2” үйлчилгээний цогцолборыг Лүн суманд байгуулсан.
С-2	Гэр баазуудын нөхцөл, материаллаг баазыг сайжруулах	Дутуу хэрэгжсэн	Хувийн хэвшлийн компаниуд өөрсдийн гэр баазуудыг сайжруулан ажиллаж байна. Сүүлийн 5 жилд цомцог гэр баазууд олноор нээгдсэн. Өвлийн нөхцөлд ажилладаг гэр баазууд үүнийг дагаад гэр баазын дэд бүтэц, халуун хүйтэн ус, бие засах өрөөний асуудлаа шийдэж байна.
С-3	Өмнөговийн онгоцны буудлын зурвасыг сайжруулах	Дутуу хэрэгжсэн	2007 онд 2200м урт, 40м өргөн зурвастай нисэх буудал байгуулагдсан. 2020 онд зурвасын засвар хийж нэмэлт хучилт хийсэн боловч зурвасаа уртасгаагүй. Жуулчдыг хүлээн авах төв нь хүний нөөцийн хомсдолоос үүдэн ажиллаагүй. Засгийн газраас олон улсын буудал болгохоо албан ёсоор илэрхийлсэн.
С-4	Спортын идэвхтэй амралтыг өргөжүүлэх	Дутуу хэрэгжсэн	Хувийн хэвшлийн санаачилгаар адал явдалт аялал, шүхэрт нислэг зэрэг оролдлогууд гарсан боловч хангалтгүй байна.
С-5	Морьдын хүрээлэн	Хэрэгжээгүй	Морьдын хүрээлэн байгуулах хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх оролдлого амжилтгүй болсон.

Эх сурвалж : Судалгааны баг

2.4 Холбогдох байгууллагууд

Монгол улсын аялал жуулчлалын хөгжилтэй холбоотой байгууллагууд нь доорхын дагуу болно.

Хүснэгт 2-5: Аялал жуулчлалын хөгжилтэй холбоотой байгууллагууд

	Байгууллагын нэр	Гол үүрэг
Төрийн Байгууллага	БОАЖЯ Ministry of Nature, Environment and Tourism	Монгол улсын тогтвортой хөгжлийн зорилгод нийцсэн байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын талаарх хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, зохицуулах. Аялал жуулчлалын талаарх мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээллээр хангах.
	ЗТХЯ Ministry of Road and Transport Development	Авто зам, агаар болон газрын тээврийн талаарх хууль тогтоомж, бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, зохицуулах.
	Үндэсний Хөгжлийн Газар National Development Agency	Улсын хөгжлийн цогц бодлого боловсруулах. Салбар хоорондын харилцаа, хамтын ажиллагааг зохицуулах стратеги зорилтын хүрээнд аялал жуулчлалын салбарын бодлогыг бусад салбарын бодлоготой уялдуулах.
	Сангийн Яам Ministry of Finance	Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэл, худалдан авах ажиллагааны бодлого, төрийн сангийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт болон зээл тусламжийн санхүүжилтийн хүрээнд үүрэг хариуцлага хүлээнэ.
	Соёлын Яам Ministry of Culture	Соёлын талаарх хууль тогтоомж, бодлого, стратегийг боловсруулах, хэрэгжүүлэх, зохицуулах.
	ГЗБГЗЗГ Administration of Land Affairs, Geodesy and Cartography	Бүх шатны газар зохион байгуулалтын төлөвлөгөөгөөр дамжуулан аялал жуулчлалын газрын одоогийн газар ашиглалт, аялал жуулчлалын маршрутыг төлөвлөж, ирээдүйд тухайн газрыг хадгалах, хамгаалах, зохистой ашиглах талаар санал болгох
	ГХЯ, Консулын Газар Consular Department, Ministry of Foreign Affairs	Гадаад улсаас Монгол улсад зорчих гадаадын иргэдэд виз олгох ажлыг хөнгөвчлөх санал боловсруулж, эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар холбогдох байгууллагатай хамтарч ажиллах. Дипломат, албан зэрэг визийн зөвшөөрлийг хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газруудад хүргүүлэх, Улаанбаатарт суугаа гадаад улсын Дипломат төлөөлөгчийн газруудыг мэдээллээр хангах.
	Нийслэлийн Аялал Жуулчлалын Газар Ulaanbaatar city Tourism Department	Засгийн газар болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн эдийн засаг, нийгмийн зорилгод нийцүүлэн, нийслэлийн хүрээнд аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлдэг. Нийслэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, гадаад дотоод жуулчдыг хүлээн авах хүчин чадал, аялал жуулчлалын бүтээгдэхүүн болон үйлчилгээг сайжруулах зорилго бүхий бодлогыг зохицуулж, хэрэгжүүлэх.
	Аялал Жуулчлалын Хөгжлийн Төв Mongolian Tourism Organization	БОАЖЯ-ны харьяа, бие даасан Төрийн Өмчит Үйлдвэрийн газар. Гадаад, дотоод хамтын ажиллагаа, олон талт төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, жуулчны урсгал нэмэгдүүлэх зорилгоор гадаад, дотоод сурталчилгаа явуулах, үйлчилгээний стандарт, гэрчилгээжүүлэлт, зэрэглэл тогтоох, аялал жуулчлалын талаар сургалт, МIСЕ арга хэмжээ зохион байгуулах зэрэг өргөн хүрээнд үйл ажиллагаа явуулах.

Төрийн Бус Байгууллага	Монголын Аялал Жуулчлалын Холбоо Mongolian Tourism Association	Монголын хамгийн том аялал жуулчлалын холбооны хувьд гишүүдийнхээ эрх ашгийг хамгаалах, Монгол орны гадаад сурталчилгааг сайжруулах, гадаад жуулчдын тоог нэмэгдүүлэх, салбарын үйлчилгээний чанарыг сайжруулах, мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх зэрэг Монголын улсын аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх талаар гишүүн байгууллагууд, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай бүх талаар хамтран ажиллах.
	Монголын Зочид Буудлуудын Холбоо Mongolian hotels association	Монгол улсын зочлох үйлчилгээний салбарын хөгжлийн бодлогод нөлөөллийн үүрэгтэй оролцох, бизнес эрхлэгчдийг дэмжих хууль эрх зүйн таатай орчныг бий болгоход санал дүгнэлт гаргаж ажиллах, гишүүн байгууллагуудын эрх ашгийг хамгаалах.
	Мэргэжлийн Хөтөч Тайлбарлагчдын Холбоо Mongolian Professional Tour Guides Association.	АЖ-ын хүний нөөцийн чухал бүрэлдэхүүн болох аяллын хөтөч тайлбарлагчийг сургах, мэргэшүүлэн чадавхижуулах, эрх ашгийг хамгаалах.
	Монголын Спорт Аяллын Холбоо Mongolian Sports Travel Federation	1993 онд Монголын спорт аяллын холбоо нэртэйгээр байгуулагдаж, 2001 онд Монголын адал явдал, спорт аяллын холбоо болж нэрээ өөрчилсөн ба 2016 онд уугуул нэрээ буцаан бүтцийн өөрчлөлт хийсэн. Байгальд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлэх.
	Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим (МҮХАҮТ) Mongolian National Chamber of Commerce and Industry	Монголд үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагуудыг нэгтгэсэн, гишүүн байгууллагуудын эрх ашгийг хамгаалах үүрэгтэй.
	МҮХАҮТ-ын дэргэдэх Аялал Жуулчлалын Зөвлөл Tourism council under Mongolian National Chamber of Commerce and Industry	2004 онд байгуулагдсан. Аялал жуулчлалын салбарын бизнес орчны бодлоготой холбоотой санал зөвлөмж дэвшүүлэх, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг үр дүнтэй болгох арга замыг эрэлхийлж хэрэгжүүлэх, аялал жуулчлалын бизнес орчин, тулгарч буй асуудлын талаар хурал зөвлөгөөн, семинар зохион байгуулах.

Эх сурвалж : Судалгааны баг

(1) Төрийн байгууллага

1) Байгаль орчин, аялал жуулчлалын яам

Монгол Улсын Аялал жуулчлалын тухай хуульд заасны дагуу Монгол улсын аялал жуулчлалын талаар бодлого боловсруулах төрийн захиргааны төв байгууллага. 121 ажилтан, 8 газар хэлтсээс бүрдэх ба аялал жуулчлалын асуудлыг хамаардаг аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газар нь 7-8 ажилтантай. Уг газар нь аялал жуулчлалын тухай хууль тогтоомжийн орчныг сайжруулах, аялал жуулчлалын бодлого, төсөл хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, аялал жуулчлалын мэдээллийн сан бүрдүүлж, хэрэглэгчдийг мэдээллээр хангах үүрэгтэй. Тус яамны харьяанд “Аялал жуулчлалын хөгжлийн төв”, “Байгаль хамгаалах сан” зэрэг хэд хэдэн хэрэгжүүлэгч агентлаг үйл ажиллагаа явуулдаг.

2) Аялал Жуулчлалын Хөгжлийн Төв

2017 оны байгуулагдсан. БОАЖЯ-ны хэрэгжүүлэгч агентлагын нэг. 18 ажилтантай. Гадаад, дотоодод сурталчилгаа явуулах (зах зээл тодорхойлох, маркетинг хийх), боловсон хүчнийг хөгжүүлэх мэргэжлийн сургалт төлөвлөх, аялал жуулчлалын салбарын статистик судалгаа шинжилгээ хийж, мэдээлэл цуглуулж боловсруулах, гадаад дотоодын олон талт төсөл хөтөлбөр боловсруулах, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэхэд дэмжлэх үзүүлэх, үйлчилгээний стандарт, гэрчилгээжүүлэлт, зэрэглэл тогтоох, төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулах зэрэг олон үйл ажиллагаа явуулдаг. 2021 оны 7-р сард олон улсын нисэх онгоцны

буудал шинээр нээгдсэнтэй холбогдуулан, Монгол улсыг зорин ирэх хүмүүсийг мэдээллээр хангах “ Жуулчдын мэдээллийн төв”-ийг байгуулахаар бэлтгэл ажлаа хангаж байна. Уг төвийн веб сайтын англи дээрх хувилбар нь ажиллахгүй байгаа, Монгол хэл дээр цөөн тооны мэдээлэл байршуулсан байгаа боловч төвийн Фэйсбүүк (facebook) -ын хуудсаар дамжуулан аялал жуулчлалын талаар хэрэгжүүлж буй Засгийн газрын (Аялал жуулчлалын сайдын) үйл ажиллагааны тоймыг тогтмол мэдээлж байна.

3) Зам, Тээвэр Хөгжлийн Яам

Авто зам болон агаар, ус, төмөр замын тээврийн талаарх стратеги төлөвлөгөө, бодлого боловсруулах, бодлогын хэрэгжилтийг зохицуулах, зам тээврийн удирдлага, хөрөнгө оруулалт татах, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлдэг. Монгол улсыг Ази болон европыг холбосон тээвэр логистикийн зангилаа төв болгох алсын харааны хүрээнд эдийн засгийн өсөлтийг хангахуйц, тээврийн ухаалаг системд суурилсан үндэсний тээвэр, логистикийн сүлжээг байгуулах зорилт тавин ажиллаж байна. Ухаалаг системд суурилсан авто замын төлбөр хураах, хяналтын механизмыг бүрдүүлэх замаар авто замын сангийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн, авто замын санг бие даасан үйл ажиллагаанд шилжүүлэх боломжтой болно. Улмаар байгаль орчинд ээлтэй, эрэлтэд нийцсэн тогтвортой, хүртээмжтэй, аюулгүй тээврийн үйлчилгээг хөгжүүлснээр аялал жуулчлалын хөгжилд хувь нэмэр оруулж, агаарын тээврийг либералчлах, өрсөлдөөнийг бий болгох замаар нислэгийн тоо, чиглэлийг нэмэгдүүлэн, орон нутгийн нисэх буудлуудын ашиглалтыг сайжруулахаар ажиллаж байна.

4) Үндэсний Хөгжлийн Газар

Эдийн засгийн тэргүүлэх чиглэл, салбарыг тодорхойлж, хөгжлийн бодлогыг хүн амын нутагшилт, суурьшил, бүсчилсэн хөгжлийн болон орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан, хөрөнгө оруулалтын нэгдсэн болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодлогыг зохистой төлөвлөж, улсын эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх зорилготой. Орон зайн мэдээллийн их өгөгдлийн санд үндэслэн хөгжлийн төлөвлөлт, гүйцэтгэл, удирдлага, мониторингийн платформ байгуулах төслийг боловсруулсан бөгөөд энэхүү төсөлд аялал жуулчлалын бүх төрлийн мэдээллийг байршлын мэдээлэлтэй уялдуулан цуглуулахаар төлөвлөж байна. Цаашид, уг платформу аялал жуулчлалын мэдээллийн баазтай холбож нэгтгэнэ.

5) Соёлын Яам

Яамны зорилго нь ард иргэдийг соён гэгээрүүлэхэд чиглэсэн соёл, урлагийн чанартай, хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, түүх, соёлын өвийг хадгалж хамгаалах, түгээн дэлгэрүүлэх, уламжлал, шинэчлэлийг хослуулсан үндэсний онцлогтой соёл, урлагийг хөгжүүлэхэд оршино. Соёлын өвийн газар, Урлаг, уран бүтээлийн газар зэрэг газар хэлтсүүдтэй бөгөөд Засгийн газрын тэргүүлэх чиглэл, үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан соёлын салбарын бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэхэд бусад яам, газруудын үйл ажиллагааны уялдааг хангаж, зохицуулах үүрэгтэй.

б) Аймаг, орон нутгийн аялал жуулчлалын захиргаа

Улаанбаатар хотоос бусад аймаг, орон нутгийн аялал жуулчлалын газрууд нь цөөн орон тоогоор үйл ажиллагаа явуулдаг.

Хүснэгт 2-6: Аймаг, орон нутаг дах аялал жуулчлалын захиргааны тогтолцоо (Улаанбаатар хотоос бусад)

Судалгаанд хамрагдсан бүс нутаг	Байгууллагын нэр, хариуцах газар хэлтэс (ажилтны тоо)
Дундговь аймаг	• Байгаль орчин аялал жуулчлалын газар, Аялал жуулчлалын хэлтэс (1 хүн)
Өмнөговь аймаг	• Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Аялал жуулчлалын бодлого хариуцсан мэргэжилтэн (1 хүн) • Байгаль орчин аялал жуулчлалын газар (2 хүн)
Говьсүмбэр аймаг	• Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Байгаль орчин, аялал жуулчлалын үйл ажиллагаа хариуцсан ажилтан (1 хүн)

Судалгаанд хамрагдсан бүс нутаг	Байгууллагын нэр, хариуцах газар хэлтэс (ажилтны тоо)
	• Байгаль орчин, аялал жуулчлалын газар (1 мэргэжилтэн)
Дорноговь аймаг	• Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Аялал жуулчлал хариуцсан 1 ажилтан) • Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Нийт ажилтан 19, аялал жуулчлал хариуцсан 1 ажилтан)
Өвөрхангай аймаг	• Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Аялал жуулчлал хариуцсан 1 ажилтан) • Орхоны хөндийн БЦГ-ын хамгаалалттай захиргаа (Аялал жуулчлал хариуцсан 1 ажилтан) http://uvurkhangai-baigaliorchin.com/
Архангай аймаг	• Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Аялал жуулчлал хариуцсан 1 ажилтан) https://baigal.ar.gov.mn/ • Аялал жуулчлалын мэдээллийн төв (Орон нутгийн олон нийтийн байгууллага)
Төв аймаг	• Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Аялал жуулчлал хариуцсан 1 ажилтан)



Эх сурвалж : Нийслэлийн аялал жуулчлалын газрын веб сайтын мэдээнд үндэслэн судалгааны баг боловсруулав.

Зураг 2-2: Нийслэлийн аялал жуулчлалын газрын бүтэц (Нийт 22 ажилтан)

(2) Төрийн бус байгууллага

1) Монголын аялал жуулчлалын холбоо (МАЖХ)

1992 онд Монголын аялал жуулчлалын салбарт ажиллагсдын санаачилгаар үүсгэн байгуулагдсан ТББ бөгөөд холбооны эрхэм зорилго нь гишүүдийнхээ эрх ашгийг хамгаалж, Монголын аялал жуулчлалын салбарыг эдийн засгийн тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэхийн төлөө гишүүн байгууллагууд болон холбогдох төрийн байгууллагуудын хооронд гүүр болж, бүх талаар хамтран ажиллахад оршино. Доорх үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.

- Хууль зүйн орчин, бизнесийн салбар дах шударга өрсөлдөөнийг бий болгохын төлөө төрийн захиргааны байгууллагуудтай хамтран, салбарын бодлогыг боловсруулахад санал дэвшүүлж, хамтран ажиллах,
- Хэвлэл мэдээлэл болон бусад бүх төрлийн мэдээллийн сувгаар дамжуулан өөрийн гишүүдэд үйлчлэх, олон улсын болон өөрийн орны аялал жуулчлалын салбартай холбогдолтой төрөл бүрийн мэдээллээр тогтмол хангах, мэдээллийн зохих санг бий болгох,
- Салбарын гишүүн байгууллагуудын чуулган, сургалт семинар, санал солилцох уулзалт зэрэг арга хэмжээг зохион байгуулах,
- Олон улсын болон гадаад, дотоодын аялал жуулчлалын байгууллага, үйл ажиллагааны тухай мэдээллээр хангах
- Салбарын боловсон хүчний ур чадварыг дээшлүүлэх, аяллын бүтээгдэхүүн, үйлчилгээг сайжруулах талаар сургалт, семинар, давтан сургалтад хамруулах, шаардлагатай гарын авлага, материал тараах,
- Монгол орны талаар гадаад дотоодын зах зээлд сурталчлах, МАЖХ болон түүний гишүүн байгууллагын үйл ажиллагаа, нийгэмд оруулж буй хувь нэмрийг олон нийтэд таниулах
- Гишүүн байгууллагуудын харилцааг зохицуулах, ур чадвар, мэдлэг туршлагаа солилцох талаар дэмжлэг үзүүлэх,

Үйл ажиллагааны төсвийн хувьд, улсаас ямар нэгэн татаас авдаггүй бөгөөд гишүүнчлэлийн төлбөрөөр санхүүждэг. Гишүүнчлэлийн жилийн төлбөр 500,000 төгрөг, гэр баазын гишүүнчлэлийн төлбөр жилийн 250,000 төгрөг, аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл шинээр авах 100,000 төгрөг, сунгуулах 50,000 төгрөг.

2) Монголын мэргэжлийн хөтөч тайлбарлагчдын холбоо¹

Монголын мэргэжлийн хөтөч тайлбарлагчдын холбоо нь гишүүдээ чадавхижуулах, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, зөвлөгөөгөөр хангах, төрөл бүрийн сургалт, арга хэмжээ, үйл ажиллагааг холбогдох төр, төрийн бус байгууллагуудтай хамтран хэрэгжүүлдэг. Сүүлийн жилүүдэд, БОАЖЯ, Монголын аялал жуулчлалын холбоо ТББ, Нийслэлийн аялал жуулчлалын газар, Монголын Үндэсний Түүхийн музей, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)-тай хамтарч ажилласан. Холбооны сургагч багш нар БОАЖЯ-наас жил бүр зохион байгуулдаг салбарын хүний нөөцийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөрт тогтмол, идэвхтэй хамрагддаг.

Тус холбоо нь “Дэлхийн Хөтөч Тайлбарлагчдын Холбоодын Нийгэмлэг”-ийн албан ёсны хөтөлбөрийг Монгол улсад зохион байгуулах эрхтэйгээр, аяллын хөтөч тайлбарлагчид байвал зохих ур чадвар, техникийг эзэмшүүлэх зорилгоор өнгөрсөн жилд 3 удаагийн сургалт семинар зохион байгуулсан ба нийт 90 орчим хөтөч уг хөтөлбөрт хамрагджээ. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр бага хэмжээний орлого олсон байна.

Мэргэжлийн өндөр ур чадвартай аяллын хөтөч, тайлбарлагч бэлдсэнээр дэлхийд улс орноо таниулах, аяллын хөтөч тайлбарлагч нь бие даасан ажил мэргэжил болох тухай ойлголтыг нэмэгдүүлэх, тулгарч буй хөдөлмөр, нийгмийн асуудлыг (нийгмийн даатгалд хамрагдах боломжгүй байх зэрэг) шийдвэрлэх талаар холбогдох байгууллагуудтай зөвшилцөх зэрэг үйл ажиллагааг хийж, хэрэгжүүлдэг.

3) Монголын зочид буудлуудын холбоо

1997 оны 5 сарын 14-ний өдөр Улаанбаатар хотод үүсгэн байгуулагдсан. 2021 оны байдлаар үндсэн 82, дэмжигч 100 орчим гишүүнтэй үйл ажиллагаа явуулж байна. Холбооноос зохион байгуулдаг сургалт, судалгаанд 300 орчим зочид буудал оролцдог. Улсын хэмжээнд 21 аймагт салбартай, зочлох үйлчилгээний салбарын өрсөлдөөнийг нэмэгдүүлэх, мэргэшсэн, өндөр ур чадвартай боловсон хүчнийг бэлдэх, гишүүдийн эрх ашгийг хамгаалах, Монголын зочид буудлын үйлчилгээг олон улсын түвшинд хүргэх зорилготой. Дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулж

¹ <https://www.mptga.org/>

байна.

- Олон улсын хурал, семинар, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах (Улаанбаатар хотын даргын ивээл дор Нийслэлийн аялал жуулчлалын газрын үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлдэг “ HoReCa (Hotel, restaurant, catering) expo” үзэсгэлэнг 2016 оноос хойш тогтмол хамтран зохион байгуулж байна.)
- Зочид буудлуудын зэрэглэл тогтоох комисс, стандартын техникийн хороо, хуулийн шинэчлэлийн ажлын хэсэгт төлөөлөл оролцох
- Жижиг дунд, зэрэглэлгүй зочид буудлуудад бизнесийн зөвлөх үйлчилгээ өгөх
- Зочид буудлын үйлчилгээнд чанарын үнэлгээ хийх
- Үйлчилгээний ажилтнуудад ажлын байран дээрх дадлага сургалт зохион байгуулах
- Төрийн байгууллага болон олон улсын байгууллагуудтай гэрээгээр хамтран ажиллах
- Холбогдох албан байгууллагуудтай хамтран сургалт зохион байгуулах

4) Монголын спорт аяллын холбоо

Адал явдалт спорт аяллын төрлүүдийг хөгжүүлэх зорилготой төрийн бус байгууллага. “Монголын Спорт Аяллын Холбоо” нэртэйгээр 1993 онд үүсгэн байгуулагдаж 2001 онд “Монголын Адал Явдалт Спорт Аяллын Холбоо” болон өргөжиж нэрээ өөрчилсөн ба 2016 оны 11 сард уугуул нэрээ сэргээн “Монголын спорт аяллын холбоо” болон бүтэц зохион байгуулалтаа шинэчилсэн. Үйл ажиллагааныхаа хүрээнд хувь хүний байгаль эх орноо хайрлах, тэсвэр хатуужил суух, хөгжил тал дээр илүү анхаарч, хувьсан өөрчлөгдөж буй байгальдаа дасан зохицож, манлайлах чадвар бүхий иргэд, залуусыг бэлтгэх үүднээс олон талт спорт аялал (урт холын явган аялал, дугуйн, морин, тэмээн, каноэ) болон сургалтыг түлхүү хөгжүүлэн явуулж байна. Холбооноос санаачлан спорт аяллын мэргэшлийн төвшин тогтоох шалгалт авч, зэрэг олгох систем нэвтрүүлж, гишүүдээ чадавхижуулах ажлыг хийж байна. Холбоодын гишүүд нь аялал жуулчлалын салбарын аж ахуйн нэгж, байгууллага төдийгүй явган аяллын клуб зэрэг иргэдийн байгууллагууд ч байдаг бөгөөд улсын хэмжээнд 3-аас бусад аймагт салбарлан үйл ажиллагаа явуулдаг. Улаанбаатар хотын хэмжээнд 20 гаруй клуб гишүүнээр элссэн байна.

5) МҮХАҮТ-ын дэргэдэх Аялал жуулчлалын зөвлөл

2004 онд үүсгэн байгуулагдсан. Үйл ажиллагааны гол чиглэл нь аялал жуулчлалын салбарын бизнес орчны бодлоготой холбоотой санал зөвлөмж дэвшүүлэх, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг үр дүнтэй болгох арга замыг эрэлхийлж хэрэгжүүлэх, МҮХАҮТ-аас зохион байгуулдаг арга хэмжээнд аялал жуулчлалын зөвлөлийн гишүүдийг оролцоход дэмжлэг үзүүлэх зэрэг болно. Аялал жуулчлалын салбарын бизнес орчин, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх талаар хурал, семинар зохион байгуулж, салбарын нэгдсэн цогц мэдээллийн бааз бүрдүүлэхээр төлөвлөж байна.

2.5 Хууль эрх зүйн тогтолцоо

(1) Гадаадын иргэн, харьяат хилээр нэвтрэхтэй холбоотой хууль тогтоомж

1) Хуулийн агуулга

Гадаадын иргэн, харьяат хилээр нэвтрэхтэй холбоотой мөрдөгдөж буй хууль тогтоомжийн тухайд, 2010 оны 7 сард батлагдсан (2020 оны 12 сард шинэчлэгдэж, 2021 оны 6 сараас дагаж мөрдөнө) “Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль”, 2001 оны 4 сард батлагдсан “Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль”, 2018 онд батлагдсан “Монгол Улсын виз олгох журам”, 2018 онд батлагдсан “Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам” зэрэг болно.

2) Хуультай холбоотой асуудлууд

“Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль” -ийн дутагдалтай талыг доор дурдав. Гадаад улсаас зорчин ирэх иргэдийн бүртгэлийг хянах улсын нэгдсэн тогтолцоо бүрдээгүй, жуулчдын бодит тоог гаргах боломжгүй байх магадлалтай.

Хүснэгт 2-7: "Гадаад иргэний эрх зүйн байдлын тухай хууль"-тай холбоотой асуудлууд

Зүйл заалт	Агуулга	Асуудал
16.1	Визийг дараах байгууллага олгоно: 16.1.1.гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага; 16.1.2.гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага; 16.1.3.Монгол улсаас хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газар.	ГИХГ хариултдаа "Хуульд зааснаар ГХЯ, ГИХГ, хилийн чанад дахь Дипломат төлөөлөгчийн газрууд бүгд виз олгох эрхтэй, энэ нь бүх байгууллагуудын эрх үүрэг давхцаж байгаа гэсэн үг. Мөн, ГХЯ болох ГИХГ нь виз олгохдоо тус бүр өөр өөр мэдээллийн сан үүсгэж, ашигладаг учир, улсын хэмжээнд гаднаас зорчин ирэх жуулчдыг нэгдсэн байдлаар хянах тогтолцоо бүрдээгүй" гэж дурдав.

Эх сурвалж : "Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль", асуулгын хариуг ашиглан судалгааны баг боловсруулав.

3) Хуулийн шинэчлэл

"Гадаад иргэдийн эрх зүйн байдлын тухай хууль" -д 2020 оны 12 сард өөрчлөлт оруулсан бөгөөд, 2021 оны 6 сараас дагаж мөрдөгдөнө. ГИХГ-ын мэдээллээс харахад, хуулийн гол өөрчлөлт нь цахим виз олгох, виз мэдүүлгийн төв байгуулахтай холбоотой заалтууд нэмэгдсэн байна. Цахим виз нэвтрүүлж, улс бүрт виз мэдүүлгийн төв байгуулж, үйлчилгээг нэгтгэж хялбаршуулснаар, зуучлалын хөлс болон жуулчдад учрах хүндрэлийг бууруулах зорилготой байна.

Түүнчлэн, виз мэдүүлэх төв нь визний мэдүүлэг, материалыг шалгах үйл ажиллагаа явуулах ба виз олгох эрх нь хилийн чанад дахь дипломат төлөөлөгчдийн газарт байна. Мөн, төвийг аль усад байгуулах, ямар аж ахуйн нэгж, байгууллагад зөвшөөрөл олгох талаар Засгийн газар шийдэх бөгөөд, одоогийн байдлаар эцэслэж шийдээгүй байна.

Түүнчлэн, "Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль" шинэчилсэн найруулгад нийцүүлэн, "Монгол Улсын виз олгох журам", "Гадаадын иргэн Монгол Улсад суух болон түүнийг бүртгэх журам"-ыг тус тус шинэчлэхээр Хууль Зүйн Яам ажиллаж байна.

(2) Аялал жуулчлалын тухай хууль

1) Хуулийн агуулга

Аялал жуулчлалтай холбоотой мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн хувьд, 2000 оны 5 сард батлагдсан "Аялал жуулчлалын тухай хууль" болно. Үүнд, аялал жуулчлалын тухай хууль тогтоомж нь Аялал жуулчлалын тухай хуулиас гадна Иргэний хууль, Газрын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ гэж заасан. Уг хуульд, аялал жуулчлалын байгууллага болон жуулчны үйлчилгээний байгууллагын үйл ажиллагаа, аяллын хөтөч-тайлбарлагчийн эрх үүрэг, аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрх үүрэг зэргийг тусгасан.

Хуульд, "Аялал жуулчлалын байгууллага" гэж аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг бүрдүүлэх, сурталчлах, худалдах, худалдан авах, аялал жуулчлалын багц буюу тухайлсан үйлчилгээг зохион байгуулж байгаа ашгийн төлөө хуулийн этгээдийг; "Жуулчны үйлчилгээний байгууллага" гэж зочид буудал, жуулчны бааз, зоогийн газар, амралт сувилал, тээвэр, холбоо, үзвэрийн зэрэг үйлчилгээг жуулчинд үзүүлж байгаа байгууллагыг хэлнэ гэж тодорхойлсон.

Хуулийн 16-р зүйлд, аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (БОАЖЯ) нь, аялал жуулчлал хөгжүүлэх төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг хангах; аялал жуулчлалын байгууллага хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах; Монгол орныг гадаад, дотоодод сурталчлах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ гэж заасан. Мөн, аялал жуулчлалын байгууллага, зочид буудал, жуулчны баазад зэрэглэл тогтоох журмыг батлах; жуулчны бааз, зочид буудал, амралт, рашаан сувиллын газрын тоо, байршлыг тогтоох, тэдгээрийн нэгдсэн бүртгэл

хөтлөх зэрэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ гэж заасан байна.

Зочид буудалд зэрэглэл тогтоох тухайд, 2008 онд Стандартчилал хэмжил зүйн үндэсний төвөөс Монгол улсын стандарт “Хэрэглэгчдэд зориулагдсан үйлчилгээний стандарт буюу зочид буудлын үйлчилгээний чанарын үндсэн шаардлага”-ыг гаргасан. Стандартын дагуу зэрэглэлийг тогтоохдоо, байршил, барилга болон орчин, веб хуудас, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, байгаль орчны нөлөөлөл, оршин суугч, нийгэм, хүний эрхийг хангах, ажилчдын ажлын орчин нөхцөл, хүүхдэд үзүүлэх үйлчилгээ зэрэг 15 төрлийн үндсэн шалгуур үзүүлэлтийг шалгаж, 5 шатлалт үнэлгээг хийнэ. Аялал жуулчлалын тухай хуульд 3 ба түүнээс дээш од бүхий зэрэглэлийг хангасан буудлыг “дээд зэрэглэлийн зочид буудал” гэж заасан. Жуулчны баазуудын хувьд ч ялгаагүй, 2009 онд Монгол Улсын стандарт “Амралтын газар, жуулчны бааз, гэр буудалд тавигдах ерөнхий шаардлага”-ыг мөрдөж байна.

2) Хуультай холбоотой асуудлууд

Хуультай холбоотой асуудлууд болон бусад хуультай үл нийцэх асуудлын талаар доор дурдав.

Хүснэгт 2-8: Аялал жуулчлалын тухай хуультай холбоотой асуудлууд болон бусад хуультай зөрчилдөх байдал

Зүйл заалт	Агуулга (“ ” хаалтад хуулийн заалт эх хувилбараараа бичигдсэн)	Асуудал болон бусад хуультай үл нийцэх
8.1.3	“Тухайн жилд үйлчлүүлсэн жуулчдын талаарх судалгааг тогтоосон журмын дагуу аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргаж өгөх”	8-р зүйлд аялал жуулчлалын байгууллагын эрх үүргийг тодорхойлсон заалт юм. Уг хэсэгт “эрх үүрэг” биш “хамтран ажиллах” гэдэг талаас нь тусгаж өгсөн нь зүйтэй болно. АЖ байгууллагаас тодруулахад, “ жуулчдын талаарх судалгааг яамны аль газар хэлтэс хариуцах нь тодорхойгүй, судалгааны агуулгыг ч нарийвчлан заагаагүй” байдалтай байна.
10.3	“Жуулчны үйлчилгээний байгууллага энэ хуулийн 4.1-д заасан үйл ажиллагаа явуулахыг хориглоно.”	4.1-д аялал жуулчлалын байгууллагын үйл ажиллагааг (аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг төлөвлөх, бүрдүүлэх, сурталчлах, бөөнөөр болон жижиглэнгээр худалдах, аялал зохион байгуулах) тусгасан. Ихэнх АЖ байгууллагууд хотод үйл ажиллагаа явуулдаг бол үйлчлүүлэгчдийн хэрэгцээ шаардлагын талаарх мэдээлэл газар дээр, жуулчны үйлчилгээний байгууллагуудад төвлөрдөг учир, тухайн байгууллагуудын үйл ажиллагааны чиглэлийг ялгаж тогтоохгүй байснаар, улирлын болон орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн илүү сайн аяллын бүтээгдэхүүн төлөвлөж, хэрэгжүүлэх боломжтой гэсэн санал ирүүлсэн. Японы аяллын тухай хуулиар, бүс нутгийн аяллын компанийн үйл ажиллагааг зохицуулж өгснөөр, өнөөдрийн хүртэл зорилтот аялал төлөвлөж, хэрэгжүүлэх боломжгүй байсан бусад аялал жуулчлалын байгууллага, зочид буудал, буучийн газрууд нь тухайн байршиж буй орон нутагтаа зочид хүлээн авах аяллын бүтээгдэхүүн төлөвлөх, борлуулах боломжтой болсон.
11.1	“Төрөөс экспортын үйлдвэрлэлд үзүүлэх дэмжлэг, хөнгөлөлтөд аялал жуулчлалын байгууллага, зочид буудлын гадаадын	2021 оны 5 сард Ерөнхий сайд, АЖ салбарынхантай хийсэн уулзалтын үеэр (цаашид, ЕС-ын өглөөний

	жуулчдад үзүүлсэн үйлчилгээ нэг адил хамаарна.”	уулзалт гэх) ² Монголын зочид буудлуудын холбооноос, энэ зүйл заалт нь “Нэмүү өртгийн татварын тухай хууль”-тай зөрчилдөж байгааг хэлсэн. НӨАТ-ын тухай хуульд зочид буудлын үйлчилгээ татвараас чөлөөлөгдөхгүй гэж заасан байдаг ба энэ талаар судалгааны явцад хийсэн асуумжид бас дурдагдсан байна.
15	Аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (БОАЖЯ)-аас гадна, Ерөнхий сайдын дэргэд аялал жуулчлалын зөвлөл байхаар заасан. Уг зөвлөл нь аялал жуулчлалын талаар төрийн нэгдсэн бодлого боловсруулах болон хэрэгжүүлэх асуудлаар Ерөнхий сайдад зөвлөгөө өгөх, санал дүгнэлт гаргах үүрэгтэй.	АЖ байгууллагын хариултаас харахад, сайдын дэргэдэх зөвлөлийн ажлын журам гараагүй, зөвлөл байгуулагдсанаас хойш огт хуралдаагүй байна.
16.1.13	“Аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь, аялал жуулчлалын бүсэд хүлээн авах жуулчдын тоог тогтоох”	Аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад (БОАЖЯ), байгаль орчны нөлөөлөл, даацад үндэслэн хүлээн авах жуулчдын тоог тогтоох эрхийг олгосон. Гэвч, бодит байдал дээр жуулчдын тоог тогтоохдоо огтхон ч эдгээр хүчин зүйлийг анхаардаггүй байна.

Эх сурвалж : “Аялал жуулчлалын тухай хууль”, асуулгын хариу, 2021.2.25-ны ”Ерөнхий Сайдын өглөөний уулзалт”-д үндэслэн судалгааны баг боловсруулав.


Холбогдох аялал жуулчлалын газрын мэдээллээр, дээрх олон асуудлыг дагуулсан “Аялал жуулчлалын тухай хууль”-ийг хэзээ шинэчлэх нь тодорхойгүй, нэмэлт өөрчлөлт оруулах талаар хуулийн төсөл боловсруулах ажил ч одоогоор хийгдэж эхлээгүй байна.

(3) Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль

1) Хуулийн агуулга


1994 оны 11 сард батлагдсан “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль” нь, тусгай хамгаалалттай газар нутгийн ангилал, ангилал тус бүрийн хамгаалалтын дэглэм, тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх төрийн байгууллагын бүрэн эрх, тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглахтай холбогдолтой харилцааг зохицуулахад оршино. Тусгай хамгаалалттай газар нутгийг доорх зургийн дагуу дархан цаазат газар; байгалийн цогцолборт газар; байгалийн нөөц газар; дурсгалт газар хэмээн үндсэн 4 төрлөөр ангилж, төрөл бүрийг дотор нь нарийвчлан тодорхойлж өгсөн. Судалгаанд хамруулсан маршрутын хүрээнд нийт 30 газрыг (дархан цаазат газар 3; байгалийн цогцолборт газар 9 ; байгалийн нөөц газар 13; дурсгалт газар 5) тусгай хамгаалалтад авсан байна.

² Ерөнхий сайдын санаачилгаар АЖ салбарын төлөөлөлтэй хийсэн уулзалт. Хууль эрх зүйн зохицуулалт байхгүй



Эх сурвалж : ”Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль”-аас судалгааны баг боловсруулав

Зураг 2-3: Тусгай хамгаалалттай газар нутгийн ангилал




Эх сурвалж : БОАЖЯ, ТХГН-ын удирдлагын газар, Улсын ТХГН-ын мэдээллийн санд³ үндэслэн төслийн баг боловсруулав

Зураг 2-4: Тусгай хамгаалалттай газар нутгийн ангиллын газрын зураг

³ <https://www.eic.mn/spa/gis.php> (2021.02.16 өдрийн байдлаар)


Хуулийн 7-р зүйлд, дархан цаазат газрыг “Байгалийн бүс, бүслүүрийн онцлог, хэв шинжийг төлөөлж чадах унаган төрхөө хадгалсан байдал, шинжлэх ухааны онцгой ач холбогдлыг нь харгалзан байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах зорилгоор улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг дархан цаазат газар гэнэ” гэж тодорхойлжээ. Доорх зургийн дагуу судалгааны маршрутын хүрээнд 3 дархан цаазат газар хамрагдав.



Эх сурвалж : БОАЖЯ,ТХГН-ын удирдлагын газар,Улсын ТХГН-ын мэдээллийн санд⁴ үндэслэн судалгааны баг боловсруулав.

Зураг 2-5: Дархан цаазат газрын газрын зураг (Судалгааны маршрут)

Хуулийн 13-р зүйлд, Байгалийн цогцолборт газрыг “ Байгалийн унаган төрхөө харьцангуй хадгалсан, түүх, соёл, шинжлэх ухааны болон танин мэдэхүй, экологийн хүмүүжилд ач холбогдол бүхий улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг байгалийн цогцолборт газар гэнэ.” гэж тодорхойлжээ. Доорх зурагт дүрсэлсний дагуу судалгааны маршрутын хүрээнд 9 байгалийн цогцолборт газар хамрагдав.



Эх сурвалж : БОАЖЯ,ТХГН-ын удирдлагын газар, Улсын ТХГН-ын мэдээллийн сан⁵ үндэслэн судалгааны баг боловсруулав.

⁴ <https://eic.mn/spa/> (2021.02.16 өдрийн байдлаар)

⁵ <https://eic.mn/spa/> (2021.02.16 өдрийн байдлаар)

Зураг 2-6: Байгалийн цогцолборт газрын газрын зураг (Судалгааны маршрут)


Хуулийн 19-р зүйлд, Байгалийн нөөц газрыг “ Байгалийн тодорхой хэв шинж, аль нэгэн нөөц, баялгийг хамгаалах, хадгалах, нөхөн сэргээх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг байгалийн нөөц газар гэнэ.” гэж тодорхойлжээ. Доорх зургийн дагуу судалгааны маршрутын хүрээнд 13 байгалийн нөөц газар хамрагдав.



Эх сурвалж : БОАЖЯ,ТХГН-ын удирдлагын газар,Улсын ТХГН-ын мэдээллийн санд⁶ үндэслэн судалгааны баг боловсруулав.

Зураг 2-7: Байгалийн нөөц газрын газрын зураг (Судалгааны маршрут)

Хуулийн 22-р зүйлд, Дурсгалт газрыг “Байгалийн өвөрмөц тогтоц, түүх, соёлын ул мөрийг уламжлагдан хадгалагдсан байгалийн байдлаар нь өвлөн үлдээх зорилгоор улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг дурсгалт газар гэнэ.” гэж тодорхойлжээ. Доорх зургийн дагуу судалгааны маршрутын хүрээнд 5 дурсгалт газар хамрагдав.



Эх сурвалж : БОАЖЯ,ТХГН-ын удирдлагын газар,Улсын ТХГН-ын мэдээллийн санд⁷ үндэслэн судалгааны баг боловсруулав.

⁶ <https://eic.mn/spa/> (2021.02.16 өдрийн байдлаар)

⁷ <https://eic.mn/spa/> (2021.02.16 өдрийн байдлаар)

Зураг2-8: Дурсгалт газрын газрын зураг (Судалгааны маршрут)

2) Хуультай холбоотой асуудлууд

Хуультай холбоотой асуудлын талаар доор дурдав.

Хүснэгт 2-9: Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуультай холбоотой асуудлууд

Зүйл заалт	Агуулга (“ ” хаалгад хуулийн заалт эх хувилбараараа бичигдсэн)	Асуудал
11.1.6	“байгалийн аялал, жуулчлалыг тогтоосон зам, чиглэлээр зохих журмын дагуу зохион байгуулах”	Хязгаарлалтын бүсэд аялал жуулчлалыг тогтоосон газар, зам чиглэлийн дагуу хийх дэглэм тогтоосон хэдий ч, өмнөх дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны даргын дурдсанаар, дэглэмийг иргэд дагаж мөрдөж байгаад хяналт тавьж чадахгүй байгаагаас үүдэж, аялагчид дуртай газраа хоноглох, чөлөөтэй зорчих, хог хаягдлын асуудал гарч байна.
30.1.6	“зөвшөөрөгдсөн аялал, жуулчлалын зам, чиглэлийг тэмдэгжүүлэх, шаардлагатай орон байр барих, тээврийн хэрэгслийн зогсоол гаргах, биеийн тамирын болон нийтийн бусад арга хэмжээ явуулах газар, журмыг тогтоох, эрүүл ахуйн нөхцөлийг нь хангах, тэдгээрийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран тохижуулах”	Хамгаалалтын захиргааны ажлын хүрээнд, аялал жуулчлалын зам чиглэлийг тэмдэгжүүлэхээр заасан боловч, тэмдэг тэмдэглэгээний арчилгаа, бүрэн бүтэн байдалд тавих хяналт сул, салхи бороонд өгөрч муудаж харагдахгүй болсон, хэт бохир болсноос байгалийн өнгө үзэмжид сөргөөр нөлөөлөх зэрэг асуудлууд гарч байна.

Эх сурвалж : “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль”, “Хөрөнгө оруулалтын тухай хууль”, асуулгад үндэслэн судалгааны баг боловсруулав.

Тусгай хамгаалалттай газар нутаг руу нэвтрэх хураамж гадаад хүн 3000 төгрөг, Монгол хүн түүний 10 хувьтай тэнцэх төлбөртэй. Татварын хуулиар, хураамжийг улсын татварт тушаах ба татварын тогтолцоогоор тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаанд буцаан олгогддоггүй. Мөн, өмнөх хамгаалалтын захиргааны дарга, хураамжийн хэмжээ бага учир өөрчлөх шаардлагатай талаар дурджээ.

3) Хуулийн шинэчлэл

“Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын хуулийн төсөл БОАЖЯ-ны веб хуудас дээр 2016 оноос хойш байршиж байна.⁸ БОАЖЯ-наас 2021 оны УИХ-ын хаврын чуулганд өргөн мэдүүлэхээр төлөвлөж байгаа гэх мэдээлэл байгаа бөгөөд, хуулийн шинэчлэл хүлээгдэж байна. Одоогийн байдлаар БОАЖЯ-ны веб хуудсанд байршуулсан хуулийн төсөлд үндэслэн гол нэмэлт өөрчлөлтүүдийг хүснэгтэд буулгав.

Хүснэгт 2-10: ”Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төсөл

Мөрдөгдөж буй хууль	Шинэчилсэн найруулгын төсөл
33.2 “ Тусгай хамгаалалттай газар нутагт гадаад улсын хуулийн этгээд олон улсын байгууллага, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, гадаадын	“Тусгай хамгаалалттай газар нутагт гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн, гадаадын хуулийн этгээдэд газар ашиглуулахыг

⁸ <http://www.mne.mn/wp-content/uploads/2017/07/10.pdf> (2021.03.15 өдрийн байдлаар)

Мөрдөгдөж буй хууль	Шинэчилсэн найруулгын төсөл
хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид газар ашиглуулахыг хориглоно.”	хориглоно” гэж заасан хэдий ч, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид газар ашиглуулахыг хориглоогүй. Харин, гадаад улсын хуулийн этгээд гэж, Монголоос бусад гадаад улсад байгуулагдсан хуулийн этгээдийг хэлэх бөгөөд, “Хөрөнгө оруулалтын тухай хууль”-д заасан гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжээс өөр болно.
11.1.6 Дархан цаазат газрын хязгаарлалтын бүсэд байгалийн аялал, жуулчлал явуулахыг зөвшөөрөх боловч, онгон бүс болон хамгаалалтын бүсэд хориглодог. Тиймээс, аяллын маршрут (аялах боломжтой газар, зам, чиглэлтэй холбоотой дэглэм, журам) ч зөвхөн хязгаарлалтын бүсэд хамааралтай.	Дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны өмнөх даргын дурдсанчлан, аялагчид дархан цаазат газрын хязгаарлалтын бүсээс бусад газраар ч гэсэн зорчих тохиолдол их учир, аяллын маршрутыг тодорхойлж, шинэчилсэн хуулийн төсөлд дархан цаазат газрын хамгаалалтын бүсэд ч аялж, жуулчлахыг зөвшөөрөх заалт оруулсан.
<p>6.2 Тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах ажлыг санхүүжүүлэх хөрөнгө нь дараах эх үүсвэрийн тухай</p> <p>6.2.1 улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт;</p> <p>6.2.2 аялал, жуулчлалын болон бусад ажил, үйлчилгээний орлого;</p> <p>6.2.3 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хандив, тусламж;</p> <p>6.2.4 тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдийн учруулсан хохирлын нөхөн төлбөрийн орлого.</p>	<p>Доорх байдлаар санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.</p> <p>Улсын болон орон нутгийн төсөв;</p> <p>Тусгай хамгаалалттай газар нутагт нэвтрэх болон үйлчилгээ эрхэлсний хөлс;</p> <p>Тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль орчин, байгалийн нөөцөд учруулсан хохирлын нөхөн төлбөрийн орлого;</p> <p>Гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын иргэн, хуулийн этгээдээс өгсөн буцалтгүй тусламж, хандив;</p> <p>Иргэн, хуулийн этгээдээс тусгай хамгаалалттай газар нутгийн биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын зардлыг санхүүжүүлэх хөрөнгө;</p> <p>Тусгай хамгаалалттай газар нутгийн экосистемийн үйлчилгээний төлбөр;</p> <p>Хууль тогтоомжоор зөвшөөрсөн бусад орлого</p>

Эх сурвалж : “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль”, “Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль”, Хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон асуулгад үндэслэн судалгааны баг боловсруулав.

(4) Байгаль орчныг хамгаалах тухай хууль

1) Хуулийн агуулга

1995 оны 3 сард батлагдсан “Байгаль орчныг хамгаалах тухай хууль”-аар байгаль орчныг хамгаалах талаарх төрийн чиг үүрэг, зарчим; байгалийн баялгийг өмчлөх, ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ; байгаль орчны үнэлгээ, судалгаа шинжилгээ, аудит; байгаль орчныг хамгаалах талаарх төрийн байгууллагын бүрэн эрх; аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг зэргийг зохицуулна.

Уг хуулийн 6.1-д “Монгол улсын иргэнд өмчлүүлснээс бусад газар, газрын хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг төрийн өмч мөн бөгөөд төрийн эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөл, эрхийн бичгээр ашиглахаас бусад тохиолдолд халдашгүй байна.” гэж тодорхойлсон. Хариуцах эрх бүхий төрийн байгууллагын хувьд, байгалийн нөөцийн төрлөөс хамааран БОАЖЯ, уул уурхайн баялаг олборлохтой холбоотой тохиолдолд Уул уурхайн Яам байна. Мөн, 6.2-т “Хуульд өөрөөр заагаагүй бол Монгол улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын иргэн, хуулийн этгээд байгалийн баялгийг зохих төлбөр, хураамжийг төлж, гэрээ, тусгай зөвшөөрөл буюу эрхийн бичгийн дагуу ашиглаж болно.” гэж заасан ба гадаадын иргэн болон гадаадын хуулийн этгээд ч байгалийн баялгийг ашиглах

боломжтой байна. Гэвч, “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль”-ийн 33.2-т “Тусгай хамгаалалттай газар нутагт гадаад улсын хуулийн этгээд олон улсын байгууллага, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид газар ашиглуулахыг хориглоно.” гэж заасан байгаа тул, тусгай хамгаалалттай газрыг ашиглах боломжгүй.

2) Хуультай холбоотой асуудлууд

Уг хуультай холбоотой асуудлыг доор дурдав.

Хүснэгт 2-11: ”Байгаль орчныг хамгаалах тухай хууль”- тай холбоотой асуудлууд

Зүйл заалт	Агуулга (“ ” хаалтад хуулийн заалт эх хувилбараараа бичигдсэн)	Асуудал
31.1.6	“аж ахуйн нэгж, байгууллагууд төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу экологийн паспорт хөтлөх.”	БОАЖЯ-ны мэргэжилтэн “экологийн паспортыг хөтлөх нь аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчинд хандах хандлагыг тодорхойлох чухал үзүүлэлт бөгөөд, байгальд ээлтэй үнэлгээ авсан байгууллагууд үйл ажиллагаагаа олон нийтэд сурталчлахад эерэгээр нөлөөлөх боломжтой учраас, энэ системийг нэвтрүүлсэн” гэсэн бол, байгаль орчны байгууллагын төлөөлөл “экологийн паспорт огт хөтөлдөггүй” гэж хариулсан болно.
Хууль бүхэлдээ	Хууль бүхэлдээ хамаарна.	Байгаль хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-ын төлөөлөл, “Хуулийг дагаж мөрдөхгүй байгаагаас болж, хог хаягдлын асуудлаас эхлээд, байгаль орчин устаж үгүй болох эрсдэл үүсэж байна. Гол нь хуулийг өөрчилж, шинэчлэхдээ биш, өргөн уудам нутаг дэвсгэртэй Монгол улсын хувьд, хуулийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх нь чухал юм” хэмээн саналаа илэрхийлсэн.

Эх сурвалж : “Байгаль орчныг хамгаалах тухай хууль” болон асуулгад үндэслэн судалгааны баг боловсруулав.

3) Хуулийн шинэчлэл

ХЗДХЯ-ны мэргэжилтний дурдсанаар, 2019 оны “ Үндсэн хууль”-ийн өөрчлөлтөд нийцүүлэн, “Байгаль орчныг хамгаалах тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулах (өөрчлөлт оруулах хэсэг: уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй байгаль орчны доройтлоос сэргийлэх тухай) шаардлагатай боловч, одоогоор хуулийн шинэчилсэн найруулгын төсөл тус яаманд ирээгүй байна.

(5) Соёлын өвийг хамгаалах тухай хууль

1) Хуулийн агуулга

2014 оны 5 сард “Соёлын өвийг хамгаалах тухай хууль”-ийн шинэчилсэн найруулга батлагдсан бөгөөд уг хуулиар соёлын өвийн ангилал, зэрэглэл; соёлын өвийн талаарх төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх; соёлын өвийн бүртгэл; судалгаа; соёлын өвийг эзэмших, ашиглах, өмчлөх; соёлын өвийг хамгаалах тогтолцоо; сэргээн засварлах; сурталчлах; соёлын өвийг хянах зэрэг харилцааг зохицуулна.

2) Хуультай холбоотой асуудлууд

Хуультай холбоотой асуудлыг доор дурдав.

Хүснэгт 2-12: ”Соёлын өвийг хамгаалах тухай хууль”-тай холбоотой асуудлууд

Зүйл заалт	Агуулга (“ ” хаалтад хуулийн заалт эх хувилбараараа бичигдсэн)	Асуудал
37.3	37.Соёлын өвийг хамгаалах тогтолцооны тухай 37.3 “Соёлын өвийн анхны төрх, нэгдмэл цогц байдлыг алдагдуулахгүйгээр	Соёлын Яамны (СЯ) ажилтны дурдсанаар, 37.3 заалт мөрдөгдөхгүй байгаа ба хамгаалалтад авах шаардлагатай хэсгийн

Зүйл заалт	Агуулга (“ ” хаалтад хуулийн заалт эх хувилбараараа бичигдсэн)	Асуудал
	тухайн орон нутагт нь хадгалах зарчим баримтална. Хадгалалт хамгаалалтын нөхцөлийг сайжруулах зорилгоор соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний зөвшөөрлөөр төрийн болон, орон нутгийн музейд шилжүүлэн хадгалж болно.” Нэгдмэл цогц байдал гэдэг нь, соёлын өв нь олон хэсгээс бүрдсэн тохиолдолд бүхлээр нь, нэгдсэн байдлаар хамгаалахыг хэлнэ.	хүрээ хязгаарыг, хилийн заагийг тогтоогүйгээс үүдэн соёлын өвийн ойр орчимд барилга баригдах зэрэг асуудал үүсэж байна.
41	Соёлын өвийг хамгаалах үйл ажиллагааг улсын болон орон нутгийн төсөв; Монгол улсын болон гадаадын иргэн, олон улсын байгууллага, хуулийн этгээдээс олгосон хөрөнгө, хандив, тусламж, бусад эх үүсвэрээс санхүүжүүлнэ гэж заасан байна.	СЯ-ны ажилтны дурдсанаар, одоогоор бусад эх үүсвэрээс орж ирэх орлого бараг байхгүй бөгөөд улсын болон орон нутгийн төсөв, хандиваар санхүүждэг байна.
42.1	“Улсын Их Хурал соёлын өвийн дурсгалт газрын унаган төрх, соёлын үнэт зүйлийн язгуур шинжийг хамгаалах зорилгоор тусгай хамгаалалтад авах тухай шийдвэр гаргаж, хилийн заагийг батална.”	СЯ-ны ажилтны дурдсанаар, 42.1-г дагаж мөрдөгдөхгүй байгаа бөгөөд, хамгаалалтын хилийн заагийг тогтоогоогүйгээс, соёлын өвийн ойр орчимд барилга баригдах зэрэг асуудал үүсэж байна.
42.7	“Соёлын өвийн дурсгалт газрын хамгаалалтын менежментийг хариуцан хэрэгжүүлэх үүрэг бүхий хамгаалалтын захиргаа ажиллана.” (3.1.6 “Соёлын өвийн дурсгалт газар” гэж соёлын биет болон биет бус өв нь байгаль орчин, уламжлалт ахуйтайгаа харилцан шүтэлцсэн соёлын орон зай, газар нутгийг хэлнэ.)	СЯ-ны ажилтны дурдсанаар, хамгаалалтын захиргаа Дэлхийн өвд бүртгэгдсэн “Орхоны хөндийн соёлын дурсгалт газар”, “Монгол Алтайн нурууны хадны зургийн цогцолбор”, “Бурхан Халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутаг” гэсэн 3 газарт байгуулагдсан. Бусад соёлын өвийн дурсгалт газарт тусад нь хамгаалалтын захиргаа байгуулаагүй бөгөөд ойр орчмын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа хариуцдаг.
45.2	“Сум, дүүргийн Засаг дарга хамгаалалтын бүс тогтоосон түүх, соёлын дурсгалт газарт гэрээт харуул томилж ажиллуулна.”	СЯ-ны мэргэжилтний дурдсанаар, ихэнх түүх соёлын дурсгалт газруудад харуул томилж ажиллуулаагүй байна.

Эх сурвалж : “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” болон асуулгад үндэслэн судалгааны баг боловсруулав.

3) Хуулийн шинэчлэл

Соёлын Яамны мэргэжилтний дурдсанаар, хуульд нэмэлт өөрчлөлт оруулах төлөвлөгөө байхгүй, хуулийн шинэчилсэн найруулгын төслийг ч одоогоор боловсруулаагүй байна.

(6) Газрын тухай хууль

2020 оны 6 сард “Газрын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулга батлагдсан. Хуулиар, газрын харилцааны талаарх төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх; газар зохион байгуулалт, түүний санхүүжилт; газар өмчлөх, эзэмшүүлэх, ашиглуулахтай холбоотой харилцааг зохицуулна. Уг хуульд заасан газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн ялгааг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 2-13: Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн ялгаа

Газрын эрх	Ялгаа
Газар өмчлөх	Газар өмчлөх эрх гэдэг ойлголт нь “газрыг чөлөөтэй эзэмших”, “ашиглах”, “захиран зарцуулах” гэсэн 3 хэсгээс бүрдэнэ. Монгол Улсын Үндсэн Хуульд “Монгол улсын газар нь төр нийтийн өмч мөн” гэж заасан ба гагцхүү Монгол улсын иргэн хувийн хэрэгцээнд зориулж газар өмчлөх боломжтой байдаг. Харин, тухайн иргэн өөрийн өмчилж буй газрыг гадаадын иргэнд шилжүүлэхийг хориглодог.
Газар эзэмших	Газар эзэмших эрх гэдэг нь газрыг гэрээнд заасан зориулалт, нөхцөл, болзлын дагуу хуулиар зөвшөөрсөн хүрээнд өөрийн мэдэлд байлгахыг хэлэх бөгөөд зөвхөн Монголын Улсын иргэн, дотоодын аж ахуйн нэгж байгууллагад хамаатай. Хуулийн дагуу доорх байдлаар газар эзэмших эрхтэй. 60 жил хүртэлх хугацаагаар эзэмшүүлж болно (хугацааг сунгах боломжтой). Эзэмшиж буй тухайн газраа бүгдийг нь буюу зарим хэсгийг бусдад ашиглуулж болно. Монгол улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэх, барьцаалах үйл ажиллагаа явуулж болно.
Газар ашиглах	Газар ашиглах эрх гэдэг нь хуулиар зөвшөөрсөн хүрээнд газар өмчлөгч (төр эсвэл Монгол улсын иргэн), эзэмшигчтэй байгуулсан гэрээнд заасны дагуу аль нэг ашигтай чанарыг нь гаргаж хэрэглэхийг хэлнэ. УИХ нь гадаад улс, олон улсын байгууллага, гадаадын хуулийн этгээдэд газрыг тодорхой хугацаагаар түрээс, концессын гэрээгээр ашиглуулах талаар шийдвэр гаргах бүрэн эрхтэй. Засгийн газар нь тухайн газрын зааг, ашиглах журмыг тогтооно. Монгол улсад байнга (183 хоногоос дээш хугацаагаар) оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнд газрыг зөвхөн гэр бүлийн хамтын хэрэгцээний нь зориулалтаар ашиглуулах асуудлыг дуудлага худалдааны зарчмаар тухайн шатны Засаг дарга шийдвэрлэнэ.

Эх сурвалж : JICA 「Монгол Улсын хөрөнгө оруулалтын гарын авлага」⁹ -д үндэслэн судалгааны баг боловсруулав.

Гадаад улс, олон улсын байгууллага, гадаадын хуулийн этгээд, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгууллага, гадаадын иргэн, харьяалалгүй хүнд газрыг зөвхөн гэрээнд заасан зориулалт, хугацаа, нөхцөл болзлын дагуу “ашиглахыг” зөвшөөрнө. Уг хуулийн 6.3-т “Гадаад улс, олон улсын байгууллага, гадаад улсын хуулийн этгээд, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын иргэн, харьяалалгүй хүн тодорхой зориулалт, хугацаа, болзол, гэрээний үндсэн дээр хууль тогтоомжийн дагуу газар ашиглагч байж болно.” ; 44.7-д “Гадаадын иргэн, харьяалалгүй хүн газар ашиглах тухай хүсэлт гаргахын өмнө гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн эрх бүхий байгууллагаас тодорхойлолт авсан байна.” гэж тус тус заасан байна.

(7) Иргэний хууль

2002 оны 1 сард батлагдсан “Иргэний хууль”-ийн 34 дүгээр бүлэгт, аялал жуулчлал зохион байгуулагч болон жуулчин хоорондын гэрээ, доголдол, гэрээ дуусгавар болох, хохирол нөхөн төлбөр, аялал зохион байгуулагчийн хариуцлагын хязгаар, гэрээнээс татгалзах эрхтэй холбоотой харилцааг зохицуулахаар заасан байна. Харин, аялал жуулчлал зохион байгуулагчийн талаарх тодорхойлолтыг тусгаагүй.

(8) Хүрээлэн буй орчин буюу газар нутгийн үзэмжийг хамгаалах тухай хууль тогтоомж

Хүрээлэн буй орчин буюу газар нутгийн үзэмжийг хамгаалах тухай хууль тогтоомж байхгүй. 2011 онд Отгонтэнгэр их сургуулиас “Хүрээлэн буй орчин буюу газар нутгийн үзэмжийг хамгаалах нь” сэдвийн хүрээнд олон улсын эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулж, тус бага хуралд БОАЖЯ, Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газар, Хууль зүйн

⁹ https://www.jica.go.jp/priv_partner/case/field/ku57pq00002azzsv-att/invest_mongol_01.pdf (2021.03.13 өдрийн байдлаар)

үндэсний хүрээлэн, Монгол болон Япон улсын зарим их, дээд сургуулиудын эрдэмтэн, судлаачид оролцсон. Оролцогчдын зүгээс, хүрээлэн буй орчны үзэмжийг хамгаалах асуудлыг анхаарахгүй орхигдуулж байгаа нь тухайн газар нутгийн үзэмжийг алдагдуулах зэрэг асуудал үүсэж буй бөгөөд аялал жуулчлал эрчимтэй хөгжиж буй өнөөгийн нөхцөлд байгаль газар нутгийн үзэмжийг хадгалах, хамгаалахтай холбоотой стандарт, шаардлагыг бий болгох нь чухал талаар хөнджээ.¹⁰ Мөн, Соёлын Яамны ажилтан, энэ талаар холбогдох хууль тогтоомж батлагдаж гараагүйн улмаас соёлын өвийн ойр орчимд аж ахуйн нэгж байгууллагууд зар сурталчилгааны самбар байрлуулах зэрэг асуудлууд гарч байгаа тухай асуулгад дурдсан байна.

(9) Хөрөнгө оруулалтын тухай хууль

1) Хуулийн агуулга

2013 оны 10 сард батлагдсан “Хөрөнгө оруулалтын тухай хууль”-д хөрөнгө оруулагчийн эрх, үүрэг; хөрөнгө оруулалтын талаарх төрийн байгууллагын бүрэн эрх; хөрөнгө оруулалтын дэмжлэг; хөрөнгө оруулалтын орчныг тогтворжуулах талаар тусгасан. Энэ хуулийн 3.1.5-д “Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж” гэж Монгол улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 25 буюу түүнээс дээш хувийг гадаадын хөрөнгө оруулагч эзэмшиж байгаа бөгөөд гадаадын хөрөнгө оруулагч тус бүрийн оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ нь 100 мянган америк доллар буюу түүнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс дээш байх аж ахуйн нэгжийг хэлнэ” ;

13.1-д “Тогтворжуулах гэрчилгээ олгох замаар хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэх хуулийн этгээдийн төлөх татварын хувь, хэмжээг тогтворжуулна.” гэсэн нь заасан нөхцөл болзлыг хангасан тохиолдолд, хөрөнгө оруулагчид (хувь хүн, хуулийн этгээд) тогтворжуулах гэрчилгээ олгосон үеийн татварын хувь хэмжээг урт хугацааны туршид хэвээр хадгалах баталгаа болох юм. Мөн, 13.4-д “Тогтворжуулах гэрчилгээний хүчинтэй байх хугацаанд татварын хууль тогтоомжид энэ хуулийн 14.1-д заасан албан татвар, төлбөрийн хувь, хэмжээг бууруулах өөрчлөлт орсон тохиолдолд тогтворжуулах гэрчилгээ эзэмшигч хуулийн этгээд уг өөрчлөлтөд хамаарах ба харин нэмэгдүүлэх өөрчлөлт орсон тохиолдолд уг өөрчлөлтөд хамаарахгүй.” гэж заасан байгаа нь, хөрөнгө оруулагчид ашиггүй нөхцөлөөр хуульд өөрчлөлт орсон ч сөргөөр нөлөөлөхгүй болохыг баталгаажуулж байна. 14.1-д заасан албан татвар, төлбөрийн хувь хэмжээ гэдэг нь аж ахуйн нэгжийн орлогын албан татвар; гаалийн албан татвар; нэмэгдсэн өртгийн албан татвар; ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болно. 16.2.2-г уул уурхайн олборлолт, хүнд үйлдвэр, дэд бүтцийн салбараас бусад салбарт тогтворжуулах гэрчилгээ олгох хугацааг заасан бөгөөд хөрөнгө оруулалтын хэмжээнээс хамааран 5-15 жилийн хугацаатайгаар тогтворжуулах гэрчилгээг олгоно.

2) Хуультай холбоотой асуудлууд

Хуультай холбоотой асуудлыг доорх хүснэгтэд дурдав.

Хүснэгт 2-14: ”Хөрөнгө оруулалтын тухай хууль”-тай холбоотой асуудал

Зүйл заалт	Агуулга	Асуудал
3.1.5	“гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж” гэж Монгол улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 25 буюу түүнээс дээш хувийг гадаадын хөрөнгө оруулагч эзэмшиж байгаа	Үндэсний Хөгжлийн Газрын мэргэжилтний дурдсаны дагуу, гадаадын хөрөнгө оруулагч тус бүрийн оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ 100 мянган ам.доллар буюу түүнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс дээш байх гэсэн хатуу шаардлага нь гадаадын хөрөнгө оруулалтыг бууруулах нэг хүчин зүйл болж байна. Мөн, энэ шаардлага нь уул уурхайн чиглэлийн аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалтад тавигдах шаардлагыг үндэслэж тогтоосон хэмжээ учир бусад

¹⁰ <https://gogo.mn/r/83800> (2021.03.14 өдрийн байдлаар)

Зүйл заалт	Агуулга	Асуудал
	бөгөөд гадаадын хөрөнгө оруулагч тус бүрийн оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ нь 100 мянган америк доллар буюу түүнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс дээш байх аж ахуйн нэгжийг;	салбараас орж ирэх хөрөнгө оруулалтыг бодолцон, хэмжээ, шаардлагыг өөрчилж тогтоох шаардлага үүсч байгаа тул, хуульд нэмэлт өөрчлөлт оруулах саналтай байгаа. Гэвч, Үндэсний Хөгжлийн газар хуулийн төсөл санаачилж, өргөн мэдүүлэх эрхгүй учир, хууль өөрчлөгдсөн ч тус газрын санал тусгагдах эсэх нь тодорхойгүй болно.

Эх сурвалж : Хөрөнгө оруулалтын хууль болон асуулгад үндэслэн судалгааны баг боловсруулав.

Мөн, “Хөрөнгө оруулалтын тухай хууль” батлагдсанаар “Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль”-ийг хүчингүй болсонд тооцсон байна.¹¹

(10) Компанийн тухай хууль

1) Хуулийн агуулга

2011 оны 10 сард “Компанийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулга батлагдсан. Тус хууль компани, түүний хэлбэр (хязгаарлагдмал хариуцлагатай болон хувьцаат компани) , компани байгуулах, компанийн дүрэм, хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл зэрэг холбогдох зүйл заалтаас бүрдэнэ.

2) Хуультай холбоотой асуудлууд

Монгол Улсын Их Сургуулийн багшийн дурдсаны дагуу, аялал жуулчлалын компанитай холбоотой заалт болон асуудал байхгүй болно.

(11) Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль

1) Хуулийн агуулга

2019 оны 6 сард “Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль”-ийн шинэчилсэн найруулга батлагдсан. Уг хуульд жижиг дунд үйлдвэрийн тодорхойлолт; жижиг дунд үйлдвэр, үйлчилгээнд үзүүлэх төрийн дэмжлэг; жижиг дунд үйлдвэрийн сан; жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийн эрх, үүрэг; жижиг дунд үйлдвэр, үйлчилгээний талаарх төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрхийн талаар тусгасан. Доорх хүснэгтийн дагуу, заасан шаардлагыг хангасан жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийг бичил, жижиг, дунд үйлдвэр үйлчилгээ эрхлэгч гэж ангилсан байна.

Хүснэгт 2-15: Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийн төрөл, шаардлага

Ангилал	Зүйл заалт	Агуулга
Бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч	5.1.1	10 хүртэл ажилтантай, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг, жилийн 300.0 сая төгрөг хүртэл борлуулалтын орлоготой аж ахуйн нэгж
Жижиг үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч	5.1.2	10-50 хүртэл ажилтантай, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг, жилийн 300.0 сая-1.0 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой аж ахуйн нэгж
Дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч	5.1.3	дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч” гэж 50-200 хүртэл ажилтантай, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг, жилийн 1.0--2.5 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой аж ахуйн нэгж

Эх сурвалж : Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль

Тус хуулийн 11-р зүйлд жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг санхүүжүүлэх зорилго бүхий “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан” -гийн талаар тусгаж, нэг удаа олгох зээлийн хэмжээг доорх хүснэгтэд заасны дагуу тогтоосон байна.

Хүснэгт 2-16: Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас нэг удаа олгох зээлийн хэмжээ

Ангилал	Зүйл заалт	Агуулга
Бичил үйлдвэр,	11.6.1	бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид жилийн борлуулалтын орлогоос хамааруулан 300.0 сая төгрөг хүртэл;

¹¹ ХЗДХЯ Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн веб хуудас <https://www.legalinfo.mn/law/details/212> (2021.03.18 өдрийн байдлаар)

Ангилал	Зүйл заалт	Агуулга
үйлчилгээ эрхлэгч		
Жижиг үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч	11.6.2	жижиг үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид жилийн борлуулалтын орлогоос хамааруулан 1.0 тэрбум төгрөг хүртэл;
Дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч	11.6.3	дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид жилийн борлуулалтын орлогоос хамааруулан 2.5 тэрбум төгрөг хүртэл;

Эх сурвалж : Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль

2) Хуультай холбоотой асуудлууд

Хууль зүй, дотоод хэргийн яамны ажилтны дурдсаны дагуу, жижиг дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш удаагүй байгаа ба ямар нэг асуудал гараагүй байна. Харин, 2021 оны 2 сарын 25-ны өдөр Ерөнхий сайдын санаачилсан өглөөний уулзалтын үеэр, Монголын аялал жуулчлалын холбоо болон жуулчны баазын төлөөлөлүүдийн зүгээс, “ жижиг дунд үйлдвэрийн сангаас зээл авахад нийгмийн даатгалын шимтгэл, татвар төлөлтийг хоцроож байгаагүй, өөр төрлийн өр зээлгүй, НӨАТ төлөгч байх гэсэн шаардлага тавьдаг. Эдгээр шаардлагыг хангах аялал жуулчлалын компани тун цөөн учир, зээл олгох нөхцөлийг хөнгөлж өгөх” талаар саналаа илэрхийлсэн. Үүнд, Сангийн сайд “Нийгмийн даатгалын шимтгэлийн төлөлтийг хоцроож байгаагүй гэдэг шаардлагад 2019 он буюу цар тахал дэгдэхээс өмнөх хугацааг хамруулж байгаа, мөн НӨАТ-ыг зөвхөн жилд 1 тэрбум төгрөгөөс дээш орлоготой аж ахуйн нэгжид ногдуулдаг ба ихэнх аялал жуулчлалын компаниудад бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийн ангилалд багтдаг тул хамаарахгүй” гэсэн хариулт өгч, энэ асуудлаар холбогдох байгууллагуудтай зөвшилцөнө гэдгээ илэрхийлсэн.

(12) Хөдөлмөрийн тухай хууль

1999 оны 5 сард батлагдсан “Хөдөлмөрийн тухай хууль”-д ажил олгогчийн санаачилгаар хөдөлмөрийн гэрээг цуцлах үндэслэлийг доорх хүснэгтэд дурдсаны дагуу тусгасан байна.

Хүснэгт 2-17: Ажил олгогчийн санаачлагчаар хөдөлмөрийн гэрээг цуцлах үндэслэл

Зүйл заалт	Агуулга
40.1.1	аж ахуйн нэгж, байгууллага болон түүний салбар, нэгж татан буугдсан, орон тоо хасагдсан, эсхүл ажилтны тоог цөөрүүлсэн
40.1.2	ажилтан мэргэжил, ур чадвар, эрүүл мэндийн хувьд гүйцэтгэж байгаа ажил, албан тушаалдаа тэнцэхгүй болсон нь тогтоогдсон;
40.1.3	ажилтан 60 нас хүрч өндөр насны тэтгэвэр авах эрх үүссэн;
40.1.4	ажилтан хөдөлмөрийн сахилгын зөрчлийг давтан гаргасан, эсхүл хөдөлмөрийн харилцааг шууд зогсоохоор хөдөлмөрийн гэрээнд тухайлан заасан нөхцөлд зөрчил гаргасан;
40.1.5	мөнгө болон эд хөрөнгө хариуцсан ажилтан ажил олгогчийн итгэлийг алдсан буруутай үйлдэл, эс үйлдэхүй гаргасан нь тогтоогдсон;
40.1.6	сонгууль, томилолтоор өөр орон тооны ажил, албан тушаалд ажиллах болсон;
40.1.7	контрактад заасан үндэслэл буй болсон.

Эх сурвалж : Хөдөлмөрийн тухай хууль

Аялал жуулчлалын салбарын ажил улирлын шинжтэй учир, жилийн турш тогтвортой орлого олохын тулд давхар ажил хийх ажилтнууд олон байдаг. Одоо мөрдөгдөж байгаа хуулийн хүрээнд зэрэгцсэн хөдөлмөр эрхлэх талаар тусгагдаагүй бөгөөд компанийн дүрмээр зохицуулдаг. Салбарын үйлдвэрчний эвлэлийн дурдсаны дагуу, хуулийг шинэчлэхээр төлөвлөж байгаа ба шинэчилсэн найруулгын төсөлд “ Үндсэн ажил олгогчтой ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг, эсхүл зах зээлд өрсөлддөг аж ахуйн нэгж, байгууллагад ажиллах бол, зэрэгцсэн хөдөлмөрийн

гэрээ байгуулахдаа үндсэн ажил олгогчоос зөвшөөрөл авна” гэсэн заалтыг оруулсан байна.

2.6 Хүний нөөцийг хөгжүүлэх

Аялал жуулчлалын салбарын боловсон хүчнийг гол төлөв Улаанбаатар хот дахь боловсролын байгууллагууд бэлтгэн гаргадаг ба орон нутгийн хувьд зарим нэг бүс нутагт байдаг мэргэжлийн боловсролын сургалтын төвүүд тогооч, зөөгч, аяллын хөтөч-тайлбарлагч зэрэг мэргэжлээр сургадаг. Гол бэрхшээл нь, аялал жуулчлалын салбарын ажил улирлын шинжтэй, тогтвортой ажлын байраар хангах боломжгүй байдгаас анги дүүргэлт дутуу байх явдал юм. Мөн, Өмнөговь аймаг зэрэг уул уурхайн олборлолт ихтэй нутагт, аялал жуулчлалын байгууллагаас илүү уул уурхайн компанид ажилд орох тохиолдол олон байдаг. Иймд, аялал жуулчлалын компаниуд хүний нөөцөө бүрдүүлэх үүднээс тухайн оюутантай гэрээ байгуулж, сургуулиа төгсөх хүртэл зуны улиралд цагаар ажиллуулах, ажилчдынхаа өвлийн улирлын нийгмийн даатгалын шимтгэлийг компани бүрэн даах зэрэг арга хэмжээ авдаг байна.

БОАЖЯ-аас аялал жуулчлалын үйлчилгээг сайжруулах, орон нутгийн иргэдийн оролцоог дэмжих зорилгоор 2019 оноос 2 жил дараалан “Зочлох үйлчилгээний төрөлжсөн сургалт”-ыг үндэсний хэмжээнд зохион байгуулсан. Судалгаанд оролцсон бүс нутгуудыг авч үзвэл, уг сургалтад Дундговь аймаг 545 хүн, Өмнөговь аймаг 795 хүн, Говьсүмбэр аймаг 258 хүн, Дорноговь аймаг 545 хүн, Архангай аймаг 192, Өвөрхангай аймаг 531 хүн, Улаанбаатар хот 6,963 хүн, нийт 9,829 хүн тус тус хамрагдаж, гэрчилгээгээ гардан авчээ.

Сургалтыг аялал жуулчлалын салбарт олон жил ажилласан туршлагатай мэргэжилтэн, МУИС-ын багш судлаачид удирдан явуулж, гэрчилгээ олгодог. Суралцагчдын ихэнх нь аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа эрхлэх сонирхолтой, жуулчдын баазад ажиллахаасаа илүү хувиараа бие даан компани байгуулах, гэр хаус ажиллуулах хүсэлтэй байна. Говийн бүс нутагт сургалт явуулсан “Гайхамшигт Говь” АЖ холбооны дурдсаны дагуу, Монголд хувиараа хөдөлмөр эрхлэхэд тулгардаг хамгийн том бэрхшээл нь, газар төрийн өмч учраас тухайн орон нутгийн захиргаанаас тусгай зөвшөөрөл авах шаардлагатай, ялангуяа аялал жуулчлалын бүс орчим газар ашиглах зөвшөөрөл авахад хүндрэлтэй байдаг гэсэн асуудлыг дурдаж болно.

Төрийн болон төрийн бус байгууллагуудын зүгээс аялал жуулчлалын салбарын боловсон хүчнийг бэлтгэх талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээг доор дурдав.

(1) Төрийн байгууллага

1) Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам

Аялал жуулчлалын салбарын боловсон хүчнийг гол төлөв их, дээд сургууль болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүд (МСҮТ) бэлтгэн гаргадаг ба их дээд сургуулиудыг Боловсролын Яам, МСҮТ-ийг Нийгэм Хамгаалал, Хөдөлмөрийн Яам хариуцдаг. БОАЖЯ-аас улсын хэмжээнд менежер, аяллын хөтөч, тогооч, зөөгч, бармен, жолооч зэрэг зочлох үйлчилгээний мэргэжлээр сургалтыг тогтмол зохион байгуулж ирсэн ба 2019 оноос эхлэн аялал жуулчлалын салбарын хөгжлийг шинэ түвшинд хүргэж, аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулахад үйл ажиллагаагаа чиглүүлэхээр төлөвлөж, зочлох үйлчилгээний мэргэжлийн 10-12 сургалтын хөтөлбөрийг боловсруулсан.

2019-2020 онд зөөгч, бармен, бариста, өрөө болон гэрийн үйлчлэгч, тогооч, жолооч, ачаа зөөгч, хаалгач гэсэн 9 мэргэжлээр зочлох үйлчилгээний мэргэшүүлэх сургалтыг Улаанбаатар хот болон 21 аймагт зохион байгуулж, улсын хэмжээнд нийт 10 мянга гаруй иргэд “үнэ төлбөргүй” суралцаж, гэрчилгээ авсан.

Түүнчлэн, Солонгосын аялал жуулчлалын газар (КТО)-тай хамтран хэрэгжүүлж буй “Construction of a Mongolian Tourism Education Center and Strengthening Workforce Capabilities Project” төслийн хүрээнд, дэлхий даяар тархсан Ковид-19 цар тахлын үед аялал жуулчлалын байгууллагын дагаж мөрдөх дүрэм журам, стандарттай холбоотой мэдээллээр хангах ажлыг хэрэгжүүлж, салбарын байгууллагуудад зориулан цар тахлыг даван туулах, сэргэлтийн үе рүү шилжих маркетинг төлөвлөгөө боловсруулах талаар олон улсын туршлагаас суралцах “Аялал жуулчлалын шинэ чиг хандлага болон цахим шилжилт” сэдэвт вебинарыг зохион байгуулж, 100 гаруй хүн оролцов.



Эх сурвалж : Дорноговь аймаг, Байгаль орчин, аялал жуулчлалын газар

Зураг 2-9: Семинарын үеэр

2) Аялал Жуулчлалын Хөгжлийн Төв ТӨҮГ

АЖХТ нь гаднын сургагч багш нарыг урин, төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бүтээгдэхүүн, үйл ажиллагаа, үйлчилгээ гэсэн чиглэлээр сургалт явуулдаг. БОАЖЯ болон бусад холбогдох байгууллагуудын захиалгаар, мөн бие даан зохион байгуулдаг. 2020 онд олон улсын байгууллагын боловсруулсан, Ковид-19 цар тахлын дараа аялал жуулчлалын салбарын дагаж мөрдөх шаардлагатай шинэ стандарт, дүрэм журмыг Монгол хэл руу орчуулан гаргасан бөгөөд 2021 онд БОАЖЯ-ны захиалгаар 21 аймгийн мэргэжилтнүүдэд 7 төрлийн сургалт хэрэгжүүлэхээр төлөвлөж, эхний сургалтыг энэ сэдвээр зохион байгуулах талаар ярилцаж байна. Мөн, салбарын холбогдох байгууллагуудад Монгол хэл дээр орчуулагдсан дээрх шинэ стандарт, журмыг үнэ төлбөргүй тараахаар төлөвлөж байна.

2019 онд АЖХТ- өөс эрхлэн явуулсан судалгаанд МУ-д үйл ажиллагаа явуулдаг тур оператор компаниудын өгсөн хариултыг харвал, үйлчилгээний салбарын ажилтнуудын ур чадвар хамгийн дутмаг байгааг дурджээ. Энэ нь, салбарын үйлчилгээний чанарыг сайжруулах хамгийн чухал асуудал бөгөөд, мэргэшлийн дадлага туршлага олгох нарийн мэргэжлийн сургалт дутмаг, орон нутгийн хувьд энэ чиглэлээр сургалт бараг хийгддэггүйтэй холбоотой юм.

Аялал жуулчлалын салбарын шийдвэрлэх асуудлын нэг нь хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах явдал бөгөөд, дэлхий даяар тархсан цар тахлын нөлөө ч асуудлыг улам даамжруулж байна. Үүнээс үүдэн мэргэжлийн боловсон хүчнийг тогтвортой ажлын байраар хангах хүндрэл үүсэх магадлалтай учир, Монголд хэрэгжүүлэх боломжтой шинэ стандарт дүрэм журмыг боловсруулж, аялал жуулчлал, ялангуяа үйлчилгээтэй холбоотой ажилтан бэлтгэх, чадавхижуулах сургалтыг тасралгүй явуулах шаардлагатай байгаа талаар саналаа ирүүлжээ.

(2) Боловсролын байгууллага (Их дээд сургууль, МСҮТ)

1) Их дээд сургууль

Монгол улсын дээд боловсролын асуудлыг Боловсрол, шинжлэх ухааны яам хариуцдаг бөгөөд 2019 оны тоо баримтаас харвал улсын хэмжээнд 95 их, дээд сургууль байна. Үүнээс, аялал жуулчлалын мэргэжлээр мэргэжилтэн бэлтгэдэг 30 их, дээд сургууль (хувийн сургуулийг оруулаад) байдаг бөгөөд тэдгээрээс төрийн өмчийн 9 сургууль, төрийн бус өмчийн 13 сургууль, нийт 22 их, дээд сургуулийг анкет судалгаанд хамруулав. (Судалгааны хугацаа: 2021.1.28-2.9). Судалгаанд хамрагдсан их дээд сургуулийн танилцуулга, сургалтын хөтөлбөрийн онцлог, давуу талыг Хүснэгт 2-18-д үзүүлэв. Зарим сургуулийн сургалтын хөтөлбөрийн онцлогоос дурдвал, 11

сургуульд гадаад хэл үздэг, үүнээс 6 сургууль Хятад, Солонгос, Япон хэлийг сонгон суралцах боломжтой, мөн Америк улс руу интерншип-дадлагад хамруулдаг сургууль ч байна. 2018 оноос хойш 3 сургууль аялал жуулчлал болон салбарын холбогдох мэргэжлийн ангийг шинээр нээжээ. Харин, МҮИС-ын аялал жуулчлал, газарзүйн тэнхимд (аялал жуулчлалын менежмент мэргэжлээр) элсэн суралцаж буй оюутан одоогоор байхгүй байна. 2021 оны байдлаар судалгаанд хамрагдсан их, дээд сургуулиудад нийт 78 багш ажиллаж, 1,475 оюутан суралцаж байгаа ба 5,023 оюутан төгсөн гарчээ.

Хүснэгт 2-18: Судалгааны хамрагдсан их дээд сургуулиудын мэдээлэл, сургалтын хөтөлбөрийн онцлог

No.	Сургуулийн нэр, хөтөлбөрийн онцлог	Тэнхимийн нэр	Мэргэшэх чиглэл	АЖ, ЗУ-ий багш	Суралцаж буй оюутны тоо	Төгсөгчийн тоо
1	Монгол Улсын Их Сургууль - Олон улсад докторын зэрэг хамгаалсан багшлах боловсон хүчин - Сургалтын олон янзын аргаар зааж чадвартай багш нар - Аялал жуулчлалын салбарын Яам, ТББ, ОУБ, хувийн хэвшилтэй хамтран ажилласан олон жилийн туршлага - Эрамыс Мундус хөтөлбөртэй хамтын ажиллагаатай - Гадаад зочин багш, судлаачаар ажилладаг багш нар - Сургалтын тохиолот орчин - Олон улсын жишиг б/уайн номын сан - Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн их сургууль - Аялал жуулчлалын бакалаврын т/вшний сургалтын анхдагч - Либерал арт хөтөлбөр - Хичээлийн баялаг агуулга	Шинжлэх Ухааны Сургууль Байгалийн Ухааны салбар Газар зүйн тэнхим	Аялал жуулчлалын менежмент Аялал жуулчлал судлал Соёлын аялал жуулчлал	4	60	660
2	ХААИС -Эдийн засаг бизнесийн сургуульд аялал жуулчлалын маркетингийн төрөлжсөн хөтөлбөрийг Монгол улсад анх удаа хэрэгжүүлж байна. -Агроэкологийн сургуульд, байгалийн аялал жуулчлалын мэргэжлийн ангид байгалийн объектуудыг талаар, мөн ХАА, маа чиглэлийн судалгаа шинжилгээний лабораториор бүрэн хангагдсан тул, Монголын нүүдэлчдийн соёл үндэслэсэн байгаль экологийн аялал жуулчлалын талаар т/лх/у судалдаг.	Эдийн засаг бизнесийн сургууль Маркетингийн тэнхим	Аялал жуулчлалын маркетинг	5	48	шинээр нээсэн учир төгсөгчгүй
		Агроэкологийн сургууль Экологийн тэнхим	Байгалийн аялал жуулчлал	8	59	675
3	МУБИС -Аялал жуулчлалын менежер хөтөлбөрөөр суралцагчид мэргэжлийн хичээлээс гадна гадаад хэлийг сонголттойгоор олон цагаар судлах боломжтой. Мөн БНХАУ, Япон, Солонгос зэрэг улсуудад 6-12 сарын дугаартай дадлага хийж боломжтой.	Бизнесийн Тамирын Сургууль	Аялал жуулчлал (Спорт аялал)	2	41	95
4	ШУТИС -Аялал жуулчлалын менежментээр мэргэшиж, Японд 1 жил интерншип хөтөлбөрт хамрагддаг.	Бизнесийн Улирлага, Хүмүүнлэгийн Сургууль	Аялал Жуулчлалын Менежмент	4	79	—
5	Худалдаа Үйлдвэрлэлийн Их Сургууль	Худалдаа маркетингийн тэнхим	Аялал жуулчлалын менежер, Аялал жуулчлал, зочлох үйлчилгээний мэргэжилтэн	2	—	—
6	Соёлын Сургууль (Соёл Урлагийн Их Сургууль) -Үндэсний өв соёл тулгуурласан соёлын аялал жуулчлал, Соёл суурьтай аялал жуулчлалын мэргэжилтэн бэлтгэдэг.	Соёл Судлалын Судалгаа, Сургалтын профессорын баг	•Соёлын судлаач багш •Соёлын өв музей судлал •Соёл судлал – Нийгэм соёлын ажилтан •Соёл судлал – Ардын урлаг судлал	2	31	—
		Аялал жуулчлал	• Соёлын Аялал Жуулчлал • Аялал Жуулчлал – Гадаад хэл •Зочлох Үйлчилгээ	—	—	шинээр нээсэн учир элсэгчгүй
7	Соёл-Эрхэм дээд сургууль -Эко аялал жуулчлалаас гадна, хятад, япон хэл сонгон үздэг.	Аялал Жуулчлал	Аялал жуулчлалын менежмент	2	7	180
8	Монголын Үндэсний Их Сургууль -Тусгай сонирхолын аялал жуулчлалын чиглэлээр мэргэшүүдэг сургалт явуулдаг. "Аялал жуулчлал" хөтөлбөр нь Япон улсуруу дадлагажих хөтөлбөрөөр оюутнуудаа илгээжэг ба япон хэлийг 4 жил тасралтгүй судлахаар хөтөлбөрөө шинэчилсэн.	Аялал Жуулчлал Газрын Харилцааны Сургууль	Аялал жуулчлалын менежмент	—	2015 оноос хойш элсэгчгүй	500
			Аялал жуулчлал	—	97	2018 онд шинээр нээсэн учир төгсөгчгүй
			Зочлох үйлчилгээ	—	14	152
			Агаарын тээврийн үйлчилгээ	—	69	2018 онд шинээр нээсэн учир төгсөгчгүй
9	Олон Улсын Улаанбаатарын Их Сургууль -Аялал жуулчлалын менежмент, сонгогч хэлээр мэргэшүүлдэг.	Бизнес менежмент тэнхим	Аялал жуулчлалын менежмент	3	79	—
10	Хүмүүнлэгийн Ухааны Их Сургууль -Аялал жуулчлалын боловсролын хөтөлбөрт гадаад хэл, газарзүйн хичээл ордог.	Бизнес менежмент тэнхим	Аялал жуулчлалын менежмент	2	125	1000

11	Огонтэнгэр их сургууль -Аялал жуулчлалын хөтөлбөр нь Япон улсад цалинтай дадлагажигч хөтөлбөр хэрэгжүүлдэг. -Европын холбооны Erasmus+ төслийн хүрээнд Аялал жуулчлалын хөтөлбөрөөр суралцагчдыг ажлын байранд дадлагажуулах, МУ дахь уг хөтөлбөрийн чанарыг сайжруулах төсөл хэрэгжүүлж эхэлсэн. -Агаарын тээврийн үйлчилгээ хөтөлбөр нь Монгол Улсдаа анхдагч онгоцны үйлчлэгч болдож байгаа, МИАТ, Хүннү Эйр, ИНЕГ гэсэн байгууллагуудтай гэрээтэй оюутнуудаа зочлох үйлчилгээ, нислэгт гарган дадлагажуулдаг. -Солонгосын сургуультай 2+2 хөтөлбөр хэрэгжүүлдэг	Эдийн засаг, бизнесийн удирдлагын сургууль	Аялал жуулчлалын менежмент Агаарын тээврийн үйлчилгээ	4	25 120	— —
12	Глобал удирдагч их сургууль • Хичээл англи хэлээр явагддаг, Америкийн их сургуультай холбоотой ажилладаг.	Бизнесийн удирдлагын тэнхим	Аялал жуулчлалын менежмент	2	—	45
13	Эгүгэн Их Сургууль -Эрүүл мэндийн аялал жуулчлалын чиглэлээр сургалт явуулахаараа онцлог.	Төрийн захиргаа, бизнесийн удирдлага	Аялал жуулчлал, сувиллын газрын менежмент	2	5	—
14	MIU Сургууль -Олон улсын аялал жуулчлалын талаарх хичээл англи хэлээр явагддаг.	Зочид буудал, аялал жуулчлалын менежмент	—	5	—	—
15	Газарчин Дээд Сургууль -Монголд аялал жуулчлалын мэргэжилтэн бэлтгэдэг анхны сургууль	Аялал жуулчлалын менежмент	—	4	80	1050
16	Идэр Их Сургууль -Лондон ABE, АНУ-ын ACBSP байгууллагын бизнесийн хөтөлбөрийн магадлан итгэмжлэл, -БНАСУ, АНУ оюутан солилцоо, -Япон оронд интернип, цалинтай дадлагажигч хөтөлбөр,	Бизнесийн удирдлагын тэнхим	Аялал жуулчлал, зочлох үйлчилгээний менежмент	3	260	—
17	Их засаг олон улсын их сургууль -Хөтөлбөрийн 23 хувь нь чадвар олгоход чиглэлдсэн дадлага, практик, 10 хувь нь контент хөгжүүлэлт, 32 хувь нь адал явдал аялал, мэргэжлийн хичээлүүд эзэлдэг.	Үндэсний инженер технологийн сургууль	Байгалийн аялал жуулчлал Гадаад хэл аялал жуулчлал Зочид буудал зоогийн газрын менежмент	7	132	—
18	Хангай Их Сургууль	Бизнесийн удирдлага, мэдээлэл технологийн тэнхим	Аялал жуулчлалын менежмент	3	22	100
19	Сити Их Сургууль	Аялал жуулчлалын тэнхим	1.Аялал жуулчлал 2.Зочлох үйлчилгээ 3.Агаарын тээврийн үйлчилгээ	2	80	350
20	Ховд Их Сургууль -АЖ-ын үйлчилгээний бүх салбарт ажиллах чадвартай менежер бэлтгэдэг -Гадаад хэлний гүнзгийрүүлэн сонгон судлах боломжтой /англи, орос, япон, солонгос/ -Хөтөч тайлбарлагчийн ур чадварыг давхар эзэмшдэг -Байгалийн чиглэлийн АЖ-н хүрээнд гүнзгийрсэн мэдлэг, ур чадварыг олгодог	Нийгэм Хүмүүнлэгийн ухааны сургууль Бизнесийн тэнхим	Аялал жуулчлалын менежмент	1	10	136
21	Дархан дээд сургууль -Аялал жуулчлал, гадаад хэлний чадварлаг мэргэжилтэн бэлддэг.	Хүмүүнлэгийн ухааны тэнхим	Аялал жуулчлал (Англи хэл, Япон хэл)	4	—	—
22	Дорнод дээд сургууль -Хятад хэлнийг түлхүү судалдаг.	Хүмүүнлэгийн ухааны тэнхим	Аялал жуулчлал, Хятад хэлний орчуулагч	1	32	80
Нийт				78	1,475	5,023

Эх сурвалж : Анкетаар авсан судалгааны дүнд үндэслэн судалгааны баг боловсруулав.

2) Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллага

Монголд МСҮТ зэрэг мэргэжлийн ур чадвар олгодог боловсролын байгууллага нь ажил үүргийн хүрээнд Нийгэм хамгаалал, хөдөлмөрийн яаманд харьяалагддаг. Сургалтын хувьд, дунд болон ахлах сургуулийн сурагчдад зориулсан (1.5-аас 3 жил), насанд хүрэгчдэд зориулсан (богино хугацааны) хөтөлбөрүүдтэй. 2019 оны байдлаар улсын хэмжээнд тусгай зөвшөөрөлтэй нийт 86 мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагууд байгаа ба үүнээс 15 байгууллага нь аялал жуулчлал болон зочлох үйлчилгээний чиглэлээр мэргэжилтэн бэлтгэж байна. Судалгааны баг одоо үйл ажиллагаа явуулж буй дараах 10 байгууллагаас анкетын болон аман асуулгаар судалгаа авав (Судалгааны хугацаа:2021.2.1-2.9). Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагууд сургалтын хөтөлбөрөө боловсруулахдаа хамтарч ажилладаг тур оператор, зочид буудал, жуулчны бааз зэрэг аж ахуйн нэгж, байгууллагуудаас судалгаа авч, тэдний санал санаачилгад үндэслэн сургалт зохион байгуулдгаараа онцлог юм. Орон нутгийн хувьд, тухайн бүс нутгийн аялал жуулчлалтай холбоотой сэдвийг хичээлийн агуулгад түлхүү оруулдаг ба орон нутгийн ажлын байрны эрэлт хэрэгцээ, ажил олгогчийн шаардлагад нийцсэн сургалтын хөтөлбөрөөр сургалт явуулж, төгсөгчдөө хамтарч ажилладаг байгууллагад зуучилж ажилд оруулах тохиолдол ч байдаг байна. 2021 оны байдлаар эдгээр 10 байгууллагад нийт 34 багш ажиллаж, 371 оюутан суралцаж байна. Харин, аялал жуулчлалын мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэж эхэлснээс хойш нийт 4,225 суралцагч төгсөн гарчээ.

Хүснэгт 2-19: Судалгаанд хамрагдсан мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагуудын мэдээлэл болон сургалтын хөтөлбөрийн онцлог, давуу тал

No.	МСҮТ нэрс, сургалтын хөтөлбөрийн онцлог	Тэнхимийн нэр	Мэргэшил	АЖ, ЗҮ-ний багш	Суралцаж буй оюутны тоо	Нийт төгсөгчдийн тоо
1	Гурвантамир МСҮТ	Тэнхимгүй	Зочид буудал, жуулчны баазын үйлчилгээний ажилтан (1 жил)	2	75	58
2	Универсал Политехник Коллеж • МУИС-ын харьяа учир тус их сургуулийн багш нар ажилладаг. Жил бүр шинээр элсэх оюутны тоо 20%-аар нэмэгдэж байгаа.	—	Хөтөч тайлбарлагч	2	40	20
3	Аялал жуулчлалын ур чадварын МСҮТ • Чадамжид суурилсан хөтөлбөр хэрэгжүүлдэг. Нью жуулчин компанийн харьяа.	Аялал жуулчлал, зочлох үйлчилгээний тэнхим	Аялал жуулчлал, зочлох үйлчилгээний мэргэжлийн ажилтан	5	77	295
4	Үйлдвэрлэл Урлалын Политеник Коллеж • Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийг сургалтандаа ашигладаг.Зочид буудал, үйлчилгээний салбарын мэргэжилтэн бэлтгэхэд түлхүү анхаардаг.	Мэдээллийн технологи, аялал жуулчлалын тэнхим	Зочид буудал, жуулчны баазын үйлчилгээний ажилтан (1 жил) □	3	55	441
			Агаарын хөлгийн үйлчилгээний ажилтан (2 жил)		8	37
5	Техник технологийн дээд сургууль • Зочлох үйлчилгээний салбарын гол хүний нөөц болох менежер, рестораны ажилтнууд, зочид буудал, зоогийн газрын үйлчилгээний ажилтнууд зэргийг ажил олгогчдын эрэлтэд нийцүүлэн мэдлэг, чадамж, хандлага эзэмшүүлэхэд хөтөлбөрөө боловсруулсан.	Хүнс, био инженерчлэлийн тэнхим	Аялал жуулчлал, зочид буудал, жуулчны баазын үйлчилгээний ажилтан	13	38	2345
6	Архангай аймаг дахь МСҮТ • Бүс, орон нутгийн аялал жуулчлалын хичээлийн цаг илүү түлхүү ордог.	Хөдөө Аж Ахуй, барилга,үйлчилгээний тэнхим	Аялал жуулчлалын хөтөч, тайлбарлагч	2	18	—
7	Өвөрхангай аймаг дахь Политехник коллеж • Сурагчдад зориулсан хангалттай дадлагын баазтай бөгөөд сурагч бүрийг дадлага хийх боломжоор хангаж өгдөг. Ур чадварыг нэмэгдүүлж суралцагч бүртэй тулж ажилладаг.	Компьютер, Эдийн засгийн баг	Зочид буудал, жуулчны баазын үйлчилгээний ажилтан (1 жил)	2	24	20
8	Дундговь аймаг дахь МСҮТ • Орон нутаг дахь ажлын байрны шаардлага, ажил олгогчдын эрэлт хэрэгцээнд тулгуурлан боловсруулагдсан, ажлын байран дээр зохион байгуулдаг. Ажлын байран дээрх дадлагын хувьд, тогооч болон борлуулалтын ажил голлодог.	Үйлдвэр, үйлчилгээний тэнхим	Зочид буудал, жуулчны баазын үйлчилгээний ажилтан	1	—	9
9	Хангай МСҮТ • Аяллын хөтөч мэргэжлээр элсэгчдэд сургалт явуулдаг нь тухайн мэргэжлийн мэргэшсэн боловсон хүчин бэлтгэх үндсэн суурийг нь тавьж өгдөг.	Мэргэжлийн танхим	Аяллын хөтөч, □	3	24	1000
			Зочид буудал, Жуулчны баазын үйлчилгээний ажилтан (1 жил)			
10	Хөвсгөл аймаг дахь МСҮТ • Орон нутгийн онцлог аялал жуулчлалын маршрутын дагуу мэдээллийг тусгасан. Мөн аялал жуулчлалын салбарын түншлэгч байгууллагуудын саналыг тусгасан. Аялал жуулчлалын бүс учир үйлчилгээний салбарын хүний нөөцийг хөгжүүлэхэд түлхүү анхаардаг.	Үйлдвэр, үйлчилгээний заах аргын нэгдэл	Аяллын хөтөч	1	12	—
Нийт				34	371	4,225

Эх сурвалж : Анкет судалгааны дүнд үндэслэн судалгааны баг боловсруулав.

Их дээд сургууль, МСҮТ, коллежуудаас авсан судалгааны дүнд үндэслэн, тулгарч буй нийтлэг асуудлыг доор нэгтгэн дурдав.

- Аялал жуулчлалын салбарын мэргэжлийн үнэлэмж сул байдгаас, аялал жуулчлалын холбогдох байгууллагууд мэргэжлийн бус хүнийг бага цалин хөлсөөр ажиллуулдаг. Тиймээс салбарын ур чадвартай, мэргэжил эзэмшсэн хүмүүсийн ажлын байр хязгаарлагдмал байна.
- Элсэн суралцагчид болон нийгэмд аялал жуулчлалын талаарх ойлголт сул, нэр хүнд тааруу. Суралцагчид аялал жуулчлал, зочлох үйлчилгээний мэргэжлээр сурах сонирхол, эрэлт хэрэгцээ хомс байна.
- Аялал жуулчлалын чиглэлийн мэргэжлийн хичээлээс гадна гадаад хэлний боловсрол олгодог боловч, багш нарын мэдлэг туршлага, сургалтын орчин нөхцөл хангалтгүйгээс ихэвчлэн мэргэжлийн гадаад хэлний багш бус гадаад хэл мэддэг мэргэжлийн бус хүн авч ажиллуулдаг.
- Анги танхимд практик сургалт явуулах тоног төхөөрөмж, хэрэгсэл, шаардлагатай сурах бичиг, гарын авлага дутмаг.

Эдгээр асуудлуудтай холбогдуулан, шаардлагатай дэмжлэг туслалцааны талаар, аялал жуулчлалын чиглэлээр мэргэжлийн түвшинд боловсрол олгодог олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сургууль байгуулах зэрэг сургалтын орчин нөхцөлийг бүрдүүлэх, ажлын байран дээрх дадлага сургалтыг хамтарч хэрэгжүүлэх, багш нарыг мэргэшүүлж, чадавхижуулах сургалтыг зохион байгуулах зэрэг саналуудыг дэвшүүлсэн байна.

(3) Төрийн бус байгууллага

1) Монголын Аялал Жуулчлалын Холбоо

Энгийн горимоор үйл ажиллагаагаа явуулж байх үед, тур операторуудын удирдлага, менежер, аяллын хөтөч, тайлбарлагч, жолооч, тогооч нарт зориулсан анхан шатнаас ахисан түвшний бүх төрлийн сургалт болон аяллын бүтээгдэхүүний төлөвлөлт хариуцсан мэргэжилтнүүдэд зориулсан зорилтот сургалтыг зохион байгуулдаг. Мөн, хууль эрх зүй, гэрээ хэлцэл, нийгмийн даатгал зэрэг аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагаагаа өргөтгөхтэй холбоотой мэдлэг туршлага солилцох чиглэлээр сургалт зохион байгуулдаг боловч, 2020 онд дэлхийг хамарсан Ковид-19 цар тахлын нөлөөгөөр ямар нэгэн сургалтын үйл ажиллагаагаа явуулаагүй. Харин, 2021 он гарснаас хойш, хууль эрх зүй, нийгмийн даатгал, татвар хураамжтай холбоотой сэдвээр сургалтын хөтөлбөр боловсруулж, цахим хэлбэрээр зайн сургалт явуулж байна.

Цаашид, олон улсын байгууллагатай хамтран, туршлага солилцох, хууль эрх зүйн мэдлэгээ нэмэгдүүлэх талаар шат дараалалтай сургалтыг тогтмол хийхээр төлөвлөж байгаа бөгөөд, улмаар хүний нөөцийг чадавхижуулах чиглэлээр төсөл боловсруулж, санал болгохоор ажиллаж байна. Холбооны зүгээс холбогдох сургалт, семинарын үйл ажиллагааг тасралтгүй, шат дараалалтайгаар зохион байгуулах, мөн сургалтын үр дүнгийн талаар судалгаа хийх, сургалтад оролцсон хүмүүстэйгээ эргэх холбоотой байх нь чухал гэж үзэж байна.

2) Мэргэжлийн Хөтөч Тайлбарлагчдын Холбоо

2003 оноос хойш, хөтөч тайлбарлагчдын ур чадварыг дээшлүүлэх, суурь мэдлэг олгох хуваарьт сургалтыг жилд 3 удаа хэрэгжүүлж ирсэн. Мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалт нь хөтөч-тайлбарлагч нар зайлшгүй эзэмшвэл зохистой техник, мэргэжлийн ур чадварыг заадаг. Суурь мэдлэг олгох сургалтыг Шинжлэх Ухааны Академитай, эмнэлгийн анхны тусламж үзүүлэх, хууль зүйн чиглэлийн сургалтуудыг бусад мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулдаг. Сургалтын заах арга, сургалт хэрэгжүүлэх арга хэлбэрийг байнга шинэчилж, сайжруулсаар ирсэн ба орон нутгийн хөтөч-тайлбарлагчдад зориулсан сургалтыг ч тогтмол явуулж байна. Мөн, байгаль орчинд ээлтэй хариуцлагатай аялах “ Ул мөрөө бүү үлдээ” зарчмыг дагаж мөрдөх талаар дадлага сургалтыг ч хэрэгжүүлдэг.

Цаашид, Ковид-19 цар тахлын нөлөөгөөр бий болсон шинэ дүрэм журам, стандартад тулгуурлан, бусад улсын туршлагаас суралцаж одоо байгаа сургалтын хөтөлбөрөө сайжруулж, аяллын хөтөч тайлбарлагч, салбарын үйлчилгээний ажилтнуудад халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх

талаар, амьдралын шинэ хэв маягт хэрхэн дасан зохицож амьдрах талаар 12 цагийн сургалтыг, донор болон төрийн захиргааны байгууллагуудтай хамтран зохион байгуулахаар төлөвлөж байна. 2021 оны 3 сард, байгалийн түүхийн музей (Үлэг гүрвэлийн музей)-тэй хамтран, хөтөч тайлбарлагч нарт онол, дадлага хосолсон 2-3 өдрийн сургалтыг хэрэгжүүлсэн.

Сургалтын тоог нэмээд зогсохгүй, хөтөч тайлбарлагчийн мэргэжлийн эрх, үнэмлэх олгох стандарт боловсруулж, эрх олгох сургалт хэрэгжүүлэх, хөтөч тайлбарлагчийн ажлыг улирлын онцлогтой ажил мэргэжлийн ангилалд оруулж баталгаажуулан, нийгмийн даатгалын шимтгэлд хамрагддаг болгох, тэднийг тогтвортой ажиллах тогтолцоог бүрдүүлэх зорилго тавин ажиллаж байна. Мөн, хөтөч тайлбарлагчдын хувьд хамгийн ойр ажилладаг багийн гишүүд болох аяллын жолоочийн үйлчилгээний талаар сургалт явуулах хүсэлт ирсэн боловч, хараахан ойрын төлөвлөгөөнд тусгагдаагүй байна.

Тус холбооноос, “аялал жуулчлалын мэргэжлээр их дээд сургууль төгссөн хүмүүс бүгд гадаад хэлний мэдлэгтэй байдаггүйтэй адил, гадаад хэлээр мэргэшсэн хүмүүсийн дунд аялал жуулчлалын талаар ойлголтгүй, менежментийн ур чадваргүй хүмүүс ч олон бий. Тиймээс шинэ мэргэжлээр сургана гэхээсээ илүү, одоо байгаа хүмүүсээ чадавхижуулж, аялал жуулчлалын шинэ урсгал чиглэл (тогтвортой аялал жуулчлал, цахим аялал зэрэг)-тэй холбоотой сургалт явуулах талаар төлөвлөгөөндөө тусгах нь зүйтэй” гэсэн санал илэрхийлжээ.

3) Монголын Зочид Буудлуудын Холбоо

Хөдөлмөр, нийгэм хамгааллын яамнаас мэргэжлийн сургалт зохион байгуулах тусгай зөвшөөрөлтэй байгууллага бөгөөд, зочид буудлын өрөөний үйлчлэгч, зочин хүлээн авагч, гэрийн үйлчилгээ хариуцсан ажилтан, аяллын тогооч (аяллын багтай хамт явах тогооч), хаалгач, ачаа зөөгчийн мэргэжлийн үнэмлэх олгох сургалтыг зохион байгуулдаг. 2020 оны 9 сараас 2021 оны 2 сар хүртэл Европын сэргээн босголтын банктэй хамтран, 6 төрлийн олон улсын мэргэжлийн сургалтад салбарын хүний нөөцийн менежерүүдийг үнэ төлбөргүй хамруулсан. Орон нутгийн зочид буудлуудын зочлох үйлчилгээ хариуцсан албан тушаалтнуудад онлайн сургалтыг шат дараалалтай явуулж байна.

Цаашид, хүний нөөцийн хомсдолд ороод буй эрэлт хэрэгцээ ихтэй мэргэжил болох тогооч, зөөгч, гэрийн үйлчлэгч, орон нутгийн хөтөч-тайлбарлагч, зочид хүлээн авагч нарт зориулж сургалт хийхээр төлөвлөж байна. Мөн, хөдөлмөр эрхлээгүй иргэдийн ажлын байрны эрэлт хэрэгцээнд үндэслэн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх бодлогын дагуу, 14-21 хоногийн хугацаатай мэргэжлийн ур чадвар олгох сургалтыг зохион байгуулахаар төлөвлөж байна.


4) Аялал Жуулчлалын Боловсрол Хөгжлийн Нийгэмлэг

БОАЖЯ-ны дэмжлэгтэйгээр аялал жуулчлалын салбарын багш судлаачдад зориулсан богино хугацааны мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулсаар ирсэн. 2021 оны байдлаар сургалт хийхгүй байгаа бөгөөд, аялал жуулчлал, зочлох үйлчилгээний салбарын хүнийг нөөцийг хөгжүүлэхэд шаардлагатай сурах бичиг, гарын авлага боловсруулахаар мэдээлэл цуглуулж, судалгаа хийж байна. Мөн, онлайн сувгаар аялал жуулчлалын салбартай холбоотой мэдлэг мэдээллийг хүргэж байна.

2.7 Тээврийн салбарын дэд бүтэц

(1) Нисэх онгоцны буудал, агаарын тээвэр


2021 оны 7 сард шинэ нисэх онгоцны буудал нээгдэхээс өмнө, Улаанбаатар хотоос 15 км орчим зайд байрлах Буянт-Ухаа нисэх онгоцны буудал нь Монгол улсын агаарын замын үүд хаалга болж, олон улсын нислэг үйлддэг цорын ганц нисэх буудал байсан ба цагт 1000 орчим зорчигч хүлээн авах хүчин чадалтай. 2019 онд Буянт-Ухаа нисэх онгоцны буудлаас хөөрч буух нислэг болон улсын хэмжээний бусад агаарын тээврээр зорчсон нийт зорчигчдын тоо 1,621,571 хүн (дотоодод 433,367 хүн, олон улсад зорчигчид 1,188,204 хүн) (2019 он, ҮСХ) болж өмнөх оноос 14 хувь өссөн байна. Нислэгийн тооны хувьд жилд нийт 18,109 нислэг (олон улсын нислэг 10,142, дотоодын нислэг 7,967) (2019 он, ИНЕГ статистик) үйлдэж, өмнөх оноос тус бүр 19%, 25% өссөн байна. Ковид-19 цар тахлын нөлөөгөөр 2020 онд нислэгийн тоо цөөрсөн хэдий ч, сүүлийн жилүүдэд дотоод, гадаад нислэгээр зорчигчдын тоо нэмэгдэх хандлагатай байна.



Эх сурвалж : Үндэсний Статистикийн Хорооны мэдээллийн санд үндэслэн судалгааны баг боловсруулав.

Зураг 2-10: 2015-2020 оны агаарын тээвэрээр зорчигчдын тоо (нислэгийн төрлөөр)

2020 онд Ковид-19 цар тахлын нөлөөгөөр Монгол Улсын Засгийн Газар хилээ хаах шийдвэр гаргаснаар, жуулчид төдийгүй дотоод гадаад нислэгийн тоо огцом буурсан. Доор 2019 онд олон улсын нислэгээр зорчсон зорчигчдын тоо, урсгал чиглэлийг гадаад улс, хотоор нь харуулав. 2019 онд 21 улс руу хуваарьт нислэг үйлдэж байсан бөгөөд хамгийн олон зорчигч Улаанбаатар-Сөүл чиглэлд, дараа нь Бээжин, Москва, ХонгКонг, харин Токио 5-рт жагссан байна. Монгол улсын агаарын тээврийн салбарт, аялал жуулчлалын салбар шууд нөлөө үзүүлдэг бөгөөд зуны улирал буюу жил бүрийн 6-8 дугаар саруудад жуулчдын тоо өсдөгийг эндээс харж болно.



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хорооны мэдээллийн санд үндэслэн судалгааны баг боловсруулав

Зураг 2-11: Олон улсын нислэгээр зорчигчид (2019он)

Дээр дурдсаны дагуу, одоогийн байдлаар Монгол улсын хувьд Ковид-19 цар тахлын нөлөөгөөр зарим гадаад улс, хот руу хийж буй захиалгат нислэгээс өөр нислэг үйлдэхгүй байгаа учир, нислэгийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл цуглуулахад хүндрэлтэй байна. Доор 2019 оны нислэгийн чиглэл, агаарын тээврийн компани, тасалбарын үнэ, нислэгийн давтамж, хугацаа зэрэг мэдээллийг харуулав.

Хүснэгт 2-20: Улаанбаатар хотын Буянт-Ухаа НОБ-ын олон улсын нислэгийн мэдээлэл (2019 оны байдлаар)

	Нислэг хийх хотын нэр	Дамжин өнгөрөх газрын нэр	Давтамж		Зуны үнэ	Өвлийн үнэ	Тодруулга
			Зун (3.31~10.26)	Өвөл (10.27~3.28)	Төлбөрийн нэгж : Төгрөг (2 талын нислэгийн дундаж үнэ)		
1	Seoul (Korean Air)	шууд	7 хоногт 3 удаа	7 хоногт 3 удаа	996,800	870,000	
	Seoul (MIAT)	шууд	7 хоногт 7-11 удаа	7 хоногт 6 удаа	1,112,100	854,700	
	Seoul (Asiana Airlines)	шууд	7 хоногт 3 удаа	7 хоногт 3 удаа	870,300	870,300	
2	Beijing (Air China)	шууд	7 хоногт 7 удаа	7 хоногт 7 удаа	646,900	646,900	
	Beijing (MIAT)	шууд	7 хоногт 7-10 удаа	7 хоногт 7 удаа	775,500	805,200	
3	Moscow (Aeroflot)	шууд	7 хоногт 3 удаа	7 хоногт 5 удаа	1,570,400	1,570,400	
	Moscow (MIAT)	шууд	7 хоногт 4 удаа (Мя, Пү, Ба, Ням)	7 хоногт 2 удаа	1,744,700	1,800,500	Пү, Ням (зун) - Тогтмол хуваарьт нислэг; Мя, Ба- Нэмэлт нислэг (зөвхөн 7-8 сард)
4	Hong Kong (EZnis)	шууд	7 хоногт 2 удаа	7 хоногт 2 удаа	1,100,000	828,000	
	Hong Kong (MIAT)	шууд	7 хоногт 7 удаа	7 хоногт 2 удаа	974,900	1,210,700	
5	Tokyo (MIAT)	шууд	7 хоногт 5-7 удаа	7 хоногт 5 удаа (Да, Мя, Ба, Бя, Ням)	1,651,600	712,900	Да, Лха, Ба -Тогтмол хуваарьт нислэг; Мя, Пү, Бям, Ням-Нэмэлт нислэг (Хуваарь, хугацаа өөрчлөгдөх магадлалтай)
6	Busan (Air Busan)	шууд	7 хоногт 1 удаа	7 хоногт 1 удаа	768,000	768,000	
	Busan (MIAT)	шууд	7 хоногт 2 удаа	7 хоногт 2 удаа	1,070,300	686,000	
7	Erlan (Hunnu Air)	шууд	7 хоногт 2 удаа	7 хоногт 2 удаа	400,000	400,000	
8	Istanbul-Bishkek (Turkish Airlines)	Бишкек	7 хоногт 3 удаа	7 хоногт 3 удаа	1,900,000	1,892,300	
9	Berlin (MIAT)	шууд	7 хоногт 3 удаа (Пү, Ба, Ням)	7 хоногт 2 удаа	2,316,300	2,379,500	
10	Hohhot (Air China)	шууд	7 хоногт 2 удаа	7 хоногт 2 удаа	560,700	671,300	
	Hohhot (Aero Mongolia)	шууд	7 хоногт 3 удаа (Да, Лха, Ба)	7 хоногт 3 удаа (Да, Лха, Ба)	705,000	705,000	
11	Irkutsk (Asiana Airlines)	шууд	7 хоногт 2 удаа (Мя, Бям)	7 хоногт 2 удаа	518,440	552,840	
	Irkutsk (Aero Mongolia)	шууд	7 хоногт 4 удаа (Да, Лха, Ба, Ням)	7 хоногт 3 удаа (Да, Лха, Ба)	425,000	425,000	
12	Guangzhou (MIAT)	шууд	7 хоногт 2 удаа	7 хоногт 2 удаа	1,002,500	1,002,500	
13	Moscow-Berlin (MIAT)	Москва	7 хоногт 3 удаа (Пү, Ба, Ням)	7 хоногт 2 удаа	2,316,300	2,379,500	Пү, Ням (зун) -Тогтмол хуваарьт нислэг(Москвагаар дайрч өнгөрнө) ; Ба-Нэмэлт нислэг (зөвхөн 7-8 сард)
14	Hailar (Hunnu Air)	шууд	7 хоногт 3 удаа	7 хоногт 2 удаа	400,000	400,000	
15	Frankfurt (MIAT)	шууд	7 хоногт 3 удаа (Мя, Лха, Бям)	7 хоногт 2 удаа	2,245,000	2,150,000	
16	Bangkok (MIAT)	шууд	7 хоногт 2 удаа (Лха, Бям)	7 хоногт 2 удаа	1,690,000	1,690,000	
17	Nur-Sultan (Scat Airlines)	шууд	7 хоногт 2 удаа	7 хоногт 2 удаа	1,235,100	1,235,100	
18	Ulan-Ude (Aero Mongolia)	шууд	7 хоногт 2 удаа	7 хоногт 2 удаа	300,000	300,000	
	Ulan-Ude (Hunnu Air)	шууд	7 хоногт 2 удаа	7 хоногт 2 удаа	290,000	256,900	
19	Manzhouli (Hunnu Air)	Улаан-Үд	7 хоногт 3 удаа	7 хоногт 2 удаа	325,000	295,000	
20	Osaka (Korean Air)	шууд	7 хоногт 2 удаа	-	1,646,500	-	
	Osaka (MIAT)	шууд	7 хоногт 2 удаа	-	1,588,900	-	Лха, Ням (Зөвхөн 7-8 сард)
21	Tianjin	шууд	7 хоногт 3 удаа (Да, Лха, Ба)	7 хоногт 3 удаа (Да, Лха, Ба)	530,000	530,000	

Эх сурвалж : Интернет дэх мэдээлэлд үндэслэн судалгааны баг боловсруулав.


Монгол улсад 2013 оноос эхлэн ЖАЙКА-ийн хөнгөлөлттэй зээлээр шинэ нисэх онгоцны буудал барих төсөл хэрэгжиж, нийслэл Улаанбаатар хотоос баруун тийш 50 км зайд орших Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт шинэ нисэх онгоцны буудал баригдсан. Шинэ нисэх онгоцны буудал (Нисэх буудлын нэр Чингис Хаан нисэх онгоцны буудал) -ын нээлт янз бүрийн шалтгаанаар хойшлогдсоор, 2021 оны 7 сарын 4-ний өдөр үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Ингэснээр, гадаад дотоод бүх нислэг шинэ Улаанбаатар олон улсын нисэх онгоцны буудал руу

шилжиж, одоогийн Буянт-Ухаа нисэх онгоцны буудлыг дадлага сургалтын зориулалтаар ашиглахаар төлөвлөж байна. Шинэ нисэх онгоцны буудал зорчигч тээврийн болон ачааны тус бүр 1 терминалтай, Буянт-Ухаа нисэх буудалтай адилхан 1 нислэгийн зурвастай боловч онгоц 2 талаасаа хөөрч буух боломжтойгоороо ялгаатай. Иймд, хүлээн авах нислэгийн тоо нэмэгдэж, жилд 3 сая хүн хүлээж авах хүчин чадалтай болох юм. Шинэ нисэх онгоцны буудлын үйл ажиллагааны хувьд, ЖАЙКА-аас “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын хүний нөөц, ашиглалт, менежментийн чадавхийг сайжруулах төсөл”-ийг хэрэгжүүлж байгаагаас гадна, Монгол Японы хамтарсан компани менежментийг хариуцахаар болсон. Ийнхүү Монголын нисэх буудлын үйл ажиллагаанд Японы ноу-хау туршлагыг нэвтрүүлснээр, үйлчилгээний чанар сайжирч, цаашид аялал жуулчлалын хөгжилд чухал хувь нэмэр оруулна гэж найдаж байна.

Агаарын тээврийн хөгжлийн хэтийн төлөвлөгөөний тэргүүлэх чиглэл нь шинэ нисэх буудлын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах явдал юм. Улмаар, 2024 он хүртэл зарим орон нутгийн нисэх буудлыг 4С ангилал (Олон улсын иргэний агаарын тээврийн байгууллага (ИКАО)-ын баталсан нисэх буудлын стандартын 4С ангилал: нислэгийн зурвас 1,800м-ээс урт, нислэг үйлдэх онгоцны далавчны урт 24м-36м дотор байх) болгож сайжруулах, орон нутгийн нисэх буудлын барилга байгууламж, хөөрч буух зурвасыг засварлах, сэргээн барих зэрэг төлөвлөгөө тусгагдсан байна. Одоогийн байдлаар зөвхөн шинэ нисэх онгоцны буудалд олон улсын нислэг хүлээн авч байгаа бөгөөд, Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого Алсын хараа 2050-д тусгасны дагуу, 2040 он хүртэл Дорнод, Увс, Баянхонгор, Ховд, Өмнөговь, Хөвсгөл гэсэн 6 аймгаас гадна Завхан, Өвөрхангай аймаг дах нисэх онгоцны буудлыг олон улсын нисэх онгоцны буудал болгож, зорчигч болон ачаа тээвэр хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлэхээр төлөвлөж байна.

(2) Төмөр Зам


Монгол улсын төмөр замын салбарт төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд үйл ажиллагаа явуулдаг ч үйл ажиллагааны цар хүрээгээрээ “Улаанбаатар төмөр зам” (ХНН) зонхилох байр суурийг эзэлж, Монгол улсын төмөр замын нийт сүлжээний 90 гаруй хувийг эзэмшдэг. Монгол улс нийтдээ 1815 км урт төмөр замтай бөгөөд урд хилээс хойд хил хүртэл 5 чиглэлд нийт 63 өртөөтэй.



Эх сурвалж : Landbridge LLC веб хуудаснаас авч ашиглав. https://www.landbridge.mn/Default.aspx?page=136&news_id=1113

Зураг 2-12: Төмөр замын сүлжээ

2019 оны байдлаар, төмөр замын тээврээр 2,948,100 хүн (2019 он, ҮСХ) зорчсон нь, өмнөх оноос 14.6 хувиар өсөж, 2010 оноос 16.2 хувиар буурсан байна. Сүүлийн жилүүдэд төмөр замын зорчигчдын тоо тогтмол буурч байгаа нь авто замын дэд бүтэц хөгжсөн хот хооронд зорчих автобусны ая тухтай байдал, аюулгүйн байдал зэргээс шалтгаалан иргэд хувийн машин болон хот хооронд зорчигч тээврийн унаагаар үйлчлүүлэх нь нэмэгдэж, илүү түргэн шуурхай тээврийн хэрэгслийг сонгох болсонтой холбоотой байна. Харин 2019 онд зорчигч тээврийн хэмжээ өссөн шалтгаан нь Улаанбаатар-Дархан-Уул аймгийг холбосон авто замын шинэчлэлттэй холбоотойгоор иргэд төмөр замын тээврийг сонгох нь ихэссэнтэй холбоотой байна. Мөн төмөр замын тээврээр дотоодод зорчсон зорчигчдын тоо 2,834,600 хүн (96.15%), олон улсад зорчигчид 113,500 хүн (3.85%) байна.



Эх сурвалж: 2019 Үндэсний Статистикийн Хорооны мэдээлэлд үндэслэн судалгааны баг боловсруулав.

Зураг 2-13: Төмөр замаар зорчигчдын тоо

Олон улсын зорчигчийн галт тэрэгний хуваарийг доор үзүүлэв. Бээжин-Улаанбаатар, Москва-Улаанбаатар гэсэн том хотуудаар зочлон, галт тэрэгний цонхоор Монголын үзэсгэлэнт байгалийг тольдонгоо тайван сайхан аялах боломжтой бөгөөд галт тэргэнд хоолны газартай, тав тухтай байдаг.

Хүснэгт 2-21: Олон улсын зорчигчийн галт тэрэгний хуваарь

Чиглэл	Давтамж
Москва→Улаанбаатар→Бээжин; Бээжин→Улаанбаатар→Москва	7 хоногт 1 удаа
Москва→Улаанбаатар; Улаанбаатар→Москва	7 хоногт 2 удаа
Эрхүү→Улаанбаатар; Улаанбаатар→Эрхүү	Өдөр бүр
Улаанбаатар→Эрээн; Эрээн→Улаанбаатар	7 хоногт 4 удаа
Улаанбаатар→Бээжин; Бээжин →Улаанбаатар	7 хоногт 1 удаа

Доорх хүснэгтэд одоо хэрэгжиж байгаа болон цаашид төлөвлөж буй төмөр замын зарим нэг томоохон төсөл хөтөлбөрийн талаарх мэдээллийг тусгав. Төмөр замыг хөгжүүлэх төлөвлөгөөний гол хөшүүрэг нь уул уурхай, Орос Хятадын хоорондох нүүрс тээвэрлэх гэсэн эдийн засгийн холбогдолтой төслүүд зонхилж, аялал жуулчлалыг хөгжүүлэхтэй холбоотой төсөл хөтөлбөр ховор байна.

Хүснэгт 2-22: Төмөр замын салбарын томоохон төсөл хөтөлбөрүүд


Төслийн мэдээлэл	Хэрэгжүүлэгч байгууллага	Хэрэгжих хугацаа
Богдхан төмөр замын төсөл (135.8км) (Улаанбаатар хотын урд хэсгээр явах, тээвэр логистикийн зориулалттай)	Монгол Улсын Засгийн Газар	2024 онд дуусгахаар төлөвлөж байна.
Монгол улсын баруун хязгаарт, хойд урд хилийг холбосон 1270 км урттай төмөр замын ТЭЗҮ-ыг боловсруулсан хийсэн (Бүгд Найрамдах Тува улсын нүүрс олборлолттой холбоотой)	Монгол Улсын Засгийн Газар	2024 онд дуусгахаар төлөвлөж байна.
Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 416.1 км төмөр зам барих төсөл (Өмнөговь аймаг дах Тавантолгойн нүүрсний орд газартай холбоотой)	Монгол Улсын Засгийн Газар	2021 онд дууссан.
Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн 258.4км төмөр зам барих төсөл (Өмнөговь аймаг дах Тавантолгойн нүүрсний орд газартай холбоотой)	Монгол Улсын Засгийн Газар	2022 онд дуусгахаар төлөвлөж байна.
Монгол улсын зүүн бүсэд, Дорноговь аймгийн Сайншанд-Баруун Урт, Баруун Урт-Хөөт-Чойбалсан, Хөөт-Бичигт чиглэлийн нийт 846км төмөр зам барих төсөл	Монгол Улсын Засгийн Газар	2024 онд дуусгахаар төлөвлөж байна.

Эх сурвалж : Судалгааны баг

Төмөр замд түшиглэсэн аялал жуулчлалын тухайд, 2016 онд Орос, БНХАУ, Монгол улсын хооронд Цайны Замын Олон Улсын Холбоо байгуулагдаж, галт тэрэгний аяллын шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх талаар хамтарч ажиллахаар болсон. Энэхүү санаачилгын хүрээнд, тухайн улсын Засгийн Газраас төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагуудыг бодлогоор дэмжиж, үйл ажиллагаа явуулах бизнесийн орчныг бүрдүүлэх талаар тусгасан байна. Монгол улсын хувьд, цайны замын галт тэрэгний аяллын шугамаар 7-9 саруудад БНХАУ-аас 1 сая орчим жуулчин хүлээн авахаар төлөвлөж байгаа бөгөөд, дээрх олон улсын холбоонд элссэнээс хойш 2018 оны 7 сард анх удаа цайны замын аяллыг зохион байгуулж, үүнд 400 хүн оролцжээ.¹²

Цайны замын аялал нь олон улсын стандартыг хангасан өндөр зэрэглэлийн галт тэрэгний аяллыг хөгжүүлэх аяллын шинэ бүтээгдэхүүн бөгөөд зөвхөн аялал жуулчлалыг хөгжүүлээд зогсохгүй, аяллаар дамжуулан улс орноо сурталчлах, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулах юм. Mongolia Quest компани Орос, Хятад, Монгол, мөн БНАСАУ улсаар дамжин өнгөрөх цайны замын аяллын бүтээгдэхүүнийг боловсруулсан ба аяллын хугацаанд доорхын дагуу нийтдээ 7700 км урт замыг туулж, аялал 18-20 өдөр үргэлжилнэ.¹³

Монголын нутаг дэвсгэрт БНХАУ-тай хил залгаа Дорноговь аймгаас Говьсүмбэр чиглэлийн төмөр замаар Улаанбаатар хотод хүрээд, Улаанбаатар хотоос хойшоо ОХУ-ын Эрхүү хотыг чиглэн хөдөлнө.



Эх сурвалж : Google Map ашиглан судалгааны баг боловсруулав

¹² <https://montsame.mn/jp/read/96582> (2021.03.15 өдрийн байдлаар)

¹³ <https://www.ubn.mn/p/7187> (2021.03.15 өдрийн байдлаар)

Зураг 2-14: Цайны замын төмөр замын аяллын маршрут (жишээ)

(3) Авто зам

Монгол улсын авто замын сүлжээний нийт урт 111,900км (2019он, ҮСХ), үүнээс олон улсын болон улсын чанартай зам 14,918 км, орон нутгийн чанартай зам 96,125.3 км, тусгай зориулалтын буюу уул уурхайн зориулалттай зам 872.7 км, нийслэлийн авто зам 870 км байна. Мөн, улсын хэмжээнд нийт 9,800 км зам хатуу хучилттай байна.

Монгол улсад, ОХУ болон БНХАУ-тай хиллэх хилийн зааг дээр авто замын шалган өнгөрүүлэх олон боомт (ачааны болон зорчигч тээврийн) байдаг ба үндсэндээ жуулчид авто замаар хилээр орж ирэхдээ Оросын талаас Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сум (УБ хотоос 346 км орчим), Хятад талаас Дорноговь аймгийн Замын-Үүд сум (УБ хотоос 650км орчим) дах хилийн боомтоор нэвтэрнэ.

Монгол Улсын Засгийн газар авто замыг сайжруулахад ихээхэн анхаарал тавьсаар ирсэн бөгөөд 2020 онд Улаанбаатар хотыг 21 аймгийн төвтэй хатуу хучилттай замаар холбох бүтээн байгуулалтын ажил амжилттай дуусаж, орон нутгийн иргэдийн ахуй амьдрал, бизнесийн орчинд чухал ач нөлөө үзүүлсэн. Мөн, гадаад дотоодын аялагчдын хувьд ч ая тухтай, богино хугацаанд зорьсон газартаа хүрэх давуу талууд бий болсон бөгөөд аялал жуулчлалын хөгжилд ч өндөр хувь нэмэр оруулсан. Ялангуяа, сүүлийн жилүүдэд дотоодын аялал жуулчлал эрчимтэй хөгжсөн гол хүчин зүйл нь авто замын нөхцөл байдал сайжирсантай холбоотой. Улаанбаатар хотоос энэ удаагийн судалгааны маршрут болох Өмнөговь аймгийн Даланзадгад, Дорноговь аймгийн Сайншанд, Өвөрхангай аймгийн Хархорин, Төв аймгийн Зуунмод, Тэрэлж байгалийн цогцолборт газар хүртэлх замууд бүгд хатуу хучилттай болно.

Гэвч, аймгийн төв хүрэх гол замуудын нөхцөл байдал сайжирч байгаа ч төв замаас салж аялал жуулчлалын газруудад хүрэх зам хатуу хучилтгүй учир, жуулчид зорьсон газраа хүртлээ урт удаан зам туулж, энэ нь биед нэлээд ачаалалтай байхаас гадна, өвөл зуны улиралд бороо цаснаар машин шавар шалбааг, цасан хунгарт сууж, гацах зэрэг хүндрэл үүсдэг. Өвөл цагт зам мөстөж халтиргаа үүссэнээр замд илүү урт хугацаа зарцуулдаг, тэсгим хүйтэнд машин эвдрэх зэрэг аюулгүй байдлын хувьд эрсдэл ихтэй. Түүнчлэн, орон нутгийн замын тэмдэг тэмдэглэгээ хангалтгүй, ухаалаг утасны газрын зураг, зам байршлын аппликэйшн хөгжөөгүйгээс төөрөх аюултай, ялангуяа төв замаас гарах тохиолдолд тухайн орон нутгийн замыг мэддэг жолоочийг аялалд авч явах нь чухал юм.




Эх сурвалж : <https://mn.maps-mongolia.com/>

Зураг 2-15: Монгол улсын авто замын газрын зураг

2019 онд Улаанбаатар хот доторх хөдөлгөөнөөс бусад дотоодын зорчигч хөдөлгөөний урсгалыг тээврийн хэрэгслээр нь ангилж харвал, төмөр замаар 2,834,600 хүн, авто замаар 14,717,700 хүн, харин агаарын замаар 433,400 хүн тус тус зорчиж (2019 он, ҮСХ), авто тээврийн хувьд авто машин, автобусыг хамгийн олон хүн ашиглажээ. Ялангуяа, аяллын шугамаар, Хөвсгөлөөс бусад ихэнх чиглэлд авто машин, автобусаар зорчих явдал их байна. Энэ нь орон нутгийн нислэг, галт тэрэгний чиглэл хуваарь хязгаарлагдмал, дотоод нислэгийн тасалбарын үнэ өндөр, давтамж цөөн байдгаас аялал жуулчлалын улиралд тасалбарын олдоц муу зэрэг шалтгаантай холбоотой. Мөн замын туршид байгалийн үзэсгэлэнг тольдонгоо аялах нь Монгол дах аялал жуулчлалын сэтгэл татам онцлог, давуу тал учир, иргэд машин автобусаар аялахыг илүүд үздэг нь ч нэг шалтгаан гэж хэлж болно.

Сүүлийн жилүүдэд авто замын салбарт хэрэгжүүлсэн томоохон төслүүдийн тухайд, дээр дурдсан 21 аймгийн төвийг нийслэлтэй холбосон улсын хэмжээний хатуу хучилттай зам барих ажил байсан бөгөөд, үүнээс гадна одооч гэсэн тодорхой бүс нутгуудад олон улсын болон хот хооронд, орон нутгийн авто замын сүлжээг өргөтгөх ажлууд хийгдэж байна. Мөн, Төв аймагт баригдсан Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх онгоцны буудлыг Улаанбаатар хоттой холбох 32.2 км урттай, 1 урсгал нь 3 эгнээ бүхий, 2 давхар 10 см зузаан асфальт бетон хучилттай, Монгол улсын анхны хурдны замыг Хятад Улсын хөнгөлөлттэй зээлээр барьсан байна. Уг хурдны замын тэмдэг тэмдэглэгээг байрлуулж, 2021 оны 4-р улиралд ашиглалтад оруулахаар бэлтгэл ажил хийгдэж байна.



Эх сурвалж : БОАЖЯ-ны тайлан мэдээнд (2021.2.25 байдлаар) үндэслэн судалгааны баг боловсруулав.

Зураг 2-16: Монгол улсын авто замыг хөгжүүлэх төлөвлөгөө

(4) Нийтийн бие засах газар

Засгийн газраас жуулчдын урсгал ихтэй байгалийн үзэсгэлэнт газрууд, түүх соёлын өвийн ойр орчимд нийтийн бие засах газар барих төслийг 2016 оноос хэрэгжүүлж эхэлсэн. 2019 онд Хөвсгөл нуур, Увс нуур, Элсэн тасархай, Орхоны хөндий, Тэрэлж байгалийн цогцолборт газар, Богд уул зэрэг газруудад нийтийн бие засах газрыг байгуулсан. Мөн, Хяргас нуур, Өгий нуур, Хар ус нуур, Буйр нуур зэрэг 13 газарт машины зогсоол, бие засах газар бүхий аяллын отог байгуулсан. 2020-2024 онд улсын төсөв болон бусад санхүүгийн эх үүсвэрээр уг төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна.

(5) Орон нутгийн зам дагуух үйлчилгээний цогцолбор (түр амрах цэг, ариун цэврийн өрөө), отоглох цэг

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Аялал жуулчлалын гол чиглэлийн авто зам дагуу түр буудаллах цэг, үйлчилгээний цогцолбор байгуулах” зорилт тусгасан. Энэ хүрээнд БОАЖЯ, ЗТХЯ-наас жуулчид ихээр зорин очдог байгаль, түүх, соёлын өвийн ойр орчимд бие засах газар, машины зогсоол бүхий отоглох цэг, мөн аялал жуулчлалын гол чиглэлийн авто зам дагуу түр амрах цэг, үйлчилгээний цогцолбор байгуулах стандартыг батлуулж, техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, байршлын судалгааг хийж гүйцэтгэн, зарим газруудад барилгын ажлыг эхлүүлээд байна. Монгол Улсын Засгийн газраас барьж байгуулахаар төлөвлөж байгаа аяллын отог, зам дагуух үйлчилгээний цогцолбор байгуулах талаарх төлөвлөгөөг доор нэгтгэн харуулав.

Хүснэгт 2-23: Одоо баригдаж байгаа болон барихаар төлөвлөж буй зам дагуух үйлчилгээний цогцолбор, отоглох цэг

	Отоглох цэг		Үйлчилгээний цогцолбор
Агуулга	Жуулчдын урсгал ихтэй 100 газрыг сонгож отоглох цэг байгуулах (Нэгдсэн стандартын дагуу мэдээллийн самбар, тэмдэг тэмдэглэгээ байршуулж, отог бүрт саравч, майхан барих хэсэг, машины зогсоол, био бие засах газар эсвэл ариун цэврийн өрөөтэй байх)		Аялал жуулчлалын гол цэгүүд рүү зорчих авто зам дагуу А,В,С ¹⁴ ангиллын түр амрах цэг, үйлчилгээний цогцолбор (Мичи но эки) байгуулах төлөвлөгөө
Хэрэгжүүлэх хугацаа	2020-2024 он		2021-2025 он
Санхүүжилтийн эх үүсвэр	Улсын төсөв : 8 тэрбум төгрөг (80 газар)	Олон улсын төсөл зэрэг бусад санхүүгийн эх үүсвэр (20 газар)	Хувий хэвшил : 60 тэрбум төгрөг
Байршил	Аялал жуулчлалын 80 гол цэг	Аялал жуулчлалын 20 гол цэг	Аялал жуулчлалын 10 гол цэг

Эх сурвалж : БОАЖ-ын сайдын тайлан мэдээнд (2021.2.25) үндэслэн судалгааны баг боловсруулав.

Отоглох цэгийн хувьд, дээрхийн дагуу Өвөрхангай аймгийн Найман нуур, Завхан аймгийн Завхан даян хайрхан, Увс аймгийн Хяргас нуур зэрэг ялангуяа дотоодын жуулчдын урсгал ихтэй аялал жуулчлалын газруудад байгуулж эхэлж байна. Үйлчилгээний цогцолборын тухайд, БОАЖЯ, ЗТХЯ, ЖАЙКА-ийн үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төсөлтэй хамтран байршлын судалгааг хийж, эцсийн байдлаар 31 газрыг санал болгосон. Цаашид, МҮХАҮТ-ын дэмжлэгтэйгээр үйлчилгээний цогцолборуудыг хувийн хэвшлийн оролцоотойгоор барьж байгуулах, үйл ажиллагааг хариуцуулах байдлаар шийдэх төлөвлөгөөтэй байна.


2.8 Гадаадын жуулчдын чиг хандлага

(1) Гадаадын жуулчид

Монгол улсад зочилсон гадаадын иргэдийн тоо, жуулчид¹⁵-ын тооны аль аль нь 2015-2019 онуудад өсөх хандлагатай байсан боловч Ковид-19 халдварт цар тахлын нөлөөгөөр 2020 онд 2019 оны тоон үзүүлэлтийн аравны нэг болтлоо огцом буурсан байна.

¹⁴ Өдөрт зорчин өнгөрөх машины тоо 10,000-аас илүү зам дагуу А ангилал, 5,000-10,000 бол В ангилал, 5,000-аас доош бол С ангиллын үйлчилгээний цогцолбор байгуулахаар төлөвлөсөн.


¹⁵ “Жуулчин” гэдэг нь, ажлын бус зорилгоор, байнгын оршин суудаг газраасаа өөр газарт 183 хоногоос илүүгүй хугацаагаар аялж, тэндээ байхыг хэлнэ.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хорооны статистик мэдээлэлд үндэслэн судалгааны баг боловсруулав

Зураг 2-17: Монголд зочилсон гадаадын иргэдийн тоо болон түүний доторх жуулчдын тооны өөрчлөлт

Монгол улсын үндэсний статистикийн хорооны мэдээллээс харахад аялал жуулчлалын орлогын хэмжээ 2015-2019 онуудад тогтвортойгоор өссөн бөгөөд өсөлтийн хувь нь Монгол улсад ирсэн гадаадын жуулчдын тооны өсөлтийн хувийг давсан байна. Гэвч аялал жуулчлалын орлогын хэмжээний тухайд 2021 онд 2 -р сарын 25 -нд Ерөнхий сайдын санаачилгаар зохион байгуулагдсан өглөөний уулзалт дээр Монголын аялал жуулчлалын холбоо "Олон янзын тоо баримт байгаа ба одоогийн нөхцөл байдлыг зөв ойлгохын тулд тэдгээрийг цэгцлэн нэгтгэх шаардлагатай байна" гэж онцолсон байна.




Эх сурвалж: Байгаль орчин, аялал жуулчлалын яам (2011-2018), Ерөнхий сайдын өглөөний уулзалт 2021.02.25 (2019 он) -ын материалд үндэслэн судалгааны баг боловсруулав.

Зураг 2-18: Монголын аялал жуулчлалын орлогын хэмжээ

Монгол улсад зочилсон гадаадын иргэдийн тоог ирсэн зорилго тус бүрээр нь (эхний 4 зүйлээр) авч үзвэл, аялал жуулчлалын зорилгоор ирсэн гадаадын иргэдийн тоо 2015-2019 онуудад тогтмол өссөн байна. 2016 онд Аялал жуулчлалын зорилгоор ирсэн иргэдийн тоо хувийн зорилгоор ирсэн иргэдийн тооноос давж эхний 1-т орсон ба түүнээс хойш 2019 он хүртэл аялал жуулчлалын зорилгоор ирсэн иргэдийн тооны өсөлтийн хувь хамгийн өндөр байсан байна. Эндээс Монголын

аялал жуулчлалын эрэлт хэрэгцээ ихээр нэмэгдэж байсан нь харагдаж байгаа болно. ҮСХ-ны мэдээлэлд үндэслэн 2015-2019 онд аялал жуулчлалын зорилгоор Монголд ирсэн гадаадын иргэдийн тоог бүс нутаг тус бүрээр авч үзвэл Африкийн бүс нутгийн 2018-2019 оныг эс тооцвол бүх газар нутгаас ирэгсдийн тоо тасралтгүй өссөн байна.


Мөн зөвхөн аялал жуулчлалын зорилгоор бус, хувиараа албан ажлаар гэх мэт бусад зорилгоор Монголд зочилж байгаа хүмүүсийн дотроос тодорхой хэсэг нь амралтын өдрүүд болон ажлынхаа дундуур аялж жуулчлах тул, Монголын хилээр орж ирж байгаа нийт гадаадын иргэдийн тооны өсөлт нь аялал жуулчлалын салбарт түлхэц болох юм.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хорооны статистик мэдээлэлд үндэслэн судалгааны баг боловсруулав. Энд үзүүлснээс бусад Монголд ирсэн зорилго: Транзит, Сургалт, Байнгын оршин суух, Бусад

Зураг 2-19: Монгол улсад зорчсон гадаадын иргэдийн тоо (хамгийн их хүн ирсэн аяллын 4 зорилго тус бүрээр)

2019 онд Монголд зочилсон гадаадын жуулчдыг улсаар нь авч үзвэл БНХАУ 30%, ОХУ 25% орчмыг эзэлж байгаа бөгөөд Монгол улстай хиллэдэг энэ 2 улсаас ирсэн иргэд нийлээд нийт дүнгийн 50-аас дээш хувийг эзэлж байна. Үүн дээр 3-т орж байгаа БНСУ-ыг нэмбэл энэ 3 улс нийлээд нийт дүнгийн 70-аас дээш хувийг эзлэх юм. Монгол улсад зочлох гадаадын жуулчид тодорхой хэдхэн улсаас ирэх байдлаар хэт төвлөрөх нь, Монголын аялал жуулчлалын салбар тухайн улсуудын эдийн засгийн нөхцөл байдлын нөлөөлөлд хэт автах эрсдэлийг нэмэгдүүлэх, мөн тухайн орны олон нийтийн амралтын үеэр хэт төвлөрч жуулчид ирэх зэрэг нөлөөтэй тул, аль болох олон орноос жуулчид ирдэг болгох шаардлагатай гэж хэлж болно. Монгол улсад хамгийн олон жуулчин ирсэн эхний 10 орны жуулчдын 2015-2019 оны тооны өсөлтийг харвал, 1-рт БНСУ (215% орчим), 2-рт ОХУ (201% орчим), 3-рт Австрали (146% орчим), 4-рт Герман (138% орчим), 5-рт Франц (132% орчим), 6-рт АНУ (131% орчим), 7-рт Япон (127% орчим), 8-рт БНХАУ (116% орчим), 9-рт Казахстан (113% орчим), 10-рт Англи (97% орчим) орсон байна. 2012-2019 онуудад эдгээр улсын байр дараалал дотроо бага зэрэг өөрчлөгдсөн хэдий ч, эхний 10 байранд дээрх улсууд өөрчлөгдөхгүй байсаар ирсэн.. Нийт ирсэн жуулчдын тоогоороо эхний 4-т БНХАУ, ОХУ, БНСУ, Япон улсууд орж байна.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хорооны статистик мэдээлэлд үндэслэн судалгааны баг боловсруулав

Зураг 2-20: 2019 онд Монголд ирсэн гадаадын жуулчдын тоо (улс тус бүрээр) болон Гадаадын жуулчдын тоонд гарсан өөрчлөлт (эхний 4 улс)

Монгол улсад зочилж буй гадаадын жуулчдын тоо нь БНСУ-ыг оролцуулаад бусад улсын гадагш чиглэсэн аяллын (outbound) зах зээлийн 1% -иас бага хувийг эзэлж байгаа ба улс орон бүрт зах зээлийг хөгжүүлэх боломж байгаа юм. БНСУ-аас Монголыг зорих жуулчдын тоо хурдацтай өсөж байгаа ба БНСУ-ын гадагш чиглэсэн аяллын зах зээл угаасаа өсөлттэй байгаа юм. Монголыг зорих жуулчдын тоо нь гадагш чиглэсэн аяллын зах зээлийн өсөлтөөсөө илүүгээр нэмэгдэж байгаа орон бол ОХУ юм. Мөн нэг хүн тутмын аяллын хэрэглээний хэмжээ хамгийн өндөр байгаа нь Австрали улс байна. Япон улс нь БНХАУ, ОХУ, БНСУ-ыг бодвол Монголд очиж байгаа жуулчдын тоогоороо цөөхөн бөгөөд угаасаа гадагш чиглэсэн аяллын зах зээл нь бусад орнуудтай харьцуулахад бага, өсөлтийн хувь ч тийм өндөр биш байдаг. Гэхдээ, Монголыг зорих жуулчны тоо нь гадагш чиглэсэн аяллын зах зээлийнх нь 0.11 хувийг эзэлж байгаа юм. Энэ нь БНХАУ -тай ижил хэмжээтэй ба Монголтой илүү ойрхон байдаг ОХУ, БНСУ-ын дараа орж байгаа юм.


Хүснэгт 2-24: Бусад орнуудын гадагш чиглэсэн аялал (outbound) болон Монгол улсад зочилсон гадаадын жуулчдын талаарх мэдээлэл

Улсын нэр	2018 он Гадагш чиглэсэн аялагчдын тоонд Монголд зочилсон жуулчдын эзлэх хувь	Гадагш чиглэсэн аялал (outbound)			Монголд зочилсон гадаадын жуулчид	
		2018 он хүний тоо (сая)	2015-2018 он өсөлтийн хувь	Нэг удаагийн аялалд гарах зардал (ам.доллар)	2018 он хүний тоо	2015-2018 он өсөлтийн хувь
БНХАУ	0.11%	149.7	128%	1,850	163,979	113%
ОХУ	0.31%	42.0	122%	820	129,095	183%
БНСУ	0.29%	28.7	149%	1,223	84,184	178%
Япон	0.11%	19.0	117%	1,070	20,990	109%
АНУ	0.02%	92.6	125%	1,360	17,838	124%
Герман	0.01%	108.5	130%	880	10,819	120%
Франц	0.03%	30.5	115%	1,600	9,773	122%
Австрали	0.07%	11.4	116%	3,240	7,495	156%

Эх сурвалж: Гадагш чиглэсэн аялал (outbound)-ын мэдээллийг UNWTO “International tourist departures”, Монгол улсад зочилсон гадаадын жуулчдын талаарх мэдээллийг Үндэсний Статистикийн Хорооноос гаргасан мэдээлэлд үндэслэн судалгааны баг боловсруулав

Гадаадын жуулчдын Монголд зочлох үе нь улирлаас ихээхэн хамааралтай бөгөөд 2019 оны тухайд, 2-р улирал (4-6-р сар), 3-р улирал (7-9-р сар) -д ирсэн жуулчид нийт жуулчдын 70% -г эзэлж байхад, хүйтэн өвлийн улирал болох 1-р улирал (1-3-р сар), 4-р улиралд (10-12-р сар) -д 30 % нь иржээ. Жуулчлах зорилгоор ирсэн гадаад иргэдийн тооны өсөлт өндөр байсан 2015-2019 оны мэдээллээс харахад жуулчдын тоо ерөнхийдөө бүх улиралд нэмэгдэж ирсэн ба ялангуяа 2, 3-

р улирлын өсөлтийн хувь өндөр байна. Жуулчид 2, 3-р улирал буюу жилийн хагаст нь төвлөрч ирдэг байна.




Эх сурвалж: Үндэсний статистикийн хорооны статистик мэдээлэлд үндэслэн судалгааны баг боловсруулав

Зураг 2-21: Монгол улсад зочилсон гадаадын жуулчдын тоо (2019 оны улирал тус бүрээр), Монгол улсад зочилсон гадаадын жуулчдын тооны өөрчлөлт (улирал тус бүрээр)

Улирлын ялгааны тухай улсаар нь авч үзвэл, "амрах / аялах" зорилгоор зочлогчдын хувь өндөр, "бизнес / ажил"-ын зорилгоор зочлогчдын хувь багатай Франц, Солонгос, Германчуудын тухайд улирлаас хамаарах хувь нь өндөр байна. Эсрэгээрээ "амрах / аялах" зорилгоор зорчигсад цөөнтэй Орос, Хятадын иргэд улирлаас хамаарах хувь нь бага байна. Аялал жуулчлалын салбарыг жилийн турш тогтвортой орлоготой байлгахын тулд өвлийн хүйтэн улирал дахь жуулчдын тоог нэмэгдүүлэх нь чухал шаардлагатай хэдий ч, бизнес, албан ажил, суралцах гэх мэт аялал жуулчлалаас өөр зорилгоор хэдийнэ Монголд ирээд өвлийг өнгөрөөж байдаг гадаадын иргэдэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх нь илүү ойр, үр дүнтэй ажил болно гэж үзэж байна.

Сүүлийн жилүүдэд Монголд зочлох жуулчдын тоо нь өндөр өсөлттэй байгаа БНХАУ, ОХУ, БНСУ (Зураг 2-20) дотроос БНСУ "амрах / аялах" зорилгоор ирсэн жуулчдын эзлэх хувиараа өндөрт орж байна. 2016 онд Air Busan, 2019 онд Asiana Airlines -ийн шинэ нислэгүүд хийгдэж эхэлсэн нь жуулчдын тоо нэмэгдэхэд нөлөөлсөн гэж үзэж байна.



Эх сурвалж: Улирал тус бүрийн мэдээллийг Үндэсний Статистикийн Хорооны Мэдээлэл, улс тус бүрийн мэдээллийг Аялал жуулчлалын түүвэр судалгаа 2019¹⁶ (Монгол улсын Төв Банк, Монгол Улсын Аялал Жуулчлалын Хөгжлийн Төв) -нд үндэслэн судалгааны баг боловсруулав.

Зураг 2-22: Монгол улсад зочилсон гадаадын жуулчдын тоо (улсаар /улирлаар /зорилгоор)

¹⁶ 2019 оны 8-р сард 2 төрлийн түүвэр судалгааг хийсэн. Эхнийх нь 1,543 гадаадын жуулчид (90% нь Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудал, үлдсэн 10% жуулчид байрлаж байсан жуулчны бааз, зочид буудал) -ын дунд хийсэн судалгаа (хүчинтэй хариулт: 1436). Хоёр дахь нь 41 аялал жуулчлалын компанийн дунд хийсэн судалгаа (хүчинтэй хариулт: 34).

Аялал жуулчлалын түүвэр судалгаа-2019 он (Монголын улсын Төв банк, Монголын Аялал жуулчлалын хөгжлийн төв) (цаашид "Аялал жуулчлалын түүвэр судалгаа 2019" гэх) -с харахад жуулчдын Монгол улсад саатсан дундаж хугацаа нь 7 хүртэлх хоног 42%, 7-14 хоног 34% , 14-30 хоног 19%, 30-аас дээш хоног 5% байсан бөгөөд улс орноор ангилан үзвэл АНУ, Герман, Франц, Англи улсын жуулчид 7-оос дээш хоногийн хугацаатай аялсан байна. Энэхүү түүвэр судалгаанд жуулчдын Монголд аялсан хугацааг улс орноор ангилж гаргаагүй тул, хамгийн сүүлийнх нь 2017 онд хийгдсэн бага зэрэг хуучин ч гэсэн, холбогдох байгууллагуудын явуулсан хэд хэдэн асуулга судалгааны дүнд үндэслэн Монголд аялсан хоногийн дунжийг улс орноор ангилж тооцсон болно. БНСУ, Япон, Өмнөд Азиас ирсэн жуулчдын аялж саатах хугацаа ерөнхийдөө богинохон бөгөөд Европоос ирсэн жуулчдын аялах хугацаа ч богиносох хандлагатай байгааг харж болно.

Хүснэгт 2-25: Жуулчдын аяллын дундаж хугацааны өөрчлөлт (улсаар)

Анкет судалгааны төрөл	Судалгааг хийсэн үе	Хариулсан хүний тоо (хүн)	Улсын нэр	Аяллын дундаж хугацаа (хоног)			
				2004 Анкет	2012 Анкет	2015 Анкет	2017 Анкет
2004	2004.7.1-9.20 хүртэл 80 өдөр	3,017	АНУ, Канад	-	-	-	13
			АНУ	13.6	18.5	15.7	-
			Австрали, Шинэ Зеланд	-	-	-	11
			Австрали	15.4	17.5	15.4	-
			БНСУ	8.1	9	9	6
			БНХАУ	8.5	13.6	11	16
			Герман	18.3	18.7	16.7	12
			Англи	18.6	19.4	15	10
			ОХУ	-	-	-	11
			Франц	19	19.6	14	12
			Япон	7.1	6.4	6.9	7
			Өмнөд Ази	-	-	-	8
			Бусад Европ	16	16.9	14.5	12
			бусад	12	19.9	14	19
2012	2012.6.17-8.25 хүртэл 70 өдөр	3,542					
2015	2015.7.9-8.3 хүртэл 27 өдөр	2,041 (Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудал)					
2017	2017 оны 3-р улирал	1,350 (Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудал : 1,016 Алтанбулаг хилийн боомт : 256 Замын-Үүд хилийн боомт : 78)					

Эх сурвалж: 2004, 2012, 2015 Анкет: Улаанбаатар хотод аялсан гадаадын жуулчдын сэтгэл ханамжийн судалгаа 2015 (Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Аялал жуулчлалын тогтвортой хөгжлийн төв), 2017 Анкет: Монгол улсад зочилж буй гадаадын жуулчдын зардлын судалгаа (Монгол улсын Төв Банк)-нд үндэслэн судалгааны баг боловсруулав.

Монголын аяллын нэг онцлог бол жуулчид аяллын багцыг голчлон ашиглаж ирдэг явдал юм. "Аялал жуулчлалын түүвэр судалгаа 2019" -ны "Аяллаа өөрөө төлөвлөж зохион байгуулсан уу эсвэл аяллын тур агентаар дамжуулан зохион байгуулсан уу?" гэсэн асуултад нийт жуулчдын 60 гаруй хувь нь аяллаа тур агентаар дамжуулан зохион байгуулсан гэж хариулсан байна. Мөн аяллаа өөрөө зохион байгуулсан жуулчдын хувьд ч 53% нь Монголын тур операторт хандсан (нэг өдрийн аяллын тур гэх мэт) гэж хариулжээ. Жишээлбэл, Японд зочилж буй гадаадын жуулчдын хувьд Вьетнамаас бусад орнуудын тухайд, жуулчдынх нь 62% (ихэнх улс 80%-с дээш) нь аяллаа өөрөө зохион байгуулж ирдэг (Японд зочлох гадаадын иргэдийн хэрэглээний чиг хандлагын судалгаа 2019, Японы Аялал жуулчлалын агентлаг) гэсэн байхад Монгол улсад үүнээс эсрэгээрээ байгаа юм. Үүнд Монголын аялал жуулчлалын талаар мэдээлэл цуглуулах нь хүндрэлтэй, хувиараа аялахад бэрхшээл их гардаг, өндөр настай жуулчид их байдаг гэсэн 3 шалтгаан нөлөөлж байгаа гэж таамаглаж байна.

- Мэдээлэл цуглуулахад хүндрэл учирдаг


"Аялал жуулчлалын түүвэр судалгаа 2019"-ны "Монгол улсад ирэхээс өмнө тулгардаг бэрхшээлүүд" гэсэн асуултад жуулчдын хариулсан хариултыг илүү ноцтойгоос нь жагсааж үзүүлбэл "өөрийн орны хэл дээр мэдээлэл олддоггүй", "нислэгийн үнэ өндөр байдаг", "мэдээлэл дутмаг байдаг", "виз авахад хүндрэлтэй" гэсэн бэрхшээлүүдийг дурдсан байна. Мөн судалгааны багийн Японы аялал жуулчлалын компаниудын дунд явуулсан асуулга судалгаагаар ч мөн адил "Монголын аяллын бүтээгдэхүүн бий болгоход тулгарах бэрхшээл" гэсэн асуултад "мэдээлэл цуглуулахад бэрхшээлтэй байдаг" гэж ихэнх компани хариулсан байна. Мэдээлэл цуглуулах нь аялал жуулчлалын компаниудын хувьд ч хэцүү байхад, хувь хүн өөрөө бүх мэдээллийг цуглуулж, аяллаа зохион байгуулна гэдэг ихэд хүндрэлтэй байх нь харагдаж байгаа юм.

- Хувиараа аялахад хүндрэлтэй

Монголд аялал жуулчлалын цэгүүдэд ч англи хэл дээрх тайлбар, тэмдэглэгээ дутагдалтай байдаг бөгөөд англиар ярьж чаддаггүй ажилтнууд олон тул зочид буудал, унаа машин захиалахад хүндрэлтэй байдаг. Түүнчлэн хувиараа аялах тохиолдолд аяллын онгоц унааны зардал өндөр, дээр дурдсанчлан урьдчилан мэдээлэл цуглуулахад ч бэрхшээлтэй учраас хувиараа аялагчид хүссэнээрээ хялбархан аялж, зугаалахад бэрхшээлтэй улс юм.

- Өндөр настай жуулчид их

"Аялал жуулчлалын түүвэр судалгаа 2019" -нд хамрагдсан хүмүүсийн талаас илүү хувь нь 40-өөс дээш насны, тэр дунд 3 хүн тутмын 1 нь 55-аас дээш насны аялагчид байсан байна. Судалгааны багийн Монголын аялал жуулчлалын компаниудад хийсэн анкет судалгаа¹⁷-нд ч гэсэн "Азийн орнуудаас Монгол улсад ирж буй жуулчдын 70% нь 55-аас дээш насны хүмүүс байдаг" гэсэн хариулт байсан. Өндөр настнууд залуучуудаас илүү аялал жуулчлалын компани ашиглах нь их байдаг учир багц аяллын хэрэглээ өндөр байна гэж үзэж байна.




Эх сурвалж: "Аялал жуулчлалын түүвэр судалгаа 2019" -нд үндэслэн судалгааны баг боловсруулав

Зураг 2-23: "Аялал жуулчлалын түүвэр судалгаа 2019" -ны "Аяллаа өөрөө зохион байгуулсан уу? , аяллын тур агентаар дамжуулан зохион байгуулсан уу?" гэсэн асуултын хариулт

Монгол улсад хийсэн аяллын сэтгэл ханамжийн тухайд "Аялал жуулчлалын түүвэр судалгаа 2019" -нд аялагчдын 38% нь сэтгэл хангалуун, 56% нь дунд зэрэг болон ердийн, 5% нь сэтгэл хангалуун бус, 1% нь огт хангалтгүй гэсэн үнэлгээ өгсөн ба эндээс харахад сэтгэл ханамжийн үнэлгээ харьцангуй өндөр байна. Сэтгэл ханамжийг бууруулдаг хүчин зүйлсийн тухайд улс орон, нас, хүйсээс үл хамааран ихэнх хүмүүс бие засах газар гэж хариулжээ. Бусад хүчин зүйлсийн тухайд ч олон зүйлс дурдагдсан байгаа бөгөөд шийдвэрлэх шаардлагатай асуудал их байгаа юм. Интернет ба харилцаа холбооны тухайд, тухайн хүний аяллын зорилго, аялагч, жуулчдын онцлогоос хамаарч өөр өөрөөр үнэлсэн ба 40 -өөс доош насны аялагчид үүнд их ач холбогдол өгдөг бол юу ч үгүй онгон байгалийг илүүд үздэг баруун европын аялагчид интернет, харилцаа холбооны нөхцөл байдал тааруу байсан ч үзэсгэлэнт онгон байгалийг үзэж мэдэрсэндээ сэтгэл хангалуун байдаг байна. Хоол ундны тухайд бусад анкет судалгаануудад, шөнийн цэнгээний газар цөөн, ажиллах цаг нь богинохон, кафе болон Монгол хоолноос өөр олон орны хоолтой

¹⁷ Аялал жуулчлалын 38 компани, 10 зочид буудал, 6 бэлэг дурсгалын зүйл борлуулагч аж ахуйн нэгж эрхлэгчид хамрагдсан судалгаа

ресторан ховор байгааг онцолжээ.



Эх сурвалж: "Аялал жуулчлалын түүвэр судалгаа 2019" -нд үндэслэн судалгааны баг боловсруулав

Зураг 2-24: Монгол дахь аяллын сэтгэл ханамж, аяллын явцад хүндрэл учруулсан асуудлууд


Мөн сэтгэл ханамжид нөлөөлдөг бас нэг хүчин зүйл бол хөтөч бөгөөд сайн хөтөчтэй явсан аялагчийн сэтгэл ханамж харьцангуй өндөр байдаг гэж "Аялал жуулчлалын түүвэр судалгаа 2019"-нд дурдсан байна. Уг судалгаанд хамрагдсан жуулчдын 60 хувь нь аяллын хөтөч, тайлбарлагчтай холбоотой асуулгыг бөглөсөн бөгөөд тэдний 50 орчим хувь нь туршлага, мэдлэг, гадаад хэлний чадвар, мэргэжлийн ур чадвар зэрэг бүх үзүүлэлтээр нь сэтгэл хангалуун гэж хариулсан байна. Харин 40 орчим хувь нь дунд зэрэг, 10 орчим хувь нь сэтгэл хангалуун бус гэж хариулжээ. Судалгааны багийн Монголын аялал жуулчлалын холбоодоос авсан санал асуулгад хөтөч, жолооч, тогооч нарын талаар, мөн түүнчлэн дэлгүүр, зугаа цэнгэл, хоол хүнс, дэн буудал гэх мэт үйлчилгээтэй холбоотой гомдол их гардаг гэж хариулжээ. Гэвч судалгааны баг Японы аялал жуулчлалын компаниудын дунд явуулсан асуулга судалгааны дүнгээс харахад, хөтөч нарын ур чадварын түвшний ялгаатай байдал зэрэг зарим нэг асуудлыг дурдсаныг эс тооцвол ерөнхийдөө хөтчийн талаарх үнэлгээ сайн байсан. Нөгөөтэйгүүр аялал жуулчлалын холбоодын зүгээс "бусад орнуудтай харьцуулахад Япон хэлтэй хөтчүүдийн талаарх гомдол бага байдаг", "Япон хүмүүст хандсан ажилчдын харилцаа, хандлагад ямар нэгэн асуудал байдаггүй" гэх мэт санал ч байсан бөгөөд хойшид ямар хэлний, аль бүс нутгийн жуулчдыг хариуцсан хөтчийн (шаардагдах мэдээллийн хэмжээ өөр өөр) чанар сайн байгааг, эсвэл сайжруулах шаардлагатай байна гэдгийг судалж үзэх шаардлагатай.

"Аялал жуулчлалын түүвэр судалгаа 2019" -ны нарийвчилсан дүн шинжилгээ (Нэмэлт мэдээлэл)

Монгол улсад ирж буй гадаадын жуулчдын онцлогийг илүү нарийвчлан харахад тус болох зорилгоор нэмэлт мэдээлэл болгож, түүврийн тоо нь цөөхөн боловч "Аялал жуулчлалын түүвэр судалгаа 2019" -ны анхны өгөгдөлд үндэслэн судалгааны багийн хийсэн нарийвчилсан дүн шинжилгээний үр дүнг доор харуулж байна. Тус судалгааны анхны өгөгдлийг холбогдох байгууллагуудаас лавласан боловч эцсийн тайланд ашигласан мэдээллийг олж чадаагүй ба дахин дахин лавлаж эрж сурсны үр дүнд эцсийн тайланд ашигласантай хамгийн ойр өгөгдлийг ашигласан болно.

Монголд аялагчдын насны ангиллыг улсаар нь авч үзвэл ялангуяа АНУ, Японы тухайд өндөр настай жуулчид ихтэй, АНУ-аас ирсэн жуулчдын талаас илүү хувь нь 56-аас дээш насны хүмүүс


байна. Эдгээр хоёр улсыг эс тооцвол 24-39 насны жуулчдын тоо хамгийн олон байна.








Эх сурвалж: "Аялал жуулчлалын түүвэр судалгаа 2019" -ны анхны өгөгдөлд үндэслэн, судалгааны баг боловсруулав




Зураг 2-25: Монгол улсад зочлогчдын насны ангилал¹⁸ (улсаар)

Монголд ирэхээс өмнө мэдээлэл цуглуулахад хамгийн их хэрэг болсон мэдээллийн эх үүсвэрийн тухай улс болон насаар нь судалж үзэхэд БНСУ, Япон, АНУ, Франц улсын бүх насны ангилалын иргэд аялал жуулчлалын компаниудын мэдээллийг ашигладаг байна. Олон нийтийн сүлжээ, интернэт ашиглан мэдээлэл цуглуулдаг хувь өндөр орнуудад БНХАУ, ОХУ, АНУ, Англи зэрэг, олон тооны жуулчид ирдэг мэдээлэл ихтэй хөрш зэргэлдээ орнууд, мөн бусад хэлтэй харьцуулахад мэдээллийн хэмжээ харьцангуй ихтэй англи хэлийг эх хэлээ болгодог улс орнууд орж байна. Эдгээр 4 орны олон нийтийн сүлжээ, интернэт ашиглалт нь насны ангиллаас хамаарч эзлэх хувь өөр өөр байгаа бөгөөд бусад улсын хувьд ч гэсэн залуучууд ихэвчлэн ашигладаг гэх мэт насны бүлгээс хамаарч өөр өөр байна. Зөвхөн Япон улсын тухайд бүх насны ангилалд олон нийтийн сүлжээ, интернэт ашиглах хувь нь маш доогуур байна.



¹⁸ 24 нас нь "24 наснаас доош", "24-39 нас" -ны аль алинд нь хамаарах боловч судалгаанд ашиглагдсан асуулгын хуудсан дахь сонголтууд "24 наснаас доош", "24-39" гэсэн сонголттой байсан тул түүний дагуу орчуулсан болно.



















Эх сурвалж: "Аялал жуулчлалын түүвэр судалгаа 2019" -ны анхны өгөгдөлд үндэслэн, судалгааны баг боловсруулав

Зураг 2-26: Улс, насны бүлгээр хамгийн их хэрэг болсон мэдээллийн эх сурвалж (хариулт давхардсан)¹⁹

БНСУ, Франц улсын бүх насны ангилалд, мөн Япон, АНУ, Герман улсуудын 40-өөс дээш насны иргэд аялал жуулчлалын компаниар дамжуулан аялах нь их байна. Мөн Япон, АНУ, Герман, Франц зэрэг орны аялал жуулчлалын компаниар дамжуулан аяллаа зохион байгуулдаг иргэдийн ихэнх нь насны ангилал нь дээшлэх тусам Монголоос өөр улсын аялал жуулчлалын компани ашигладаг бөгөөд, өөрөөр хэлбэл ихэнх нь өөрийн орны аялал жуулчлалын компанийг ашигладаг хэмээн таамаглаж болно. Зураг 2-25-д үзүүлсэнчлэн Япон, АНУ-аас Монголд аялдаг хүмүүсийн 60 гаруй хувь нь (Япон 61 %, АНУ 75 %) 40 -с дээш насны хүмүүс буюу өндөр насны хүмүүс байдаг тул, онцгойлон энэ 2 улсын аялал жуулчлалын компаниуд, түүгээр зогсохгүй бусад орны аялал жуулчлалын компаниуд Монголын аялал жуулчлалд томоохон үүрэг гүйцэтгэдэг нь харагдаж байна.

¹⁹ 24 нас нь "24 наснаас доош", "24-39 нас" -ны аль алинд нь хамаарах боловч судалгаанд ашиглагдсан асуулгын хуудсан дахь сонголтууд "24 наснаас доош", "24-39" гэсэн сонголттой байсан тул түүний дагуу орчуулсан болно.






Эх сурвалж: "Аялал жуулчлалын түүвэр судалгаа 2019" -ны анхны өгөгдөлд үндэслэн, судалгааны баг боловсруулав

Зураг 2-27: Улс / насны бүлгээр аяллаа зохион байгуулсан арга, аялал жуулчлалын компанийн байрлал (аяллаа зохион байгуулсан арга тус бүрээр)²⁰

Аялал жуулчлалын зорилгоор Монголд зорчсон иргэдийг улс, насны бүлгээр нь авч үзвэл БНСУ-ын бүх насны ангилалд жуулчдын 50-иас дээш хувь нь 7 хоног хүртэлх богино хугацаагаар аялжээ. Мөн БНСУ, Япон, Герман улсын иргэдийн тухайд, хамгийн их цаг зав боломжтой байх магадлалтай тэтгэврийн насны хүмүүсийг багтаасан 56-аас дээш насны ангилалд ч гэсэн 7 хоног хүртэлх богино хугацаагаар аялсан хүмүүсийн эзлэх хувь хамгийн өндөр байна. Дээрх 3 улсын 56-аас дээш насны хүмүүсийн аялах хугацаа нь бусад насны бүлгүүдтэй нь харьцуулахад илүү богинохон байгаа нь энэ насныхан удаан хугацаагаар аялах боломжгүй байх учир шалтгаан байна гэж үзэж байна. 56-аас дээш насныхан илүү удаан хугацаагаар аялах боломжтой насны бүлэг тул, энэ талаар нарийвчилсан судалгаа хийх нь үр дүнтэй. Харин Франц, Англи улсын бүх насны ангилал, Герман улсын 55-аас доош бүх насны ангилалд 7 хоног хүртэлх богино хугацаагаар аялах хувь бага байдаг ба ялангуяа Франц улсын иргэд насны бүлгээс үл хамааран 14 хоногоос дээш удаан хугацаагаар аялдаг хүмүүсийн эзлэх хувь өндөр байдаг байна.



Эх сурвалж: "Аялал жуулчлалын түүвэр судалгаа 2019" -ны анхны өгөгдөлд үндэслэн, судалгааны баг боловсруулав.

²⁰ 24 нас нь "24 наснаас доош", "24-39 нас"- ны аль алинд нь хамаарах боловч судалгаанд ашиглагдсан асуулгын хуудсан дахь сонголтууд "24 наснаас доош", "24-39" гэсэн сонголттой байсан тул түүний дагуу орчуулсан болно.

Зураг 2-28: Аялал жуулчлалын зорилгоор зорчигсдын Монголд саатсан хугацаа (улс, насны бүлгээр)²¹

(2) Дотоодын жуулчдын чиг хандлага

Дотоодын жуулчдын талаарх албан ёсны статистик тоо баримт Монголд хангалттай байдаггүй боловч "World Travel & Tourism Council"-аас гаргасан "Mongolia 2020 Annual Research:Key Highlits" тайланд Монгол улсын дотоодын жуулчдын аялал жуулчлалын хэрэглээний хэмжээг 31%, гадаадын жуулчдын аялал жуулчлалын хэрэглээний хэмжээг 69% хэмээн дурдсан байна.

Ковид-19 халдварт цар тахлын улмаас гадаадын жуулчид цөөрсөн тул аялал жуулчлалын компаниуд өмнө нь нэг их борлуулдаггүй байсан дотоодын аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг аялагчдад зориулж шинээр хөгжүүлж санал болгосон боловч аялал жуулчлалын компанийг ашигласан дотоодын аялагчид цөөхөн байжээ. Монголчууд аялах чиглэл, маршрутаа өөрсдөө хайж, судлах замаар аялах нь их бөгөөд 2020 оны хавар МУИС -ийн Аялал жуулчлалын факультетын профессоруудын хийсэн асуулга судалгааны "Та аялахдаа аялал жуулчлалын компани ашигладаг уу?" гэсэн асуултад 95% нь "үгүй" гэж хариулжээ. Дотоодын аялагчид ихэвчлэн машинаар аялж, хоол хүнсээ ч машиндаа ачиж авч явах нь их тул ресторан, цайны газар зэрэг үйлчилгээний байгууллагыг бараг ашигладаггүй байна. Энэ нь дотоодын аялал жуулчлалын хэрэглээний хэмжээ бага байгаагийн нэг шалтгаан гэж үзэж байна.

2.9 Аялал жуулчлалын салбар

(1) Аялал жуулчлалын компани / аяллын хөтөч

Ковид-19 халдварт цар тахал дэлхийн даяар тархахаас өмнөх үед, аялал жуулчлалын компаниуд 11,000 хүний ажлын байр бий болгосон бөгөөд 2019 онд 570 орчим аялал жуулчлалын компани аялал жуулчлалын нийт орлогын 40 орчим хувийг эзлэх 240 сая ам. долларын орлогыг оруулжээ. Гэвч ихэнх компаниуд гадаадаас жуулчид хүлээж авдаг тул 2020 онд орлого нь 98% -иар буурсан байна. 2020 онд БОАЖЯ-наас хэрэгжүүлсэн Ковид-19 халдварт цар тахлын нөлөөллийн судалгааны дүнгээс үзэхэд 85 компани дампуурч, ажилчдынх нь 49% нь ажлаасаа халагдсан байна. Аялал жуулчлалын салбарын энэхүү нөхцөл байдлыг үнэлж, ямар тусламж, дэмжлэг хэрэгтэйг тодорхойлохоор БОАЖЯ, Монголын аялал жуулчлалын холбоо хамтран судалгаа хийсэн ба компаниудаас бага хүүтэй зээлийн нөхцөлийг зөөлрүүлэх, нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх зэрэг санхүүгийн дэмжлэг хүссэн санал гарсан байна.²²

Аялал жуулчлалын компаниуд нь Ковид-19 халдварт цар тахлын нөлөөнөөс өмнө улирлын чанартай бизнес эрхэлдэг тул зээл авч үйл ажиллагаагаа явуулдаг байсан. Тэд зуны орлогынхоо ойролцоогоор 60% -ийг өвөл, намар, хавар үндсэн ажилчдынхаа ажлын байрыг хадгалах болон бусад төлөвлөсөн, төлөвлөөгүй зардалд зарцуулдаг тул үлдэх ашиг нь бага байдаг. "Аялал жуулчлалын түүвэр судалгаа 2019"-аас харахад аялал жуулчлалын компаниудын нийт ажиллагсдын ердөө 19% нь нийгмийн даатгалд хамрагдсан буюу үндсэн ажилтан, үлдсэн хэсэг нь гэрээт ажилтан байгаа болно. Судалгааны багийнхан аялал жуулчлалын холбоодын дунд явуулсан асуулга судалгаагаар²³, нийт аялал жуулчлалын компанийн 52%, жуулчны баазын 70% нь зээл авч зуны орлоготой залгадаг байна. Жил бүрийн хавар банк санхүүгийн байгууллагаас зээл авч, үйл ажиллагаагаа эрхэлсээр аялал жуулчлалын улирлын зун хүргэдэг гэжээ. Энэ тогтолцоо нь аяллын хөтчийн ажлын байрыг жилийн турш хадгалахад хүндрэл учруулдаг. Нийт хөтчийн 84% нь зуны улиралд хөтөч, орчуулагчаар ажиллаж, намар, өвлийн улиралд нь хөтөч, орчуулагчийн ажилтайгаа зэрэгцүүлэн өөр ажил хийх, хөтчийн ажил огт байхгүй тохиолдолд түр өөр ажилд орох эсвэл бүр ажилгүй байдаг байна. Хавраас аяллын захиалгууд орж эхэлдэг тул

²¹ 24 нас нь "24 наснаас доош", "24-39 нас" -ны аль алинд нь хамаарах боловч судалгаанд ашиглагдсан асуулгын хуудсан дахь сонголтууд "24 наснаас доош", "24-39" гэсэн сонголттой байсан тул түүний дагуу орчуулсан болно. 7 хоног, 14 хоногийн тухайд мөн адил. болно.

²² Ерөнхий сайдын өглөөний уулзалт (Монголын Аялал Жуулчлалын Холбоо, 2021.02.25)

²³ Монголын аялал жуулчлалын холбоо, Монголын Мэргэжлийн хөтөлгөч тайлбарлагчдын холбоо, Аялал Жуулчлалын Тогтвортой Хөгжлийн Төв, Аялал жуулчлалын боловсрол, хөгжлийн төв зэрэг газраас авсан асуулга судалгааны үр дүн

аяллын хөтчийн ажилдаа бэлтгэдэг.

"Аялал жуулчлалын түүвэр судалгаа 2019" -т улирлын шинж чанартай байдлаас гадна дараах бэрхшээлүүд аялал жуулчлалын компаниудад тулгарч байгааг онцолсон байгаа бөгөөд цаашид нэн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатай асуудалд эрх зүйн орчныг сайжруулах, аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг хөгжүүлэх гэж тодорхойлсон байна. Монгол орныг гадаад орнуудад сурталчлах тухайд, олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцох хүсэлтэй байдаг ч зардал, төсвийн хүндрэл болон оролцох эрхээ олж авах боломж хомс байдлаас шалтгаалан үзэсгэлэнд оролцох нь хязгаарлагддаг хэмээн дурджээ. Монголын аялал жуулчлалын талаарх мэдээлэл дутмаг байдаг тухайд "2.8 Гадаадын жуулчдын чиг хандлага"-д ч тодорхой дурдсанчлан жуулчид, Японы аялал жуулчлалын компанийн аль аль нь энэ талаар бас онцлон тэмдэглэж байгаа болно. Судалгааны багийн Японы аялал жуулчлалын компаниудын дунд явуулсан асуулга судалгаагаар ч "Монголын аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг борлуулахад тулгарч буй бэрхшээл" гэдэгт "сонирхол татахуйц сурталчилгааны контент (фото зураг, видео) хомс байдаг", "(бусад улс орнуудтай харьцуулахад) аялал жуулчлалын компанийн зүгээс жуулчдад танилцуулах мэдээлэл дутмаг" гэж онцолсон байгаа бөгөөд "Монгол улсын төр, Засгийн газраас хэрэгжүүлэхийг хүсэж буй арга хэмжээ" -ийн тухайд "аялал жуулчлалын компаниудыг урих", "хамгийн сүүлийн үеийн мэдээ, мэдээллээр (аялал жуулчлалын газруудын тухай тодорхой мэдээлэл, аяллын зайг багтаасан аялал жуулчлалын ерөнхий мэдээлэл) хангах" гэсэн санал хүсэлт олон байв. Монгол улсын аялал жуулчлалын компаниуд нь жижиг дунд аж ахуй нэгжүүд голдуу байдаг. Тиймээс зөвхөн аялал жуулчлалын компаниуд бусад улс орнуудтай өрсөлдөнгөө Монгол улсыг гадаадын зах зээлд сурталчлах нь ихээхэн бэрхшээлтэй тул төр засаг, орон нутаг, бусад холбогдох байгууллагуудын нягт хамтын ажиллагаа, үүрэг хариуцлагын хуваарилалт шаардлагатай.

Хүснэгт 2-26: Аялал жуулчлалын компани, аялал жуулчлалын салбарт тулгарч буй асуудлууд

No	Асуудал
1	Хууль эрх зүйн орчныг сайжруулах (тэр дундаа "Аялал жуулчлалын тухай хууль"-ийг шинэчлэн найруулах)
2	Олон нийтийн англи хэлний мэдлэгийг дээшлүүлэх, мэргэжлийн ажиллах хүчин, хүний нөөцийн чадамжийг нэмэгдүүлэх
3	Монгол улсыг гадаад оронд сурталчлах
4	Олон улсын нислэгийн тоог нэмэгдүүлэх, үнийг бууруулах
5	Дэд бүтцийг сайжруулах (хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох, чанартай авто замын сүлжээг бүрдүүлэх гэх мэт)
6	Аялал жуулчлалын компаниудаас бусад аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг үйлчилгээний газруудын стандартыг сайжруулах, зэрэглэл тогтоох, хэрэгжилтийг хянах (үйлчилгээний газруудын үйлчилгээ стандартад нийцдэггүй)
7	Эвент, арга хэмжээ батлагдсан хуваарьгүй, тодорхой бус

Эх сурвалж: "Аялал жуулчлалын түүвэр судалгаа 2019" -нд үндэслэн судалгааны баг боловсруулав

(2) Байр сууц, хоол унд

Зочид буудал, жуулчны бааз зэрэг жуулчид хонож саатдаг газрууд болон зоогийн газар, рестораны цалин харьцангуй бага байдаг. Монголын аялал жуулчлалын холбооноос авсан ярилцлагад дурдсанаар үүний үндсэн шалтгаан нь аялал жуулчлалын компани, аяллын хөтчийн нэгэн адил эдгээр байгууллага ч улирлын чанартай учраас үндсэн ажилтан авах боломжгүй, ихэнх нь цагийн ажилтан байдаг. Түүнчлэн хүнсний ногоо, жимс зэрэг хүнсний бүтээгдэхүүний ихэнхийг дотоодын ханган нийлүүлэлт бага тул гадаадаас импортлодог, дотоодын үйлдвэрлэл хөгжөөгүй тул зочид буудлын ор гэх мэт буудлын эд хогшил, тоног төхөөрөмжүүдийг ч импортын бүтээгдэхүүнээр хангадаг. Ер нь жуулчдад үзүүлэх үйлчилгээний эд хэрэглэгдэхүүний ойролцоогоор 70% -ийг импортын бүтээгдэхүүн эзэлж, үүндээ өндөр татвар төлдөг тул нийт зардлаас хөдөлмөрийн хөлсийг багасгах хандлагатай байдаг гэж онцолж байна. Мөн зочид буудлын салбарын тухайд зөвшөөрөл өгч, гэрчилгээ олгохдоо заавал телевиз байрлуулах, хувцасны шүүгээ том, сайн чанарын байх ёстой гэх мэтээр стандарт тогтоож, онцын шаардлагагүй эд бараа суурилуулахыг заасан байдаг нь анхны хөрөнгө оруулалтын дүнг өндөр болгож, үр ашиггүй зардал гаргаж байна.

(3) Жуулчны бааз

2019 онд нийт 450 жуулчны бааз (нийт орны тоо: 20,000 орчим) 10,350 орчим ажилтантай байсан ба 90 орчим тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн байна. Үүнээс жуулчны баазууд нутгийн малчид болон орон нутгийн аж ахуй нэгжээс хүнсний бүтээгдэхүүн худалдаж авсан мөнгөн дүн 22.5 тэрбум төгрөг байжээ. Жуулчны баазууд сүүлийн жилүүдэд олноор бий болсон бөгөөд ялангуяа Хөвсгөл, Горхи-Тэрэлжийн БЦГ, Өвөрхангай аймгийн Хархорин дахь жуулчны баазууд нь хоорондын зай барих тогтсон дүрмийг баримталдаггүй зэрэг байдал ажиглагдаж байна.²⁴

(4) Зочид буудал

2019 он хүртэл Монголд 460 зочид буудал байсан боловч зарим зочид буудал үйл ажиллагаагаа өөрчилж оффисын түрээсийн бизнес эрхлэх болсон тул зочид буудлын тоо 430 болж цөөрсөн байна. Зочид буудлуудын орлого 2020 онд их хэмжээгээр буурсан бөгөөд Ковид-19 халдварт цар тахлын халдвар хамгаалалт, эрүүл ахуйн арга хэмжээний улмаас эсрэгээр нь зардал нь ихээр нэмэгдсэн байна. Зочид буудлын салбар ч улирлын чанартай тул зуны улиралд ердийн үйл ажиллагаагаа явуулдаг боловч бусад улиралд дадлага, сургалт явуулах зэрэг өөр үйл ажиллагаа явуулах болдог байна.²⁵

Хүснэгт 2-27: Зочид буудлын салбарын үндсэн мэдээлэл

Үндсэн мэдээлэл	2019 он	2020 он (2019 онтой хийсэн харьцуулалт)
Зочид буудлын тоо	460	430 (▲30)
Ажиллагсдын тоо	37,484 хүн	16,860 хүн (▲46%)
Үйлчлүүлэгчдийн тоо	913,000 хүн	45,650 хүн (▲95%)
Орлого	297.8 тэрбум төгрөг	131.4 тэрбум төгрөг (▲ 166.4 тэрбум төгрөг)
Зардал	302.5 тэрбум төгрөг	225.4 тэрбум төгрөг (▲ 77.1 тэрбум төгрөг)
Орлого-Зардал	▲4.6 тэрбум төгрөг	▲ 94 тэрбум төгрөг (▲ нь 89.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн)

Эх сурвалж: "Ерөнхий сайдын өглөөний уулзалт (Монголын зочид буудлуудын холбоо, 2021.02.25)-нд үндэслэн судалгааны баг боловсруулав

Судалгааны багийн хийсэн судалгааны дүнгээс²⁶ харахад Монгол улсад 5 одтой 8 зочид буудал байдгаас бүгд Улаанбаатар хотод байрладаг байна. 4 одтой 23 зочид буудлаас 22 нь Улаанбаатар хотод байрладаг бөгөөд Өвөрхангай аймагт 1 нь буюу Ikh Khorum Hotel байдаг. Японы аялал жуулчлалын компаниудаас авсан асуулга судалгаанд Улаанбаатар хотоос өөр газрын зочид буудлууд тохь тух муутай байдаг тухай мөн тансаг зэрэглэлийн зочид буудал цөөхөн тухай онцолсон байгаа тул хэрэглээний хэмжээ өндөр чинээлэг хүмүүсийг орон нутагт татахын тулд зочид буудлуудыг сайжруулж шинэчлэх шаардлагатай юм.

(5) MICE²⁷

MICE зохион байгуулах боломжтой байгууламжууд бараг бүгд Улаанбаатар хотод байрладаг бөгөөд MICE -ийн жуулчид тухайн газрын ойролцоох зочид буудлуудад байрлаж, Улаанбаатар хотын ойр орчмоор голчлон аялдаг. Сүүлийн жилүүдэд зохион байгуулагдсан олон улсын хурал, зөвлөгөөний ихэнх нь Шангри-Ла зочид буудалд, жуулчид хамгийн их ирдэг зуны улиралд болсон бөгөөд Монголын зочид буудлуудын холбооноос жуулчид ихтэй зуны улиралд аль болох

²⁴ Ерөнхий сайдын өглөөний уулзалт ("Mongolia Voyage" компани, "Khuvsgul Eco Tour" компани, 2021.02.25)

²⁵ Ерөнхий сайдын өглөөний уулзалт (Монголын Зочид Буудлуудын Холбоо, 2021.02.25)

²⁶ Монголын Зочид Буудлуудын Холбооны веб сайт, зочид буудлуудын веб сайт, Фэйсбүүк хуудас, утсаар авсан ярилцлага гэх мэт мэдээллийг нэгтгэсэн дүн. 2021 оны 2 -р сарын 22 -ны байдлаар.

²⁷ Meeting, Incentive Travel, Convention, Exhibition/Event товчилсон үг. Олон улсын хэмжээний хурал, аялал, үзэсгэлэн, эвент, арга хэмжээ

MICE зохион байгуулахгүй байх талаар Засгийн газарт хүсэлт тавьсан байна.²⁸

iHOTEL зочид буудлын MICE хариуцсан ажилтны хэлж буйгаар Монгол улс MICE зохион байгуулах газарт сонгогддог шалтгаан нь, олон улсын хурал зөвлөгөөн зохион байгуулах газрын хувьд Монгол улс нь шинэ, ховор газар болдог мөн нисэх онгоцны буудлаас MICE болох Улаанбаатар хотын төв хүртэл ойрхон байдаг тул хурал зөвлөгөө зэрэг арга хэмжээ дууссаны дараа богино хугацаанд тал нутаг, байгалийн үзэсгэлэнт газруудаар аялах боломжтой зэрэг байна.

Хүснэгт 2-28: Сүүлийн жилүүдэд зохион байгуулагдсан Олон улсын хурал, зөвлөгөөн болон MICE зохион байгуулагддаг гол байгууламжуудын жагсаалт

Сүүлийн жилүүдэд зохион байгуулагдсан Олон улсын хурал, зөвлөгөөний жагсаалт			MICE зохион байгуулагддаг гол байгууламжуудын жагсаалт		
Олон улсын хурал, зөвлөгөөний нэр	Оролцсон хүний тоо	Зохион байгуулагдсан газар	№	MICE зохион байгуулагдсан газрын нэр	Танхимын багтаамж (хүн)
ABU Ази, Номхон далайн бүсийн орнуудын роботын тэмцээн (2019/8/23-27)	300	• Buyan-Ukhaa Sport Complex	1	Buyant-Ukhaa Sport Complex	5045
Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олонд түшиглэн хөгжүүлэх Ази, Номхон далайн бүсийн IV конгресс 2019 (2019/7/2-3)	600+	• SHANGRI-LA HOTEL Ulaanbaatar	2	SHANGRI-LA HOTEL Ulaanbaatar	1200
Дэлхийн бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн чуулга уулзалт 2018 (2018/9/6-8)	300	• The Corporate Hotel and Convention Center	3	Crocus Event Center	1200
Гамшгийн эрсдэлийг бууруулах Азийн сайд нарын бага хурал (2018/7/3-6)	3,000	• SHANGRI-LA HOTEL Ulaanbaatar	4	Misheel EXPO	800
JCI байгууллагын Ази, номхон далайн бүсийн чуулга уулзалт (2017/6/8-11)	3,620	• SHANGRI-LA HOTEL Ulaanbaatar	5	Chinggis Khaan Hotel	2022.6 сард 3дахин их багтаамжтай бно
Ази-Европын Дээд түвшний 11 дүгээр уулзалт (2016/7/15-16)	4,218 (+Хэвлэл мэдээллийн 619 ажилтан)	• SHANGRI-LA HOTEL Ulaanbaatar • Ulaanbaatar Hotel • The Blue Sky Hotel and Tower • Best Western Premier Tuushin Hotel • The Corporate Hotel and Convention Center • Buyan-Ukhaa Sport Complex	6	Grand Hill Hotel	600
			7	Dariganga Hotel	550
			8	Best Western Premier Tuushin Hotel	500
			9	Bavangol Hotel	450
			10	Holiday Inn Ulaanbaatar Hotel	350
			11	White Rock Center	300
			12	Ulaanbaatar Hotel	300
			13	The Blue Sky Hotel and Tower	250
			14	Novotel Ulaanbaatar Hotel	250
			15	Kempinski Hotel Khan Palace	240
			16	Tereji hotel	150
			17	The Corporate Hotel and Convention Center	Мэдээлэлгүй

Сүхбаатар аймгийн Дарьганга зочид буудлаас бусад нь бүгд Улаанбаатарт байрладаг.

Эх сурвалж: Олон улсын зочид буудлын хүний нөөцийг хөгжүүлэх холбоо болон судалгааны баг хамтран боловсруулав

Хүснэгт 2-29: MICE жуулчдын зочилдог аялал жуулчлалын гол газрууд

²⁸ Ерөнхий сайдын өглөөний уулзалт (2021.02.25)

No	Аялал жуулчлалын гол газрууд	Байршил	Нийслэл хүртэлх зай
1	Гандантэгчинлэн Хийд	Улаанбаатар хот	Хот дотор
2	Зайсан Толгой	Улаанбаатар хот	Хот дотор
3	Чингис хааны талбай, Засгийн Газрын ордон	Улаанбаатар хот	Хот дотор
4	Улаанбаатар төмөр замын өртөө	Улаанбаатар хот	Хот дотор
5	Горхи-Тэрэлж үндэсний цэцэрлэгт хүрээлэн (Мэлхий хад гэх мэт)	Улаанбаатар хот, Налайх дүүрэг	65 км
6	Арьяабалын хийд	Улаанбаатар хот, Налайх дүүрэг	65 км
7	Цонжин болдог Чингис хааны хөшөөт цогцолбор	Төв аймгийн Эрдэнэ сум	52 км
8	13-р зууны тосгон	Төв аймгийн Эрдэнэ сум	96 км
9	Хустайн байгалийн цогцолборт газар	Төв аймгийн Алтанбулаг сум	80 км
10	Эвент зохион байгуулагчдаас зохион явуулдаг Баяр наадам	Улаанбаатар хотын ойролцоох тал нутагт ихэвчлэн зохион байгуулдаг	

Эх сурвалж: Conscierge Service Mongolia ХХК-н захиалга хариуцсан ажилтнаас авсан мэдээлэлд үндэслэн Олон улсын зочид буудлын хүний нөөцийг хөгжүүлэх холбоо болон судалгааны баг хамтран боловсруулав

(6) Чацаргана үйлдвэрлэл

Монголд ургадаг Чацаргана хэмээх шар жимсийг Монголд "Шар доктор" гэж нэрлэдэг бөгөөд витамин, эрдэс бодис зэрэг шим тэжээлээр баялаг юм. Сүүлийн жилүүдэд дэлхий даяараа эрүүл мэнддээ санаа тавих хандлага өндөрсөж байгаатай холбогдуулан Чацаргана нь олон улсад ч сайн танигдаж эхэлж байгаа юм. Япон, БНСУ, Тайвань руу бага хэмжээгээр экспортолж эхлээд байгаа бөгөөд Европ, АНУ-ын сонирхлыг ч ихээр татаж байгаа юм. Гэвч Монгол улсад үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь бусад орноос Монгол улсад импортолсон бүтээгдэхүүнээс илүү үнэтэй байдаг. Монголын Чацарганы холбоо нь цаашид тариаланг өргөжүүлэх, хураах ажлыг механикжуулах, нам температурт хатаах боловсруулах технологи, бүтээгдэхүүн хөгжүүлэх, хүний нөөцийг хөгжүүлэх зэрэг төрөл бүрийн сайжруулалт хийх шаардлагатай байна гэж байв. Аялал жуулчлалын салбарт бэлэг дурсгалын зүйлээс гадна зарим компаниуд тариалант, боловсруулалт зэрэг аялал жуулчлалын хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа бөгөөд БНХАУ, Тайвань, БНСУ, Японоос ирсэн жуулчид оролцдог байна.


(7) Ноос, ноолуурын үйлдвэрлэл

Ноос, ноолууран бүтээгдэхүүн нь Монголын томоохон бэлэг дурсгалын зүйлсийн нэг бөгөөд Японоос Монголд анх удаа буцалтгүй тусламжаар хэрэгжүүлсэн төсөл нь 1977 онд Говь ноолуурын үйлдвэрийг байгуулсан явдал юм. Монголын Ноос Ноолуурын холбоо нь, зарим сав баглаа боодлоос бусад үйлдвэрлэлийн бараг бүх процессыг дотооддоо хийдэг бөгөөд цаашид ноолуурын үйлдвэрлэлийн үе шатанд туршлагын хөтөлбөр хэрэгжүүлэх бодолтой байгаа хэмээж байна.

(8) Гадаадын хөрөнгө оруулалт

Монгол улсад 1990 оноос 2020 оны 3-р улирал дуустал нийт 123 орноос 28.8 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийгдээд байна. Нийт 123 орны 14,900 орчим гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж бүртгэгдсэн байдаг ба улсаар нь авч үзвэл, нийт хөрөнгө оруулалтын 26% буюу 7.5 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтыг Канад улс Монгол улсад оруулж хөрөнгө оруулалтын хэмжээгээрээ тэргүүлж байна. БНХАУ 5.5 тэрбум ам.долларын 7,536 аж ахуйн нэгж бүртгэгдсэн нь нийт гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн тоогоороо 50%-ийг эзэлж, хөрөнгө оруулалтын хэмжээгээрээ нийт хөрөнгө оруулалтын 19 % орчмыг эзэлж 2-рт жагсаж байна. 3-рт, нийт хөрөнгө оруулалтын 15% орчим буюу 4.3 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтыг Нидерланд улс оруулж, нийт хөрөнгө оруулалтын 7% орчим буюу 2.1 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтыг Люксембургээс оруулж 4-р байранд жагсаж байна. Сингапур улс нийт хөрөнгө оруулалтын 5.6% буюу 1.6 тэрбум долларын хөрөнгө оруулалтыг хийж 5-р байранд жагсжээ. Үүний дараа Хонгконг, Британийн Виржиний арлууд, Япон гэсэн дараалалтай

байгаа бөгөөд 8-р байранд эрэмбэлэгдсэн Япон улсын тухайд 1 тэрбум орчим ам.долларын хөрөнгө оруулалт оруулж, гадаадын нийт хөрөнгө оруулалтын 3.5%-ийг эзэлж байна.



Эх сурвалж: Япон дахь Монгол Улсын ЭСЯ -ны материал, Үндэсний Хөгжлийн Газраас гаргасан INVEST IN MONGOLIA 2021 оны 3 -р сарын дугаарт үндэслэн судалгааны баг боловсруулав

Хүснэгт 2-30: Гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ / улсаар/ (1990-2020 оны 3-р улирал)

Хөрөнгө оруулалтын хэмжээг салбар тус бүрээр нь авч үзвэл, геологи, уул уурхайн эрэл хайгуул, олборлолт, газрын тосны салбар нийт хөрөнгө оруулалтын 70 % буюу 20.2 тэрбум ам.доллар /460 аж ахуйн нэгж/, худалдаа, нийтийн хоолны салбар 16.8 % буюу 4.8 тэрбум ам.доллар /10,171 аж ахуйн нэгж/, банк, санхүүгийн үйл ажиллагааны салбарт 3.2 % буюу 941 сая ам. доллар /126 аж ахуйн нэгж/, инженерийн барилга байгууламж, барилгын материалын үйлдвэрлэлийн салбарт 1.3% буюу 401 сая ам.долларын/462 аж ахуйн нэгж/, тээврийн салбар 1.2% буюу 348.8 сая ам.доллар /255 аж ахуйн нэгж/, хөнгөн үйлдвэр, хөдөө аж ахуй, аялал жуулчлал гэсэн дараалалтай байгаа бөгөөд аялал жуулчлалын салбар 0.3% буюу 84 сая ам.доллар /433 аж ахуйн нэгж/ байв.

Засгийн газар гадаадын хөрөнгө оруулалтыг татах үйл ажиллагааны хүрээнд Ерөнхий сайдын 2016 оны 136 дугаар тушаалаар "Хөрөнгө оруулагчдын эрхийг хамгаалах зөвлөл" -ийг байгуулсан. Энэ нь хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, хүнд суртал, хууль бус үйл ажиллагааны талаарх гомдлыг шийдвэрлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилготой юм. Зөвлөлийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга даргалж, Ажлын албыг Үндэсний хөгжлийн газар хариуцдаг ба төрийн байгууллага, хувийн хэвшлийн 16 төлөөлөгчөөс бүрддэг. Гол үйл ажиллагаа нь дараах байдалтай байна.

- Хөрөнгө оруулагчдаас ирсэн гомдлыг цахимаар хүлээн авч, гомдлын шийдвэрлэлтийн хяналтын системийг хөгжүүлэх: Хөрөнгө оруулагч нь гаргасан гомдлын шийдвэрлэлтийн байдлыг шалгах, төрийн байгууллагууд хооронд мэдээлэл солилцох ажлыг хялбарчлах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зорилготой системийг хөгжүүлнэ.
- " Invest in Mongolia " нэг цэгийн үйлчилгээний төв: Төрийн 5 байгууллагын үйлчилгээг нэг дор нэгтгэж, гадаадын хөрөнгө оруулалттай компани байгуулах, шинэ бизнес эрхлэхтэй холбоотой янз бүрийн бичиг баримт бүрдүүлэлт, бүртгэлийн ажил зэргийг нэг дор хийхэд шаардлагатай орчныг бүрдүүлж байна.
- Хөрөнгө оруулагчдын цахим бүртгэлийн систем: Хөрөнгө оруулагчдад төрөл бүрийн гэрчилгээ олгох, нэг цэгийн үйлчилгээний төвүүдээр төрийн байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох ажлыг хялбарчлах зорилготой системийг хөгжүүлэхээр ажиллаж байна.
- Гэрчилгээ олгох: Татвар, хураамжийг тодорхойлохын тулд тодорхой хугацаанд бизнесийн тогтвортой үйл ажиллагаа явуулсан гэх мэт тодорхой шалгуур хангасан хөрөнгө

оруулагчдад гэрчилгээ олгоно.

- Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах: Засгийн газар 500 тэрбум төгрөгөөс дээш хэмжээний хөрөнгө оруулалт хийх хөрөнгө оруулагчтай түүний гаргасан хүсэлтийн дагуу үйл ажиллагаа явуулах орчныг нь тогтвортой байлгах зорилгоор хөрөнгө оруулалтын гэрээ байгуулна.

Монгол улсын 32 дахь Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Эдийн засгийг сэргээх төлөвлөгөөндөө Ерөнхий сайдын дэргэд гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих зөвлөлийг байгуулна гэдгээ олон нийтэд зарласан. Тэрээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаар ажиллаж байх хугацаандаа “Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөл”-ийн даргаар ажиллаж байв. Зөвлөлийн ажлын алба болох Үндэсний хөгжлийн газар нь Дэлхийн банк группийн Олон улсын санхүүгийн корпорацитай (IFC) хамтран “Хөрөнгө оруулагчаас гаргасан гомдлыг цахим хэлбэрээр бүртгэх, шийдвэрлэлтэд хяналт тавих систем”-ыг хөгжүүлж, 2020 оны 06 дугаар сарын 16-ны өдөр ашиглалтад оруулсан. Тус систем нь хөрөнгө оруулагчдын гомдлыг төрийн байгууллагуудын олон талын оролцоотойгоор шийдвэрлэх ба хөрөнгө оруулагчдад өөрийн гомдлын шийдвэрлэлтийн явцыг цахимаар хянах боломжийг олгосон. Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих зөвлөл байгуулагдсанаар үйл ажиллагааны цар хүрээ нь улам тэлж, тодорхойлсон салбаруудад гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, татах төлөвлөгөө гаргаж, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах талаар ерөнхий сайдад зөвлөх ба хөрөнгө оруулалтын дараах халамж, хамгаалалтад түлхүү анхаарах чиг үүрэгтэй байх төлөвтэй байна. Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ “Төр, засаг баялаг бүтээгчдийг, гадаад дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжих, аль болох түншлэх чиглэлийг барьж ажиллана. Энэ үүднээс бид бизнесийн тогтвортой орчныг бүрдүүлсэн бодлогын томоохон шинэчлэл рүү алхаж байна” гэж хэлжээ (2021 он 2 сар: Үндэсний Хөгжлийн Газраас гаргасан INVEST IN MONGOLIA).

“Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.5.3-т “Гадаадын хөрөнгө оруулагчдын эрх ашгийг тууштай хамгаалж, дэд бүтэц, уул уурхай, эрчим хүч, хүнс, хөдөө аж ахуй, аялал жуулчлал зэрэг эдийн засгийн тэргүүлэх салбар, мега төслүүдэд гадаадын хөрөнгө оруулалт татах, хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж авахад дэмжлэг үзүүлнэ” гэж тусгасан байна.²⁹

Одоогийн байдлаар хөрөнгө оруулалтын орчныг шинэчлэх зорилгоор Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.

Дээр дурдсанчлан Засгийн газрын байр суурь нь гадаадын хөрөнгө оруулалтыг татах бодлого баримталж байгаа боловч нөгөө талаас аялал жуулчлалын салбарт 2020 оны эхээр буюу Ковид-19 цар тахлын халдвар аялал жуулчлалын салбарт нөлөөлөхөөс өмнө, тухайн үед БОАЖЯ-ны Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газрын дарга асан С.Баясгалангийн ярилцлагад, жуулчны бааз, ресорт, тур операторуудын хувьд дотоодын хөрөнгө оруулалт давамгайлж байна. Улсын хэмжээнд байгаа олон улсын сүлжээ 7 зочид буудлын хувьд ч ялгаагүй. Гэхдээ аялал жуулчлалын үйл ажиллагаа тусгай зөвшөөрөл авах шаардлагагүй учраас гаднын хөрөнгө оруулалттай компаниуд ч үйл ажиллагаагаа явуулах боломжтой. Монгол улсад БНСУ-ын компаниуд Солонгос жуулчдаа, ӨМӨЗО-ы компаниуд Хятадын жуулчдыг хүлээн авснаар дотоодын компаниудын эрх ашгийг зөрчиж байна хэмээн шүүмжлэлд өртөөд байгаа бөгөөд дотоодын компаниудын эрх ашгийг хамгаалахын тулд давуу байдал үүсгэх зохицуулалт шаардлагатай гэж үзээд байгаа. Тиймээс аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэгчдийг тусгай зөвшөөрөлтэй болгох талаар Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгад тусгах санал дэвшүүлсэн байгаа тал дээр анхаарах шаардлагатай.³⁰

2.10 Аялал жуулчлалын маркетинг сурталчилгаа

(1) Байгаль орчин, аялал жуулчлалын яам

²⁹ <https://www.legalinfo.mn/annex/details/11219?lawid=15586> (2021.03.26 өдрийн байдлаар)

³⁰ <http://www.mne.mn/?p=10468> (2021.03.26 өдрийн байдлаар)

Монгол улсын үзэсгэлэнт байгаль, түүх соёл, амьдралын хэв маягийг тусгасан аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг олон улсын зах зээлд таниулан сурталчлах зорилгоор аялал жуулчлалын холбоо болон салбарын аж ахуйн нэгж байгууллагууд хамтран олон улсын үзэсгэлэнд тогтмол оролцдог. 2018 оны 9 сард Токио, 2019 оны 11 сард Осака хотод зохион байгуулагдсан “Туризм Экспо” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд тухайн үеийн Байгаль орчин аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат оролцсон.

Одоогийн байдлаар дотоодын жуулчдад зориулсан аялал жуулчлалын зорих газруудын мэдээлэл, үйлчилгээний байгууллагуудын сурталчилгаа, захиалгын цахим систем бий болгож, гар утасны аппликейшн болгон хөгжүүлээд байна. Ингэснээр жуулчид мэдээлэл авах эрэлтийг хангаж, үйлчилгээний байгууллага, үйлчлүүлэгч хооронд үүсэх сурталчилгаа, захиалгын харилцааг цахимжуулаад байна. Дутагдаж буй технологи, Япон улс хувь нэмэр оруулах боломжтой зүйлийн тухайд, өндөр мэдлэг туршлагатай зар сурталчилгаа, маркетингийн багтай хамтарч ажиллах боломжоор хангах, зар сурталчилгааны танилцуулга материал, технологи, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх зэрэг санал ирүүлэв.

Хүснэгт 2-31: БОАЖЯ-ны холбогдох байгууллагуудын веб сайт

Төрийн байгууллага	Албан ёсны веб сайт	Фэйсбүүк хуудас
БОАЖЯ	http://www.mne.mn/	https://www.facebook.com/mne.mn
БОАЖЯ-ны Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газар	-	https://www.facebook.com/TourismPolicyCoordinationDepartment
Аялал жуулчлалын хөгжлийн төв	http://mto.mn/	https://www.facebook.com/www.mto.mn

Эх сурвалж : Судалгааны баг

БОАЖЯ-ны веб сайт нь зөвхөн Монгол хэл дээр бөгөөд аялал жуулчлалын талаар ямар нэгэн мэдээлэл байхгүй байна.

(2) Үндэсний Хөгжлийн Газар

Гадаадын жуулчид, зорилтот зах зээлийн талаар судалгаа хийж, орон нутгийн засаг захиргааны байгууллага болон хувийн хэвшлийн байгууллагуудад судалгааны үр дүнгийн талаар нээлтэй танилцуулдаг. Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ) -тэй хамтран, Баянхонгор, Сэлэнгэ аймагт жуулчдад зориулсан мэдээллийн төв болон орон нутгийн онцлог брэнд бараа бүтээгдэхүүн борлуулах төвийг байгуулсан.

(3) Соёлын Яам

Маркетинг төлөвлөгөө байхгүй. Маркетинг сурталчилгаанд үйл ажиллагааны зардлын 5% тусгасан байгаа ч, өөр дэлгэрэнгүй мэдээлэл байхгүй.

(4) ГХЯ-ны Консулын хэлтэс

“Хариуцлагатай аялцаага” арга хэмжээний хүрээнд богино видео шторкийг монгол иргэдийн хамгийн их зорчдог БНСУ-ын ЭСЯ-тай хамтран хийсэн.

(5) Аялал Жуулчлалын Хөгжлийн Төв

2021 оны 7 сард нээгдсэн Олон улсын шинэ нисэх онгоцны буудалд байрлах "Жуулчны мэдээллийн төв"-д Монгол улсыг зорин ирэх аялагчдад VR төхөөрөмжөөр дамжуулан дижитал контентын үйлчилгээг санал болгохоор төлөвлөж байна. Үүний тулд, Монгол Улсын Их Сургуулийн дэргэдэх “Гарааны Дижитал Солюшн” ХХК-тай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан. Тус компанитай хамтран Монгол улсыг дэлхий дахинд сурталчлах зорилгоор, аялал жуулчлалын салбарын цахим шинэчлэлийг эхлүүлж, орон нутгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх цахим контентуудыг бүтээх, виртуал аялал жуулчлалыг нэвтрүүлэх, түүнд зориулсан өгөгдлийн сан, программ хангамжийг бий болгох зэрэг ажлуудыг хийхээр төлөвлөж байна.

(6) Монголын Аялал Жуулчлалын Холбоо

Гадаадын жуулчид болон зорилтот зах зээлийн талаар судалгаа явуулдаг. БОАЖЯ-тай хамтран жил бүр зохион байгуулагддаг аялал жуулчлалын олон улсын үзэсгэлэнгүүдэд (Лондонд болдог дэлхийн аялал жуулчлалын маркет “WTM”, Германы Берлинд болдог олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн “ITB”, Японы “Tourism Expo Japan”, ОХУ-ын Москвагийн олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн “МИТТ” , Олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн “ITM”, Энэтхэгийн Аутбаунд аялал жуулчлалын үзэсгэлэн “OTM”) зориулсан контент бүтээдэг. Үйл ажиллагааны зардлын 30-40% маркетинг сурталчилгаанд зарцуулдаг.

(7) Мэргэжлийн Хөтөч Тайлбарлагчдын Холбоо

Гадаадын жуулчид болон зорилтот зах зээлийн талаар судалгаа явуулдаг. Холбооны талаарх мэдээлэл сурталчилгааг байгууллагын албан ёсны веб сайт болон Фэйсбүүк хуудсаар идэвхтэй түгээдэг боловч гадаадын жуулчдад зориулсан маркетинг зар сурталчилгаа явуулдаггүй.


2.11 Аялал жуулчлалын гол нөөц баялаг

Монгол улс нь зүүн Азийн баруун хойд хэсэгт оршдог, баруун хэсгээр Монгол Алтайн нуруу, зүүн хэсгээр өргөн уудам тал газар, хойд хэсгээр Сибирийн хөвч тайгатай холбогдох ойн бүс, өмнө хэсгээр дэлхийд 4-т ордог говийн их элсэн манхан үргэлжилсэн хуурай бүс зэрэг байгалийн үзэсгэлэн цогцолсон орон бөгөөд уулархаг бүслүүрийн ургамал болон ховор ан амьтантай. Мөн, Чингис Хааны үеэс улбаатай Монголын эзэнт гүрний түүх, нүүдэлчдийн ахуй соёлтой уялдан хөгжиж буй болсон өвөрмөц, уламжлалт урлаг соёлтой, морьтон үндэстний эртний балгасын олдвор бүхий орон юм. 1923 онд говийн Баянзагаас дэлхийд анх удаа үлэг гүрвэлийн чулуужсан өндөг олдсон бөгөөд Монгол улс нь дэлхий дээр үлэг гүрвэлийн олдвор олдсон цөөн хэдэн газрын нэг юм. Нүд алдам цэлийсэн говийн элсэн манхан, одод тэнгэр зэрэг байгалийн үзэсгэлэнт өнгө төрх төдийгүй, соёл, түүх, эртний олдвор, ургамал ан амьтан зэрэг аялал жуулчлалын арвин нөөцтэй орон юм. Мөн, Монголд доорх 4 газар дэлхийн өвд бүртгэгдсэн байдаг.

Хүснэгт 2-32: Монгол улс дахь дэлхийн өвийн жагсаалт

Дэлхийн өвийн нэр	Агуулга
Увс нуурын ай сав газар	Байгалийн онгон төрх хөндөгдөөгүй үлдсэн үзэсгэлэнт газар бөгөөд Түрэг болон Скифүүд үндэстний 40,000 гаруй төрлийн археологийн дурсгалуудыг агуулдаг. 700,000 гаруй хавтгай дөрвөлжин км нутгийг хамарсан Увс нуурын ай сав газрын төв хэсэгт Увс нуур (давстай) байдаг бөгөөд ойр орчимд нь Киргиз үндэстний өлгий нутаг гэгддэг Хяргас нуур болон 4,000м өндөр сүрлэг Алтайн уулс оршино. Дэлхийн хамгийн хойд цөлийн бүс, дэлхийн хамгийн умард Тундрын бүс байршдаг. Мөн, том давсан уултай. Давстай нуураас гадна цэнгэг устай нуур ч уг ай савд байдаг учир нүүдлийн шувууд ч олноор цуглардаг.
Орхоны хөндийн соёлын дурсгалт газар	13-р зууны Монголын эзэнт гүрний залгамжлагч Өгөөдэй хаан Хархорин хотыг нийслэл болгохоор зарлиг гаргасан. Олон зууны турш Орхон мөрний хөндий нь тал нутгийн нүүдэлчдийн хүчирхэг эзэнт улсуудын төв болсоор иржээ. Үүний хамгийн эртний нотолгоо нь 8-р зууны үед тогтнож байсан Хөх Түрэгийн эзэнт гүрний Билгэ хаанд зориулсан Руни бичээс бүхий чулуун хөшөө юм. Уг хөшөөнд эртний Турк болон Хятадаар бичиг тэмдэглэгдсэн үлдсэн байдаг. Хархоринд, Монголын эзэнт гүрний сэргээн мандалтыг илэрхийлсэн яст мэлхийн дүрстэй хөшөө байдаг. 17-р зуунд баригдсан Буддын шашны Эрдэнэ Зуу хийдэд одоо ч ном хурдаг бөгөөд, дотроо бурхан тахил зэрэг үзмэр бүхий зарим сүм дуганыг шашны музей болгон ашигладаг. Хархорум музейгээр зочилж эртний балгас тууриас олдсон соёлын өвтэй танилцах боломжтой.
Монгол Алтайн нурууны хадны зургийн цогцолбор	Монгол Алтайн нуруунд орших 3 хадны зургийн цогцолбор юм. МЭӨ 11,000 оноос МЭ 9-р зуун хүртэлх 12,000 жилийн хүн төрөлхтний соёлын хөгжлийг илэрхийлсэн, үе үеийн хойд Азийн бүс нутгийн амьдралын хэв маяг, орчны байдлыг дүрсэлсэн олон хадны зураг байдаг. Монголын баруун хязгаар Баян-Өлгийн аймагт байх хадны сүг зургаас домогт гардаг арслан заан зэрэг амьтдын дүрс, ан гөрөө хийж буй байдал, зэвсэг хэрэглэл, хүмүүсийн аж амьдралын өөрчлөлтийг үзэх боломжтой.
Бурхан Халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутаг	Монгол улсын төв хэсгээс зүүн тийш сунаж тогтсон Хан Хэнтийн нуруунд орших уулын нэр. Монголын нууц товчоо зэрэг түүхийн бусад эх сурвалжид Монгол туургатны эх, түүхийн голомт нутаг хэмээн тэмдэглэгдэн үлджээ. Мөн, Чингис хааны төрсөн нутаг бөгөөд түүнийг нутаглуулсан ариун дагшин газар гэж үздэг. Уулын нэр нь бурхны уул гэсэн утгыг илэрхийлдэг. Чингис хаан Монголын эзэнт гүрнийг анхлан тунхагласан гэгддэг ба энд Монголын эзэнт гүрний бусад хаадыг нутаглуулсан гэсэн яриа ч байдаг. 1990 оны эхээр Японы Ёмиүри сонин Чингисийн онгоныг хайх судалгааны ажлыг хийсэн ч Хөх түрэгийн эзэнт гүрний үеийн хэдэн мянган археологийн олдвор илрүүлснээс хэтэрсэнгүй. Сүүлийн үед үндсэрхэг үзэл хүчтэй болж судалгааны ажил зогсонги байдалтай байна.

Эх сурвалж : ЮНЕСКО (Нэгдсэн Үндэстний Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага)-ын тайланд тулгуурлан судалгааны баг боловсруулав.



Хархорин

Эх сурвалж : Судалгааны баг



Баянзаг



Увс нуурын хотгор

Зураг 2-29: Аялал жуулчлалын газрууд

Монголын биет бус соёлын өв олноор бүртгэгдсэн байдаг. Дуу хөгжимтэй холбоотой соёлын өвийн талаар Хүснэгт 2-33-д танилцуулах ба үүнээс гадна Монголчуудын уламжлалт сууц болох гэр, үндэсний хамгийн том баяр болох наадам, карпис ундааны гарал үүслийн эхлэл болсон айраг, баруун аймгуудын нэг Баян-Өлгий аймгийн Казак үндэстний бүргэдийн ан, 13-р зуунд зохиогдсон үндэсний уйгаржин бичиг зэрэг олон төрлийн биет бус соёлын өв Монголд байдаг.

Хүснэгт 2-33: Монголын зарим биет бус соёлын өвийн танилцуулга

Соёлын өвийн нэр	Агуулга
Морин хуур	2 чавхдастай Монголыг төлөөлөх хөгжмийн зэмсэг. Хөгжмийн толгой хэсэгт морин толгойн сийлбэр байх тул, Японд Хятадтай адилхан “Морин толгойт ятга” гэсэн утгатай ханз үсгээр нэрлэдэг. Мөн, Японд Сүхийн цагаан морь домогт гарч ирдэг хөгжмийн зэмсэг гэдгээрээ алдартай. Дэлхийд цорын ганц Морин хуурын чуулгын тоглолт болон дэлхийн үндэсний дуу хөгжмийн тэмцээнд түрүүлсэн “Домог” хамтлагийн уран бүтээлчдийн тоглолтыг дэргэдээс нь үзэх боломжтой. Улаанбаатар хотод байдаг гадаад хүмүүст зориулсан үндэсний дуу бүжгийн Түмэн эх чуулгын тоглолтыг хүссэн үедээ очиж үзэж болно. Мөн, тус чуулганы уран бүтээлчдийг ганцаарчлан урьж тоглуулах ч боломжтой.
Хөөмий	Монголын уламжлалт дуу хоолойгоороо хөгжимдөх арга бөгөөд дээд доод 2 өнгө аялгууг нэгэн зэрэг гаргадгаараа онцлог юм. Монголын ардын уламжлалт дуу төдийгүй, заримдаа Япон дууг (акатонбо, фүрүсато г.м) ч хөөмийлж сонирхуулдаг.
Уртын дуу	Уртын дуу нь Монголын уламжлалт ардын урлагийн нэг юм. Мөн богино хэмжээний аялгуутай ардын богино дуу ч гэж бас байдаг.

Эх сурвалж : Судалгааны баг

2.11.1 Уламжлалт соёл урлаг, гар урлал, идээ ундаа

(1) Монгол гэр

Үржил шимт өвс даган малтайгаа нүүдэллэн амьдардаг малчид монгол хэлээр гэр хэмээх зөөвөрлөх боломжтой сууцанд амьдардаг. Нүүхдээ гэрээ буулган, зөөж тээвэрлэхэд дөхөм байдлаар хэдэн хэсэг болгон хураана. Шалнаас бусад хэсгийн жин нийтдээ 250-300 кг хүнд бөгөөд үхэр эсвэл тэмээгээр ачлага хийдэг. Харин, сүүлийн үед ачааны тэрэг их ашигладаг болсон байна. Гэрийг 2-3 хүн, 1.5-2 цагийн хугацаанд барьж бэлэн болгоно. 2 баганыг тоонотой холбож, тооныг тойруулан унь гэж нэрлэгдэх саваа модыг хананд холбож бэхлэн, гаднаас нь эсгий бүрээсээр бүтээнэ. Гэрийн голд зуух байрлуулж, хаалгаар ороод баруун талд гал тогооны хэсэг, эгц дээр хойморт гэрийн эзэн суух бөгөөд бусад эрэгтэй хүн гэрийн зүүн талд, эмэгтэй хүн баруун талд суудаг заншилтай.



Эх сурвалж : Судалгааны баг

Зураг 2-30: Монгол гэрийн дүр зураг

(2) Бууз

Бууз нь Монголын хамгийн түгээмэл хоолны нэг бөгөөд Хятадаас гаралтай гэж үздэг. Хятадын банштай төстэй боловч илүү том, амт нь өөр, Монголын уламжлалт хоол болон хөгжжээ. Гурил зуурч, дугуй хэлбэрт оруулж элдээд, дотор нь гол төлөв хонины мах хийж чимхээд, жигнэж болгодог. Айл бүрийн бууз өөр амттай байдаг нь, махандаа хольсон ногоо, амтлагч хийгээд давсны хатуу сул зэрэг амталгаа өөр байдагтай холбоотой.

(3) Айраг

Айргийг Японоор банюүшү гэж нэрлэдэг. Ширэн хөхүүрт гүүний саамыг хийж олон удаа бүлж исгэнэ. Эрт дээр үеэс л нүүдэлчин Монголчууд айргийг ундандаа хэрэглэж ирсэн бөгөөд шим тэжээл ихтэй ундаа юм. Гүүний сүүний уургын агууламжийн 40% нь альбумин, глобулин зэрэг шингэц сайтай уураг байдаг бөгөөд энэ нь эхийн хөхний сүүний найрлагатай бараг дүйцдэг. Мөн, 1 л айраг хүний биед хэрэгцээтэй С аминдэмийн хоногийн хэрэгцээг хангаж чаддаг.

(4) Морин хуур

Монголд хамгийн өргөн хэрэглэгддэг хөгжмийн зэмсгийн нэг бөгөөд олон төрлийн баяр наадам, тэмдэглэлт үйл ажиллагааны үеэр морин хуурыг эгшиглүүлж, дуу бүжигтэй хослуулан хөгжимдөх тохиолдол ч бий. Өмнө нь адууны арьс, яс, сүүлний үсийг ашигладаг байсан бол одоо зөвхөн морин хуурын чавхдасыг адууны сүүлээр, хуурын их биеийг модоор буюу ихэвчлэн хус модоор хийдэг болжээ. Япончууд морин хуурын талаар, бага ангийн сурах бичигт орсон “Сүхийн цагаан морь” домгоор (ӨМӨЗО Монголын домог үлгэр) сайн мэддэг. Монгол Улсын Засгийн Газраас морин хуурын хөгжилд онцгой анхаарч ирсний нэг тод жишээ нь Үндэсний их баяр наадмын үеэр 999 морин хуурчид хөгжимдсөн явдал юм. Мөн, шилдэг морин хуурчдаас бүрдсэн “Морин хуурын чуулга”-ын уран бүтээлчид аялан тоглолт хийх зэргээр Монголын уламжлалт соёл урлагийг дэлхий дахинд түгээн дэлгэрүүлэхээр хичээн ажиллаж байна.

(5) Шагай

Амьтны шагайн ясыг ашигладаг эртний уламжлалт тоглоом наадгай бөгөөд одоо ч Монголчууд шагайгаар нааддаг хэвээрээ. Гол төлөв хонь, ямааны шагайг ашигладаг ба нийт 80 гаруй төрлийн шагайн наадгай, шагайн мэргэ бас байдаг байна.

(6) Цагаан идээ

Өнө удаан жилийн турш, Монгол малчид төрөл бүрийн өвөрмөц аргаар цагаан идээгээ боловсруулж, тараг аарц, ааруул бяслаг, айраг зэрэг сүүн бүтээгдэхүүнийг идээ ундандаа хэрэглэсээр ирсэн. Мөн айргаа нэрж архи (шимийн архи) ч гаргаж авдаг байна. Монголчууд өвлийн цагт махан хоол хүнс хэрэглэдэг учир, хаврын сүүлээр ходоодоо цэвэрлэх зорилгоор цагаан идээг бага багаар, харин зуны улиралд цагаан идээгээ түлхүү хүртдэг. Зуныг цагаан улирал гэж нэрлэн, малчид өвлийг өнтэй давахын тулд сүүгээ цагаагаа боловсруулан ааруул бяслаг зэрэг олон төрлийн цагаан идээгээ бэлтгэн боловсруулдаг байна.

(7) Монгол бөх

Бөх гэж нэрлэгдэх Монгол сумо нь Монгол болон ӨМӨЗО зэрэг Монголчуудын уламжлалт спорт бөгөөд “Эрийн 3 чадвар”-ын хамгийн чухал чадварт тооцогддог. Харин, үлдсэн 2 чадвар нь нум сум болон морин уралдаан юм.

(8) Дээл (Монголын үндэсний хувцас)

Монгол угсаатны дээл хувцас нь олон зуун жилийн түүхтэй, үндэстэн ястан бүрийн амьдралын хэв маяг, уламжлалыг шингээсэн байдаг. Эмэгтэй дээлийн хувьд хүүхдийнх болон гэрлэсэн эмэгтэйнх хоорондоо ялгаатай. Монголын уламжлалт дээл хувцас нь, малгай, мөрөвч, гутал, бусад гоёл чимэглэлээс бүрддэг байна.

2.11.2 Баяр наадам, эвент

(1) Наадам

Улсын их баяр наадам нь үндэсний тусгаар тогтнолын өдөр болох 7 сарын 11-13 өдрүүдэд зохион байгуулагддаг уламжлалт баяр юм. 7 сарын 11-нд болох нээлтийн ажиллагааг үзэхээр иргэд үндэсний хувцсаа өмсөөд цэнгэлдэх хүрээлэндээ цугларцгаадаг. Монгол бөх болон сурын

харвааны тэмцээн төв цэнгэлдэх хүрээлэнд болдог бол морины уралдаан хотоос зайдуу Хүй долоон худагт зохион байгуулагддаг. 7 сарын 13-нд Уяачдын баяр болдог. Аймаг болон сумдад ч мөн адил орон нутгийн наадам болдог. Орон нутгийн наадмаар үндэсний дуу бүжгийг сонирхох зэрэг наадмыг ойроос мэдрэх боломжтой.

Монгол бөхийн барилдаанд 512 бөх даваагаа ахиулж барилддаг дүрэмтэй. 9-ийн даваагаар түрүү магнай тодрох бөгөөд Японы сумо бөхөөс ялгаатай нь, гар газар хүрсэн тохиолдолд ялагдсанд тооцогдохгүй, харин өвдөг, мөр газар хүрсэн тохиолдолд тахимаа өгдөг. Улсын наадамд түрүүлсэн бөх нь их нэр хүндтэй бөгөөд, эхний удаагийн түрүү магнайд арслан, 2 түрүүлсэн бол аварга, 5 удаа түрүүлбэл дархан аварга цолтой болно. Аварга нь Японы сумо бөхийн ёкозуна цолтой дүйцнэ. Ёкозуна Хакухо-гийн аав Х.Мөнхбат гуай аварга цолтой бөх хүн байсан. Мөн, Ёкозуна асан Асашорүгийн ах Д.Сумъяабазар (Одоо Улаанбаатар хотын дарга) бас аварга цолтой.

Хурдан морины уралдааныг насны ангиллаар даага, шүдлэн, хязалан, соёолон, азарга, их нас гэсэн 6 төрлөөр, мөн газрын хол ойрыг морьдын насанд тохируулан уралдуулдаг бөгөөд хамгийн хол нь 25км байдаг. Харин, морьдыг 6-12 насны эрэгтэй эмэгтэй хүүхэд унаж уралддаг.

Сурын харвааг Монголоор нум сум гэж нэрлэнэ. Харвах зайны хувьд эрэгтэй 75 метр, эмэгтэй 65 метр, 17-оос доош настай бол тухайн нас хүйсээс хамаарч тогтоосон зайнаас (эрэгтэй: нас х 4м, эмэгтэй: нас х 3м) харвадаг.



Эх сурвалж : Судалгааны баг



Зураг 2-31: Улсын их наадам болон орон нутгийн наадмын хурдан морины уралдааны дүр зураг
(2) Цагаан сар

Монголд, билгийн тооллын шинэ жилийг цагаан сар хэмээн тэмдэглэдэг уламжлалтай. Цагаан сараар, эхлээд гэр бүл, хамаатан садны өндөр настнуудынхаа амар амгаланг эрэн золгож, дараа нь ажлын газар албан байгууллагын удирдах албан тушаалтан болон ойр дотны хүмүүсийнхээ гэрт зочилж, сар шинийн мэнд хүргэдэг. Цагаан сар нь Монголчуудын хувьд бусдыг хүндэлж хайрлах, талархсан сэтгэлээ илэрхийлэх хамгийн чухал баяр юм. Хүүхэд хөгшчүүдэд мөнгө өгч гарыг нь цайлгадаг. Идээ ундааны хувьд ч сүү цагаан идээгээр ширээгээ засдаг. Энэ баяраар өрх айл бүр зочид гийчдээ угтан авахад бэлтгэж, олон мянган ширхэг бууз хийн, гадаах тагтан дээрээ өрж, байгалийн аргаар хөлдөөдөг. Нүүдэлчдийн уламжлалт соёл заншлыг ойлгож мэдрэхийг хүсвэл цагаан сарын баярыг заавал үзэхийг санал болгож байна.

2.11.3 Өвлийн аялал жуулчлалын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлууд

Дээр дурдсанчлан, Монгол улс аялал жуулчлалын арвин их нөөцтэй ч зөвхөн цаг агаарын хувьд хамгийн таатай зуны улиралд л жуулчдын урсгал төвлөрч байгаа учир, аялал жуулчлалын улирлаа уртасгах, ялангуяа хагас жил орчим үргэлжлэх өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх нь томоохон асуудал болоод байна. Өнөөдрийг хүртэл тодорхой хэмжээнд өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэхээр хичээж байгаа ч тэмээний баяр, мөсний баяраас гадна, тухайн аймгийн бусдаас ялгарах онцлог шинжийг аяллын бүтээгдэхүүндээ шингээж хөгжүүлэх шаардлагатай байна. Аймаг бүр аяллын нөөц баялгаа хэрхэн зөв, оновчтой ашиглах талаар дор бүрнээ шинэ санаа оноо эрж хайсаар буй бөгөөд амжилттай хэрэгжиж буй нэг жишээ нь Өмнөговь аймагт болдог “Тэмээний баяр” юм.

Хүснэгт 2-34: Аймаг орон нутгийн өвлийн баяр, арга хэмжээ

Аймгийн нэр	Арга хэмжээний нэр
Дорноговь аймаг	2012, 2013 он, “Тэмээний баяр”, Тэмээн полоны улсын аварга шалгаруулах тэмцээн
	Буддын ноён хутагт Данзанравжаагийн мэндэлсний түүхт ойг тэмдэглэх, 1993 оноос хойш 5 жил тутамд
	Шамбалын ерөөл тавьсан тэмдэглэлт ойг тэмдэглэх, 2007 оноос хойш жил бүрийн 9 сарын 10-ны өдөр
	Авто раллигийн тэмцээн зэрэг
Өвөрхангай аймаг	Хархоринд, “Мөсний баяр”, “Мөсөн авиралтын тэмцээн”-ийг анх удаа зохион байгуулсан.
	Бат-Өлзий суманд, олон улсын стандартыг хангасан цанын бааз барих газрыг сонгосон.
Архангай аймаг	Тамирын жавар мөсны баяр (1-р сарын 3 дах бямба, ням гараг) Өгий нуурын загасчлал (3-р сарын 3 дах бямба, ням гараг), “Өгий кап” загасчлалын спортын улсын тэмцээн
Өмнөговь аймаг	“Тэмээний баяр” (11 сарын эхээр сум тойрон хэрэгжиж, 3 сарын эхээр Булган суманд хаалтын арга хэмжээ - тэмээний баярыг тэмдэглэдэг.) (Дэлгэрэнгүйг аялал жуулчлалын нөөц хэсгээс үзнэ үү.)
	Цас мөсний баяр (Ёлын ам)
	Треккинг аялал
	Чоно агнах аялал (1 сарын 1-ний өдөр)
	Цагаан сар
	Өвлийн байгаль, ирвэсийн зураг авах аялал

Эх сурвалж : Судалгааны баг

Монголын үндэсний сайтын хөгжлийн нэгдсэн холбооны зүгээс 2021 оны 3 сард, аялал жуулчлалын салбарын аж ахуйн нэгж байгууллагын төлөөлөл, төрийн албан хаагч, нийслэлийн ИТХ-ын төлөөлөгч зэрэг 21 хүнээс өвлийн аялал жуулчлалын талаарх санал сэтгэгдлийг нь асууж тодруулан, эмхтгэн гаргасан байна. Зарим хүмүүс Монголын аялал жуулчлалын талаар зөвхөн ерөнхий хариулт өгсөн тул судалгааны багын зүгээс өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, хэрэгжүүлбэл зохистой арга хэмжээний талаар асуусан асуултын хариултыг зөвхөн доорх хүснэгтэд нэгтгэн харуулав. Энэхүү төслийн санаачлагч нь М.Дархижав, редактор Ч.Буянбадрах, хэвлэлийн эх бэлтгэлийг О. Ууганбаатар нар хийж гүйцэтгэжээ.

Хариулт дотроос санал болгосон зарим арга хэмжээ, жишээ нь мөсний баяр, мөсөн авиралтыг Архангай аймагт, нохой чарганы аяллыг Төв аймгийн Тэрэлжид, тэмээний баярыг Өмнөговь аймагт хэдийнээ хэрэгжүүлж эхлээд байна. Мөн, хариултад дурдагдсан ихэнх арга хэмжээ, эвентүүд нь бусад улс оронд зохион байгуулагддаг ба Монголын онцлогийг тусгасан, өөрөөр хэлбэл зөвхөн Монголд л үзэж харж, мэдэрч болох онцгой санал санаачилга ховор байна. Гэвч, бага зэрэг онцлог шинж чанар, хүний сэтгэлийг татах үнэ цэнийг нэмж шингээж өгснөөр өвлийн аялал жуулчлалын нөөц бололцоог хөгжүүлэх боломжтой саналууд ч тусгагдсан байна. Улмаар, эхлээд дотоодын жуулчдад зориулсан өвлийн аяллын бүтээгдэхүүнийг хөгжүүлж нутагшуулаад, дараа нь түүнийгээ гадаад хүмүүст сурталчлах нь зүйтэй тухай, өвлийн МICE арга хэмжээг нэмэгдүүлэх зэрэг аялал жуулчлалын хөгжлийн үндсэн зарчимд тулгуурласан санал санаачилга болон мөсний шагай харваа, өвлийн улирлын гадаад оюутан солилцоо зэрэг өвөрмөц саналууд ч тусгагдсан байна. Нэгтгэн дүгнэхэд, эдгээр нь Монголын нөхцөлд өвлийн улирлыг аялал жуулчлалын нөөц болгон ашиглаж, хөгжүүлэх нь хэр зэрэг бэрхшээлтэйг илтгэн харуулж буй хэрэг юм. Зөвхөн Монголд л мэдэрч, үзэж харж болох аяллын бүтээгдэхүүнийг бий болгох, сурталчлан таниулах нь өөрөө асуудал болоод бөгөөд, ирүүлсэн хариултад дурдсанчлан, эхлээд Монголчуудад зориулсан бүтээгдэхүүн бий болгох нь чухал гэж үзэж байна. Мөн, Канад, хойд Европ зэрэг хүйтэн цаг агаартай улс орнууд өвлийн аялал жуулчлалын хөтөлбөрөө хэрхэн яаж боловсруулдаг талаар мэргэжлийн түвшинд судалгаа хийх, өвлийн аялал жуулчлалаар тэргүүлдэг улс гүрнүүдийн туршлагаас суралцах нь Монголд өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд томоохон түлхэц болно гэж бодож байна.

Хүснэгт 2-35: Өвлийн аялал жуулчлалын талаар салбарын холбогдох хүмүүсийн санал

No.	Нэр, албан тушаал	Өвлийн аялал жуулчлалын талаарх санал
1	Сүхээ Алдархишиг Монголиа Эспедишнс энд Турс ХХК-ийн захирал	<ol style="list-style-type: none"> 1. Мөсний баяр 2. Мөсөн авиралт (Спорт) 3. Гол дагуу алхах, гүйх, тэшүүр, дугуйн аялал 4. Бүх төрлийн өвлийн спортын тэмцээн зохиох 5. Цана, өвлийн саун үйлчилгээ
2	Чойбалсан Буянбадрах Монголиан Гайд Турс ХХК-ийн захирал	<ol style="list-style-type: none"> 1. Цас, мөсний баяр 2. Адууны баяр 3. Тэмээний баяр 4. Монголын өвлийн өнгө төрх, нүүдэлчин амьдралын хэв маяг, цагаан сар, халуун рашаан зэрэг Монголын уламжлалт ёс заншлыг тусгасан сэдэвчилсэн аяллын хөтөлбөр 5. Гол дагуу нохой чарга, дугуйгаар явах, загасчлах
3	Пүрэвсүрэн Наранбаяр Нийслэлийн ИТХ-ийн төлөөлөгч	<ol style="list-style-type: none"> 1. Нүүдэлчдийн өвлийн баяр (Тэмээ, бүргэд, мөсний баяр) 2. Төрийн бодлого боловсруулах, хүний нөөцийг хөгжүүлэх 3. Тогтмол үнэтэй чартер нислэг, зочид буудал, такси үйлчилгээг нэвтрүүлэх 4. Уриа нэвтрүүлэх 5. Олон улсын хурал цуглаан, арга хэмжээ зохион байгуулах 6. Өвлийн улирлын оюутан солилцоо 7. Монгол дуурь, балет үзэх аялал 8. Дотоодын оюутан сурагчдын өвлийн улирлын аяллын хөтөлбөрийг хөгжүүлэх 9. Олон улсын зах зээлд зар сурталчилгаа явуулах 10. Олон улсын стандартыг нэвтрүүлэх
4	Дашдооров Гэрэлтөв Монголиан күүст ХХК- ийн гүйцэтгэх захирал	<ol style="list-style-type: none"> 1. Мөсөн авиралт (Спорт) 2. Тэмээний баяр, Бүргэдийн баяр, Мөсний баяр 3. Малчдын амьдралтай танилцах 4. Цана зэрэг өвлийн спорт 5. УБ хотод суурилсан гоо сайхан, танин мэдэхүйн аялал 6. Кино зураг авалт, нүүдэлчдийн соёл уламжлалтай танилцах аялал 7. Бүх төрлийн өвлийн эвент
5	Отгонбаатар Тулга Номадик Трейлс ХХК- ийн захирал	<ol style="list-style-type: none"> 1. Мөс, тэмээ, бүргэдийн баяр 2. Мөсөн авиралт, адууын баяр 3. Нүүдэлчдийн ахуй амьдрал (сарлаг, цаа буга, бүргэд, 5 хошуу мал) 4. Өвлийн байгалийн үзэсгэлэнт газраар аялах 5. Баримтат кино зураг авалт, төрөл бүрийн видео бичлэг 6. Шинжлэх ухааны аялал 7. Өвлийн улирлын оюутан солилцоо 8. Нохой чарга, цасны мотоцикл, чарга, сноуборд, цана 9. Хаданд авирах 10. Өвлийн амьтан, шувуу ажиглах 11. Өвлийн фото зураг авах аялал 12. —40° хэмийн хүйтэнд алхах, мотоциклоор явах, чарга, тэшүүр, морин аялал, машинаар аялах 13. Онлайн, виртуал аялал
6	Аюурзана Ариунгэрэл Нийслэлийн аялал жуулчлалын газрын дарга	<ol style="list-style-type: none"> 1. Цас мөс, бүргэд, адууны баяр 2. Төрөл бүрийн өвлийн спортын тэмцээн (нум сум, тэшүүр, сноуборд, рагби, шүхрээр буух, хаданд авирах, мөсөн дээр шагай наадгай) 3. Дугуй, мотоциклоор явах, нохой чарга, өвлийн загварын шоу,

No.	Нэр, албан тушаал	Өвлийн аялал жуулчлалын талаарх санал
		<p>шувуу ажиглах, цаа буга, тэмээ, бүргэдтэй зураг авахуулах</p> <ol style="list-style-type: none"> 4. Улаанбаатарын өвлийн баяр 5. Монголын өвлийн уламжлалт ёс заншилтай холбоотой сэдэвчилсэн аялал 6. Галт тэргээр аялах, загасчлах 7. Мөсөн урлагийн тэмцээн 8. Тэмээгээр аялах
7	Мягмаржав Навчаа Цолмон Трэвел ХХК-ын захирал	<ol style="list-style-type: none"> 1. Мөс, тэмээ, бүргэдийн баяр 2. Өвлийн экстрим-спорт аялал 3. Аялал жуулчлалын цогцолбор байгууламж (дотроо усан сан, цэцэрлэгт хүрээлэн, ресторан хоолны газартай, урлаг соёлын арга хэмжээ явуулдаг г.м), цана, чарга, тэшүүр, мөсөн дээрх поло зэрэг гадаа явуулдаг спорттой хослуулах 4. Мөсөн гулсуур, дугуй, мотоцикл, морин аялал, өвлийн байгалийн үзэсгэлэнтэй танилцах аялал, фото зургийн аялал
8	Дамба Отгонбаяр Монголын аялал жуулчлалын холбооны Гүйцэтгэх захирал	<ol style="list-style-type: none"> 1. Төрөл бүрийн цанын бааз хөгжүүлэх 2. Саунтай авто машин, саунтай пургоноор аялах 3. Галт тэрэгний аяллыг цанын аялалтай хослуулах
9	Доржпалам Үүрийнтуяа Талын Үнэг ХХК-ын захирал	<ol style="list-style-type: none"> 1. Нохой чарга, цана, тэшүүр, груп алхалт, хаданд болон мөсөн авиралт зэрэг экстрим аялал 2. Бүх төрлийн арга хэмжээ зохион байгуулах (Олон улсын хурал цуглаан, шоу, сургалт эвент)
10	Баатарсүрэнгийн Барсболд Дисковер Монголиа Трэйвел ХХК-ын захирал	<ol style="list-style-type: none"> 1. Мөс, тэмээний баяр 2. Засгийн газрын тогтвортой бодлого, тууштай дэмжлэг 3. Өвлийн эвент 4. Төрөл бүрийн өвлийн спортын уралдаан тэмцээн 5. Байгууллага, аж ахуйн нэгжийн сургалт аялал (Байгаль, нүүдэлчдийн амьдралын хэв маягтай уялдуулан хөгжүүлэх) 6. Галт тэрэгний (Эвент, арга хэмжээнд оролцох) 7. Нүүдэлчдийн ахуй амьдралтай танилцах аялал 8. Органик бүтээгдэхүүний борлуулалт (Монголын мах болон сүүн бүтээгдэхүүн) 9. Өвлийн улирлын гэр бүлийн аяллыг хөгжүүлэх 10. Чөлөөт алхалт, морин аялал, нохой чарга, цана, чарга 11. Эрсдэлийн даатгал (риск менежмент төлөвлөгөө, мөнгөн хуримтлал)
11	Батбаяр Ижилмөрөн Тэнүүн тур ХХК-ийн захирал	<ol style="list-style-type: none"> 1. Мөс, бүргэд, адуу, тэмээний баяр 2. Нүүдэлчин ахуй амьдрал 3. Өвөл Якутаас эхэлдэг арга хэмжээтэй төстэй эвент 4. Урлагийн тоглолт үзэх, соёлын төв, нийтийн бие засах газар байгуулах 5. Хөвсгөл нуурын мөсөн дээрх мотоцикл аялал 6. Мөсөн замын авто уралдаан, ралли 7. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн даатгалын систем 8. —30°С хэмд ч ажрахгүй Монгол гэр, хоол хүнс, хувцас хэрэгсэл зэргийг танилцуулах төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны бодлого
12	Joel Rauzi Жоэль Раузи Винд оф Монголиа ХХК-ийн захирал	<ol style="list-style-type: none"> 1. Мэргэжлийн хөтчийн сургалт 2. Дэд бүтцийн хөгжил (зочид буудал, жуулчны бааз зэрэг) 3. Жуулчдын тоог хязгаарлахгүй байх 4. Аялал жуулчлалын яамыг чадавхижуулах

No.	Нэр, албан тушаал	Өвлийн аялал жуулчлалын талаарх санал
		<p>5. Эвент нь аялал жуулчлалыг хөгжүүлэх дагалдах бүтээгдэхүүнээс хэтрэхгүй</p> <p>6. Өвлийн аялал хэрэгжүүлдэг олон улсын жагсаалтад Монгол улсыг оруулж бүртгүүлэх</p> <p>7. Одоо байгаа аялал жуулчлалын байгууллагууд шаардлагатай үйлчилгээ үзүүлэх (Жишээ нь цэвэр ус өгөх зэрэг)</p> <p>8. Байгалийн үзэсгэлэнт, хээр тал, нүүдэлчдийн ахуй соёлтой танилцах</p> <p>9. Хөтчийн удирдах чадвар, мэдлэгийг дээшлүүлэх</p> <p>10. Өвлийн аялал жуулчлалаас илүү боловсон хүчний хөгжлийг тэргүүнд тавих шаардлагатай.</p> <p>11. Иргэдэд өвлийн аялал жуулчлал, аяллын эрсдэл, байгаль хамгаалал, цэвэрхэн соёлтой аялах, зэрлэг ан амьтдыг хамгаалах талаар мэдлэг олгох нь чухал</p> <p>12. Зочид буудал болон бусад байрлах газруудын стандартыг хангуулж, үйлчилгээг сайжруулах</p> <p>13. Өвлийн аялалд гэр бааз хамгийн тохиромжтой учир гэр баазын үйлчилгээний чанарыг сайжруулах</p> <p>14. Жолоочид жилийн турш машиндаа шаардлагатай техник үзлэгийг сайтар хийж, эрсдэлээс урьдчилан сэргийлж, бэлтгэлээ хангах</p> <p>15. Нүүдэлчдийн өвлийн ахуй амьдралтай танилцах боломжтой болохыг илүү идэвхтэй сурталчлах</p>
13	Хумбаа Түмэндэлгэр Өмнөговь аймгийн “Гайхамшигт Говь” АЖ холбооны тэргүүн	<p>1. Өвлийн аялал жуулчлалд зориулсан байгууламж</p> <p>2. Тэмээн аялал, тэмээний баяр, нохой чарга, дугуйн аялал, цас, мөсний баяр, мөсөн урлаг, морин аялал, ууланд алхах, саунтай бага оврын автобус аялал</p> <p>3. Өмнөговь аймагт Зэрлэг амьтдын хүрээлэн байгуулах (Ховордсон ан амьтад)</p> <p>4. Мэргэжлийн хөтөч тайлбарлагчийг сургах</p> <p>5. Дотоодод зохиогддог эвентүүдийг “Нүүдэлчдийн өвлийн баяр” нэгдсэн арга хэмжээний хүрээнд зохион байгуулах, төрөл, агуулга, хэрэгжүүлэх цаг хугацааг давхардуулахгүй байх.</p> <p>6. Эвент зохиогдож байгаа газар байршлыг хооронд нь ойртуулах.</p> <p>7. Орон нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлж, эвентүүдийг тууштай тогтмол зохион байгуулах</p> <p>8. Ижил төрлийн арга хэмжээг нэгтгэж, давхардуулахгүй байх</p> <p>9. ТББ болон хувийн хэвшлийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх</p> <p>10. Засгийн газраас тодорхой тогтсон хэмжээний санхүүгийн үйлчилгээгээр тогтмол хангах</p> <p>11. Ховордсон ан амьтдыг ажиглах аялал</p> <p>12. Задгай баазыг өвлийн улирлын онцлогт тохируулан өөрчлөх</p> <p>13. Тээвэрт зөвхөн автобус төдийгүй онгоцыг ч гэсэн ашиглах</p> <p>14. Аялал жуулчлалыг экспортын салбар гэж үзэн, гадна дотногүй өргөнөөр сурталчилж, урт хугацааны бага хүүтэй зээлийн бодлого хэрэгжүүлэх</p> <p>15. Аялал жуулчлалын газрууд болон зочид буудал жуулчны бааз хоорондын зайг, үйл ажиллагааны талаар хуульчлах</p> <p>16. Шинжлэх ухаанд үндэслэсэн төрийн зөв бодлого, төлөвлөгөө шаардлагатай.</p>
14	Энхбат Цэрэнбат Мөнх Харилцаа ТББ-ын тэргүүн	<p>1. БНХАУ-ын туршлагаас суралцаж, эхлээд дотоод аялагчдад зориулсан өвлийн аяллыг хөгжүүлж, дараагийн шатанд гадаадын жуулчдыг татах</p>

No.	Нэр, албан тушаал	Өвлийн аялал жуулчлалын талаарх санал
		<ol style="list-style-type: none"> 2. Засгийн газраас тогтвортой санхүүгийн бодлого хэрэгжүүлэх 3. Зохиогдож буй баяр, арга хэмжээг сайжруулж, дүрэм журам, хамрах хүрээний талаар стандарт тогтоох 4. Зөвхөн хэдхэн эвент зохиогоод өвлийн аялал жуулчлал хөгжихгүй учир, Монголын эрс тэс уур амьсгал, өвлийн тэсгим хүйтнийг мэдрэх аяллын бүтээгдэхүүнтэй хослуулбал сонирхолтой болно. 5. Олон улсын өвлийн спортын тэмцээн уралдааныг Монголд хийх 6. Гадаад жуулчид Монгол улсын хөгжил хэр хоцорч явааг, бодит байдлыг үзэхээр ирдэг. 7. Дэд бүтцийг сайжруулах 8. Эрсдэлийн даатгал 9. Үйлчилгээний түвшнийг сайжруулах, аялагчдын ая тухтай байдлыг хангах 10. Өвлийн аялагчдад байр хоол, зарим нэг үйлчилгээний зардлын тодорхой хувийг буцаан олгох.
15	Рэнцэнхүү Зоригтбаатар Дорнод Аялал Жуулчлалын Нэгдэл- ийн тэргүүн	<ol style="list-style-type: none"> 1. Бусад улсаас ялгаатай онцлог зан үйл, соёлыг түлхүү танилцуулах 2. Аймаг бүр жилд 1 удаа өвлийн наадам хийх, хугацааг давхардуулахгүй байх, орон нутгийн онцлогийг тусгах 3. ”Өвлийн Наадам”-ыг сурталчлах 3 компани байгуулж, Америк, Европ, Азийн улсууд руу идэвхтэй сурталчлах 4. Засгийн газрын аялал жуулчлалын засаглалыг сайжруулах 5. Аялал жуулчлалын байгууллагуудын менежментийг сайжруулах, төрөөс дэмжлэг үзүүлэх 6. Аялал жуулчлалын стандарт боловсруулах 7. Аялал жуулчлалын салбарын холбогдох байгууллагуудын харилцааг зохицуулах хууль шаардлагатай, төр болон хувийн хэвшил, ТББ байгууллагууд хоорондоо өрсөлдөхгүй байх. 8. Нэгдсэн тарифын бодлогыг хэрэгжүүлэх 9. Нүүдэлчдийн уламжлал соёлд суурилсан үйлчилгээг стандартчилах 10. Олон улсын стандартыг хангасан аялал жуулчлалын үйлчилгээг нэвтрүүлэх
16	Дашбэлэн Мөнхтөмөр Хаппи Сити Групп ХХК- ийн АЖ хариуцсан захирал	<ol style="list-style-type: none"> 1. Засгийн газраас аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого 2. Дэд бүтцийн хөгжил 3. Төр, орон нутаг, ТББ, хувийн хэвшил, иргэдийн хамтын ажиллагаанд тодорхой болгох 4. Шаардлагатай хууль журам, стандартыг баталж, хэрэгжүүлэх 5. Төр, орон нутгийн захиргааны ажилтнуудад аялал жуулчлалын боловсрол олгох сургалт зохион байгуулах 6. Эвентийг хэрэгжүүлэх тогтолцоог сайжруулах 7. Өвлийн эвентийг төрөөс баталгаажуулж, хэрэгжүүлэх 8. Нийслэл хотод 12 сараас 3 сар дуустал хугацаанд гэрэлт гудамж байгуулах 9. Нийслэл хотод, 12 сарын 1-нээс 1 сарын 31 хүртэл шинэ оны үзэсгэлэнг гаргах 10. Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд мөсөн хот, гэрлэн чимэглэл байрлуулах 11. Цанын бааз, тэшүүрийн талбай барих

No.	Нэр, албан тушаал	Өвлийн аялал жуулчлалын талаарх санал
		12. Дархан, Эрдэнэт хотод өвлийн спортын ордон барих, мэргэжлийн тамирчид бэлтгэл хийх, ард иргэд хоккей тоглох, тэшүүрээр гулгах 13. Нийслэл хотод дотоод гадаадын брэнд бүтээгдэхүүний хямдралын аян явуулах 14. Жуулчдад татварыг (НӨАТ) буцаан олгох 15. Малчдын аж амьдралыг харуулсан “ малчдын хот” байгуулах 16. Мөс, тэмээ, бүргэдийн баяр 17. Аяллын зориулалттай чартер нислэгийн үйлчилгээг хөгжүүлэх 18. Хүйтний улиралд тохиромжтой халуун рашаан сувиллын газар байгуулах 19. Олон улсад нэр хүндтэй өвлийн спорт хөгжүүлэх (цана, тэшүүр, сноуборд, мотоцикл, хоккей зэрэг) 20. Туул, Сэлбэ голын мөсөн дээрх шагай наадгай 21. Скай резорт болон үндэсний цэцэрлэгт хүрээлэнд цасаар байлдах тэмцээн зохион байгуулах 22. Өвлийн аяллын аюулгүй байдлын талаар хөтөч, жолоочдод сургалт явуулах 23. Хүйтэнд тэсвэртэй технологиор хийсэн хувцас хэрэглэл ашиглах
17	Баделгажы Эрбахыт МҮИС (Хувийн)-ийн аялал жуулчлалын багш	1. Сноубордыг моринд бэхлээд татах г.м экстрим аялал 2. Үйлчилгээг сайжруулах 3. Хүний нөөцийг хөгжүүлэх 4. Дулаан барилга байгууламж барих 5. Хүйтэнд тэсвэртэй хувцас үйлдвэрлэл (Өвлийн аялалд зориулж) 6. Туйлын хөх туяаг харахад ашигладаг шилэн байртай ижил төстэй байгууламжийг өвлийн од харах зориулалтаар байгуулах.
18	Дагвачүлтгэм Содномсамдан Баянхонгор аймгийн БОАЖГ-ын мэргэжилтэн	1.Тухайн бүс нутгийн онцлогийг тусгасан аялал (түүх, соёл, байгаль) 2. Өртөг багатай 3. Төрийн тогтвортой бодлого 4. Иргэдийн оролцоо 5. Дээрх 4 хүчин зүйл аялал жуулчлалын хөгжилд чухал нөлөөтэй. 6. Улсын хэмжээний эвент, арга хэмжээ зохиох 7. Эвент нь орон нутгийн онцлог, соёлыг тусгасан учир утгатай байх
19	Намхай Адъяболд Нью Майлстоун ХХК-ийн захирал	1. Мөсний баяр 2. Монгол гэр, урц майханд хонох 3. Нохой чарга, морин чарга, тэмээн аялал, мөсөн урлаг 4. Халуун рашаан 5. Зул сарын арга хэмжээ 6. Соёлын аялал 7. Дугуй, мотоцикл аялал, чөлөөт алхалт, малчин айлд хонох 8. Бэсрэг наадам, галын наадам 9. Бүргэдийн баяр, чонотой зураг авахуулах, цагаан сар
20	Мягмардорж Мөнхжаргал ЖИМ аяллын хөтөч сэтгүүлийн эрхлэгч	1. Монголын уламжлал соёлыг харуулсан аялал жуулчлалын жишиг хотхоныг бий болгож, хөгжүүлэх 2. Мөсөн урлал 3. Дугуйн аялал, ууланд алхах, цана, снөүкайт (Сноубордыг шүхрээр чирэх)

Но.	Нэр, албан тушаал	Өвлийн аялал жуулчлалын талаарх санал
21	Батжаргалын Мөнхмандах Номадик Лежендс Тур Сервис ХХК-ийн захирал	1. Цанын бааз (Олон улсын стандартад нийцсэн) 2. Нохой чарга, дугуйн аялал, зөөврийн саун, ууланд алхах болон ууланд авирах 3. Халуун рашаан сувилал

Эх сурвалж : Монголын үндэсний сайтын хөгжлийн нэгдсэн холбооны мэдээлэлд үндэслэн судалгааны баг боловсруулав.

2.12 Аялал жуулчлалын салбарын бусад донор байгууллагуудын чиг хандлага

Аялал жуулчлалын салбарын бусад донор байгууллагуудын тусламж, хамтын ажиллагаа дараах байдалтай байна.

Хүснэгт 2-36: Монгол улсын аялал жуулчлалын салбарын донор байгууллагуудын жагсаалт

Донор байгууллагууд	Гол үйл ажиллагаа
НҮБ-ын Дэлхийн аялал жуулчлалын байгууллага (UNWTO)	"Аялал жуулчлалын ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх" төслийг 2015 оны 3 -р сараас 2017 оны 6 -р сар хүртэл хэрэгжүүлсэн. Ковид -19 цар тахлын нөлөөнд өртсөн аялал жуулчлалын салбарын нөлөөллийг судалж, сэргээх төлөвлөгөө боловсруулах төслийг цаашид хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байна.
НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр (UNDP)	2010 оны 8 -р сараас 2018 оны 4 -р сар хүртэл Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутгийн системийн менежментийн үр нөлөө, санхүүгийн тогтвортой байдлыг дэмжих зорилгоор "Монгол улсын дархан цаазат газрын сүлжээг бэхжүүлэх" ажлыг хэрэгжүүлсэн.
Дэлхийн банк (WB)	2000-аад онд "Зам, тээвэр хөгжүүлэх төсөл" болгон Эрдэнэсант-Арвайхээр, Хархорин-Тосонцэнгэл гэх мэт газруудын авто замыг сайжруулсан. 2020 оны 11-р сард дэд бүтцийн салбарын хэрэгцээ болон хөрөнгө оруулах тэргүүлэх чиглэлүүдийг судалж, дүгнэсэн "ИнфаСАП: Харилцан хамааралтай эдийн засгийг төрөлжүүлэх дэд бүтэц" -ийг хэвлэсэн бөгөөд үүнд аялал жуулчлалтай холбоотой дэд бүтцийн үнэлгээ ч багтсан болно.
Олон улсын санхүүгийн корпораци (IFC)	2012 онд Шангри-Ла Улаанбаатар (SLUB) төслийн 1-р үе шат болох 280 өрөө, оффис, дэлгүүр бүхий 5 одтой зочид буудлын бүтээн байгуулалтыг хийсэн, 2018 онд Шангри-Ла Улаанбаатарын 2-р үе шат болох 25 давхар оффисын барилга, 185 айлын орон сууцны барилга, ресторан, кино театр зэрэг 5 давхар худалдааны төв, хамгаалах байртай машины зогсоол зэрэг цогц байгууламжуудыг бүтээн байгуулахад хөрөнгө оруулалт хийсэн. 2016 онд Монголын ноолуур боловсруулалтын тэргүүлэгч компани Монгол Микрон Кашмер ХХК (ММС)- ын 123 зочны өрөө, дэлгүүр, 200 машины зогсоол бүхий цогц байгууламжийн бүтээн байгуулалтад хөрөнгө оруулалт хийсэн.
Азийн Хөгжлийн банк (ADB)	"Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газарт иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэх нэгдсэн төсөл", "Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл" гэх мэт олон төсөл, CAREC ³¹ бүсийн аялал жуулчлалын төслүүдийг хэрэгжүүлсэн (доор дэлгэрэнгүй).
Европын холбоо (EU)	Ноолуур, арьс шир, ноосны үйлдвэрлэл эрхлэх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор 2014 оноос хойш "Монгол улсад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих (SECIM)" төсөл үргэлжилж байна. 2018-2022 он хүртэл "Монголын Нэхмэлийн Салбарын Тогтвортой Үйлдвэрлэл, Эко Тэмдэг" төслийг

³¹ Central Asia Regional Economic Cooperation (Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа) Төв Азийн голдуу 11 орон, хөгжлийн түншүүдтэй хамтран хөгжлийг дэмжих замаар эдийн засгийн өсөлтийг хурдасгах, ядуурлыг бууруулах зорилготой түншлэл. Монгол улс мөн гишүүн орон юм.

Донор байгууллагууд	Гол үйл ажиллагаа
	хэрэгжүүлж, тогтвортой түүхий эдийг бэлтгэх, тогтвортой бүтээгдэхүүний брэндийг үүсгэн бэхжүүлэх, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлж, ногоон санхүүжилтийн эх үүсвэрүүдэд холбогдоход тусалж, хэрэглэгчдийн хүрээг тэлэхэд дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулж байна. Түүнчлэн Европын хөрөнгө оруулалтын банк нь, Улаанбаатар хотын гэр хорооллын бохир ус цэвэрлэх, ариун цэврийг сайжруулах АХБ -ны “ULAANBAATAR WWS” төслийн хөтөлбөрт хэсэгчлэн хөрөнгө оруулалт хийсэн.
Япон Улс (ЖАЙКА, Гадаад харилцааны яам)	ЖАЙКА-ийн хамтын ажиллагаа нь 1999 оны Аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөөний судалгаанаас эхэлсэн бөгөөд Хархорум музейг барьж байгуулах, Монголын Үндэсний музейн цуглуулгыг хадгалах орчныг сайжруулах тоног төхөөрөмжийг шинэчлэх ажлыг буцалтгүй тусламжаар хийж гүйцэтгэсэн. Аялал жуулчлалтай холбоотой дэд бүтцийн тухайд гэвэл Дорноговийн чиглэлийн төмөр замын тээврийн чадавхийг сайжруулах, Улаанбаатар хотын авто замын засвар, арчлалтын ажлыг хэрэгжүүлэхэд тусламж, дэмжлэг үзүүлсэн. Одоо хэрэгжиж буй төсөл нь "Монгол орны зам, цаг уурын нөхцөлд тохирсон авто замын хучилтын технологийн чадавхийг сайжруулах төсөл" ба 2019-2022 онуудад Зам, тээврийн хөгжлийн яам, Зам, тээврийн хөгжлийн төвийн зам хучилтын технологийн чадавхийг бэхжүүлэх замаар хатуу хучилттай замын бүтцийн зураг төсөл, авто замын хучилтын хийц, хольц төсөллөх стандарт боловсруулах, боловсронгуй болгох ажлуудыг хийхээр төлөвлөж байна. Мөн хөнгөлөлттэй зээлээр баригдсан Улаанбаатар олон улсын шинэ нисэх онгоцны буудал 2021 оны 7 -р сарын 4 -нд ашиглалтад орсон. Гадаад Хэргийн Яам нь 1995 оноос музейн мэргэжилтнүүдийн ур чадварыг дээшлүүлэх (хадгалах, сэргээн засварлах, үзэсгэлэн гаргах, үйл ажиллагаа явуулах) зорилгоор семинар зохион байгуулах, дэлхийн өв, биет бус соёлын өвийг бүртгэх талаар сургалт явуулах зэрэг, ЮНЕСКО-оор дамжуулан соёлын өвийг хамгаалах, хүний нөөцийг хөгжүүлэх тусламж, дэмжлэгийг үзүүлж ирсэн.
БНСУ (КТО)	БНСУ-ын Аялал жуулчлалын байгууллагаас "Монголын аялал жуулчлалын сургалт, дадлагын төв байгуулах, ажиллах хүчний чадавхийг бэхжүүлэх төсөл" -ийг хэрэгжүүлж байна. Монголд тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх аялал жуулчлалын сургалт, дадлагын төв байгуулах, аялал жуулчлалын үйлчилгээний ажилчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх зорилготой. Сургалтын төвийг 2022 он гэхэд барьж дуусгахаар төлөвлөж байна. 2019-2020 онуудад Монгол улсын аялал жуулчлалын ажиллах хүчний чадавхийг бэхжүүлэх мастер төлөвлөгөө боловсруулах, мастер төлөвлөгөөнд үндэслэн сургалтын хөтөлбөр боловсруулах, туршилтын дадлага, сургалт зохион байгуулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлсэн.
Кувейт (KFAED)	Арабын эдийн засгийн хөгжлийн Кувейт сан (KFAED) нь Хэнтий аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг бэхжүүлэх зорилгоор Өндөрхааны нисэх онгоцны буудлын агаарын тээвэрт шаардлагатай дэд бүтцийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж байна (2021 оны 6 -р сард дуусах төлөвлөгөөтэй байгаа).
Турк (TIKA)	1994 оноос хойш Туркийн олон улсын хамтын ажиллагаа, зохицуулах агентлаг (TIKA) -аар дамжуулан эртний Туркийн Орхоны бичээсийг хамгаалах музей байгуулах, Хархориноос Хөшөө Цайдам хүртэлх замын хатуу хучилтыг техникийн туслалцаатайгаар гүйцэтгэсэн.
Герман (GIZ, KfW)	Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ) нь "Монгол Улсын тогтвортой аялал жуулчлал, хүртээмжтэй эдийн засаг", "Тусгай хамгаалалттай газар нутгуудад дэмжлэг үзүүлэх замаар экосистемийг хадгалан хамгаалахад хувь нэмэр оруулах нь (SPACES) төсөл"-үүдийг хэрэгжүүлсэн. Германы Сэргээн Босголтын Зээлийн Банк

Донор байгууллагууд	Гол үйл ажиллагаа
	(KfW) нь Монгол улсад “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийг хэрэгжүүлсэн (доор дэлгэрэнгүй тайлбарласан болно).

Эх сурвалж: Судалгааны баг

Дээрх хүснэгтээс, ДАЖБ, АХБ, Германы GIZ, KfW нь аялал жуулчлалын салбарын гол донор байгууллага болох нь харагдаж байна. Эдгээр байгууллагуудын тусламж, хамтын ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг дараах байдлаар оруулав.

(1) НҮБ -ын Дэлхийн аялал жуулчлалын байгууллага (UNWTO)

НҮБ-ын Дэлхийн аялал жуулчлалын байгууллага нь 2015 оны 3-р сараас 2017 оны 6-р сар хүртэл "Аялал жуулчлалын ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх" төслийг хэрэгжүүлж, зочлох үйлчилгээ / аялал жуулчлалын менежмент, зочид буудлын үйл ажиллагааны дэвшилтэт менежмент, аяллын хөтчийн сургалт зэрэг төрөл бүрийн сургалтуудыг явуулжээ. 2017 оны 5-р сарын байдлаар эдгээр сургалтад нийт 350 хүн оролцсон бөгөөд сургалтад оролцогчдын 70% нь төсөл хэрэгжих явцад аялал жуулчлалын салбарт ажилд орж чадсан байна.

Мөн Монгол Улсын БОАЖЯ-аас Дэлхийн аялал жуулчлалын байгууллагад хандаж Ковид -19 цар тахлын нөлөөнд өртсөн аялал жуулчлалын салбарын нөлөөллийг судалж, сэргээх төлөвлөгөө боловсруулж өгөхийг хүссэн байна. Энэхүү төслөөр аялал жуулчлалын салбарын жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр боловсруулах, Tourism Satellite Account (Аялал жуулчлалын хиймэл дагуулын тооцоо)³² аргыг нэвтрүүлэхээр төлөвлөж байсан боловч 2021 оны 1-р сарын сүүлээр Ерөнхий сайд, БОАЖ-ын Сайд солигдсоноос үүдэн хөтөлбөрийн агуулга болон хэрэгжилт одоогоор тодорхойгүй байна.

(2) Азийн хөгжлийн банк (АХБ)

АХБ нь тогтвортой аялал жуулчлалын чадавхийг сайжруулах замаар орон нутгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэх зорилгоор "Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газарт иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэх нэгдсэн төсөл" -ийг 2016-2019 онд хэрэгжүүлсэн. Мөн 2019-2025 он хүртэл "Аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэх төсөл"-ийг Хөвсгөл, Хэнтий аймгуудад хэрэгжүүлж байгаа бөгөөд Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газар, Онон-Балжийн байгалийн цогцолборт газарт дэд бүтэц, ариун цэврийн байгууламжийг сайжруулах, аялал жуулчлалын тогтвортой хөгжлийг хянаж, удирдах чадварыг дээшлүүлэх зэрэг ажлыг хэрэгжүүлж байна. Хэнтий аймагт музей, кафе, театр, тайз бүхий томоохон цогцолборыг 2021-2024 оны хооронд барихаар төлөвлөж байна. Үүний зэрэгцээ 2020 оны 6-р сараас 2021 оны 4-р сар хүртэл "Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл (2-р үе шат)" -ын ТЭЗҮ-ийн судалгааг Баян-Өлгий, Увс, Ховд аймгуудад хийж байна. Энэхүү төсөл нь орон нутгийн аялал жуулчлалын бизнесийг хөгжүүлэх, дэд бүтцийг бүрдүүлэх, ариун цэвэр, хог хаягдлын менежментийг сайжруулах, соёлын өв, тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг бэхжүүлэхэд чиглэсэн 2027 он хүртэлх урт хугацааны төсөл бөгөөд аялал жуулчлалын төв, дижитал музей, аялал жуулчлалын гудамжийг байгуулах төлөвлөгөөтэй байгаа юм.

Түүнчлэн АХБ нь "CAREC TOURISM STRATEGY 2030" -ыг Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа/CAREC/ -ны бүс нутгийн аялал жуулчлалын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх нийтлэг стратеги, ерөнхий хүрээ гэж томъёолжээ. Энэхүү стратегидаа аялал жуулчлалын тэргүүлэх 7 кластерын бүс нутгийг сонгон тогтоож, Алтай, Говийн бүс гэсэн 2 Монголын бүс нутаг сонгогдсон байна. Бүс нутаг тус бүрийн нарийвчилсан стратегиудыг цаашид хэлэлцэж тогтоох төлөвлөгөөтэй байна.

³² Тухайн улс орны эдийн засагт үзүүлэх аялал жуулчлалын нөлөөллийг хэмжих статистик арга. Япон хэлээр "Travel / Tourism Satellite Account" гэнэ. ДАЖБ нь "Recommended Methodological Framework 2008" (TSA: RMF08) олон улсын стандартыг боловсруулсан байна.

Эдгээр төслөөс гадна "Монгол улсын тээврийн ухаалаг систем" төслийг 2016 оны 7 -р сараас 2017 оны 8 -р сар хүртэл хэрэгжүүлж, 21 аймгийн ITS үйлчилгээний тэргүүлэх чиглэлүүдийн жагсаалтыг гаргаж, ITS семинар зохион байгуулжээ. Замын хөдөлгөөнийг сайжруулах зорилгоор "Баруун бүсийн авто замын коридорыг хөгжүүлэх хөтөлбөр-I шат (2014-2021)", "Баруун бүсийн авто замын коридорын хөрөнгө оруулалтын хөтөлбөр-II шат" (2014 оноос хойш үргэлжилж байгаа) хөтөлбөрүүдийг мөн хэрэгжүүлж байгаа бөгөөд АХБ-ны төслүүд нь олон салбарыг хамарч хэрэгжиж байгаа юм.

(3) Герман улс (GIZ, KfW)

Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ) нь 2018 оны 6 -р сараас 2020 оны 6-р сар хүртэл "Монгол Улсын тогтвортой аялал жуулчлал, хүртээмжтэй эдийн засаг" төслийг Монгол улс, Тайландын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага ТИСА -тай гурван талт хамтын ажиллагааны төсөл болгон Баянхонгор, Сэлэнгэ, Увс аймагт хэрэгжүүлсэн. Энэхүү төслөөр эко аялал жуулчлалын төлөвлөлт, аялал жуулчлалын газрын менежментийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, аялал жуулчлалын байгальд ээлтэй бүтээгдэхүүн болон үнэ цэнийн сүлжээг Монгол улсын 3 аймагт бий болгох, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд зориулсан сургалт зохин байгуулах, орон нутгийн зах зээлийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн төр, хувийн хэвшлийн түншлэлийн (PPT) загварыг хөгжүүлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх гэх мэт олон салбарыг хамарсан чадавхийг хөгжүүлэх хөтөлбөрийг боловсруулж, орон нутгийн болон улсын түвшинд аялал жуулчлалын стратеги, бодлого боловсруулалтыг дэмжиж ажиллаж байна.

Мөн 2019-2022 онуудад "Тусгай хамгаалалттай газар нутгуудад дэмжлэг үзүүлэх замаар экосистемийг хадгалан хамгаалахад хувь нэмэр оруулах нь (SPACES) төсөл"-ийг хэрэгжүүлж байна. Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн байгууллагуудын санхүүгийн чадавхийг сайжруулах мөн тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн байгууллагууд нь орлогоо өөрсдөө бүрдүүлэх боломжийг олгох дүрмийн төслийг боловсруулахад БОАЖЯ-нд дэмжлэг үзүүлэх, тусгай хамгаалалттай газар нутагт байгаль орчинд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлэх, тусгай хамгаалалттай газрыг хэт ашиглаж, даац хэтрэхээс урьдчилан сэргийлэхийн тулд аялал жуулчлалын компаниуд, бусад холбогдох газруудад ашиглалтын өөр төлөвлөгөө боловсруулахад нь зөвлөгөө өгөх зэргээр хамтран ажиллаж байна.


Түүнчлэн Германы Сэргээн Босголтын Зээлийн Банк (KfW) нь Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг бэхжүүлэх, орон нутгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэх замаар биологийн олон янз байдлыг хамгаалах зорилгоор "Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох" төслийг 2015-2026 онуудад хэрэгжүүлж байна. Уг төслөөр Хархорин сум, Төвхөн хийд, Улаан цутгалан орчимд авто машины зогсоол, мэдээллийн самбар, ариун цэврийн байгууламж бүхий отоглох цэг / майхан барьж хоноглох талбайг байгуулсан байна.

3-р бүлэг

Зорилтот бүс нутаг болох аялал
жуулчлалын маршрутын ерөнхий
танилцуулга

3-р бүлэг Зорилтот бүс нутаг болох аялал жуулчлалын маршрутын ерөнхий танилцуулга

Монгол улс 21 аймаг, нийслэл Улаанбаатар хот гэсэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжтэй. Энэхүү тайлангийн 1.2.2 -т тайлбарласан аялал жуулчлалын 4 маршрутад багтсан нийслэл Улаанбаатар хот болон 7 аймгийн аялал жуулчлалын салбарын ерөнхий танилцуулгыг энэ бүлэгт оруулсан болно.




Эх сурвалж: Судалгааны баг

Зураг 3-1: Судалгааны зорилтот бүс нутаг болох аймгууд ба Улаанбаатар хот

3.1 Өмнөговийн аялал жуулчлалын маршрут

3.1.1 Үндсэн мэдээлэл , Аялал жуулчлалын нөөцийн тухай

Өмнөговийн аялал жуулчлалын маршрут (Улаанбаатар хот - Дундговь аймгийн Мандалговь хот - Өмнөговь аймгийн Даланзадгад хот орчмын бүс нутаг) нь Монгол орны топографийн ангиллаар говийн бүсэд (ургамал тачир сийрэг, элсэн манхантай, элс хайрган хөрстэй хээр тал) хамаарах бүс нутаг юм. Нийслэл Улаанбаатараас Дундговь аймгийн Мандалговь хот хүртэлх 280 км, Мандалговь хотоос Даланзадгад хот хүртэл 300 км хатуу хучилттай авто замыг барьж дуусгасан. Ингэснээр сүүлийн жилүүдэд эдгээр бүс нутаг руу явахад хялбар болсон байна.



Зураг 3-2: Өмнөговийн аялал жуулчлалын маршрут, аялал жуулчлалын гол нөөц

(1) Дундговь аймгийн Мандалговь хот орчмын бүс нутаг

Дундговь аймаг нь 74,690 км² газар нутагтай, 47,104 хүн амтай (2020 он). Тэгш тал газрын хамгийн өндөр нь далайн түвшнээс дээш 1530 м, хамгийн нам нь 980 м өндөрт өргөгдсөн газар бөгөөд дундаж температур нь өвлийн улиралд -16-19 хэм хүйтэн, зундаа 17-21 хэм дулаан байдаг. Аймгийн төв Мандалговь хот нь Өмнөговь аймгийн Ханбогд сум, Цогтцэций сум, Гашуун сухайтын хилийн боомт, Даланзадгад хот, Гурван тэс чиглэх уул уурхайтай холбоотой автомашин, автобус, хувийн автомашин, дундын такси зэрэг олон тээврийн хэрэгслийн дамжин өнгөрөх цэг болж байдаг. Сүүлийн жилүүдэд Дундговь аймгийн хоол хүнсний болон үйлчилгээний салбар хурдацтай хөгжиж байгаа нь тус аймгаар дамжин өнгөрөх хүмүүсийн тоо нэмэгдсэнтэй холбоотой гэж үзэж байгаа боловч энэ чиглэлээр нарийвчилсан судалгаа хийгдээгүй байна. Аялал жуулчлалын гол төв нь “Их газрын чулуу” хэмээх боржин чулуун бүс нутаг юм.

Мандалговь хот нь Дундговь аймгийн төв хэсэгт байрладаг бөгөөд Өмнөговь аймаг руу явах хамгийн дөт авто зам дайрдаг аймгийн төв юм. Улаанбаатар - Мандалговь - Даланзадгад хот хоорондын авто зам хатуу хучилттай болсноор Өмнөговийг зорих аялагчдын тоо сүүлийн жилүүдэд нэмэгдсээр байна. Үүнтэй холбоотойгоор Мандалговь хотын зочид буудал, хоол үйлчилгээ, амралтын газруудын тоо ч нэмэгдсээр байна. Одоогоор 5 зочид буудал (159 өрөө), 11 ресторан (770 суудал) ажиллаж байна. Гэхдээ нийтийн бие засах газар байдаггүй бөгөөд рестораны бие засах газрыг хэрэглэх шаардлагатай болдог. Хатуу хучилттай авто зам тавигдсанаар тус аймгийн Өлзийт сумд байдаг өвөрмөц, байгалийн үзэсгэлэнт газар болох Цагаан Суварга гадаад, дотоодын жуулчид ихээр очдог газруудын нэг болжээ. Доорх хүснэгтэд үзүүлсэнчлэн тус аймагт аялал жуулчлалын хэд хэдэн нөөц байдаг боловч одоохондоо аялал жуулчлал дөнгөж л хөгжиж эхэлж байгаа гэхэд болно.

Хүснэгт 3-1: Мандалговь хот орчмын аялал жуулчлалын гол нөөцүүд

Аялал жуулчлалын гол үзмэрүүд	Улирал	Товч мэдээлэл
Бага газрын чулуу ТХГ	Зун	Боржин чулуун байгалийн өвөрмөц тогтоцтой хад, цохиотой газар. Үндэсний дуу хөгжмийн концерт задгай талбайд зохиогддог. Мөн жил бүрийн намар “Адуучин, айргийн баяр” болдог байна.
Их газрын чулуу БЦГ	Зун	Жил бүрийн 8-р сарын 10-аас 2 өдрийн турш “Уяхан замбуу тивийн наран” урлагийн их наадам асар том хад, асгадын дунд барьсан байгалийн задгай тайзан дээр зохиогддог. Үндэсний дуу хөгжим төдийгүй рок зэрэг орчин үеийн дуу хөгжимчид ч оролцдог, Дундговь аймгийн хамгийн том арга хэмжээ бөгөөд 2019 онд 15,000

Аялал жуулчлалын гол үзмэрүүд	Улирал	Товч мэдээлэл
		хүн оролцжээ. 7-р сард “Морь ба Монголын аялал” нэртэй явган аялал 2 өдрийн турш зохион байгуулагддаг.
Цагаан Суварга	Зун	Эртний хадны сүг зураг ихтэй байгалийн үзэсгэлэнт аялал жуулчлалын газар. Дэл ууланд байдаг “Гучин хоёр хүнт” хэмээх хадны зургаас сэдэвлэсэн “Хөмөргөн гурвалжин” бүжгэн жүжгийг 2016-2018 оны хооронд 10 гаруй удаа Улаанбаатар хотод тоглосон байна. Мөн 2018 оны 12-р сард Францын Парис хотод ЮНЕСКО-гийн төв байранд ч энэхүү тоглолтыг хийжээ. Дэл уулын хадны зургийг хамгаалах, аялал жуулчлалын нөөц болгон ашиглах зорилгоор орон нутгийн иргэдийн санаачилгаар "Дэл уулын гайхамшиг" ТББ -ыг байгуулж, идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. 2020 онд 1500 гаруй жуулчин Дэл уулын хадны зургийг үзэж сонирхжээ. ³³ 9-р сард “Их говийн тэмээний баяр” -г зохион байгуулдаг бөгөөд 2 өдөр үргэлжилдэг тус баярт бусад аймгаас ч малчид тэмээтэйгээ ирж оролцдог.
Онгийн хийд	Зун	9-р сард “Малчны баяр-Ардын урлагийн наадам” зохион байгуулдаг.

Эх сурвалж: Судалгааны баг

(2) Өмнөговь аймгийн Даланзадгад хот орчмын бүс нутаг

Өмнөговь аймаг нь 165,000 км² газар нутагтай, 71,493 хүн амтай (2020 он). Монгол улсын хамгийн том газар нутагтай боловч хүн амын нягтрал хамгийн бага аймаг гэдгээрээ онцлогтой. Үлэг гүрвэлийн чулуужсан өндөг дэлхийд анх удаа олдсон газар гэдгээрээ алдаршсан аймаг юм. Мөн Монголд анхны гадаадын жуулчдыг хүлээж авах бааз Өмнөговь аймагт нээгдэж байсан. 1996 онд Өмнөговь аймгийн нийгэм эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх салбарыг аялал жуулчлал, уул уурхай, хөдөө аж ахуй гэж тодорхойлж байсан. 2000 оноос хойш Оюу толгойн зэс-алтны орд, Таван толгойн нүүрсний орд зэрэг дэлхийд дээгүүрт орох ашигт малтмалын баялаг ордуудаа ашиглаж эхэлснээр уул уурхайн салбар эрчимтэй хөгжсөн. Аймгийн төсвийн орлогын ихэнхийг уул уурхайгаас бүрдүүлж байгаа тул өдгөө аймгийн нийгэм, эдийн засгийн тэргүүлэх салбарыг хариуцлагатай уул уурхай, тогтвортой аялал жуулчлал, эрчимжсэн хөдөө аж ахуй гэж тодорхойлж байна. Үлэг гүрвэлийн анхны өндөг олдсон, олдворт газар Баянзаг, Гурвансайхан уулын байгалийн үзэсгэлэнт тогтоц Ёлын ам, Хонгорын элсэн манхан зэрэг аялал жуулчлалын алдартай газрууд байдаг.

Өмнөговь аймгийн төв нь Даланзадгад хот бөгөөд тус аймгийн аялал жуулчлалын гол төв нь болох юм. 1923 онд Нью -Йорк дахь Америкийн Байгалийн түүхийн музейгээс илгээгдсэн Эндрюсийн экспедиц одоогийн Булган сумын нутаг Баянзагаас дэлхийн анхны үлэг гүрвэлийн өндгийг илрүүлж, Өмнөговийг дэлхийд таниулжээ. Тус аймагт элсэн манхан, үлэг гүрвэлийн чулуужсан олдвор олдсон газар, түүхийн бусад дурсгалт газрууд ч их байдаг. Мөн аялал жуулчлалын олон эвент, арга хэмжээ зохион байгуулагддаг.

Хүснэгт 3-2: Даланзадгад хот орчмын аялал жуулчлалын гол нөөцүүд

Аялал жуулчлалын гол үзмэрүүд	Улирал	Товч мэдээлэл
Ёлын ам (Гурвансайхан уулын байгалийн үзэсгэлэнт тогтоц)	Тогтмол	Говь Гурвансайхан ууланд байдаг уулын хавцал бөгөөд халуун зуны улиралд ч хавцлын мөс нь хайлдаггүй. Аргаль, янгир, цоохор ирвэс зэрэг олон зэрлэг амьтад байдаг. Хавцал нь Өмнөговь аймгийн бахархалт шувуу Ёлын өлгий нутаг юм.

³³ "Дэл уулын гайхамшиг" ТББ -ын дарга Б.Батмөнх, 2021 он

Аялал жуулчлалын гол үзмэрүүд	Улирал	Товч мэдээлэл
Хонгорын элс (Хэмжээгээрээ Азид 4 т ордог элсэн манхан)	Тогтмол	195м өндөр, 180 гаруй км урт үргэлжилсэн элсэн манхан юм. Элсэн манхны оргил өөд авирах, элсэн дээгүүр чаргаар гулгах зэргээр зугаацаж болдог. Элсэн манхны ойр хавьд Хулан жороо зэрэг Монголын “Улаан ном”-д бүртгэгдсэн ховор шувууд, мөн Дэлдэн зараа гэх мэт шөнийн амьдралтай ховор амьтдыг харж болно. Түүнчлэн малчин айлаар зочлох, тэмээ унах боломжтой. Ойролцоох жуулчны баазууд нь халуун устай шүршүүртэй, боловсон бие засах газартай. 9-р сарын хоёр дахь баасан, бямба, ням гаригт “Элсэн манхны баяр” зохион байгуулж, марафон гүйлт, элсний оргил булаалдах тэмцээн, элсний сумо, элсний волейбол зэрэг тэмцээнүүдийг зохион байгуулдаг.
Хавцгайт (хадны зураг)	Тогтмол	Олон мянган жилийн өмнөх хадны зургийг үзэх боломжтой.
Шар цавын үлэг гүрвэлийн мөрт газар	Тогтмол	90 сая жилийн өмнөх үлэг гүрвэлийн 18 мянган мөр нэг дороос олдсон бөгөөд энэ нь дэлхийн хэмжээнд хамгийн олонд тооцогддог.
Баянзаг (Үлэг гүрвэлийн анхны өндөг олдсон, олдворт газар)	Зун	АНУ-ын судлаач Эндрюс 1923 онд дэлхийд анх удаа үлэг гүрвэлийн чулуужсан өндгийг олсон газар юм. 60 гаруй сая жилийн өмнөх улаан хөндийгөөс үлэг гүрвэлийн чулуужсан олдвор олноор олдсон. Нар жаргах үед улаанаар гэрэлтдэг тул англиар Flaming Cliffs (Улалзах Цонж) гэж нэрлэдэг байна. Улаан шаварлаг хөрс нь тэгш талаас 100 гаруй метрийн өндөрт оршдог бөгөөд тэндээс өргөн уудам, гайхамшигтай үзэсгэлэнт газруудыг харах нь ер бусын сэтгэгдэл төрүүлж, мартагдашгүй дурсамж болдог. Аялал жуулчлалын мэдээллийн төвд Америкийн Байгалийн түүхийн музейн малтлага хийсэн үеийн тухай баримтат киног үзэх боломжтой.
200км Тэмээн аялал	Зун	Даланзадгад хотоос Хонгорын элс хүртэл тэмээгээр явах аялал юм. Энэхүү аялал нь Хонгорын элс, Баянзаг орчмын малчдын орлогын гол эх үүсвэр болдог.
Тэмээний уралдаан, тэмээний баяр	Зсар	Жил бүрийн 3-р сарын 6, 7-ны өдрүүдэд Өмнөговь аймгийн Булган суманд зохион байгуулагддаг. 2016 онд нэгэн зэрэг 1108 тэмээ уралдуулж Гиннесийн дээд амжилтыг тогтоож байсан бөгөөд тогтмол болдог өвлийн баяр юм. Ойролцоох 3 аймгийн тэмээчид ирж оролцдог.
Цас, мөсний баяр	Өвөл	Өвлийн улиралд болдог цас, мөсний баяр нь Ёлын ам, Хавцгайтын ам зэрэг өвлийн үзэмж үзэсгэлэнтэй газруудад болдог.

Эх сурвалж: Судалгааны баг

Монголд хамгийн анх гадаадын иргэдийг хүлээж авахад зориулсан жуулчны баазыг 1963 онд Өмнөговь аймагт байгуулсан түүхтэй. Гадаадын жуулчдыг хүлээж авах тал дээр маш их хүчин чармайлт гаргаж байгаа аймгуудын нэг юм. Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь Баянзаг, Хонгорын элс, Шар цавын үлэг гүрвэлийн мөрт газрыг дэлхийн жишигт нийцсэн аялал жуулчлалын газар болгохоор хөрөнгө оруулан тохижуулж байна. Мөн аймгийн байгалийн түүхийн музейн сэргээн засварлалтын ажил хийгдэж байгаа бөгөөд 90% ийн гүйцэтгэлтэй явж байна.

Өмнөговь аймгийн аялал жуулчлалын нэг онцлог нь бусад аймагтай харьцуулахад нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг илүү хөгжүүлж байгаа явдал юм. Энэ үйл ажиллагаа нь, 1996 онд Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ) болон “Газарчин” дээд сургуулийн багш нар хамтран тус аймгийн Сэврэй суманд зохион байгуулсан аялал жуулчлалын үйлчилгээний семинараас эхлэлтэй юм. Энэхүү семинарыг "Түмэн тэмээ-Тэмээн аялал

жуулчлалын холбоо" ны гишүүд, малчдад зориулж зохион байгуулжээ. Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ) нь нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх, орон нутгийн аялал жуулчлалын нөөцийг ашиглах, гар урлал, эсгий бүтээгдэхүүн үйлдвэрлэх чадавхийг дээшлүүлэх, аялал жуулчлалаас орлого олох тогтолцоог бүрдүүлэх зорилгоор олон сургалт семинар зохион байгуулжээ. Үүний зэрэгцээ байгаль орчныг хамгаалах чиглэлээр ч олон төрлийн үйл ажиллагаа явуулж байгаа юм.

Сүүлийн жилүүдэд Өмнөговь аймагт аялал жуулчлалын салбарын бизнесийг сонирхдог хүмүүсийн тоо нэмэгдэж, энэ салбарт шинээр бизнесийн үйл ажиллагаа эхлүүлж буй хүмүүс ч ихсэж байна. Аялагч, жуулчдад зориулсан кофе шоп гэхэд Даланзадгад хотод 5, Баяндалай суманд 1, нийт 6 газар шинээр нээгджээ. 2020 онд Даланзадгад хотод 2 зочид буудал шинээр баригдаж, мөн Даланзадгад хотоос 12 км -ийн зайтай газар жуулчны бааз шинээр байгуулагдсан бөгөөд Ковид-19 намжсаны дараа нээхээр төлөвлөж байгаа юм. (Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн Н.Бурмаа, 2021он).

Гэр буудал ажиллуулах сонирхолтой хүмүүс ч их байдаг. 2019 онд, 4 -р сарын эхнээс 11-р сар хүртэл ажиллуулж, хамгийн их жуулчин хүлээн авсан гэр буудал ойролцоогоор 1500 жуулчин байрлуулж 19.5 сая төгрөгийн орлого олжээ. Гэр буудал нь, гадаадын жуулчин 1 хүн 1 хоног (хоолгүй) 10,000-15,000 төгрөг байдаг бол дотоодын жуулчин 1 гэр нь 50,000 төгрөг (5 ортой) эсвэл 60,000 төгрөг (6 ортой) ний үнэтэй байдаг. Дотоодын жуулчид 5 аас дээш тооны хүн олуулаа 1 гэрт хонох тохиолдол олон бөгөөд зарим нь өөрсдийн майхантайгаа явдаг тул гадаадын жуулчдаас орох орлогын хэмжээ нь илүү байдаг.

Өмнөговь аймаг нь “Аялал жуулчлал-Өрхийн орлого” хөтөлбөрийнхөө хүрээнд тус аймгийн “Гэр буудлын журам” -ыг аймгийн ИТХ-ын 2019 оны 12-р сарын 4-ний 9/11-тоот тогтоолоор батлан гаргажээ. Уг журмыг баталснаар орон нутгийн иргэд гэр буудал ажиллуулж орлого олох эрх зүйн орчин бүрдсэн байна (Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн Н.Бурмаа, 2021он). Гэр буудал ажиллуулдаг аж ахуйн нэгжүүд нь, сумдын газрын зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн газар ашиглах эрхийн зөвшөөрлийг олгох үедээ, ИТХ-аас баталсан энэхүү “Гэр буудлын журам”-ыг дагаж мөрдөх ёстой гэж үзэж байна (Ёлын ам орчмын гэр буудал эрхлэгчдийн "Жаргалант" нөхөрлөлийн дарга Б.Оюунгэрэл, 2021 он).

Одоогийн байдлаар Өмнөговь аймагт 61 гэр буудал байгаа бөгөөд морь унуулах, тэмээгээр аялуулах үйлчилгээ үзүүлдэг 56 малчин айл байдаг. Малчид гэр буудал ажиллуулахаас гадна эсгийгээр хийсэн бэлэг дурсгалын зүйл зарж борлуулах, морь, тэмээ унуулах зэрэг үйлчилгээг үзүүлдэг бөгөөд Ёлын амын ойролцоо 6 айл бэлэг дурсгалын дэлгүүр ажиллуулж байна. Бэлэг дурсгалын дэлгүүр ажиллуулахаас өөрөөр малчдын орлогын эх үүсвэр болох бас нэг боломж бол нэн ховор, зэрлэг ан амьтад (Цоохор ирвэс, Мануул, Эрээн хүрнэ) ажиглах аяллын хөтөч хийх юм. Аялал жуулчлалын компаниуд орон нутгийн малчидтай гэрээ байгуулан, зэрлэг ан амьтдын байршил, хөдөлгөөнийг хянах, морь, тэмээ, гэр түрээслэх, цагаан идээ худалдаж авах, орон нутгийн хөтчөөр ажиллуулах зэрэг янз бүрийн чиглэлээр хамтран ажиллаж байна. Жишээлбэл, зэрлэг ан амьтдыг ажиглах 10 хоногийн 1 удаагийн аялалд нутгийн 3-7 малчин оролцож, нэг хүн 1- 4 сая төгрөгийн орлого олдог. Хавартаа ноолуур, өвөлдөө малын мах, арьс зарж борлуулахаас өөр орлогын эх үүсвэргүй байсан малчид, ийм аялалд оролцох замаар орлогоо нэмэгдүүлж байна. Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын хөгжил нь нутгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлэхээс гадна ховор ан амьтад, зэрлэг шувуу, ургамлын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, байгаль хамгаалах үйл ажиллагаанд идэвхтэй оролцоход ч хувь нэмэр оруулдаг (Өмнөговь аймаг, Tum Eco-tour компаний менежер Т.Цэлмэг).

2019 онд Ёлын Амын орчимд иргэдийн 2 Нөхөрлөл байгуулагдсан. Нэг нь гэр буудал ажиллуулдаг 12 өрхийн хамтарсан "Жаргалант" нөхөрлөл бөгөөд тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаатай гэрээ байгуулан бүс нутгийнхаа хог хаягдлыг цуглуулах, цэвэрлэх ажлыг гүйцэтгэдэг. Хоёр дахь нь Ёлын амын ойр орчимд гэр буудал, бэлэг дурсгалын дэлгүүр, ресторан ажиллуулдаг, морь унах, тэмээ унах үйлчилгээ үзүүлдэг хувиараа бизнес эрхлэгчдийн хамтран байгуулсан "Зүүн сайхан эх нутаг" нөхөрлөл юм. Говь Гурвансайханы БЦГ-ын хамгаалалтын захиргаатай байгуулсан гэрээний дагуу Ёлын амын хогийг цэвэрлэж, нийтийн бие засах газрыг цэвэрлэн тохижуулж байна.

3.1.2 Төлөвлөгөө / Аян / Арга хэмжээ

(1) Аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөөний тойм

Одоогоор Дундговь аймагт хэрэгжиж буй аймгийн бодлогын хөтөлбөр байхгүй бөгөөд аялал жуулчлалыг хөгжүүлэх мастер төлөвлөгөөг 2022 онд гаргахаар төлөвлөж байна.

Өмнөговь аймгийн ИТХ-ын 2019 оны 12 -р сарын 4 -ний өдрийн 9/10 тоот тогтоолоор баталсан "Өмнөговь аймгийн Аялал жуулчлалын хөгжлийн хэтийн төлөв 2019-2029" баримт бичиг нь, ирэх 10 жилд аялал жуулчлалын талаар баримтлах бодлого болон хэрэгжих юм. Энэхүү хэтийн төлөвийг тодорхойлсон баримт бичгийн анхны төслийг аймгийн "Гайхамшигт Говь" АЖ холбоо болон Улаанбаатар Аялал Жуулчлалын Холбоо хамтран боловсруулжээ. Иймэрхүү маягаар, хөдөө орон нутгийн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд ТББ-ууд голлох үүрэг гүйцэтгэх нь нэлээд ховор тохиолдол юм. Тус хөтөлбөрт үйл ажиллагааг хэн хариуцаж, хэдий хугацаанд хэрэгжүүлэхийг тодорхой заасан нь маш онцлог, давуу талтай бөгөөд бусад орон нутгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөнд загвар болгож болох тул танилцуулж байна. Ихэнх үйл ажиллагааны хэрэгжилтийг "Гайхамшигт Говь" АЖ холбоо хариуцах бөгөөд бүрэн хэрэгжилтийг Аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний газар тогтоох тогтолцоотойгоор төлөвлөгдсөн байна. 111 үйл ажиллагааг тусгасан энэхүү хөтөлбөр нь (1) аймгийн бүсчилсэн хөгжлийн хүрээнд хэрэгжүүлэх 43 үйл ажиллагаа, (2) "Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого 2019-2026" -н хүрээнд хэрэгжүүлэх 68 үйл ажиллагаанаас бүрдэнэ. Эдгээр үйл ажиллагаанд аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэх, аялал жуулчлалын нөөцийг хамгаалах, нутгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, аялал жуулчлалын салбарын ажилчдыг сургах гэх мэт төрөл бүрийн төлөвлөгөө багтсан болно.

Түүнчлэн энэхүү хөтөлбөрт үндэслэн тус аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн үндсэн бодлогын дагуу шаардлагатай төсвийг шийдвэрлэдэг систем 2019 оноос хойш хэрэгжиж иржээ. 2021 онд хэрэгжүүлэхээр төсөв нь шийдэгдсэн дараах үйл ажиллагаанууд байна. Үүнд эвент, сургалт явуулах (50 сая төгрөг), Дэмчогийн хийдийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрт холбож, Шар цавын бүтээн байгуулалтыг дуусгах (482.3 сая төгрөг), Хавтгай тэмээ, Бөхөн гөрөөс нутагшуулж, хамгаалах үйл ажиллагаа (70 сая төгрөг), Баянзагийн цахилгаан шугамын зураг төсөв (30 сая төгрөг), ан амьтны усан хангамжийг нэмэгдүүлж, нар салхины энергиэр ажилладаг худаг гаргах (114 сая төгрөг), Халиун буга нутагшуулж тоо толгойг нэмэгдүүлэх, "Говийн гайхамшигт зургаа" уулзалт арга хэмжээг Өмнөговь аймагт зохион байгуулах (90 сая төгрөг) зэрэг болно.

Судалгааны зорилтот бүс болох говийн аймгуудын тухайд "Алсын хараа 2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын бүсчилсэн хөгжлийн бүлэгт, "Палеонтологийн болон говийн нэн ховор амьтдын үндэсний парк, түүх, шашин, соёлын өв, байгаль газарзүй, рашаан сувилалд түшиглэсэн амралт сувилал, аялал жуулчлалын цогцолбор байгуулна" гэж төлөвлөсөн байна. Энэхүү ажлыг 1-р үе шатны 2030 он хүртэл хугацаанд хийж дуусгана гэжээ.

2019 онд УИХ-аар баталсан "Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого 2019-2026"-т Өмнөговь аймагт хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын хүрээнд аймгийн нисэх онгоцны буудлыг олон улсын нисэх буудал болгон хөгжүүлэх болон палеонтологийн аялал жуулчлалын үндэсний хүрээлэн байгуулах гэсэн 2 зүйлийг онцолсон байна.

"Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн хавсралтад, Говийн бүсийн аялал жуулчлалыг хөгжүүлэх цогц төсөл, Гурвансайхан нисэх буудлыг 4С ангиллын олон улсын нисэх буудал болгох (300 тэрбум төгрөг), Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн 45.5 км төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх, Зүүнбаян-Ханги чиглэлийн 281 км төмөр замын төслийг эхлүүлэх, Даланзадгад-Баяндалай-Гурвантэс чиглэлийн 220 км хатуу хучилттай авто замын төсөл зэргийг тусгажээ.

Өргөн уудам нутаг дэвсгэртэй нутаг учраас аялал жуулчлалын бүх алдартай газар нутаг бүрийн чиглэлд хатуу хучилттай авто зам барих нь санхүүгийн хувьд боломжгүй боловч одоогоор Хонгорын элсний ойролцоох Гурвантэс сум хүртэл хатуу хучилттай авто замыг барьж байна.

Гурвансайхан нисэх буудлыг 4С ангиллын олон улсын нисэх буудал болгох нь, Өмнөговь аймгийг ихээр зорьдог гадаадын жуулчдын ачааллыг үүрэлцэх, нийслэл хотын нисэх буудал

хаагдах тохиолдолд үүргийг шилжүүлэн авч ажиллах нисэх буудлыг бэлтгэх үүднээс ч их чухал ач холбогдолтой юм. Үүнийг Засгийн газар 2021-2026 оны төлөвлөгөөнд тусгасан байгаа боловч 2021 онд хэрэгжүүлэх төсөв батлагдаагүй байна.

Иймэрхүү маягаар дэд бүтцийн салбарыг хөгжүүлвэл тус аймгаар аялагчдын ая тухыг хангах нөхцөл байдал ихээхэн сайжрах болно.

Өмнөговь аймагт аялал жуулчлалын нөөцийг хамгаалах, хадгалах үйл ажиллагаа тууштай хэрэгжиж байгаа ба Баянзаг, Шарцавт хамгаалалтын хашаа барих, аялал жуулчлалын төв байгуулах зэрэг арга хэмжээг авч, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэхийн төлөө хичээн ажиллаж байгаа юм.

Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газар нь тус аймгийг төв, баруун, зүүн гэсэн гурван бүсэд хувааж аялал жуулчлалыг хөгжүүлэхээр төлөвлөж байна. Зүүн бүсэд нь дэлхийн томоохон ордын нэг болох Оюу толгойн зэс-алтны орд, Таван толгойн нүүрсний орд байдаг ба авто зам, төмөр замын бүтээн байгуулалтын тухайд БНХАУ-тай нягт хамтран ажиллаж байгаа тул үүнтэй уялдаад аялал жуулчлалын нөөцийн хүртээмж ч сайжрах магадлалтай.

Засгийн газар уул уурхайн үр өгөөжийг тухайн аймаг орон нутагт хүртээмжтэй байлгах бодлого баримталдаг тул Өмнөговь аймаг нь эдийн засгийн чадавх хамгийн сайн аймагт орно. Тус аймгаас бэлтгэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх 100 гаруй төсөл байна. Тэдгээр төсөлд аймгийн музейг байгуулах, Баянзагийг Дэлхийн өвд бүртгүүлэх бэлтгэл ажлыг дуусгах зэрэг багтжээ. Дэд бүтцийг хөгжүүлэх төлөвлөгөөг богино хугацаанд шийдвэрлэх санхүүгийн эх үүсвэрийг баталгаажуулах нь амаргүй боловч уул уурхайн нөөц боломжтой аймгийн хувьд харьцангуй санхүүгийн таатай нөхцөлтэй тул аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх магадлал өндөр билээ.

(2) "Өмнөговь аймгийн Аялал жуулчлалын хөгжлийн хэтийн төлөв 2019-2029" (Аймгийн ИТХ-ын 2019 оны 12 -р сарын 4 -ний өдрийн 9/10 тоот тогтоол)

Өмнөговь аймагт маш идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг “Гайхамшигт Говь” АЖ холбоо байдаг ба тус аймгийн аялал жуулчлалын төслүүдийг Аймгийн Засаг Даргын Тамгын газартай нягт уялдаа холбоотойгоор хэрэгжүүлж, аялал жуулчлалыг хөгжүүлж байна. Тус ТББ Аймгийн Засаг Даргын Тамгын газартай хамтран боловсруулсан үйл ажиллагааны хөтөлбөрт нийт 111 төслийг бүс нутаг, салбар, хамтран оролцогч тус бүрээр хүснэгтлэн гаргасан байна. Эдгээрээс зөвхөн судалгааны багийн хувьд онцгой ач холбогдолтой гэж үзсэн үйл ажиллагаануудыг түүвэрлэн доорх хүснэгтэд танилцуулж байна. Төслийн агуулга, хариуцагч байгууллага, хамтран оролцогчид, хэрэгжүүлэх хугацаа, хэрэгжилтийн байдал, шаардлагатай төсөв гэх мэт зүйлийг тодорхой тусгасан бөгөөд төслийн цар хүрээ, үр нөлөөг харьцуулан дүгнэх боломжтой.

Гэхдээ, хэтэрхий олон, дараалсан төлөвлөгөөтэй мөн ТББ болон тус аймгийн аялал жуулчлалын газар нь ганцхан орон тооны ажилтантай байдаг тул үр дүнтэй хэрэгжүүлж чадах эсэх нь эргэлзээтэй. Түүнчлэн санхүүгийн эх үүсвэр ч баталгаагүй бөгөөд санхүүжигдэнэ гэсэн найдварт үндэслэл төлөвлөсөн зэрэг асуудалтай гэдгийг онцлох байна.

Хүснэгт 3-3: Өмнөговь аймгийн бүсчилсэн хөгжлийн хүрээнд хэрэгжүүлэх ажлууд
(Даланзадгад хотын хэмжээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа)

	Үйл ажиллагааны агуулга	Хариуцах байгууллага	Хамтран оролцогчид	Хэрэгжүүлэх хугацаа / Хэрэгжилтийн байдал
1	Аялал жуулчлалын мэдээллийн сүлжээ, аяллын замын зургийг гарган нийтэд түгээх	Аймгийн БОАЖГ	“Гайхамшигт Говь” АЖ Холбоо	2020-2021 он 2020 онд аймгийн төсвийн 28 сая төгрөгөөр аймгийн бүх жуулчны бааз, зарим зочид буудлуудын QR кодын мэдээллийг багтаасан Өмнөговь аймгийн аяллын замын шинэ зураг болон аймгийн аялал жуулчлалын

				танилцуулгыг Монгол, англи хэл дээр хэвлэн гаргасан.
2	Аяллын хөтөлбөрийг баяжуулж, тайлбарлагч хөтчүүдийг бэлтгэж сургах	Аймгийн БОАЖГ	“Гайхамшигт Говь” АЖ Холбоо	2020 оноос хойш 2020 онд “Зочлох үйлчилгээний мэргэшсэн сургалт”-ыг зохион байгуулж 680 хүн хамрагдсан.
3	Аймгийн Байгалийн түүхийн музейг засаж тохижуулах	Аймгийн БОАЖГ, Аймгийн музей, Боловсрол соёлын газар	Аялал жуулчлалын мэргэжлийн байгууллагууд	2020 оноос хойш Байгалийн түүхийн музейн дотоод засал, тохижилт нь одоогийн байдлаар 90 хувийн гүйцэтгэлтэй явж байна.
4	Дунд сургуулийн сурагчдад мэдлэг мэдээлэл олгох музейн сургалтын хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх	Аймгийн БОАЖГ, Боловсрол, соёлын газар	“Гайхамшигт Говь” АЖ Холбоо	2020 оноос хугацааны туршид (Ковид-19 халдвар тархсантай холбогдуулан түр хойшлуулсан)
5	Даланзадгайн цөөрмийг түшиглэн аялал жуулчлалын бүс байгуулж гар урлалын бүтээгдэхүүн борлуулах, ардын урлагийн тоглолт хийх зэрэг үйлчилгээ үзүүлэх нэгдсэн төв байгуулж ажлын байр бий болгох	Аймгийн БОАЖГ, Даланзадгад хотын ИТХ, Аймгийн ЗДТГ Далангийн 5-р баг	“Гайхамшигт Говь” АЖ Холбоо	2020-2029 он Цэцэрлэгт хүрээлэнг 3 тэрбум төгрөгөөр бүтээн байгуулахаар төлөвлөсөн.

Эх сурвалж: “Гайхамшигт Говь” АЖ Холбоо нэгтгэн боловсруулав.

Хүснэгт 3-4: Өмнөговь аймгийн бүсчилсэн хөгжлийн хүрээнд хэрэгжүүлэх ажлууд (Зүүн бүсийн нутагт хэрэгжүүлэх үйл ажиллагаа)

	Үйл ажиллагааны агуулга	Хариуцах байгууллага	Хамтран оролцогчид	Хэрэгжүүлэх хугацаа
6	Манлай сумын төвд аялал жуулчлал, байгаль орчны мэдээллийн төв, нийтийн бие засах газар бүхий үйлчилгээний төвийг бий болгох	Сумын ЗДТГ	“Гайхамшигт Говь” АЖ Холбоо	2020-2023 он
7	Ханбогд суманд Байгаль орчин аялал жуулчлалын мэдээллийн төв, нийтийн бие засах газар байгуулах	Сумын ЗДТГ	Аймгийн ЗДТГ	2020-2023 он 2022 оноос хэрэгжүүлэх БОАЖЯ-ны төсөлд хамрагдахаар батлагдсан.
8	Нутгийн иргэдэд аялал жуулчлалын иж бүрэн сургалт явуулах	“Гайхамшигт Говь” АЖ Холбоо	Сумын ЗДТГ	2020-2021 он

	Үйл ажиллагааны агуулга	Хариуцах байгууллага	Хамтран оролцогчид	Хэрэгжүүлэх хугацаа
9	Шарцав, Хүрдэт агуйн нэмэлт бүтээн байгуулалтыг дуусгах	Аймгийн БОАЖГ, МПОХ Нийгэмлэг	Сумын ЗДТГ, Мэргэжлийн байгууллага	2020 оноос хойш Шар цавын бүтээн байгуулалтад 705.5 сая төгрөг батлагдсан. Ажлын гүйцэтгэл 80 хувьтай байна.

Эх сурвалж: “Гайхамшигт Говь” АЖ Холбоо нэгтгэн боловсруулав.

“Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого 2019-2026”-н хүрээнд хэрэгжүүлэх ажлууд дараах болно.

Хүснэгт 3-5: Газар зүйн байрлал, байгаль, түүх, соёлын өвд тулгуурласан аялал жуулчлалын бүс нутгийг төрөлжүүлэн хөгжүүлж, эрүүл ахуй, үйлчилгээний чанар, стандартыг сайжруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд хийх ажлууд

	Үйл ажиллагааны агуулга	Хариуцах байгууллага	Хамтран оролцогчид	Хэрэгжүүлэх хугацаа
10	Ёлын амны орчны аялал жуулчлалын даацын судалгааг хийж, Говь Гурвансайхан БЦГ-ын Оюутын амны нэвтрэх цэгийн орчинд дахин нарийвчилсан, зохион байгуулалт, төлөвлөлт хийх	ТХГНХЗ, Аймгийн БОАЖГ	Мэргэжлийн байгууллага	2020-2026 он Ёлын ам музейн орчинд өндөр хүчдэл хүргэж цахилгаанаар хангах ажил хийгдэж дууссан.
11	Оюутын орчинд байгаа үйлчилгээний цэгүүд, музей зэргийг нэгдсэн барилга байгууламжид байрлуулж, хоол унд, нийтийн бие засах газар, үйлчилгээгээр хангах төвийг байгуулах	ТХГНХЗ, Аймгийн БОАЖГ	Орон нутгийн аж ахуйн нэгжүүд, “Гайхамшигт Говь” АЖ Холбоо	2020-2026 он Хэрэгжүүлэх төсөл батлагдсан.
12	Орон нутгийн байгаль орчны ТББ, нөхөрлөл, аж ахуйн нэгжийг өөрөө өөрийгөө санхүүжүүлэн ажиллах эрх зүйн боломжоор хангах боломж бүрдүүлэх	ТХГНХЗ, Аймгийн БОАЖГ	“Гайхамшигт Говь” АЖ Холбоо	2020-2026 ТХГ-ын тодорхой хэсгийг орон нутгийн ТББ-уудад менежментийн гэрээгээр ашиглах зөвлөмж, дүрмүүд гарсан.

Эх сурвалж: “Гайхамшигт Говь” АЖ Холбоо нэгтгэн боловсруулав.

Хүснэгт 3-6: Аялал жуулчлалын боловсрол, сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг хөгжүүлж, хүний нөөцийн ур чадварыг дээшлүүлэх, чадавхижуулах хүрээнд хийх ажлууд

	Үйл ажиллагааны агуулга	Хариуцах байгууллага	Хамтран оролцогчид	Хэрэгжүүлэх хугацаа
13	Шар цавын үлэг гүрвэлийн мөрт газарт аймгаас баталсан соёлын өвийн менежментийн төлөвлөгөөний дагуу	Палеонтологийн Хүрээлэн, Аймгийн ЗДТГ	“Гайхамшигт Говь” АЖ Холбоо	2020-2026 он Шар цавын бүтээн байгуулалтад 705.5 сая төгрөг батлагдсан. Ажлын гүйцэтгэл 80 хувьтай байна.

	Үйл ажиллагааны агуулга	Хариуцах байгууллага	Хамтран оролцогчид	Хэрэгжүүлэх хугацаа
	бүтээн байгуулалт, судалгааны ажлуудыг хийх			
14	Баянзагт аймгаас баталсан соёлын өвийн менежментийн төлөвлөгөөний дагуу бүтээн байгуулалт, судалгааны ажлуудыг хийх	Палеонтологийн Хүрээлэн, Аймгийн ЗДТГ	Мэргэжлийн байгууллага	2020-2026 он Баянзагийн эртний хүмүүсийн суурин газарт Археологийн хүрээлэнгээс судалгаа явуулж задгай музей байгуулах 25 сая төгрөгийн төслийг гаргасан.

Эх сурвалж: “Гайхамшигт Говь” АЖ Холбоо нэгтгэн боловсруулав.

Хүснэгт 3-7: Төр, шинжлэх ухаан, бизнесийн үр ашигтай хамтын ажиллагаа, харилцан уялдаатай, нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх хүрээнд хийх ажлууд

	Үйл ажиллагааны агуулга	Хариуцах байгууллага	Хамтран оролцогчид	Хэрэгжүүлэх хугацаа
15	Аймгийн ИТХ-ын тогтоолын дагуу Байгалийн түүхийн музейд түшиглэсэн Палеонтологи, геологи, түүх соёлын судалгааны төвийг байгуулах	ШУА, Аймгийн ЗДТГ	МПОХН “Гайхамшигт Говь” АЖ Холбоо	2020-2029 он Шар цавд Аймгийн ИТХ хуралдаж Судалгааны төв байгуулах Аймгийн ИТХ-ын тогтоолыг гаргасан.
16	“Баянзаг-Улалзах Цонж Хөгжлийн Төв” ТББ-ийг түүх соёлын өвийн хамгаалал, аялал жуулчлалын төв болгон тогтвортой ажиллуулах	ШУА, Булган сумын ЗДТГ	МПОХН “Гайхамшигт Говь” АЖ Холбоо	2020-2029 он
17	Аймгийн хөтөч тайлбарлагчид, жолооч нарын нэгдсэн холбоо, гишүүддээ үйлчилдэг ТББ-ыг байгуулж гэр буудал, жуулчны бааз, хөтөч тайлбарлагчид, жолооч нарын Ёс зүйн дүрмийг боловсруулан хэрэгжүүлэх	БОАЖГ, “Гайхамшигт Говь” АЖ Холбоо	Мэргэжлийн байгууллагууд	2020-оноос хойш Ёс зүйн дүрмийн төслүүдийг нэгтгэж эхэлсэн.
18	Аялал жуулчлал, үйлчилгээний салбарын ажилтан бэлтгэх, мэргэшүүлэх сургалтыг Политехникийн коллежтой хамтран хэрэгжүүлэх	Аймгийн БОАЖГ, Боловсрол соёлын газар, Политехник коллеж	Мэргэжлийн байгууллагууд	2020 оноос хойш Аймгийн Боловсрол соёлын газарт санал хүргүүлж судалж байна.
19	Хонгорын элс орчмын Хулан адуу, Хар сүүлт зээрийн тархац нутагт шинээр өвөлжөө, зуслангийн зориулалтаар газар олгохыг зогсоох	ТХГНХЗ, Аймгийн БОАЖГ, Сэврэй сумын ЗДТГ	—	2020-2026 он

	Үйл ажиллагааны агуулга	Хариуцах байгууллага	Хамтран оролцогчид	Хэрэгжүүлэх хугацаа
20	Баян бор нурууны энгэрт байршсан Хулан адууны ус уудаг жижиг булаг, бэлчээрийн орчныг нь мал, хүний хөлөөс чөлөөлөх	ТХГНХЗ, Аймгийн БОАЖГ	Сумын ЗДТГ	2020-2026 он
21	Хонгорын элсний аялал жуулчлалын бүсэд байгаа гэр буудлуудыг нүүлгэн шилжүүлэх	ТХГНХЗ, Аймгийн БОАЖГ	Сумын ЗДТГ	2020-2026 он Сэврэй сум, Хамгаалалтын захиргаа, орон нутгийн иргэд нэгдсэн шийдэлд хүрсэн.
22	Хонгорын элсний Адаг нуураас цааш автомашинтай аялахыг хязгаарлах	ТХГНХЗ, Аймгийн БОАЖГ	Сумын ЗДТГ	2020-2026 он
23	Цахиуртын хөндийн чулуун зэвсгийн дархны газрын бүрэн судалгааг гадаад, дотоодын мэргэжлийн байгууллагын оролцоонд түшиглэн хэрэгжүүлж, байнгын хамгаалалтад авах	ТХГНХЗ, Аймгийн БОАЖГ, Мэргэжлийн байгууллага	Сумын ЗДТГ	2020-2026 он

Эх сурвалж: “Гайхамшигт Говь” АЖ Холбоо нэгтгэн боловсруулав.

Хүснэгт 3-8: Дорнод, Өмнөговь, Өвөрхангай, Хөвсгөл, Увс, Ховд аймгуудын нисэх онгоцны буудлыг олон улсын нисэх буудал болгон хөгжүүлж, орон нутгийн нисэх буудлуудын хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд хийх ажлууд

	Үйл ажиллагааны агуулга	Хариуцах байгууллага	Хамтран оролцогчид	Хэрэгжүүлэх хугацаа
24	Гурван сайхан нисэх буудлыг 4С ангиллын олон улсын нисэх буудал болгож дэлхийн бусад орнуудад шууд нислэг үйлдэх боломжийг бүрдүүлэх	БОАЖЯ, ИНЕГ, Аймгийн ЗДТГ	Донор байгууллага	2020-2026 он

Эх сурвалж: “Гайхамшигт Говь” АЖ Холбоо нэгтгэн боловсруулав.

Хүснэгт 3-9: Аялал жуулчлалын гол чиглэл дагуу төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд үйлчилгээний цогцолбор бүхий түр буудаллах цэгүүдийг байгуулах зорилтын хүрээнд хийх ажлууд

	Үйл ажиллагааны агуулга	Хариуцах байгууллага	Хамтран оролцогчид	Хэрэгжүүлэх хугацаа
25	Аймгийн бүх сумдад нийтийн бие засах газрыг байгуулж, зочид буудлуудын чанар, хангамж, үйлчилгээг сайжруулах	Аймгийн ИТХ, Аймгийн ЗДТГ	Аймгийн аж ахуйн нэгжүүд	2020-2029 он Булган суманд орон нутгийн төсвийн хөрөнгөөр, Баяндалай суманд улсын төсвийн хөрөнгөөр хийхээр төлөвлөгдсөн

Эх сурвалж: “Гайхамшигт Говь” АЖ Холбоо нэгтгэн боловсруулав.

Хүснэгт 3-10: Явган аяллын гол чиглэл болон тусгай хамгаалалттай газар нутгийн аяллын зам, жимийг тохижуулах, мэдээллийн самбар, тэмдэг, тэмдэглэгээнүүдийг байршуулах зорилтын хүрээнд хийх ажлууд

	Үйл ажиллагааны агуулга	Хариуцах байгууллага	Хамтран оролцогчид	Хэрэгжүүлэх хугацаа
26	Зүүн сайхан ууланд явган аяллын жим байгуулах, тэмдэгжүүлэх	Аймгийн БОАЖГ, Сумдын ЗДТГ	Аймгийн аж ахуйн нэгжүүд	2020-2029 он
27	Зөөлөнгийн Нуруунд явган аяллын жим байгуулах, тэмдэгжүүлэх	Аймгийн БОАЖГ, Сумдын ЗДТГ	Аймгийн аж ахуйн нэгжүүд	2020-2029 он
28	Тусгай хамгаалалттай газруудад нэвтрэх хэсэгт нэгдсэн тэмдэг, тэмдэглэгээг хийх	Аймгийн БОАЖГ, Сумдын ЗДТГ	Аймгийн аж ахуйн нэгжүүд	2020-2029 он
29	Тусгай хамгаалалттай газрууд дахь ховор чухал биологийн төрөл зүйлүүдийн мэдээллийн санг нэмэгдүүлэх	Аймгийн БОАЖГ, Сумдын ЗДТГ	Аймгийн аж ахуйн нэгжүүд	2020-2029 он “Жаргалант” Олон улсын Говь судлалын төвд гадаад, дотоодын судлаач эрдэмтдийн ажиллах, амьдрах орчныг бүрдүүлснээр судалгааны фонд үүсгэх.

Эх сурвалж: “Гайхамшигт Говь” АЖ Холбоо нэгтгэн боловсруулав.

Хүснэгт 3-11: Жуулчид голлон зорих байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад отоглох цэгүүдийг байгуулах зорилтын хүрээнд хийх ажлууд

	Үйл ажиллагааны агуулга	Хариуцах байгууллага	Хамтран оролцогчид	Хэрэгжүүлэх хугацаа
30	Хонгорын голд Дуут манхан, Сэрүүн булагт отоглох нэгдсэн цэгийг байгуулах	Аймгийн БОАЖГ, ТХГНХЗ	“Гайхамшигт Говь” АЖ Холбоо	2020-2029 он Хонгорын элсний аялал жуулчлалын төлөвлөгөөний хүрээнд нийтийн бие засах газрыг байгуулсан. 2021 онд отоглох нэгдсэн цэгийг байгуулах төлөвлөгөөтэй байна.
31	Баянзагт отоглох цэг байгуулах	Аймгийн БОАЖГ, ТХГНХЗ	“Гайхамшигт Говь” АЖ Холбоо	2020-2026 он Баянзагийн хамгаалалтын захиргаа өөрийн хөрөнгөөр 2021 онд шийдэх төлөвлөгөөтэй байна.
32	Ёлын аманд хонож, отоглох цэг байгуулах	Аймгийн БОАЖГ, ТХГНХЗ	“Гайхамшигт Говь” АЖ Холбоо	2020-2026 он

Эх сурвалж: “Гайхамшигт Говь” АЖ Холбоо нэгтгэн боловсруулав.

Хүснэгт 3-12: Жуулчдад шаардлагатай мэдээллээр хангах мэдээллийн төв, цэгүүдийг Монгол улсад нэвтрэх боомтуудад байрлуулах зорилтын хүрээнд хийх ажлууд

	Үйл ажиллагааны агуулга	Хариуцах байгууллага	Хамтран оролцогчид	Хэрэгжүүлэх хугацаа
33	Гашуун сухайт, Шивээ хүрэнгийн боомтуудад Аялал жуулчлалын мэдээллийн төв байгуулах	Аймгийн БОАЖГ	Аялал жуулчлалын мэргэжлийн байгууллагууд	2020-2029 он
34	Аялал жуулчлалын гол газруудын зочид буудал, гэр буудал, кофе шоп, үйлчилгээний газруудыг аялал жуулчлалын мэдээллийн төв болгон ашиглах	Аймгийн БОАЖГ Аялал жуулчлалын мэргэжлийн байгууллагууд	Сумдын ЗДТГ	2020-2029 он Баяндалай, Булган сумдад 2021 оноос хэрэгжинэ.

Эх сурвалж: “Гайхамшигт Говь” АЖ Холбоо нэгтгэн боловсруулав.

Хүснэгт 3-13: Аялал жуулчлалын гол бүс нутгуудад байгаль орчинд ээлтэй технологиор хатуу хог хаягдлыг дарж булшлах, шингэн хог хаягдлыг нөөцлөх зориулалтын цэгүүдийг байгуулах зорилтын хүрээнд хийх ажлууд

	Үйл ажиллагааны агуулга	Хариуцах байгууллага	Хамтран оролцогчид	Хэрэгжүүлэх хугацаа
35	Аймгийн төвд хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр барьж, ашиглалтад оруулах	Аймгийн ЗДТГ, Сумын ЗДТГ	Аймгийн аж ахуйн нэгжүүд	2020-2026 он
36	Сумын төвүүдийн нэгдсэн хогийн цэгийг сайжруулах, сумын орох гарах замд хогийн цэгийн байршлыг заасан тэмдгийг байрлуулах, хог хаягдлын сангийн дансыг байршуулах	Аймгийн ЗДТГ, Сумын ЗДТГ Аялал жуулчлалын мэргэжлийн байгууллагууд	Аймгийн аж ахуйн нэгжүүд	2020-2029 он

Эх сурвалж: “Гайхамшигт Говь” АЖ Холбоо нэгтгэн боловсруулав.

Хүснэгт 3-14: Олон улсын үзэсгэлэнд Монгол улсыг сурталчлахад төр, хувийн хэвшлийн түншлэл, салбар дундын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд хийх ажлууд

	Үйл ажиллагааны агуулга	Хариуцах байгууллага	Хамтран оролцогчид	Хэрэгжүүлэх хугацаа
37	Нийслэл УБ хотод болдог ITM, Ulaanbaatar Travel Экро-д жил бүр тогтмол оролцох	Аймгийн БОАЖГ	“Гайхамшигт Говь” АЖ Холбоо	2020-2026 он 2021 оны аймгийн төсөвт үзэсгэлэнд оролцох, эвент арга хэмжээ зохион байгуулахад зориулж 5 сая төгрөг батлагдсан.
38	Хойд Америк, Европ, Ази тивд болдог үзэсгэлэнгүүдэд жилд нэг удаа оролцож байх	Аймгийн БОАЖГ	“Гайхамшигт Говь” АЖ Холбоо	2020-2026 он (Ковид-19 халдвар тархсантай холбогдуулан түр зогссон)

Эх сурвалж: “Гайхамшигт Говь” АЖ Холбоо нэгтгэн боловсруулав.

Хүснэгт 3-15: Хөрш орнуудтай хамтран аялал болон хил дамнасан аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх зорилтын хүрээнд хийх ажлууд

	Үйл ажиллагааны агуулга	Хариуцах байгууллага	Хамтран оролцогчид	Хэрэгжүүлэх хугацаа
39	Баруун, Зүүн бүсийн хил орчмын болон хил дамнасан 1-3 өдрийн тусгайлсан аяллын хөтөлбөр гаргах	“Гайхамшигт Говь” АЖ Холбоо	Аялал жуулчлалын компаниуд	2020-2029 он

Эх сурвалж: “Гайхамшигт Говь” АЖ Холбоо нэгтгэн боловсруулав.

Хүснэгт 3-16: Торгоны зам, Цайны зам, Их Түмэн голын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөтөлбөрийн гишүүн улс орнуудтай хамтран хөгжүүлэх зорилтын хүрээнд хийх ажлууд

	Үйл ажиллагааны агуулга	Хариуцах байгууллага	Хамтран оролцогчид	Хэрэгжүүлэх хугацаа
40	Аймгийн Байгалийн түүхийн музейд Цайны замын талаар үзэсгэлэн гаргах	Аймгийн БОАЖГ Байгалийн түүхийн музей	“Гайхамшигт Говь” АЖ Холбоо	2020-2029 он

Эх сурвалж: “Гайхамшигт Говь” АЖ Холбоо нэгтгэн боловсруулав.

Хүснэгт 3-17: Говийн бүсэд байгалийн, палеонтологи, геологи, геофизикийн аялал жуулчлалыг түлхүү хөгжүүлэх чиглэлээр аялал жуулчлалын нөөц, даацын судалгаа хийж, аялал жуулчлалын бүтээгдэхүүний хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох зорилтын хүрээнд хийх ажлууд

	Үйл ажиллагааны агуулга	Хариуцах байгууллага	Хамтран оролцогчид	Хэрэгжүүлэх хугацаа
41	Шарцав, Баянзаг, Нэмэгт, Хэрмэн цавын олдворт газруудыг ЮНЕСКО-гийн Гео-паркуудад бүртгүүлэх	Аймгийн ИТХ ШУА-н Палеонтологийн Хүрээлэн	Аймгийн ЗДТГ	2020-2029 он Баянзагийг бүртгүүлэх эхний бэлтгэл ажлууд хийгдсэн.

Эх сурвалж: “Гайхамшигт Говь” АЖ Холбоо нэгтгэн боловсруулав.

Хүснэгт 3-18: Байгалийн унаган төрхийг хадгалах, хамгаалах чиглэлээр тогтвортой аялал жуулчлалын бүсүүдийг тогтоож, хөгжүүлэх зорилтын хүрээнд хийх ажлууд

	Үйл ажиллагааны агуулга	Хариуцах байгууллага	Хамтран оролцогчид	Хэрэгжүүлэх хугацаа
42	Өмнөговь аймгийн экологийн хувьд чухал бүс нутгуудад шинжлэх ухааны нарийвчилсан судалгааг явуулж аялал жуулчлалын зориулалтаар хамгаалалтад бүрэн авах	Аймгийн ИТХ, Аймгийн ЗДТГ, Сумын ИТХ, Сумын ЗДТГ	Мэргэжлийн байгууллагууд	2020-2025 он

Эх сурвалж: “Гайхамшигт Говь” АЖ Холбоо нэгтгэн боловсруулав.

Хүснэгт 3-19: Өмнөговь аймагт палеонтологийн аялал жуулчлалын үндэсний хүрээлэн байгуулах зорилтын хүрээнд хийх ажлууд

	Үйл ажиллагааны агуулга	Хариуцах байгууллага	Хамтран оролцогчид	Хэрэгжүүлэх хугацаа
43	Шар Цавын Соёлын Өвийн Менежментийн Төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлэх	МПОХН	“Гайхамшигт Говь” АЖ Холбоо	2020-2026 он Шар цавын бүтээн байгуулалтад 705.5 сая төгрөг батлагдаж ажлын гүйцэтгэл 80 хувьтай байна.

	Үйл ажиллагааны агуулга	Хариуцах байгууллага	Хамтран оролцогчид	Хэрэгжүүлэх хугацаа
44	Баянзагийн Соёлын Өвийн Менежментийн Төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлэх	“Баянзаг-Улалзах Цонж Хөгжлийн Төв” ТББ	Мэргэжлийн байгууллагууд	2020-2029 он Баянзагийн хамгаалалтын захиргаа өөрөө өөрийгөө санхүүжүүлэн ажиллах тогтолцоог бүрдүүлсэн. Ковид-19 намжиж аялал жуулчлал өргөжсөнөөр төслийг өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлнэ.

Эх сурвалж: “Гайхамшигт Говь” АЖ Холбоо нэгтгэн боловсруулав.

Хүснэгт 3-20: Хил орчмын аялал жуулчлалын хөгжлийг эрчимжүүлэх зорилтын хүрээнд хийх ажлууд

Эх сурвалж: “Гайхамшигт Говь” АЖ Холбоо нэгтгэн боловсруулав.

	Үйл ажиллагааны агуулга	Хариуцах байгууллага	Хамтран оролцогчид	Хэрэгжүүлэх хугацаа
45	Орвог гашууны бор толгойд хүүхэд залуучуудын эх оронч үзлийг дэмжих, хэрэгжүүлэх аяллыг тогтмол зохион байгуулах (Жил бүрийн 12-р анги төгсөгчдийн аяллыг нэгдсэн журмаар зохион байгуулдаг болно).	Хил Хамгаалах Ерөнхий Газар, Аймгийн ЗДТГ, Сумын ЗДТГ	“Гайхамшигт Говь” АЖ Холбоо	2020-2026 он 2021 оноос төгсөх ангийн сурагчдад төрөлх нутагтайгаа танилцах аяллын хөтөлбөрийг баталсан.

Хүснэгт 3-21: Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжлийг бодлогоор дэмжиж, аялал жуулчлалд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилтын хүрээнд хийх ажлууд

	Үйл ажиллагааны агуулга	Хариуцах байгууллага	Хамтран оролцогчид	Хэрэгжүүлэх хугацаа
46	Аялал жуулчлалын гол бүс нутгууд дахь нөхөрлөлүүдийг чадавхижуулах, ТХГ-ын зарим хэсгийг менежментийн гэрээгээр хариуцуулан ажиллуулах	Аймгийн БОАЖГ, ТХГНХЗ	Нутгийн иргэд	2020-2029 Германы GIZ байгууллагын Spice төслийн хүрээнд хэрэгжүүлэх боломжийг судалж байгаа.
47	Нутгийн иргэдэд гар урлал, хөтөч тайлбарлагч, үйлчилгээний сургалтыг тогтмол зохион байгуулах, нэгдсэн зохион байгуулалтад оруулах, Ёс зүйн дүрэмтэй болгох	“Гайхамшигт Говь” АЖ Холбоо	Нутгийн иргэд	2020-2029 он Ковид-19 намжиж, хол хорио дуусахаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Эх сурвалж: “Гайхамшигт Говь” АЖ Холбоо нэгтгэн боловсруулав.

Хүснэгт 3-22: Аялал жуулчлалын зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгааг тогтмол хийж, аялал жуулчлалын сургалт, судалгаа, үйлдвэрлэлд ашиглах боломжийг бүрдүүлэх зорилтын хүрээнд хийх ажлууд

	Үйл ажиллагааны агуулга	Хариуцах байгууллага	Хамтран оролцогчид	Хэрэгжүүлэх хугацаа
48	Аймгийн аялал жуулчлал эрхлэгч иргэдэд зочлох үйлчилгээний сургалтыг зохион байгуулах, мэргэшүүлэх, ажлын байраар хангах	Аймгийн БОАЖГ, “Гайхамшигт Говь” АЖ Холбоо	Орон нутгийн гэр бааз, Аялал жуулчлалын компаниуд	2020-2029 он БОАЖЯ-аас таван жилийн хугацаатайгаар “Зочлох үйлчилгээний төрөлжсөн сургалт”-ыг зохион байгуулах төлөвлөгөө батлагдсан.

Эх сурвалж: “Гайхамшигт Говь” АЖ Холбоо нэгтгэн боловсруулав.


3.1.3 Аялал жуулчлалын салбарын холбогдох байгууллагууд

(1) “Баянзаг- Улалзах Цонж Хөгжлийн Төв” ТББ

Олон улсын байгууллагуудын дэмжлэгтэй, нутгийн иргэдийн оролцоотой шинэ хэлбэрийн ТББ-ыг байгуулж, байгалийн цогцолборт газар, аялал жуулчлалын алдартай газруудын хамгаалалтын захиргаа, менежментийн үүргийг гүйцэтгүүлдэг. Ийм шинэлэг аргаар зэрлэг адуу-Тахийг сэргээн нутагшуулж хамгаалдаг “Хустайн цогцолбор газар”, Дорноговийн “Их нартын Байгалийн нөөц газар” ажиллаж байна (Хүснэгт 3-19, дугаар 44). Улс, аймаг, сум, ТББ гэсэн төр, хувийн хэвшил харилцан уялдаатай ажиллаж, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх гэсэн энэхүү оролдлого нь өөрөө өөрийгөө удирдах шинэ, шилдэг жишиг арга болж байна. Үйл ажиллагааны үндсэн механизм нь, аялал жуулчлалын газруудын хамгаалалтын захиргаа, менежментийн үүргийг гүйцэтгэж буй ТББ-т тус газарт нэвтрэх хураамжийг хураах эрхийг олгохын зэрэгцээ тухайн газрыг арчилж хамгаалах, ажилчдын цалинг олгох үүргийг хүлээлгэдэг. ТББ нь татвараас чөлөөлөгддөг тул улсад татвар төлдөггүй. “Баянзаг- Улалзах Цонж Хөгжлийн Төв” ТББ-ын тухайд 5 жилийн дараа санхүүгийн хүчин чадлаа бүрэн бэхжүүлж, нутгийн иргэдээс ирүүлсэн Байгаль хамгаалал, Боловсрол, Эрүүл мэндийн чиглэлийн төслүүдэд нийт орлогынхоо 30 хүртэл хувиар хүүгүй зээл олгох үүрэгтэйгээр ажиллаж байна.



Өмнөговь аймгийн төсвийн хөрөнгөөр 2018-2020 онд хийсэн бүтээн байгуулалт





Мэдээллийн танхим доторх мэдээллүүд



Эх сурвалж: “Баянзаг- Уулзах Цонж Хөгжлийн Төв” ТББ

Зураг 3-3: “Баянзаг - Уулзах Цонж Хөгжлийн Төв” ТББ-ын танилцуулга

(2) “Гайхамшигт Говь” АЖ Холбоо ТББ

2006 онд байгуулагдсан “Гайхамшигт Говь” АЖ холбоо ТББ нь, аялал жуулчлалын салбарын төрөл бүрийн ажил үүрэг гүйцэтгэдэг гишүүдээс бүрдсэн, энэ салбарт аймагтаа цорын ганц ТББ юм. Тус байгууллагын гишүүн байгууллага болон иргэдийг жагсаавал 26 жуулчны бааз, 14 зочид буудал, 45 дэн буудал, 61 гэр буудал, 58 морь, тэмээ унуулж үйлчилдэг иргэн, 58 хөтөч, тайлбарлагч, 60 жолооч байна. Байгууллагын гишүүнчлэлийн хураамж 250,000 төгрөг байдаг. Жил бүр Өмнөговийн ЗДТГ -аас олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, тэмээний баярыг зохион байгуулахад тус бүр таван сая төгрөгийн татаас олгодог. Үлэг гүрвэлийн чулуужсан олдворт газар, элсэн манхан, ам газруудын байгаль, түүх соёлын олдворт газруудын менежментийн төлөвлөгөө, гэр буудлуудын дагаж мөрдөх журмыг боловсруулах зэрэг ажлуудад оролцдог. “Говь Гурвансайхан” БЦГ-ын хамгаалалтын захиргаатай хамтран ажиллаж, байгаль хамгаалагч, орон нутгийн иргэдэд мэргэжлийн сургалт, сурталчилгаа тогтмол явуулж байна. Мөн “Говь Гурвансайхан” БЦГ-т үйл ажиллагаа явуулдаг гэр буудал, нөхөрлөлүүдэд байгаль орчин, аялал жуулчлалын үйлчилгээний сургалтыг захиалгаар зохион байгуулдаг. Түүнчлэн 2015 оноос хойш Японы Чива мужийн Абики хотод төвтэй “Абики зэрлэг шувуу хамгаалах нийгэмлэг” тэй байнгын харилцаатай хамтран ажиллаж, Абики хотын шувууны баярт 5 жил дараалан оролцжээ.

3.1.4 Аялал жуулчлалын салбарын татварын орлого

Аялал жуулчлалтай холбоотой татварын орлогын хэмжээг тооцоолоход хэцүү байдаг. Тооцоолох боломжгүй шалтгааны нэг нь өнөөгийн аялал жуулчлалын татварын системийн асуудал байдаг. Жуулчны татвар гэж байдаггүй тул аялал жуулчлалын компаниуд орлогын албан татвараас гадна газар ашигласны төлбөр, зөвшөөрлийн хураамжийг харьяа орон нутагт тушаадаг. Байгалийн Цогцолборт газар, тусгай хамгаалалттай газрын газар ашиглалтын төлбөр, зөвшөөрлийн хураамжийг тухайн байрлаж байгаа орон нутгийн засаг захиргаа хураан төвлөрүүлж, улсын төсөвт оруулдаг. Өмнөговь аймгийн аялал жуулчлалтай холбоотой татварын орлого (тооцоолох боломжтой) дараах байдалтай байна.

(1) Жуулчны баазуудад ногдуулах татвар

Өмнөговь аймагт үйл ажиллагаа явуулж буй 26 жуулчны баазаас 22 нь аймагтаа, үлдсэн 4 нь Улаанбаатар хотод аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлдөг. Жуулчны баазуудын аж ахуйн нэгжийн орлогын албан татвар нь улсын болон орон нутгийн засаг захиргааны төсвийн эх үүсвэр болдог.

Монголын аялал жуулчлалын тэргүүлэгч компаниудын нэг болох “Жуулчин говь” ХХК -ийн 2019 онд төлсөн татварын хэмжээг дараах хүснэгтэд харуулав. Үүгээр тус компанийн жуулчны баазын төлсөн татварын хэмжээг мэдэж болно.

Хүснэгт 3-23: "Жуулчин Говь" ХХК -ийн 2019 онд төлсөн татварын хэмжээ

No	Татварын төрөл	Дүн (төг)
1	Нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ)	19,031,871.93
2	Хувь хүний орлогын албан татвар	2,549,121.16
3	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	3,247,478.89
4	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	741,600.00
5	Газар ашигласны төлбөр	4,500,000.00
6	Нийгмийн даатгалын шимтгэл (Улаанбаатар хот Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс)	2,267,718.00
7	Нийгмийн даатгалын шимтгэл (Өмнөговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс)	975,600.00
8	Ус ашигласны төлбөр	1,350,000.00
	Нийт:	34,663,389.98

Эх сурвалж: "Жуулчин Говь" ХХК -ийн Жуулчны бааз 2021

(2) Тусгай хамгаалалттай газар нутагт нэвтрэх хураамж

Өмнөговь аймаг нь Говь Гурвансайхан БЦГ, Говийн Бага ДЦГ, Тост, Тосон бумбын нурууны БНГ гэсэн гурван улсын тусгай хамгаалалттай газар нутагтай. Эдгээр тусгай хамгаалалттай газар нутагт нэвтрэх хураамж болгож гадаадын жуулчдаас 1 хүний 3,000 төгрөг (1.09 ам.доллар), дотоодын жуулчдаас 300 төгрөг (0.11 ам.доллар) -ийг тухайн газрын байгаль хамгаалах ажилтнууд хураан авч тасалбар олгодог. Хураамжийн орлогыг БОАЖЯ-нд тушаадаг. Тусгай хамгаалалттай газар нутгууд энэ хураамжийн орлогыг ашиглах эрхгүй байдаг.


(3) Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт нэвтрэх хураамж

2019 оны 2-р сарын 27-ны өдөр "Баянзаг-Улалзах Цонж Хөгжлийн төв" ТББ (бүртгэлийн дугаар: 8305668) нь үлэг гүрвэлийн чулуужсан олдворын газар болох Баянзагт байгуулагдаж, Баянзагийн хамгаалалтын менежментийг хариуцаж ажиллах болсон. Уг ТББ нь Баянзагт аялаж зочилж байгаа гадаадын жуулчдаас нэг хүний 10,000 төгрөг (3.64 ам.доллар), дотоодын жуулчдаас 3,000 төгрөг (1.09 ам.доллар)-ийг хурааж ажилладаг. Хураамжийг байгууллагын санхүүжилтэд зарцуулдаг бөгөөд Баянзагийн хамгаалалт, байгууламжийн засвар үйлчилгээ, ажилчдын цалинд зарцуулдаг байна.

3.1.5 Дэд бүтцийн байдал

(1) Нисэх онгоцны буудал, нислэг

Дотоодын нислэгийг ихэвчлэн баруун зүгийн аймгууд руу хийдэг ба нийт 9 аймаг руу нийслэлээс тогтмол нислэгтэй. Энэ удаагийн судалгаанд хамрагдсан бүс нутгуудаас зөвхөн Өмнөговь аймаг руу л тогтмол нислэгтэй байдаг.



Эх сурвалж: Судалгааны баг

Зураг 3-4: Дотоодын нислэгийн маршрут (2019)


Өмнөговь аймгийн Даланзадгад хот руу Аэро Монголиа, Хүннү Эйр компаниуд тогтмол нислэг хийдэг. Гэвч Ковид-19 цар тахлын үеийн хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн улмаас агаарын тээврийн компаниудын нислэгийн нөхцөл байдлын сүүлийн үеийн болон хэтийн төлөвийн талаар тодорхой мэдээлэл авахад хүндрэлтэй байгаа болно.

Хүснэгт 3-24: Өмнөговь аймгийн Даланзадгад хот руу хийх нислэгийн мэдээлэл (2019 оны байдлаар)

Нислэгийн чиглэл	Нисэх Цаг	Агаарын тээвэрлэгч	Нислэгийн тоо		Зуны үнэ (төг)	Өвлийн үнэ (төг)
			Зун	Өвөл		
Даланзадгад (Өмнөговь)	1цаг 30 минут	Aero Mongolia	Өдөр бүр	Долоо хоногт 1-2 удаа	300,000	250,000
		Hunnu Air	Өдөр бүр	Долоо хоногт 1 удаа	605,200	200,000

Эх сурвалж: Интернэтийн мэдээлэлд үндэслэн судалгааны баг боловсруулав.

2019 онд Өмнөговь аймаг руу зорчигсдын тоог доорх хүснэгтэд харуулж байна. Үүнд Оюу Толгойн уурхай руу хийгддэг захиалгат нислэгээр зорчигсод мөн багтсан болно. Өмнөговь аймаг руу нисдэг дөрвөн чиглэлээс Улаанбаатар-Оюу Толгой, Улаанбаатар-Оюу Толгой-Даланзадгад, Улаанбаатар-Овоот гэсэн гурван чиглэл нь зөвхөн Оюу Толгойн уурхайн ажилчдад зориулсан захиалгат нислэг бөгөөд эдгээр чиглэлийн нислэг нь нийт дотоодын нислэгийн дийлэнх буюу 73% -ийг эзэлж байна (2019: Иргэний нисэхийн ерөнхий газрын статистик мэдээлэл). Өмнөговь аймаг руу нисэж буй зорчигчдын тоог сар тус бүрээр харахад жилийн турш хэлбэлзэл бага, мөн дийлэнх зорчигчид уул уурхайд хамаарах хүмүүс байдгаас харахад Өмнөговь аймгийн аялалд онгоц маш бага хэрэглэгддэг гэж хэлж болохоор байна.



Эх сурвалж: Монгол Улсын Үндэсний Статистикийн Хорооноос гаргасан мэдээлэлд үндэслэн судалгааны баг боловсруулав.

Зураг 3-5: Судалгааны зорилтот бүс нутаг болох Өмнөговь аймаг руу дотоод нислэгээр зорчигчдын тоо (2019 он)

(2) Зам / Тээвэр

1) Дундговь аймаг

Улаанбаатараас Даланзадгад хүрэх гол авто замаас Дэлгэрцогт, Хулд, Сайнцагаан, Луус зэрэг сум хүртэлх авто зам хатуу хучилттай. Харин бусад сум, аялал жуулчлалын газрууд хүрэх зам нь шороон зам байдаг.


2) Өмнөговь аймаг

Өмнөговь аймгийн төв, баруун, зүүн бүсийн гол сумдаар дайрдаг авто замуудыг хатуу хучилттай авто зам болгож хөгжүүлсэн. Гэвч өргөн уудам газар нутагтай, аялал жуулчлалын газрууд нь хоорондоо их хол зайтай байдаг тул тэр бүх чиглэлийг хатуу хучилттай замаар холбох төлөвлөгөө одоогоор байхгүй байна.

Өмнөговь аймаг нь, аймгийнхаа төсвөөр барьсан баруун бүсийн хатуу хучилттай авто замын засвар үйлчилгээнд зарцуулах зорилгоор зам ашиглалтын төлбөр хураах механизмыг бүрдүүлж,

замын төлбөр хураах цэг байгуулсан. Цаашид ашиглалтын хураамжаа санхүүгийн эх үүсвэр болгож замаа тогтмол сайжруулах төлөвлөгөөтэй байгаа ч аялал жуулчлалын гол чиглэлүүдтэй шууд холбогддог хатуу хучилттай зам байхгүй хэвээр байна.

Улаанбаатар хотоос Өмнөговь аймгийн Даланзадгад хот хүртэлх гол зам болон Даланзадгад хотоос цааш Гурвантэс чиглэл, Баяндалайг өнгөрөх хүртэлх 80 км орчим замыг хатуу хучилттай болгосон. Үүнээс гадна, БНХАУ хүртэлх уул уурхайн зам болох Таван толгойн нүүрсний уурхайгаас Гашуун сухайт чиглэл болон Овоот толгой нүүрсний уурхайгаас Нарийн сухайт чиглэл, Оюу Толгойн орд болон Ханбогд сум хүртэл тус тус хатуу хучилттай. Бусад замууд нь шороон зам байдаг. Цаашид бусад замуудыг хатуу хучилттай болгохын тулд "Өмнөговь аймгийн Бүсчилсэн хөгжлийн хөтөлбөр 2010-2021"-нд үндэслэн аймгийн нутаг дэвсгэрийг төв, баруун, зүүн бүс болгон хувааж хөгжүүлэхээр төлөвлөж байна.



Эх сурвалж: Өмнөговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар

Зураг 3-б: Аялал жуулчлалын гол чиглэлүүдийн авто замын зураг (хатуу хучилттай болон шороон зам) 2020 он

<Төвийн бүс нутаг>

Даланзадгад хот-Мандалговь хот-Улаанбаатар хотыг холбосон 585 км авто зам нь хатуу хучилттай. Энэхүү хатуу хучилттай замаас шороон замаар салж яваад Дундговийн Сүм хөх бүрд, Их газрын чулуу, Бага газрын чулуу, Цагаан Суварга, Дэл уулын хадны зураг зэрэг аялал жуулчлалын газруудаар тойрон аялаад ойр орчмын жуулчны баазад хонох боломжтой юм.

Энэхүү хатуу хучилттай зам нь Мандалговь хотыг дайран өнгөрдөг тул замдаа Мандалговь хотод буудаллан амарч, алжаал тайлж хонож болно. Мөн түүнчлэн Өмнөговь аймгийн Цогт-Овоо сумаар ч энэ авто зам нь дайрдаг. Цогт-Овоо суманд тэмээний сүүн бүтээгдэхүүн болон бусад хэрэгцээ, шаардлагатай зүйлсийг худалдаж авах боломжтой бөгөөд нийтийн бие засах газар ч суурилуулсан байдаг.

Ойрын жилүүдэд (2021-2025) , Өмнөговь аймгийн төвийн бүсийн аялал жуулчлалын гол цэг болох Баянзаг руу хатуу хучилттай авто зам тавих төлөвлөгөөтэй байна. Цаашлаад Булган сум-Мандал-овоо сум-Дундговь аймгийн Сайхан-Овоо сум хооронд хатуу хучилттай авто замыг тавьж, Улаанбаатар хот-Өвөрхангай аймаг хоорондох төв замтай холбохоор үе шаттайгаар төлөвлөж байна. Ингэснээр Хангайн бүс, Хархориноос говийн бүсийг зорьж ирэх жуулчдын тоо нэмэгдэнэ гэж үзэж байна.

<Баруун бүс нутаг>

Өмнөговь аймаг нь, хамгийн их аялал жуулчлал хөгжсөн баруун бүс нутаг болох Гурвантэс сум болон Даланзадгад хотыг холбосон 316 км авто замыг сайжруулах төслийг аймгийн төсвийн хөрөнгөөр эхлүүлж, 2012-2016 оны хооронд 80 км замыг нь хатуу хучилттай болгож тохижуулжээ.

Үүний үр дүнд энэ авто зам дайрч өнгөрдөг Баяндалай суманд зочид буудал, зоогийн газар болон бусад үйлчилгээний газрууд нээгджээ. Гэвч, энэхүү төслийн хэрэгжилт нь 2016-2020 онуудад удааширч, 4 жилийн хугацаанд ердөө 20 км авто замыг л хатуу хучилттай болгож чадсан байна. Авто замыг сайжруулах энэхүү төслийн зам засварын ажлыг 2020-2024 он гэхэд дуусгахаар төлөвлөж байгаа бөгөөд 2021 оны төсөвт 30 км авто замыг хатуу хучилттай болгох зардлыг тусгасан байна. Энэхүү төсөл бүрэн хэрэгжиж чадвал Даланзадгад хот-Баяндалай сум-Ноён сум-Сэврэй сум-Дунд голын давсны үйлдвэр-Гурвантэс сум нь бүгд хатуу хучилттай замаар холбогдох юм. Үүний үр дүнд Өмнөговь аймгийн аялал жуулчлалын гол цэг болох Хонгорын элс, Ноён Богд уул, Толь Хад, Сэврэйн хадны зураг, Салхитын хөндийн хадны зураг, Ганжуур Данжуур цохио, Ухаа Толгод, Нэмэгт, Тост, Тосон Бумбын нуруу, Хөвд, Хуршуутын гол, Хэрмэн Цав, Зуун мод, Зулганай, Наран даац, Бүгийн цав, Ногоонцав гэх мэт газарлуу зорчих зам сайжирч, аялал жуулчлалын цэг, үлэг гүрвэлийн олдворт газар зэргийг нөөц болгон ашигласан аялал жуулчлалыг хөгжүүлэх асар их боломжийг бий болгоно.

Мөн хилийн Шивээхүрэн боомт руу очиход ч хялбар болох тул БНХАУ- руу аялж зочлоход болон хил орчмын бүс нутгийн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд ч сайнаар нөлөөлнө.

Төлөвлөж буй энэхүү авто зам ашиглалтад орвол хөрш зэргэлдээх Баянхонгор аймгийн Эхийн гол, мөн Хавтгай, Мазаалай зэрэг ховор амьтдын өлгий нутаг болох Сэгс цагаан богд болон Алтай нутгаас говийг зорих замыг ч хялбар болгох юм. Үүний үр дүнд Баянхонгор аймаг, Говь-Алтай аймаг, Өвөрхангай аймгаар дамжсан аялал жуулчлалыг хөгжүүлэхэд ихээхэн түлхэц болох боломжтой.

<Зүүн бүс нутаг>

Тус аймгийн зүүн бүс нутагт дэлхийн томоохон ордын нэг болох Таван Толгойн нүүрсний уурхай, Оюу Толгойн зэс-алтын орд байдаг бөгөөд экспорт, тээвэрлэлтийн зориулалтаар Таван толгойн нүүрсний уурхайгаас Гашуун сухайтын хилийн боомт хүртэл нийт 200 км хатуу хучилттай авто замыг тавьсан байна.

Даланзадгад хот-Цогтцэций сум хоорондох 59.6 км хатуу хучилттай авто зам засагдаж дуусвал, зүүн бүсийн уул уурхайн бүх гол цэгүүд хатуу хучилттай замаар холбогдох болно.

Монголын Засгийн газар нь цаашид Таван толгой -Ханги-Мандалын хилийн боомт (Дорноговь аймаг) хоорондын хатуу хучилттай замыг барих ажлыг төлөвлөж байна. Одоогийн байдлаар Таван толгой-Гашуун сухайт хилийн боомт-Сайншанд хот хооронд төмөр зам тавих барилгын ажил хийгдэж байгаа бөгөөд удахгүй дуусах төлөвтэй байна. Даланзадгад хот-Цогтцэций-Цагаан Хад-Гашуун сухайт хилийн боомтын хооронд хатуу хучилттай замтай болох нь хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд эергээр нөлөөлнө гэж найдаж байгаа юм.

Зүүн бүс нутгийн хатуу хучилттай зам нь Цогтцэций сум болон Ханбогд сумыг холбодог. Ханбогд сумын аялал жуулчлалын гол газар болох Дэмчогийн хийд, Хүрдэт агуй, Галбын говь, үлэг гүрвэлийн чулуужсан мөр байдаг Манлай сумын Шар цав зэрэг газрууд бий. Эдгээр газар нутгууд хатуу хучилттай замаар бүрэн холбогдоогүй ч , өмнөх үетэйгээ харьцуулахад шороон зам нь нэлээд багассан юм.

(3) Цэвэр ус

1) Дундговь аймаг

Аймгийн төв Мандалговь хот болон Сайнцагаан, Гурвансайхан, Өлзийт сумдын төв нь төвлөрсөн усан хангамжийн системд холбогдсон. Бусад сумд худгийн усыг зөөвөрлөж ашигладаг.

2) Өмнөговь аймаг

Өмнөговь аймаг нь Монгол улсын нийт газар нутгийн 10.6% -ийг эзэлдэг боловч нийт усны нөөцийн ердөө 0.5% -ийг эзэлдэг. Энэ нь тус аймагт усны нөөц маш хомс гэдгийг илтгэж байгаа юм. Тус аймагт газрын гүн дэх усны эх үүсвэр 30- ыг илрүүлснээс 27 газрыг нь 1982 оноос хойш төр, хувийн хэвшлийн хайгуулаар илрүүлсэн байна. Тэрхүү 27- ийн 5 нь хэт хатуу устай хэмээдэг бол 22 нь ашиглаж болох эх үүсвэр юм.

Бүх сум гадаргын усны нөөц багатай бөгөөд худгийн усыг ашигладаг. Сүүлийн жилүүдэд дэлхийн дулаарал болон уул уурхайн олборлолт зэрэг хүний хүчин зүйлээс хамааралтай байгаль орчны сүйрэл ихсэж олон гол мөрний усны хэмжээ багасаж, ширгэхэд хүрч байна (2015 оны гадаргын усны эх үүсвэрийн мэдээлэл). Гэвч сумдын төв хангалттай хэмжээний усан хангамжтай байна (Эх сурвалж: "Өмнөговь аймгийн цөлжилт, газрын доройтлын үнэлгээ" судалгааны тайлан А.Хауленбек (Ph.D), Улаанбаатар хот, 2017 он).

Өмнөговь аймагт голын ус ашигладаг жуулчны бааз огт байхгүй. Жуулчны баазуудын 3 нь 5 км зайтай орших худгийн усыг зөөвөрлөж ашигладаг бол бусад нь 70-150 м гүний худаг ухаж, усан хангамжаа шийджээ. Говийн бүс нутагт, худгаас гарах усны хэмжээ 1 литр / секундээс их байх тохиолдолд худаг болгон ашиглах стандартыг хангасан гэж үздэг тул бүх худаг дээрх хэмжээнээс их ус гардаг. Жуулчны баазууд ч энэ стандартад нийцсэн худаг ашигладаг тул усны хомсдол үүсдэггүй. Жуулчны баазууд ус ашиглаж эхлэхээсээ өмнө усны нөөц ашиглалтын менежментийн төлөвлөгөөг батлуулах ёстой. Мөн тэд ус ашиглалтын төлбөрөө тоолуурын заалтаар төлөх, тогтмол хураамж төлөх гэсэн 2 аргын аль нэгээр төлдөг бөгөөд тогтмол хураамж төлөх тохиолдолд сар бүр 1 сая орчим төгрөг (364 ам.доллар) -ийг ашиглалтын хязгаарлалтгүйгээр төлдөг (Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Усны нөөц ашиглалт хамгаалалт, сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн Т. Соёлмаа, 2021).

(4) Бохир ус

1) Дундговь аймаг

Аймгийн төв Мандалговь хот болон Сайнцагаан, Гурвансайхан, Өлзийт сумдын төв нь төвлөрсөн бохир усны системд холбогдсон. Дээрх 4 сумаас бусад суманд бохир ус цэвэрлэх байгууламж байдаггүй бөгөөд машинаар цуглуулсан бохир усыг сумын захын бохир ус хаях цэг рүү шууд хаядаг.

2) Өмнөговь аймаг

Тус аймаг бохир усыг Монгол улсын MNS4943: 2011 стандартын дагуу цэвэрлэж байна. Одоогийн байдлаар Өмнөговь аймгийн Даланзадгад хотод АХБ-ны 8.5 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлээр хоногт 3000 м³ усыг цэвэрлэх хүчин чадалтай, 98% буюу биологийн бүрэн цэвэрлэгээтэй цэвэрлэх байгууламжийг шинээр барьж байна. Барилгын ажлын гүйцэтгэл одоогоор 70%-тай байгаа бөгөөд 2021 онд ашиглалтад орох юм. Даланзадгад хотын энэхүү цэвэрлэх байгууламж ашиглалтад орсноор цаашид бүх хот, сум ижил стандартын цэвэрлэх байгууламжтай болно (Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Усны нөөц ашиглалт хамгаалалт, сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн Т. Соёлмаа, 2021).

Гэр баазуудын ус цэвэрлэх байгууламжийн судалгааны дүн дараах байдалтай байна. Гэр баазууд өөр өөрийн хүчин чадал, арга замаараа бохир усаа цэвэршүүлж байгаа тул хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлэх нь бага гэж үзэж байна.

- Даланзадгад хотоос 50 км -ийн зайд байрлах "Говь Мираж" жуулчны бааз нь Их Британийн технологиор Vortex (Польш улсад үйлдвэрлэсэн) цахилгаан ус цэвэршүүлэх байгууламжийг суурилуулан ашиглаж, цэвэршүүлсэн усаараа мод усалдаг.
- Даланзадгад хотоос 210 км-ийн зайд, Хонгорын элсэнд байрлах "Говийн анар" жуулчны бааз нь 2020 онд БНХАУ-д үйлдвэрлэсэн бохир ус цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулсан боловч Ковид-19-ын нөлөөгөөр үйл ажиллагаа явуулж чадахгүй байгаа тул одоог хүртэл ашиглалтад оруулаагүй байна.
- Даланзадгад хотоос 216 км-ийн зайд, Хонгорын элсэнд байрлах "Жуулчин говь-2" жуулчны бааз нь Монголд үйлдвэрлэсэн бохир ус цэвэршүүлэх системийг нэвтрүүлсэн ч, усаа дахин ашигладаггүй.
- Даланзадгад хотоос 50 км зайд байрлах "Дрийм Гоби" жуулчны бааз нь бохир ус цэвэрлэх төхөөрөмж суурилуулсан боловч усаа дахин ашигладаггүй байна. Цэвэрлэх төхөөрөмжөөс гарсан усыг Даланзадгад хотын ус цэвэрлэх байгууламж руу улиралд (4 сар тутам) 2-3 удаа бохир ус тээвэрлэгч машинаар тээвэрлэдэг. Тээврийн зардал нь 1 удаа 160,000 төгрөг

(ойролцоогоор 58 ам.доллар) болдог.

- Даланзадгад хотоос 38 км -ийн зайд байрлах "Говийн өргөө" жуулчны бааз нь Монголд үйлдвэрлэсэн бохир ус цэвэршүүлэх системийг нэвтрүүлэн ашигладаг ба цэвэршүүлсэн усаараа мод усалдаг байна.

Бусад жуулчны баазууд нь бохир усны танк суурилуулсан бөгөөд дүүрсэн үед нь бохир ус тээвэрлэгч машинаар ойролцоох хот, сумын цэвэрлэх байгууламж руу тээвэрлэн зөөж асгадаг.

Хонгорын элс орчмын жуулчны бааз гэх мэт хот, сумын төвөөс алслагдсан газар байрлах баазууд нь Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын газрын удирдлага дор зориулалтын талбайд гүн нүх ухаж, тэнд бохир ус, хог хаягдлаа хаядаг байна. Зарим жуулчны баазууд бохир ус тээвэрлэгч машинаар Сэврэй сумруу бохир усаа тээвэрлэн цэвэрлүүлдэг. Төлбөр нь 1м³ тутамд 15,000 төгрөг байдаг байна. Хатуу хог хаягдлаа ч мөн Сэврэй сумын хогийн цэг рүү зөөвөрлөдөг. Нэг жуулчны бааз жилд 50,000 төгрөгийн хог хаягдлын төлбөрийг тус суманд төлдөг (Сэврэй сум, Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн Э.Оюунцэцэг, 2021). Өнөөг хүртэл Өмнөговь аймагт бохир уснаас үүдэлтэй байгаль орчны бохирдол, хохирлын талаарх гомдол, мэдээлэл ирээгүй байна (Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Усны нөөц ашиглалт хамгаалалт, сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн Т. Соёлмаа, 2021).

(5) Хог хаягдлын менежмент

1) Дундговь аймаг

Аймгийн төвийн хэмжээнд хог ачигч зургаан машинтай бол сумдын хувьд 12 суманд хог ачигч машин байдаг. Тус аймаг нийтдээ 14 сумтай ба 12 буюу ихэнх сум өөрөө хог ачигч машинтай байгаа юм. Саяхан болтол хогийг ялгахгүйгээр бүх төрлийн хог хаягдлыг нэг дор цуглуулдаг байсан, харин сүүлийн үед хогоо ангилж ялгадаг системд шилжиж байна. Аймагт нэг хогийн цэг байдаг бөгөөд Улаанбаатар луу тээвэрлэдэг дахин боловсруулах хог хаягдлаас бусдыг энд булдаг.

2) Өмнөговь аймаг

Өмнөговь аймагт хог цэвэрлэх байгууламж байхгүй. Аймгийн төв буюу Даланзадгад хотын хэмжээнд 23 хог ачигч машин ажиллаж өдөр бүр айлууд болон аж ахуйн нэгжийн хог хаягдлыг цуглуулдаг. Цуглуулсан хог хаягдлаа Даланзадгад хотоос 13 км зайтай, 5 га талбай бүхий хогийн цэгт хаяж, булдаг ба дахин боловсруулах хог хаягдлыг ангилж ялгаж авдаг. 2020 оны байдлаар газарт булсан хог хаягдлын хэмжээ 91,800 тонн болсон гэсэн тоо баримт байна (Өмнөговь аймгийн Даланзадгад хотын ЗДТГ, Хөгжил, үйлчилгээний газрын дарга Н.Лувсанбаяр, 2021).

Даланзадгад хотын ЗДТГазар 66 ажилтантай, тэдний дөрөв нь өдөр бүр ээлжээр цуглуулсан хогноос хуванцар, лаазыг ялган авч, тусгай машинаар шахдаг. Өмнөговьд дахин боловсруулах хогийн байгууламж байхгүй тул хог хаягдлын хэмжээ 10 тоннд хүрэхэд Улаанбаатар хот руу дахин боловсруулах хог хаягдлаа тээвэрлэдэг.

Даланзадгад хотын айл өрхүүд хогоо ялгаж, ангилан хотод байрлуулсан 54 хогийн цэг рүү зөөж авчирч хаядаг. Хотын төв хаалга, залуучуудын соёл спортын төв, зугаа цэнгээний газрууд гэх мэт хүн хөл ихтэй байршлуудад хогийн савыг ангилан байрлуулж, дахин боловсруулах хогийг цуглуулдаг.

Айл өрхийн хог хаягдлыг байр, орон сууц, гудамжинд нь байрлуулсан том хогийн саванд хаялдаг. Сар бүр орон нутгийн засаг захиргаа хогийг нь цуглуулж авдаг, айл өрхүүд хог хаягдлын хураамж болгон сард 2000-2500 төгрөг төлдөг байна.

Жуулчны баазуудын ихэнх нь Даланзадгад хотын гадна байрладаг тул дээр дурдсан орон нутгаас хог цуглуулах үйлчилгээнд хамрагдахгүй. Тиймээс ойролцоох хот, сумын хогийн цэг хүртэл өөрсдөө зөөж, холбогдох засаг захиргаанд хог хаягдлын хураамжаа төлдөг. Жил бүр бүх жуулчны баазууд байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөгөө гаргаж Байгаль орчин, аялал жуулчлалын газраар батлуулах ёстой байдаг. Энэхүү байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөнд хог хаягдал цуглуулах, зайлуулах тухай тусгах үүрэг хүлээдэг. Энэ систем нь жуулчны баазууд хог хаягдлыг зохих ёсоор цуглуулж, зайлуулахад тодорхой хэмжээгээр нөлөөлж

байгаа юм.

Жишээлбэл, Даланзадгад хотоос 35 км -ийн зайд орших "Жуулчин говь" жуулчны бааз нь хамгийн ойрхон сум болох Ханхонгор суманд жилд 100,000 төгрөгийн хог хаягдлын хураамж төлж, хог хаягдлаа Даланзадгад хотын хогийн цэг рүү тээвэрлэдэг. ("Жуулчин говь" жуулчны баазын нягтлан бодогч Мөнгөнцэцэг, 2021). Жуулчны баазуудаас хураасан хог хаягдлын хураамжийн орлогыг хот, сумын хог хаягдлыг цуглуулах, цэвэрлэх үйл ажиллагаанд болон ажилчдын цалин хөлсөнд зарцуулдаг.

Жуулчны баазын хог хаягдлын 60-70 хувийг хуванцар сав, лааз, шил эзэлдэг. Гэвч Өмнөговь аймагт хуванцрыг дахин боловсруулах технологи, систем, боловсруулах үйлдвэр байдаггүй. Түүнчлэн, Даланзадгад хотоос зайтай хол байдаг тул жуулчны баазууд эдгээр дахин боловсруулж болох хог хаягдлыг ангилж ялгалгүйгээр хамгийн ойрын хогийн цэг рүү шууд тээвэрлэн хаяж байна.

<Хог хаягдлыг хууль бусаар хаяж буй шалтгаан, Монгол хүний хог хаягдлын тухай ойлголт, соёл>

Монголын түүхэнд, ялангуяа Чингис хааны үед батлагдсан "Их Засаг" хэмээх хууль (ял шийтгэл оноох заалт)-д, хууль бусаар хог хаях, ус бохирдуулах, амьтныг олноор агнаж, ургамлыг хэт ихээр тастах, гал түймэр тавих зэрэг гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд цаазаар авах ял ногдуулдаг байсан гэж бичсэн байдаг. Өнөөг хүртэл Монголын уламжлалт нүүдлийн ахуй амьдралд, байгальд задардаггүй, байгаль орчинд сөрөг нөлөөтэй хог хаягдал байгаагүй. Монголын нүүдэлчид малын махаа салхинд хатааж ашигладаг бөгөөд цагаан идээг малын ходоод, гэдэс гүзээг сав болгон хурааж хадгалдаг байсан уламжлалтай. Ийм амьдралын хэв маягтай байсан учраас байгальд задардаггүй хог хаягдал гардаггүй байв. Өдгөө хүн амын дийлэнх нь суурьшмал амьдралын хэв маягт шилжсэнээр, шил, хуванцар, механик бүтээгдэхүүн, цемент зэрэг байгальд задардаггүй хог хаягдлын хэмжээ ихээхэн нэмэгдэж иржээ.

Монголчууд уул, усаа эзэнтэй хэмээн тахиж шүтэж, байгаль дэлхийгээ хайрлах, хамгаалах баялаг уламжлалтай. Үүнтэй холбоотой зан заншил, баяр наадам, ёслолыг хийж ирсэн. Гэвч социализмын үед энэхүү ёслол, арга хэмжээг шашны зан үйл, мухар сүсэг хэмээн үзэж хааж хориглосноор олон уламжлал, зан заншил алдагдсан юм. Тиймээс, хүн ам шигүү суурьшсан газарт их хэмжээний хог хаягдал хаа сайгүй хөглөрч, хөдөө тал нутагт амьдарч байгаа малчид хүртэл гуу жалга, хөндий газар луу хууль бусаар хогоо хаядаг болсон байна. Гэвч ардчилалд шилжсэний дараа уул, усаа шүтэх, тахиx нь чөлөөтэй болж, ёс заншил сэргэн, байгаль орчноо дээдлэх, хамгаалах хадгалах сэтгэл зүй, хог хаягдлаа эмх цэгцтэй хаях ойлголт ухамсар нь нэмэгдсэн. Өнөөг хүртэл Өмнөговь аймагт хог хаягдлаар байгаль орчныг сүйтгэсэн гэсэн гомдол, мэдээлэл бүртгэгдээгүй байна (Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Агаарын бохирдол, хог хаягдлын асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Батжаргал, 2021).

(6) Эрчим хүч / харилцаа холбоо

1) Дундговь аймаг

Бүх сумд төвийн эрчим хүчний сүлжээнд холбогдсон ба 15 суманд харилцаа холбооны сүлжээ, оптик шилэн кабель тавигджээ. Монголын үүрэн холбооны үндэсний оператор компани болох Gmobile -ийн холбооны сүлжээ 15 суманд орж ирсэн бөгөөд малчид ихээр ашигладаг. Бүх сум 3G -д холбогдсон тул интернэт сүлжээг аялал жуулчлалын бүс нутагт чөлөөтэй ашиглах боломжтой.

2) Өмнөговь аймаг

Тус аймгийн 26 жуулчны баазаас Даланзадгад хотын ойролцоох 11 жуулчны бааз нь Булган сум болон Буянт хүүхдийн зуслангийн өндөр хүчдэлийн шугамд өөрсдийн зардлаар кабель холбож, эрчим хүчнийхээ асуудлыг шийдсэн тул, тог тасрахаа больсон байна. Кабель холбох зардал 20 сая төгрөг (7282 ам.доллар) байдаг. Мөн 2 жуулчны бааз нарны болон салхин цахилгаан станц суурилуулсан бөгөөд үлдсэн 13 жуулчны бааз нь 3-10 кВт-н жижиг дизель генератор ашигладаг.

“Өмнөговь аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2021 оны Үндсэн чиглэл”д үндэслэн, Хонгорын элсэнд нарны цахилгаан станц барих төсөв болгож 100 сая төгрөг (36,409 ам.доллар) хуваарилжээ (Эх сурвалж: Өмнөговь аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2021

оны Үндсэн чиглэл). Хонгорын элс болон Баянзаг зэрэг аялал жуулчлалын алдартай газруудын жуулчны баазуудаас цаашид төвийн эрчим хүчний сүлжээнд холбогдох хүсэлт гаргаж байгаа боловч тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын хэмжээ асар их болох тул одоогоор шийдэлд хүрээгүй байна. Цаашид Хонгорын элс, Баянзаг орчмын жуулчны баазууд төвийн эрчим хүчний системд холбогдвол цахилгаан дамжуулах өндөр хүчдэлийн шугам нь байгалийн үзэмж эвдэх, зэрлэг шувуудад сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай тул, байгаль экологид ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлдэггүй технологийг ашиглах, шувуудыг тогонд цохиулахаас урьдчилан сэргийлэх аргыг нэвтрүүлэх шаардлагатай.

(7) Зам дагуух үйлчилгээний цэгүүд (түр амрах, бие засах газар)

1) Дундговь аймаг

Мандалговь хот нь Улаанбаатар хотоос Даланзадгад хот хүрэх замын яг хагаст оршдог тул Мандалговиор дамжин өнгөрч буй бараг бүх зорчигч, жуулчид энд хооллох, амрах, зарим нь хонох чухал цэг болдог. Улаанбаатар хот-Мандалговь хот-Даланзадгад хот чиглэлийн зам дагуу өнөөг хүртэл албан ёсоор барьж байгуулсан амрах саатах газар, нийтийн бие засах газар байдаггүй.

Дундговь аймгийн засаг захиргаа Мандалговь хотод Японы "Замын өртөө" (Мичи но эки) маягийн амрах байгууламж бариулах хүсэлтийг 2021 онд БОАЖЯ-нд хүргүүлжээ.

Өмнөговь аймгийг зорих жуулчид, уул уурхайчдын тоо нэмэгдэхийн хэрээр Мандалговь хотод амрах, хооллох хүмүүсийн тоо нэмэгдэж байгаа бөгөөд Өмнөговь аймаг руу зорчих зорчигсдын замын буудаллах гол цэгийн чухал үүргийг Мандалговь хот нь гүйцэтгэдэг. Үүнтэй холбоотойгоор тус хотын зарим үйлчилгээний салбарууд хурдацтай хөгжиж байгаа бөгөөд 2021 оны мэдээгээр 5 зочид буудал (нийт 159 өрөө), 11 ресторан (нийт 770 суудал) ажиллаж байна. Мөн төв зам дагуух Хулд сум, Луус суманд ч 5 шинэ ресторан нээгдсэн тул рестораны тоо нь Мандалговь хотынхтой нийлээд 16 болж байгаа юм. Дундговь аймгийн төв нь замын дамжин өнгөрөх цэг болж хөгжих боломжтой боловч одоогоор зөвхөн үйлчилгээний салбар л хөгжиж байна. Хамгийн чухал зүйл болох амрах газар (нийтийн бие засах газар) өнөөг хүртэл байхгүй байгаа нь гадаадын жуулчдын наад захын хэрэгцээг хангаж чадахгүй байгаа юм. Тиймээс жуулчид эдгээр ресторан, зочид буудлуудын бие засах газрыг ашиглахаас өөр аргагүй болдог.

2) Өмнөговь аймаг

Нийтийн бие засах газар байгуулах, цэвэрлэгээ, үйлчилгээг тогтмол хийх нь Монгол улсын хувьд нийтлэг тулгамдсан асуудал хэвээр байна. Хэтийн төлөвлөгөөндөө байнга тусгадаг боловч аялал жуулчлалын зам дагуу олон газарт амрах, нийтийн бие засах газар байгуулах шаардлагатай, одоо ч хүрэлцэхгүй байна. "Өмнөговь аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2021 оны Үндсэн чиглэл" -ын 129-р зүйлд "Эко жорлон" төсөл, гэр хорооллын айл өрхийн хог хаягдлыг ангилах орчныг бүрдүүлэх төсөл зэрэг ажлууд тусгагдаж, нийт 614 сая төгрөгийн төсөв тооцоологдсон байна. (Эх сурвалж: "Өмнөговь аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2021 оны Үндсэн чиглэл")

Даланзадгад хот-Мандалговь хот хоорондын хатуу хучилттай зам дагуу байрлах Цогт-Овоо сум мөн Даланзадгад хот-Гурвантэс сум хоорондын хатуу хучилттай зам дагуу байрлах Баяндалай суманд нийтийн бие засах газар байгуулсан байдаг. Цогт-Овоо сумын нийтийн бие засах газрын менежментийг гэрээгээр тус сумын иргэн хувь хүнээр хийлгэдэг бөгөөд бие засах газар угсралтын зардал нь 7 сая төгрөг, ашиглалтын төлбөр нь 500 төгрөг (0.18 ам.доллар) байдаг.

Монгол улсын аялал жуулчлалын гол цэгүүдийн нэг болох Баянзаг хэмээх үлэг гүрвэлийн чулуужсан олдворын газраас 18 км -т орших Булган суманд 2025 он гэхэд нийтийн бие засах газар байгуулахаар төлөвлөж аймгийн төсөвт 60 сая төгрөгийг суулгахаар аймгийн ИТХ-аар баталжээ. Гэхдээ зөвхөн нийтийн бие засах газар байгуулах нь хангалтгүй тул "Замын өртөө" (Мичи но эки) маягийн цогцолбор барих төлөвлөгөөг Булган сумаас сонгогдсон ИТХ-ын гишүүнээр дамжуулан хүргүүлсэн байна. Булган сум нь Баянзагаас Хонгорын элс хүртэлх зам дагуу байрладаг, Өмнөговь аймгийн төвийн бүсийн аялал жуулчлалын салбарын чухал цэг болох сумын төв юм.

Аялал жуулчлалын гол чиглэл болох Баянзаг, Ёлын Ам, Мухар шивэртийн ам, Хавцгайтын ам,

Хонгорын элсэнд говийн уур амьсгалд тохирсон хуурай бие засах газар байдаг. Эдгээрээс Баянзагт ойрхон 2 нийтийн бие засах газрын үйл ажиллагааг "Баянзаг-Улалзах Цонж Хөгжлийн төв" ТББ хариуцан ажилладаг. Хонгорын элс дэх нийтийн бие засах газрыг цаашид Сэврэй сумын иргэд шинээр байгуулах ТББ хариуцан ажиллах төлөвлөгөөтэй байна.

Даланзадгад хотын төвийн хамгийн хөл хөдөлгөөн ихтэй газар болох Ажнайн талбай, зах, төв цэнгэлдэх хүрээлэн, соёл амралтын төв, зочид буудал, зоогийн газруудад нийтийн бие засах газар ажилладаг. Өмнөговь аймгийн бүх жуулчны бааз боловсон бие засах газартай бөгөөд эрүүл ахуй, ариун цэвэрт их анхаарч ажилладаг.

2020 оны 10-р сард БОАЖЯ-ны судалгааны баг Даланзадгад хотод очиж зам дагуух амрах цэгүүдийн байршлын талаар судалгаа хийн, энэ асуудлаараа Байгаль орчин, аялал жуулчлалын газар, "Гайхамшигт Говь" АЖ холбоотой санал солилцсон байна. Тэр үед "Гайхамшигт Говь" АЖ холбооноос дараах цэгүүдэд амрах төв байгуулах санал гаргажээ. Үүнд, Улаанбаатар хотоос 115 км -т байрлах Довын гуанз, Довын гуанзаас 165 км -т байрлах Мандалговь, Мандалговиос 170 км -т байрлах Өмнөговь аймгийн Цогт-Овоо сум, Цогт-Овоо сумаас 130 км -ийн зайд байрлах Даланзадгадад тус тус амрах цэгүүд байгуулахыг санал болгожээ. Мөн Даланзадгадаас баруун бүс нутгийн чиглэлд Баяндалай сумд, зүүн бүс нутгийн чиглэлд Цогтцэций сумд, засмал зам дагуу биш ч аялал жуулчлалын газар гэдгээрээ алдартай Булган суманд тус тус амрах цэг байгуулах нь зүйтэй хэмээсэн.

Одоогийн байдлаар БОАЖ-ын Сайдын зүгээс 2020 оны 12 -р сарын 12 -ны өдрийн 01/8785 тоот тушаалаар Өмнөговь аймгийн Баяндалай суманд "Замын өртөө" (Мичи но эки) маягийн байгууламж барих зориулалтаар, орон нутгийн газрыг ашиглах тусгай эрхийг олгосон байна.

3.1.6 Жуулчдын чиг хандлага

Өмнөговийг зорьсон жуулчдын тоог гадаадын болон дотоодын жуулчид тус бүрээр харуулж байна. Дундговь аймагт зорчсон жуулчдын судалгаа байхгүйгээс тоо, хэмжээг мэдэх боломжгүй байв.



Эх сурвалж: Говь Гурвансайхан БЦГ-ын хамгаалалтын захиргаа, аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн Т.Ганчулуун, 2020 он

Зураг 3-7: Өмнөговийг зорьсон жуулчдын тоо

3.1.7 Аялал жуулчлалын салбарын чиг хандлага

1) Өмнөговь аймгийн аялал жуулчлалын салбарт ажиллагсдын нийт тоо

Өмнөговь аймгийн хэмжээнд ажил эрхэлдэг хүний тоо дөнгөж 25,000 хүн (2017 он) байгаагаас аялал жуулчлалын салбарт ажиллагсад нь 1200 хүн байна. Энэ тоо нь зөвхөн орон тооны ажилтан болон зун үйл ажиллагаагаа явуулдаг жуулчны баазуудын ажилтнуудыг оруулаад гаргасан тоо бөгөөд аймгийн хэмжээний ажил эрхлэгчдийн тоотой харьцуулахад нилээдгүй хувийг эзэлж байгаа нь харагдана. Үүн дээр рестораны болон улирлын чанартай ажилчдын тоог нэмж оруулбал

энэ салбарт ажиллагсдын тоо бүр их гарах юм. Энэ бол аялал жуулчлалын салбар нь тус аймагт нийгэм болон эдийн засгийн талаасаа ямар чухал үүрэг гүйцэтгэдгийг илтгэж байгаа юм. Аялал жуулчлалын салбар нь ажиллах хүч, хамрах хүрээ, оруулах хувь нэмэр зэрэг олон хүчин зүйлээрээ Өмнөговь аймгийн хамгийн чухал салбар болох нь харагдаж байна

Жуулчны баазад ажиллагсдын цалингийн системээс харахад менежер, тогоочийн цалин харьцангуй өндөр байна. Харин бусад ажил мэргэжлийн хувьд орон нутгийн төрийн албан хаагчдын цалингаас арай доогуур байна.

Хүснэгт 3-25: Өмнөговь аймгийн аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдал (бизнесийн төрөл тус бүрээр)

	Төрөл	Тоо	Ажилчдын тоо
1	Зочид буудал	14	129
2	Гэр буудал	45	127
3	Жуулчны бааз	26	Орон тооны 150 + Улирлын чанартай 760
4	Тур оператор болон тур агент	1	5
5	Ресторан	30	231
6	Музей	9	19
7	Аялал жуулчлалын холбоо	1	1

Эх сурвалж: Өмнөговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар

а) Жуулчны бааз, Аялал жуулчлалын компани бөгөөд жуулчны бааз

Өмнөговь аймагт үйл ажиллагаа явуулж буй жуулчны баазууд нь 4 -р сараас 10-р сар хүртэлх аялал жуулчлалын улиралд л зөвхөн үйл ажиллагаа явуулдаг. Аялал жуулчлалын улиралд нэг жуулчны баазад дунджаар 6-8 үндсэн ажилтан ажилладаг бөгөөд аймгийн хэмжээгээр жуулчны баазуудын үндсэн ажилтан нийтдээ 150 орчим хүн байдаг. Жуулчны баазуудад улирлын чанартай ажиллагсдын дийлэнх нь аялал жуулчлалын чиглэлээр сурч буй их дээд сургуулийн оюутнууд (1-3-р курсийн оюутнууд) бөгөөд аялал жуулчлалын улиралд 6-р сараас 8-р сарын сүүл хүртэл түр гэрээгээр ажилладаг. Нэг жуулчны бааз дунджаар 8-12 оюутныг түр ажилд авдаг. Түүнчлэн жуулчны бааз бүр 7-р сараас 9 -р сарын ачаалал ихтэй үедээ тогооч, зөөгч, гэр буудлын үйлчлэгч, үйлчилгээний туслах ажилтнаа нэмж түр ажилтны гэрээгээр ажиллуулдаг.

б) Аялал жуулчлалын компани

Нэг тур оператор таван үндсэн ажилтантай үйл ажиллагаа явуулж байна. Аялал жуулчлалын компаниуд нь жуулчдын захиалгад нийцүүлэн жолооч, орчуулагч хөтөч, тогооч, үйлчилгээний туслах ажилтнуудыг түр ажилтнаар авдаг ба орон нутгийн хөтчөөр малчдыг ажиллуулдаг. Зэрлэг ан амьтдыг ажиглах аялалд орон нутгийн хөтчөөр малчдыг ажиллуулах нь их байдаг бөгөөд жилд дунджаар 20-25 хүнийг ажиллуулдаг. Жилд 8-12 групп жуулчдыг хүлээж авдаг (Өмнөговь аймаг, Tum Eco-tour компаний менежер, Т.Цэлмэг).

в) Зочид буудал

Даланзадгад хотод 14 зочид буудал үйл ажиллагаа явуулж байна. Эдгээрийн 1 нь 3 одтой, 2 нь 2 одтой. Нэгэн зэрэг 347 жуулчин хүлээн авах боломжтой бөгөөд бүх зочид буудлын нийт ажиллагсдын тоо 129 байна. Зочид буудлын түр ажилчдын нийт тоог мэдэх боломжгүй бөгөөд төрөл бүрийн хүлээн авалт, шинэ жилийн баяр гэх мэт томоохон арга хэмжээний үеэр нэг удаа дунджаар 3-6 зөөгч түр ажилд авдаг байна.

г) Дэн буудал

Өмнөговь аймагт хөдөө орон нутгийг оролцуулаад нийт 45 дэн буудал үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд нэгэн зэрэг хүлээж авах боломжтой жуулчдын тоо 639, нийт ажилтны тоо 127 байна (Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Аялал жуулчлалхариуцсан мэргэжилтэн Н.Бурмаа, 2021). Бүх жуулчны баазын үндсэн ажиллагсдын нийт тоо 150, зуны улиралд 1 жуулчны баазад дунджаар 25-40 түр ажилтан ажилладаг ба нийт 26 жуулчны баазад 780 орчим түр ажилтан ажилладаг байна (өвлийн улиралд үйл ажиллагаа явуулдаггүй тул энэ тоо нь зуны улирал, өвлийн улиралд ажиллагсдын тооны ялгаа болно).

е) Музей, үзэсгэлэн, уран зургийн галерейд ажиллагсдын тоо

Өмнөговь аймгийн бүх сумд өөрсдийн музейтэй. 2020 оноос эхлэн 8 суманд соёлын өвийг хариуцсан ажилтан ажиллаж байна. Цаашид бүх сумдад соёлын өвийг хариуцсан ажилтан ажиллуулах төлөвлөгөөтэй байгаа юм. Аймгийн музей нь нийт 11 ажилтантай. Одоогоор Даланзадгад хотод 98 тэрбум төгрөгийн өртөгтэй байгалийн шинэ музей баригдаж байгаа бөгөөд 2021 онд ашиглалтад оруулахаар төлөвлөжээ (Аймгийн Байгалийн музей, эрдэмтэн судлаач Л.Болормаа, 2021).

ф) Аялал жуулчлалын холбооны тоо, ажиллагсдын тоо

“Гайхамшигт Говь” АЖ холбоо нь Өмнөговь аймгийн аялал жуулчлалтай холбоотой цорын ганц ТББ юм. Дэлгэрэнгүй мэдээллийг дээр дурдсан бөгөөд холбооны тэргүүнээс бусад нь сайн дурын ажилтан юм.

2) Аялал жуулчлалын салбарын ажилтнуудын цалингийн түвшин, хөдөлмөрийн нөхцөл (ажил мэргэжил тус бүрээр)

Хөрөнгө оруулагчид өөрсдөө ихэвчлэн жуулчны баазын ерөнхий менежер, менежерүүд байдаг. Тэднийг цалингаас гадна урамшуулал, ногдол ашгийг давхар авдаг хэмээдэг ба энэ талаар олон нийтэд мэдээлдэггүй. Өмнөговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь байгаа мэдээлэлдээ үндэслэн ажил мэргэжил тус бүрийн сарын цалингийн хэмжээг ойролцоогоор дараах байдлаар тооцоолж гаргажээ. ҮСХ-ны мэдээлснээр 2019 оны улсын дундаж цалин 1.1 сая төгрөг байгаа ба менежер, тогоочоос бусад аялал жуулчлалын салбарын ажилчдын цалин нийт хүн амын дунджаас доогуур байгаа нь харагдаж байна.

Хүснэгт 3-26: Өмнөговь аймгийн Аялал жуулчлалын салбарын ажилтнуудын сарын дундаж цалин (ажил мэргэжил тус бүрээр)

Ажил мэргэжил	Сарын цалингийн хэмжээ
Ерөнхий менежер / менежер	1,500,000-2,000,000 төгрөг
Тогооч (ахисан түвшний)	2,000,000-2,500,000 төгрөг
Гэр буудлын үйлчилгээний ажилтан (ихэвчлэн оюутнууд)	600,000 -800,000 төгрөг
Зөөгч / бармен	600,000-800,000 төгрөг
Үйлчилгээний туслах ажилтан	500,000-600,000 төгрөг
Хамгаалагч (жилийн турш тогтмол цалин авдаг)	600,000-700,000 төгрөг

Эх сурвалж: Өмнөговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар

6-р сарын сүүлээс 8-р сарын сүүл хүртэлх үе хамгийн ачаалал ихтэй байдаг. Ялангуяа тогооч, зөөгч, хоноглох гэрийн үйлчилгээний ажилчид өглөөний 5 цагаас шөнийн 1 цаг хүртэл ажиллах тохиолдол ч байдаг. Зарим компани хөдөлмөрийн нөхцөлийг харгалзан сарын дундуур эсвэл сарын сүүлээр ажилчиддаа урамшуулал олгодог боловч урамшууллын хэмжээг нь нийтэд ил мэдээлдэггүй байна.

Жуулчны баазууд нь ерөнхий менежер, менежер, харуулаас бусад нь улирлын чанартай ажилчид байдаг. Зарим жуулчны бааз өвлийн улиралд ажилладаггүй ч сарын цалингийн талыг тэтгэмж болгон ажилчиддаа олгодог байна. Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын ажилчдын сарын дундаж цалин дараах байдалтай байна.

Хүснэгт 3-27: Өмнөговь аймгийн төрийн албан хаагчдын сарын дундаж цалин

Төрийн албан хаагчдын албан тушаал	Сарын дундаж цалин
Сумын байгаль хамгаалагч	639,285 төгрөг
Аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн	791,532 төгрөг
Аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга	1,088,657 төгрөг
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтэс, Аялал жуулчлалын бодлого хариуцсан ажилтан	791,532 төгрөг
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтсийн дарга	1,088,657 төгрөг

Эх сурвалж: Өмнөговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, 2021

3.1.8 Аялал жуулчлалын маркетинг, сурталчилгааны байдал

Тус аймгийн албан ёсны веб сайтын “Аялал жуулчлал” цэсээр дамжиж ороход Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон аймгийн лого тэмдэг бүхий хэсэг гарч ирдэг. Аймгийн аялал жуулчлалын газруудын зураг, бусад мэдээлэл гарч ирэх хэдий ч зөвхөн монгол хэл дээр байдаг нь учир дутагдалтай. Зорилтот зах зээлийн судалгаа байхгүй мөн гадаад хэл дээр мэдээлэл түгээхгүй байгаа сул тал байна.³⁴

“Өмнөговь аймаг” гэсэн нэртэй фэйсбүүк хуудас ажилладаг бөгөөд гишүүнээр бүртгүүлсэн хүмүүс пост оруулах боломжтой хуудас. Гэхдээ аймаг, нутаг орныхоо жуулчлалын салбарын мэдээлэл түгээх сайтын үүргийг гүйцэтгэж чадахгүй байна.

Эдгээрээс өөр албан ёсны веб сайт, мэдээлэл сурталчилгаа түгээх хэрэгсэл байдаггүй бөгөөд аялал жуулчлалын холбоо ч веб сайтгүй байна. Аялал жуулчлалын компанийн мэдээллээс өөр Өмнөговийн аялал жуулчлалын тухай англи хэл дээрх мэдээлэл үндсэндээ байхгүй. Англи хэл дээр байх тэдгээр мэдээлэл ч чамлалттай. Цөөн тооны мэдээлэлтэй тэд нар нь тогтмол шинэчлэгддэггүйн дээр байх ёстой зураг, танилцуулга нь устгагдсан гэх мэт дутагдалтай зүйл ихтэй байгаа юм.

3.1.9 SWOT шинжилгээ

Өмнөговийн аялал жуулчлалын маршрут нь байгалийн үзэмж сайтайгаас гадна аяллын бусад маршрутад байдаггүй үлэг гүрвэлийн болон эртний балгасын олдвор гэх мэт ховор сонин үзэмрүүд бүхий газар нутагтай өрсөлдөх чадвар сайтай, аялал жуулчлалын нөөцтэй. Зорилтот жуулчид нь (1) үлэг гүрвэл судлаач, палеонтологич гэх мэт судлаачид, (2) үлэг гүрвэл сонирхогчид болох юм. Үлэг гүрвэлийн олон тооны олдворыг ойроос үзэж танилцах боломжтой газар гэдгээрээ бусад орноос илүү давуу талтай. Тиймээс энэ бүс нутгийн содон, ховор сэтгэл татам байдлыг дэлхий дахинд үр дүнтэй сурталчилж чадвал гадаадын судлаачид, палеонтологич төдий бус жирийн жуулчдыг ч татах нөөц бололцоотой юм. Түүнчлэн үлэг гүрвэлийн олдвор судлалд шинэ нээлт хийсэн чухал газар бөгөөд үлэг гүрвэлийн олдворын хайлтын ажил өнөө ч үргэлжилсээр байгаа. Тиймээс цаашид ч шинэ олдвор олдож, түүнийг жуулчид дэргэдээс нь харах ховор боломж завшаан олдих магадлалтай юм. Үлэг гүрвэлийн мөрийг түүхт газар дээр нь очиж харахын тулд Улаанбаатар хотоос нэг талдаа 10 гаруй цаг машинаар явж очдог. Гэвч дэлхий дээрх ийм ховор үзэмрийг үзэж өргөн уудам талд нутгаар аялах тул олон арван цаг машинаар явж очих нь тийм ч бэрхшээлтэй асуудал биш юм.

Хүснэгт 3-28 нь Өмнөговийн аялал жуулчлалын маршрутын давуу ба сул талуудад дүн шинжилгээ хийж нэгтгэсэн SWOT шинжилгээ болно. Дотоод орчны давуу тал нь S, сул тал нь W, гадаад орчны боломжийг O, аюул заналыг T гэж илэрхийлсэн болно. Давуу болон сул талуудын тодорхой нөхцөл байдал дараах байдалтай байна.

³⁴ Өмнөговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас гаргасан Өмнөговь аймгийн аялал жуулчлалын гол маршрутын зураг:
<https://tourism.omnogovi.gov.mn/files/images/%D0%9C%D0%B0%D1%80%D1%88%D1%80%D1%83%D1%82/DZ-Baynzag-Hongoriin%20gol-DZ%20aylal.jpg>

Хүснэгт 3-28: Өмнөговийн аялал жуулчлалын маршрутын давуу болон сул талууд (SWOT шинжилгээ)

	Нөөц бололцоо	Хязгаарлах нөхцөл
	Давуу тал Strength	Сул тал Weakness
Дотоод орчин	<p><u>Аялал жуулчлалын нөөц</u> -Дэлхийд ховорт орох уудам тал нутаг, өвөрмөц байгалийн үзэсгэлэн (том, жижиг элсэн манхан) асар том хавцлууд -Өргөн уудам хээр тал, цэлмэг, хөх тэнгэр, шөнийн тэнгэр дүүрэн од -Олон төрлийн ховор амьтад (мазаалай, хавтгай гэх мэт) -Үлэг гүрвэлийн өлгий нутаг (Өдгөө ч төрөл бүрийн малтлага хийж байгаа, олдвор олдсон газрууд байдаг) -Эртний хадны зураг -Ардын бүжиг</p> <p><u>Дэд бүтэц</u> -Гол авто замуудыг хатуу хучилттай болгосон -Дотоодын нисэх буудал байдаг (1 цаг гаруй хугацаанд нийслэлээс аймгийн төвд хүрэх боломжтой) -Аймаг, сумын төвүүд интернэтэд холбогдсон -Алслагдсан газарт байрлах жуулчны баазууд дизель генератортай</p> <p><u>Хууль / дүрэм</u> -Аймгийн ЗДТГ аялал жуулчлалын чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулахын зэрэгцээ ТББ -тай хамтран ажилладаг -Үлэг гүрвэлийн олдворт газрыг тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар хамгаалдаг -Хог хаягдлаа бага гаргах, байгаль орчинд ээлтэй байх тал дээр анхаарч ажилладаг</p> <p><u>Үйлчилгээ</u> -УБ хотоос Өмнөговь орох замын яг тэг дунд байдаг Мандалговь хотод ресторан зэрэг үйлчилгээний газар ихсэж байгаа -Гадаадын иргэдэд зориулсан зочид буудал, жуулчны баазууд баригдсан -Ардын урлагийн үзвэр үйлчилгээ үзүүлдэг ТББ -ууд байдаг</p>	<p><u>Аялал жуулчлалын нөөц</u> -Өвлийн улиралд хэт хүйтэн</p> <p><u>Дэд бүтэц</u> -УБ хотоос Даланзадгад хүртэл машинаар 8 цаг орчим явдаг -Гол замаас бусад, аялал жуулчлалын газруудад хүрэх замууд ихэнх нь шороон зам байдаг -Олон улсын нисэх онгоцны буудал байхгүй -Дотоодын нислэгийн тоо цөөхөн -Замд нийтийн бие засах газар байдаггүй, зөвхөн цайны газар л ашиглах боломжтой -Аймаг, сумдын төвөөс бусад газар интернэтийн сүлжээ муутай -Цахилгаан түгээх сүлжээнд холбогдоогүй газруудын цахилгаан хангамжид ихэвчлэн чулуужсан түлш хэрэглэдэг -Аялал жуулчлалын газруудад халаалт тааруухан байдаг</p> <p><u>Хууль / дүрэм</u> -Аялал жуулчлалын мэдээллийн самбар хөгжөөгүй -Жуулчны баазыг барих тогтсон газар гэж байдаггүй</p> <p><u>Үйлчилгээ</u> -Бэлэг дурсгалын төрөл, зүйл цөөн</p> <p><u>Мэдээлэл / Маркетинг</u> -Найдвартай мэдээллийн эх үүсвэр дутмаг</p>

	Боломж Opportunity	Аюул занал Threat
Гадаад орчин	<p><u>Аялал жуулчлалын нөөц</u> -Шинээр хөгжүүлэх боломжтой газар, аялал жуулчлалын сэдэв бий</p> <p><u>Дэд бүтэц</u> -Дотоодын нисэх буудлууд олон улсын нисэх буудал болох магадлалтай</p> <p><u>Мэдээлэл / Маркетинг</u> -Гадаадын жуулчид зочлох дуртай газар бөгөөд жуулчдын дунд алдартай</p>	<p><u>Хууль / дүрэм</u> -Замгүй газраар зорчиж, хөрс доройтуулах олон салаа зам үүсгэх аюултай -Зориулалтын бүсээс өөр газар жуулчны бааз дураараа барих явдал ихсэх аюултай</p> <p><u>Мэдээлэл / Маркетинг</u> -Үйлчлүүлэгчдийн ихэнх нь гадаадын жуулчид тул олон улсын нөхцөл байдлын нөлөөнд өртөх аюултай</p>

Эх сурвалж: Судалгааны баг

(1) Өмнөговийн аялал жуулчлалын маршрутыг хөгжүүлэх давуу тал

1) Аялал жуулчлалын нөөц

- ① "Үлэг гүрвэлийн өлгий нутаг" гэж хэлж болох аймаг юм. Үлэг гүрвэлийн чулуужсан өндөг олдсон газар Баянзаг, үлэг гүрвэлийн чулуужсан мөр байдаг Шарцав, Азидаа томоохонд ордог Хонгорын элс зэрэг аялал жуулчлалын алдартай нөөцүүд байдаг. Тиймээс палеонтологийн хүрээлэн гэх мэт үндэсний болон гадаадын судалгааны байгууллагуудтай хамтарсан төслүүд ч олноор хэрэгжиж байдаг.
- ② Тэмээний баяр хийх, ховор ан амьтад ажиглах гэх мэт шинэ эвент, арга хэмжээ, тодорхой зорилтот аялал жуулчлалыг хөгжүүлэхэд ихэд анхаарч ажиллаж байгаа.
- ③ Их газрын чулуу БЦГ-т зохион байгуулагддаг урлагийн их наадам нь 15,000 (2019 он) хүнийг хамарсан том арга хэмжээ болж өргөжиж байгаа хэдий ч зорилтот үйлчлүүлэгчид нь дотоодын жуулчид юм. Цагаан Суваргын хадны зургаас сэдэвлэсэн бүжгэн жүжиг нь ЮНЕСКО -гийн төв байранд тоглолтоо хийсэн бөгөөд үүнтэй уялдаатайгаар цаашид эдгээр аялал жуулчлалын газрууд нь гадаадын жуулчдын анхаарлыг татах магадлал өндөртэй юм.



Үлэг гүрвэлийн олдвор



Баянзаг



Хонгорын элс



Цагаан Суварга

2) Дэд бүтэц

- ① Улаанбаатар хотоос Өмнөговийн нийслэл Даланзадгад хот хүртэлх авто замыг хатуу хучилттай болгосноор дотоодын жуулчдын тоо эрс нэмэгдэж байна. Улаанбаатараас Өмнөговь хүрэх нислэгийн тоог нэмэгдүүлж, Гурван Сайхан нисэх онгоцны буудлыг олон улсын нисэх буудал болгох ажлыг хэрэгжүүлж чадвал, тус аймгийн гадаад, дотоодын жуулчдыг хүлээн авах боломж ихээхэн өргөжих юм.
- ② Ихэнх зочид буудал, жуулчны баазууд боловсон бие засах газар, халуун ус, шүршүүрээр тоноглогдсон байдаг.
- ③ Аймаг, сумын төвүүд интернэтэд холбогдсон.
- ④ Сумын төвөөс алслагдсан газарт байрлах жуулчны баазууд нь дизель генератораар цахилгаан эрчим хүчээ хангадаг.

3) Үйлчилгээ

- ① Улаанбаатар хотоос Даланзадгад руу машинаар явахад ойролцоогоор 8 цаг зарцуулдаг тул замын дунд байх Дундговь аймгийн Мандалговь хот нь буудаллаж амрах цэг болж хөгжиж байна.
- ② Соёлын биет бус өмч болох ардын бүжиг, баяр наадмыг жуулчдад зориулсан эвент болгон тоглож үзүүлэх боломжтой.
- ③ Өмнөговь аймаг нь Монгол улсын анхны гадаадын иргэдийг хүлээж авах жуулчны бааз нээгдсэн газар бөгөөд гадаадын жуулчдыг хүлээж авах арвин туршлагатай.

4) Мэдээлэл / Маркетинг

- ① 2019 онд 42,132 гадаадын жуулчин³⁵, 12,955 дотоодын жуулчин аялсан байна. Эндээс харахад дотоодын жуулчдын тооноос гадаадын жуулчид нь хамаагүй их байна. Энэ нь тус аймаг гадаадын иргэдийн сонирхол, сэтгэлийг ихээр татах аялал жуулчлалын нөөцтэй болохыг нотолж байгаа юм.³⁶ Тус аймагт 1990 -ээд онд Японы иргэд их ирдэг байсан бол одоо БНСУ-ын иргэд хамгийн их ирдэг аж.
- ② БНСУ, Монгол улс хоёрын хооронд MIAT компаниас гадна Солонгосын 2 компани (Korean Air, Asiana) өдөр бүр тогтмол нислэг үйлддэг бөгөөд Монголын хөдөө орон нутгийн аялал жуулчлалд ч эерэг нөлөө үзүүлсэн нь 2019 онд Өмнөд Солонгосоос ирсэн жуулчдын тоо 100,000 давснаас харагдаж байгаа болно.

³⁵ Говь Гурвансайханы БЦГ-ын Хамгаалалтын Захиргаа

³⁶ ШУА Vol.58 No.04 (228) 2018 У. Хишигдалай, Н.Бат-Эрдэнэ



Зочид буудал



Жуулчны бааз

(2) Өмнөговийн аялал жуулчлалын маршрутын хөгжлийг хязгаарлах нөхцөл

1) Аялал жуулчлалын нөөц

- ① Өвлийн улиралд -40 хэм хүрч хүйтэрдэг.
- ② Говийн тал нь машинаар явахад бартаа, саадгүй байдаг тул хатуу хучилттай замаас өөр газраар автомашинууд явах нь их, тал газар маш олон салаа зам үүссэн байх нь элбэг. Ингэснээр хур тунадас багатай, нэн хуурай эх газрын уур амьсгалтай бүс нутагт хөрс, ургамлыг сүйдлэх аюултай тул байгалийн нөөцийг хамгаалах, хадгалах талаасаа энэ нь сул тал болох юм.

2) Дэд бүтэц

- ① Улаанбаатараас ирэх нислэг нь, зуны оргил үед ч гэсэн өдөрт 2 компанийн тус бүр нэг нэг нислэг үйлдэгддэг ба жуулчдын тоо цөөрөх өвлийн улиралд 7 хоногт 1 удаа л нислэг байдаг. Энэ 1 удаагийн нислэг нь уул уурхайн компанийн захиалгаар нисдэг тул ердийн үйлчлүүлэгчдийг суулгадаггүй. Нисэх онгоц нь хэмжээ нь жижиг (50-100 хүний багтаамжтай) тул зорчигчдын тоо эрс ихэсдэг зуны улиралд нислэгийн тийз олж авахад туйлын хэцүү болдог. Нисэх онгоцны буудлын өнөөгийн нөхцөлд (нислэгийн зурвасын урт, өргөн гэх мэт) том оврын онгоц нисэх боломжгүй гэсэн асуудал гардаг. Энэ шалтгааны улмаас Говийг зорих хүсэлтэй жуулчдыг бүрэн хүлээж авч чадахгүй байгаа магадлал өндөр юм.
- ② Нийслэлээс Өмнөговь аймгийн төв Даланзадгад хот хүрэх гол зам нь засмал зам боловч 580 орчим км зайтай, машинаар 8 цаг орчим зарцуулагддаг.
- ③ Монгол улсын Засгийн газрын хөгжлийн төлөвлөгөөнд Гурван сайхан нисэх буудлыг хөгжүүлэх, олон улсын нисэх буудал болгох төлөвлөгөө (2021-2026) багтсан байгаа боловч санхүүгийн эх үүсвэр тодорхой бус, 2021 онд төсөв батлагдаагүй байна. Гадаадын жуулчдыг татахад шаардлагатай нисэх онгоцны буудал нь бүрэн хөгжөөгүй байгаа болно.
- ④ Аймгийн төвөөс аялал хийх аялал жуулчлалын газрууд хүрэхэд хол зайтай байдаг. Уул уурхайн хатуу хучилттай замыг эс тооцвол аялал жуулчлалын газар хүрэх ихэнх зам нь шороон зам байна. Гэхдээ Говийн шороон зам харьцангуй тэгш саад тотгор бага байдаг.
- ⑤ Дундговь аймгийн аялал жуулчлалын газар болох, гадаадын жуулчдын анхаарлыг татах бүрэн боломжтой “Цагаан Суварга” хэмээх эртний хадны зураг (аймгийн төвөөс 35км орчим зайтай) болон дотоодын жуулчдад алдартай “Их газрын чулуу” (аймгийн төвөөс 85 км орчим зайтай), “Бага Газрын Чулуу” (аймгийн төвөөс 35 км орчим зайтай) хүртэлх авто замуудыг хатуу хучилттай болгох ажил хийгдээгүй байна.
- ⑥ Дундговь аймгийн Мандалговь хот нь зам дагуух түр буудаллаж амрах цэг болон хөгжиж байгаа ч нийтийн бие засах газар байгуулагдаагүй тул ресторан, цайны газрын бие засах газрыг ашиглах эсвэл хүн цочирдмоор гадаа бие засах газрыг ашиглахаас өөр аргагүй

байдаг. Гадаадын жуулчдаас авсан асуулга судалгааны үр дүнгээс харахад бие засах газар хүрэлцээ муу, чанаргүй байдаг талаар ихээхэн санал гомдол гардаг тул нэн түрүүнд шийдвэрлэх шаардлагатай.

- ⑦ Аялал жуулчлалын газруудын ойр орчимд нийтийн бие засах газар байдаггүй. Өмнөговь аймгийн Говь Гурвансайхан БЦГ (Ёлын амын мөс) -т аялагсдын нийт тоо 2019 онд 55,000 орчимд хүрсэн бөгөөд Ковид-19 намжсаны дараа аялал жуулчлан эргэн сэргэж хөгжихийг бодолцон ажил аялал жуулчлалын газруудад нэн яаралтай нийтийн бие засах газар суурилуулах нь зүйтэй.
- ⑧ Цахилгаан эрчим хүчний сүлжээнд холбогдоогүй жуулчны баазууд одоогоор дизель генераторыг ашиглаж байгаа бөгөөд цаашид аялал жуулчлалын гол газруудыг цахилгаан эрчим хүчний сүлжээнд холбох асуудал тавигдаж буй юм. Гэвч энэ нь байгалийн үзэмжийг алдагдуулж болзошгүй. Өмнөговь аймгийн тухайд бол нарны эрчим хүчийг хөгжүүлэх нь тохиромжтой.

3) Хууль / Дүрэм

- ① Цаашид жуулчдын тоо нэмэгдэхийг харгалзан, явах замыг ойлгомжтой тодорхой болгож, жуулчдыг төөрөхөөс урьдчилан сэргийлэх үүднээс ч замын тэмдэг, аялал жуулчлалын мэдээллийн самбарыг суурилуулах шаардлагатай гэж үзэж байна.
- ② Дотоодын жуулчдын дийлэнх нь өөрсдийн майхантайгаа аялдаг тул аялал жуулчлалын нөөц, байгаль орчноо хамгаалах үүднээс майхан барих зориулалтын талбайг тогтоож, тогтоосон газраас өөр газарт майхан барьж буудаллахыг хориглох нь зүйтэй. Өнөөг хүртэл ийнхүү зохицуулж, хянаж чадахгүй байгаагийн үндсэн шалтгаан нь хариуцсан ажилтнуудын тоо цөөхөн, хамрах газар нутаг нь хэт өргөн уудам байгаатай холбоотой бололтой.

4) Үйлчилгээ

- ① Гадаадын жуулчдын сонирхлыг татах бэлэг дурсгалын зүйлийг хөгжүүлэх ажил хоцорч байна.
- ② Гадаад хэлний мэдлэгтэй хүний нөөц дутмаг байна.

5) Мэдээлэл / Маркетинг

- ① Өмнөговь аймаг болон Дундговь аймгийн аль аль нь маркетинг / сурталчилгааны стратеги боловсруулж чадаагүй байна. Гадаадын иргэдэд чиглэсэн аялал жуулчлалын сурталчилгаа огт хийгдэхгүй байна гэж хэлж болно (аймгуудын веб сайтад орсон ч аялал жуулчлалтай холбоотой мэдээлэл Монгол хэл дээр ч бараг байдаггүй).
- ② Монголын аялал жуулчлалын газруудыг гадаад улс орнуудад хэрхэн яаж сурталчлах тухайд, юуны өмнө үндэсний стратеги төлөвлөгөө боловсруулах шаардлагатай. Энэ ажлын хүрээнд аймаг бүр өөрийн аялал жуулчлалын онцлогийг тодотгосон маркетинг / сурталчилгааг явуулах ба төр, орон нутгийн нягт уялдаа холбоотой үйл ажиллагаанд ТББ, хувийн хэвшлүүд нэгдэж хамтран ажиллах нь хамгийн тохиромжтой загвар болох юм. Мэдээж аймгууд өөрсдийн маркетинг / сурталчилгааг бие даан хийх ч боломжтой. Нэн тэргүүнд аялал жуулчлалын мэдээллийн чиглэлээр төрөлжсөн веб сайтыг хийх шаардлагатай байгаа ба зорилтот улс орон бүрийн хэлээр аймгийн аялал жуулчлалын газар нутгууд, аялал жуулчлалын агентлагууд, эвент, арга хэмжээний тухай зэрэг төрөл бүрийн баялаг мэдээллийг тогтмол түгээх шаардлагатай байна.
- ③ Орон нутгийн зарим жуулчны компани ховор ан амьтдыг ажиглах аялын маш сайн мэдээллийн сайттай байна. Эдгээр сайт шиг, Өмнөговийн сэтгэл татам байдлыг сайн түгээж чадах сайтыг бүтээх нь тийм ч хэцүү биш гэж үзэж байна.
- ④ Хамгийн чухал зүйл бол, аймгийн ЗДТГазар буюу төрийн байгууллагаас түгээх мэдээлэл нь найдвартай, үнэн бодитой хэмээн аялагчид, жуулчид итгэж хүлээж авдаг. Харин орон нутгийн, сайн танигдаагүй хувийн компанийн түгээсэн мэдээллийг хүлээж авах, итгэх итгэл муу байдгийг харгалзан үзэх хэрэгтэй. Түүнчлэн хувийн компаниуд мэдээллийг тасралтгүй шинэчилж, тогтвортойгоор түгээж чадах хэмжээнд хүрч төлөвшөөгүй байна. Үүнийг хувийн компаниудын веб сайтуудын мэдээлэл шинэчлэгдэхгүй байгаа байдал баталж байгаа юм.

3.2 Дорноговийн аялал жуулчлалын маршрут

3.2.1 Аялал жуулчлалын нөөцийн тухай

Дорноговийн аялал жуулчлалын маршрут (Улаанбаатар хот-Говьсүмбэр аймгийн Чойр хот-Дорноговь аймгийн Сайншанд хот-Замын-Үүд орчим) нь Улаанбаатар хотоор дайран өнгөрөх Москва-Бээжин чиглэлийн Улаанбаатар төмөр замын дагуу байрладаг.



Зураг 3-8: Дорноговийн аялал жуулчлалын маршрут

(1) Говьсүмбэр аймгийн Чойр хот орчмын бүс нутаг

Говьсүмбэр аймаг нь 5,540 км² газар нутагтай, 18,008 хүн амтай (2020 он). Газар нутгийн хувьд жижиг ч газрын тос, нүүрс, холимог металл, тоосгоны шавар, эрдэс будаг, хайлуур жонш, шохойн чулуу, бал чулуу зэрэг байгалийн баялаг нөөцтэй. Далайн түвшнээс дээш 1000-1200 метрийн өндөрт оршдог бөгөөд элс хайрган хөрстэй говь болон тал хээр хосолсон онцлогтой. Эх газрын эрс тэс уур амьсгалтай нутаг бөгөөд температурын ялгаа их зундаа 37 хэм, өвөлдөө -37 хэм байдаг.

Говьсүмбэр аймгийн төв нь Чойр хот бол Чингис хааны овог Боржигин овогтны газар нутаг юм. Түүнчлэн, эрт дээр үед Хятадаас Орос руу чиглэсэн цайны замын өртөө газар байсан гэдгээрээ алдартай. Говьсүмбэр аймаг нь Боржигин овогтны уламжлалт өв соёл үүсэж хөгжсөн газар бөгөөд нүүдэлчдийн түүх, соёлын дурсгалт газар ихтэй онгон байгалиараа байгаа говь болон тал хээрийн өвөрмөц тогтоцтой газар нутагтай. Зүүн Жанжин чойрын хийд, Чойрын богд уул, Дагвасүндэл бурхан, Хүслийн хад, Зараагийн зүүн өврийн хүн чулуу, Төмөр утасны хорооны туурь, Чингэлийн хад (хиргисүүр) зэрэг түүхийн болон соёлын өвийн дурсгалт газрууд байдаг. Аялал жуулчлалын гол нөөц нь Хүннү,Түрэгийн үеийн түүхэн дурсгалт газрууд (булш, хиргисүүр), хадны зураг, хадны бичээс, Зараан Толгойн хадны зураг, Цагаан Дарь эх, Дагвасүндэл зэрэг хаданд сийлсэн бурхадны зураг, Чойрын Хийдийн туурь зэрэг болно.

2018 онд аймгийн цорын ганц аялал жуулчлалын бааз болох "Боржигон Голомт" жуулчны бааз байгуулагдсан. Мөн 2 зочид буудал байдаг.

Москва-Улаанбаатар-Бээжин чиглэлийн олон улсын төмөр зам, Улаанбаатар-Чойр-Замын-Үүд чиглэлийн хатуу хучилттай авто зам, олон улсын өндөр хурдны шилэн кабелийн сүлжээ дамжин өнгөрдөг бөгөөд цахилгаан эрчим хүч, газрын тос, газрын тос хадгалах агуулах зэрэг дэд бүтэц, зам тээвэр маш сайн хөгжсөн газар нутаг юм.

Хүснэгт 3-29: Чойр хот орчмын аялал жуулчлалын гол нөөцүүд

Аялал жуулчлалын нөөц	Улирал	Товч мэдээлэл
"Боржигон Голомт" аялал жуулчлалын бааз	Зун	Чойрын Богд уулын Сакура цэцэг үзэх, морь унах гэх мэт

Эх сурвалж: Судалгааны баг

(2) Дорноговь аймгийн Сайншанд хот орчмын бүс нутаг

Дорноговь аймаг нь 109,500 км² газар нутагтай, 71,014 хүн амтай (2020 он) . Эртнээс нааш өмнөд хилийн хаалга болсон Замын-Үүдээс Чойрыг дамжин одоогийн Улаанбаатар хот ордог “Гүнж зам” тус аймгийн нутгаар дайран өнгөрдөг байсан ба энэ нь Монгол улсын гадаад худалдаа, соёлын харилцааны гол зам болж байжээ. Одоо ч гэсэн ОХУ, БНХАУ-ыг холбосон төмөр зам тус аймгийг дайран өнгөрдөг. Энэ замын дагуу тус аймгийн хүн амын 55% нь оршин суудаг. Аймгийн газар нутагт том гол мөрөн, нуур байдаггүй ч газар доорх усны нөөц ихтэй, хэд хэдэн рашаан устай. Нутгийн ихэнхэд говийн бор хөрс тархсан бөгөөд элсэрхэг нутаг юм. Хүчтэй цасан ба шороон шуурга, ган, зудын аюул цөөн бус удаа тохиодог, сүүлийн жилүүдийн хуурайшилтын улмаас цөлжилтийн явц хурдсаж байна. Аялал жуулчлалын газар Хамарын хийд болон Энергийн төвд дотоодын жуулчид их аялдаг.

Дорноговь аймагт Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгууд, шашин мөргөлийн, түүх соёлын дурсгалт газрууд олон байдаг бөгөөд Ноён хутагт Данзанравжаагийн ерөөл тавьсан Шамбалын орон, Хамарын хийд, Хан Баянзүрх хайрхан уул, Бүрдэнийн хөндий, элсэн манхан, Хашаатын говь, Их нартын хад, Цонжийн чулуу, Цагаан дэлийн агуй зэрэг аялал жуулчлалын арвин баялаг нөөц байдаг.

Улаанбаатар-Чойр-Замын-Үүд чиглэлийн авто зам хатуу хучилттай болж ашиглалтад орсон нь бүс нутгийн аялал жуулчлалын хөгжилд, нэн ялангуяа дотоодын аялал жуулчлалын чиглэлд томоохон хувь нэмэр болсон байна. Замын-Үүд-Хамарын хийдийн чиглэлд 42 км авто зам тавигдсан нь Хамарын хийдийг зорих гадаад, дотоодын жуулчдын аятай тухтай аялах боломжийг бүрдүүлж байна. БНХАУ-ын жуулчдыг татах зорилгоор Замын-Үүд суманд аялал жуулчлалын цогцолбор, Сайншанд хотод амралт зугаалга, аялал жуулчлалын зориулалт бүхий “Дорноговь-80” цогцолбор, Дорноговь аймгийн хүндэтгэлийн хаалга, Хамарын хийдийн цогцолбор, Өв соёлын өргөө буюу Соёмбо цогцолбор, өндөр зэрэглэлийн зочид буудлуудыг тус тус барьж байгуулан Дорноговь аймгийн аялал жуулчлалын бүтээн байгуулалтыг төр, хувийн хэвшлийн оролцоотойгоор бүтээн байгуулж байна.

Дорноговь аймаг нь аялал жуулчлалын арвин нөөцөө ашиглан, дараах аяллын төрлүүдийг аймагтаа хөгжүүлэх боломжтой гэж үзэж байна.

- Палеонтологийн аялал
- Археологийн аялал
- Шувуу ажиглах аялал
- Зэрлэг ан амьтан харах аялал
- Явган аялал
- Морь, тэмээн аялал
- Цэцэг ажиглах аялал
- Элсний аялал
- Унадаг дугуй, мотоцикл болон авто аялал
- Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал
- Бясалгалын аялал
- Эмчилгээ сувилгааны аялал
- Агаарын бөмбөлөгтэй аялал

Хүснэгт 3-30: Сайншанд хот орчмын аялал жуулчлалын гол нөөцүүд

Аялал жуулчлалын нөөц	Улирал	Товч мэдээлэл
Хамарын хийд, Энергийн төвийн аялал	Тогтмол	Ноён хутагт Данзанравжаагийн ерөөл тавьсан хийд ба түүний ойролцоо байдаг Энергийн төв. Шашин шүтлэг, түүх соёлын түүхэн дурсгалт газруудыг үзэх боломжтой.
Хэсэг байшинт, Олон байшинт эртний хотын туурь	Тогтмол	60 км орчим зам дагуу чулуун хутга, булш, байшин барилгын үлдэгдэл зэрэг эртний хотын туурийг үзэж болно.
Сүйхэнтийн чулуужсан ой, элс	Тогтмол	Эртний мод, хожуул чулуужсан хэвээрээ эгнээд үлдсэн байдаг.
Сүлдэн хөх толгой	Тогтмол	Чингис хааны тугийг тахиж байсан түүхэн дурсгалт эртний хийд

Эх сурвалж: Судалгааны баг

(3) Дорноговь аймгийн Замын-Үүд сум орчмын бүс нутаг

Замын-Үүд сум нь Орос-Монгол-Хятадыг холбосон Монголын төмөр замын хамгийн урд үзүүрт байрладаг. Улаанбаатар хоттой төмөр замаас гадна хатуу хучилттай авто замаар холбогддог тул БНХАУ-руу аялах, бизнес худалдаа хийх Монголын худалдаачид, бизнесменүүд их ирж очдог, хөл хөдөлгөөн ихтэй сум болон хөгжиж байна. Улаанбаатар төмөр замын Аялал жуулчлалын товчоо нь гадаадын жуулчдын хэрэгцээ, сонирхлын судалгаанд үндэслэн говийн аялал жуулчлал, хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор 2001 онд "Дорнын говь" аялал жуулчлалын баазыг Замын-Үүд сумын төвөөс 7 км газарт байгуулжээ. Тус жуулчны бааз нь байнгын эрчим хүч, шуудан холбоогоор хангагдсан бөгөөд голчлон автомашинаар аялагч жуулчид, Монголын хил, говь нутгийг зорин ирсэн жуулчид ашигладаг.

Замын-Үүд суманд 900 га нутаг дэвсгэртэй “Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүс байгуулагдаж байгаа бөгөөд БНХАУ-аас 50 сая, Монгол улсаас 8.8 сая ам.долларын санхүүжилтийг хийж, дулаан хангамж, цэвэр, бохир ус цэвэрлэх байгууламж, цахилгаан хангамж, авто зам барих гэх мэт дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажил хийгдэж байна. Энэ бүс нутаг аялал жуулчлал гэхээсээ илүү БНХАУ-тай хийх эдийн засгийн хамтын ажиллагааны төв болж хөгжих төлөвтэй байна.

3.2.2 Төлөвлөгөө / Аян / Арга хэмжээ

(1) Говьсүмбэр аймгийн бодлогын хөтөлбөр / төлөвлөгөө

Тус аймаг нь хойд талаараа Төв аймаг, зүүн өмнөд болон урд талаар Дорноговь аймаг, баруун урд талаараа Дундговь аймаг нийт 4 аймгийн 10 сумтай хиллэдэг. Улаанбаатар хотоос баруун урагш 220 км -т оршдог. Авто зам болон төмөр замын босоо тэнхлэгт холбогдсон дэд бүтэцтэй тул дэд бүтэц нь харьцангуй сайн хөгжсөн аймаг юм. Монголын хамгийн сүүлд байгуулагдсан аймгийн нэг болно.

Говьсүмбэр аймгийн нутаг дэвсгэр нь үндэсний Тулгар төрийн өв, Цагаан зээрийн байгалийн өв, Их говийн байгалийн өв газруудад хамаарагддаг, байгаль, соёлын нөөц бүхий газар бөгөөд эртний "Цайны зам" -ын гол өртөө байрлаж байсан газар юм. Түүнчлэн Боржигин түмний өлгий нутаг хэмээгддэг ба Боржигины өв соёл, зан заншлыг агуулсан түүхэн уламжлалыг сэргээж хөгжүүлэхээр зорьж байгаа аймаг юм.

БОАЖЯ, “Цайны зам”-ын судлалын төв болон бусад холбогдох байгууллагаас “Цайны зам” дагуух өртөө хотуудыг тодруулан, зангилаа хотуудыг "Нүүдэлчдийн аялал жуулчлалын төв" болгон хөгжүүлэх зорилгыг тавин судалгааны ажлыг эхлүүлжээ. Судалгаанд тус аймгийн Чойрын Богд уулын тусгай хамгаалалттай газар хамрагдаж байгаа юм.

Говьсүмбэр аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 2 -ны өдрийн 74 дүгээр тогтоолоор аймгийн аялал жуулчлалыг 2016-2020 онд хөгжүүлэх "Аялал жуулчлалыг хөгжүүлэх дэд хөтөлбөр"-ийг баталсан байна. Нийт 4 зорилтын хүрээнд 39 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Хүснэгт 3-31: 2019-2020 онд аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтийн байдал

2019 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	
①	"Зараагийн зүүн өврийн хүн чулуу" түүхэн дурсгалт газрыг тохижуулж, байгаль хамгаалах үйл ажиллагааг сайжруулсан.
②	Түр буудаллах цэгүүдийг хоёр газарт байгуулсан.
③	Аймгийн аялал жуулчлалын компаниудын нэгдсэн мэдээллийн санг бий болгож, www.tourism.govismber.gov.mn веб сайтад байршуулж, олон нийтэд сурталчилсан.
④	"Боржигин 2019" уламжлалт соёлын арга хэмжээг 2019 оны 7-р сарын 26-наас 28-ны хооронд зохион байгуулсан.
⑤	Бусад төлөвлөсөн арга хэмжээ 94% -ийн гүйцэтгэлтэй байна
2020 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	
①	Аялал жуулчлалын гол маршрутын дагуу "Зүүн Чойрын Хийд", "Хүүхдийн овоо"-ны хажууд, монгол хэл дээрх тайлбар болон тайлбарыг англи хэл дээр орчуулсан албан ёсны мэдээллийн гантиг чулуун самбар суурилуулсан.
②	"Боржигин Голомт" жуулчны бааз нь 2020 оны 5-р сараас эхлэн дараах аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлж байна.
③	Чойрын богд уулын сакура үзэх аялал
④	Морин циркийн шоу / Монголын морь унах соёлыг харуулсан эвент / "Урцны Гэрэл" адал явдалт аялал
Тус жуулчны бааз нь 2020 оны эцэс хүртэл нийт 4200 дотоодын жуулчин хүлээж авсан байна.	

Эх сурвалж: Говьсүмбэр аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар

(2) Дорноговь аймгийн аялал жуулчлалын хөгжлийн бодлого

Дорноговь аймагт аялал жуулчлалын хөгжүүлэхэд одоогоор дараах бодлогын баримт бичгүүдийг баримталж байна.

а) Дорноговь аймгийн аялал жуулчлалын мастер төлөвлөгөө

Дорноговь аймгийн ИТХ-ын 2020 оны 06-р сарын 19-ны өдрийн 13/09 тоот тушаалаар батлагдсан. Мастер төлөвлөгөөний гол зорилго нь тогтвортой хөгжлийн зарчим, шалгуурт нийцсэн өрсөлдөх чадвар бүхий хил орчмын болон хил дамнасан аялал жуулчлалын шинэлэг орц, гарц бүс нутаг болно гэжээ. Аймгийн аялал жуулчлалыг 5 тулгуурт хөгжлийн бодлого, төлөвлөлтөөр тодорхойлсон байна.

Хүснэгт 3-32: Дорноговь аймгийн аялал жуулчлалын мастер төлөвлөгөө

Бүс нутаг	Хамрах сум	Давуу тал	Сул тал
Хамарын хийд шашин, соёлын аялал жуулчлалын бүс	Өргөн, Эрдэнэ, Сайншанд	-Дотоодын аялал сайн хөгжсөн -Хамгийн ойрын ирээдүйн төлөвлөгөөтэй -Дэд бүтэц сайтай -Төмөр замыг ашиглах боломжтой	-Үйлчилгээний байгууллагууд сайн хөгжөөгүй -Маркетинг сурталчилгаа хангалттай бус -Үйлчилгээний даац хэтрэх аюултай
Хил орчмын болон хил дамнасан аялал жуулчлалын бүс	Замын үүд, Ханги боомт	-Эдийн засгийн үр өгөөж сайн -Гадаад зах зээлд амархан холбогдох боломжтой -Үйлчилгээний цогцолборууд төлөвлөгдсөн	-Байгаль, түүх соёлын үзмэр хүрэх дэд бүтэц муу
Их нарт- Загийн усны хоолой-Арван наймын богд уулын эко аялал жуулчлалын бүс	Мандах, Сайхандулаан, Даланжаргалан, Айраг	-Байгалийн нөөц ихтэй -Нутгийн иргэд болон төрийн байгууллагын хамтын ажиллагаа сайн	-Дэд бүтэц муу -Үйлчилгээний байгууллага цөөн

Бүс нутаг	Хамрах сум	Давуу тал	Сул тал
		-Байгаль хамгаалал, хяналт сайн -Рашаан усны нөөцтэй	
Эргэлийн зоо- Сүйхэнтийн эрдэм шинжилгээ судалгааны аялал жуулчлалын бүс	Хатанбулаг, Хөвсгөл, Улаанбадрах	-Байгалийн өвөрмөц тогтоцтой	-Дэд бүтэц муу, хэт их алслагдсан
Их бага Эрээний нурууны байгалийн аялал жуулчлалын бүс	Алтанширээ, Дэлгэрэх, Иххэт	-Байгалийн өвөрмөц тогтоцтой	-Дэд бүтэц муу

Эх сурвалж: Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар

Хилийн боомт хот болох Замын-Үүдэд эдийн засгийн чөлөөт бүс байгуулагдаж байгаа болон БНХАУ талын хилийн боомт хот Эрэнхот нь Монгол улсыг бараа бүтээгдэхүүнээр ханган нийлүүлэх гол төв болж байдаг мөн түүнчлэн Монголын олон жижиглэн худалдаачид энэ хотод зорчдог зэрэг Дорноговь аймаг нь Монгол улс, БНХАУ хоорондын худалдааны гол төв болж байдаг онцлогтой.

“Дорноговь аймагт аялал жуулчлалыг хөгжүүлэх дэд хөтөлбөр 2017-2020” -аас харахад ерөнхийдөө улсын төсөв болон гадаадын хөрөнгө оруулалтыг санхүүгийн эх үүсвэр гэж үздэг бөгөөд тус аймгийн аялал жуулчлалын хөтөлбөрийн 2019, 2020 оны төсөв жилд 25 сая төгрөг (9,102 ам доллар) гээд их бага хэмжээтэйгээр төлөвлөгдсөн байгаа болно. Үүнийг 6 зорилт (аялал жуулчлалын бүс нутагт авто замын чиглэл тогтоох, аялал жуулчлалын үйлчилгээний ажилчдыг өргөжүүлэх, стандартыг тогтоох, үйлчилгээг сайжруулах, мэдээлэл, сурталчилгааны хүртээмжийг сайжруулах, аялал жуулчлалын үйл ажиллагааг дэмжих арга хэмжээ зохион байгуулах гэх мэт) ыг биелүүлэхэд зарцуулсан байна.

2020 онд боловсруулсан "Аялал жуулчлалыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө" нд маркетингийн стратеги болгож лого, уриа лоозон хийх, аялал жуулчлалын гол газар болох Хамарын хийд, Ханбаянзүрх уулыг түшиглэсэн шашин, соёлын аялал жуулчлалын газрыг сурталчлах, байгалийн болон палеонтологи, түүхийн цогцолбор байгуулах, эдгээрийг сонирхож буй гадаад, дотоодын жуулчдыг татах, хил орчмын зорилтот зах зээлд зориулсан маркетинг хийх зэрэг зах зээлийг харгалзаж үзсэн төлөвлөгөөг гаргасан байгаа боловч одоо байгаа дэд хөтөлбөртэй уялдаа холбоогүй мөн санхүүгийн эх үүсвэр ч тодорхой биш байна.

Эртний хадны зураг, агуй зэрэг аялал жуулчлалын ховор нандин нөөцүүдийн хадгалалт, хамгаалалт тааруухан гэмтэж, эвдрэх эрсдэл ихтэй байгааг аймгийн захиргаа ойлгож хамгаалалтад авч эхэлж байна.

2020 онд аймгийн ИТХ-аар батлагдсан аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт аялал жуулчлалыг хөгжүүлэх тухай (1) байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх, (2) үндэсний онцлог бүхий, байгаль орчинд ээлтэй, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх, (3) аймгийн аялал жуулчлалын төлөвлөгөөг хэрэгжүүлж, жуулчдын тоог нэмэгдүүлэх, (4) орлогыг нэмэгдүүлэх зорилгоор аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг шинэчилж, сурталчлах, (5) үндэсний зан заншил, уламжлал, нүүдэлчдийн соёлд суурилсан аялал жуулчлалыг хөгжүүлэх гэж заасан байгаа боловч тодорхой үйл ажиллагааны төлөвлөгөө байхгүй, ерөнхий тунхаг шинжтэй хөтөлбөр ажээ.

Дорноговь аймагт аялал жуулчлалын хөгжил тийм ч эрчимтэй биш байгаа юм. Тус аймгийн аялал жуулчлалын салбарын үндсэн үйлчлүүлэгч нь дотоодын аялагчид байдаг, аялал жуулчлалын салбарт ажилладаг хүний тоо 2020 онд 1024 хүн буюу хөдөлмөрийн насны хүн амын дөнгөж 2.1%-ийг эзэлж байгаа. Гадаад харилцааны тухайд, хил залгаа БНХАУ-тай хийх харилцааг илүү анхаарч үздэг. Энэ бүхнээс харахад аялал жуулчлалын салбарт ач холбогдол өгөхгүй байгаа нь харагдаж байна. Гэвч бодит байдал дээр аялал жуулчлалын салбарыг хөгжүүлснээр ажилгүй иргэдийн тоог багасгах, иргэдийн орлогыг нэмэгдүүлж аймгийн эдийн

засаг, нийгмийг хөгжүүлэх боломж өндөр байгаа юм. 2020 онд боловсруулж гаргасан аялал жуулчлалыг хөгжүүлэх мастер төлөвлөгөөнд тусгагдсан маркетингийн бодлого, төлөвлөлт их анхаарал татаж байгаа юм.

- b) Дорноговь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны “Хөгжлийн төлөө хамтдаа-2” /2020-2024/ хөтөлбөр

Дорноговь аймгийн ИТХ-ын 02/06 тоот тушаалаар батлагдсан. Үндэсний өв соёл, уламжлалт спортыг хөгжүүлэх “Монгол бахархал” төв байгуулах, Хамарын хийдэд ноён Хутагт Данзанравжаагийн нэрэмжит соёл-аялал жуулчлалын цогцолбор барих ажлыг эхлүүлэх, байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэхдээ үндэсний онцлог бүхий, байгаль орчинд ээлтэй, нутгийн иргэдэд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг түлхүү хөгжүүлэх зэрэг төлөвлөгөө тусгагджээ. Мөн “Цахим Монгол” (E-MONGOLIA) арга хэмжээний хүрээнд аймгийн аялал жуулчлалыг сурталчлах, орлогыг нэмэгдүүлэх ажил хийнэ гэсэн байгаа бөгөөд ингэснээр цаашид аймгийн хэмжээнд гадаад, дотоодын аялагчдын анхаарлыг татах бодитой арга хэмжээ хэрэгжүүлэх боломж нээгдсэн байна.

- c) “Талын зам” үндэсний хөтөлбөр

Засгийн газрын 2017 оны 142-р тоот тогтоолоор баталж 2019 оны 421 тоот тогтоолоор “Талын зам” хэмээн нэрийг нь өөрчилсөн. Монгол улсын нийгэм эдийн засгийг 10 салбар чиглэлээр хөгжүүлэхээр зорилт дэвшүүлсэн ба Зорилт 8-ийн хүрээнд авто замын үндсэн коридорыг түшиглэн аялал жуулчлалын парк, төрөлжсөн цогцолбор, хилийн боомтын аялал жуулчлалын кластер байгуулж, аялал жуулчлалыг үндэсний хэмжээнд бүсчлэн хөгжүүлнэ хэмээн зорилтыг тодорхойлжээ. Уг хөтөлбөрт Дорноговь аймгийн тухайд Хамарын хийдийн шашин мөргөл, аялал жуулчлалын цогцолбор, хилийн боомтын кластер буюу Замын-Үүд, Ханги боомтын аялал жуулчлалын цогцолбор ч багтсан болно.

- d) Дорноговь аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх дэд хөтөлбөр

Аймгийн ИТХ-ын удирдах зөвлөлөөр 2011 онд батлагдсан хөтөлбөр юм. Уг хөтөлбөр “Дорноговь аймагт аялал жуулчлалыг байгаль, түүх, соёлын дурсгалт газруудыг түшиглэн орон нутгийн онцлогтой аялал жуулчлал хөгжих таатай боломж нөхцөлийг бүрдүүлэх, менежментийг сайжруулах, аймгийн эдийн засгийн хөгжил, иргэдийн амьжиргааны түвшнийг дээшлүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулах” гэсэн зорилтын хүрээнд 2011-2014 он, 2015-2017 он, 2018 -2020 онуудад үе шаттайгаар хэрэгжигдсэн байна. Доорх хүснэгтэд үзүүлсэнчлэн 2020 онд 27 сая төгрөгийг төсөвлөжээ. Эдгээрээс Ковид-19-ийн нөлөөгөөр зарим төсөл хэрэгжигдээгүй ба 14 сая төгрөгийн 9 төсөл хэрэгжиж чадсан аж. Ковид-19-ийн хязгаарлалтын дэглэмийн улмаас аялал жуулчлалын үйл ажиллагаа 2021 онд ч хязгаарлагдаж байгаа тул энэ онд 4 төсөл л хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3-33: Аялал жуулчлалын үйл ажиллагааны төсвийн гүйцэтгэл

	Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	2019 он /мян.төг/		2020 он /мян.төг/		2021 он /мян.төг/
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэл
1	Дорноговь аймгийн аялал жуулчлалын мастер төлөвлөгөөг боловсруулах	15,000.0	15,000.0	-	-	-
2	International Travel Mart, Horeca Industry үзэсгэлэн, Улаанбаатар үзэсгэлэнд оролцох	3,000.0	3,000.0	3,000.0	3,000.0	3,000.0
3	Зам дагуух "А, В, С" ангиллын замын өртөө үйлчилгээний цэгүүдийн байршлыг тодорхойлж, орон нутгийн газар зохион	500.0	500.0	-	-	-

	Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	2019 он /мян.төг/		2020 он /мян.төг/		2021 он /мян.төг/
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэл
	байгуулалтын төлөвлөгөөнд тусгах					
4	Их нарт БНГ-т отоглох цэг байгуулах	-	-	4,000.0	4,000.0	-
5	Аялал жуулчлалын танилцуулга боловсруулах, хэвлэх	-	-	2,000.0	2,000.0	-
6	What3words имэйлийн системийг нэвтрүүлэхэд шаардлагатай сургалт, семинарыг явуулах, бүртгүүлэх	-	-	5,000.0	5,000.0	-
7	Их нарт БНГ-н мэдээллийн төвийг үе шаттайгаар хөгжүүлэх	-	-	-	-	3,000.0
8	Дорноговь аймгийн аялал жуулчлалыг гадаад дотоодод сурталчлах үйл ажиллагааг хэрэгжүүлэх	-	-	-	-	1,000.0
9	Дорноговь аймгийн аялал жуулчлалын мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх	-	-	13,000.0	0	11,000.0
	Нийт	18,500.0	18,500.0	27,000.0	14,000.0	18,000.0

Эх сурвалж: Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар

Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газар нь Шизуока мужтай эгч дүүс хотын харилцаатай бөгөөд хөдөө аж ахуй, соёл, боловсрол, эрүүл мэнд, эрчим хүчний салбарт амжилттай хамтран ажиллаж байна. Мөн 2013 онд байгуулагдсан Их нартын БНГ-ын хамгаалалтын захиргаа нь АНУ-ын Денверийн зоологийн сан, “Анза-Боррего” цөлийн паркттай хамтарч ажилладаг зэргээр Дорноговь аймаг нь олон улсын хамтын ажиллагаагаар дамжуулан аялал жуулчлалыг хөгжүүлж байгаа онцлогтой юм.

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны “Хөгжлийн төлөө хамтдаа-2” мөрийн хөтөлбөрт “хөрш болон өндөр хөгжилтэй орнууд, тэдгээрийн муж, хотуудтай хамтын ажиллагаа хөгжүүлэн, олон тулгуурт гадаад харилцааны бодлогыг хэрэгжүүлж, аймгийнхаа эдийн засаг, нийгмийн хөгжилд дэмжлэг авах нөхцөлийг бүрдүүлэх, хөрөнгө оруулалт татахаар зорилт тавин ажиллана” хэмээн олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх ач холбогдлыг чухалчилсан байна.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ЗДТГ нь БНХАУ-ын ӨМӨЗОрны Эрээн хотын ардын засгийн ордонтой хамтран ажиллах гэрээний загварыг 2017 онд үйлдэн, “Хятад Монгол хоёр улсын хил дамнасан аялал жуулчлалын бүс” байгуулах асуудлаар хэлэлцсэн байна.

3.2.3 Аялал жуулчлалын салбарын холбогдох байгууллагууд

(1) Төрийн захиргааны байгууллага / Улсын байгууллага

1) Хамарын хийдийн сав газрын захиргаа³⁷

Аймгийн ИТХ-ын 2005 оны 12-дугаар сарын 19-ны 3/11 тоот тогтоолоор Ханбаянзүрх уул орчмын 3710 га газар, Ойн нөөц газарт ”Хашаатын говийн 8400 га газар, 2010 оны 07-р сарын 18-

³⁷ <https://dornogovi.gov.mn/>

ны 5/04 тогтоолоор Хамарын хийд, Шамбалын ерөөл тавьсан хаалга зэргийг багтаасан 44627 га газар, Чойлонгийн уулын хийдийн туурь байгаа Зоогийн хоолой, палеонтологийн ач холбогдол бүхий газар, цагаан эрэг, улаан дов, далайн хөндий зэрэг 26764 га газар нутгийг “Байгаль түүхийн дурсгалт газар”-ын төрөлд хамааруулан аймгийн тусгай хамгаалалтад авсан. Хамарын хийдийн сав газрын хамгаалалт, үйл ажиллагааг сайжруулах зорилгоор Сайншанд сумын ИТХ-аас гаргасан шийдвэрийн дагуу 2017 оны 1-р сарын 1-ний өдрөөс Хамарын хийдийн сав газрын захиргааг Сайншанд сумын Хот тохижилтын газрын харьяа болгоод үйл ажиллагаа явуулж байна. Тус хот тохижилтын газар нь байгаль орчныг хамгаалах, аялал жуулчлалыг хөгжүүлэх, хотын өнгө үзэмжийг сайжруулах, ногоон байгууламж, хог хаягдлыг цэвэрлэх үйл ажиллагааг хариуцан ажилладаг байна. Сайншанд сумын Хот тохижилтын газар нь дараах аялал жуулчлалын газрыг хариуцан ажиллаж байна.

Хүснэгт 3-34: Сайншанд сумын Хот тохижилтын газарт хамаардаг аялал жуулчлалын газрууд

1	Ханбаянзүрх уул
2	Хамарын хийд
3	Өвгөн Суварга
4	Цагийн хүрд/Их тэнгэр хонх
5	Амьд Буддагийн рашаан булаг гэж нэрлэгдсэн Нагаржунай
6	Шамбалын орон буюу Энергийн төв
7	Ёлхойн хавцал/ Даянчин агуй
8	Тонтой овоо, толгод
9	Зоогийн хоолой (Зоо гэдэг нь говийн бүс нутгийн газрын хэлбэрийг дүрсэлж хэлдэг үг юм)
10	Хашаат говь

Эх сурвалж: Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар

Тус захиргаа нь жил бүрийн 4 -р сарын сүүлээс 5 -р сарын эхэн хүртэл "Сакура цэцэг үзэх аялал", жил бүрийн 9-р сард "Шамбалын их ерөөл хурах ёслол" -ыг зохион байгуулдаг.

Сайншанд сумын төсвөөр санхүүждэг ба аялагч, жуулчдаас хураасан хураамж ч орлогын эх үүсвэр болдог. 2019 онд 180 сая, 2020 онд 120 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн бөгөөд ихэнх нь дотоодын жуулчдаас оржээ. 2019 онд 90,000 гаруй жуулчин, 2020 онд 60,000 орчим жуулчин зочилсон ба үүний 91 нь гадаадын иргэд байжээ.

2) Их нартын БНГ-ын хамгаалалтын захиргаа³⁸

Тус БНГ нь УИХ-ын 1996 оны 43 дугаар тогтоолоор улсын тусгай хамгаалалттай газар бүртгэгдсэн юм. 1999-2013 он хүртэл Денверийн зоологийн сан, Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Засаг даргын Тамгын газар, Калифорния мужийн “Анза-Боррего” цөлийн парк зэрэг байгууллагуудтай хамтран ажиллах гэрээний дагуу байгаль хамгаалах үйл ажиллагааг хийж гүйцэтгэсэн.

2013 оны 5-р сарын 2-ны өдөр Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюун, Дорноговь аймгийн Засаг дарга П.Ганхуяг нар "Их Нартын байгалийн нөөц газрын хамгаалалтын менежментийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх" гэрээг байгуулж <Аргалт агнуур судалгааны төв> ТББ-ийн Дорноговь дахь салбарт хамгаалалтын менежментийн ажлыг хариуцуулсан ажээ. Мөн аймгийн ИТХ-н тогтоолоор Даланжаргалан суманд хамгаалалтын захиргаа байгуулагдан үйл ажиллагаагаа явуулах болсон (Жич: Үүгээр тус байгууллага нь олсон ашгаа өөрсдөө захиран зарцуулах боломжтой болж, Хустайн БЦГазартай адилхан өөрөө өөрийгөө санхүүжүүлэн удирдах аргыг нэвтрүүлсэн болно).

(2) Төрийн бус байгууллага

1) Дорноговь аймгийн аялал жуулчлалын холбоо

Аялал жуулчлалтай холбоотой үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага гэж аймагтаа

³⁸ <http://ikhkart.mpa.gov.mn/about>

албан ёсоор бүртгүүлсэн цорын ганц байгууллага юм. 2017 онд байгуулагдсан ба аймгийн аялал жуулчлалын 60 орчим бизнес эрхлэгч гишүүн нь байдаг. 2017, 2018 онуудад Улаанбаатар хотод зохион байгуулагдсан Олон улсын аялал жуулчлалын аялалд тус аймгийн аялал жуулчлалын оператор компаниудыг цуглуулж оролцуулж байсан.

3.2.4 Дэд бүтцийн байдал

(1) Төмөр зам

Орос, Монгол, Хятадыг холбосон төмөр зам (Монголын хэсгийг "Улаанбаатар төмөр зам" гэж нэрлэдэг) нь энэ удаагийн судалгааны зорилтот бүс нутаг болох Говьсүмбэр аймгийн төв Чойр, Дорноговь аймгийн төв Сайншанд хотод зогсдог ба хилийн боомт хот болох Дорноговь аймгийн Замын-Үүд хүртэл өдөр болгон явдаг. Энэ чиглэлийн галт тэргийг зөвхөн зүүн өмнөд аймаг руу зорчих хүсэлтэй иргэд төдийгүй БНХАУ руу аялах зорилготой иргэд ч ашигладаг. Улаанбаатар хотоос Говьсүмбэр, Дорноговь аймгийн чиглэлийн төмөр замын өртөөдийн нэрийг Зураг 2-12: Төмөр замын сүлжээ зургаас харна уу.

Дорноговь аймагт, Улаанбаатар Төмөр замын аялал жуулчлалын төвөөс зохион байгуулдаг Хамарын хийд, Ханбаянзүрх чиглэлийн 2 шөнө 3 өдрийн (галт тэргэнд хононо) аялал мөн жил болгоны 1-сарын 1-нд болдог Багахангай дүүргийн Хангай өртөөний "Шинэ оны анхны нар харах" аялал зэргийг тогтмол төлөвлөж, хэрэгжүүлж байна.

(2) Авто Зам

1) Говьсүмбэр аймаг

Улаанбаатар хотоос Замын-Үүд хүртэлх төв замаас салаад Чойр хотын төв хүртэл, мөн Чойр хотын төвийн замын зарим нэг хэсэг нь хатуу хучилттай, бусад зам нь шороон зам байдаг.

2) Дорноговь аймаг

Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх төслийн хүрээнд АХБ, БНСУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээл, Мянганы сорилтын сангийн хөрөнгө оруулалт, санхүүжилтээр Чойр-Сайншанд-Замын-Үүд чиглэл буюу АН-3 чиглэлийн авто зам ашиглалтад орсноор Улаанбаатар хоттой 432 км, Замын-Үүд сумтай 232 км авто замаар холбогдож, улсын замаас Сайншандын төв рүү 6.9 км авто зам хатуу хучилттай болсон.

Сайншандаас Хамарын хийд хүртэл 42 км авто замтай. Сайншанд нь, хот дотор нийт 11,4 км авто замтай. Улсын чанартай авто замаас Сайншанд хот руу 3км замаар холбогддог.

Сайншанд хотын хэмжээнд хөнгөвчилсөн хучилттай авто зам 18.1 км, цемент бетон хучилттай авто зам 5.4 км, хайрган хучилттай авто зам 2.2 км, 19 метр урт төмөр бетон гүүр, 93 метр бетон хоолой ашиглагдаж байна. Аймгийн төвөөс бүх сумдтай ердийн хөрсөн замаар холбогдсон.

Хүснэгт 3-35: Дорноговь аймгийн төв болон сумдын хоорондох зай

Но.	Сумын нэр	Зай /км/	Замын нөхцөл	Но.	Сумын нэр	Зай /км/	Замын нөхцөл
1	Айраг	124	Хатуу хучилттай зам	8	Өргөн	61	Сайжруулсан шороон зам
2	Алтанширээ	84	Сайжруулсан шороон зам	9	Сайхандулаан	97	Сайжруулсан шороон зам
3	Даланжаргалан	149	Хатуу хучилттай зам	10	Хатанбулаг	230	Сайжруулсан шороон зам
4	Дэлгэрэх	137	Сайжруулсан шороон зам	11	Хөвсгөл	161	Сайжруулсан шороон зам
5	Иххэт	162	Сайжруулсан шороон зам	12	Улаанбадрах	133	Сайжруулсан шороон зам
6	Замын-Үүд	218	Хатуу хучилттай зам	13	Эрдэнэ	103	Хатуу хучилттай зам
7	Мандах	170	Сайжруулсан шороон зам				

Эх сурвалж: Дорноговь аймаг

Тус аймагт байнгын ажиллагаатай Замын-Үүд (Замын-Үүд сум), Ханги (Хатанбулаг сум) хилийн боомтууд байдаг. Дээр дурдсанчлан Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн 432 км хатуу хучилттай авто замтай. Одоогоор Сайншанд-Зүүн баян-Хөвсгөл сум-Ханги боомт хүртэлх хатуу хучилттай 290 км авто замыг сайжруулахаар төлөвлөж байна.

Хатанбулаг сумын Ханги хилийн боомт, зүүн баян чиглэлийн авто зам ашиглалтад орвол хилийн бүсийн аялал жуулчлал хөгжүүлэхэд ихээхэн ач холбогдолтой болох юм. Хатанбулаг суманд хилийн бүсийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор нэг ээлжид 2000 жуулчин хүлээн авах хүчин чадалтай “Анчин отог” жуулчны бааз байгуулагдсан.

Орон нутгийн авто замын сүлжээг сайжруулах зорилгоор орон нутгийн замын санг бүрдүүлэн ажиллаж, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвараас жилдээ 170-190 сая төгрөгийг орон нутгийн замын санд төвлөрүүлэн шинээр зам барих, засвар шинэчлэлийн ажилд зарцуулж байна.

Цаашид бүс нутгийн хөгжлийн хүрээнд Сайншандаас Хамарын-хийд-Зүүнбаян-Хөвсгөл-Ханги-мандал хүртэлх чиглэлд 260 км хатуу хучилттай хар зам, Сайншандаас Сүхбаатар аймгийн Баруун-Урт сум хүртэл сайжруулсан хайрган хучилттай авто замыг улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, уул уурхай компаниудын дэмжлэгтэйгээр барихаар төлөвлөөд байна.

(3) Цэвэр ус

1) Дорноговь аймаг

Дорноговь аймгийн Мандах, Сайхандулаан, Дэлгэрэх, Улаанбадрах зэрэг сум нь 1-2 км-ийн зайнаас ачааны машинаар ундны усаа тээвэрлэдэг. Айраг, Алтанширээ, Иххэт, Даланжаргалан, Өргөн, Сайншанд, Хөвсгөл, Хатанбулаг, Эрдэнэ, Замын-Үүд зэрэг сум нь дамжуулах хоолойгоор усны станцуудтай холбогддог.

Ундны ус нь фтор, хүнцэл, уран зэрэг 2-3н параметрийн чанарын шаардлагыг хангадаггүй. Тиймээс Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх сан, Бүс нутгийн хөгжлийн сан, компаниудын санхүүжилтээр 2017 онд 3, 2018 онд 2, 2019 онд 5, 2020 онд нийт 17 худаг гаргах бөгөөд цэвэрлэх төхөөрөмж, ус зөөлрүүлэх төхөөрөмж суурилуулсан.



Эх сурвалж: Аймгийн засаг Даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс

Зураг 3-9: Сайншанд сумын ус түгээх цэг

Түүнчлэн тус аймгийн Сайншанд, Айраг, Замын-Үүд сумдад цэвэр усны нийт 13 үйлдвэр үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд аймгийн иргэд ундны ус болгон худалдан авч хэрэглэдэг байна.



Эх сурвалж: Аймгийн засаг Даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс

Зураг 3-10: “Оргих Доргио”, “Үлэмж” цэвэр усны үйлдвэр

Дорноговь аймгийн Засаг даргын 2020-2024 оны мөрийн хөтөлбөрт ундны усны хангамжийг хөгжүүлэх чиглэлээр дараах ажлуудыг тусгасан болно.

Хүснэгт 3-36: Дорноговь аймгийн Засаг даргын 2020-2024 оны мөрийн хөтөлбөр (Ундны усны хангамжийг сайжруулах)

Холбогдох заалт	Ундны усны хангамжийг сайжруулах төлөвлөгөөний агуулга
5.1.2	Усны нөөцийг бохирдол, хомсдолоос сэргийлэх, хүн амыг баталгаат ундны усаар хангах нэгдсэн менежментийг сайжруулна.
5.1.2.1	Газрын доорх усны чанар, нөөцөд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээг хэрэгжүүлнэ.
5.1.2.2	Сумын төвүүдийн ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийг нарийвчлан тогтоож мөрдүүлж хэвшүүлнэ.
5.1.2.3	Булаг, шанд, рашааны ундаргын эхийг хамгаалж, тохижуулах ажлыг үргэлжлүүлнэ.
5.1.2.4	Сумдын ундны усыг чанарыг шинжилгээнд хамруулж, цэнэгжүүлэх төхөөрөмжийг суурилуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, стандартын шаардлага хангасан ундны усаар хангана.

Эх сурвалж: Дорноговь аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт үндэслэн Судалгааны баг нэгтгэн боловсруулав.

(4) Бохир ус

1) Говьсүмбэр аймаг

Чойр хотод бохир ус цэвэрлэх байгууламж байдаг боловч бохир усны хоолойд холбогдоогүй айл өрх, байгууламжаас гарсан бохир усыг бохир ус цэвэрлэх машинаар шууд хогийн цэг рүү аваачиж хаядаг.

2) Дорноговь аймаг

Одоогоор Сайншандад ашиглагдаж байгаа бохир ус цэвэрлэх байгууламж нь 1986 онд баригдсан бөгөөд тоног төхөөрөмжийн эвдрэлээс болж 1993 оноос хойш технологийн дагуу ажиллаж чадахгүй болсон. Өдгөө 27 дахь жилдээ бохир ус шингээх даланд татан төвлөрүүлж, картын системээр дамжуулан тунгааж байгальд хаяж байна.

Тус аймаг нь АХБ-ны хөнгөлөлттэй зээлийн төслөөр Сайншанд сумын 2-р багт 3000м³/хоног хүчин чадал бүхий цэвэрлэх байгууламжийг шинээр барихаар болж, нээлтийн арга хэмжээг 2019 оны 05 дугаар сарын 17-ны өдөр хийсэн байна. Цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажлыг АХБ-ны 3,6 сая ам долларын хөрөнгө оруулалтаар Турк улсын “ННС” ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд ашиглалтад орсноор хоногт 1000м³ саарал ус боловсруулах хүчин чадлаар саарал усыг ногоон байгууламжийн усалгаа, үйлдвэрлэлийн технологийн үйл ажиллагаанд ашиглах боломж бүрдэнэ. Гэвч одоогоор Ковид-19 ийн нөлөөгөөр барилга угсралтын ажил хугацаанаасаа хоцорч байгаа болно (Зураг 3-13).

Мөн Сайншанд сумын 4,7-р багт төвлөрч буй бохир усыг шинээр баригдах цэвэрлэх үйлдвэртэй холбох 4.4 км шугамын угсралтын ажлыг хийж дууссан байна.



Эх сурвалж: Аймгийн засаг Даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс

Зураг 3-11: Сайншанд сумын 4,7-р багт байрших цэвэрлэх байгууламж



Эх сурвалж: Аймгийн засаг Даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс

Зураг 3-12: Сайншанд сумын 1,2,3,6-р багт байрших цэвэрлэх байгууламж



Эх сурвалж: Судалгааны баг



Зураг 3-13: Сайншанд сумын 2-р багт байрлах 3000 м³/хоног хүчин чадал бүхий цэвэрлэх байгууламж (Одоохондоо ашиглаагүй байгаа)

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны мөрийн хөтөлбөрт аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулж, цэвэрлэх байгууламжаас гарсан саарал усыг дахин ашиглах боломжийг судлах мөн аялал жуулчлалын газруудын ариун цэврийн байгууламжийг боловсронгуй болгох жишиг төсөл хэрэгжүүлэх, сайн туршлагыг дэлгэрүүлэх зэрэг зэрэг бохир усыг цэвэрлэх талаарх ажлуудыг хэрэгжүүлэхээр заагаад байна.

(5) Хог хаягдлын менежмент

1) Дорноговь аймаг

Дорноговь аймгийн ИТХ-ын 2019 оны 06 сарын 10-ны өдрийн 11/02 тоот тогтоолоор “Энгийн

хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам”-ыг батлан, өдгөө хэрэгжүүлж байна. Энэ журмаар энгийн хог хаягдлыг Сайншанд сумын хэмжээнд ангилан цуглуулах, дахин боловсруулах боломжтой хог хаягдлын төрөл, түүнийг боловсруулах, ашиглах эрх зүйн зохицуулалт, хогны хураамж, суурин газрын хог хаягдлыг устгах зааварчилгаа зэргийг нарийвчлан зааснаас гадна, хог хаягдлын асуудлаар бүх шатны байгууллагын хэрэгжүүлэх үүрэг хариуцлага, эрхийн талаар тусгасан байна. Сайншанд хотын хувьд хог хаягдлыг цуглуулах, булшлах нэг цэгтэй бөгөөд хотын ойролцоох аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагууд мөн энэ журмын дагуу хаягдлаа тээвэрлэн устгуулдаг. Сум бүр суурин газрын ойролцоо хог хаягдлыг цуглуулж, булшлах тодорхой цэгүүдтэй. Сайншанд суманд өдөрт 25-35 тонн хог хаягдал тээвэрлэгдэн хогийн цэгт төвлөрдөг. Хог хаягдлын 60 орчим хувь нь дахин боловсруулах боломжтой зүйлс байдаг гэсэн судалгаа бий. Иймээс хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрийг 2020 он 8-р сард байгуулсан бөгөөд хялгар уут, хуванцар савыг цуглуулан нягтаршуулж, дахин боловсруулан хотын гудамж талбайг тохижуулах, сандал, хайс хийх боломжтой үйлдвэр юм байна. “Эко говь” төслийн хүрээнд хог хаягдлыг ялгах, дахин ашиглах үйлдвэрийн газрын асуудлыг шийдвэрлэн хэрэгжүүлсэн байна. Тухайн байгууллага нь цаашдаа жижиг, дунд үйлдвэрийн төсөлд хамрагдан модны үртэс, шил зэрэг бүтээгдэхүүний хог хаягдлаар бүтээгдэхүүн хийхээр төлөвлөн ажиллаж байна.



Эх сурвалж: Аймгийн засаг Даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс

Зураг 3-14: Хуванцар хог хаягдал цуглуулах сав



Эх сурвалж: Аймгийн засаг Даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс

Зураг 3-15: "Эко-Говь" төслийн сандал ба хайс

Одоогийн байдлаар Улаанбаатар хотоос Замын-Үүд хүрэх авто зам дагуу хог хаягдлыг цуглуулан булшлах ямар нэгэн цэг байхгүй. Мөн Хамарын хийдийн цогцолбор, Бүрдэнэ булаг, Их Нарт зэрэг аяллын үзмэрүүдийн ойролцоо хогийн савыг байршуулсан боловч тухайн орчинд устгах боломжгүй тул суурин газарт тээвэрлэн булшилдаг.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2020-2024 оны мөрийн хөтөлбөрт хог хаягдлын менежментийг сайжруулж, дахин боловсруулах үйлдвэрлэлийг дэмжихийн зэрэгцээ зарим сумдын хог хаягдлыг ангилан төвлөрүүлэх, аюултай хог хаягдлыг цуглуулах цэг байгуулж ажиллахаар төлөвлөсөн байна. Одоогоор Сайншанд сумаас бусад сумдад ангилан төвлөрүүлж байгаа цэг байхгүй. Тус аймагт 16 хогийн цэг (106 га) байдаг бөгөөд хог хаягдлыг эдгээр газарт булдаг байна.

(6) Эрчим хүч, харилцаа холбоо

1) Говьсүмбэр

Чойр хот нийтдээ төвийн эрчим хүчний сүлжээнд холбогдсон. Гар утас ч чөлөөтэй ашиглах боломжтой.

2) Дорноговь

Тус аймаг нь 14 сумтай бөгөөд бүгд төвийн эрчим хүчний сүлжээнд холбогдсон тул цахилгаан хангамж тогтвортой байдаг. Багануур-Сайншанд 220 кВ, Сайншанд-Замын-Үүд 110 кВ, Сайншанд-Зүүнбаян 35 кВ чиглэлийн төвийн цахилгаан хангамж, Сайншанд, Өргөн сумдын нутаг дэвсгэрт орших “Салхин парк 55МВт”, Сайншанд сумын “Нарны цахилгаан станц 30МВт”, “Замын-үүд сумын нарны цахилгаан станц 15МВт” гэх мэт байгалийн сэргээгдэх эрчим хүчний хангамжтай газар ч байдаг.



Эх сурвалж: Аймгийн засаг Даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс

Зураг 3-16: Сайншанд сумын салхин парк



Эх сурвалж: Аймгийн засаг Даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс

Зураг 3-17: Замын-үүд сумын нарны цахилгаан станц



Эх сурвалж: Аймгийн засаг Даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс

Зураг 3-18: Сайншанд сумын төвөөс зүүн тийш орших нар салхины цахилгаан станцын байршил

Тус аймгийн Мандах, Хатанбулаг сум салхин цахилгаан станцтай, бусад сумд төвийн өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугамд холбогдсон. Дээрх хоёр сумыг нэгдсэн шугамд холбох ажлыг эхлүүлсэн.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2020-2024 оны мөрийн хөтөлбөрт, Сайншанд сумын

дулааны станцын хүчин чадлыг нэмэгдүүлэх судалгааны ажлыг хийлгэж, барилгын ажлыг эхлүүлэх, Чойр-Сайншандын 230 км урттай 220 кВт-ын хүчдэлтэй цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барих, Мандах, Сайхандулаан сумдад халаалтын зуух, нэгдсэн инженерийн шугам барих ажлыг хийж, үе шаттайгаар хэрэгжүүлэх, Улаанбаатар төмөр замын харьяаны халаалтын зуух, инженерийн шугам сүлжээг орон нутагт авах ажлыг судлах зэрэг үйл ажиллагаа тусгагдсан байна.

(7) Үйлчилгээний цэгүүд (түр амрах газар, бие засах газар)

1) Дорноговь аймгийн Мандалговь хотын чиглэл

Улаанбаатар хотоос Замын-Үүд сум хүртэл 681 км хатуу хучилттай замтай. Багахангай дүүрэг, Чойр хот, Сайншанд, Замын-Үүд суманд үйлчилгээний төвүүд төвлөрсөн байх ба авто зам дагуу 7-н байршилд түр буудаллах, хооллох газар байдаг. Эдгээрийн нэг болох Чойр хотын Дугуй хэмээх үйлчилгээний төв нь нийтийн бие засах газрын хувьд боловсон, хоолны газар, хүнс болон ахуйн хэрэглээний барааны дэлгүүртэй бол бусад нь зөвхөн хоолны үйлчилгээ үзүүлдэг байна.

Хүснэгт 3-37: Зам дагуух байгууламж, үйлчилгээний төрөл

	Байршил	Улаанбаатар хотоос алслагдсан зай	Байгууллагын нэр	Үйлчилгээний нэр төрөл
1	Мааньт /Төв аймгийн Баян сум/	120 км	“Болор-1” зоогийн газар	Хоолны үйлчилгээ, Бие засах гадаах жорлон
2	14-р зөрлөг	150 км	Зоогийн газар	Хоолны үйлчилгээ, Бие засах гадаах жорлон
3	Чойр хот	235 км	Дугуй төв	Ресторан, Нийтийн бие засах тохилог газар, Мини дэлгүүр, Дэн буудал, Дугуй засвар
4	25-р зөрлөг /Алаг толгойн нүүрсний уурхай/	300 км	Зоогийн газар	Хоолны үйлчилгээ, Бие засах гадаах жорлон, Хүнсний дэлгүүр
5	Даланжаргалан сум	310 км	“Болор-2” зоогийн газар	Хоолны үйлчилгээ, Бие засах гадаах жорлон
6	Айраг сум	330 км	“Бабу” зоогийн газар	Хоолны үйлчилгээ, Бие засах гадаах жорлон
7	Сайншанд сум	426 км	Зоогийн газрууд	2 зоогийн газартай, Бие засах гадаах жорлон

Эх сурвалж: Судалгааны баг

Хүснэгт 3-37-д харуулсанчлан Сайншанд сумын 4-р багт нийтийн бие засах газар байдаг (Зураг 3-19). Сайншанд сумын төвийн дөрвөн замын уулзварын баруун хойд талд, төв цэцэрлэгт хүрээлэн гэсэн 2 байршилд боловсон үйлчилгээтэй нийтийн бие засах байгууламж байдаг (Зураг 3-20 баруун талынх). Хамарын хийд, Шамбалын орон, Ханбаянзүрх хайрхан орчимд нийтдээ шинэ хуучин 7 нийтийн бие засах байгууламжтай. Зарим жуулчны баазад боловсон бие засах газар байдаг. Бусад бааз болон гэр үйлчилгээ үзүүлдэг газарт нүхэн жорлонтой. Хийдийн урд байрлах боловсон бие засах газар нь (Зураг 3-20 зүүн талынх) доороо танктай, бохирыг соруулдаг байхаар бүтээсэн боловч халаалтгүйн улмаас шугам нь хөлдөх гэх мэтээр эвдрэл үүсэж ажиллагаагүй болсон. Энэ нь техникийн доголдол эсвэл барилгын алдаанаас болсон эсэхийг судалж, дүгнэх шаардлагатай. Боловсон бие засах газар бол жилийн турш цахилгаанд холбогдсон байдаг тул хөлддөггүй.



Эх сурвалж: Судалгааны баг

Зураг 3-19: 4-р багийн нийтийн бие засах газрын жишээ



Эх сурвалж: Судалгааны баг



Зураг 3-20: (Зүүн) Хамарын хийдийн урд байрлах боловсон бие засах газар, (Баруун) Сумын төвийн боловсон бие засах газар

3.2.5 Жуулчдын чиг хандлага

Зураг 3-21-д Сайншандын Хамарын хийд, Ханбаянзүрх уул, Хүслийн ууланд аялсан жуулчдын тоог (гадаад, дотоодын жуулчин тус бүрээр) харуулж байна.



Эх сурвалж: Хамарын хийд орчмын хамгаалалтын захиргааны дарга Ш.Байгалмаа

Зураг 3-21: Жуулчдын тоо (гадаад, дотоодын жуулчин тус бүрээр)

Одоогоор Дорноговь аймаг руу аялсан нийт жуулчдын тоог нарийн тодорхой мэдэх арга байхгүй ба аймгийн алдартай аялал жуулчлалын газруудаар зочлогчдын нийт тоог дээрх Зураг 3-21-д

үзүүлэв. Хамарын хийд мөн ойролцоох энергийн төв нь алдартай аялал жуулчлалын газар юм. Жуулчдын ихэнх нь дотоодын жуулчид бөгөөд гадаадын жуулчдад сайн танигдаагүй газар тул, гадаадын жуулчдын тоо тогтмол 2000 орчим байдаг. Харин дотоодын жуулчдын тоо 2014 онд өмнөх оны 40,200 хүнээс 94,553 хүн болж, 2015 онд бүр 110,574 хүн болж огцом нэмэгджээ. 2015 оноос хойш жуулчдын тоо цөөрч ирсэн байгаа нь тухайн бүс нутагт жуулчдын сонирхлыг татах зүйл бага байгаа эсвэл хүлээж авах газрын үйлчилгээ муу гэх мэт шалтгааны аль нь болох нь тодорхой байдаггүй.

3.2.6 Аялал жуулчлалын салбарын чиг хандлага

1) Дорноговь аймаг

Дорноговь аймгийн аялал жуулчлалын салбарт нийт 1024 хүн ажиллаж байгаа бөгөөд тус аймгийн нийт ажил эрхлэгчид болох 33,346 хүн (2019) тэй харьцуулж үзэхэд аялал жуулчлалын салбарын эзлэх хувь бага хэвээр байгаа нь харагдаж байна. Энэ нь эсрэгээрээ аялал жуулчлалын салбарыг хөгжүүлснээр ажилгүй иргэдийг ажилтай болгох эерэг нөлөө ихтэй гэж хэлж болох юм.

Хүснэгт 3-38: Дорноговь аймгийн аялал жуулчлалын салбарын ажилтны тоо

	Байгууллагын төрөл	Тоо	Ажилтны тоо
1	Зочид буудал	20	177
2	Дэн буудал	15	Тодорхой бус
3	Жуулчны бааз	6	40
4	Амралтын газар	3	21
5	Рашаан сувилал	3	25
6	Орон сууц түрээслэгч	20	40
7	Тур оператор /тур агент	5	30
8	Ресторан	30	180
9	Автомашин түрээслэгч	11	11
10	Хөтөч	-	50
11	Музей /Хийд	12	150
12	Гар урлал (бэлэг дурсгалын зүйл)	-	300
Нийт хүний тоо			1,024

Эх сурвалж: Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар

3.2.7 Аялал жуулчлалын маркетинг, сурталчилгааны байдал

1) Дорноговь аймаг

Тус аймгийн веб сайт нь зөвхөн монгол хэлээр мэдээлэл гаргадаг. Аймгийн аялал жуулчлалтай холбоотой цэс байдаггүй бөгөөд "Аймгийн тухай" гэсэн цэсийг нээхэд аймгийн хүн ам, эдийн засгийн талаарх үндсэн статистик тоо баримтыг танилцуулсан байна. "Аймгийн 9 гайхамшиг" гэсэн хэсэгт орж үзвэл аймгийн 9 үзэсгэлэнт газрын нэг нэг л зураг байх агаад өөр зураг ч байхгүй зургийн тайлбар ч байхгүй байна. Энэхүү веб сайт нь гадаадын байтугай дотоодын жуулчдын мэдээлэл авах хэрэгцээг хангаж чадахааргүй байна.

Нөгөөтээгүүр, Дорноговь аймгийн аялал жуулчлалын мэдээллийн төв байгуулж, тус аймгийн аялал жуулчлалын салбарын мэдээлэл, хоноглох газрын танилцуулга, видео танилцуулга, байгаль, түүхийн тухай гэх мэт нийт 15 ширхэг мэдээллийг монгол хэлээр бэлтгэн Facebook -т байршуулсан байгаа бөгөөд 40,000 гаруй хүн үзжээ.



Эх сурвалж: Дорноговь аймаг

Зураг 3-22: Сайншанд сумын аялал жуулчлалын мэдээллийн төв

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны эрхлэн гаргасан Mongolia Travel платформд аялал жуулчлал эрхлэгч бүхий л байгууллагууд өөрсдийн сурталчилгаагаа байршуулж болох бөгөөд #FeelMongolia хаштагаар аялагчид олон нийтэд өөрийн аяллын сэтгэгдлийг бичиж байршуулах боломжтой.³⁹ Мөн Trip Advisor зэрэг аяллын платформуудад сурталчилгааг байршуулж байна.



Эх сурвалж: www.dornogovi.gov.mn/home

Зураг 3-23: Дорноговь аймгийн веб сайтын зураг

Англи хэл дээр хэдхэн тооны веб сайт⁴⁰ байдаг ба мэдээллийн хэмжээ ч бага, хамгийн сүүлийн шинэчлэлт нь 2017 онд хийгдсэн байна. Аялал жуулчлалын агентлаг болох Legend Tour⁴¹ -ын сайт байдаг боловч дотоод, гадаадын жуулчдад зориулсан сурталчилгаа гэхэд хангалтгүй мэдээлэлтэй байгаа юм.

Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь 2009 оноос хойш зохион байгуулагдаж буй "International Travel Mart" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцож, тус аймгийн аялал жуулчлалын байгууллагуудын үйл ажиллагааг сурталчилж ирсэн. Түүнчлэн Дорноговь аймаг нь "ITM-2016" аялал жуулчлалын олон улсын үзэсгэлэнгийн түншийн хувиар Монголын аялал жуулчлалын холбоотой хамтран үзэсгэлэн гаргажээ. Энэхүү олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд аймгийн аялал жуулчлалын холбоо байнга оролцож ирсэн юм. Тус аймгийн аялал жуулчлалын салбарт яаралтай шийдэх шаардлагатай тулгамдаж буй нэгэн чухал асуудал бол маркетинг сурталчилгааны ажил хоцрогдож буй байдал. Гадаадын зах зээлд зориулсан албан ёсны веб сайт байхгүй, тогтмол мэдээлэл, сурталчилгаагаа түгээдэг ямар нэгэн хэрэгсэл байхгүй, Монголын аялал жуулчлалын холбооноос жил бүр зохион байгуулдаг ITM - с өөр үзэсгэлэнд оролцдоггүй, мэдээлэл нь зөвхөн төрийн байгууллагуудын веб сайтаар дамжиж

³⁹ <https://m.facebook.com/Mongolia-Travel-Community-1382468838739101/>

⁴⁰ http://www.drben.net/Mongolia_Report/Aimag/Dornogovi/Dornogovi_Province-Index.html

⁴¹ <https://www.legendtour.ru/eng/about.shtml>

түгээгддэг зэрэг дутагдал байна.

3.2.8 SWOT шинжилгээ

Дорноговийн аялал жуулчлалын маршрут нь, Хамарын хийд, Энергийн төв зэрэг алдартай газрууд нь дотоодын жуулчдыг татдаг боловч энэ бүс нутгийн аялал жуулчлалын нөөц бүрэн судлагдаагүй, мэдээлэл хэтэрхий дутмаг байгаа юм. Мөн Хамарын хийд хүрэх замаас бусад зам хатуу хучилтгүй тул ажил жуулчлалын газруудад очиход хүндрэлтэй байдаг. Нөгөөтээгүүр, нийслэл Улаанбаатар болон БНХАУ-ыг холбосон төмөр зам, хатуу хучилттай авто зам нь тус аймгаар дайрдаг тул, Дорноговь аймгийн төвийн төмөр замыг ашигласан аяллыг хөгжүүлэх боломжтойгоос гадна, "Замын-Үүд" чөлөөт бүс бүтээн байгуулагдсаны дараа БНХАУ-ын худалдаачид, жуулчид тус улсад зочилж аялал жуулчлал, худалдаа үйлчилгээг хөгжүүлнэ гэсэн найдлага ч байгаа болно. Гэвч, энэ маршрутын талаарх мэдээлэл гадаад хэл дээр бараг байдаггүй бөгөөд бусад маршрутын адил баталгаатай, найдвартай мэдээллийг гадаад улс орнуудад түгээж чадахгүй байгаа юм.

Доорх хүснэгтэд Дорноговийн аялал жуулчлалын маршрутын давуу болон сул талуудын SWOT шинжилгээг харуулж байна.

Хүснэгт 3-39: Дорноговийн аялал жуулчлалын маршрутын давуу болон сул талууд (SWOT шинжилгээ)

	Нөөц бололцоо		Хязгаарлах нөхцөл	
	Давуу тал	Strength	Сул тал	Weakness
Дотоод орчин	<p><u>Аялал жуулчлалын нөөц</u></p> <ul style="list-style-type: none"> -Хамарын хийд, Энергийн төв -Их нартын БНГ -Загийн ус БНГ (Заг гэдэг нь цөлийн мод юм) -Сүйхэнтийн чулуужсан ой -Чингис хааны алтан ургийн овог Боржигин овог -Монгол улс, БНХАУ-ын хилийн боомт хот Замын -Үүд -Төмөр замын аялал, говийн нар жаргах агшин <p><u>Дэд бүтэц</u></p> <ul style="list-style-type: none"> -Орос-Хятад-Монголын хойноос урдыг холбосон төмөр замтай -УБ хотоос БНХАУ-ын хил хүртэл 432 км хатуу хучилттай замтай -Замын -Үүд суманд Эдийн засгийн чөлөөт бүс байгуулагдаж байгаа -Сумын төвүүд харилцаа холбоо, цахилгаан, эрчим хүчний сүлжээнд бүрэн холбогдсон <p><u>Үйлчилгээ</u></p> <ul style="list-style-type: none"> -Зам зуур түр амрах цэг болох Чойрт амарч алжаал тайлах байгууламж байдаг -Дотоодын аялагчдад зориулсан хоноглох, отоглох цэгүүдтэй 		<p><u>Аялал жуулчлалын нөөц</u></p> <ul style="list-style-type: none"> -Гадаадын жуулчдын сонирхлыг татах аялал жуулчлалын нөөцийг бүрэн дүүрэн хөгжүүлээгүй <p><u>Дэд бүтэц</u></p> <ul style="list-style-type: none"> -Төмөр замыг ашигласан аялал жуулчлалын хөтөлбөр ховор байдаг -Нисэх буудал байдаггүй <p><u>Хууль / дүрэм</u></p> <ul style="list-style-type: none"> -Байгалийн нөөцийн хамгаалалт хангалтгүй -Дорноговь аймагт аялал жуулчлалтай холбоотой хөгжлийн хөтөлбөр бараг байдаггүй -Аялал жуулчлалын салбар дахь төр, хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагаа сул, дутмаг <p><u>Үйлчилгээ</u></p> <ul style="list-style-type: none"> -Аялал жуулчлалын компаниуд хөгжөөгүй -Аялал жуулчлалын үйлчилгээний чанар муу -Бэлэг дурсгалын төрөл зүйл хөгжөөгүй -Гадаадын жуулчдын эрэлт хэрэгцээг хангаж чадах хоноглох газар дутмаг -Мэдээлэл / Маркетинг -Мэдээлэл түгээлт хангалтгүй 	

	Боломж Opportunity	Аюул занал Threat
Гадаад орчин	<u>Дэд бүтэц</u> -Төмөр замын аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой -Орос-Хятад-Монголын олон улсын аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөөнд багтдаг <u>Мэдээлэл / Маркетинг</u> -Хил орчмын БНХАУ-ын жуулчдыг татах боломжтой	<u>Хууль / дүрэм</u> -Уул уурхайн хөгжил нь байгаль орчныг сүйтгэдэг -Жуулчид ихэссэнтэй холбогдуулан нэн ховор, зэрлэг амьтад цөөрч байгаа <u>Мэдээлэл / Маркетинг</u> -БНХАУ-ын жуулчид ихсэх тохиолдолд, үндсэрхэг үзэлтэй холбоотой асуудлууд үүсэж болзошгүй -Өвөр Монголын зах зээлтэй өрсөлдөх шаардлагатай -Худалдаа, бизнесийн үйл ажиллагаа нь аялал жуулчлалын үйл ажиллагаанаас дээгүүрт тавигддаг

Эх сурвалж: Судалгааны баг

(1) Дорноговийн аялал жуулчлалын маршрутыг хөгжүүлэх давуу тал

1) Аялал жуулчлалын нөөц

- ① Дорноговийн аялал жуулчлалын маршрут нь, Чингис хааны алтан ургийн Боржигин овогтын нутаг болох Гомьсүмбэр аймаг, Хамарын хийд, Энергийн төв байрладаг Дорноговь аймгийг хамаардаг.
- ② Аялал жуулчлалын үзмэр болон хөгжөөгүй газар олон, цаашдын хөгжлийн бодлого стратегиас хамааран хөгжих нөөц бололцоо ихтэй.
- ③ Дотоодын жуулчид нь, суут лам, говийн догшин ноён хутагт Данзанравжаа биедээ энерги хуримтлуулдаг байсан гэгдэх Энергийн төв болох Шамбалын орон, Хамарын хийд, Их нартын БНГ, Хашаатын говийн элс, Цагаан Дэлийн агуй гэх мэт аялал жуулчлалын газруудаар их аялдаг.

2) Дэд бүтэц

- ① Нийслэл Улаанбаатар хотоос Дорноговь аймгийн Замын -Үүдийн хилийн боомт хүртэлх 432 км замыг (MR100) хатуу хучилттай болгосноор авто машинаар зорчиход амар хялбар болсон.
- ② Бээжин, Москва хотыг холбосон олон улсын төмөр замын Монголын хэсэг болох Улаанбаатар төмөр замын сүлжээ нь энэ бүс нутгаар дайрч өнгөрдөг. Одоохондоо голчлон ачаа тээвэрлэдэг боловч цаашид гадаадын иргэдэд зориулсан галт тэрэгний урт хугацааны аяллыг төлөвлөх боломжтой.
- ③ Дорноговь аймаг нь, хилийн боомт Замын-Үүд ("замын хаалга" гэсэн утгатай) ийн нэр шиг Монгол улс БНХАУ-тай харилцах гол үүд хаалга болж байдаг ба Монголын эдийн засагт амин чухал ач холбогдолтой газар юм. Замын-Үүдийн боомтод эдийн засгийн чөлөөт бүс байгуулагдаж байгаа бөгөөд цаашид Монгол, Хятадын хооронд худалдаа, бизнес эрхэлдэг БНХАУ-ын худалдаачдад чиглэсэн дэлгүүр, худалдааны төв, хил орчмын аялал жуулчлал хөгжих магадлал өндөртэй.

3) Хууль/Дүрэм

- ① Их нартын БНГ-ыг хуулиар хамгаалж, нэн ховор амьтдыг (Янгир) хамгаалахад анхаарч ажиллаж байна.
- ② Дорноговь аймгийн ажилгүйдлийн түвшин 17.8% (2020 оны хүн амын статистик тоо мэдээ) байгаа тул, аялал жуулчлалыг хөгжүүлснээр эдгээр хүмүүсийг ажлын байраар хангаж, бүс нутгийн эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах боломжтой юм.

4) Үйлчилгээ

- ① Зам дагуух түр буудаллах цэг болох Чойрт амарч алжаал тайлах үйлчилгээний байгууламж байдаг
- ② Дотоодын аялагчдад зориулсан хоноглох, отоглох цэгүүдтэй

5) Мэдээлэл / Маркетинг

- ① Хамарын хийдэд аялагсдын тоог харахад, Ковид-19 -н халдвар тархалтын өмнөх 2019 онд дотоодын жуулчид 67,838 байхад гадаадын жуулчид 2,182 буюу гадаадын жуулчдаас 31 дахин их дотоодын жуулчид зорчсон байна. Эндээс харахад Хамарын хийд нь шашин шүтлэг, эргэл мөргөлийн газар гэдгээрээ Монголын аялал жуулчлалд онцгой байр суурь эзэлдэг нь тодорхой байгаа болно.
- ② Замын-Үүдийн боомтод эдийн засгийн чөлөөт бүс байгуулагдаж, БНХАУ-ын худалдаачид ихээр орж ирэх үед дэлгүүр, худалдааны төв, хил орчмын аялал жуулчлал хөгжих магадлал өндөр.
- ③ БНХАУ-ын иргэд ноолууран болон махан бүтээгдэхүүн зэргийг бэлэг дурсгалын зүйл болгон худалдаж авдаг. Өвөрмонголоос хямд тул, Замын-Үүдийн худалдааны төв нь БНХАУ-ын хэрэглэгчдийг татах боломжтой.
- ④ Дорноговь аймаг нь элс хайрган хөрстэй, ургамал тачир сийрэг, өргөн уудам хээр тал бүхий говийн нутаг тул, газар нутгийн ихэнх нь ой мод бүхий Япончуудын хувьд урьд хожид үзэж харж байгаагүй ховор байгалийн үзэмж болох юм. Тэр утгаараа Япон хүмүүсийн сэтгэлийг илүү татах боломжтой бүс нутаг юм.
- ⑤ Төмөр замыг ашигласан, гадаадын иргэдэд зориулсан Талын галт тэрэгний аяллыг хямд үнээр төлөвлөх боломжтой. Галт тэрэгний үйлчилгээг сайжруулах, Сайншандаас аялах маршрутыг төлөвлөх зэрэгт Монголд салбартай Японы аялал жуулчлалын компанийг газар дээр нь урьж зөвлөгөө авах нь зүйтэй болов уу.



Энергийн төв



Чулуужсан ойн мод



Хамарын хийд

(2) Дорноговийн аялал жуулчлалын маршрутын хөгжлийг хязгаарлах нөхцөл

1) Аялал жуулчлалын нөөц

- ① Өвлийн улиралд -40 хэм хүртэл хүйтэрдэг.
- ② Элсэн манхан гэх мэт байгалийн нөөц газрын онцлог шинж чанараараа Өмнөговийн аялал жуулчлалын маршруттай төстэй тул өрсөлдөгч нь болох юм.
- ③ Жуулчид ихэссэний улмаас нэн ховор амьтад үзэгдэх нь цөөрч, нэн ховор амьтдыг ажиглах аяллын тоо буурч байна.

2) Дэд бүтэц

- ① Хамарын хийд хүрэх замаас бусад зам хатуу хучилтгүй, аялал жуулчлалын газруудын хоорондох зай хол байдаг тул, гадаадын жуулчдад чиглэсэн аялал жуулчлалын хөгжил нь онгон байгаль дахь адал явдалт аялалд илүү тохиромжтой.
- ② Аялал жуулчлалын гол газрууд байдаг Хатанбулаг, Даланжаргалан, Хөвсгөл, Дэлгэрэх, Мандах, Алтанширээ, Иххэт сум хүртэлх хатуу хучилттай авто замын өргөтгөлийг хийж чадаагүй хэвээрээ байгаа.
- ③ Улаанбаатар хотоос БНХАУ руу чиглэсэн гол замыг хатуу хучилттай болгосноос хойш Сайншанд руу галт тэргээр зорчих хүмүүсийн тоо буурсан гэсэн хачирхалтай үр дүнд хүрсэн. БНХАУ-ын хилийн боомт Эрэн хотоос бараа, бүтээгдэхүүн тээвэрлэхэд одоо ашиглаж байгаа олон улсын галт тэрэг ч ачааны машинаар солигдох магадлал өндөртэй. Тийм ч учраас энэ цаг үед л галт тэрэгний аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжийг нухацтай авч үзэх ёстой юм.
- ④ Нийслэлээс Сайншанд хүрэх авто замын дагуух Говьсүмбэр аймаг болон аймгийн гол авто зам дагуу үйлчилгээний цогцолбор (Замын өртөө) барих, гол аялал жуулчлалын газруудад гадаадын иргэд ч ашиглаж болох нийтийн бие засах газрыг олноор байгуулахгүй бол аялал жуулчлалын газрын хувьд нэр хүнд буурах магадлалтай. Чойр-Сайншанд-Замын-Үүд хоорондын гол зам дагуу нийтийн бие засах газартай амрах газрыг дор хаяж 2 газарт барих нь зүйтэй.

3) Хууль тогтоомж, дүрэм журам

- ① Аялал жуулчлалын нөөцийг хамгаалах үүднээс ч замын тэмдэг, самбарыг суурилуулах шаардлагатай. Тээврийн хэрэгслүүд замгүй газраас дураараа давхиж байгалийг сүйтгэж болзошгүй юм.
- ② Замын тэмдэг, аялал жуулчлалын мэдээллийн самбар байдаггүй. Байгаль, түүх, соёлын нөөц бүхий Говийн Бага ДЦГ, Их нартын чулуу, Цонж Чулуу, Загийн ус, Эргэлийн Зоо, Сүйхэнтийн чулуужсан ой болон элсэн манхан, Чойрын Богд уул, Хэсэг Байшинт, Олон байшинт зэрэг аялал жуулчлалын үнэ цэнэтэй газруудыг хадгалах, хамгаалах зорилгоор замын тэмдэг, аялал жуулчлалын мэдээллийн самбарыг суурилуулах ёстой.

4) Үйлчилгээ

- ① Гадаадын жуулчдад үзүүлэх үйлчилгээний чанар муу, үйлчилгээний салбар хөгжөөгүй.
- ② Боловсрол, сургалтад хамрагдсан аялал жуулчлалын хөтөч байдаггүй.

5) Мэдээлэл / маркетинг

- ① Гадаадын иргэдэд чиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх үйл ажиллагаа хоцорч байгаа тул мэдээлэл түгээлт ч хангалтгүй байна.
- ② Хамарын хийд болон Энергийн төв нь дотоодын жуулчдын анхаарлыг их татдаг нь шашин, мөргөл, домог гэх мэт талаас бол ойлгомжтой байгаа болно. Аялал жуулчлалын энэ бүс нутгийн зорилтот үйлчлүүлэгч бол дотоодын аялагчид гэдэг нь тодорхой байгаа


боловч 2015 онд хамгийн олон буюу 110,574 хүн болж дээд цэгтээ хүрсний дараа дотоодын жуулчдын тоо буурсаар байна. Энэ нь тухайн бүс нутаг жуулчдын дунд нэр хүнд нь буурсан эсвэл аймгийн маркетинг, сурталчилгааны ажил сайн хийгдэхгүй байгаа гэх мэт шалтгааны аль нь болохыг үнэлж дүгнэж үзэх шаардлагатай.

- ③ Тухайн нутгийн сэтгэл татам байдлыг гадаадын жуулчдад үнэн зөв хүргэх гадаад хэл дээрх мэдээлэл, тэр тусмаа англи хэл дээрх мэдээлэл дутмаг гэж хэлэхээс өөр аргагүй байгаа болно. Аймгийн ЗДТГ-ын мэдээлэл ч англи хэл дээр байдаггүй.
- ④ Гадаадын улс орнуудад чиглэсэн мэдээллийг түгээх төсвийн болон хүний нөөцийн хомсдолтой.

3.3 Хархорины аялал жуулчлалын маршрут

3.3.1 Аялал жуулчлалын нөөцийн тухай

Хархорины бүс нутаг орчмын аялал жуулчлал нь эзэнт гүрний нийслэл байсан Хархорин хотоос эхлээд, Хужиртын рашаан сувилал, Орхоны хүрхрээ зэрэг түүхийн дурсгалт газрууд, нүүдлийн соёлтой ахуй амьдрал хийгээд Хангай нутгийн үзэсгэлэнт байгальтай танилцах боломжтойгоороо онцлог юм. Ийм олон онцлог бүхий аялал гэдгээрээ гадаадын аялагчдын дунд их алдартай. Хархориноос Архангайгаар дамжин дэлхийн хамгийн цэнгэг нуур хэмээгддэг Хөвсгөл нуурыг зорих аяллын маршрут байх ба аялагчид ч их байдаг. Гадаадын жуулчдад зориулсан Архангай аймгийн аяллын чиглэлд Түрэгийн үеийн хөшөө дурсгал бүхий Хөшөө Цайдам, загасчлалаараа алдартай Өгий нуур, Бивако нуураас 4 дахин том хэмжээтэй цэнгэг уст нуур Тэрхийн цагаан нуур, Японы хөрөнгө оруулалтаар байгуулагдсан Цэнхэрийн халуун рашаан гэх мэт газрууд бий бөгөөд эдгээрийг өмнө зүгийн Хархорины аялалтай хослуулах нь түгээмэл байдаг.



Зураг 3-24: Хархорины аялал жуулчлалын маршрут

(1) Архангай аймаг

Архангай аймаг нь 55,300 км² газар нутагтай, 94,948 хүн амтай (2020 он). Ойт хээр, тал хээр нутаг хосолсон, өвөлдөө дунджаар -30 аас -38 хэм хүртэл хүйтэрч, зундаа 25 аас 36 хэм хүртэл халдаг бүс нутаг юм. Аж ахуйн голлох салбар нь мал аж ахуй агаад загасаар баялаг гол мөрөн, галт уул, галт уулын дэлбэрэлтээс үүссэн нуур, өргөн уудам ой хээр, тал нутаг зэрэг байгалийн үзэсгэлэнт газар ихтэй аймаг юм. Тэрхийн цагаан нуур, Цэнхэрийн халуун рашаан мөн эртний нүүдэлчдийн эзэнт гүрний балгас байдаг бөгөөд хуучин чулуун зэвсгийн үеийн олдвор ч ихээр олддог.

Монголын нэрт яруу найрагч Д.Нацагдорж өөрийн шүлэгтээ Монголын байгалийн үзэсгэлэн цогцоор бүрдсэн нутаг гэж Архангай аймгийг магтан шүлэглэсэн байдаг. Ой мод, тал нутгийн ногоон өнгө нь маш үзэсгэлэнтэй. Энэ бүс нутгийг 8-р зууныг хүртэл Түрэг, Уйгарчууд эзэлж байсан бөгөөд тэр үеийн балгас олноор үлдсэн нь бий.

Хүснэгт 3-40: Цэцэрлэг хот (аймгийн төв) орчмын аялал жуулчлалын гол нөөцүүд

Аялал жуулчлалын гол үзмэрүүд	Улирал	Товч мэдээлэл
Тэрхийн цагаан нуур	Тогтмол	Бивако нуураас 4 дахин том хэмжээтэй цэнгэг уст нуур. Нуурын хөвөөнд асар том унтарсан галт уул байдаг бөгөөд байгалийн өвөрмөц тогтоц бүхий үзэсгэлэнт газруудыг эндээс үзэх боломжтой.
Цэнхэрийн халуун рашаан	Тогтмол	Хамгийн анх Японы хөрөнгө оруулалтаар халуун рашаантай жуулчны бааз баригдсан газар. Эрүүл мэндэд тустай төдийгүй арьс, гоо сайханд ч сайн нөлөөтэй гэгддэг.
Өгий нуур	Тогтмол	Рамсарын конвенцид бүртгэлтэй нуур ба загасчлах дуртай хүмүүс ихээр зорьдог.
Эрдэнэбулган сум	Тогтмол	Гайхамшигтай үзэсгэлэнт байгалийн өнгө төрхөөрөө алдартай.

Эх сурвалж : Судалгааны баг

(2) Өвөрхангай аймаг

Өвөрхангай аймаг нь 62,895 км² газар нутагтай, 116,786 хүн амтай (2020 он). Нутгийн баруун хойд хэсгээр Хангайн нурууны салбар уулс, баруун өмнөд хэсгээр Алтай нурууны салбар уулс сүндэрлэж, төв хэсэг нь тал хээрийн өргөн уудам нутагтай. 2000 гаруй жилийн турш их талын нүүдэлчдийн нутаг байсаар ирсэн. Монгол орны хамгийн олон малтай (2020 оны 12 сарын байдлаар 44 сая 790 мянга орчим тоо толгой) аймаг бөгөөд аймгийн иргэд уламжлалт гар урлал, мал аж ахуй зэрэг эртний нүүдэлчдийн соёлын биет бус өвийг өвлөн уламжилж эрхэлдэг. Нутгийн хойд хэсэгт газар тариаланг хөгжүүлсэн, түүнчлэн барилгын материалын үйлдвэр, хүнсний үйлдвэрүүд тус аймагт бий. Одоогийн Хархорин нь Монголын эзэнт гүрний нийслэл Хархорум хот байсан агаад Дэлхийн өв болох Орхоны Хөндийн соёлын дурсгалт газарт 17-р зуунд баригдсан Эрдэнэ Зуу хийд оршдог. Мөн түүнчлэн Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар барьж байгуулсан Хархорум музейд малтлагаар олдсон эртний эд өлгийн зүйл зэргийг үзүүлэн таниулсан байдаг зэрэг түүх, соёлын дурсгалт өв их байдаг.⁴²

Хархорин нь Монголын эзэнт гүрний 2 дахь их хаан Өгэдэй 1235 онд Монголын эзэнт гүрний нийслэл болгосон газар юм. Мин улсын довтолгоонд сүйтгэгдсэн эзэнт гүрний нийслэлийн суурин дээр 1585 онд Бурхны шашны хийд Эрдэнэ Зууг барьсан бөгөөд өдгөө Бурхны шашны музей болон ашиглагдаж байна. Дэлхийн өвд бүртгэгдсэн Орхоны хөндийн нэгээхэн хэсэгт оршдог Хархорин нь гадаадын жуулчдад хамгийн өндрөөр үнэлэгддэг аялал жуулчлалын газруудын нэг юм.

Хүснэгт 3-41: Хархорин орчмын аялал жуулчлалын алдартай газрууд

Аялал жуулчлалын гол үзмэрүүд	Улирал	Товч мэдээлэл
Эрдэнэ Зуу хийд	Тогтмол	1586 онд баригдсан Бурхны шашны хийд бөгөөд өдгөө музей болгосон.
Хархорум музей	Тогтмол	Японы Засгийн газрын буцалтгүй тусламжаар 2011 онд барьж байгуулсан музей. Монголын түүх соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг хадгалж хамгаалах, судлах газар болж байдаг.

⁴² Эх сурвалж: The regions of Mongolia Uvurhangai Aimag

Аялал жуулчлалын гол үзмэрүүд	Улирал	Товч мэдээлэл
Хөшөө Цайдам	Тогтмол	8-р зууны үеийн Түрэгийн эзэгнэлийн түүхэн дурсгал болох, Билгэ хаанд зориулж босгосон гэрэлт хөшөө зэрэг Түрэгийн хаант улсын түүх, соёлтой холбогдол бүхий үнэт эд өлгийн зүйл, олдворыг үзүүлэн таниулдаг.
Хужирт	Тогтмол	Рашаан сувилал (дотоодын аялагчдад зориулсан)
Орхоны хүрхрээ болон Орхоны Хөндий	Тогтмол	Монголд хамгийн алдартай хүрхрээ
Төвхөн хийд	Тогтмол	Монголын анхдугаар Богд Өндөр Гэгээн Занабазар үүсгэн байгуулж, энэ хийдэд сууж байсан гэгддэг. Цэцэг, ургамал элбэгтэй.

Эх сурвалж : Судалгааны баг

3.3.2 Төлөвлөгөө / Аян / Арга хэмжээ

"Алсын хараа 2050" -ын бүс, орон нутгийн хөгжлийн бүлэгт Архангай аймаг, Өвөрхангай аймаг зэрэг Хангайн бүс нутгийг хөгжүүлэх тухайд "Хангайн нурууны экосистем, томоохон голуудын сав дагуух адал явдалт болон Орхоны Хөндийн дурсгалт газрыг түшиглэсэн соёлын аялал жуулчлалын цогцолбор байгуулна" хэмээн тусгасан байгаа бөгөөд байгалийн болон түүх, соёлын баялаг өвийг хадгалж хамгаалахын зэрэгцээ эдгээрт түшиглэсэн аялал жуулчлалыг тэнцвэртэйгээр хөгжүүлэхийг зорьж байгаа нь харагдаж байгаа юм.

"2019-2026 онуудад Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого"-д Өвөрхангай аймгийн нисэх буудлыг олон улсын нисэх буудал болгох, "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл" хавсралт-д Орхоны Хөндийн Нүүдэлчдийн төрт улсын цогцолбор байгуулах, Өвөрхангай аймгийн Хужирт - Төвхөн хийд - Улаан цутгалан чиглэлийн хатуу хучилттай авто зам барих, Орхон голын 220 у/м төмөр бетон гүүрийг барих, Архангай аймгийн Өлзийт - Хөвсгөл аймаг чиглэлийн аялал жуулчлалын авто зам барих улсын төслүүд тусгагдсан байна.

БОАЖЯ нь үйлчилгээний цогцолборуудыг улсын чанартай авто зам дагуу сумдад байрлуулахаар төлөвлөж байгаа юм. Нөгөөтэйгүүр орон нутгийн түвшний аялал жуулчлалын хөгжлийн төлөвлөгөө ч батлагдан гарч, Орхоны Хөндийг хамаардаг 2 аймаг тухайн бүс нутгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх ач холбогдлыг тодорхойлж, аялал жуулчлалын газруудыг онцлог шинжээр нь ангилсан "Орхоны Хөндийн бүс нутгийн аялал жуулчлалын стратеги 2020" -ыг нэгтгэн гаргасан байна. Гэвч, тухайн бүс нутгийг дотоод, гадаадад сурталчлах гэсэн талаасаа хангалттай бус мөн одоогийн байдлаар энэ стратегид үндэслэн байгуулагдсан хороо тодорхой үйл ажиллагаа явуулж чадахгүй байгаа юм.

2020 оны 12 сард аймгийн ИТХ-аар батлагдсан Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт аялал жуулчлалыг хөгжүүлэх тухай "Байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ" хэмээн заагаад Хархорин, Эрдэнэ Зуу музейг холбосон аялал жуулчлалын гудамж байгуулах, аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэх төсөл болон аялал жуулчлалын маршрут тус бүрээр хөгжүүлэх төслийг гарган төлөвлөсөн байна. Хархорин сумаас Архангай аймагт орших Хөшөө цайдам (Түрэгийн үеийн хөшөө дурсгалын музей) аас Өгий нуураар дамжин Зүүн-Баруун төв зам хүрэх замыг 2021 онд барьж эхлэхээр төлөвлөж байна. Энэ замыг барьснаар өмнө болон хойд зүгийн аялал жуулчлал ихэд хялбар болж, аялал жуулчлалын шинэ маршрутыг хөгжүүлэхэд ихээхэн хувь нэмэр болох болов уу.

(1) Өвөрхангай аймгийн аялал жуулчлалын бодлого, төлөвлөгөө

Өвөрхангай аймагт аялал жуулчлалын холбогдолтой олон бодлого, төлөвлөгөө байдаг хэдий ч тэдгээрийн тэргүүлэх чиглэл, хамаарал нь тодорхой бус байна.

Хүснэгт 3-42: Өвөрхангай аймгийн аялал жуулчлалын хөгжлийн бодлогын гол баримт бичиг

	Аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого, төлөвлөгөө	Батлагдсан огноо	Хуудасны тоо	
1	Орхоны Хөндийн бүс нутгийн аялал жуулчлалын стратеги 2020	2017	25	
2	Орхоны Хөндийн БЦГ-ын аялал жуулчлалын менежмент 2017-2021	2017	101	
3	Аймгийн аялал жуулчлалын хөгжлийн бодлогын гол баримт бичиг	Өвөрхангай аймгийн эдийн засгийг 2014-2024 онд хөгжүүлэх бодлогын баримт бичиг	2014	45
4		Өвөрхангай аймгийн Аялал жуулчлалын дэд хөтөлбөр /2018-2022/	2018.04.27	7
5		Аялал жуулчлалын дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө /2019-2022/	2019.12.27	5
6		Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	2020.12.02	36
Бусад холбогдох хөтөлбөр, төлөвлөгөө				
7	Дэлхийн өв - Орхоны Хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргаа	Уг захиргаанаас гаргасан тусгай бодлогын баримт бичиг гэж байдаггүй. "Дэлхийн өвийн конвенц" -д заасан заалтын дагуу үйл ажиллагаагаа явуулдаг.	-	-

Эх сурвалж : Өвөрхангай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар

Хархорин-Орхоны Хөндийн бүс нутгийн аялал жуулчлалын хөгжлийн дараах 2 стратеги төлөвлөгөөг Архангай, Өвөрхангай аймгууд боловсруулж гаргасан байна.

1) Орхоны Хөндийн бүс нутгийн аялал жуулчлалын стратеги-2020⁴³

2018 онд Европын холбоо, Чехийн хөгжлийн агентлагийн санхүүжилтээр Орхоны Хөндийн бүс нутагт орших Архангай, Өвөрхангай аймгийн 10 суманд хэрэгжсэн “Чадваржсан иргэд-Тогтворжсон амьжиргаа” (ЧИ-ТА) төслийн дэмжлэгээр “Орхоны Хөндийн бүс нутгийн аялал жуулчлалын стратеги-2020” төлөвлөгөөг дээрх хоёр аймаг хамтран боловсруулж гаргасан байна. Стратеги хөтөлбөрт аялал жуулчлалын салбарын ач холбогдлыг иргэдэд ойлгомжтой байдлаар тайлбарлажээ.

“Орхоны Хөндийн бүс нутгийн аялал жуулчлалын стратеги-2020”-г үйл ажиллагааг хэрэгжүүлэх талуудын хамтын ажиллагааны хэлбэрийг “Аялал жуулчлалын хөгжлийн хороо” хэмээн нэрлэсэн байна. Тухайн хороо нь, төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшил болон иргэдийн төлөөлөгч 9 хүний бүрэлдэхүүнтэй бөгөөд нарийн бичгийн даргын ажил үүргийг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга гүйцэтгэх юм. Аялал жуулчлалын хөгжлийн хороо нь сум болгонд дэд хороотой байх ба дэд хорооны даргын ажил үүргийг сумдын орлогч дарга гүйцэтгэнэ.

Энэхүү стратеги төлөвлөгөөгөөр тухайн бүс нутгийн алдартай бүтээгдэхүүн, үйлчилгээг илрүүлэн, бүс нутгийн брэнд болгон хөгжүүлэх маркетингийн бодлогыг боловсруулж, брэнджүүлснээр бусад газар нутгуудаас ялгаран, нэр хүндээ өсгөх бөгөөд үүний дүнд тухайн газрыг чиглэх хөрөнгө оруулалт, жуулчдыг татах, нэр хүндийг өсгөх ач холбогдолтой хэмээн үзэж байгаа юм.

2016-2019 оны хооронд 40 компани, 10 сумын боловсон хүчнийг чадавхижуулах сургалтыг Чехийн хөгжлийн агентлагийн санхүүжилтээр (ойролцоогоор 343,315 ам. доллар) хэрэгжүүлжээ. 2020 оны үйл ажиллагааны хүрээнд 2 аймаг хамтран аялал жуулчлалыг хөгжүүлэх хороог

⁴³ <https://montsame.mn/jp/read/93192>

байгуулсан бөгөөд дэд хороодыг Хархорин сум зэрэг 5 суманд байгуулсан боловч одоогоор бодитой ажил хийгдээгүй байна.

2) Орхоны Хөндийн БЦГ-ын аялал жуулчлалын менежмент 2017-2021

Энэхүү төлөвлөгөө нь Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ) -ийн дэмжлэгтэйгээр 2017 онд боловсруулсан ТХГН-ийн аялал жуулчлалын менежментийн төлөвлөгөө юм. Хархорины бүс нутгийн байгалийн үзэсгэлэн болон соёлын өвийг хамгаалах, ТХГН-ийн хамгаалалтын үйл ажиллагааг бэхжүүлэхийн тулд аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, орон нутгийнхны оролцоог хангах, маркетинг мэдээллийн үйлчилгээгээр хангах, аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэх зэрэг тодорхой арга хэмжээг багтаасан төлөвлөгөө болж чадсан. Орхоны Хөндийн БЦГ-ын хамгаалалтын захиргаа нь энэхүү төлөвлөгөөний хэрэгжилтийг үндсэнд нь хангаж амжилттай гүйцэтгэж байна.

3) Өвөрхангай аймгийн эдийн засгийг 2014-2024 онд хөгжүүлэх бодлогын баримт бичиг

2017 онд боловсруулсан энэхүү баримт бичигт Өвөрхангай аймгийн эдийн засгийн дөрвөн тэргүүлэх салбарын (хөдөө аж ахуй, аялал жуулчлал, худалдаа үйлчилгээ ба тээвэр логистик, барилга, барилгын материалын үйлдвэрлэл) дунд болон урт хугацааны зорилтуудыг тодорхойлсон байна. Түүнчлэн Өвөрхангай аймаг нь 2024 онд 1 сая жуулчин хүлээн авахаар төлөвлөж, үүний тулд дөрвөн зорилтыг дэвшүүлсэн байгаа болно. Гэвч, энэхүү бодлогын баримт бичигт хэрэгжүүлэх тодорхой ажлын төлөвлөгөө, төсөв тодорхойгүй байгаа бөгөөд өнөөг хүртэл гүйцэтгэлийн үнэлгээг хийгээгүй байна.

4) Өвөрхангай аймгийн “Аялал жуулчлалын дэд хөтөлбөр” /2018-2022/

Өвөрхангай аймгийн “Аялал жуулчлалын дэд хөтөлбөр” нь 2018 онд аймгийн ИТХ-ын шийдвэрийн дагуу 2018-2022 онуудад хэрэгжихээр батлагдсан 5 жилийн төлөвлөгөөт хөтөлбөр юм. Энэхүү хөтөлбөр нь 4 зорилттой бөгөөд эдгээр зорилтод хүрэхийн тулд хэрэгжүүлэх 21 арга хэмжээг төлөвлөсөн. Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн байдлыг Хүснэгт 3-43, Өвөрхангай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын нэгдсэн үнэлгээг Хүснэгт 3-44-д тус тус үзүүлж байна.

Хүснэгт 3-43: Өвөрхангай аймгийн Аялал жуулчлалын дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн байдал

	Зорилт	Хэрэгжилтийн байдал
1	Аялал жуулчлалыг хөгжүүлэх зохион байгуулалтыг хангах	Хэрэгжиж байгаа
2	Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, түүний дэд бүтцийг хөгжүүлэх	Хэрэгжиж байгаа
3	Аялал жуулчлалын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх	Хэрэгжсэн
4	Аялал жуулчлалын арга хэмжээ /эвент/-г нэмэгдүүлж, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх	Хэрэгжсэн

Эх сурвалж: Өвөрхангай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар

Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд хийсэн аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газрын үнэлэлт, дүгнэлтээс харахад, тухайн арга хэмжээний санхүүгийн эх үүсвэрийг шийдэж чадаагүй, эсвэл санхүүжилт хангалттай бус байсны улмаас хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээ /эвент/-г хэрэгжүүлж чадаагүй гэж үзсэн байна.

Хүснэгт 3-44: Өвөрхангай аймгийн Аялал жуулчлалын дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ (2020 оны эцсийн байдлаар)

Хөтөлбөрийн агуулга		Гүйцэтгэл					
1	Аялал жуулчлалын дэд хөтөлбөр Өвөрхангай аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2018 оны 4-р сарын 27-ны өдрийн 33-р тогтоол	Аймгийн хэмжээнд тогтвортой, байгальд ээлтэй, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар орон нутгийн эдийн засгийн хөгжилд аялал жуулчлалын салбарын оролцоог тэргүүлэх байр сууринд хүргэхийг зорилго болгоно.					
2	Хөтөлбөрийн санхүүжилт	Улсын болон орон нутгийн төсөв, төсөл, хөтөлбөр					
3	Хэрэгжүүлэгч байгууллага	Хэрэгжүүлэгч гол байгууллага: Аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газар Хамтрагч байгууллага: Аймгийн Засаг даргын Тамгын газар, Аялал жуулчлалын холбоо					
4	Хөтөлбөрийн зорилт	Зорилт 1: Аялал жуулчлалыг хөгжүүлэх зохион байгуулалтыг хангах Зорилт 2: Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, түүний дэд бүтцийг хөгжүүлэх Зорилт 3: Аялал жуулчлалын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх Зорилт 4: Аялал жуулчлалын арга хэмжээ /эвент/-ийг нэмэгдүүлж, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх					
5	Зардал	Төсөв Шардагдах нийт зардал): Задаргаа: 1-р хөтөлбөр: 2-р хөтөлбөр: 3-р хөтөлбөр: 4-р хөтөлбөр:	Төсөв (2020 он) - 800.0 10 67.0	Гүйцэтгэл (2020 он) - 250.0 9.0 10.0	% 70% 70% 100% 70%		
6	Төсөл, хөтөлбөрийн зорилт	Төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэл					
Зорилт 1-ийн хүрээнд							
Зорилт 1:	Аялал жуулчлалыг хөгжүүлэх зохион байгуулалтыг хангах	Орхоны хөндийн бүс нутгийн аялал жуулчлалыг нутгийн иргэдэд түшиглэн хөгжүүлж, үйлчилгээний чанар, стандартыг сайжруулах зорилгоор аймгийн ИТХ-ын 2014 оны 37 дахь шийдвэрээр "Аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэхэд баримтлах журам"-д нэмэлт өөрчлөлт оруулж, аймгийн ИТХурлын 2020 оны 05-р сарын 14-ний өдрийн 34 дүгээр тогтоолоор батлуулсан байна. Журмын хэрэгжилтэнд сумдын ЗДТГазаруудтай хамтран хяналт тавьж ажилласан ажээ. 2020 оны байдлаар 71 өрх зочны гэр, 25 өрх морин аялалыг зохион байгуулж ажилсан байна.					
Зорилт 2-ийн хүрээнд							
Зорилт 2:	Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, түүний дэд бүтцийг хөгжүүлэх	Аялал жуулчлалын голлох чиглэлүүдийн дагуух дэд бүтэц, бүс нутгийг хөгжүүлж, сайжруулах зорилгоор Хархорин суманд улсын төсвөөр аялал жуулчлалын гудамж байгуулж эхэлсэн ба гүйцэтгэгч компаниар Хархорин ус суваг, ЭБЦТСтанцын Хархорин салбар, ДШЛ ХХК тус тус шалгарчээ. 2020 оны байдлаар 50,0 сая орчим төгрөг өртөг бүхий цэвэр, бохир усны шугам татах ажил хийгдсэн байна. Эрдэнэ Зуу музейн гадна талбайд жуулчдад зориулсан 80-100 хүний суудалтай зуны "Задгай театр" барьж байгаа бөгөөд барилгын ажлын 90 хувийн гүйцэтгэлтэй байна. Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор Бат-Өлзий суманд олон улсын стандартад нийцсэн цанын бааз барих дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажил эхэлжээ.					
Зорилт 3-ийн хүрээнд							
Зорилт 3:	Аялал жуулчлалын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх	Аялал жуулчлалын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор "ИТМ-2020" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцох бэлтгэл ажлыг аймгийн аялал жуулчлалын холбоотой хамтран зохион байгуулж оролцсон. Орон нутгийн засаг захиргааны байгууллагаас аялал жуулчлалын компаниудыг дэмжих зорилгоор талбайн түрээсийн болон тохижилтын зардалд 9.0 сая төгрөгийг аймгийн ЗДТГ азар, БОАЖГ азараас шийдвэрлэн гаргажээ. Энэхүү үзэсгэлэнд аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг 5 төрийн байгууллага, 1 ТББ, 16 жуулчны бааз, 1 зочид буудал, 1 ресторан оролцож, бүс нутгийнхаа түүх, соёл, өөрсдийн үйл ажиллагааг сурталчилжээ. Мөн аялал жуулчлалын төрөл бүрийн семинар, сургалтанд оролцсон байна. 2020 оны энэхүү үзэсгэлэнгийн үеэр 80 гаруй хамтран ажиллах гэрээ байгуулагджээ. Мөн соёлын өв, түүх соёлын дурсгалт газруудын тухай танилцуулгыг бэлтгэж, оролцогчдод мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулсан.					
Зорилт 4-ийн хүрээнд							
Зорилт 4:	Аялал жуулчлалын арга хэмжээ /эвент/-ийг нэмэгдүүлж, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх	Дэлхий даяар тархаад байгаа Ковид-19 цар тахал Монголд гарсантай холбогдуулан БОАЖЯамны сайдын тушаалаар 2020 онд хийхээр төлөвлөж байсан аялал жуулчлалын бүх арга хэмжээ, эвентийг 2020 оны 3-р сарын 1-ний өдрөөс эхлэн цуцалсан юм. Өвөрхангай аймаг нь энэ 1 жилийн хугацаанд 6 арга хэмжээ төлөвлөсөн байсан ба 2020 оны 1-р сарын 5-нд Төгрөг суманд өвлийн эвент болох "Тэмээчдийн Баяр", 7-р сарын 22-нд Хужирт суманд Урса мажур болон Талбиун жуулчны баазтай хамтран дотоодын жуулчдад зориулсан "Монгол эсгий урлалын баяр"-ыг зохион байгуулсан. Эдгээр эвентийг 160 гаруй дотоод аялагчид үзэж сонирхсон.					
7	Дүгнэлт (Үр дүн, Сул тал, Анхаарах зүйл)	Хөтөлбөрийн дагуу холбогдох арга хэмжээг зохион байгуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэх.					
8	Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагуудын хөндлөнгийн үнэлгээ	Байхгүй					
9	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ (өөрсдийн үнэлгээ)	Биелэлт дундаж 77.5%	Зорилтот түвшин 4	Зорилт 1 70%	Зорилт 2 70%	Зорилт 3 100%	Зорилт 4 70%
10	Төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэлийн нийт үнэлгээ (Сайдын үнэлгээ)	Нэгдсэн үнэлгээ Байхгүй					

Эх сурвалж: Өвөрхангай аймгийн Аялал жуулчлалын бодлого хариуцсан мэргэжилтнээс ирүүлсэн материалд үндэслэн судалгааны баг нэгтгэв.

5) Аялал жуулчлалын дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө /2019-2022/ Өвөрхангай аймгийн аялал жуулчлалын дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ нь хараахан хийгдээгүй байна.

6) Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр Өвөрхангай аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын тогтоолоор “ Өвөрхангай аймгийн

Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг батлан гаргасан байна. Хөтөлбөрөөр “Байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх”-ийг зорилт болгож нийт 12 хэрэгжүүлэх арга хэмжээг тусгажээ. Энэхүү хөтөлбөрийг “Урт хугацааны хөгжлийн бодлого Алсын Хараа-2050” тай уялдуулснаараа онцлогтой. Тухайлбал, хөтөлбөрийн эхний бүлэг нь “Үндэсний бахархал”, аялал жуулчлалын талаарх бүлгийг “Ногоон хөгжил, аялал жуулчлал” хэмээн гарчиглаж байгаль орчин хамгаалахыг илүү чухалчилсан байна. Мөн “Хархорин, Эрдэнэ Зуу музейг холбосон аялал жуулчлалын гудамж байгуулна” гэх мэтээр аялал жуулчлалын газар тус бүрээр хэрэгжүүлэх төслүүдийг тодорхой төлөвлөжээ. Гэвч, эдгээр хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр тодорхой бус байгаа юм. Хөтөлбөрийн аялал жуулчлалын салбарт хамаарах хэсэгт тус аймгийн аялал жуулчлалын өмнөх бодлогын баримт бичгүүдэд тусгасан асуудлуудыг оруулснаас гадна аялал жуулчлалын дэд хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлж ажиллах тухай ч багтаасан байна.

(2) Архангай аймгийн аялал жуулчлалын бодлого, төлөвлөгөө

Архангай аймгийн аялал жуулчлалын хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг нэгтгэн харуулав. Өвөрхангай аймагтай хамтран боловсруулсан ” Орхоны Хөндийн бүс нутгийн аялал жуулчлалын стратеги-2020 ”-ийг Өвөрхангай аймгийн бодлогын баримт бичгийн “3.3.2 Төлөвлөгөө / Аян / Арга хэмжээ” хэсэгт танилцуулсан ба Архангай аймгийн аялал жуулчлалын бодлогын баримт бичигт дурдагдсан зүйлсийг харахад Өвөрхангай аймгийнхтай ижил төстэй асуудлууд ч харагдаж байгаа болно.

- ① Архангай аймгийн аялал жуулчлалын бодлогын баримт бичигт санхүүгийн эх үүсвэрийг тодорхой тусгаагүй байгаа тул, тавьсан зорилт, зорилгодоо хүрэх магадлал бага болов уу.
- ② Аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөө, бодлого, арга хэмжээг уялдуулан зохицуулах ажлыг хариуцах эзэн тодорхой бус мөн баримт бичигт заасан зорилт, бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх гол оролцогчид, тэдгээрийн гүйцэтгэх үүрэг, түүнчлэн хэрэгжүүлэх үе шат бүрд хүлээх үүрэг хариуцлагын талаар ч тодорхой тусгаагүй байгаа юм.
- ③ Аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд нийтлэг харагдаж буй нэг зүйл бол орон нутгийн засаг захиргаа, төрийн байгууллагуудыг эдийн засаг, нийгмийн хөгжлийн бүхий л салбарт оролцуулахаар төлөвлөсөн байгаа боловч хувийн хэвшил, орон нутгийн иргэд, ТББ -уудын оролцоо тодорхой бус, энэ талаар огт тусгаагүй байгаа юм.
- ④ Аймгийн бодлогын баримт бичгийг, аялал жуулчлалыг хөгжүүлэхэд тодорхой үр нөлөөтэй байж чадсан хэмээн өөрсдөө сайнаар үнэлж байгаа. Гэвч хэдэн хувьтай хэрэгжиж, ямар үр нөлөө үзүүлсэн талаар тодорхой дурдсан зүйл байхгүй тул, бодлогын хэрэгжилтийн түвшин, үр нөлөөг бодитойгоор үнэлж дүгнэх хэмжүүр байхгүй ба бодит үр дүнг үнэлэх боломжгүй юм.
- ⑤ Хүчин төгөлдөр үйлчилж буй аялал жуулчлалын бодлогын олон баримт бичиг байдаг боловч тэдгээрийн харилцан хамаарал, тэргүүлэх чиглэл нь тодорхойгүй байдаг. Иймээс аймгууд аймгийнхаа аялал жуулчлалын бодлого, хөтөлбөрийг багтаасан нэгдсэн нэг л баримт бичгийг гаргах нь хэрэгжилтийн үүрэг, хариуцлага гэх мэт олон зүйл ойлгомжтой, тодорхой болохоор харагдаж байгаа юм. Архангай аймгийн хувьд, Засаг даргын үйл ажиллагааны төлөвлөгөөнд бусад бодлогын баримт бичгийн агуулгыг тусгасан байгаа нь бодлого тууштай, тогтвортой байх гэсэн утгаараа үнэлүүштэй.
- ⑥ Архангай аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичиг дэх төслийн ихэнх нь их хэмжээний төсөв шаардагдах зүйлүүд байгаа болно. Санхүүгийн эх үүсвэрийг улс, орон нутгийн төсөв, олон улсын зээл, тусламж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт гэх мэтээр төлөвлөсөн байгаа хэдий ч энэ их хөрөнгийг босгохын тулд ямар үйл ажиллагаа явуулах нь тодорхой бус байна.

Хүснэгт 3-45: Архангай аймгийн аялал жуулчлалын хөгжлийн бодлогын баримт бичиг

	Аялал жуулчлалын хөгжлийн бодлого, төлөвлөгөө	Батлагдсан огноо
1	Орхоны Хөндийн бүс нутгийн аялал жуулчлалын стратеги 2020	2017
2	1) "Архангай аймгийн аялал жуулчлалын дэд хөтөлбөр 2018-2022"	2015.06.09
	2) "Нүүдлийн соёл, аялал жуулчлалын олон улсын төв" болгон хөгжүүлэх /2019-2030/ дунд хугацааны баримт бичиг "	2018.11.19
	3) Архангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	2020.12.03

Эх сурвалж: Архангай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар

1) Архангай аймгийн “ Аялал жуулчлалын дэд хөтөлбөр 2018-2022 ”

2015 онд аймгийн ИТХ-аар батлагдсан “ Аялал жуулчлалын дэд хөтөлбөр ” ийг 2015-2030 оны хооронд хэрэгжүүлнэ хэмээн төлөвлөсөн байна. Хөтөлбөр нь 6 зорилттой, зорилтод хүрэхийн тулд хэрэгжүүлэх 32 арга хэмжээнээс бүрджээ. Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн байдлыг дараах хүснэгтэд харахад ихэнх арга хэмжээг хэрэгжүүлсэн хэмээн Архангай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар мэдээлж байгаа ба үр дүнтэй байсан эсэхийг дурдаагүй байна. Гэвч, тус хөтөлбөр нь Архангай аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, маркетингийн асуудлыг шийдвэрлэхэд тус нэмэр болсон хэмээн аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар үнэлж байгаа юм.

Хүснэгт 3-46: Архангай аймгийн Аялал жуулчлалын дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн байдал

	Зорилт	Хэрэгжилтийн байдал
1	Бүтэц, зохион байгуулалтыг сайжруулах	Хэрэгжиж байгаа
2	Байгаль орчин, түүх соёлын өвийг хамгаалах, эдийн засгийн эргэлтэд оруулах	Хэрэгжсэн
3	Аялал жуулчлалын бодлогыг дэд бүтцийн салбарын бодлоготой уялдуулан сайжруулах	Хэрэгжсэн
4	Маркетинг, сурталчилгааг өргөжүүлэх	Хэрэгжсэн
5	Мэргэшилт, хүний нөөцийн баазыг бэхжүүлэх	Хэрэгжсэн
6	Аялал жуулчлалын мэдээллийн төвийг ажиллуулах	Хэрэгжсэн

Эх сурвалж: Архангай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар

2) "Нүүдлийн соёл, аялал жуулчлалын олон улсын төв" болгон хөгжүүлэх /2019-2030/ дунд хугацааны баримт бичиг "

Архангай аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаар Архангай аймгийг “Нүүдэлчдийн соёл, аялал жуулчлалын олон улсын төв” болгон хөгжүүлэх дунд хугацааны (2019-2030) баримт бичгийг баталсан. Энэхүү баримт бичгийн хүрээнд аймгийн 19 сумыг цогцоор нь хөгжүүлэхээр тусгаж, Дэлхийн (Төв Азийн) нүүдэлчдийн түүх, соёлын музей, аялал жуулчлалын цогцолбор байгуулах, Сарлагийн музей, Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын судалгааны төв, Шилэн гүүр, "Увдист орон (Шидэт орон)" цогцолбор, Төв Монголын байгаль, түүх соёлын музей, Солийн Данзангийн Музей, Олон улсын нисэх онгоцны буудал, Олон улсын хүүхдийн зуслан Өгийнуур, Хорго-Тэрхийн цагаан нуурын экосистемийн тэнцвэрийг хадгалж, хамгаалах, аялал жуулчлалын үндэсний парк байгуулах гэсэн 9 тулгуур төвийг байгуулахаар төлөвлөж, санхүүгийн эх үүсвэрийг улс, аймаг, орон нутгийн төсөв, олон улсын зээл тусламж, гадаадын болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан байна.

Мөн голлох бүс дэх зам, эрчим хүч зэрэг дэд бүтцийг сайжруулах, шинээр байгуулах, “Нүүдэлчдийн соёлын өдөр”-үүдийг тогтмол зохион байгуулах, аялал жуулчлалын компаниудыг аймгаас бодлогоор дэмжих, нүүдлийн соёл, аялал жуулчлалын 219 мэргэжилтэн бэлтгэх зэрэг арга хэмжээнүүдийг тусгажээ.

3) Архангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр

2020 оны 12-р сард ИТХ-ын хуралдаанаар Архангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл

ажиллагааны хөтөлбөрийг баталсан. Тус хөтөлбөрийн “Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх” зорилтын хүрээнд “Нүүдлийн соёл, аялал жуулчлалын олон улсын төв болгон хөгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөө”/2019-2030/, “Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл- II” зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх 7 зүйлийг тусгажээ. Өөрөөр хэлбэл Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт бодлогын бусад баримт бичигт дурдсан асуудлуудыг тусгасан аж. Ингэснээр бодлогын тууштай, тогтвортой байдлыг хадгалж чадаж байгаа нь сайшаалтай.

3.3.3 Аялал жуулчлалын салбарын холбогдох байгууллагууд

(1) Өвөрхангай аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд холбогдох байгууллагууд

”Дэлхийн өв-Орхоны Хөндийн нүүдэлчид” ТББ нь 2010 оны 11-р сарын 8-нд байгуулагдсан. Монголын аялал жуулчлалын холбооны гишүүн тус байгууллага нь сүүлийн 2 жилд холбооны гишүүн жуулчны баазуудаас гишүүнчлэлийн татвараа аваагүй.

Өвөрхангай аймгийн аялал жуулчлалын холбоо нь аймгийн удирдлагууд солигдсонтой холбогдуулан үйл ажиллагаагаа түр зогсоожээ. Гишүүд ихээр өөрчлөгдсөн тул цаашдын үйл ажиллагааны чиглэл амархан шийдэгдэхгүй байх магадлал өндөр юм.

(2) Архангай аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд холбогдох байгууллагууд

Архангай аймгийн жуулчны бааз, зочид буудал зэрэг 40 байгууллага гишүүнээр нь элссэн “Эртний нүүдэлчдийн өлгий” ТББ байдаг. Тус байгууллага зөвхөн гишүүнчлэлийн татвараар үйл ажиллагаагаа явуулдаг.

3.3.4 Аялал жуулчлалын салбарын татварын орлого

(1) Өвөрхангай аймгийн аялал жуулчлалын салбарын орлого

Доорх хүснэгтэд Өвөрхангай аймгийн аялал жуулчлалын салбарын орлогыг харуулав. Орон нутгийн засаг захиргааны гол орлого нь газар ашиглуулсны төлбөр, бохир ус цэвэршүүлсний төлбөр байдаг нь эндээс харагдаж байна.

Хүснэгт 3-47: Өвөрхангай аймгийн аялал жуулчлалын салбарын орлого

	Сумын нэр	Ус ашигласны төлбөр (сая. төг)	Бохир усны үйлчилгээний төлбөр (сая. төг)	Газар ашигласны төлбөр (сая. төг)	Агнуурын нөөц ашигласны төлбөр (сая. төг)	Ой ашигласны төлбөр (сая. төг)
1	Арвайхээр	5.3	244.6	274.9	2.8	-
2	Бат-Өлзий	-	20.8	5.4	-	91.3
3	Бүрд	-	4.1	3.6	19.2	-
4	Хархорин	10.2	70.0	120.7	-	2.2
5	Хужирт	115.6	22.7	22.6	44.9	10.3
6	Уянга	192.9	22.1	16.2	-	4.4

Эх сурвалж: Өвөрхангай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар

Өвөрхангай аймагт байдаг Орхоны Хөндийн БЦГ-ын хувьд бол ТХГН-т нэвтрэх хураамж нь аялагчдаас орох гол орлого болдог.

Хүснэгт 3-48: Орхоны Хөндийн БЦГ-ын Хамгаалалтын захиргааны орлого

Он	Гадаадын жуулчдаас авсан нэвтрэх хураамж (төг)	Дотоодын жуулчдаас авсан нэвтрэх хураамж (төг)	Нэвтрэх хураамжаас олсон нийт орлого (төг)	Эко гэрийн хураамж (төг)	Нийт орлого (төг)
2019	28,770,000.00	4,502,100.00	33,272,100.00	2,885,000.00	36,157,100.00
2020	N/A	10,569,000.00	10,569,000.00	1,306,000.00	11,875,000.00

Эх сурвалж: Орхоны Хөндийн БЦГ-ын Хамгаалалтын захиргаа

(2) Архангай аймгийн аялал жуулчлалын салбарын орлого

Архангай аймгийн зарим сумдын эко гэрийн (нутгийн иргэд орон нутгийн засаг захиргааны зөвшөөрөлтэйгөөр жуулчид хонуулах гэр ажиллуулахыг хэлнэ) ус, газар ашигласны төлбөрөөс олсон орлогыг харуулж байна (Хүснэгт 3-49). Архангай аймгийн хөдөө орон нутагт газар ашиглалтын төлбөр гэх мэт татварын орлого бараг байдаггүйг эндээс харж болно.

Хүснэгт 3-49: Архангай аймгийн зарим сумын татварын орлого

	Сумын нэр	2019 он (нийт, төг)	2020 он (нийт, төг)
1	Тариат	1,271,500 (14 эко гэрийн хураамж)	225,000 (3н эко гэрийн хураамж)
2	Ихтамир	Ус ашигласны төлбөр - 600,000 Хог хаягдлын үйлчилгээний хураамж - 300,000 Газар ашигласны төлбөр - 220,000	Ус ашигласны төлбөр - 600,000 Хог хаягдлын үйлчилгээний хураамж - 300,000 Газар ашигласны төлбөр - 220,000
3	Цэнхэр	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр - 28,848,745 Хог хаягдлын үйлчилгээний хураамж - 2,500,000 Үл хөдлөх хөрөнгийн татвар - 4,187,000	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр - 22,543,000 Хог хаягдлын үйлчилгээний хураамж - 2,500,000 Үл хөдлөх хөрөнгийн татвар - 4,187,000 Экогэрийн хураамж - 2,800,000
4	Хотонт	Аж ахуйн нэгжийн татвар - 120,000 Ус ашигласны төлбөр - 90,000 Рашааны нөөц ашигласны төлбөр - 1,300,000 Хог хаягдлын үйлчилгээний хураамж - 200,000 Үл хөдлөх хөрөнгийн татвар - 250,000	Аж ахуйн нэгжийн татвар - 120,000 Ус ашигласны төлбөр - 90,000 Рашааны нөөц ашигласны төлбөр - 1,650,000 Хог хаягдлын үйлчилгээний хураамж - 250,000 Үл хөдлөх хөрөнгийн татвар - 650,000
5	Өгий нуур	Ус ашигласны төлбөр - 1,500,000 Хог хаягдлын үйлчилгээний хураамж - 750,000 Газар ашигласны төлбөр - 190,000 Үл хөдлөх хөрөнгийн татвар - 1,968,950 Аж ахуйн нэгжийн татвар - 60,000 Экогэрийн хураамж - 900,000	Ус ашигласны төлбөр - 1,000,000 Хог хаягдлын үйлчилгээний хураамж - 750,000 Газар ашигласны төлбөр - 190,000 Үл хөдлөх хөрөнгийн татвар - 1,968,950 Аж ахуйн нэгжийн татвар - 60,000 Эко гэрийн хураамж - 900,000
6	Төвшрүүлэх	Рашааны нөөц ашигласны төлбөр - 1,970,000 Хог хаягдлын үйлчилгээний хураамж - 100,000	Рашааны нөөц ашигласны төлбөр - 2,000,000 Хог хаягдлын үйлчилгээний хураамж - 100,000
7	Цэцэрлэг	Рашааны нөөц ашигласны төлбөр - 1,425,000	Рашааны нөөц ашигласны төлбөр - 3,452,600

Эх сурвалж: Архангай аймаг

3.3.5 Дэд бүтцийн байдал

(1) Авто зам

1) Өвөрхангай аймаг

Хархорин орчмын бүс нутаг нь Улаанбаатар хоттой 365 км хатуу хучилттай замаар холбогддог. Аймгийн төвөөсөө 137 км зайтай бөгөөд 60 км нь хатуу хучилттай зам юм. Энэ бүс нутгийн аялал жуулчлалыг хөгжүүлэхийн тулд Зам, тээврийн хөгжлийн яамны авто зам хөгжүүлэх хөрөнгөөр Хужиртаас Орхон-Нарийн голын уулзвар хүртэл 30 км, уулзвараас Төвхөн хийд хүртэл 18 км,

Улаан цутгалан хүртэл 39.9 км, Бат-Өлзий сумын төв хүртэл 2,2 км, нийт 90.1 км урт зам тавих ажил 2012 онд эхэлсэн боловч одоогийн байдлаар барилгын ажил удааширч, зарим газар зогсонги байдалтай байна. Хархориноос Хужирт сум хүртэл 54 км, Хархориноос Хөшөө Цайдам хүртэл 45 км хатуу хучилттай засмал зам Турк улсын хөрөнгө оруулалтаар тавигдсан нь аялал жуулчлалын хөгжилд ихээхэн ач холбогдолтой байна.

2018 онд Монгол Улсын Засгийн газраас батлан гаргасан аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөөнд тус бүс нутагт аялал жуулчлалын гол чиглэлүүдийг тогтоохоор тусгасан. Тэрхүү аялал жуулчлалын гол чиглэлүүд нь SR10 Хархорин сум-Шанхын хийд-Хужирт сум-Зүүнбаян-Улаан сум, SR20 Хархорин сум-Шанхын хийд-Бат-Өлзий сум-Улаан цутгалан хүрхрээ-Төвхөн хийд, SR 30 Хархорин сум-Хөшөө цайдам цогцолбор-Өгий нуур зэрэг болно.



Эх сурвалж: Монгол улсын Засгийн газрын 171-р тогтоолын Хавсралт

Зураг 3-25: Хархорин орчмын бүс нутгийн авто замын сүлжээ

Одоогийн байдлаар гадаад дотоодын жуулчид голчлон Өвөрхангай аймгийн хойд хэсгээр аялах магадлал өндөр байгаа тул ойрын жилүүдэд Өмнөговь аймаг руу ойртох замыг барих ажлыг эхлүүлэх нь нэн чухал юм. Тус замыг ашиглалтад оруулснаар аймгаар дамжин өнгөрөх тээврийн хэмжээний хүчин чадал үлэмж нэмэгдэх боломжтой бөгөөд Өмнөговь аймгаас Өвөрхангай аймаг руу, мөн Хархорин сум зэрэг хойд сумдаас урд сумд руу жуулчдын урсгалыг чиглүүлэх таатай нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна.

2) Архангай аймаг

Баруун аймгуудыг нийслэлтэй холбодог хатуу хучилттай гол авто зам нь аймгийн нутаг дэвсгэрээр дайран өнгөрдөг тул авто замуудын зам засварын ажил харьцангуй сайн хийгдсэн. Гэвч, Цэнхэрийн рашаан, Өгий нуур, Хөх нуур, Суварга Хайрхан руу чиглэсэн замууд шороон зам байдаг бөгөөд зуны улиралд шалбааг их тогтдог тул цаашид эдгээр авто замыг сайжруулах шаардлагатай юм.

2017-2019 онд Цэцэрлэг, Тариат, Ихтамир зэрэг суманд 10 гаруй км хатуу хучилттай зам тавьжээ. 2021 оноос хэрэгжүүлж эхлэх хөрөнгө оруулалтын ажилд Хархорин - Цэцэрлэг чиглэлийн А0602 дугаартай авто замаас Өгий нуур – Батцэнгэл - Ихтамир чиглэлийн А27 дугаартай мянганы замын хэвтээ тэнхлэгийн авто зам хүртэлх авто замын ажил болон Цэнхэрийн халуун рашаан хүртэлх сайжруулсан шороон зам барих зэрэг томоохон төслүүд багтсан болно.

(2) Цэвэр ус

Архангай аймагт үйл ажиллагаа явуулж буй 34 жуулчны бааз нь өөрсдийн ашигладаг худгийн усны судалгаа, дүгнэлтийг 2020 онд гаргуулж, сум тус бүртэй гэрээ байгуулжээ. Усны чанартай холбоотой асуудал Архангай аймагт гараагүй байна.

(3) Бохир ус

1) Өвөрхангай аймаг

Одоогийн байдлаар Орхоны Хөндий орчмын сумдад бохир ус цэвэрлэх байгууламж байхгүй ба бохир ус зайлуулах цэгүүдэд хаях эсвэл хөрсөнд шингээх аргаар цэвэрлэж байна.

2) Архангай аймаг

Аймгийн төв Цэцэрлэг хотод өдөрт 1600м³ ус цэвэрлэх хүчин чадалтай цэвэрлэх байгууламж ажилладаг ба цэвэршүүлсэн усыг хөрсөнд хаядаг. 2021 онд өдөрт 300 м³ ус цэвэрлэх хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийг Тариат суманд ашиглалтад оруулахаар бэлтгэж байна. Одоогийн байдлаар бусад газарт бохир усыг зориулалтын ус зайлуулах цэгт хаяж байгаа болно.

(4) Хог хаягдлын менежмент

Орхоны Хөндийн БЦГ гэх мэт ТХГН-т 2020 оноос хойш хог хаягдлын түр цэгүүдийг байгуулжээ. Цугларсан хог хаягдлыг сард нэг удаа ойролцоох сумын хог хаягдлын цэг рүү 5 -170 км -ийн зайд тээвэрлэн хаяж байна. Холбогдох судалгаанаас харахад хүн өдөрт 270-900 грамм хог хаягдал гаргадаг ажээ.

Хүснэгт 3-50: Архангай аймгийн зарим сумын хог хаягдлын үйлчилгээний нөхцөл байдал

(2019 оны байдлаар)

	Сумын нэр	Энгийн хатуу хог хаягдлын төвлөрсөн цэгийн нийт талбай (га)	Тээвэрлэсэн энгийн хатуу хог хаягдлын нийт хэмжээ (тонн)	Төвлөрүүлсэн хог хаягдлын хураамжийн нийт орлого (мян.төг)
1	Эрдэнэбулган	5.00	20,806.00	91,533.20
2	Цэнхэр	5.00	442.30	12,989.10

Эх сурвалж: Архангай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар

(5) Эрчим хүч, харилцаа холбоо

Орхоны Хөндийн бүс нутагт хамаарах сумууд төвийн эрчим хүчний системд холбогдсон байдаг. Мөн сумын төв орчмын бүс нутагт үүрэн холбооны операторууд нэвтэрсэн. Хархорин орчмын жуулчны баазууд төвийн эрчим хүчний системд холбогдсон ба алслагдсан бүс нутагт дизель генератор ашигладаг тул цахилгаан тасрах тохиолдол бараг байхгүй.

(6) Зорилтот бүс нутгийн үйлчилгээний цэгүүд (түр амрах газар, бие засах газар)

1) Өвөрхангай аймгийн Хархорин сумын чиглэл

Сүүлийн жилүүдэд Улаанбаатар хотоос Хархорин хүрэх зам дагуу байнгын үйлчлүүлэгчийн шаардлага хангасан үйлчилгээний цогцолбор (SA) барих төсөл хэрэгжиж байгаа бөгөөд төрөөс бодлогын дэмжлэг үзүүлж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт хийгдэж байгаа болно. Хархорины чиглэлийн улсын чанартай авто зам дагуух үйлчилгээний гол цогцолбор (SA) болох Төв аймгийн Лүн сумын Урьхан цогцолбор болон Элсэн тасархай орчимд баригдсан авто замын зогсоол үйлчилгээний цэгийн гаднах байдлыг дараах фото зургаар харуулав.



Эх сурвалж: Урьхан цогцолборын веб сайт

Зураг 3-26: Шинээр нээгдсэн үйлчилгээний цэг (Төв аймгийн Лүн сум Урьхан цогцолбор)



Эх сурвалж: Элсэн тасархайн веб сайт

Зураг 3-27: Шинээр нээгдсэн үйлчилгээний цэг (Элсэн тасархай)

Архангай аймгийн хувьд, аялал жуулчлалын гол чиглэлийн MR300 маршрутын дагуу Хотонт, Цэнхэр, Эрдэнэбулган, Ихтамир, Тариат, Цахир зэрэг сумдын төвөөр дайрч өнгөрдөг боловч одоогийн байдлаар зам дагуух өртөө зогсоол, үйлчилгээний цэг (SA) нь ихэвчлэн хоолны газрууд байна.

БОАЖЯ-ны Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газраас орон даяар улсын чанартай авто зам дагуу 13 үйлчилгээний цогцолбор сүүлийн жилүүдэд барихаар төлөвлөж байна.



Эх сурвалж: БОАЖЯ-ны Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газар

Зураг 3-28: Үйлчилгээний цогцолборын загвар зураг

Мөн БОАЖЯ нь 2019 онд Хөвсгөл нуур, Увс нуур, Элсэн тасархай, Орхоны Хөндий, Горхи-Тэрэлж, Богд уул, Түлүүгийн даваа зэрэг газруудад хоноглох, амрах цэгүүдийг байгуулжээ.⁴⁴

3.3.6 Жуулчдын чиг хандлага

Дотоодын жуулчдын тооны өсөлтөөс харахад Ковид-19-ын тархалт дотоодын аялал жуулчлалд огт нөлөөлөөгүйг харж болно. Мөн Япон улсын буцалтгүй тусламжаар барьсан Хархорум музейг үзэгчдийн тоо тогтмол өсөж байна. Хархорум музейг үзэх Монгол хүн цөөхөн байгаа нь музейн тасалбарын үнэ өндөр байгаатай холбоотой байх магадлалтай

Хүснэгт 3-51: Хархориныг зорьсон жуулчдын тоо (гадаадын болон дотоодын жуулчид тус бүрээр)

	Хархорум музей		Эрдэнэ Зуу хийд		Хөшөө Цайдам	
	2019	2020	2019	2020	2019	2020
Гадаадын жуулчин	18,388	155	27,919	326	-	

⁴⁴ <https://ikon.mn/n/1xjl>

	Хархорум музей		Эрдэнэ Зуу хийд		Хөшөө Цайдам	
	2019	2020	2019	2020	2019	2020
Дотоодын жуулчин	5,582	5,357	31,950	33,195	-	Засварын улмаас хаагдсан
Нийт	23,970	5,512	59,566	33,522	2,800	
Тасалбарын Үнэ (төг)	8,000		Гадаад хүн 5,000; Монгол хүн 3,000		5000 хүүхэд үнэгүй	

Эх сурвалж: Музейнүүдийн статистик мэдээлэлд үндэслэн судалгааны баг боловсруулав.

3.3.7 Аялал жуулчлалын салбарын чиг хандлага

(1) Өвөрхангай аймгийн аялал жуулчлалын салбар

Өвөрхангай аймагт үйл ажиллагаа явуулж байгаа жуулчны баазуудад ажиллагсдын ихэнх нь зөвхөн зуны улиралд ажилладаг бөгөөд байнгын ажилтнуудаас хоёр дахин их улирлын чанартай ажилтантай жуулчны бааз ч байдаг. Тиймээс ажиллагсдын сарын дундаж цалин харьцангуй бага буюу ойролцоогоор 500,000 төгрөг гэж гарчээ. Жуулчны баазын ажилтнуудын дундаж цалинг харахад төрийн албан хаагчдын дундаж цалинтай ойролцоо буюу зөрүү багатай байна. Ажиллагсдаас тогооч хамгийн өндөр цалинтай байгаа нь ажлын ачаалал, мэргэжлийн үнэмлэх, ур чадварын түвшингээс шалтгаалдаг байна. Гэхдээ Өвөрхангай аймгийн зочид буудал, музейн ажилтнуудын цалингийн хэмжээнд тийм ч их зөрүү байхгүй байна.

Жуулчны баазад ажиллагсдын тоо, дундаж цалингийн хэмжээг доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 3-52: Жуулчны баазад ажиллагсдын тоо

Жуулчны баазын нэр	Нийт ажилтны тоо	Үүнээс:		Ажилтны тоо								
		Байнгын	Улирлын	Менежер	Зочин утгагч	Гэр, өрөөний үйлчилгээ	Хөлөч	Тогооч	Бармен	Зөөгч	Туслах ажилтан	Жолооч
Найманнуур	10	3	7	1	2	2	-	2	1	2	-	-
Бөөрөг	6	3	3	1	2	2	-	1	-	2	-	-
Орхон түшээ	6	2	4	1	1	1	-	2	-	1	-	-
Орхоны хүрхрээ	6	2	4	1	-	2	-	1	-	1	1	-
Форест лэнд	6	2	4	1	-	2	-	1	-	1	1	-
Хүрхрээ тур	7	2	5	1	-	-	-	-	-	-	-	-
Орхон турс	10	5	5	1	2	-	-	1	-	-	1	1
Могойт спа	8	4	-	1	-	-	-	-	-	-	-	-
Талбиун	16	8	8	3	1	4	-	1	-	1	4	-
Хашхан	12	3	9	1	2	2	-	2	1	1	2	-
Баясгалан	6	2	4	1	-	2	-	1	-	1	1	-
Морин поло	36	6	30	2	2	4	-	4	-	2	4	3
Урса мажор	12	4	8	1	1	3	-	2	2	-	1	1
Мөнгөн мод	Үйл ажиллагаа эхлээгүй байгаа											
Ойдов	5	2	3	1	-	-	-	1	-	1	1	-
Анжа	15	3	12	1	1	3	-	2	1	2	5	-
Хубилай	Хариулт ирүүлээгүй											

Жуулчны баазын нэр	Нийт ажилтны тоо	Үүнээс:		Ажилтны тоо								
		Байнгын	Улирлын	Менежер	Зочин угтагч	Гэр, ерөөний үйлчилгээ	Хөтөч	Тогооч	Бармен	Зөөгч	Туслах ажилтан	Жолооч
Асалэнд	35	10	25	2	4	4	1	3	2	3	10	-
Их Монгол	Хариулт ирүүлээгүй											
Мишээл	Түр ажиллахгүй байгаа											
Номин	6	2	4	1	-	-	-	1	-	1	3	-
Мөнхтэнгэр	14	3	11	1	1	3	-	2	1	2	3	-
Хаан тайж	8	2	6	1	-	3	-	1	-	1	2	-
Анар	6	2	4	1	-	2	-	1	-	1	1	-
Хархорин Өргөө	15	3	12	1	-	3	-	2	-	2	5	-
Свийт Говь	12	4	8	1	1	3	-	2	2	-	1	1
Баянговь	20	4	16	1	2	4	-	2	2	2	5	1
Хайрхан	5	2		1	-	-	-	-	-	-	-	-
Хайрханы хишиг	Ажиллахгүй байгаа											
Нийт дүн	282	83	192	28	22	49	1	35	12	27	51	7

Эх сурвалж: Өвөрхангай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар

Хүснэгт 3-53: Жуулчны баазын ажиллагсдын сарын дундаж цалин (Хархорин, Бат-Өлзий, Хужирт, Уянга, Арвайхээр)

Жуулчны баазын ажиллагсад	Сарын дундаж цалин (төг)
Менежер	900,000
Зочин угтагч	400,000
Гэр, ерөөний үйлчлэгч	500,000
Тогооч	1,200,000
Бармен	600,000
Зөөгч	400,000
Туслах ажилтан (гал тогооны)	500,000
Жолооч	500,000

Эх сурвалж: Өвөрхангай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар

Өвөрхангай аймгийн Арвайхээр, Хархорин, Бат-Өлзий, Хужирт, Уянга сумдын нутагт үйл ажиллагаа явуулж байгаа 12 зочид буудлуудын ажиллагсдын тоог ажлын байр тус бүрээр нэгтгэн Хүснэгт 3-54-д, мөн эдгээр ажиллагсдын сарын дундаж цалинг Хүснэгт 3-55-д тус тус үзүүлэв. Нийт ажиллагсдын тоо жуулчны баазын нийт ажиллагсдын тооноос 50 орчим хүнээр бага байгаа боловч байнгын ажилтан дийлэнх хувийг эзэлдэг. Зочид буудалд ажиллагсдын хувьд жуулчны баазтай харьцуулахад үйл ажиллагаа нь улирлаас хамаарах хамаарал бага тул нийт ажиллагсдын 91% нь байнгын ажилтай байдаг байна. Зочид буудалтай адилхан жилийн турш ажилладаг музей ч мөн ажиллагсдынх нь 92% байнгын ажилтан байдаг.

Хүснэгт 3-54: Өвөрхангай аймгийн 5 суманд үйл ажиллагаагаа явуулж буй зочид буудлуудын ажиллагсдын тоо (Хархорин, Бат-Өлзий, Хужирт, Уянга, Арвайхээр)

Зочид буудлын нэр	Нийт ажилтны тоо	Үүнээс:		Ажилтны тоо							
		Байнгын	Улирлын	Менежер	Зочин угтагч	Өрөөний үйлчилгээ	Тогооч	Бармен	Зөөгч	Туслах ажилтан	Жолооч
Арвай палас	38	35	3	1	3	3	5	2	3	9	1
Өшгөг	17	14	3	1	3	2	2	1	1	2	1
Шунхлай	23	13	10	1	3	3	2	1	1	7	-
Баянбулаг	3	3	-	1	-	-	-	-	-	2	-
Тайм	15	13	2	1	3	2	2	1	-	4	-
Хобби	3	3	-	1	-	-	-	-	-	-	-
Баянширээ	1	1	-	1	-	-	-	-	-	-	-
Өлзийт	2	2	-	1	-	-	-	-	-	-	-
Их Хорум	31	28	3	2	3	4	6	2	4	4	-
Богд	40	40	-	2	6	2	3	2	4	9	-
Хан хужирт	50	50	-	3	4	6	4	2	4	15	1
Алтан нутаг	9	9	-	1		2	2	1	-	3	-
Нийт дүн	232	211	21	16	25	24	26	12	17	55	3

Эх сурвалж: Өвөрхангай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар

Хүснэгт 3-55: Зочид буудлын ажиллагсдын сарын дундаж цалин (Хархорин, Бат-Өлзий, Хужирт, Уянга, Арвайхээр)

Зочид буудлын ажиллагсад	Ажилтны дундаж цалин (төг)
Менежер	1,200,000
Зочин угтагч	600,000
Гэр, өрөөний үйлчлэгч	500,000
Тогооч	700,000
Бармен	500,000
Зөөгч	500,000
Харуул хамгаалалтын ажилтан	450,000

Эх сурвалж: Өвөрхангай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар

Арвайхээр болон Хархорин сумдад үйл ажиллагаа явуулж буй аймгийн болон улсын чанартай музейн ажиллагсдын тоог Хүснэгт 3-56-д, ажиллагсдын дундаж цалинг Хүснэгт 3-57-д харуулав. Аймаг, орон нутгийн музей нь жилийн 4 улиралд үйл ажиллагаа явуулдаг учир улирлын чанартай ажиллагсад бага, байнгын ажиллагсад нийт ажиллагсдын 92%-ийг эзэлдэг байна. 2019 онд улсын дундаж цалин 1.1 сая төгрөг байсан. Энэ дүнтэй харьцуулахад зочид буудлын ажилчдын цалин маш бага байна гэж хэлэхээр байна.

Хүснэгт 3-56: Өвөрхангай аймгийн музейн ажилчдын тоо

Музейн нэр	Нийт ажилтны тоо	Үүнээс:		Ажилтны тоо						
		Байгын	Улирлын	Менежер	Оффис ажилтан	Тайлбарлагч	Жолооч	Туслах ажилтан	Жижүүр	Бусад
Занабазарын нэрэмжит Өвөрхангай аймгийн музей	14	14	-	-	6	1	1	2	4	-
Эрдэнэ Зуу музей	23	21	2	1	12	1	1	1	6	-
Харахоруммузей	31	28	3	1	19	1	1	-	3	5
Нийт дүн	68	63	5	2	37	3	3	3	13	5

Эх сурвалж: Өвөрхангай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар

Хүснэгт 3-57: Музейн ажиллагсдын сарын дундаж цалин (Хархорин, Арвайхээр)

Музейн ажиллагсад	Сарын дундаж цалин (төг)
Менежер	800,000
Оффис ажилтан (албаны дарга, сан хөмрөгч, ЭША, нягтлан г.м.)	700,000
Тайлбарлагч	680,000
Жолооч	600,000
Жижүүр	600,000
Бусад (касс, үйлчлэгч, сантехникч г.м.)	550,000

Эх сурвалж: Өвөрхангай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар

Аялал жуулчлалын үйл ажиллагаа дахь орон нутгийнхны оролцооны тухайд гэвэл 2020 оны байдлаар Орхоны хөндийн бүс нутагт 71 өрх эко гэр ажиллуулж аялагч, жуулчдыг хүлээн авсан байна. Мөн морин аялын хөтөч хийдэг 25 иргэн бүртгэгджээ. Орон нутагт зохион байгуулагдаж байгаа эвент, арга хэмжээг нутгийн иргэдэд түшиглэн зохион байгуулж, орлого олох боломжийг нэмэгдүүлэхээр ажиллаж байгаа болно. “Торгоны зам-Хархорум хот”, “Сарлагийн баяр”, “Монгол эсгий урлалын баяр” эвентүүдийг зохион байгуулах үеэр малчдын гар дээрээс цагаан идээ худалдан авах, гар урлалаар хийсэн бүтээгдэхүүн борлуулах боломжийг бий болгож байна. 2019 онд зохион байгуулсан эвентээр Өвөрхангай аймгийн Бат-өлзий, Хархорин, Хужирт, Уянга, Зүүнбаян-улаан сумын 22 малчин айл худалдаа эрхэлсэн байна.

(2) Архангай аймгийн аялал жуулчлалын салбар

2020 оны байдлаар Архангай аймгийн аялал жуулчлалын салбарт ажиллагсдын нийт тоог нэгтгэн үзүүлэв. Архангай аймагт мөн л адил, жуулчны баазад ажилладаг гэрээт ажилтны тоо, үндсэн ажилтнаас гурав дахин их байгааг онцолж болох юм.

Хүснэгт 3-58: Архангай аймгийн аялал жуулчлалын салбарт ажиллагсдын тоо

	Байгууллагын төрөл	Нийт ажилтнуудын тоо			
		Нийт тоо	Үндсэн	Гэрээт /улирлын/	Гэрээт /цагийн/
1	Жуулчны бааз	337	88	263	0
2	Гэр буудал /Эко гэр/	222	202	20	0
3	Зочид буудал	26	26	0	0
4	Дэн буудал	57	56	0	1
5	Амралтын газар	14	3	11	0
6	Рашаан, сувиллын газар	45	31	14	0
	Нийт	701	406	308	1

Эх сурвалж: Архангай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар

3.3.8 Аялал жуулчлалын маркетинг, сурталчилгааны байдал

Тус аймаг нь жуулчдад зориулсан веб сайт⁴⁵ нээсэн байгаа боловч одоогоор ашиглах боломжгүй байна. Түүнчлэн Архангай аймгийн аялал жуулчлалтай холбоотой мэдээллийн сангийн сайт⁴⁶ нээсэн байгаа боловч энэ сайт ч мөн одоогоор ашиглах боломжгүй байгаа юм. Архангай аймгийн аялал жуулчлалын мэдээллийн төв нэртэй фейсбүүк хуудас⁴⁷ ч мөн нээгдсэн байна.

Энэ бүхнээс дүгнэж хэлэхэд, Хархорины бүс нутгийн тухай гадаадын жуулчдад зориулсан ойлгомжтой бөгөөд тогтвортой мэдээллийн эх сурвалж байхгүй байна. Мөн Архангай, Өвөрхангай аймгийн аялал жуулчлалын газруудыг танилцуулсан сайт, мэдээлэл (Монгол хэл, Англи хэл, Орос хэл, Хятад хэл, Япон хэл дээрх) хомс байна. Хэдийгээр үүнийг хувийн хэвшлийн компаниуд тус тусдаа хийж байгаа ч гэсэн жуулчдын сэтгэл ханамж, аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн, аялж очих газрын тухай зар сурталчилгааны үйл ажиллагааг улам ихээр эрчимжүүлж, шинээр хөгжүүлэх шаардлагатай байгаа юм.

Монголд ирж буй аялагчид #FEELMONGOLIA хаштагийг ашиглан Монголын тухай пост, мэдээллийг нийгмийн сүлжээн дээрээс хайж олох боломжтой болжээ. Фэйсбүүк, Твиттер, Инстаграм дээр олон нийтийн тохиргоотой оруулсан бүх пост, мэдээлэл нэгдсэн сурталчилгааны платформд автоматаар нэгтгэгдэж, Монголыг гадаад улсад сурталчлах контент болон үлдэж чадах юм. Гэвч энэ нь Монголд аялах хүсэлтэй хүн яг өөрийн хүсэж буй мэдээлэлдээ богино хугацаанд хүрч, мэдээллийг системтэйгээр цуглуулах талаас бол хангалтгүй юм. (Лавлах: <https://www.facebook.com/arkhangaiTouristinfoCenter/>)

Монгол улсыг гадаад улс орнуудад сурталчилсан контент бүтээх зорилгоор Монгол Улсын БОАЖ-ын яамнаас олон арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулж байна. Жишээлбэл, саяхан “Destination Mongolia by Amadeus & Ministry of Tourism, Mongolia” контентыг бүтээсэн байна.

Орхоны Хөндийн аялал жуулчлалын зорилгот зах зээлийг тодорхойлоогүй тул хувийн хэвшлийн аялал жуулчлалын байгууллагууд өөрийн байгууллагаас англи хэл дээр сурталчилгааны зарим нэгэн видео контентыг бүтээснээс өөр улсын байгууллагын нэгдсэн брэнд сурталчилгаа, контент одоогоор байхгүй байна.

Хүснэгт 3-59: Аялал жуулчлалын газруудын видео контент

Видео контент	Байгууллага	Холбоос
From Kharakhorin Local Naadam	Discover Mongolia Travel	https://www.facebook.com/DiscoverMongoliaTravel/videos/from-kharakhorin-local-naadam/2269741253340583/
Kharkhorin & Erdene Zuu Hiyd	Expoza Travel	https://www.youtube.com/watch?v=XvReY8GuvQM
Erdene zuu museum in Karakorum, Mongolia	Nomadic Expeditions	https://www.youtube.com/watch?v=zrq3j8IPO9g


Эх сурвалж: Судалгааны баг

2020 онд Хархорины 800 жилийн ой тохиосонтой холбогдуулан эртний нийслэлийн талаар Виртуал Хархорин контентыг бүтээсэн ба цаашид англи хэл болон бусад орны хэлнээ хөрвүүлэхээр ажиллаж байгаа аж.

⁴⁵ www.uvurkhangainature.com

⁴⁶ www.arkhangaitravel.org ; www.travelarkhangai.mn

⁴⁷ https://m.facebook.com/arkhangaiTouristinfoCenter/?_rd=1



Эх сурвалж: Өвөрхангай аймаг <https://www.youtube.com/watch?v=wk76ZCtDo-w&t=347s>

Зураг 3-29: 13-р зууны Монголын эзэнт гүрний нийслэл Хархорум хотыг танилцуулсан Виртуал Хархорин контент

Өвөрхангай аймгийн аялал жуулчлалын үзэсгэлэнт газрын болон маршрутын танилцуулга англи, япон хэл дээр байхгүй байна. Монгол хэл дээр веб сайт, сошиал медиаг ашигласан зарим хуудас байдаг ч байнга шинэчлэгддэггүй, шинэ мэдээ мэдээлэл дутмаг байдаг. Англи хэл дээр хайлт хийж үзэхэд мэдээлэл бүр ч хязгаарлагдаж, бараг олдохгүй байна. Компаниуд тус тусдаа өөр өөрсдийн мэдээллийг түгээж байгаа хэдий ч энэ бүх мэдээллийг нэг дор цуглуулсан, нэгдсэн портал болгох зайлшгүй шаардлагатай.

Бүс нутгийн маркетингийн асуудлаар сонирхогч талуудын хамтын ажиллагааг хангаж, бүс нутгийн иргэдийн оролцоотой стратеги төлөвлөлтийг боловсруулсан шилдэг жишээ нь “Орхоны хөндийн бүс нутгийн аялал жуулчлалын стратеги 2020” болон “Орхоны хөндийн Байгалийн Цогцолборт Газрын менежментийн төлөвлөгөө 2017-2021” юм. Бодлого төлөвлөлтийн энэ хоёр баримт бичгүүдэд аялал жуулчлалын маркетинг, сурталчилгааны стратегийг тодорхойлж, маркетингийн төлөвлөгөөг боловсруулсан байна.

Өвөрхангай аймгийн хувьд, Улаанбаатар хотод жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “ITM” аялал жуулчлалын олон улсын үзэсгэлэнд тус аймагт аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, ТББ-ын оролцоог хангаж хамтран оролцдог. Тухайлбал, уг үзэсгэлэнд 2013 онд Өвөрхангай аймаг түнш аймгаар оролцож, Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газар, Өвөрхангай аймгийн аялал жуулчлалын холбоо зэрэг байгууллагууд хамтран ажилласан байна. 2019 онд 29 аж ахуйн нэгж, байгууллага “ITM” аялал жуулчлалын олон улсын үзэсгэлэнд оролцож, аймгийнхаа үйл ажиллагааг сурталчилж, аялал жуулчлалын компаниудтай хамтран ажиллах гэрээ хэлэлцээрийг хийсэн байна.

Архангай аймаг нь “ITM” аялал жуулчлалын олон улсын үзэсгэлэнд 2014 оноос хойш тогтмол оролцож байгаа бөгөөд 2015 онд үзэсгэлэнгийн түнш аймгаар оролцож аймаг орон нутгаа сурталчилсан байна. Монголд зохион байгуулагдах аялал жуулчлалын маркетингийн иймэрхүү томоохон арга хэмжээнд Архангай аймгийн төрийн байгууллагаас гадна хувийн хэвшлийн аж ахуйн нэгжээс оролцогчид ч ихсэж байна.

Одоогоор Хархорины бүс нутгийн маркетингийн стратегийг тодорхойлж, үйл ажиллагааны гүйцэтгэлийг үнэлж дүгнэх байгууллага байхгүй байна. Тийм учраас энэ зорилгоор “Орхоны хөндийн бүс нутгийн аялал жуулчлалын стратеги 2020”-д зааснаар аймаг, сумдад Аялал Жуулчлалын Хөгжлийн Хороог байгуулсан боловч үйл ажиллагаа нь жигдрээгүй, тодорхойгүй байна. Орхоны хөндийн БЦГ-ын хамгаалалтын захиргаа нь өөрийн бүтцэд мэдээлэл, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэнтэй бөгөөд уг мэргэжилтэн тухайн БЦГ-ыг зах зээлтэй холбох, хамтран ажиллагсадтай харилцаа холбоо тогтоох, ТХГН-ийн мэдээлэл, судалгаа, зар сурталчилгаа, идэвхжүүлэлт, веб сайтын мэдээллийг шинэчлэх, удирдах зэрэг ажлуудыг хариуцан ажиллаж байна. Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын

захиргаа нь өөрийн веб сайтдаа аялал жуулчлалын эвент мэдээллийн буланг байршуулсан нь сайшаалтай явдал юм.

Хархоринд зочилж буй гадаадын жуулчдын ихэнх нь эртний Монголын нийслэл, байгалийн үзэсгэлэнт байдал, өргөн уудам орон зай, нүүдэлчин амьдралын хэв маяг, зэрлэг амьтан ургамлыг харах гэж ирдэг. Гэтэл аялал жуулчлалын гол газруудад жишээлбэл Орхоны хүрхрээ зэрэг зарим газар нутагт зуны улиралд хүн ихээр төвлөрч, түгжрэл үүсэх асуудал гардаг. Аялал жуулчлалын хөгжлийг даган гарч байгаа төлөвлөлт, санхүүгийн болон хүний нөөцийн менежментийн асуудлыг шийдвэрлэхгүй байгаа тул Орхоны хөндийн байгаль, түүх соёлын хосгүй нөөц, үзмэрүүдийн бүсэд байгаль орчин, нийгмийн сөрөг нөлөөллүүд үүсэж эхлээд байгаа юм. Байгаль орчинд жуулчны баазын үйл ажиллагаанаас үзүүлэх сөрөг нөлөөллийг жуулчны баазууд өөрсдөө хог хаягдал, газрын доройтол, зохицуулалтгүй зам харгуй гаргах, усны бохирдол хэмээн тодорхойлсон байна.⁴⁸ 2020 оны зун, Монгол улсын Экологийн цагдаагийн алба болон ЖАЙКА (Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны байгууллага) хамтран дотоодын аялагчдад чиглэсэн “Ирлээ Явлаа Цэвэр” аяныг зохион байгуулан ажилласан байна. Аяны хүрээнд иргэдийг байгаль орчинд ээлтэй хог хаягдалгүй аялахад уриалсан контентуудыг бэлтгэж, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, нийгмийн сүлжээнүүдээр түгээх, Улаанбаатар хотоос гарах болон аймаг руу орох постуудад “Аяллын дүрэм”-ыг түгээж, иргэдийн аялах боловсролд дэмжлэг үзүүлэх, иргэд олон нийтийн байгаль хамгаалах оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн багц арга хэмжээнүүдийг системтэйгээр зохион байгуулжээ.⁴⁹ Хархорины бүсийн нутгийн иргэд Монголд аялах гадаадын жуулчдыг хүлээн авахад эергээр ханддаг. Монгол улсын ерөнхийлөгч асан Х. Баттулга Өвөрхангай аймгийн Хархорин суманд айлчилж, нутгийн иргэдтэй хийсэн уулзалтын үеэр нутгийн иргэдийн зүгээс Хархорины бүсэд аялал жуулчлалыг хөгжүүлэхэд анхаарлаа хандуулж өгөхийг хүссэн байна.⁵⁰

3.3.9 SWOT шинжилгээ

Хархорин орчмын аялал жуулчлалын маршрут жуулчдад их таалагддаг. Учир нь Улаанбаатар хоттой ойрхон, Монголын түүх, уламжлал, соёлын өв талаасаа үзэж харах, зүйл ихтэй. 2004 онд Дэлхийн соёлын өвд бүртгэгдсэн Орхоны хөндийн соёлын дурсгалт газар нь үзэж сонирхох зүйлээр арвин, нутгийн иргэд өдгөө ч нүүдлийн мал аж ахуй эрхлэн амьдардаг юм. Тиймээс жуулчид эртний суурины туурь, балгас зэрэг түүхийн дурсгалт газар үзэж сонирхохоос гадна малчин айлын амьдрал ахуйтай танилцах боломжтой. Эргэн тойронд нь халуун рашаан, хүрхрээ зэрэг байгалийн үзэсгэлэнт газрууд их бөгөөд аялал жуулчлал ч нэлээд хөгжиж, жил бүр ирэх дотоодын аялагчид цөөнгүй байдаг ба дахин дахин ирэх хүмүүс ч олон. Орхоны хөндийг багтаасан Хархорин орчмын аялал жуулчлалын маршрут нь Монголын уламжлал, түүх, соёлыг сонирхдог жуулчдын сонирхлыг ихэд татдаг чиглэл билээ.

⁴⁸ 2011 он: НҮБХХ / Байгаль орчин, аялал жуулчлалын яам "Тусгай хамгаалалттай газар нутгийн аялал жуулчлалын орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийн судалгаа"

⁴⁹ “Жуулчдын хамгийн их очдог газруудад отоглох, хоноглох 100 цэг байгуулна” (Мэдээний сайт <https://www.montsame.mn/mn/read/250107> 2020.07.12)

⁵⁰ Эх сурвалж: “Хархорин сумын иргэд аялал жуулчлалын хөгжлийн асуудалд анхаарахыг Ерөнхийлөгчөөс хүслээ” (Мэдээний сайт <https://news.zindaa.mn/2dly> 2018.05.28)

Хүснэгт 3-60: Хархорин орчмын аялал жуулчлалын маршрутын давуу ба сул талууд (SWOT шинжилгээ)

	Нөөц бололцоо	Хязгаарлах нөхцөл
	Давуу тал Strength	Сул тал Weakness
Дотоод орчин	<p><u>Аялал жуулчлалын нөөц</u> -Дэлхийн өвд бүртгэгдсэн (Орхоны хөндийн соёлын дурсгалт газар) -Үзэсгэлэнт байгаль (Өргөн уудам тал, уул, нуур, уулын ургамал, амьтан) -Халуун рашаан, хүрхрээнд ойрхон жуулчны бааз -Эртний хотын тууриас олдсон олдворуудыг цуглуулсан Харахорум музей -Түрэгийн үеийн археологийн дурсгалууд -Монголын эзэнт гүрний нийслэл Хархорум хотын туурь -Эрдэнэ Зуу хийд (17 -р зуунд баригдсан)</p> <p><u>Дэд бүтэц</u> -Нийслэлээс хатуу хучилттай замаар явсаар 5 цагийн дотор хүрэх боломжтой</p> <p><u>Үйлчилгээ</u> -Амралтын газар, жуулчны бааз, гэр буудал хангалттай байдаг -Морь, тэмээ унуулах үйлчилгээтэй -Адууны өвөг болох Тахь үзэх боломжтой (Хархорин явах замд)</p>	<p><u>Аялал жуулчлалын нөөц</u> -Жуулчны бааз зэрэг хоноглох газарт үндэсний дуу хөгжим, бүжиг гэх мэт урлаг, уран сайхны хөтөлбөр дутмаг</p> <p><u>Дэд бүтэц</u> -Аялал жуулчлалын газарт хүрэх авто замын зарим хэсэг нь шороон зам байдаг -Нийтийн бие засах газар хүрэлцээ муутай, тохь тухгүй</p> <p><u>Хууль / Дүрэм</u> -Орхоны хөндийн аялал жуулчлалын зөвлөл идэвхтэй үйл ажиллагаа явуулдаггүй -Аялал жуулчлалын төсөв бага -ТББ идэвхтэй үйл ажиллагаа явуулдаггүй</p> <p><u>Мэдээлэл, сурталчилгаа</u> -Найдвартай мэдээллийн эх үүсвэр дутмаг</p>
	Боломж Opportunity	Аюул занал Threat
Гадаад орчин	<p><u>Мэдээлэл / Маркетинг</u> -Улаанбаатар хотоос хамгийн ойрхон аялал жуулчлалын газар гэдгээрээ алдартай -Байгалийн үзэсгэлэн, түүх соёлын дурсгалт газруудыг нэг дор үзэх боломжтой -Богино хугацааны аялагчид ч очиж үзэх боломжтой -13-р зууны Монголын эзэнт гүрнийг дэлхий даяараа мэддэг</p>	<p><u>Аялал жуулчлалын нөөц</u> -Уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны доройтлоос шалтгаалан экосистемийн тэнцвэрт байдал алдагдах аюултай -Байгаль хамгаалалт хангалттай бус байна</p> <p><u>Хууль / Дүрэм</u> -Жуулчдын тоо нэмэгдсэнээр хог хаягдлын асуудал үүсгэж болзошгүй</p> <p><u>Мэдээлэл / Маркетинг</u> -Дотооддоо өрсөлдөгчтэй (ялангуяа Архангай аймаг)</p>

Эх сурвалж: Судалгааны баг


(1) Хархорины аялал жуулчлалын маршрутыг хөгжүүлэх давуу тал

1) Аялал жуулчлалын нөөц

- ① Хархорины бүс нутаг нь, бүс нутаг тэр чигээрээ "Орхоны хөндийн соёлын дурсгалт газар" гэж Дэлхийн өвд бүртгэгдсэн, үзэсгэлэнт газар юм.
- ② Архангай аймагт Монголд ховор байдаг халуун рашаан (Цэнхэрийн халуун рашаан) болон Тэрхийн цагаан нуур зэрэг амралтын газрууд байдаг.
- ③ Өргөн уудам ногоон талтай, уулс сүндэрлэсэн энэ хангай нутагт эрт дээр үеэс Хүннү, Түрэг, Уйгар, Кидан зэрэг төрт улсууд нутаглаж ирсэн байдаг. Монгол үндэстнүүдийн хувьд 13-р зуунд 2 дахь их хаан Өгэдэй Монголын эзэнт гүрний нийслэл болгож байсан,

түүхийн аялал жуулчлалын нөөц газар юм.

- ④ Хархоринд 17-р зуунд баригдсан Эрдэнэ Зуу хийд, Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар барьж байгуулсан Хархорум музей байдаг нь эртний түүх дурсгалтай танилцах бүрэн боломжтой



Эрдэнэ Зуу хийд



Тэрхийн цагаан нуур



Хөшөө цайдам
(Түрэгийн үеийн хөшөө дурсгал)



Хар Балгас

2) Дэд бүтэц

- ① Улаанбаатараас Хархорин хүртэлх 365 км зайтай. Авто зам нь хатуу хучилттай тул машинаар 5 цаг орчим яваад Хархорин хүрэх боломжтой.
- ② Замд хувийн хэвшлийн амралтын газар болон цэвэрхэн, боловсон бие засах газар байдаг.
- ③ 2 шөнө 3 өдөр, 3 шөнө 4 өдөр гэх мэт харьцангуй богино хугацааны аяллаар ч Монгол орны түүх, соёл, байгалийн өвийг үзэж сонирхон, нүүдлийн мал аж ахуйтай танилцах боломжтой, нийслэлд хамгийн ойрхон аялал жуулчлалын газар юм.
- ④ Эрчим хүч, харилцаа холбооны сүлжээ ашиглах боломжтой.

3) Хууль/Дүрэм

- ① Хангайн нурууны ойр орчмын бүс нутгийг байгалийн цогцолборт газар болгосон бөгөөд Дэлхийн өвд бүртгэгдэж, хамгаалагдсан.

4) Үйлчилгээ

- ① Амралтын газар, жуулчны бааз их байдаг бөгөөд гэрт хонож үзэх, морь, тэмээ унах зэрэг үйлчилгээтэй.

- ② Адууны өвөг болох тахь үзэж, ардын бүжиг гэх мэт үндэсний соёлтой танилцах боломжтой.

5) Мэдээлэл / Маркетинг

- ① Хархорум музейд Орхоны хөндий, Хархорум хотын тууриас олдсон биет олдворуудыг дэлгэн үзүүлдэг. Өмнө нь ЖАЙКА-ийн Далайн чанад дахь сайн дурын гишүүн идэвхтэйгээр үйл ажиллагаа явуулж байсан бөгөөд үзмэрийн тайлбар англи, япон хэлээр бичигдсэн байдаг нь гадаадын жуулчдад ойлгомжтой байдаг.
- ② Дээр дурдсанчлан Дэлхийн соёлын өвд бүртгэгдсэн, гадаадын жуулчдын сонирхлыг татах өндөр магадлалтай аялал жуулчлалын газар тул, аймгийн холбогдох газрууд аялал жуулчлалын мэдээлэл, танилцуулгыг англи болон бусад гадаад хэл дээр хөрвүүлэх зэргээр гадаадын жуулчин хүлээж авах орчныг бүрдүүлж чадвал жуулчдын тоог нэмэгдүүлэх бүрэн боломжтой юм.

(2) Хархорины аялал жуулчлалын маршрутын хөгжлийг хязгаарлах нөхцөл

1) Аялал жуулчлалын нөөц

- ① Өвөрхангай аймгийн төв болон өмнөд хэсэг дэх аялал жуулчлалын нөөц хөгжөөгүй.

2) Дэд бүтэц

- ① Улаанбаатараас аялал жуулчлалын газар болох Хархорин хүртэл онгоц нисдэггүй тул, хатуу хучилттай замаар 5 цаг орчим явахаас өөр сонголт байхгүй.
- ② Хархориноос бусад Өвөрхангай аймгийн аялал жуулчлалын газрууд нь гол төлөв аймгийн хойд хэсэгт, Архангай аймгийн хилийн ойролцоо байрладаг ба шороон зам ихтэй тул цаг их зарцуулж байж очдог.
- ③ Зүүн-баруун төв авто замаас салж Хөшөө Цайдам, Өгий нуураар дайраад зүүн-баруун төв авто зам руу нийлэх зам болон зүүн-баруун төв авто замаас Цэнхэрийн халуун рашаан хүрэх зам хатуу хучилтгүй байна.
- ④ Дээр дурдсанчлан Хархорин-Орхон орчмын аялал жуулчлалын гол газруудын хоорондох зам нь хатуу хучилтгүй бөгөөд ялангуяа Хөшөө Цайдамаас Өгий нуураар дайраад Зүүн-Баруун төв авто зам хүрэх зам, аймгийн өмнөд хэсэгт байдаг Хужирт, Төвхөн хийд орчмын авто замыг яаралтай хатуу хучилттай болгох шаардлагатай байна.
- ⑤ Архангай аймаг нь хүний гар хүрээгүй онгон байгалиараа алдартай боловч гол аялал жуулчлалын газрууд нь төв авто замаас хол, хатуу хучилтгүй замтай байдаг тул очиход хүндрэлтэй байдаг. Зам дагуу амрах цэг, нийтийн бие засах газар ч дутагдалтай. Тариат суманд цогцолбор барих Засгийн газрын төлөвлөгөө байгаа ба энэ төлөвлөгөөнөөс тусад нь нийтийн бие засах газар барих шаардлагатай байна.

3) Хууль, Дүрэм

- ① Хархорин дахь аялал жуулчлалын газруудыг тусгай хамгаалалттай газар нутаг гэж тодорхойлсон байгаа боловч хяналтын систем сул, аялагч, жуулчдад зориулсан ёс зүйн сургалт, сурталчилгааг хангалттай явуулдаггүй хэвээр байна.
- ② Хог хаягдлыг зөв зохистой цэвэрлэж, боловсруулахгүй байгаа бөгөөд энэ нь байгаль орчинд сөргөөр нөлөөлж эхэлж байгаа тухай жуулчны баазууд мэдээлж байна. Мөн тусгай хамгаалалттай газар нутагт тээврийн хэрэгслээр дамжин өнгөрөх замыг тодорхой болгож зохицуулахгүй байгаа нь байгаль орчныг доройтуулан сүйтгэх шалтгаан болох вий хэмээн эмзэглэж байгаа юм.
- ③ Тусгай хамгаалалттай бүсэд зориулалтын зам барьж дуусаагүй, эсвэл тусгайлан зориулсан зам байхгүй. Тусгай хамгаалалттай газар нутагт байрлах жуулчны баазууд нь байгаль орчинд сөрөг нөлөөлөл учруулж болзошгүй тул жуулчны бааз барих газрыг тусгайлан тогтоож, байгуулж өгөх шаардлагатай.

- ④ Замын тэмдэг, тэмдэглэгээ, аялал жуулчлалын мэдээллийн самбар зэрэг нь хуучирч муудан, орчны өнгө үзэмжид муугаар нөлөөлж байгаа газар ч байна.
- ⑤ Тусгай хамгаалалттай газарт нэвтрэх хураамж нь гадаадын иргэд 3000 төгрөг байдаг бол Монгол хүн 300 төгрөг байдаг. Энэ нь хэтэрхий хямд байгаа тул аялж буй жуулчдын ухамсар ч дээшлэхгүй түүнээс гадна менежментийн зардлыг ч нөхөж чаддаггүй.

4) Үйлчилгээ

- ① Бусад бүс нутагтай харьцуулахад харьцангуй олон тооны жуулчин хүлээн авдаг тул жуулчдад хэт дасаад цаашид сэтгэлээсээ үйлчлэх хандлага буурах магадлалтай.
- ② Аялал жуулчлалтай холбоотой ажил үйлчилгээ эрхэлж чадахгүй тохиолдолд, нутгийн иргэдийн дунд орлогын ялгаатай байдал үүсэж, зөрчилдөх эрсдэлтэй.

5) Мэдээлэл / Маркетинг

- ① Дэлхийд цорын ганц Монголын эзэнт гүрний түүхэн дурсгалт газрыг, аялал жуулчлалын бусад боломжит газруудтай хослуулах боломж бүрэн ашиглагдаагүй.
- ② Бүс нутгийн иргэд нийтээрээ нэгдэн оролцож ажиллах зөөлөн талбарын аялал жуулчлалын хөгжлийг идэвхжүүлэх шаардлагатай байгаа юм. Зөвхөн хувийн хэвшлүүд өрсөлдөж маркетинг хийх бус, Монголын эзэнт гүрнийг мэдрүүлэхийн тулд бүс нутгийн иргэд бүх нийтээрээ нэгдэн аялал жуулчлалыг хөгжүүлэх хүчин чармайлт гаргах нь зүйтэй юм.

3.4 Улаанбаатар хот орчмын аялал жуулчлалын маршрут

3.4.1 Аялал жуулчлалын нөөцийн тухай

(1) Улаанбаатар хот

Улаанбаатар хот нь Монгол улсын дэд бүтэц, мөнгө санхүү, соёл урлаг, спорт, боловсрол, шинжлэх ухаан, эдийн засгийн зэрэг бүх салбарын төв нь болдог, стратегийн чухал ач холбогдолтой засаг захиргааны нэгж юм.

Төмөр зам, олон улсын болон дотоодын нислэгүүдийн гол зангилаа нь Улаанбаатар хот болдог тул Монголын аялал жуулчлалын гол бүс нутагт зүй ёсоор тооцогдоно. Гадаадын жуулчид зун их ирдэг хэдий ч Улаанбаатар нь хөдөө орон нутгийн иргэд 4 улирлын туршид ирдэг, соёл урлаг, нийтийг хамарсан арга хэмжээнүүд тогтмол болдог их хот юм. Монгол улсын аялал жуулчлалын хамгийн сайн зэрэглэлийн зочид буудлууд, тур оператор компаниуд, үзвэр үйлчилгээний газрууд энэ хотод байрлана.

Хүснэгт 3-61: Улаанбаатар хотын аялал жуулчлалын гол нөөцүүд

Аялал жуулчлалын гол үзмэрүүд	Улирал	Товч мэдээлэл
Гандантэгчэнлин хийд	Тогтмол	1727 онд баригдсан ба Монголын бурхны шашинтны төв хийд юм. Мэгжиджанрайсаг бурхан хэмээх 26 метр өндөр их шүтээн Мэгжиджанрайсаг сүмд байрладаг ба Буддын шашны их сургууль, уламжлалт анагаах ухааны хүрээлэнтэй шашны цогц байгууламж юм.
Занабазарын нэрэмжит дүрслэх урлагийн музей	Тогтмол	Анхдугаар Богд Жавзандамба хутагт Өндөр гэгээн Занабазарын сийлсэн бурхад болон бүтээлүүд олноор тавигдсан байдаг. Занабазар нь Дорно дахины Микеланжело хэмээн алдаршсан байдаг.
Зайсан толгой	Тогтмол	Толгой дээрээс Улаанбаатар хотыг тольдон харах боломжтой. 1945 онд Японыг ялсан Монгол, Зөвлөлтийн дайчдын дурсгалын цогцолбор байдаг.
Богд хааны ордон музей	Тогтмол	Амьд Будда Богд хааны ордон. Хамгийн сүүлчийн Богд болох ҮШ Богд хааны цуглуулсан эд зүйлс болон Өндөр гэгээн Занабазарын бүтээлүүдийг дэлгэн харуулсан байдаг.
Чойжин ламын сүм музей	Тогтмол	Буддын шашны сүмийн музей бөгөөд Занабазарын бүтээлээс гадна бурхдын уран нарийн хийцтэй дэлгэмэл зураг, цамын баг өмсгөлүүд зэрэг шашин, соёл урлагийн олон зүйл хадгалагдаж байдаг.
Монголын Үндэсний Музей	Тогтмол	Монголчуудын түүх, соёл, угсаатны зүйн өвөрмөц өв шинжийг агуулсан төрөл бүрийн үзмэр цуглуулгатай үндэсний хэмжээний төв музей юм.
Үлэг гүрвэлийн төв музей	Тогтмол	Монгол орон бол үлэг гүрвэлийн өлгий нутаг юм. Байгалийн түүхийн музейн барилга нь хуучирч ашиглах боломжгүй болж хаагдсан ба одоогийн Үлэг гүрвэлийн төв музейд АНУ-аас буцаж ирсэн, хууль бусаар хил давсан олдворууд л зөвхөн байдаг. Байгалийн түүхийн музейд тавигдаж байсан олдворууд энэ музейд тавигдаагүй бөгөөд үлэг гүрвэлийн музей гэж хэлэхэд учир дутагдалтай.
Монголын уран зургийн галерей	Тогтмол	Монгол улс тусгаар тогтносноос хойших, орчин үеийн уран зургийн үзмэрүүдийг байнга үзүүлэхээс гадна төрөл бүрийн үзэсгэлэнг зохион байгуулж гаргадаг.
Монгол Цэргийн музей	Тогтмол	Дайны түүх, зэвсэг болон цэргийн дүрэмт хувцасны үзмэрүүд байдаг.
Арт Галерей	Тогтмол	Монголын Урчуудын Эвлэлийн Арт Галерейд уран зураг, урлагийн үзэсгэлэнг үнэ төлбөргүйгээр байнга үзэх боломжтой.

Аялал жуулчлалын гол үзмэрүүд	Улирал	Товч мэдээлэл
Улсын Драммын Эрдмийн Театр	Тогтмол бус	Үндэсний дуу бүжгийн эрдмийн чуулгын тоглолтыг голчлон зохион байгуулдаг.
Соёлын төв өргөө	Тогтмол бус	Морин хуурын чуулга, Симфони Найрал Хөгжмийн тоглолтууд болдог.
Улсын Дуурь Бүжгийн Эрдмийн Театр	Тогтмол бус	Дэлхийн болон Монголын сонгодог дуурь, балетын тоглолт жилийн турш тавигддаг.
Морин хуурын чуулга	Тогтмол бус	Монгол улсын Филармонийн харьяа бөгөөд тоглолт нь тогтмол бус байдаг.
Түмэн Эх чуулга	Тогтмол	Морин хуур, хөөмий, уртын дуу зэрэг ардын урлагийн олон төрлийг багтаасан тоглолтыг байнга зохион байгуулдаг.
"Говь" ХК-ийн ноолуурын үйлдвэр	Тогтмол	Японы Засгийн газрын тусламж дэмжлэгээр баригдсан ноолуурын үйлдвэр. Ноолууран барааны дэлгүүр болон ресторан байдаг.

Эх сурвалж: Судалгааны баг

(2) Төв аймаг

74,042км² газар нутагтай, 94,250 хүн амтай (2020 он) аймаг юм. Нутгийн төв хэсэгт Нийслэл Улаанбаатар хот оршдог тул том зах зээлд ойрхон, дэд бүтэц хамгийн сайн хөгжсөн онцлогтой аймаг ба бусад аймгуудтай харьцуулахад газар зүйн хувьд давуу талтай юм. Улаанбаатар хотоос 50 км алслагдсан аймгийн төв Зуунмод хот нь хатуу хучилттай хар замаар нийслэл Улаанбаатар хот болон өмнө зүгийн Дундговь аймгийн Мандалговь, хойд зүгийн Дархан хоттой шууд холбогдсон байдаг. Аймгийн бүх сум эрчим хүчний нэгдсэн сүлжээнд бүрэн холбогдсон. ЖАЙКА (Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны байгууллага) -гийн хөнгөлөлттэй зээлээр шинэ нисэх онгоцны буудал баригдаж 2021 оны 7-р сарын 4-нд ашиглалтад орсон юм.

Төв аймагт нийслэл Улаанбаатар хотоос гадна Шинэ Улаанбаатар олон улсын нисэх буудал, Горхи-Тэрэлж БЦГ, Хустайн Нуруу БЦГ гэх мэт Монголын аялал жуулчлалын гол нэртэй газрууд байдаг тул аялал жуулчлалаас өндөр үр өгөөж гаргаж болох боломжтой аймаг юм.

Төв аймагт байрладаг Горхи-Тэрэлж БЦГ нь Улаанбаатар хотоос ойрхон 70 км зайд байдаг ба хамгийн олон жуулчны гэр баазууд байдаг. Асар том Мэлхий хад, өвөрмөц тогтоцтой хад асга үзэж болохоос гадна Туул голын эрэг дагуух ойн бүсэд зугаалах, тансаг зэрэглэлийн зочид буудалд амрах, морь унах, цэцэг ургамал, эрвээхэй ажиглах зэргээр Монголын үзэсгэлэнт байгаль, нүүдлийн мал аж ахуйтай танилцах боломжтой, нийслэлд хамгийн ойрхон аялал жуулчлалын газар гэдгээрээ алдартай.

Хүснэгт 3-62: Улаанбаатар хот орчмын аялал жуулчлалын гол газрууд

Аялал жуулчлалын гол газрууд	Улирал	Товч мэдээлэл
Горхи-Тэрэлж БЦГ	Тогтмол	Тал нутаг, өвөрмөц тогтоцтой хад асга, Туул гол зэрэг байгалийн үзэмжийг үзэж сонирхохоос гадна морь унах, цэцэг эрвээхэйг ажиглах, гэрт хонож үзэх боломжтой.
Хустайн БЦГ	Тогтмол	19-р зууны сүүлчээр Орос улсын судлаач анх олж илрүүлсэн Монгол адууны өвөг гэгддэг тахь чөлөөтэй бэлчиж байдаг газар юм. Ойролцоох газарт морь унаж үзэх ч боломжтой.
Цонжин болдог Цогцолбор	Тогтмол	Чингис хааны хөшөө болон хөшөөнөөс харагдах үзэмж, хааны музей, Гиннест бүртгэгдсэн дэлхийн хамгийн том гутал (үндэсний гутал) гэх мэт зүйлийг үзэж сонирхох боломжтой. Эргэн тойронд нь гэр буудал олон байдаг.

Аялал жуулчлалын гол газрууд	Улирал	Товч мэдээлэл
Nomadic Mongolia	Зун	Эсгий хийх, үнээ саах зэрэг Монголын нүүдэлчдийн ахуй соёлтой танилцахаас гадна үндэсний хоол, хүнсийг амтлах боломжтой.
13-р Зуун Цогцолбор	Зун	Монголын ард түмний уламжлалт соёлтой танилцах боломжтой.

Эх сурвалж: Судалгааны баг

3.4.2 Төлөвлөгөө / Аян / Арга хэмжээ

(1) Улсын түвшний төлөвлөгөө

Улаанбаатар хот болон Улаанбаатар хотыг хүрээлэх Төв аймгийн тухайд, "Алсын хараа 2050" -ын "Бүсчилсэн хөгжил" 8-р бүлэгт "Бизнесийн аялал жуулчлалыг хөгжүүлнэ" гэсэн зорилт тавигдсан байна. Мөн "Улаанбаатар ба дагуул хот" гэсэн 9-р бүлэгт "Үндэсний онцлог бүхий аялал жуулчлал, соёлын үйлчилгээг бий болгосон, Зүүн хойд Азийн тээвэр, логистикийн болон олон улсын харилцааны зангилаа төв хот болсон дагуул хотуудыг хөгжүүлнэ" гэсэн зорилт тавигджээ. Тодруулбал, "Шинэ Зуунмод", "Майдар" хотыг дагуул хот болгон үе шаттайгаар хөгжүүлж, Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах зорилгоор зарим чиг үүргийг шилжүүлэх зорилготой гэсэн байна.

"Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого" -д Улаанбаатар хотод бизнес аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ гэж заажээ. Аялал жуулчлалын тухай "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн хавсралт хүснэгтэд, Манзуширын хийдийн түүхэн дурсгалт цогцолбор, соёл, шашин, аялал жуулчлалын төв, Улаанбаатар хотын олон улсын төмөр замын төв буудал, Монголын үндэсний археологи, угсаатны зүйн музей, лаборатори, Соёлын Яамны барилга зэргийг шинээр барьж, бүтээн байгуулахаар төлөвлөсөн байна.

(2) Бүс нутгийн түвшний төлөвлөгөө

Нийслэлийн ИТХ-аар 2020 оны 12-р сард баталсан "Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" д аялал жуулчлалын талаар дараах зүйлийг тусгасан байна.

- (a) Үндэсний агуулга шингээсэн урлагийг хөгжүүлэх замаар иргэд, олон нийт болон гадаадын жуулчдын ойлголтыг гүнзгийрүүлнэ хэмээгээд зохион байгуулах үйл ажиллагааны тоог 101, музейн үзэгчдийн тоог 446,800 хүргэнэ гэж тогтоожээ.
- (b) Үндэсний онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, олон улсын аялал жуулчлалын зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэхийг зорилт болгож, үнэлгээний шалгуурыг нийслэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээг 2025 он хүртэл жилд 1 удаа зохион байгуулах, Монголд хүлээн авах жуулчдын тоог 900,000-д хүргэх, аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ 21 төрлийг хөгжүүлэх гэж тогтоожээ.

Уг үндсэн чиглэлтэй хамт батлагдсан "Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн агуулгыг энэхүү таван жилийн үндсэн чиглэлд нийцүүлсэн бөгөөд "жуулчдыг татах аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлж, зорин очих газрын дэд бүтцийг сайжруулах, жуулчдын аюулгүй байдлыг хангах, Нийслэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, Ковид-19-ын дараах Нийслэлийн аялал жуулчлалыг сэргээх, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх" зэрэг төлөвлөгөөг тусгасан байна.

Хотын Захирагч солигдох үеэр шинэ хотын Захирагч шинэ бодлого, хөтөлбөрөө зарладаг. Шинэ хотын Захирагч 2021 оны 1-р сард ажилдаа орсон боловч 2021 оны 4-р сарын байдлаар хараахан үйл ажиллагааны хөтөлбөрөө зарлаагүй байгаа бөгөөд дээрх хөтөлбөрийг шинэ удирдлага хэрхэн хэрэгжүүлэхийг тодорхойлж хэлэх боломжгүй байна. Монголд ажил хэргийн аялал жуулчлал болох МСЕ-ийг хөгжүүлэх хөтөлбөрийг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас БОАЖЯ-нд 2020 оны 8-р сард хүргүүлсэн боловч хараахан батлагдаагүй байна.

1) Улаанбаатар хот

Монгол улсын нийслэл Улаанбаатар хот нь 4700 км² газар нутагтай, 1,585,000 хүн амтай буюу Монгол улсын нийт хүн амын бараг тал хувь нь амьдардаг (2020 он). Улаанбаатар хот нь Монгол улсын дэд бүтэц, санхүү, соёл, спорт, боловсрол, шинжлэх ухаан, эдийн засаг зэрэг бүхий л үйл ажиллагааны төв болж байдаг. Түүнчлэн төмөр замын шугам, дотоодын болон олон улсын нислэгийн зангилаа хот юм. Аялал жуулчлалын талаасаа бол музей, уран зургийн галерей, сүм хийдүүд олон байдаг бөгөөд морин хуур гэх мэт уламжлалт соёл урлагтай ч хялбархан танилцах боломжтой. Мөн олон зочид буудал, аялал жуулчлалын агентлагууд Улаанбаатар хот болон хотын эргэн тойронд байрладаг.

Ардчилсан намаас гаралтай хотын Захирагч Э.Бат-Үүл 2016 онд огцорсны дараа одоогийн хотын Захирагч Сумьяабазар томилогдох хүртэл МАН-ын Засгийн эрхэн дор нийт 5 удаа хотын Захирагч солигджээ. Хотын Захирагч ойр ойрхон солигдсоноос болоод “Найрсаг Улаанбаатар” аялал жуулчлалын аян зогссон байна. НИТХ-ын 2020 оны 12-р сарын 4-ний өдрийн 02/09 тоот тогтоолоор "Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийг баталсан ба аялал жуулчлалтай холбоотой дараах зүйлүүд тусгагджээ. Үндсэн чиглэлийн тэргүүний зорилгод "1.1. Үндэсний эв нэгдэл, Монголын өв соёлыг сурталчилсан соёлын олон талт ажил зохион байгуулна" гэж заасан бөгөөд үүнийгээ илүү тодотгоод "1.1.1. Урлагийн төрөл зүйлийг хөгжүүлэх замаар, иргэд, олон нийт болон гадаадын жуулчдад сурталчлан таниулах ажлыг эрчимжүүлж, үндэсний агуулга шингэсэн бүтээлийн тоог нэмэгдүүлнэ" гэжээ.

Энэхүү зорилтыг үнэлэх шалгуурыг "(1) 2025 он хүртэл, үндэсний агуулга шингэсэн урлагийн бүтээл 6, (2) иргэд, жуулчдад зориулан зохион байгуулах үйл ажиллагаа 101, музейн үзэгчдийн тоог 446,800д хүргэх" хэмээн тогтоосон байна. Энэ бүх үйл ажиллагааг Нийслэлийн Соёл, урлагийн газар хариуцна гэж заажээ.

Эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг "4.3 Эдийн засгийн бүтцийг төрөлжүүлж, бүтээлч эдийн засгийг хөгжүүлнэ" хэмээсэн ба үүнийгээ илүү тодотгож "4.3.1 Үндэсний онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, олон улсын аялал жуулчлалын зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ" гэж тогтоожээ. Энэхүү зорилтын үнэлгээний шалгуурыг "(1) 2025 он хүртэл нийслэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээг жилд 1ийг зохион байгуулах, (2) Монголд хүлээн авах гадаадын жуулчдын тоог 900,000д хүргэх, (3) шинээр нэвтрүүлсэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ 21 төрлийг гаргана" хэмээн тогтоосон байна. Энэ бүх үйл ажиллагааг Нийслэлийн Аялал жуулчлалын газар хариуцна гэж заажээ.

Дээрх үндсэн бодлогод нийцүүлэн НИТХ-ын 2020 оны 12-р сарын 4-ний өдрийн 02/10 тоот тогтоолоор “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг баталсан ба дараах зүйлүүдийг тусгажээ.

2.6.4 Урлагийн олон төрөл зүйлийг жигд хөгжүүлж, иргэд, олон нийт болон гадаадын жуулчдад сурталчлан таниулах ажлыг эрчимжүүлж, үндэсний агуулга шингэсэн бүтээлийн тоог нэмэгдүүлнэ.
2.6.7 Улс, нийслэл, дүүргийн хамгаалалтад байх түүх соёлын дурсгалт газар, барилга байгууламжийг бүсчлэн хувааж аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгоно.
3.4 Улаанбаатарын онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлнэ.
3.4.1 Жуулчдыг татах аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлж, зорин очих газрын дэд бүтцийг сайжруулна
3.4.2 Аялал жуулчлалын салбарт инновацыг нэвтрүүлж, гадаад, дотоодын хамтын ажиллагааг өргөжүүлж, сурталчилгаа, маркетингийн ажлыг нэмэгдүүлнэ.
3.4.3 Жуулчдын аюулгүй байдлыг хангах чиглэлээр олон талт арга хэмжээг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна.
3.4.4 “Нийслэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээ”-г боловсруулж, хэрэгжүүлнэ.
3.4.5 Ковидын дараах Нийслэлийн аялал жуулчлалыг сэргээх хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ.

а) Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2016-2020 оны үйл ажиллагааны тайлан 2020 он

Уг тайланд дараах байдлаар хэрэгжилтийг үнэлж тайлагнасан байгаа боловч 1. болон 2. ын

тухайд, үйл ажиллагааны нэр, үнэлгээний шалгуурын талаар тодорхой тайлбар байхгүй байгаа тул бодит байдлын үнэлгээ хийхэд учир дутагдалтай юм.

<p>1. Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын “Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хэрэгжилт</p> <p>Тус үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нийслэлийн Аялал жуулчлалын газраас хэрэгжүүлэхээр 4 зорилтын 6 арга хэмжээ тусгагдсан. Тайлант хугацаанд 5 арга хэмжээ 100%, 1 арга хэмжээ 70% , нийт хөтөлбөрийн 95%-тай байна. Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд нийт 5 зорилт, 29 арга хэмжээний 63 ажлыг хэрэгжүүлэхээс 62 ажлыг хийж, 1 ажлыг үнэлэх боломжгүй, нийт хэрэгжилт 100 хувийн үр дүнтэй байна.</p>
<p>2. Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт</p> <p>Тус аялал жуулчлалын газраас хариуцан хэрэгжүүлэх 9 заалт тусгагдсан. 2020 оны байдлаар 9 заалтыг 100%-ийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлэн ажилласан байна.</p>
<p>3. Аялал жуулчлалын газрын 2020 оны үйл ажиллагаа</p> <p>Ковид-19 халдвар тархалтаас урьдчилан сэргийлэх үүднээс, аялагч жуулчдад зориулсан аялал жуулчлалын зарим эвент арга хэмжээ болон гадаад орнуудад Монгол орныг сурталчлах зарим арга хэмжээнүүд цуцлагдсан. Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор “ Улаанбаатар травэл экспо-2020 ” цахим үзэсгэлэнг зохион байгуулсан байна. Энэхүү цахим үзэсгэлэнгийн 3 өдрийн үйл ажиллагааг нийт 6 сошиал хаягаар шууд дамжуулалт хийж 56,800 гаруй иргэд үзэж сонирхсон байна. Түүнчлэн “ Улаанбаатар явган аяллын фестиваль ” болон сурагчдад зориулсан хотын аялал “ E-bus city tour ” зохион байгуулжээ.</p>

б) "Найрсаг Улаанбаатар" хөтөлбөр

Хөтөлбөрийн агуулга: Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 9-р сарын 22-ны өдрийн 19-р хуралдаанаар баталсан “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрт (Hospitable Ulaanbaatar) 2016 он гэхэд 7 зорилтын хүрээнд 25 ажлыг хийхээр төлөвлөжээ.

1-р зорилтоор, хөтөлбөрийн хүрээнд аялал жуулчлалын эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, бизнес эрхлэгчдийг дэмжих бодлого, зохицуулалтыг оновчтой болгох ажлууд хийгдэхээр заасан байна. Үүнд, зочид буудал, дэн буудлын стандартыг шинэчлэх, нийслэл хотын албан татварын тухай хууль батлагдсантай холбогдуулан жуулчдын тоог ор/хоногоор тооцох аргачлалд шилжих, төрийн байгууллагуудаас зохион байгуулдаг олон улсын хурал, зөвлөгөөн, арга хэмжээг аялал жуулчлалын бус үед зохион байгуулах зэрэг зохицуулалтын ажлууд багтаж байна.

2-р зорилтоор, гадаад дотоодын жуулчид Улаанбаатар хотод аюулгүй зорчих, шаардлагатай мэдээлэл, туслалцааг шуурхай авах нөхцөлийг бүрдүүлэх ажлууд төлөвлөгджээ. Үүнд, “Жуулчны мэдээллийн лавлах утас”-ны үйлчилгээг технологийн дэвшилд тулгуурлан сайжруулах, Улаанбаатар хотын үйлчилгээний газруудын хаяг, байршлын мэдээллийг Google Map-д 3D хэлбэрээр оруулж, иргэд жуулчид гар утас, ухаалаг төхөөрөмжөө ашиглан хялбар зорчих, ойр орчмын үйлчилгээний газруудынхаа мэдээллийг авах боломжийг бүрдүүлэх ажлууд багтсан байна. Мөн Нийслэлийн аялал жуулчлалын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх болсон байна.

3-р зорилтын хүрээнд гадаад, дотоодын жуулчид, иргэдэд зориулсан амралт, аялал жуулчлалын төвүүдийг байгуулж, алжаал тайлах тав тухын орчныг бий болгох ажлууд хийгдэнэ гэжээ. Тухайлбал хот орчмын явган аяллын нэг гол чиглэлийг олон улсын стандартын дагуу үлгэр жишээ тохижуулах, НИТХ-аас батлагдсан Улаанбаатар хотын аяллын гол маршрутын дагуу, гудамж талбайд хийгдэх тохижилтын ажлууд багтаж байна.

4-р зорилт буюу Улаанбаатар хотыг аялал жуулчлалын зорих газар болгон гадаадад сурталчлах ажлын хүрээнд ХБНГУ, ОХУ, БНХАУ, Япон, Хонгконг зэрэг орнуудад зохиогддог дэлхийд тэргүүлэх аялал жуулчлалын үзэсгэлэн, яармагуудад Улаанбаатар хотыг сурталчлан оролцох, олон улсын нэр хүндтэй сонин, сэтгүүл, хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран Улаанбаатарын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үзмэрүүдийг сурталчлах цогц ажлууд хийгджээ.

5-р зорилт буюу Улаанбаатар хотын онцлог, давуу талыг тусгасан, жуулчдын хэрэгцээнд нийцсэн аяллын бүтээгдэхүүн, шинэ үйлчилгээг гаргах ажлын хүрээнд Хүрэлтогоот дахь одон

орон судлалын төвийг гадаад, дотоодын жуулчдад нээлттэй, аялал жуулчлалын төв болгох ажлыг эхлүүлэх, Улаанбаатар хотын нийтийн тээврээр зорчих, үзвэр, үйлчилгээний газруудад багцын үнээр үйлчлүүлэх боломжтой “Жуулчин” картыг үйлчилгээнд нэвтрүүлэх, агаарын такси үйлчилгээ нэвтрүүлэх эхний шатны ажлууд хийгдсэн байна.

6-р зорилтын хүрээнд жуулчдыг татах урлаг, спорт, олон нийтийн арга хэмжээг зохион байгуулах юм. Үндэсний их баяр наадмын үеэр жуулчдад зориулсан 7 томоохон олон нийтийг хамарсан соёл, урлагийн арга хэмжээ, бусад хугацаанд 21 соёл урлаг, спорт, аялал жуулчлалын арга хэмжээг зохион байгуулагджээ.

7-р зорилт буюу бүх төрлийн үйлчилгээнд найрсаг харилцаа, хандлагыг төлөвшүүлж хотын соёлыг дэлгэрүүлэх ажлын хүрээнд өндөр хөгжилтэй орны сургалтын хөтөлбөрөөр үйлчилгээний менежментийн сургалтууд явуулж, 2000 үйлчилгээний ажилтныг бэлтгэж мэргэшүүлэх юм. Үйлчилгээний болон хотын соёлыг дэлгэрүүлэх “Инээмсэглэх Монгол”, “Найрсаг Улаанбаатар” зэрэг нийгмийн аяныг явуулж эхэлжээ.

“Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд жил бүрийн нийслэлийн төсвийн 5 хувийг зарцуулж байхаар НИТХ-аас шийдвэрлэжээ. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалт, шаардагдах зардлыг Нийслэлийн Засаг Даргын Тамгын газар жил бүр хэлэлцэж баталдаг бөгөөд 2015 оны төсвийг 460 сая төгрөг байхаар шийдвэрлэсэн байна. Мөн онд 44 төсөл хэрэгжүүлж, нийт 420 сая төгрөг, 2016 онд 350 сая төгрөгийн төсөв шийдвэрлэж, 42 төсөл хэрэгжүүлсэн байна. Энэхүү хөтөлбөрийг Нийслэлийн Соёл урлагийн газар, Нийслэлийн соёл, спортын газар, Нийслэлийн эрүүл мэндийн газар, Нийслэлийн цагдаагийн газар, Нийслэлийн хөрөнгө, санхүү хариуцсан газар хэлтсүүд, Нийслэлийн татварын газартай хамтран хэрэгжүүлж, төслийн хэрэгжилт 95% байжээ.

Хөтөлбөрийн эхний шатны үйл ажиллагаа 95% -ийн гүйцэтгэлтэй гэж байгаа боловч одоогийн байдлаар албан ёсны тайлан гараагүй байгаа юм. Хөтөлбөрийн 2, 3-р үе шатыг хэрэгжүүлээгүй тул, хэрэгжилтийн хувь нь хөтөлбөрийн нийт гүйцэтгэлийн 30 орчим хувийг л эзэлж байгаа болно. Уг хөтөлбөр нь 2017 оноос хойш түр зогссон бөгөөд 2019 он гэхэд хэрэгжүүлээгүй хэвээрээ байв. Орон нутгийн сонгуулийн дараа шинээр томилогдсон удирдах албан тушаалтнууд аялал жуулчлалыг хөгжүүлэх шинэ хөтөлбөрөө зарладаг. Одоогийн шинэ удирдах албан тушаалтнууд хөтөлбөрөө зарлаагүй байна. 2020 оны 8-р сард Улаанбаатар хотын Аялал жуулчлалын газраас боловсруулж гаргасан “Монголд ажил хэргийн аялал жуулчлал болох МИСЕ-ийг хөгжүүлэх хөтөлбөр” ийг БОАЖЯ-нд хүргүүлсэн боловч хараахан батлагдаагүй байна.

Нийслэлийн Аялал жуулчлалын газар нь энэхүү “ Найрсаг Улаанбаатар ” хөтөлбөрийн төлөвлөлт, төсвийг хариуцдаг боловч 2016 оны 12-р сард Аялал жуулчлалын газрын удирдлага солигдож, шинэ газрын дарга томилогдсоноос шалтгаалан, шинэ хотын даргын боловсруулсан мөрийн хөтөлбөрийн дагуу "Улаанбаатар хотын аялал жуулчлалын дэд хөтөлбөр" -ийг хэрэгжүүлэх зорилгоор “ Найрсаг Улаанбаатар ” хөтөлбөрийн хэрэгжилтийг 2018 оны 8-р сар хүртэл хойшлуулсан. Энэ хугацаанд Улаанбаатар хотын захирагч дахин солигдсон тулд, дэд хөтөлбөрийг батлах хугацаа хойшлогдож, хэрэгжүүлэх боломжгүй болсон байна. Ийм шалтгаанаар " Найрсаг Улаанбаатар " хөтөлбөрийн хэрэгжилт 2017 оноос эхлэн бүрэн зогсжээ.

<Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн (Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт)>

- 2020 он гэхэд Улаанбаатарыг зорих жуулчдын тоог 2 саяд хүргэх зорилт тавьсан ба үр дүнг дараах байдлаар үнэлжээ.
- 2019 онд Улаанбаатар хотод 452,957 жуулчин ирсэн байна. Энэ нь тавьсан зорилтын 22.6% тай тэнцэнэ гэж шууд харьцуулж болох юм. Хөтөлбөрийн зорилтот тоо болох 2 сая жуулчныг тооцоолох аргыг албан ёсоор батлаагүй. Монгол улсын хилээр орж ирсэн жуулчдын тоог ор хоногт шилжүүлэх энэ батлагдаагүй аргачлалаар шилжүүлэн тооцоход хамгийн багадаа 1 сая 358 мянган жуулчин Монголд ирсэн болох юм.
- Улаанбаатар хотын хэмжээнд аялал жуулчлал, зочлох үйлчилгээний салбарт ажиллагсдын тоо 2017 он гэхэд 35 мянгад хүрч 2014 оны төвшнөөс 2 дахин нэмэгдсэн байна. 2019 оны байдлаар аялал жуулчлалын салбарт 85,000 хүн ажиллаж байгаагийн 57,000 хүн нь зөвхөн

Улаанбаатар хотод ажиллаж байгаа бөгөөд энэ нь аялал жуулчлалын салбарын нийт ажилтны 67% -ийг эзэлнэ гэж БОАЖЯ-аас мэдээлжээ.

- Жуулчдын аюулгүй байдал хангагдаж, 100 мянган жуулчинд ногдох гэмт хэрэг, зөрчлийн тоог гуравны нэг хүртэл бууруулсан байна. Энэхүү статистик мэдээллийг Улаанбаатар хотын цагдаагийн газраас гаргадаг байсан боловч 2018 оноос хойш гаргаагүй байна.
- Улаанбаатар хотын эдийн засагт аялал жуулчлалын салбарын эзлэх хувь 9.8% -иас 20% болж өссөн байна. БОАЖЯ-ны мэдээлж буйгаар бол Монгол улс 2019 онд 570,262 (ХХЕГ, 2020) жуулчин хүлээн авч, 607 сая ам.доллар буюу 1,685,674 сая төгрөгийн (БОАЖЯ, 2020) цэвэр ашгийг ДНБ-д бүрдүүлжээ. Энэ цэвэр ашгийн хэдэн хувь нь Улаанбаатар хотод орсон тухай тоо баримт байхгүй тул энэ үзүүлэлтийн биелэлтийг тооцоход хүндрэлтэй юм.

2) Төв аймаг

Төв аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх дэд хөтөлбөрийг аймгийн ИТХ-ын 2017 оны 7-р сарын 20-ны өдрийн 79-р тогтоолоор баталжээ. Хөтөлбөр нь 6 зорилт, 31 үйл ажиллагаанаас бүрдэнэ. Гэвч, дэд хөтөлбөрт төсвийн тухай тодорхой заалт ороогүй тул хэрэгжүүлэх ажлуудад санхүүжилт хийгдээгүй байна.

3.4.3 Аялал жуулчлалын салбарын холбогдох байгууллагууд

(1) Улаанбаатар Аялал Жуулчлалын Холбоо

Улаанбаатар Аялал Жуулчлалын Холбоо нь дотоодын аялал жуулчлалыг дэмжих, аялал жуулчлалын үндэсний хийгээд бүсийн бодлого, журам боловсруулахад оролцох, салбарын судалгаа хийх, аялал жуулчлалын зохистой хэлбэрийг дэмжих зорилгоор байгуулагдсан, нийтэд үйлчлэх ТББ юм. Хэрэгжүүлж буй төслөөсөө хамааран аялал жуулчлалын бусад мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагууд, Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг тур оператор компаниуд, тусгай хамгаалалтай газар нутгийн хамгаалалтын захиргаанууд зэрэг төрөл бүрийн оролцогч талуудтай хамтран ажилладаг байна. Улаанбаатар Аялал Жуулчлалын Холбоо нь дараах төсөл, арга хэмжээг зохион байгуулжээ.

- Улаанбаатар Травэл Экспо (ULAANBAATAR TRAVEL EXPO)

Жил бүрийн 5-р сарын сүүлчийн амралтын өдрүүдэд (дотоодын аялагчдын ихэнх нь аяллын төлөвлөгөөгөө гаргадаг үе) зохион байгуулдаг, дотоодын аялагч, амрагчдад зориулсан үндэсний цорын ганц үзэсгэлэн юм. Нийслэлийн Аялал жуулчлалын газар, БОАЖЯ-тай хамтран зохион байгуулдаг. Монгол дахь гадаадын Элчин Сайдын яамд үнэ төлбөргүй оролцож болдог. Мөн хөдөө орон нутгаас 21 аймгийн төлөөлөгчид болон жуулчны бааз, рашаан сувилал, тусгай хамгаалалттай газар нутгийн төлөөлөгчид нэг дор цугларч, уулзах боломжтойгоос гадна, аяллын даатгал, тоног төхөөрөмжийн худалдаа ч гардаг тул аяллын нэг цэгийн худалдан авалт хийх боломжийг олгодог экспо юм.

- “Хонг Конг” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, ОХУ -ын Байгаль нуурын “Байкалтур “олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн

Улаанбаатар хоттой шууд нислэгтэй эдгээр хотуудад жил бүр болдог хамгийн том үзэсгэлэнгүүд дээр Нийслэлийн Аялал жуулчлалын газрын захиалгаар үндэсний АЖ-ын компаниудын төлөөллийг бүрдүүлэн оролцож, Улаанбаатар хотыг сурталчилдаг.

- Байгаль / Соёлын өв / Аялал жуулчлалын менежментийн төлөвлөгөөнүүд

Улаанбаатар Аялал Жуулчлалын Холбоо нь зөвхөн үндэсний бодлого, хэтийн төлөвлөгөөнд төдийгүй дэлхийн болоод бүс нутгийн түвшинд нийцсэн, нийтлэг алсын хараатай аялал жуулчлалын төлөвлөгөөг бий болгоход туслах зорилгоор бүс нутаг болон аймгуудтай хамтран ажилладаг.

Түүнчлэн тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны ажилчид, байгаль хамгаалагчид, орон нутгийн судлах музей, гэр бааз эрхлэгчид зэрэг бие даасан байгууллагууд болон нөхөрлөлүүдэд аялал жуулчлалын суурь мэдлэг, ойлголт өгч, бүтээгдэхүүн, үйлчилгээ

хийхэд нь сургах сургалтуудыг зохион байгуулдаг.

3.4.4 Аялал жуулчлалын салбарын татварын орлого

(1) Улаанбаатар хот

Татварын ерөнхий хуулиар НИТХ-аар тогтоож болох татварт хувь хүний орлогын албан татвар, үл хөдлөх хөрөнгийн албан татвар, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж, нийслэл хотын албан татвар, нохойны албан татвар, байгалийн ургамал ашигласны төлбөр, халуун рашаан ашигласны төлбөрийн татвар зэрэг 9н татварыг заасан байна. 2015 оны 10-р сарын 1-ний өдрөөс эхлэн "Нийслэл хотын албан татварын тухай хууль"-иар жижиглэнгийн худалдаагаар борлуулсан бүх төрлийн согтууруулах ундаа, тамхинд болон зочид буудал, амралтын газар, ресторан, баарны үйлчилгээнд 1 хувийн нийслэл хотын албан татвар ногдуулахаар болсон байна.

Уг албан татвараар 2016 онд 3.178 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөж 3.465 тэрбум төгрөг, 2017 онд 5.139 тэрбум төвлөрүүлэхээр төлөвлөж 4.876 тэрбум, 2018 онд 8 тэрбумыг төвлөрүүлэхээр төлөвлөж, 6.429 тэрбумыг, 2019 онд 7.298 тэрбумыг нийслэлийн төсөвт тус тус төвлөрүүлсэн ба 2021 оны нийслэлийн төсвийн орлогод нийслэлийн хотын албан татвараас 9 тэрбум төгрөгийг олохоор тусгасан байна. Гэвч өнөөдрийг хүртэл уг албан татвараас 1 ч төгрөг аялал жуулчлалын салбарт зарцуулагдаагүй байна.

3.4.5 Дэд бүтэц

(1) Зам / Тээвэр

1) Улаанбаатар хот

Улаанбаатар хотын төвийн ихэнх зам хатуу хучилттай. Сүүлийн жилүүдэд хүн амын хэт төвлөрөл, автомашины тооны өсөлтөөс үүдсэн Улаанбаатар хотын замын түгжрэл нь томоохон асуудал болж байгаа бөгөөд Буянт Ухаа нисэх онгоцны буудлаас хотын төв хүртэлх 15 км зам нь оргил ачаалалтай үед 2 цаг зарцуулах тохиолдол ч байдаг. Замын түгжрэлийг арилгахын тулд төр засгаас янз бүрийн арга хэмжээ авч байгаа боловч байдал төдийлөн сайжрахгүй байна.

Улаанбаатар хотод өдөрт 930 автобус нийтийн тээврийн үйлчилгээ явуулдаг ба үүнээс 290 нь төрийн өмчийн компанийн, 640 нь хувийн өмчийн компанийн автобус байна. Мөн жуулчдад зориулж Горхи-Тэрэлж, Скайресорт гэсэн чиглэлд автобус явдаг бөгөөд хотын захиргаанаас зуны улиралд "UB City tour"-ын 2 автобусыг амралтын болон арга хэмжээний өдрүүдэд тогтмол явуулдаг ажээ.

Улаанбаатар хотын автобусны зогсоол, мэдээллийн тэмдгийг суурилуулах, ажиллуулах, засвар үйлчилгээ хийх ажлыг JCDesaux Монгол дахь салбар хариуцан ажилладаг. Автобусны зогсоолын ханан дээрх самбарын ард автобусны маршрутын зураг, сурталчилгаа байдаг. Одоогоор бүх мэдээлэл Монгол хэл дээр байгаа бөгөөд гадаадын иргэдэд англи хэлээр бичих газар байхгүй байна. Umoney смарт картын үйлчилгээ 2015 онд нэвтэрснээс хойш нийтийн тээврийн бүх автобус зогсоолыг дуут хэлбэрээр зарлаж байгаа бөгөөд үүнийг тоон хэлбэрээр мэдэгдэж болно. Түүнчлэн Ub Smart Bus ухаалаг гар утасны программаар тухайн автобусны одоогийн байрлалыг шалгах боломжтой болсон зэрэг ахиц дэвшил гарч байгаа болно. Автобусны зогсоолын зар зөвхөн монгол хэл дээр байна. Улаанбаатарын автобусны хуваарь, автобусны цагийн хуваарийг монгол хэл дээр авахад хялбар боловч англи хэл дээр хайхад бараг гарч ирэхгүй, хүндрэлтэй байдаг. Үйл ажиллагааны газрын зургийн англи хувилбарыг Аялал жуулчлалын мэдээллийн төвөөс авах боломжтой.

Хот орчмын жуулчдын зорих газраас зөвхөн Горхи-Тэрэлж рүү 2012 оноос “ДЮЦ“ ХХК-ийн нийтийн тээврийн автобус явдаг байсан ба 2018 онд нийтийн тээврийн чиглэлд өөрчлөлт оруулж уг үйлчилгээг зогсоосон. 2018 оноос “ХО:3 Городок - Дунжингарав худалдааны төв”, “ХО:4 Тэрэлж-Офицеруудын ордон” чиглэлийн үйлчилгээг явуулж эхэлсэн байна.

Түүнчлэн энэ удаагийн судалгаанд хамрагдсан аймгууд руу Улаанбаатар хотоос тогтмол автобус явдаг. Автобусны үнэ, очих газар хүртэлх хугацаа, давтамж гэх мэт мэдээллийг веб сайтаас авах

боломжтой. Автобусны зарцуулагдах хугацаа, давтамжийг харгалзан үзэхэд, жуулчдын эдгээр аймаг руу аялах тээврийн хэрэгсэл болгон ашиглахад хүндрэлтэй гэж үзэж байна.⁵¹

2015 онд Улаанбаатар хотод такси үйлчилгээ үзүүлдэг албан ёсны бүртгэлтэй 17 аж ахуйн нэгжийн 564 такси байсан ба энэ нь 2019 онд 12 аж ахуйн нэгж болж буурсан байна. Такси үйлчилгээнд “Такси үйлчилгээ. Ерөнхий шаардлага” MNS 5122:2013 улсын стандартуудыг мөрддөг. Такси үйлчилгээнд явж байгаа хүмүүсийн ихэнх нь хувь иргэд байдаг учир жуулчин үйлчлүүлэхэд бохир, хэл нэвтрэлцэхгүй, илүү мөнгө нэхэх асуудлууд гардаг. Өмнө нь такси дуудахдаа, таксины компани руу утасдаж дуудах эсвэл зам дээр гараа өргөн зогсож такси барих арга хэрэглэдэг байсан бол сүүлийн үед "UBCab" хэмээх гар утасны аппликейшнээр дамжуулан такси дуудах үйлчилгээ хүчтэй дэлгэрч эхэлсэн. Гадаадын жуулчдын тухайд бол тур операторуудаар такси дуудуулсан нь аюулгүй юм.

Улаанбаатар хотод машин түрээсийн үйлчилгээ үзүүлдэг 16 аж ахуйн нэгж байгаа ба эдгээр байгууллагууд 45 хүний суудалтай автобуснаас эхлээд том жижиг янз бүрийн машиныг жолоочтой болон жолоочгүй түрээсийн үйлчилгээнд явуулдаг. Ихэвчлэн иргэд өөрсдийн хувийн унаагаа компанийн нэр дээр бүртгүүлэн ажил, үйлчилгээнд явдаг.

2) Төв аймаг

Улаанбаатар хотоос аймгийн төв болох Зуунмод хүртэл, мөн Төв аймгийн аялал жуулчлалын алдартай газар болох Горхи-Тэрэлж БЦГ, Хустайн БЦГ, Дархан, Хэнтий чиглэлийн гол замууд хатуу хучилттай засмал замтай. Харин төв замаас Хустайн нуруу хүрэх зам шиг, төв замаас салсан замууд шороон зам байх нь элбэг.

(2) Цэвэр ус

1) Улаанбаатар хот

Улаанбаатар хотын орон сууцууд УСУГ-ын цэвэр, бохир усны шугам сүлжээнд холбогдсон байдаг тул ямар нэгэн асуудал байдаггүй. Цэвэр усны шугам сүлжээнд холбогдоогүй гэр хороололд худгийн усыг ашиглах юм уу усны машинаар ус зөөж ашигладаг. Улаанбаатар хотын ойролцоо байрлах жуулчны баазуудын ихэнх нь өөрийн эзэмшил газар дээрээ өрөмдмөл худаг гарган, усыг ил шугам хоолойгоор дамжуулан хоолны газар, ариун цэврийн байгууламжид хүргэн ашиглаж байна. Гадаадын жуулчид ихэвчлэн цэвэршүүлж савласан ус хэрэглэдэг. Ерөнхийдөө Улаанбаатар хот орчмын бүс нутагт ундны болон хэрэглээний усыг тойрсон тулгамдсан асуудал бага гардаг.

(3) Бохир ус

1) Улаанбаатар хот

Улаанбаатар хотын УСУГ-ын харьяанд төв цэвэрлэх байгууламж болон Нисэх, Био, Баянгол (Найрамдал зуслан), Налайхын цэвэрлэх байгууламжууд үйл ажиллагаа явуулдаг. Төв цэвэрлэх байгууламж ахуйн болон үйлдвэрийн бохир усыг механик, биологи, химийн цэвэрлэгээний аргаар хоногт 230000 м3 бохир ус цэвэрлэх хүчин чадалтай. Одоогийн байдлаар хоногт 160000-170000 м3 бохир ус цэвэрлэж байна. Улаанбаатар хотын ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжуудад төслийн хүрээнд хийсэн судалгаагаар тэдгээрт техник технологийн шинэчлэлт, өргөтгөл хийх шаардлагатай болохыг тодорхойлсон аж.Ус сувгийн удирдах газраас 2030 онд Улаанбаатар хотод буй болох ахуйн болон үйлдвэрийн бохир усны барагцаалсан хэмжээг дараах байдлаар тооцсон байна. 2030 он гэхэд Улаанбаатар хотын 5 цэвэрлэх байгууламжид хоногт 268,655-411,600 м.куб усыг цэвэршүүлж, байгальд нийлүүлэхээр тооцоолжээ.

БОАЖЯ-нд септик ёонкс ашиглаж байгаа жуулчны баазын тухай мэдээлэл байхгүй бөгөөд Нийслэлийн Аялал жуулчлалын газрын мэдээллийн санд бүртгэлтэй 179 жуулчны бааз, амралтын газрын 55 нь бохиороо соруулдаг бол үлдсэн 124 жуулчны бааз нь бохирыг ямар шийдлээр

⁵¹ <https://www.u-money.mn/bus-schedule>

шийдсэн тухай мэдээлэл байхгүй байна.

Жуулчны баазуудаас гарах бохир усыг зохион байгуулалттай, зохих ёсоор зайлуулж чадахгүй байгаа нь дараах шалтгаануудтай холбоотой.

- Жуулчны баазууд анх бохирын цооног хийлгэхдээ доор нь эсвэл хажуу талд нь цоорхой үүсгэж, бохирын зарим нь хөрсөнд шингээж, амархан дүүрэхгүй байх зэрэг зохисгүй үйлдэл гаргадаг. Цооногийг мэргэжлийн байгууллагаар угсруулж байгаа ч тухайн үйл явцад мэргэжлийн байгууллага хөндлөнгийн хяналт тавьдаггүй ба ажил дүссаны дараа улсын Мэргэжлийн хяналтын байгууллагаар шалгуулж, дүгнэлт гаргуулдаг. Ингэснээр жуулчны баазаас гарах бохирын тодорхой хэсэг нь байгальд хөрсөнд шингэж, жуулчны баазад зөөх зардал нь бага тусаж байна.
- Жуулчны баазаас бохир соруулж, төв цэвэрлэх байгууламж руу асгах нь үнэ өртгийн хувьд өндөр бөгөөд хотоос алслагдах тусам зардал нь өсдөг. Заримдаа сард нэг доор 2-3 удаа соруулах шаардлага гардаг. Бохир соруулдаг хувь хүмүүс жуулчны баазаас соруулж авсан бохируу цэвэрлэх байгууламж руу хүргэхгүйгээр задгай байгальд санаатай асгах тохиолдол мэр сэр гардаг.

Бохир зөөх машинууд техникийн бүрэн бүтэн байдлаа хангаагүй улмаас зөөх замд асгарах зэрэг зохисгүй үйлдлүүд гардаг. Бохирын усыг зохион байгуулалтгүй асгаж зайлуулахгүй байгаа шалтгаан нь ихэвчлэн жуулчны баазын үйл ажиллагаа эрхлэгч нарын хариуцлагагүй байдал, бохир соруулж зайлуулдаг байгууллагын хариуцлагагүй үйлдлүүд мөн түүнчлэн төрийн байгууллагуудын хяналт сул зэрэг шалтгаантай холбоотой байна.

(4) Нийтийн бие засах газар

1) Улаанбаатар хот

<Улаанбаатар хот ажиллуулдаг нийтийн бие засах газар>

2016 оны байдлаар нийтийн 11 бие засах газар ажиллаж байсан. 2020 он гэхэд 10-р нэмэгдэж, 2020 оны 8-р сарын байдлаар тогтмол ажиллаж буй нь 16 байна.

Короновирусын халдвар тархалт ихэссэнтэй холбоотойгоор үйлчлүүлдэг хүний тоо цөөрсөн бөгөөд 2020 оны 8-р сарын байдлаар өдөрт ойролцоогоор 100 хүн үйлчлүүлж байна. Өмнө нь 200 орчим хүн үйлчлүүлдэг байжээ. Ихэнх нийтийн бие засах газрууд дунджаар эрэгтэй, эмэгтэй тус бүр 3, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан 1, нийт 7 суултууртай байдаг. Ажилчид нь сарын цалин 500,000 төгрөг авдаг ба орлогоо өдөр өдөрт нь тушаадаг байна. Нийтийн бие засах газрыг барих төсөв нь 150,000,000-350,000,000 төгрөг байдаг. Эдгээр бие засах газрууд цагт 27, өдөр 500 хүнд үйлчлэх боломжтой. Төлбөр нь 200 төгрөгийн үнэтэй бөгөөд 08:00-00:00 цаг хүртэл ажилтнууд ээлжлэн ажилладаг байна.

<БОАЖЯ-наас байгуулсан бие засах газар>

БОАЖЯ-наас 2016 оноос жуулчид ихээр зорчдог газруудад боловсон ариун цэврийн байгууламжуудыг шинээр барьж, ашиглалтад оруулах ажлыг тасралтгүй хийж байна. Улаанбаатар хот орчимд жуулчдын хэрэгцээнд зориулсан боловсон бие засах газруудыг Зайсангийн ам, Горхи-Тэрэлжид барьж байгуулсан байна.

<Улаанбаатар хот болон хотын ойролцоох хувийн хэвшлийн бие засах газар>

- Шатахуун түгээх станцуудын бие засах газар

Дотоодын болон гадаадын жуулчид үйлчлүүлж болох бие засах газруудын нэг төрөл бол ШТС-н бие засах газар юм. Гадаа байх тохиолдол ч байдаг. Зарим ШТС-н бие засах газар цэвэрхэн, үнэргүй байдаг ч зарим нь хэрэглэхийн аргагүй байх гэх мэт янз бүр байдаг. Хотоос гарах чиглэлд Тэс Петролиум ХХК-ийн ШТС 12, Шунхлай ХХК -ийн ШТС 3, Магнай Трейд ХХК -ийн ШТС 18, Сод Монгол ХХК -ийн ШТС 12, Петровис ХХК -ийн ШТС 12 байгаа нь дотоодын жуулчдын үйлчлүүлэх үндсэн газар нь болсон байна.

- Томоохон худалдааны төвүүдийн бие засах газар

Хотоос баруун зүгт Оргил, Сансар, Номин, зүүн зүгт Оргил, Сансар, хойш зуслангийн бүсэд Оргил, урагшаа явах чиглэлд Оргил, Сансар, Төв аймгийн Номин зэрэг супермаркетуудын боловсон бие засах газруудаар үйлчлүүлэх боломжтой ба дотор орчин нь цэвэрхэн, олон улсын стандартад бүрэн нийцсэн.

Хөтөч нар иймэрхүү мэдээллийг ашиглан түр амрах газрыг албаар томоохон худалдааны төвд тааруулж, жуулчдыг цэвэрхэн бие засах газруудаар орох боломжоор хангадаг.

- Зам дагуух жуулчны үйлчилгээний цэгүүд

Бусад улс орнуудад байдаг шиг цайны газар, замын дэлгүүртэй, боловсон бие засах газартай үйлчилгээний газар Монголд ховор байдаг бөгөөд Улаанбаатар хотоос Дархан чиглэлд 100 км зайтай Урьхан-1, Баруун чиглэлд Төв аймгийн Лүн сумын гүүрний хажууд, хотоос 120 км, Баруун чиглэлд хотоос 280 км зайтай Хаан бууз зэрэг үйлчилгээний цэгүүд тогтмол 4 улиралд 24 цагаар ажилладаг ба цаашид ийм үйлчилгээний газрууд нэмэгдэх хандлагатай байна.

(5) Хог хаягдлын менежмент

1) Улаанбаатар хот болон Улаанбаатар хот орчмын аялал жуулчлалын газрууд

Амралтын газар, жуулчны бааз, гэр буудалд тавих ерөнхий шаардлага MNS 6043 : 2009 стандартын 4.5 бүлэгт "Хог хаягдлын цэгийг зочны байр болон гэр, барилга байгууламжаас 60м-ээс багагүй зайд, зонхилон салхины доод зүгт байрлуулж, байгалийн салхинд хийсэхгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байна" гэсэн заалттай бөгөөд стандартын энэ заалтын хүрээнд харьяаны засаг захиргааны төрийн үйлчилгээний компани (дүүрэг эсвэл аймаг)-тай хог тээвэрлэх тухай гэрээ хийдэг. Уг гэрээнд сард хэдэн удаа ирж хог ачих тухай нарийвчлан зааж өгдөг ба хот орчимд байгаа ихэнх жуулчны бааз нь дээрх стандартын дагуу энгийн хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэг рүү зөөдөг. Зарим баазуудын хогны цэг нь ил задгай байдаг ба битүү торон хашаагаар хүрээлсэн байдаг. Гэвч торон хашааны завсраар жижиг хэмжээний хог салхи шуурганд хийсэж, байгальд тархах, төвлөрсөн хогийг мал амьтан ухаж, салхинд хийсэх нөхцөлийг бий болгох зэрэг асуудал их гардаг.

Хууль бусаар дураараа хог хаяж байгаа нь дараах шалтгаануудтай холбоотой.

- Дотоодын иргэдийн аялал, зугаалгаар очихдоо замбараагүй хог хаядаг явдал. Дулааны улиралд хотын иргэд гол горхи, ой модтой газарт өдрийн аялал, амралтын өдрүүдийн аялал зохион байгуулдаг бөгөөд хотын иргэд буудалласан газрын хогоо бүрэн авч явдаггүйн улмаас байгальд энгийн хог маш ихээр бий болсон байдаг. Мөн машины цонхоор хогоо хаядаг хүн их байдаг. Дотоодын жуулчдын хамгийн их төвлөрдөг Горхи-Тэрэлж болон Туул голын эрэг орчмоор сайн дурын хүмүүс, дүүргийн ТҮК, тухайн газарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, оюутан залуучуудын нийгэм хүмүүнлэгийн хөдөлгөөн, ТББ-ууд тогтмол цэвэрлэгээ хийдэг ч дараа жил нь эргээд хогонд дарагддаг. Жишээлбэл 2017 онд БОАЖЯ-наас иргэд, аж ахуйн нэгж, сайн дурын хүмүүсийг хамруулан Горхи-Тэрэлжийн голын эрэг дагуух хогийг цэвэрлэж, нийт 40 машин хогийг төвлөрсөн хогийн цэг рүү ачуулахад цаана нь цэвэрлэгдээгүй газар үлдсэн.
- Жуулчны баазуудын хогны цэгээс хөнгөн, салхинд хийсдэг хогууд салхи шуурганаар өргөн газруудад тархаж байна. Үүний гол шалтгаан нь зарим баазууд битүү торон хогийн цэгтэй биш, хогны цэг нь онгорхой байдаг, мөн түүнчлэн гадна хогны цэгийг мал, амьтан ухаж тараах зэргээс болдог байна. Хогийг дээр дурдсан гэрээнд заасан хуваарьт хугацаанд ачуулдаггүй жуулчны баазууд ч байдаг. Мөн тухайн орчны хогийг сайн дураараа цэвэрлэдэггүй учраас энгийн хог хаягдал байнга үүсдэг байна.

2) Төв аймаг

Аймгийн төв болох Зуунмод гэх мэт ихэнх сумдад хогийг сумын захын хогийн цэгт хаядаг. Жуулчны баазуудын тухай Улаанбаатар хотын тайлбарыг үзнэ үү.

(6) Эрчим хүч, харилцаа холбоо

1) Улаанбаатар хот орчмын бүс нутаг

Улаанбаатар хот болон Горхи-Тэрэлж БЦГ-ын жуулчны баазууд нь төвийн эрчим хүчний системд холбогдсон, гар утасны сүлжээ сайтай байдаг тул цахилгаан, эрчим хүчний бэрхшээл байхгүйн дээр холбоо харилцааны хэрэгсэл ашиглах бүрэн боломжтой.

3.4.6 Жуулчдын чиг хандлага

Монголд ирж буй гадаадын жуулчдын ихэнх (95% - 98%) нь Улаанбаатар хотод саатах эсвэл Улаанбаатар хотоор дайран өнгөрдөг гэдэг тул Нийслэл хотод ирдэг жуулчны тоо нь Монгол улсын хилээр нэвтэрсэн гадаадын иргэдийн тоотой бараг тэнцүү байдаг нь үүнтэй холбоотой. Монгол улсад аль улсын иргэд хамгийн ихээр ирдгийг жагсааж харвал 2019 оны байдлаар эхний 5 д дараах орнууд оржээ. Үүнд, БНХАУ (170,000 орчим иргэн), ОХУ (140,000 орчим иргэн), БНСУ (100,000 орчим иргэн), Япон (24,000 орчим иргэн), АНУ (19,000 орчим иргэн) байгаа бөгөөд Европын орнуудаас 30,000 орчим иргэн ирсэн байна. Хил хамгаалах ерөнхий газрын мэдээлэлд үндэслэн дүгнэж үзэхэд зөвхөн аялж жуулчлах зорилгоор Монгол улсад ирдэг иргэдийн ихэнх нь Европ, АНУ-ын иргэн байдаг бололтой.

Улаанбаатар хотын хэмжээнд 2020 оны байдлаар 216 жуулчны бааз ажиллаж байгаагаас 51 нь жилийн 4 улирлын турш ажиллаж, үлдсэн жуулчны баазууд нь 5-р сарын 1-нээс 10-р сарын 1-н хүртэл улирлын чанартай ажилладаг. Гадаадын жуулчдын тал орчим хувь нь 6-9 сард төвлөрч ирдэг. МIСЕ буюу ажил хэргийн аялал жуулчлалын үеэр Шангри-Ла гэх мэт Улаанбаатар хотын томоохон зочид буудлуудыг ашигладаг боловч 2016 оны АСЕМ (Ази-Европын дээд түвшний уулзалт) уулзалтаас хойш МIСЕ-ийн томоохон төслүүдийг хэрэгжүүлж чадаагүй байна.

Улаанбаатар хотын музейд зочлогчдын тоо 2019 онд 364,400 байсан нь 2015 оны 256,100 -аас 1.42 дахин их байв. Музейд зочилсон гадаадын жуулчдын тооны талаарх мэдээ, мэдээлэл байхгүй байгаа тул гадаадын хэдэн иргэн музейг үзсэн нь тодорхойгүй байна. Музей тус бүрээр зочлогчдын тоог гаргасан статистик мэдээ байдаггүй ч хамгийн алдартай нь Монголын Үндэсний музей, Чойжин ламын сүмийн музей юм.

Улаанбаатар хот орчимд аялал жуулчлалын салбараас үүдэлтэй байгаль орчны доройтол буюу сөрөг нөлөөлөл Богд хан уул болон Горхи-Тэрэлжийн бүсэд бий болсон тухай мэдээллийг салбарын уулзалт ярилцлагад дурдсан байгаа юм. Үүний гол шалтгаан нь дотоодын жуулчдын ёс зүйгүй үйлдэл, жуулчны баазуудын хэт их төвлөрөл, жуулчны үйлчилгээний байгууллагуудын стандарт шаардлага хангаагүй зохисгүй үйл ажиллагаа зэрэг гэж үзэж байгаа юм. Бүр тодруулбал, гадаадын жуулчид байгаль орчинд сөргөөр нөлөөлөх үйлдэл, үйл ажиллагаа гаргадаггүй хэмээн төрийн байгууллага болон аялал жуулчлалын салбарт ажилладаг холбогдох хүмүүс дүгнэсэн байна.

- Улсын хэмжээнд 576 амралтын газар, жуулчны бааз (МЖБХ, 2019) байдгаас 151 нь хот орчимд байрлалтай. Үүнээс 51 нь жилийн турш (NAP⁵², 2016), үлдсэн нь 5-р сарын 1-нээс 10-р сарын 1-н хүртэл улирлын чанартай ажилладаг. 2020 оны 8-р сард НАЖГ-аас хот орчимд явуулсан тооллогоор 216 газар байгаа гэж тоолсон боловч дэлгэрэнгүй бүртгэл хийгдээгүй байна. Үүнээс хэд нь амралтын газар, жуулчны бааз, гэр бааз болох талаар ялгаж судалсан судалгаа байдаггүй.
- Монголд гэр бааз хоорондох зайг тогтоож заасан хуулийн заалт байдаггүй, гэхдээ амралтын газар, жуулчны бааз, гэр буудалд тавих ерөнхий шаардлага MNS 6034 : 2019" стандартад (1) Байгалийн нөөц, түүх, соёлын дурсгалт газраас 3 км-ээс доошгүй зайд байрлана, (2) Амралтын газар, жуулчны бааз, гэр буудал нь байгальд сөрөг нөлөөгүй үйл ажиллагаа явуулна, (3) Амралтын газар, жуулчны бааз, гэр буудлуудын хоорондын зай 5 км-ээс доошгүй байх тухай заасан байдаг.

⁵² N.A.P Group, National Architectural Project (Судалгааны компани)

- Горхи-Тэрэлжид 2016 оны байдлаар нийт 104 газар үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 70% нь стандартын энэ заалтыг хангаагүй байдаг.

Аялал жуулчлалын хөгжил Улаанбаатар хотын нийгэм, соёлын салбарт үзүүлж буй нөлөөллийн судалгааг 2015 онд нэг удаа явуулжээ. Судалгаанд оролцсон иргэдийн 51.0% нь нийгэм, соёлын байдалд аялал жуулчлал нь сайнаар нөлөөлж байна гэсэн бол 21.0% нь муугаар нөлөөлж байна гэж үнэлсэн байна. Эерэг нөлөөлөлд, гадаадын жуулчдаар дамжуулаад үйлчилгээний чанар дээшилсэн, түүх, соёлын дурсгалт газар, урлагийн бүтээлийн хамгаалалт сайжирсан, уламжлал, соёлоо үнэлж, бахархдаг болсон гэж үнэлсэн байна. Гэвч, гадаадын зарим жуулчид сүүлийн жилүүдэд Улаанбаатар хот, Горхи-Тэрэлж орчимд Sex tourism-ийн үйлчилгээг илүү сонирхох болсноор Монголчуудын дунд гадаад хүнийг дургүйцэх хандлага бий болж байна.

3.4.7 Аялал жуулчлалын салбарын чиг хандлага

- 1) Улаанбаатар хотоос хэрэгжүүлж буй арга хэмжээ, тулгарч буй асуудал

Улаанбаатар хот болон аялал жуулчлалтай холбоотой ТББ-уудад (дотоодын аялагчдад зориулсан АЖ-ын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуй нэгжүүд орно) маркетинг, сурталчилгааны төлөвлөгөө байдаггүй. " Найрсаг Улаанбаатар" аяныг өмнө нь хэрэгжүүлж байсан боловч хотын Захирагч солигдсоноос хойш маркетинг, сурталчилгааны стратегийг төлөвлөөгүй, хэрэгжүүлээгүй байна. Үүний гол шалтгаан нь зар, сурталчилгааны төсөв бага, боловсон хүчин хомсдолтой, хариуцсан ажилтан байнга солигдож байгаа явдал юм. Хотоос хэрэгжүүлж буй аялал жуулчлалын үйл ажиллагаа нь, Дэлхийн аялал жуулчлалын экспод оролцохыг эс тооцвол бүгд дотоодын зах зээлд чиглэсэн үйл ажиллагаа байгаа юм.

- 2) Улаанбаатар хот болон бусад аялал жуулчлалын байгууллага хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагаа

Дотоодын аялал жуулчлалыг дэмжих, хөгжүүлэх, аялагчдын боловсролыг дээшлүүлэх зорилгоор байгуулагдсан “Улаанбаатар Аялал Жуулчлалын Холбоо” ТББ нь төрийн байгууллага болох Нийслэлийн Аялал жуулчлалын газартай бүх л талаар хамтран ажиллаж ирсэн. Тус ТББ нь Улаанбаатар хотын соёл, байгалийн өвийн менежментийн төлөвлөгөө, Улаанбаатар хотын аялал жуулчлалын менежментийн төлөвлөгөөг боловсруулах саналыг Нийслэлийн Аялал жуулчлалын газарт тавиад байгаа болно. Эдгээр менежментийн төлөвлөгөө нь Улаанбаатар хотын аялал жуулчлалтай холбоотой хөгжлийн төлөвлөгөөг цаашид урагшлуулах урт хугацааны суурь зорилтыг хангах зорилготой юм. Улаанбаатар Аялал Жуулчлалын Холбоо ТББ нь жил бүрийн хавар дотоодын аялал жуулчлалыг сурталчлах “Улаанбаатар Травэл Экспо”-г НАЖГ болон БОАЖЯ-тай хамтран зохион байгуулдаг.

- 3) Аялал жуулчлалын салбарын гадаад, дотоод зах зээл рүү чиглэсэн сурталчилгаа, аян

Одоогийн байдлаар тодорхой зорилтот бүлэг рүү чиглэсэн идэвхтэй аян хэрэгжээгүй байна. Ковид-19-ын дараах аялал жуулчлалын үйл ажиллагааг сэргээх, сурталчлах ажлыг улс, хотын хэмжээнд өнөөг хүртэл хийгээгүй байгаа тул аль замаар явах нь тодорхой бус байна. Аялал жуулчлалын үйл ажиллагааг сэргээхийн тулд аль улс, хот руу чиглэсэн мэдээлэл сурталчилгаа түгээж, уриалах вэ гэсэн стратеги боловсруулж эхлэх нь аялал жуулчлалын урсгал зогсонги байдалд орсон энэ үе нь тохиромжтой цаг үе гэж харж байгаа юм.

- 4) Орон нутгийн засаг захиргааны аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтэд төрөөс үзүүлэх дэмжлэг

Нийслэлийн аялал жуулчлалын газар нь Улаанбаатар хотын аялал жуулчлалтай холбоотой бүхий л үйл ажиллагааг хариуцан ажилладаг. Тус газар жил бүрийн эцэст дараагийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө болон санхүүгийн төсвийг Засаг даргын Тамгын газарт хүргүүлдэг. Батлагдаж чадвал төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээнүүд нь хөтөлбөрийн дагуу хэрэгжээд явах нөхцөл бүрддэг. Ихэнх тохиолдолд НАЖГ-ын төсөв нь хүрэлцдэггүй тул, хувийн хэвшил болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажилладаг. БОАЖЯ-ны үйл ажиллагаа нь маш өргөн хүрээтэй (зөвхөн аялал жуулчлалын салбарын бус) 21 аймгийг хамран төлөвлөгддөг. Зарим тохиолдолд НАЖГ, БОАЖЯ хоорондын хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах шаардлагатай тал ажиглагддаг.

- 5) Төлөвлөгөөний хэрэгжилтэд тулгарч буй бэрхшээл, шалтгаан (цаашид авах арга хэмжээг оруулна)

Нийслэл хотын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд тулгарч буй хамгийн гол бэрхшээл бол урт хугацааны хөгжлийн хөтөлбөргүй байгаа байдал юм. Сонгууль бүрийн дараа хотын захиргааны байгууллагууд аялал жуулчлалыг хөгжүүлэх шинэ үзэл баримтлалыг дэвшүүлж ажиллах шаардлага гардаг. Үүний үр нөлөөнд өмнө нь хэрэгжиж байсан хөтөлбөрүүд залгамж чанар байхгүй шууд зогсоход хүрдэг. Цаашдаа 2-3 сонгуулийн хугацаанд дамжуулж хэрэгжүүлдэг урт хугацааны хөгжлийн хөтөлбөртэй байх нь чухал юм.

- 6) Зорилтот зах зээл рүү маркетингийн үйл ажиллагаа явуулахаас өмнө, зар сурталчилгааны мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийн стратеги боловсруулдаг байгууллага байдаг эсэх

Зорилтот зах зээлийн судалгааг явуулж, Улаанбаатар хотын удирдлагуудад зөвлөмж өгдөг мэргэжлийн байгууллага байдаггүй. Нийслэл хотод одоогоор албан ёсны маркетингийн төлөвлөгөө байхгүй байна.

- 7) Хувийн хэвшлүүдийн үйл ажиллагаа

Аялал жуулчлалын хувийн компаниуд мэдээллийг англи, япон хэл дээр идэвхтэй түгээж байна. Интернэт сайтуудад мэдээлэл нээлттэй байх боловч аль аялал жуулчлалын компани нь найдвартай, сайн үйлчилгээтэй болохыг тодорхойлоход хэцүү байдаг. Тиймээс ямар нэгэн байдлаар, жишээлбэл Нийслэлийн Аялал жуулчлалын газраас "ногоон наалт" гаргаж, баталгаажуулах гэх мэт арга хэмжээ авах нь, аялал жуулчлалын салбар хөгжиж буй Монгол улсад зайлшгүй шаардлагатай мэт санагдаж байна.

Хүснэгт 3-63: Дэлхийн улс орнуудад Улаанбаатар хотын аялал жуулчлалын мэдээлэл түгээдэг хувийн веб сайтуудын жишээ

Мэдээллийн сайт нэр	Веб сайт	Агуулга
Trip Advisor	https://www.tripadvisor.com/Tourism-g293956-Ulaanbaatar-Vacations.html	Улаанбаатар хотын тухай, мэдээ мэдээллүүд олон илэрцээр гарч ирдэг. Монголын бүх компаниудын аялал бүртгэгдсэн.
Lonely Planet	https://www.lonelyplanet.com/mongolia/ulaanbaatar	Мөн ялгаагүй Улаанбаатар хотын мэдээллүүд олон илэрцээр гарч ирдэг. Tripadviser-аас ялгаатай нь Улаанбаатар хотын нэгдсэн танилцуулгаас гадна аяллын төрөл, үзмэр, байршил зэргээр ангилж шүүх боломжтой.
Улаанбаатар Аялал Жуулчлалын Холбооны цахим хуудас	http://ubtourism.org/en	Улаанбаатар Аялал Жуулчлалын Холбооноос хөгжүүлж байгаа цахим платформ.
Tripoto	https://www.tripoto.com/ulaanbaatar	Олон улсын аялал жуулчлалын сайтуудын нэг бөгөөд Улаанбаатар хотын тухай олон мэдээллийн илэрцтэй.
Discover Mongolia	https://www.discovermongolia.mn	Дотоодын компаниудын хөгжүүлж байгаа цахим платформууд бөгөөд Улаанбаатар хотод зохион байгуулдаг аяллууд болон жуулчны үзмэрүүдийн мэдээллийг багтаасан. Дотоодын аялал жуулчлалын компаниудын веб сайтад тавьсан Улаанбаатар хотын мэдээллүүд ихээр илэрдэг.
View Mongolia Travel	https://www.viewmongolia.com	

Эх сурвалж: Судалгааны баг

3.4.8 SWOT шинжилгээ

Улаанбаатар хот нь Монгол улсын нийслэл бөгөөд хүн амын бараг тал хувь нь амьдардаг, Монгол улсын улс төр, эдийн засаг, соёл, нийгмийн хөгжлийн төв болсон хот юм. Музей, уран зургийн галерей, урлагийн тоглолт, Буддын шашны сүм хийдүүд, дэлхийд алдаршсан Буддын урлагийн олон гайхамшигт бүтээл, хүн төрөлхтний соёлын биет бус өв болох морин хуур, хөөмий, уртын дуу гэх мэт Монголыг төлөөлөх олон зүйлтэй танилцаж, уламжлал, түүх, соёлыг судлах боломжтой. Түүнчлэн Горхи-Тэрэлж БЦГ, Хустайн БЦГ, Богд хан уул ДЦГ гэх мэт үзэсгэлэнт байгальтай газрууд хоттой ойролцоо байх агаад өдөртөө аялаад ирэх боломжтой.

Монголд аялахаар ирдэг гадаадын иргэдийн 98% нь нийслэл Улаанбаатараар дамжин өнгөрдөг гэх статистик тоо баримт байх ба тэдний ихэнх нь Улаанбаатар хотод хэд хоногоор саатдаг. Тиймээс нийслэл Улаанбаатар хот бол Монголын аялал жуулчлалын төв гэж үзэж болох юм. Нөгөөтэйгүүр, хотын сүм хийдийн үзмэр, бүтээлүүд дийлэнхдээ Буддын шашных байх агаад хоорондоо ижил төстэй нэгэн хэвийн байдаг. Буддын урлагийн түүхэнд хамгийн их шүтэн бишрэгдэж ирсэн Өндөр Гэгээн Занабазарын урласан бурхад, уран баримлууд нэг дор байдаггүй өөр өөр сүм хийд газар нутагт байдаг. Гадаадын жуулчдын хамгийн их сонирхдог байсан Байгалийн түүхийн музей хаагдаж, дэлхийд хамгийн ховор нандин олдворт тооцогддог үлэг гүрвэлийн олдворуудыг харах боломжгүй болсон. Түүнчлэн өвлийн улиралд жуулчдыг татах сонирхолтой газар, арга хэмжээ байхгүй зэрэг тулгамдсан асуудал их байна.

Хүснэгт 3-64: Улаанбаатар хотын аялал жуулчлалын давуу ба сул талууд

	Нөөц бололцоо	Хязгаарлах нөхцөл
	Давуу тал Strength	Сул тал Weakness
Дотоод орчин	<p><u>Аялал жуулчлалын нөөц</u></p> <ul style="list-style-type: none"> -Горхи-Тэрэлж БЦГ (УБ хотын ойролцоо) -Адууны өвөг болох Тахийг сэргээн нутагшуулж хамгаалах бүс нутаг(Hustai National Park) -Үндэсний музей, Богд хааны ордон музей, гэх мэт -Занабазарын нэрэмжит дүрслэх урлагийн музей, Буддын сүм хийд, түүхэн дурсгалт газрууд -Үзэсгэлэн, арт галерей -Дуурийн театр, драмын театр, үндэсний дуу бүжгийн эрдмийн чуулга зэрэг мэргэжлийн урлагийн тоглолтууд -Дэлхийн төвшний ардын урлаг (дэлхийн соёлын биет бус өв) -Кафе, ресторан, шөнийн клуб -Их дэлгүүр / бэлэг дурсгалын дэлгүүр, зах, үндэсний хэв маягтай бараа бүтээгдэхүүний худалдаа <p><u>Дэд бүтэц</u></p> <ul style="list-style-type: none"> -Олон улсын нисэх онгоцны буудал байдаг -Хатуу хучилттай, засмал замтай -Дулаан, цахилгааны төвлөрсөн системтэй -Гар утас, интернэтийн сүлжээтэй <p><u>Үйлчилгээ</u></p> <ul style="list-style-type: none"> -Олон улсын стандартад нийцсэн зочид буудлууд байдаг -Гадаадын жуулчдад үйлчилж ирсэн аялал жуулчлалын агентлагууд ихтэй -Бүх төрлийн энтертеймент үйлчилгээний төв -Ноолууран бүтээгдэхүүн, гар урлал, дурсгалын зүйл худалдаж авах боломжтой -Англи хэлээр ярьж чаддаг хүн олон 	<p><u>Аялал жуулчлалын нөөц</u></p> <ul style="list-style-type: none"> -Өвлийн улиралд театр, урлагийн тоглолт цөөтэй <p><u>Дэд бүтэц</u></p> <ul style="list-style-type: none"> -Олон улсын нислэг хязгаарлагдмал -Дотоодын нислэг цөөн -Замын түгжрэл их <p><u>Хууль / дүрэм</u></p> <ul style="list-style-type: none"> -Аялал жуулчлалтай холбоотой хуулиудын хэрэгжилт сул, хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ тодорхой бус -Аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөв бага <p><u>Үйлчилгээ</u></p> <ul style="list-style-type: none"> -Хувийн такси олон, хэл нэвтрэлцэхгүй байх тохиолдол их -Үнийн шошгогүй бүтээгдэхүүн их тул, худалдан авалт хийхэд төвөгтэй -Нийтийн тээврийн автобусны маршрутын зураг, дэлгэц зөвхөн монгол хэл дээр байдаг <p><u>Мэдээлэл / Маркетинг</u></p> <ul style="list-style-type: none"> -Төрийн байгууллага гэх мэт баталгаатай газраас гаргасан аялал жуулчлалын найдвартай мэдээлэл хомс -Монголын онгон байгаль, сэтгэл татам орчин, сайн сайхан байдлыг хангалттай түгээж, сурталчилдаггүй -Аливаа эвент, үйл ажиллагааны талаарх мэдээлэл хомс, хүртээмжгүй -Гадаад хэл дээр (ялангуяа англи хэл дээр) аялал жуулчлалын мэдээлэл хомс байдаг -Веб сайтуудыг үр дүнтэй ашиглаж чаддаггүй

	Боломж Opportunity	Аюул занал Threat
Гадаад орчин	<p><u>Мэдээлэл / Маркетинг</u></p> <p>-Горхи-Тэрэлж БЦГ нь Улаанбаатар хоттой хамгийн ойрхон, жуулчдын очих дуртай газрын нэг</p> <p>-Шөнийн цагаар ч зугаалж цэнгэх олон байгууламж байдаг</p> <p>-Үндэсний өвөрмөц соёл, уламжлалт урлагийг танилцуулах төрөл бүрийн үйл ажиллагааг хөгжүүлэх, баяжуулах нөөц боломж их</p> <p>-Монгол мэргэжилтнүүд Дэлхийд алдартай үлэг гүрвэлийн музей байгуулсан</p>	<p><u>Аялал жуулчлалын нөөц</u></p> <p>-Хууль, журам зөрчиж гэр бааз ихээр барьснаас үүдэн байгаль орчны өнгө үзэмж алдагдахад хүрч байна</p> <p><u>Дэд бүтэц</u></p> <p>-Байнга түгжрэл үүсэж байдаг</p> <p>-Гадаадын иргэн такси, автобус ашиглахад бэрхшээлтэй</p> <p><u>Хууль / Дүрэм</u></p> <p>-Жуулчдын тоо нэмэгдсэнээр хог хаягдлын асуудал үүсгэж болзошгүй</p> <p><u>Мэдээлэл / Маркетинг</u></p> <p>-Жуулчны баазууд маш олон байдаг мөртлөө, тэдгээрийн талаарх мэдээлэл дутмаг, системтэй бус</p>

Эх сурвалж: Судалгааны баг

(1) Улаанбаатар хот орчмын аялал жуулчлалын маршрутыг хөгжүүлэх давуу тал

1) Аялал жуулчлалын нөөц

- ① Буддын шашны сүм хийд, музей, үзэсгэлэн, театр, урлагийн тоглолт зэрэг үзэж сонирхох зүйлс ихтэй. Монгол орны цаг уур, хүн зон, газар нутагтай танилцаж цаашид Монголд хийх аяллынхаа суурь мэдээллийг олж авах боломжтой.
- ② Хөөмий, морин хуур, монгол наадам буюу бөхийн барилдаан, морин уралдаан, сур харваа гэх мэт түүх, соёлын биет бус өв олонтой.
- ③ Үндэсний урлагийн театр зэрэг мэргэжлийн урлагийн төвүүдээс гадна амьд хөгжимтэй баар цэнгээний газар, хооллох үедээ үндэсний дуу хөгжим сонсох боломжтой хувийн хэвшлийн соёл урлагийн газрууд ч байдаг.
- ④ Бусад бүс нутгуудтай харьцуулахад өвлийн улиралд ч гэсэн үзэж сонирхох боломжтой аялал жуулчлалын байгууламжууд (музей, үзэсгэлэн, уран зургийн галерей гэх мэт) байдаг.



Гандантэгчинлэн хийд



Г.Занабазарын нэрэмжит дүрслэх урлагийн музей



Морин хуурын чуулга



Наадам

2) Дэд бүтэц

- ① Олон улсын нисэх онгоцны буудал байдаг. БНСУ-ын Сөүл хот (3 цаг 20 минут), БНХАУ-ын Бээжин хот (2 цаг 15 минут), Хонконг (4 цаг 35 минут), Япон улсын Токио хот (4 цаг 35 минут), Тайландын Бангкок хот (6 цаг) руу шууд нислэгтэй. Европоос бол Истанбул хот (8 цаг 40 минут), Франкфурт хот (9 цаг 20 минут) руу Москвагаар дамжин нисэх боломжтой.
- ② 2021 оны 7-р сард олон улсын шинэ нисэх буудал ашиглалтад орсон. Нисэхийн зурвас нь хоёр талаас буух, хөөрөх боломжтой тул, салхины нөлөөнд амархан өртөхгүй, тогтвортой нислэг хийх боломжтой юм. Монголын Засгийн газар олон улсын нислэгийн тоог нэмэгдүүлэх асуудлыг хэлэлцэж байгаа бөгөөд нислэгийн тоог нэмэгдүүлснээр жуулчдыг хүлээж авах чадавх ихээхэн сайжрах юм.
- ③ Дулаан, цахилгааны төвлөрсөн системтэй тул цахилгаан, халаалт, халуун усны үйлчилгээ тогтмол
- ④ Улаанбаатар хот болон ойр орчмын бүс нутагт гар утас, интернэтийн сүлжээ сайтай учир холбоо харилцааны ямар нэгэн бэрхшээл байхгүй
- ⑤ Цэвэр ус, бохир усны систем бүрэн тоноглогдсон тул усны хомсдол байхгүй.

3) Хууль / Дүрэм

- ① БОАЖЯ, Нийслэлийн аялал жуулчлалын газар гэх мэт аялал жуулчлал хариуцсан төрийн байгууллагууд Улаанбаатарт төвлөрдөг тул, хууль эрх зүйтэй холбоотой ямар нэгэн асуудал үүсэхэд тодруулж, лавлах боломжтой юм.

4) Үйлчилгээ

- ① Олон улсын стандартад нийцсэн зочид буудлууд бий. Тухайлбал таван одтой 8, дөрвөн одтой 23 зочид буудал байдаг бөгөөд интернэтээр захиалах бүрэн боломжтой.
- ② Таван одтой зочид буудлаас авхуулаад оюутнуудад зориулсан хямд үнэтэй зочид буудал хүртэл олон төрлийн өргөн сонголттой бөгөөд Улаанбаатар хотын бүх зочид буудал боловсон бие засах газар, халуун устай угаалгын өрөөтэй байдаг. Хотын ойролцоох Тэрэлж гэх мэт жуулчны гэр баазууд ч дотроо боловсон бие засах газар, халуун устай шүршүүр тавих нь ихсэж байна.
- ③ Бусад бүс нутагтай харьцуулахад нийтийн автобус, такси хангалттай байдаг ч хэл

нэвтрэлцэхгүй бэрхшээл байдаг. Гэсэн хэдий ч жуулчдад зориулсан олон сонголттой, жишээлбэл зочид буудлаасаа түрээсийн машин дуудах, захиалах боломжтой.

- ④ Ноолууран бүтээгдэхүүн худалдан авах боломжтой. Арьс болон эсгий зэрэг түүхий эдээр баялаг орон тул, бэлэг дурсгалын зүйл, хувцас хэрэглэгдэхүүнийг шинээр хөгжүүлж, төрөл, сонголтыг баялаг болгох боломжтой. Мөн Чингис хааны түүх дурсгалын билэгдсэн, үлэг гүрвэлийн орон гэсэн онцлогийг харуулсан бэлэг дурсгалын зүйлсийг хийх нөөц бололцоотой.

5) Мэдээлэл / Маркетинг

- ① Монгол орон нь өргөн уудам нутаг, онгон цэвэр байгалиараа гадаадын жуулчдын сэтгэлийг татдаг улс. Монгол гэдэг нэрийг дэлхий даяараа мэддэг, нийслэл Улаанбаатар хот ч гадаадынханд муугүй танигдсан хот юм.
- ② Олонд танигдаагүй аялал жуулчлалын нөөц боломж ихтэй, цаашид аялал жуулчлал хөгжих өргөн бололцоотой. Ялангуяа өнөөг хүртэл олны анхаарлыг илүү татдаг байсан "үзэх" төрлийн аялал жуулчлал төдийгүй цаашдаа жуулчин өөрийн биеэр "туршиж үзэх", "судлах" төрлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх нөөц байдаг.
- ③ Герман, Франц, Их Британи зэрэг Европын орнуудаас ирсэн жуулчид нийт жуулчдын 2.1%, 1.8%, 1.0% -ийг тус тус эзэлж байгаа бөгөөд бүгд нийлээд дөнгөж 4.9% -ийг эзэлж байна. Гэвч Монголд аялж саатах хугацааг харгалзан үзвэл нийт аялал жуулчдын 4.2% эзэлж буй Японы жуулчид дунджаар 6 хонож байхад 2.1% эзэлж буй Германы жуулчид 18 хонодог судалгаа гарчээ. Өөрөөр хэлбэл хэдий цөөн жуулчид ирж байгаа ч Монголд саатах, аялах өдөр нь илүү олон гэдэг нь харагдаж байгаа болно. Европ, АНУ, Австралиас ирэх жуулчид Улаанбаатарыг түшиглэсэн аяллын янз бүрийн маршрутаар явах өндөр боломжтой.
- ④ Аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого сул байгаа хэдий ч 2019 онд 570,000 гадаадын жуулчдыг татаж чаджээ. Хэрэв аялал жуулчлалыг хөгжүүлэх оновчтой бодлого, арга хэмжээг хэрэгжүүлж чадах юм бол ойрын ирээдүйд энэ тоог хоёр дахин нэмэгдүүлэх боломжтой юм.

(2) Улаанбаатар хот орчмын аялал жуулчлалын маршрутын хөгжлийг хязгаарлах нөхцөл

1) Аялал жуулчлалын нөөц

- ① Буддын шашны сүм, музей, үзэсгэлэн, галерей зэргийг голчлон үзэх их байдаг ба өөр үзэх, сонирхох зүйлс цөөн, цаашид өргөжих нөөц хомс байдаг. Гадаадын жуулчдын сонирхлыг их татдаг байсан ч өдгөө хаагдсан Байгалийн түүхийн музейг дахин барих төлөвлөгөө байгаа ч санхүүгийн эх үүсвэр тодорхой бус хэвээр байгаа юм. Одоогийн үлэг гүрвэлийн музей нь цаашид тогтвортой ажиллах эсэх нь тодорхойгүй (Засгийн газраас хаах тушаал гарсан гэх мэдээ ч байна) гэгддэг.
- ② Зуны улиралд, Монгол үндэсний дуу хөгжим, бүжиг, ардын язгуур урлагийн тоглолт үзүүлдэг Түмэн эх чуулгын тоглолт нь байнгын дүүрэн үзэгчидтэй байдаг тул цаашид улам бүр нэмэгдэх гадаадын жуулчдад тэр бүр хүртээмжтэй байж чадахгүй. Тиймээс, соёлын биет бус өв болох морин хуур, хөөмий, уртын дуу зэрэг ардын урлагийн тоглолтыг үзүүлж сонирхуулах газар олон байгуулах хэрэгтэй.
- ③ Монголын орчин үеийн урлаг маш сайн хөгжсөн. Гэхдээ гадаадын иргэд тэр бүр уран зургийн галерейгаар ордоггүй. Занабазарын нэрэмжит дүрслэх урлагийн музейгээс бусад орчин үеийн урлаг, уран зургийн талаарх мэдээлэл, сурталчилгаа сул байдаг. (Занабазарын нэрэмжит дүрслэх урлагийн музейн танилцуулгад Занабазарын хамгийн нэртэй бүтээл болох бурхадын зураг нэг ч байдаггүй, Занабазарын бүтээлтэй анх танилцаж буй хүнд Занабазарын бүтээлийн гайхамшиг, мөн чанарыг бүрэн мэдрүүлж чаддаггүй).

2) Дэд бүтэц

- ① Замын ачаалал маш их, байнгын түгжрэлтэйгээс хотын төвөөр явахад цаг их алддаг.
- ② Өвлийн улиралд гэр хорооллын айлууд нүүрсээр гэр орноо халаадаг тул түүхий нүүрсний утаа Улаанбаатар хотыг бүхэлд нь бохирдуулдаг. Сүүлийн жилүүдэд сайжруулсан түлшийг хэрэглээнд нэвтрүүлснээр харьцангуй багасаж байгаа боловч Улаанбаатарын агаарын бохирдол бүрэн шийдвэрлэгдэж чаддаггүй тулгамдсан асуудал хэвээр байна .

3) Хууль /Дүрэм

- ① Засгийн газар ойр ойрхон солигдох, түүнийг дагаад Засгийн газрын болон Улаанбаатар хотын удирдах албан тушаалтнууд байн байн өөрчлөгдөх гэх мэт боловсон хүчний хөдөлгөөн их байдаг нь маркетинг, сурталчилгааны стратеги боловсруулах цаг хугацаа, боломж байдаггүй. Урьд нь хэрэгжүүлж байсан " Найрсаг Улаанбаатар" хөтөлбөр ч зогсож, веб сайт нь гадаад хэлээр мэдээлэл түгээдэг байснаа мөн больжээ. Аялал жуулчлалыг хөгжүүлэхийн тулд ашиглахаар төлөвлөж байсан "Аялал жуулчлалын сан" - ийн үйл ажиллагаа ч мөн зогсжээ.
- ② Горхи-Тэрэлж БЦГ-т хууль, журам зөрчиж барьсан олон жуулчны бааз, барилга байгууламж байдаг. Барихыг зөвшөөрсөн байгаа нь ч асуудалтай бөгөөд цаашид хууль тогтоомжийг чанд мөрдүүлэх тал дээр эрх баригчид хатуу арга хэмжээ авах шаардлагатай. Энэ хэвээрээ байвал цаашид байгалийн цогцолборт газрын үнэ цэнэ буурч, аялал жуулчлалын газрын хувьд жуулчид татах, тэднийг аятай таатай байлгах орчин нөхцөл ч алдагдах болно.

4) Үйлчилгээ

- ① Аялал жуулчлалын мэргэжилтэй, мэргэшсэн боловсон хүчин дутагдалтай. БОАЖЯ-аас жил бүр сургалт явуулдаг ч хангалттай бус.

5) Мэдээлэл / Маркетинг

- ① Монгол улсын хилээр нэвтэрсэн жуулчдын статистик тоо мэдээнээс харахад БНХАУ, ОХУ-ын иргэд талаас илүү хувийг эзэлж байгаа боловч бодит байдал дээр тэдний ихэнх нь бизнесийн зорилгоор ирдэг бөгөөд аялал жуулчлалын хэрэгцээг хангаж чаддаггүй.
- ② Япон жуулчдын Монголд саатах хугацаа нь 6 хан хоног л байдаг ба энэ нь шууд нислэгийн тоо, давтамжтай бас холбоотой.
- ③ Шашин соёлын наадам болох Даншиг наадам гэх мэт уламжлалт зан үйлийг тусгасан эвент, үйл ажиллагааны утга санаа, агуулгыг гадаадын иргэдэд хангалттай ойлгуулж чаддаггүй.
- ④ Аялал жуулчлалыг хөгжүүлэх, өргөжүүлэх бодлого болгож ажил хэргийн аялал жуулчлал болох МIСE-ийг Монголд хөгжүүлэх нь зүйтэй юм. Одоогийн байдлаар хурал, уулзалтын байр, хоноглох өрөө зэргийн шаардлага хангах буудал зөвхөн Шангри-Ла зочид буудал л байна. Улаанбаатар хотод таван одтой 8, дөрвөн одтой 23 зочид буудал байдаг ба жуулчид хүлээн авах тогтолцоо аажмаар хөгжиж байгаа ч цаашид илүү өргөжүүлэх шаардлага байсаар байна.
- ⑤ Веб сайт дахь зар сурталчилгаа, сурталчилгааны мэдээллийг гадаад хэл дээр түгээдэггүй (Нийслэлийн Аялал жуулчлалын газрын веб сайт нь "англи хэл" -ний сонголттой боловч англи хэл дээр мэдээлэл гарч ирдэггүй). Үндсэндээ гадаадын иргэдэд мэдээлэл түгээх, сурталчлах ажил зогссон байна.
- ⑥ Нийслэлийн Аялал жуулчлалын газраас зохион байгуулсан “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөр зогсож, ижил төстэй өөр хөтөлбөр ч хэрэгжихгүй байна. Зар сурталчилгааны зорилгот стратегий байдаггүй бөгөөд сурталчилгааны үйл ажиллагаа ч зогсонги байдалтай байна.

3.5 Монгол улсын аялал жуулчлалын хөгжлийн өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээ

Монголын аялал жуулчлалын онцлог нь дотоодын аялагчдын тоо жилээс жилд хурдацтай өсөж байгаа явдал юм. Энэ нь аймгуудыг холбосон авто замуудыг хатуу хучилттай болгож зассантай холбоотой бөгөөд иргэд аялах, зугаалах, жуучлах сонирхол өндөртэй болсон. Түүнчлэн Засгийн газраас хүрээлэн буй орчныг хамгаалах, иргэдийн тав тухай, аюулгүй аялах нөхцөлийг бүрдүүлэхийн тулд улсын чанартай авто зам дагуу хооллож ундлах, бие засах газар бүхий үйлчилгээний цогцолбор барих ажлыг эхлүүлсэн байна. Гэсэн хэдий ч аялал жуулчлалын салбарт авч хэрэгжиж буй бодлого, хөтөлбөрийн санхүү, хууль эрх зүйн үндэс суурь муу, тогтолцоо сул байгаагаас цаашид шийдвэрлэх шаардлагатай олон тулгамдсан асуудал байна.

Доорх хүснэгтэд аялал жуулчлалын гадаад орчны өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээ, Монголын аялал жуулчлалын салбарын SWOT шинжилгээг хийсэн болно.

Хүснэгт 3-65: Гадаад орчны дүн шинжилгээ

Монгол улсын өнөөгийн байдал	
Улс төр	<ul style="list-style-type: none"> • МАН нь Улсын Их Хурлын 2016, 2020 оны сонгуульд ялсан бөгөөд 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуульд тус намаас нэр дэвшигч У.Хүрэлсүх ялалт байгуулж Монгол улсын Ерөнхийлөгч болсон. • Ардчилсан намаас гаралтай Ерөнхийлөгч асан Х.Баттулга 2017 онд Ерөнхийлөгчөөр сонгогдоноос хойш Ардчилсан Нам дотроо хуваагдаж, зөрчилдсөөр намын дэмжигчид цөөрч ирсэн. Европын орнууд, АНУ, Япон гэх мэт өндөр хөгжилтэй орнуудад сурч байсан гишүүн олонтой ХҮН нам (Хөдөлмөрийн Үндэсний Нам) нь 2020 оны сонгуульд анх удаа Улсын Их Хурал болон НИТХ-д суудал авч, Ерөнхийлөгчийн сонгуулиар ч гэсэн нийт саналын 25 % буюу Ардчилсан Намаас нэр дэвшигчээс илүү олон санал авч чадсан. • 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуулиар Ерөнхийлөгч, Засгийн газрын хоорондох зөрчилдөөнийг арилгаснаар 2 талын бодлогыг уялдуулж, тууштай тогтвортой байдлыг хангахад хялбар болсон гэж үзэж байна. Шинэ Ерөнхий сайд нь аялал жуулчлалын ач холбогдлын талаар ойлголт сайтай бөгөөд шинэчлэл хийх магадлалтай.
Эдийн засаг	<ul style="list-style-type: none"> • Японоос 4 дахин том газар нутагт 3.3 сая орчим хүн (2019 оны хүн ам) амьдардаг. Хүн ам сийрэг үзүүлэлтээр дэлхийд 2-т ордог. Экспортын 80 орчим хувийг эрдэс баялаг эзэлдэг бөгөөд үүний 90 хувийг БНХАУ-д экспортолдог. БНХАУ-аас эдийн засгийн хараат байдал улам гүнзгийрч байна. • Нэг хүнд ногдох ДНБ ойролцоогоор 4,340 ам.доллар (2019) байна. ДНБ-ийг салбар тус бүрээр авч үзвэл хамгийн эхэнд уул уурхайн салбар орж байгаа бол, удаах нь худалдаа, зочид буудал, зоогийн газар орж байна. Бүс нутгаар авч үзвэл Оюутолгойн орд гэх мэт байрладаг Өмнөговь аймгаас бусад бүс нутгийн гол аж үйлдвэрийн салбар нь мал аж ахуй юм. 2019 онд 5 хошуу мал тооллогын дүнгээр 70 сая гаран байсан.
Нийгэм	<ul style="list-style-type: none"> • Нийт хүн амын 70 орчим хувийг 39-оос доош насныхан эзэлдэг. • ҮСХ-ны мэдээлснээр (2018 он) ядуурлын түвшин 28.4% тай байгаа бөгөөд гадаадад ажил хийхээр Монголоос гарч явдаг хүн олон хэвээр байна. Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын тогтолцоо бүрдсэн боловч эмнэлгийн үйлчилгээний чанар тийм ч сайн биш юм. • Нийслэл хотын агаарын бохирдлын асуудал хурцаар тавигдаж байсан боловч сүүлийн жилүүдэд бага зэрэг буурч байгаа.
Аялал жуулчлалын өнөөгийн байдал	
	<ul style="list-style-type: none"> • БНХАУ болон ОХУ-ын дунд оршдог, далайд гарцгүй орон бөгөөд урдаас хойшоо холбосон төмөр замаар хоёр орон руу зорчдог. • Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудал 2021 оны 7-р сард ашиглалтад орсон бөгөөд Японы компани менежментийг хариуцах юм. 2020 оны 3-р сард Үндэсний агаарын тээвэрлэгч МИАТ ТӨХК нь Японы Japan Airlines компанитай аяллын дугаар хамтран эзэмших гэрээ байгуулсан. • Гадаадаас ирэх жуулчдын тоо тасралтгүй нэмэгдэж байгаа бөгөөд 2015 онтой харьцуулахад 2019 онд 146% боллоо өсжээ. 2019 оны аялал жуулчлалын салбарын орлого 2015 оныхтой харьцуулахад 219% иар өссөн буюу ойролцоогоор 607 сая ам.доллар байв.

<ul style="list-style-type: none"> • Ковид-19-ын цар тахлын үр нөлөөгөөр 2020 оны эхэн үеэс эхлэн хил хаасантай холбогдуулан 2020 онд жуулчдын тоо 58,859 болж огцом буурчээ. Аялал жуулчлалын орлого ч 2019 онтой харьцуулахад эрс буурч, аялал жуулчлалын салбарын алдагдал 570 сая ам долларт хүрсэн аж (БОАЖЯ). • МИАТ ТӨХК нь олон улсын нислэг үйлддэг Монголын цорын ганц компани юм. "МИАТ" компаниас гадна "БНХАУ-ын Иргэний агаарын тээвэр", "Korean Air", "Asiana Airlines", "Turkish Airlines", гэсэн гадаадын агаарын тээвэрлэгчид олон улсын нислэг үйлддэг. МИАТ -ийн нислэгийн чиглэлүүд өргөжиж байгаа бөгөөд одоогоор 7 улсын 12 чиглэл байна.
Монголд ирж буй гадаадын иргэд
<ul style="list-style-type: none"> • (1) БНХАУ, (2) ОХУ, (3) БНСУ (дээрх гурван орноос нийтдээ 100,000 гаруй хүн), (4) Япон (24,000 орчим хүн), (5) АНУ (19,000 хүн) хүн Монголд ирдэг бөгөөд 2012 оноос хойш энэ дараалал өөрчлөгдөөгүй. • Европын орнууд, АНУ-ын иргэд ойролцоогоор 2 долоо хоног, БНСУ, Японы иргэд 1 долоо хоног орчмын хугацаагаар Монголд саатах нь их. • Японоос ирж байгаа иргэд ихэвчлэн аялал жуулчлалын компаниар дамжуулж ирж аялдаг. • Жуулчдын тал хувь нь 40 -өөс дээш насныхан, 3 хүн тутмын 1 нь 55 -аас дээш насныхан байдаг. Ихэнх жуулчид Монголд хийсэн аялалдаа сэтгэл хангалуун байдаг байна.
Монгол-Японы харилцаа
<ul style="list-style-type: none"> • Япон улсын хувьд, Монгол улс нь нийтлэг үнэт зүйлс бүхий найрамдалт харилцаатай, “Стратегийн түнш” орон юм. Япон улс бол суралцах, боловсрол эзэмшихийг хүсдэг орнуудын хамгийн нэн тэргүүнд байдаг. • Эдийн засгийн харилцааны тухайд гэвэл, Японоос Монгол руу гаргадаг экспортын хэмжээ Монголоос Япон руу оруулдаг импортын хэмжээнээс хэд дахин их, худалдааны алдагдал ихтэй. Монголоос Японыг зорьсон хүний тоо Японоос Монголыг зорьсон хүний тооноос давсан.

Хүснэгт 3-бб: Монголын аялал жуулчлалын салбарын SWOT шинжилгээ

	Зохион байгуулалт / Тогтолцоо / Бодлого
Давуу тал	<ul style="list-style-type: none"> • “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого (2020 он) батлагдаж, хөгжлийн зорилтууд тавигдсан бөгөөд үүнд аялал жуулчлалын салбарын баримтлах чиглэлийг ч тодорхой болгосон. Түүнчлэн 2019 онд баталсан "Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого 2019-2026" -д аялал жуулчлалтай холбоотой асуудлуудыг тодорхой зааж тусгаж өгсөн байна. • Аялал жуулчлалын ач холбогдлын талаарх ойлголт гүнзгийрч, Аялал жуулчлалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, аялал жуулчлал хариуцсан бие даасан байгууллага бий болгох зэрэг асуудлууд хэлэлцэгдэж байна.
	Аялал жуулчлалын нөөц ба тэдгээрийн хадгалалт хамгаалалт
	<ul style="list-style-type: none"> • Дэлхийн өв (хадны зураг, Чингис Хааны өлгий нутаг, Орхоны хөндийн соёлын дурсгалт газар, Увс нуурын ай сав газар) Дэлхийн соёлын биет бус өв (Морин хуур, хөөмий, гэр, уртын дуу) болон бусад олон байгаль, түүх, соёлын дурсгалт газрууд байдаг. • Өргөн уудам нутаг, үзэсгэлэнт байгальтай газар олон (Алтайн Нурууд, Говийн их тал, гүн цэнгэг нуурууд гэх мэт), нүүдэлчний соёл иргэншил одоо ч хэвээрээ байдаг (уламжлалт нүүдлийн амьдрал, хэв маяг, хоол хүнстэй танилцах боломжтой) орон юм. • Дэлхийд ховорхон үлэг гүрвэлийн чулуужсан олдворын өлгий нутаг (малтлагын ажил одоо ч үргэлжилж байна) • Олон орны хэл соёлд суралцаж, сүүлийн үеийн дэвшилтэт технологийг эзэмших чадвартай шилдэг залуус ихтэй.
	Жуулчдын аюулгүй, тав тухтай орчин
	<ul style="list-style-type: none"> • Засгийн газраас авто зам дагуу үйлчилгээний цогцолбор (замын өртөө), нийтийн бие засах газар барихаар төлөвлөж байна. • Жуулчны гэр баазууд ч дотроо бие засах газар, халуун устай шүршүүр тавьж эхэлж байна.
	Аялал жуулчлалтай холбоотой хууль тогтоомж
	<ul style="list-style-type: none"> • байхгүй

Сул тал	Байгаль орчин, нийгмийн нөлөөллийг харгалзан үзэх
	• байхгүй
	Дэд бүтэц
	• Нийслэлээс аймгууд хүрэх гол авто замуудыг хатуу хучилттай болгоод дуусаж байгаа • Авто зам дагуу үйлчилгээний цогцолбор (замын өртөө), нийтийн бие засах газар суурилуулж эхэлсэн
	Хүний нөөцийн хөгжил
	• БОАЖЯ сургалтууд явуулж эхэлсэн • БНСУын Засгийн газрын тусламжтайгаар "Монголын аялал жуулчлалын сургалтын төв" баригдсан.
	Мэдээлэл түгээлт (Маркетинг / Сурталчилгаа)
	• байхгүй (Зарим хувийн хэвшлийн видео ашигласан сурталчилгаанууд маш сайн)
	Зохион байгуулалт / Тогтолцоо / Бодлого
	• Аялал жуулчлалын асуудал хариуцсан төрийн албан хаагчид нийслэл хотод ч орон нутаг ч хэт цөөхөн байдаг тул аялал жуулчлалын бодлого боловсруулж, түүнийгээ хэрэгжүүлэхэд боловсон хүчин хүрэлцдэггүй. • Аялал жуулчлалын салбарын төсөв маш бага тул ихэнх хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломжгүй байдаг. • Аялал жуулчлалын асуудлыг голлон хариуцсан бие даасан захиргааны байгууллага гэж байдаггүй. • "Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого 2019-2026"-ийг сурталчлах аялал жуулчлалыг хөгжүүлэх тодорхой стратеги боловсруулагдаагүй байна. • Аялал жуулчлалын салбар дахь гадаадын хөрөнгө оруулалтыг урамшуулах арга хэмжээ болон аялал жуулчлалд хөрөнгө оруулах хөшүүрэг байхгүй.
	Аялал жуулчлалын нөөц ба тэдгээрийн хадгалалт хамгаалалт
	• Аялал жуулчлалын ховор хийгээд эмзэг нөөц олонтой (үлэг гүрвэлийн чулуужсан олдворууд, бэлчээр гэх мэт) • Аялал жуулчлалын газруудын аялал жуулчлалын нөөцийг хадгалах, хамгаалах үйл ажиллагаа хангалттай бус • Аялал жуулчлалын нөөцийг хамгаалах талаар идэвх санаачилгатай үйл ажиллагаа хангалттай явуулдаггүй (шинээр хиймэл байгууламж барих сонирхол нь илүү их). • Аялал жуулчлалын салбарын байгууллага хооронд хамтран ажиллах, мэдээлэл солилцох тогтолцоо бүрдээгүй
	Жуулчдын аюулгүй, тав тухтай орчин
	• Төв авто замаас аялал жуулчлалын газрууд руу салсан авто замуудын дэд бүтэц хөгжөөгүйгээс замд ядардаг. • Цэвэр, тохилог нийтийн бие засах газар, халуун ус, шүршүүр одоогоор бүрэн хангалттай бус • Хоол, үйлчилгээний чанар муу • Нислэгийн тийз, үйлчилгээний төлбөр өндөр • Аялал жуулчлалын найдвартай мэдээллийг олж авахад бэрхшээлтэй (англи хэл гэх мэт гадаад хэлээр мэдээлэл түгээх байдал тааруу) • Аялал жуулчлалын газарт болон замд нийтийн бие засах газар байдаггүй
	Аялал жуулчлалтай холбоотой хууль тогтоомж
	• Аялал жуулчлалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж нь тулгамдсан асуудал ихтэй.
	Дэд бүтэц
	• Төв авто замаас бусад авто зам хатуу хучилтгүй • Аялал жуулчлалын газарт болон замд нийтийн бие засах газар байдаггүй
	Хүний нөөцийн хөгжил
	• Аялал жуулчлалын улирал богинохон, түүнээс гадна энэ салбарт ажиллагсдын дийлэнх нь тогтмол биш улирлын чанартай ажилладаг

Боломж	Зохион байгуулалт / Тогтолцоо / Бодлого
	<ul style="list-style-type: none"> • Аялал жуулчлалын нөөц ба тэдгээрийн хадгалалт хамгаалалт • Жуулчдын аюулгүй, тав тухтай орчин • Засгийн газар нийтийн бие засах газар суурилуулах төлөвлөгөөг боловсруулсан • Авто зам дагуу барих үйлчилгээний цогцолбор (Мичи но эки) -ын хэрэгжилтэд ЖАЙКА удирдамж, зөвлөгөө өгөх юм.
	Аялал жуулчлалтай холбоотой хууль тогтоомж
	• Хуульд нэмэлт өөрчлөлт оруулах магадлалтай
	Дэд бүтэц
	• Үндэсний хөгжлийн төлөвлөгөөнд дэд бүтцийг хөгжүүлэхээр заасан
	Хүний нөөцийн хөгжил
• БНСУ-ын тусламжтайгаар баригдсан "Монголын аялал жуулчлалын сургалтын төв" ийг ашиглах боломжтой болно	
Аюул занал	Зохион байгуулалт / Тогтолцоо / Бодлого
	<ul style="list-style-type: none"> • Хариуцсан ажилтан ойр ойрхон солигдох, улс төрийн шалтгаанаар байнга халаа сэлгээ хийгдэх ⇒ Мэргэжилтэнгүй болох • Хариуцсан ажлын залгамж чанар, тууштай, тогтвортой байдал алдагдах
	Аялал жуулчлалын нөөц ба тэдгээрийн хадгалалт хамгаалалт
	<ul style="list-style-type: none"> • Хамгаалалтын арга хэмжээ авахгүй байснаас элэгдэж муудан, устах • Бие засах газар байгуулахгүйгээс үүдэн хүрээлэн буй орчин ихээр бохирдох
	Жуулчдын аюулгүй, тав тухтай орчин
	<ul style="list-style-type: none"> • Жуулчдын тоо огцом ихсэж, бие засах газар хүрэлцэхгүй болох. Энэ шалтгаанаар байгаль орчны доройтох, бохирдох байдал улам бүр газар авах
	Аялал жуулчлалтай холбоотой хууль тогтоомж
	• Хуульд нэмэлт өөрчлөлт орохгүй байх
	Дэд бүтэц
	• Төсөв баталгаажуулж чадахгүй, дэд бүтцийн хөгжлийг хэрэгжүүлэхгүй байх
	Хүний нөөцийн хөгжил
	• Аялал жуулчлалын салбарыг сэргээж чадахгүй, ажилгүй болох

Эх сурвалж: Судалгааны баг

Монгол улс аялал жуулчлалын нөөцийн хувьд харьцангуй олон давуу талтай орон. Тодруулбал ЮНЕСКО-гийн дэлхийн өвд бүртгэгдсэн 4 газар, Соёлын биет бус өвд бүртгэгдсэн 11 газар байдаг. Дэлхийн эдийн засгийн форумас нэгтгэн гаргадаг Дэлхийн аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадварын үзүүлэлтээр Монгол улс нь 2019 оны байдлаар 140 орноос 93-р байранд эрэмбэлэгдсэн нь Монгол улсын өрсөлдөх чадвар сул хэвээр байгааг илтгэж байна. Харин, энэхүү судалгаанд соёл болон бизнесийн аяллын үзүүлэлтээр 59-р байранд жагсжээ.⁵³ Монголд хийх аялал жуулчлалын зорилгыг тодруулсан судалгааны асуулгад үргэлж дээгүүр байрыг эзэлдэг "байгаль"-ийн тухайд буюу байгалийн нөөц үзүүлэлтээр харьцангуй дээгүүр 62-р байранд эрэмбэлэгдсэн байна. Энэ бүхнээс харахад Монгол улс аялал жуулчлалын нөөцөөрөө олон улсын хэмжээнд өрсөлдөх чадвар хангалттай байгаа гэж хэлж болно. Монголбанк болон Аялал жуулчлалын хөгжлийн төвөөс 2019 онд хийсэн ижил төстэй судалгаагаар Монгол улсад дахин зочлох хүсэлтэй гадаадын жуулчид 65%-д хүрсэн байна. Нөгөөтэйгүүр, ЖАЙКА-ийн судалгааны баг 1998 оны 7-р сараас 8-р сар хүртэлх хугацаанд, нийт 3,031 гадаадын иргэнд хийсэн судалгаагаар дахин зочлох хүсэлтэй гэсэн жуулчны тоо 86.5% -д хүрч байсан. 1998 оны ЖАЙКА-ийн судалгаа болон түүнээс 20 жилийн дараа хийгдсэн Монголбанкны судалгаанд ижил үр дүн гарч байгаа нь гадаадын жуулчид олон хүндрэл бэрхшээлтэй тулгарч, тав тухгүй өнгөрүүлсэн ч тэдгээрээс нь давсан сайхан байгаль, соёл, ёс заншилтай танилцаж, арвин баялаг аялал жуулчлалын нөөцийг Монголд үзсэн болоод тэр болов уу.

⁵³ Дэлхийн эдийн засгийн форум, UNWTO: Дэлхийн аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадварын харьцуулсан судалгааны тайлан 2019

Монгол улсад 2019 онд гадаадын 570,000 гаруй жуулчин ирсэн бөгөөд 2016 оноос 270,000 гаруй хүнээр нэмэгдсэн байна. Ковид-19 халдварт цар тахлын нөлөөнөөс үүдэн 2020 онд жуулчдын тоо эрс цөөрсөн хэдий ч сүүлийн жилүүдэд тогтвортойгоор өсөж, аялал жуулчлалын салбарын ач холбогдол ч өндөрсөж ирсэн. Холбогдох салбарын орлого 2016 онд 310 сая доллар байсан бол 2019 онд 600 сая доллар болж богино хугацаанд хоёр дахин өсжээ.⁵⁴ Мөн сүүлийн жилүүдэд дотоодын аялагчдын тоо ч эрс нэмэгдэж, Хөвсгөл нуур, Хархорин, Хамарын хийд зэрэг нэртэй аялал жуулчлалын газруудын дотоодын аялагчдын тоо өссөөр байна.⁵⁵

Монголын дотоодын аялагчдын тоо нэмэгдэж буй шалтгаан нь аймгууд руу холбосон авто зам хатуу хучилттай болж шинэчлэн өргөтгөснөөр аялалд зарцуулагдах цаг хугацаа богиносж, аюулгүй, тав тухай болсон. Түүнээс гадна Монголчууд өөрийн орны үзэсгэлэнт газруудтай танилцаж, аялж жуулчлах сонирхол өндөрсөж байгаатай холбоотой юм. Түүнчлэн аялал жуулчлалын салбарын хөгжлийн эдийн засагт үзүүлэх хувь нэмэр, ач холбогдлыг удирдагчид ойлгож эхэлж байгаа бөгөөд "Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого 2019-2026"-г Засгийн газрын хуралдаанаар баталснаас гадна, 2020 онд Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа-2050"-г их хурлаар баталсан юм. Аялал жуулчлалын салбарыг ч мөн эдгээр үндсэн бодлогын баримт бичигт дурдсанчлан урт хугацаагаар тогтвортой хөгжүүлэхээр болжээ.

Аялал жуулчлалын хөгжлийн стратеги төлөвлөлт, хэрэгжилт нь Монгол улсын хөгжлийн нэн чухал сэдэв юм. Хүн төрөлхтөн Ковид-19 халдварт цар тахлыг даван туулж чадсан тэр үед, дэлхий даяар аялал жуулчлалын сонирхол дахин нэмэгдэх болно. Ковид-19 халдварт цар тахлын нөлөөгөөр дэлхий даяар аялал жуулчлалын салбарын үйл ажиллагаа зогсоод байгаа чухам энэ үе л, ирээдүйн стратеги боловсруулах чухал цаг үе болно. Тэр утгаараа 2021 оны 1-р сарын 27-нд шинээр томилогдсон Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, томилогдоод тун удалгүй 2021 оны 2-р сарын 25-нд аялал жуулчлалын уулзалтыг зохион байгуулж, аялал жуулчлалын салбарт тулгарч буй бэрхшээлүүдийн талаар авч хэлэлцсэн нь цаг үеэ олсон ажил байв. Энэхүү судалгааг хэрэгжүүлсэн 2021 он нь, шийдвэрлэгдэж чадалгүй удаан хүлээгдсэн Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудлыг ашиглалтад оруулах жил бөгөөд Монгол улсын аялал жуулчлалыг хөгжүүлэх стратегийн эхлэх цэг болох чухал жил юм.

Монголын аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэхийн тулд дэд бүтцээс эхлээд олон шийдвэрлэх шаардлагатай асуудал бий. Гэвч Монгол Улсын Засгийн газрын аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөөнд аялал жуулчлалтай холбоотой зам, нисэх онгоцны буудал, замын дагуух үйлчилгээний цогцолбор, нийтийн бие засах газрыг барьж тохижуулах чухал арга хэмжээнүүдийг тусгасан байна. Нөгөө талаас Засгийн газар санхүүгийн эх үүсвэр дутмагаас олон асуудлыг богино хугацаанд шийдвэрлэхэд хүндрэлтэй байдаг. ЭЗХАХБ-ын судалгаагаар дэлхий нийтийн аялал жуулчлалын салбар 2019 оны түвшинд хүрж эргэж сэргэтэл ойролцоогоор 5-6 жил зарцуулагдах төлөвтэй байгаа тул энэ үе нь Монголын аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэс суурийг тавих үе хэмээгээд, өнөөгийн тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэх тал дээр хичээн ажиллах нь чухал юм.

Байгаль орчны нэн ховор, эмзэг нөөцтэй, дотоод, гадаадын жуулчдын тоо хурдацтай нэмэгдэж буй Монгол шиг улсад аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэхийн тулд, дэд бүтцээ хөгжүүлэхийн зэрэгцээ байгаль орчин, соёлын өв зэрэг аялал жуулчлалын нөөцийн ач холбогдлын талаар олон нийтэд ойлгуулах, сурталчлан таниулах ажлыг эрчимтэй хийх нь чухал юм. Сүүлийн жилүүдэд БОАЖЯ нь АХБ зэрэг олон улсын байгууллагууд мөн бусад донор орнуудтай хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлж, аялал жуулчлалын тогтвортой хөгжлийн төлөө идэвхтэй ажиллаж байгаа нь цаг үеэ олсон ажил болж байна.

⁵⁴ Ерөнхий сайдын санаачилгаар зохион байгуулагдсан аялал жуулчлалын уулзалтын материал (БОАЖЯ, 2021.03.02)

⁵⁵ Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газарт аялагчдын тоо (дотоодын жуулчин 2019 онд 66284 хүн, 2020 онд 80590 хүн)

Хамарын хийдийн цогцолборт газарт аялагчдын тоо (дотоодын жуулчин 2017 онд 64954 хүн, 2018 онд 72366 хүн)
Орхоны хөндийн байгалийн цогцолборт газарт аялагчдын тоо (дотоодын жуулчин 2019 онд 15386 хүн, 2019 онд 16380 хүн)

4-р бүлэг

Аялал жуулчлалыг хөгжүүлэхэд тулгарч
буй асуудлууд

4-р бүлэг Аялал жуулчлалыг хөгжүүлэхэд тулгарч буй асуудлууд

2-р бүлгийн 2.2-т дурдсанчлан Монгол улсын аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэхэд Монгол Улсын Засгийн газрын урт хугацааны хөгжлийн стратеги, 5 жилийн төлөвлөгөө зэрэг үндэсний бодлого чиглэлд тусгагдсан "Аж үйлдвэрийг төрөлжүүлэх", "Бүс нутгийг хөгжүүлэх" зорилтуудыг биелүүлэхэд чухал хувь нэмэр оруулах хүлээлттэй байгаа юм. Мөн жуулчдын тоо эрс нэмэгдэж буй бүс нутагт үүсээд байгаа нийгэм болон хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөг харгалзан, Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого (2019-2026)-д тусгасан "Хүрээлэн буй орчинд ээлтэй, нутгийн иргэдийн оролцоонд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх" зорилтыг хэрэгжүүлэх нэн шаардлага бий болоод байгаа билээ. Үүний тулд 2, 3-р бүлгийн дүн шинжилгээгээр тодорхойлсончлон урьдчилсан нөхцөл болох бодлогыг хэрэгжүүлэх тогтолцоо бүрдүүлэн, санхүүгийн эх үүсвэрийг баталгаажуулах, түүн дээр нэмээд аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэх, хариуцсан төрийн албан хаагчид, аялал жуулчлалын салбарт ажиллагсдыг чадавхижуулах, хөдөлмөрийн нөхцөлийг нь сайжруулах, аялал жуулчлалын салбарыг төрөөс бодлогоор дэмжих, маркетинг, сурталчилгааны ажлыг идэвхтэй явуулах, түүнчлэн аялал жуулчлалын нөөцийг хамгаалах, хадгалах, энэ талаар олон нийтэд ухуулан таниулах ажлуудыг хэрэгжүүлэх нэн чухал шаардлагатай байна.

Энэ бүлэгт цаашид шийдвэрлэх ёстой асуудлуудыг 2, 3-р бүлгийн дүгнэлтэд үндэслэн дараах байдлаар цэгцлэн тусгаж байна.

(1) Аялал жуулчлалын асуудал хариуцсан төрийн албан хаагч, мэргэжилтэн дутмаг

Монгол улсын төр засгийн байгууллагад аялал жуулчлалын асуудал хариуцсан төрийн албан хаагч цөөхөн байдаг. БОАЖЯ нь 121 ажилтантай бөгөөд үүнээс 7 ажилтан нь аялал жуулчлалын асуудал хариуцдаг. Мөн Аялал жуулчлалын хөгжлийн төвд 18 ажилтан байдаг ба аялал жуулчлалын бодлого боловсруулах, орон нутгийн засаг захиргаанд удирдамж, зааварчилгаа өгөх, бодлогын хэрэгжилтийг хянаж зохицуулах, олон улсын хамтын ажиллагаа хэрэгжүүлэх зэрэг олон төрлийн ажлыг эдгээр ажилтнууд хариуцан ажилладаг.

Улсын болон орон нутгийн түвшинд аялал жуулчлалтай холбоотой олон бодлого төлөвлөгөө байдаг бөгөөд агуулга нь ч олон янз байдаг. Эдгээр төлөвлөгөөнд бичсэн зүйлсийг цэгцэлж, уялдуулж, ажил хэрэг болгоход одоогийн байгаа цөөхөн боловсон хүчин хүрэлцээтэй биш юм. Төрийн албан хаагчдын тоог нэмэгдүүлэхгүйгээр хувийн хэвшилтэй гэрээгээр гүйцэтгүүлэх хувилбар байж болох боловч, хүн ам цөөн, хувь хүмүүс хоорондын харилцаа холбоо нягт байдаг Монголын нийгэмд, Засгийн газар солигдох бүрд төрийн албан хаагчид төдийгүй, улсын ажлыг гэрээгээр гүйцэтгэн хэрэгжүүлдэг хувийн хэвшлүүд хүртэл солигдох тохиолдол элбэг байдаг тул хувийн хэшилд даалгах нь төрийн ажлын таслалтгүй, тогтвортой байдлыг хангахад хүндрэл учруулдаг. Төрийн албан хаагчдын орон тооны асуудлыг дахин хэлэлцэх цаг болсон гэж үзэж байна.

(2) Аялал жуулчлалын асуудал хариуцсан төрийн бие даасан агентлаг байгуулах шаардлагатай

Монголд ирж буй гадаадын жуулчдын хамгийн гол зорилго нь онгон сайхан байгалийг үзэхэд оршдог тул аялал жуулчлалын нөөц болох байгаль орчноо хамгаалахын зэрэгцээ аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор одоогийн БОАЖЯ-ыг 2014 онд шинэчлэн байгуулсан. Гэвч дэлхийн улс орнууд аялал жуулчлалаа хөгжүүлэхэд ихэд анхаарч, энэ салбарын олон улсын өрсөлдөөн ширүүсэж байгаа өнөө үед, Монгол Улсын одоогийн тогтолцоо нь хангалттай эсэхийг дахин тунгааж үзэх шаардлага бий болоод байна. Аялал жуулчлалын бодлого төлөвлөлт, хэрэгжилт, орон нутгийн засаг захиргаатай хийх хамтын ажиллагаа, аялал жуулчлалын салбарын бусад тулгамдсан асуудлууд болон хүний нөөцийн хөгжил, олон улсын хамтын ажиллагаа зэрэг өргөн хүрээний үйл ажиллагааг нэгтгэн хариуцах Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг "Аялал жуулчлалын ерөнхий газар"-ыг шинээр байгуулах цаг үе нэгэнт ирсэн шиг санагдана. Аялал жуулчлал нь эдийн засаг, соёл, байгаль орчин зэрэг олон талын салбартай холбоотой учраас Ерөнхий сайдын удирдлагын дор "Үндэсний хөгжлийн газар" байдагтай адил, Ерөнхий сайдын дэргэдэх "Аялал жуулчлалын ерөнхий газар" байгуулж ч болох юм.

(3) Улс, аймаг, хувийн хэвшил хоорондын хамтын ажиллагаанд тулгарч буй асуудал

Ихэнх аймгийн Засаг даргын Тамгын газарт аялал жуулчлалын асуудлыг хариуцдаг ажилтан нь аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газарт нэг л мэргэжилтэн томилогдон ажилладаг. Аймгийн түвшинд аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг Өмнөговь аймгийн “Гайхамшигт Говь” АЖ холбоо зэрэг ТББ байдаг ч ховор юм. Ихэнх аймагт ТББ-ууд нь бодит үйл ажиллагаа явуулах боломжгүй байдалтай.

Орон тооны хослоос үүдэн Улс, аймгийн засаг захиргааны ажлаас гүйцэтгэж амжихгүй хэсгийг ТББ болон хувийн хэвшилд хийлгэх нь төрийн байгууллагуудын ачааллыг бууруулахад чухал ач холбогдолтой боловч, дээр дурдсанчлан нийслэлээс бусад газарт ТББ-уудын үйл ажиллагаа боловсронгуй болоогүй, мөн одоо хүчин төгөлдөр байгаа ТББ-ын тухай хуулиар ашгийн төлөө үйл ажиллагаа явуулахыг хориглодог тул, ТББ-ын үйл ажиллагааны санхүүгийн эх үүсвэр нь татаас, хандивд тулгуурлахаас өөр аргагүй. Энэ шалтгааны улмаас олон ТББ бодит байдал дээр тогтмол, идэвхтэй үйл ажиллагаа явуулж чаддаггүй хэмээн үзэж байна.

Иймд Монгол Улсад аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого хэрэгжүүлэх, төсөв санхүүжилтыг баталгаажуулахад төр засаг, орон нутгийн засаг захиргаа голлох үүрэг гүйцэтгэхээс өөр аргагүй. Ялангуяа гадаад зах зээлд зар сурталчилгаа хийх үүргийг хэдийгээр аялал жуулчлалын хувийн компаниуд гүйцэтгэж байгаа ч, төр засаг, орон нутгийн засаг захиргаанаас Монголын аялал жуулчлалын цэгүүд болон түүх соёлын сэтгэл татам байдлын талаарх мэдээллийг тогтвортойгоор цацаж түгээх үйл ажиллагааг идэвхтэйгээр хэрэгжүүлэх ёстой юм.

Сүүлийн үед байгалийн цогцолборт газрын хамгаалалтын менежментийг ТББ-аар гүйцэтгүүлж, байгалийн цогцолборт газарт нэвтрэх хураамжийн орлогыг тухайн ТББ-ын үйл ажиллагааны зардал, ажилчдын цалин хөлсөнд зарцуулах гэсэн өөрөө удирдах хэлбэрийн ажил эхэлсэн. Хустайн БЦГ, Баянзаг болон Их нартын БНГ зэрэгт хэрэгжүүлж байгаа дээрх арга хэлбэрийг цаашид бусад байгалийн цогцолборт газруудад хэрэгжүүлэх боломжтой эсэхийг анхааран ажиглаж байна. Аялал жуулчлалын нөөцийн удирдлага, нутгийн иргэдийн оролцоог хангах үүднээс энэ аргыг идэвхтэй өргөжүүлэх хэрэгтэй гэж үзэж байна.

(4) Статистик, мэдээллийн боловсруулалтыг сайжруулах

Аялал жуулчлалыг хөгжүүлэх стратеги боловсруулахын тулд өнөөгийн нөхцөл байдлыг үнэн зөвөөр ойлгож мэдэх шаардлагатай боловч Монгол Улсад хэрэгтэй статистик мэдээлэл хангалтгүй байдаг. Түүвэр судалгааны анхдагч өгөгдөл байдаггүй, маягт дээрх асуумж ойлгомжгүй байдгаас зохих хариултыг олж авах боломжгүй, мөн нийтлэгдэж буй статистик мэдээллийг хэн хариуцаж байгаа нь тодорхойгүй, илд буруу ташаа статистикийн мэдээлэл (Жишээлбэл: Улаанбаатар хотод зорчсон гадаадын жуулчдын тоо нь Монголд орж ирсэн гадаадын иргэдийн тооноос их байгаа) гэх мэт дутагдалтай тал олон ажиглагдаж байна. Аймагуудад аялсан гадаадын жуулчдыг улс тус бүрээр тоолсон мэдээлэл байхгүй, эсвэл ихэнх аймагт хангалтгүй байна.

Статистикийн мэдээллийг боловсронгуй болгоход ихээхэн хэмжээний зардал, хүн хүч, цаг хугацаа шаардагдах тул цуглуулах тоо баримт, мэдээллийг илүү нарийвчилж, хэрхэн олж авах, дүн шинжилгээ хийх, ашиглах талаар сайтар төлөвлөх хэрэгтэй. Мэдээлэл цуглуулахад асуулга судалгаанаас өөр арга бас байж болно. Жишээлбэл, Монгол Улсад өргөн хэрэглэгддэг кредит картын төлбөрийн мэдээллээс гадаадын иргэдийн харьяалал (аль улсын иргэн гэх мэт) тус бүрээр хэрэглээний чиг хандлагыг, бүс нутаг тус бүрээр, эсвэл хэрэглээний төрөл тус бүрээр (жишээлбэл, хоол хүнс, ундаа, байр, тээвэр гэх мэт) мэдэж авах боломжтой. Мөн харилцаа холбооны компаниудын эзэмшиж буй гадаадын жуулчдын байршлын өгөгдөл мэдээллийг ашиглан жуулчдын динамик хөдөлгөөний талаар мэдээлэл цуглуулах боломжтой. Ийм төрлийн шинээр статистикийн мэдээллийн боловсруулах тогтолцоог бүрдүүлэхээс гадна аль хэдийн олсон өгөгдөл мэдээллийг оновчтой ашиглах талаар бодох ёстой. Хувь хүний мэдээллийг хамгаалах талаар асуудал үүсэхгүй хүрээнд цуглуулсан тоо баримт, мэдээллийг боловсруулан нийгэд зарлаж, аялал жуулчлалын компаниудыг өөрсдийн зорилгын дагуу дүн шинжилгээ хийх боломжтой болгох нь аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах болно гэж үзэж байна.

(5) Хууль эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх

Монгол Улсад хуулиар үндсэн зарчмыг л тусгаж, ард иргэдийн дагаж мөрдөх ёстой олон журмыг Засгийн газар, яамдын гаргах тогтоол тушаалаар зохицуулдаг тогтолцоотой. Аялал жуулчлалын тухай хуульд гол төлөв аялал жуулчлалын асуудлыг хариуцах төр засгийн байгууллагын эрх мэдлийг тогтоосон байдаг бөгөөд Япон улсын яам, агентлаг байгуулах тухай хуулийн агуулгатай төстэй агуулгатай. Жуулчны бааз байгуулах стандарт зэргийг дүрэм журмаар нарийвчлан заасан байдаг. Олон талын хүн байгууллагатай хамааралтай Аялал жуулчлалын тухай хуулийн хувьд ерөнхий хүрээ, бүтцийг ойлгомжтой боловсруулах шаардлагатай. Мөн зөвхөн төр засгийн эрхийн хэмжээ бус, хувийн хэвшил төр засгаас юу шаардаж болох талаар хуульд тусгаж зохицуулах нь зүйтэй. Япон улс 2006 онд “Үндэсний аялал жуулчлалыг хөгжүүлэх тухай хууль”, 2009 онд “Үндэсний аялал жуулчлалыг хөгжүүлэх суурь төлөвлөгөө”-г тус тус баталж гаргасан. Энэ хуульд аялал жуулчлалыг дамжуулан улсыг хөгжүүлэх нь үндэсний стратеги гэж тодорхойлсон. Монгол улсын хууль шиг зөвхөн төр засгийн эрх мэдлийн тухайд бус, Засгийн газар, орон нутгийн засаг захиргаа, иргэд, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн үүрэг хариуцлагын талаар тусгасан байдгаараа онцлогтой. Уг хууль нь,

- ① Олон улсад өрсөлдөх чадвартай, сонирхол татахуйц аялал жуулчлалын цэгүүдийг бий болгох
- ② Аялал жуулчлалын салбарын олон улсад өрсөлдөх чадварыг дээшлүүлэх
- ③ Гадаад дотоодын жуулчдын аяллыг хөгжүүлэх орчныг сайжруулах
- ④ Олон улсын аялал жуулчлалыг хөгжүүлэх

гэсэн 4 хэсгээс бүрдсэн бөгөөд ялангуяа ③-д жуулчдад хялбар, саадгүй, шуурхай үйлчилгээ үзүүлэх, жуулчидтай харилцах харилцааг сайжруулах, жуулчдын тав тух, аюулгүй байдлыг хангах зэрэг жуулчдад зориулсан агуулгаас гадна аялал жуулчлалын шинэ чиглэлийг нээж хөгжүүлэх, аялал жуулчлалын цэгүүдийн орчныг хамгаалах төлөвлөгөө, аялал жуулчлалын статистикийн мэдээллийг боловсруулах гэх мэт аялал жуулчлалын холбогдох бодлого, арга хэмжээний талаар заасан.

Монгол Улсад байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай дэд бүтцийн төлөвлөгөө хэрэгжүүлэх тохиолдолд "Байгаль орчныг хамгаалах тухай хууль" -ийн заалтын дагуу байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийх шаардлагатай байдаг. Төлөвлөгөөний агуулга, үр нөлөөний тухай мэдээллийг олон нийтэд нээлттэй болгохоос гадна орон нутгийн оролцогч талуудад зохих тайлбар өгөх нь бас чухал алхам юм. Нөлөөллөөс хамааран төлөвлөгөөг өөрчлөх, орлох төлөвлөгөөг шинээр бэлтгэх шаардлага болно.

Мөн нийгмийн орчинд (оршин суугчдыг нүүлгэн шилжүүлэх, амьдрал / амьжиргаа, соёлын өв, байгалийн үзэмж, ажиллах орчин гэх мэт) үзүүлэх нөлөөллийг хэмжих шаардлагатай. Тусгай хамгаалалттай газар нутгийн дэд бүтцийн төлөвлөлтийн талаар "Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль", "Соёлын өвийг хамгаалах тухай хууль" -ийн заалтыг анхаарч, соёлын өв, байгалийн үзэмжид нөлөөлөхгүй байхаар төлөвлөх шаардлагатай юм. Дараах хүснэгтэд "Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль" болон "Соёлын өвийг хамгаалах тухай хууль"-иар хориглосон зүйлсийг харуулж байна.

Хүснэгт 4-1: Тусгай хамгаалалттай газар нутаг дахь дэд бүтцийн бүтээн байгуулалтад хамаарах хуулийн заалтууд

Тусгай хамгаалалттай газар нутгийн ангилал	"Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль" болон "Соёлын өвийг хамгаалах тухай хууль"-ийн заалтууд
Дархан цаазат газар	"Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль"-ийн 12-р зүйлийн 5-д, түр буудаллах, отоглох, ажиглалт, судалгаа шинжилгээ хийх зориулалтаас өөр барилга байгууламж барихыг хориглоно.

Тусгай хамгаалалттай газар нутгийн ангилал	"Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль" болон "Соёлын өвийг хамгаалах тухай хууль"-ийн заалтууд
Байгалийн цогцолборт газар	"Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль"-ийн 18-р зүйлийн 3-т, батлагдсан ерөнхий төлөвлөгөө, зураг төсвийг зөрчиж суурины нутаг дэвсгэрийг тэлэх, барилга байгууламж барихыг хориглоно.
Байгалийн нөөц газар	"Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль"-ийн 21-р зүйлийн 2-т, байгалийн нөөц газарт түүний байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй барилга байгууламж барихыг хориглоно.
Дурсгалт газар	"Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль"-ийн 24-р зүйлийн 2-т, дурсгалт газар дахь байгалийн болон түүх, соёлын дурсгалт зүйлээс 0,1-3,0 км-ийн орчимд сүр бараа, үзэмжийг нь дарах барилга байгууламж барихыг хориглоно. "Соёлын өвийг хамгаалах тухай хууль"-ийн 38-р зүйлийн 1-1-т, түүх, соёлын дурсгалт газар түүний орчны бүсэд дэд бүтцийн барилга байгууламж барих, уул уурхай, газар тариалан эрхлэх, үйлдвэрлэл явуулахыг хориглоно. "Соёлын өвийг хамгаалах тухай хууль"-ийн 43-р зүйлийн 1-6-д, үндэсний болон дэлхийн өвийн дурсгалт газрын хамгаалалтын бүсэд шинээр барилга байгууламж барихыг хориглоно.

Эх сурвалж: "Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль", "Соёлын өвийг хамгаалах тухай хууль"-иас судалгааны баг түүвэрлэн боловсруулав.

Гэвч нэгэн дархан цаазат газар нутгийн хамгаалалтын захиргааны даргаар ажиллаж байсан хүний ярьснаар "Дүрмийг дагаж мөрдөж байгаа эсэхийг хянаж чаддаггүй, жуулчид тусгай хамгаалалттай газар нутгаар чөлөөтэй аялж, хонох боломжтой байдаг, мөн хог хаягдлын асуудал ч үүсэж байгаа" гэж байгаа нь бодит байдал юм. Жуулчдын явах зам, чиглэлийг тогтоосон ч, дархан цаазат газар нутгийн хамгаалалтын захиргааны дарга байсан хүний хэлсэнчлэн жуулчид тухайн газар хараа хяналтгүй чөлөөтэй зорчих, хоноглох боломжтой байгаагаас хогны асуудал шийдэгдэхгүй тул, хяналтын тогтолцоог яаралтай бэхжүүлэх зайлшгүй шаардлагатай юм. Үүний тулд тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын менежментийн ажил үүргийг гэрээгээр орон нутгийн иргэд болон ТББ -уудад даатгах талаар ч анхаарах хэрэгтэй.

Дэд бүтцийн төлөвлөгөөнүүдэд тавигдах нийтлэг шаардлагын хувьд байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх төлөвлөгөө байх тохиолдолд "Байгаль орчныг хамгаалах тухай хууль"-ийн заалтын дагуу байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийх шаардлагатай. Уг хуулийн 9-р зүйлийн 4-т "Нөлөөллийн үнэлгээгээр тогтоогдсон шаардлагыг төсөл хэрэгжүүлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага биелүүлэх үүрэгтэй" гэж заасан байдаг.

Одоо мөрдөгдөж байгаа "Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль"-ийн 11-р зүйлийн 1-6-д "байгалийн аялал, жуулчлалыг тогтоосон зам, чиглэлээр зохих журмын дагуу зохион байгуулах" гэж заасан байгаа бөгөөд аялал жуулчлалын зам, чиглэл (аялж болох газар, ашиглаж болох зам, тээврийн хэрэгсэл)-ийн талаар журамласан байдаг. Нөгөөтэйгүүр, дархан цаазат газар нутгийн онгон бүс, хамгаалалтын бүсийн аль алинд нь аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрдөггүй учраас, аялал жуулчлалын зам, чиглэлийг тогтоогоогүй байгаа. Цаашид бүрэн шинэчлэн найруулахаар төлөвлөж буй "Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль"-ийн нэмэлт өөрчлөлтийн төсөлд дархан цаазат газар нутгийн хамгаалалтын бүсэд ч аялал жуулчлалын үйл ажиллагааг явуулахыг зөвшөөрч байгаа тул, хуулийн нэмэлт өөрчлөлттэй уялдуулаад аялал жуулчлалын зам, чиглэлийг тогтоох шаардлагатай юм.

"Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль"-ийн 30-р зүйлийн 1-6-д хамгаалалтын захиргаа нь аялал жуулчлалын зам, чиглэлийг тэмдэгжүүлнэ гэж заасан байгаа боловч аялал жуулчлалтай холбоотой байгууллагуудын ярьж байгаагаар бодит байдал дээр "зохих ёсоор тэмдэгжүүлээгүй, мөн бороо, салхинд тэмдэг нь харагдахгүй болтлоо муудсан байдаг, шороо тоосонд дарагдан бохирдож, байгалийн үзэмжид сөргөөр нөлөөлдөг" байдалтай байна. Зам, чиглэлийн тэмдгийг зохих ёсоор арчлах талаар өмнөх хэсэгт тайлбарласанчлан, гэрээгээр

нутгийн иргэд болон ТБ -уудад хариуцуулах талаар ч авч үзэх хэрэгтэй.

Түүнчлэн аялал жуулчлалын нөөц баялагтай бүс нутаг нь аялал жуулчлалын үр өгөөжийг тэр болгон хүртэж чаддаггүй нь энэхүү судалгаагаар тодорхой болсон. Байгалийн цогцолборт газарт нэвтрэх хураамжийн орлогыг улсын орлогод тооцогдон Сангийн яаманд төвлөрдөг бөгөөд үүнийг холбогдох салбарт нь эргүүлэн ашигладаггүй. Жишээлбэл Японд тээврийн хэрэгслийн татварын орлогыг зам засварт ашигладаг. Газрын доорх эрдэс баялгийн тухайд, уул уурхай эзэмшдэг компанийн орлогын албан татварын тодорхой хэсгийг уурхай байрладаг орон нутгийн засаг захиргаанд төлдөг тогтолцоог хэдэн жилийн өмнө бүрдүүлсэн. Хэрэв аялал жуулчлалын нөөц баялгийг ч мөн баялаг гэж үзэх юм бол, аялал жуулчлалын зорилгоор энэхүү баялгийг ашиглаад олсон ашгаас татвар авах, улсын орлогын тодорхой хувийг аялал жуулчлал (дэд бүтэц, хүний нөөцийн хөгжил гэх мэт) хөгжүүлэхэд зарцуулах тогтолцоог бүрдүүлж, тухайн баялаг байгаа орон нутгийн засаг захиргаанд хувиарлах замаар орон нутаг үр өгөөж хүртэх тогтолцоог бий болгох талаар бодох ёстой.

Ихэнх жуулчны бааз Улаанбаатарт бүртгэлтэй байдаг тул, бүртгэлийн болон орлогын албан татвараас орон нутаг ашиг хүртэх боломжгүй байдаг гэсэн асуудал нь олон жил дараалан яригдаж ирсэн юм. Аялал жуулчлалын мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагаас харахад, одоогийн байдлаар жуулчны баазуудын тал орчим хувь нь хөдөө орон нутагт бүртгэлтэй болсон бөгөөд бизнес эрхлэгчдийн ухамсарт өөрчлөлт орж байгаа бололтой. Тиймээс, энэ асуудлын тухайд, орон нутгаас гомдол, эсэргүүцэл ирэх нь намжсан гэж байлаа.

(б) Аялал жуулчлалын дэд бүтцийн хөгжүүлэх

Монгол улс дэлхийн бусад оронд байхгүй аялал жуулчлалын арвин их нөөцтэй. Онгон байгаль, түүх, соёл, урлагийн алиныг ч аваад үзсэн гадаад хүний анхаарлыг бүрэн татаж чадах дур булаам аялал жуулчлалын боломж бүхий орон юм. Монгол улсад зочилсон гадаадын жуулчдын дийлэнх нь дахин ирэх хүсэлтэй гэж судалгаагаар гарсан нь үүнийг нотолж байна. Ирсэн жуулчдын 38% нь Монголд өнгөрүүлсэн аялалдаа сэтгэл маш хангалуун, 56% нь хүлээлтээс дээр эсвэл хүсэн хүлээнээс дутахгүй гэж хариулсан байхад зөвхөн 5% нь хүлээлтээс доогуур гэж хариулсан байна. Монгол улс нь дэлхийн олон орны жуулчдын зорих газар бүрэн дүүрэн болж чадах нь эндээс харагдаж байна .

Үүний зэрэгцээ гадаадын жуулчдыг Монголд аялахад тулгардаг олон бэрхшээлийн тухайд чих тавин сонсож, тусган авах шаардлагатай.

- (а) Зам тээвэр, дэд бүтэц хөгжөөгүйгээс болж, аялахад ачаалал ихтэй
- (б) Цэвэрхэн, аюулгүй нийтийн бие засах газар болон халуун ус, шүршүүрийн асуудал
- (с) Хоол, үйлчилгээний чанар тааруу
- (д) Нислэгийн тийз, үйлчилгээний төлбөр үнэтэй
- (е) Аялал жуулчлалын найдвартай мэдээллийг олж авахад хүндрэлтэй

гэх мэт, найрсаг бус олон асуудал одоо ч жуулчдад тулгарсаар байна. Улаанбаатар хот нь "Найрсаг Улаанбаатар" хөтөлбөрийг хэрэгжүүлж байсан бөгөөд түр хугацаанд хэрэгжүүлээд орших бус үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай байна.

1) Нийтийн бие засах газрын асуудал

Гадаадын жуулчдад хамгийн таагүй мэдрэмж төрүүлж, бэрхшээл учруулдаг асуудал бол бие засах газрын олдоц муу явдал юм. Улаанбаатар хотод “Сити тойлет” нэртэй нийтийн бие засах газар 22-23 газар байдаг бөгөөд үүнээс 16 нь байнга ашиглах боломжтой. Улаанбаатар хотод байх тохиолдолд худалдааны төв, шатахуун түгээх станц гэх мэт өөр газрын бие засах газрыг хэрэглэх боломжтой.

Гэвч, хөдөө орон нутагт аялах үед, бие засах газар олддоггүй бөгөөд энэ нь гадаадын иргэдийн тав тухыг хамгийн ихээр алдагдуулж, санааг зовоодог асуудал юм. БОАЖЯ-наас аялал жуулчлалын гол цэгүүдэд хүрэх авто зам дагуу боловсон бие засах газар, халуун усны үйлчилгээ бүхий цогцолбор барихаар төлөвлөж байгаа боловч, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтад

түшиглэж байгаа учир бодит байдал дээр яг хэдэн "замын өртөө" (Мичи но эки) буюу үйлчилгээний цогцолбор баригдах нь тодорхой бус байна.

БОАЖЯ-наас тусгай хамгаалалтай байгалийн цогцолборт газарт байрлах аялал жуулчлалын гол цэгүүдэд нийтийн бие засах газар суурилуулах төслийг хэрэгжүүлж байна. Энэ нь анх АХБ-наас Ядуурлыг бууруулах Япон сангийн санхүүжилтээр Хөвсгөл нуурын ойр орчмын бүс нутагт нийтийн бие засах газар суурилуулж эхэлснээс үүдэлтэй гэж бодож байна. Яамнаас суурилуулж байгаа энэхүү нийтийн бие засах газар нь соруулах болон хуурай аргын гэсэн хоёр төрөлтэй. Японд био жорлон үйлдвэрлэх технологи хөгжүүлсэн туршлагатай бөгөөд ая тухтай, аюулгүй, тогтвортой ажиллуулах гэсэн үзүүлэлтүүдээр Монголын хөдөө орон нутагт тохиормжтой бие засах газрыг сонгож суурилуулвал сайн. Аль хэдийн суурилуулсан бие засах газар нь гадаадын жуулчид хэрэглэхэд тохиромжтой, тав тухтай байгаа эсэхийг газар дээр нь очиж шалгах шаардлагатай байна.

2) Авто замыг сайжруулах

Авто зам ба замын хөдөлгөөний нөхцөл байдал нь дэд бүтэц талаасаа гадаадын жуулчдын тав тухыг алдагдуулдаг хоёр дахь хүндрэлтэй асуудал юм. Улаанбаатар хотын зам нь түгжрэл ихтэй, мөн зөвхөн гол төв замууд л хатуу хучилттай байдаг. Сүүлийн 10 орчим жилд урд хойд, зүүн барууныг холбосон авто замыг хатуу хучилттай болгосноор хот хооронд зорчиход амар хялбар болсон боловч, төв авто замаас салаад аялал жуулчлалын цэгүүдэд хүрэх замын ихэнх нь хатуу хучилтгүй. Авто замын нөхцөл байдал сайжирах нь дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах нь тодорхой. Тухайлбал Улаанбаатар-Сайншанд чиглэлийн авто зам сайжирснаар Хамарын хийдийн аялагчид ихэссэн, мөн Хөвсгөл нуур хүрэх замыг хатуу хучилттай болгосноор Хөвсгөл нуурыг зорих аялагчид ихээр нэмэгдсэн нь үүний нотолгоо юм.

Нөгөөтэйгүүр, аялал жуулчлалын гол нөөц баялгийн ойролцоо замыг нэн яаралтай хатуу хучилттай болгохгүй бол жуулчид дураараа автомашинаар зорчин байгалийн үзэмж, ландшафт сүйтгэгдэх эрсдэлтэй. Энэ байдлаас хэрхэн сэргийлэх вэ гэдэг асуудал тулгарч байна.

3) Харилцаа холбоо, интернэтийн орчныг бүрдүүлэх

Дэд бүтэц талаасаа гадаадын жуулчдад бэрхшээл учруулдаг өөр нэг асуудал бол харилцаа холбоо, интернэтийн орчин нөхцөлийн муу байдал юм. Хэдий бага багаар сайжирч байгаа боловч гар утас сумын төвөөс 8-10 км-ийн зайд л холбогдох боломжтой бөгөөд хөдөө хээр гараад явах тохиолдолд гадаад ертөнцтэй холбоо бүрэн тасардаг. Япон улсаас дөрөв дахин их газар нутагтай мөртлөө ердөө 3.4 сая хүн амтай Монгол улсад долгион дамжуулах станцын тоог нэмэгдүүлэх нь эдийн засгийн хувьд тийм ч амар зүйл биш боловч, жуулчдын сэтгэлийн амар тайван байдал, аюулгүй байдлыг хангах үүднээс гар утсаар холбоо барих боломжтой орчин бүрдүүлэх нь нэн чухал юм. Жуулчид ихээр очдог алдартай аялал жуулчлалын цэгүүдэд харилцаа холбоо тогтоох боломжийг бүрдүүлэхийн тулд тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх шаардлагатай бөгөөд энэ салбар дахь хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд төр засгийн дэмжлэг шаардлагатай. Гар утасны сүлжээний хувьд Gmobile нь хөдөө орон нутагт хэрэглэхэд нэлээд өргөн цар хүрээтэй газар холбоо барих боломжтой гэсэн мэдээлэл байгаа.

(7) Хүрээлэн буй орчин, нийгэмд үзүүлэх нөлөөний асуудал

1) Жуулчдын байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө

Монгол улсад дотоодын аялал жуулчлал сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжиж байна. Эх орныхоо гайхамшигт байгаль, түүх, соёлтой танилцах нь Монголын ард түмний эх оронч үзлийг төлөвшүүлэх үүднээс чухал ач холбогдолтой.

Зуны улирлыг голдуу хөдөө амарч өнгөрүүлдэг Монголчууд сүүлийн жилүүдэд орон нутгаар аялах нь ихэссэн бөгөөд энэ нь дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд ихээхэн түлхэц болж байгаа юм. Монголд дотоодын аялал жуулчлал эрчимтэй хөгжиж байгаа нь статистик тоо баримтаас тод харагдаж байгаа бөгөөд үүнд хатуу хучилттай авто замыг шинээр тавьж, шинэчлэн өргөтгөсөн нь ихээр нөлөөлсөн. Ковид-19 халдварт цар тахлын нөлөөгөөр гадаадын жуулчид ирээгүй 2020 онд Монголын дотоодын жуулчдын тоо төдийлөн буураагүй нь анхаарал татаж байна.

Гэвч дотоодын жуулчдын тооны өсөлт нь аялал жуулчлалын цэгүүдийн жуулчин хүлээж авах даацаас хэтэрч, хог хаягдал ихсэх, байгаль орчин доройтох шалтгаан болж байгааг Хөвсгөл нуурын жишээнээс харж болно. Тэрэлжид үйл ажиллагаа явуулж байгаа жуулчны баазууд хоорондох зайны стандарт дүрмийг үл тоомсорлон дураараа байрласнаас болоод жуулчны баазуудын тойрох орчин, байгалийн үзэмж, ландшафтад муугаар нөлөөлөх болж байна. Цаашид бусад аялал жуулчлалын цэгүүдэд байгаль орчны доройтлоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг цаг алдалгүй авах шаардлагатай. Японд явуулсан асуулга судалгаагаар "Хамгаалах ёстой зүйлээ хамгаалж чаддаг Монгол" байж чадахгүй бол жуулчлах үнэ цэнэ байхгүй гэсэн хариулт байсанд анхаарах нь зүйтэй.

Ерөнхийдөө энэ удаагийн судалгаагаар гадаадын жуулчид байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байгаа тухай бодит жишээ олдсонгүй. Гадаадын жуулчид, ялангуяа багц аяллаар ирсэн жуулчид өндөр ёс суртахуунтай байдаг бөгөөд дотоодын жуулчид шиг машиныхаа цонхоор хогоо хаях, хог хаягдлаа буусан газраа орхиод явах тохиолдол нэн ховор байдаг бололтой. Дотоодын жуулчдад байгаль хамгаалах ёс зүйг сурталчилж, ухамсрыг нь дээшлүүлбэл байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах боломжтой гэж найдаж байна.

- 2) Аялал жуулчлалын бүс нутагт зам өргөтгөх, машины зогсоол барих, нийтийн бие засах газар байрлуулах

Хатуу хучилттай авто замыг өргөтгөснөөр, зорчигчдын хөдөлгөөнийг хөнгөвчилж, аялал жуулчлалын салбарын хөгжлийн хөшүүрэг нэмэгдэнэ. Энэ жишээг Хөвсгөл нуур, Дорноговийн Хамарын хийдийн жуулчдын тоо эрс нэмэгдэж байгаагаас харж болно. Гэвч Хөвсгөл нуурыг зорих жуулчдын тоо даацаас хэтэрч, авто зам болон нийтийн бие засах газар ашиглах боломжгүй болсноос гадна, ил задгай хаясан хог хаягдал нь байгаль орчинд сөрөг нөлөө учруулж болзошгүй болсон. Хөвсгөлд АХБ-ны дэмжлэг тусалцаа амжилттай хэрэгжиж байгаа юм. Энэ удаагийн судалгааны зорилтот бүс нутагт ч Хөвсгөл нууртай ижил төстэй асуудал гарах магадлалтай байгааг анхаарах хэрэгтэй. Одоогийн байдлаар судалгааны зорилтот бүс нутгийн аль ч хэсэгт байгаль орчинд нөлөөлөхүйц хэмжээний хүний бөөгнөрөл, ачаалал үүсээгүй боловч байгаль орчин, аялал жуулчлалын нөөцийг хамгаалах үүднээс аялал жуулчлалын нэртэй цэгүүдэд авто замыг өргөтгөх, машины зогсоол байгуулах, нийтийн бие засах газар байрлуулах ажлыг яаралтай хийх шаардлагатай байна.

- 3) Жуулчны баазын тухай хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм журмыг чанд мөрдөж, хог хаягдлыг ялгаж, ангилж байхыг үүрэг болгох

Аялал жуулчлалын нэрт газруудыг үзэхээс гадна Монголчууд майхантай аялах дуртай тул, аялагчид дураараа энд тэнд майхнаа босгохоос сэргийлэх үүднээс, майхантай аялагчдыг нэг газар цуглуулж байрлуулах цэвэр ус, бие засах газар зэргээр үйлчилдэг отоглох газрыг улс болон орон нутгаас нэмж байрлуулах шаардлагатай хэмээн үзэж байна. Ихэнх жуулчны бааз хогоо ялгалгүй, тэр хэвээр нь хог хаях цэгүүдэд аваачаад, газарт булдаг. Энэ байдлаас татгалзаж, дор хаяад лааз, хуванцар хог хаягдал гэх мэт дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг ялгаж, ангилахыг үүрэг болгох хэрэгтэй. Тэрэлжид жуулчны бааз хоорондын зайн стандарт огт мөрдөгдөөгүйгээс, жуулчны баазын тоо стандартаас аль хэдийн хэтэрсэн байдалтай байна. Иймээс, цаашид хууль дүрэм зөрчиж жуулчны бааз барихгүй байхаар хяналтыг чангатах шаардлагатай юм.

- 4) Бохир усны асуудал

Судалгааны зорилтот бүс нутагт бохир ус, шингэн хаягдлыг жуулчны баазын хэмжээнээс хамааран урсгаж газарт шингээх, цэвэршүүлэх, татан зайлуулах гэсэн өөр өөр аргуудаар боловсруулж байна. Жижиг жуулчны баазууд нь бохир ус, шингэн хаягдлыг цэвэршүүлэх, татан зайлуулах зардлыг хэмнэх үүднээс ихэвчлэн байгальд урсгаж газарт шингээж байна. "Жуулчин говь" зэрэг томоохон жуулчны бааз нь татсан бохир усаа төлбөртэй цэвэршүүлэх байгууламж руу тогтмол зөөдөг байна. Харин шинээр байгуулагдсан жуулчны баазууд цэвэршүүлэх технологийг өргөнөөр хэрэглэж байна. Тэдгээрийн дотор тунгаагч сав буюу септик танк гэх технологи байгаа боловч газар дээр нь очиж үзэх боломжгүй байсан тул ашиглалтын бодит үр нөлөө нь тодорхойгүй. Тэсгим хүйтэнд Монголд ашиглаж болох цэвэршүүлэх танкийг харьцангуй хямд үнээр худалдаж авах боломжтой бол зөвхөн жуулчны бааз төдийгүй Улаанбаатар хотын 1.4 сая хүн амын тал хувь

нь амьдардаг гэр хороололд ч дэлгэрүүлэх хэрэгтэй гэж бодогдоно. Орон нутгийн суурин газрын иргэдэд зориулсан цэвэршүүлэх байгууламжийг АХБ болон бусад байгууллагын санхүүгийн дэмжлэгтэйгээр Өмнөговь аймгийн Даланзадгад хот, Дорноговь аймгийн Сайншанд хотод барьж байна.

5) Хог хаягдлын асуудал

Байгаль орчинд хамгийн их сөрөг нөлөө үзүүлж буй хог хаягдлын тухайд, Улаанбаатар хотод болон Өмнөговь аймгийн Даланзадгад хотод ялгаж хаядаг болохыг тодруулсан. Даланзадгад хотод дахин боловсруулж ашиглах боломжтой хог хаягдал, тухайлбал ундааны хуванцар савыг шахаж жижиглэн, 10 тонн болтол хуримтлуулж байгаад 500 км хол зайд орших Улаанбаатар хот руу автомашинаар зөөдөг. Орон нутгийн жуулчны баазуудын хувьд хог ачдаг машинууд тогтсон өдөрт ирж ачаад сумын хог хаягдал цуглуулах цэгт хаядаг. Зарим жуулчны бааз нь өөрийн эзэмшил газартаа тусгай цэг гаргаад, хогоо хаяж байна. Аль аль нь хогийг ялгаж, ангилахгүй байгаа бөгөөд сумын хогийн цэг нь зүгээр л тэгш тал дээр томоохон нүх ухаад хогоо хийж орхидог тул хүчтэй салхитай өдрүүдэд хог хийсэж ойр орчимд тархах, зэрлэг ан амьтад идэж бусниулах зэргээр байгаль орчинд халтай байдалтай байгаа юм. Жуулчны баазаас эхлээд хог хаягдлыг сайтар ялгаж, ангилдаг болох, тэр талаар заавар, зөвлөгөө өгөх шаардлагатай юм. Нөгөөтэйгүүр, ялгасан байгаа дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг хэрхэн цуглуулах нь зардал талаасаа хүндрэлтэй асуудал болж байгаа юм.

(8) Хүний нөөцийг хөгжүүлэх

1) Аялал жуулчлалын салбарын ажилтнуудын имижийг сайжруулах

Монголд аялал жуулчлалын салбарын ажилтан нь мэргэжлийн ажилтан бус, улирлын чанартай ажилчин гэсэн имижтэй байдаг бөгөөд аялал жуулчлалын ажил нь хэн ч хийж чадах ажил гэсэн ойлголт байдаг. Аялал жуулчлал бол маш нарийн, мэргэшсэн ажил мэргэжил гэдгийг хэрхэн яаж сурталчилж таниулах вэ гэдэг нь шийдвэр шаардсан чухал асуудал болж байна.

2) Мэргэжлийн боловсролын тогтолцоог бүрдүүлэх

Дээр дурдсанчлан аялал жуулчлалын салбарын мэргэжилтэн бэлтгэх шаардлагатай бөгөөд дараах байдлаар мэргэжлийн боловсролын тогтолцоог хөгжүүлэх шаардлагатай.

- (a) Их, дээд сургууль, мэргэжлийн боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөр, багшийг чанаржуулах
- (b) Тогооч, бармен зэрэг мэргэжлийн ажилтнуудын ур чадварыг сайжруулах
- (c) Хоноглох, отоглох газар, зоогийн газрын ажилтнуудын ур чадварыг сайжруулах

БОАЖЯ болон Олон улсын байгууллагууд аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-тай хамтран, тус тусын үйлчилгээний ажилчдад зориулж төрөл бүрийн сургалт явуулж байгаа боловч Монголд ажлаа солих хүн их байдаг учраас боловсон хүчнийг тогтворжуулах нь бас нэг чухал асуудал болж байна.

Үйлчилгээний чанарын хувьд хүнтэй харьцдаг үйлчилгээнээс гадна, бусад улс оронд энгийн хэрэглээний зүйл болсон ойр зуурын хэрэгцээт эд юмсаар хангах үйлчилгээ дутмаг байдаг талаар онцолж байна. Жишээлбэл, жуулчны баазуудад алчуур, халуун ус, толь, цахилгаанаар цэнэглэх цэг гэх мэт ойр зуурын хэрэгцээний эд юмс дутмаг байх нь жуулчдын тав тухыг алдагдуулдаг тал бий. Үйлчлүүлэгчдээ хэрхэн хүлээж авах талаарх үндсэн ойлголтыг Японы групп жуулчдыг хүлээн авдаг жуулчны баазуудад юун түрүүнд олгох шаардлагатай гэж бодож байна.

Мөн тогооч нарын ур чадварыг дээшлүүлэх шаардлагатай байна. Монголд байдаг хүнсний бүтээгдэхүүнийг ашиглан шинэ төрлийн хоол хүнс хөгжүүлэхийн тулд жуулчны баазуудын тогооч нарын дунд улсын хэмжээний томоохон уралдаан тэмцээнийг БОАЖЯ-ны нэр дор зохион байгуулах зэрэг нь ур чадварыг хөгжүүлэх хөшүүрэг, урамшуулал болох юм. Одоогийн байдлаар БОАЖЯ хөдөө орон нутагт аялал жуулчлалын чиглэлээр үйлчилгээ эрхэлж буй хүмүүст сургалт явуулж үнэмлэх олгож байгаа нь их үр дүнтэй бөгөөд БНСУ-ын засгийн газрын дэмжлэгээр баригдсан сургалтын төв үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн нь аялал жуулчлалын салбар дахь

хүний нөөцийн хөгжилд урагштай алхам болж байгаа юм. БОАЖЯ-наас зохион байгуулдаг сургалтаар аялал жуулчлалын салбарт бодитоор ажиллаж байгаа хүмүүсийн чанарыг сайжруулахад анхаарч, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх үүднээс, цаашид багшийн ур чадвар болон лекцийн агуулгыг сайжруулах талаар бодох хэрэгтэй.

3) Аялал жуулчлалтай холбоотой "үйлчилгээний чанар" муу

Энэ удаагийн судалгаагаар аялал жуулчлалын бизнес эрхлэгчтэй холбоотой чухал асуудлаар "үйлчилгээний чанар" дурдагдлаа. Нэмүү өртгийг нэмэгдүүлэхийн тулд үйлчилгээний чанарыг дээшлүүлэх зайлшгүй шаардлагатай бөгөөд дараах зүйлсийг сайжруулах шаардлагатай.

- (a) Нэгдүгээрт, гадаад хэлний мэдлэгийн асуудал. Аялал жуулчлалын салбарын ажилчидтай ойлголцоход хүндрэлтэй, мөн музей, уран зургийн галерейд гадаад хэл дээр тайлбар байдаггүй гэх мэт.
- (b) Хоёрдугаарт, зочид буудал, жуулчны бааз зэрэг хоноглох, буудаллах газар, зоогийн газар, дэлгүүр болон бусад үйлчилгээний газрын ажилчдын харилцаа, хандлага муу байдаг.
- (c) Гуравдугаарт, таксины үйлчилгээний чанарын асуудал. Зөвшөөрөлгүй хувийн такси их байдаг тул гадаад хэлний мэдлэггүй, жуулчидтай хэл нэвтрэлцэхгүй байхаас гадна, үнэ ханш нь тодорхой бус байдаг зэрэг асуудлыг олон хүн онцолж байна.
- (d) Дөрөвдүгээрт, хоолны чанарын асуудал юм. Хоолны чанар нь жуулчдын сэтгэл ханамжид ихээхэн нөлөөлдөг. Гадаадын жуулчдын сонирхолд нийцсэн хоолыг хэрхэн яаж хангах вэ гэдэг асуудал тулгарч байна.

4) Үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахын тулд хамтран ажиллах

Аялал жуулчлал нь үйлчилгээний салбар тул мэргэжлийн ур чадвартай боловсон хүчнээс гадна, үйлчилгээ үзүүлэх тогтолцоо шаардлагатай. Орчин үеийн аялал жуулчлалын салбарын үйл ажиллагааг дан ганц хүний ур чадвараар явуулах боломжгүй юм. Аялал жуулчлалын мэдээлэл танилцуулга, зочид буудал, зоогийн газар гэх мэтийн холбогдох бүх газарууд өндөр түвшинд зохион байгуулагдсан тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай. Монголд аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг хөгжүүлэхэд үйлчилгээний салбар нийтээрээ хамтран ажиллах нь чухал юм.

5) Бэлэг дурсгалын бүтээгдэхүүн хөгжүүлэх

Азийн жуулчид бэлэг дурсгалын зүйл ихээр худалдаж авах хандлагатай байдаг. Санал асуулгад оролцсон олон хүн Монголд худалдаж авах бэлэг дурсгалын зүйл байдаггүй гэж хариулжээ. Худалдан авахыг хүссэн боловч авах зүйл байхгүй байгаа нь Монгол улсын эдийн засгийн хувьд маш том боломжийг алдаж байгаа гэсэн үг юм. Бэлэг дурсгалын зүйл үйлдвэрлэх нь Монгол улсын хувьд тулгамдаж буй асуудлуудын нэг. Бэлэг дурсгалын бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүмүүсийг сургахын зэрэгцээ бүтээгдэхүүн хөгжүүлэх ерөнхий чадавхийг бэхжүүлэх шаардлагатай юм.

б) Монгол улсын иргэдэд байгаль орчны болон ёс зүйн боловсрол олгох

Сүүлийн үед дотоодын аялал жуулчлал эрс нэмэгдсэнтэй уялдан хог хаях, хээр гадаа бие засах зэрэг олон асуудал үүсэж байна. Жуулчдын тоо огцом өссөнөөс болоод тухайн газрын хүлээж авах хүчин чадал хүрэлцэхгүй байгаа гэсэн дэд бүтцийн асуудлаас гадна, дотоодын жуулчдын зүй ёсгүй үйлдэл мөн тулгамдсан асуудал болж байгаа юм. Чингис хааны үеэс уламжлагдаж ирсэн байгалийг хайрлан хамгаалж, бохирдуулдаггүй байсан Монгол ёс нь өнөөгийн байгаль орчин хамгааллын үндсэн зарчим болох бөгөөд энэ санааг түгээн дэлгэрүүлэхийн тулд ерөнхий боловсролоор байгаль орчин, ёс зүйн боловсрол олгох нь үр дүнтэй. Хэдийгээр бүх хүн зочид буудлын ажилтан, аяллын хөтөч болж гадаадын жуулчидтай шууд харилцахгүй боловч нийт иргэдэд байгаль орчин, ёс зүйн боловсрол олгох хэрэгцээ шаардлага өндөр байна.

(9) Аялал жуулчлалын маркетинг, сурталчилгаа

Аялал жуулчлалын маркетинг, сурталчилгаанд ① боловсон хүчин, төсвийн хомсдол, ② маркетинг, сурталчилгааны стратеги байхгүй гэсэн 2 том тулгамдсан асуудал байгаа болно.

1) Боловсон хүчин, төсвийн хомсдол

БОАЖЯ-ны Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газрын 7-8 ажилтан аялал жуулчлалын асуудлыг бүхэлд нь хариуцаж ажилладаг. Эдгээр цөөн тооны ажилтнууд нь аялал жуулчлалын бодлого боловсруулах, хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, хөгжлийн төлөвлөгөөг зохиох, гадаад харилцаа, гадаад зах зээл дэх зар сурталчилгааг хэрэгжүүлэх гэх мэт бүх л ажлыг хариуцдаг бөгөөд ажлын ачаалал нь өндөр. Аялал жуулчлалын контент боловсруулалт, Олон улсын аялал жуулчлалын экспо-үзэсгэлэнд оролцох зэрэг ажлыг БОАЖЯ-ны ганц ажилтан л хариуцан ажилладаг. БОАЖЯ-ны харьяанд 2017 онд байгуулагдсан Аялал жуулчлалын хөгжлийн төвийн үйл ажиллагаа нь хараахан тогтворжоогүй байгаа боловч цаашид маркетинг, сурталчилгаа, эвент, арга хэмжээ зэргийг удирдан зохион байгуулж, хэрэгжүүлэх үүрэг бүхий төв болгон хөгжүүлж, яам нь бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаагаа голчлон хариуцдаг болохыг зориж байна. 2-р бүлэгт дурдсанчлан Улаанбаатар хотоос бусад бүс нутагт аялал жуулчлал хариуцсан 1-3 хүн л байдаг бөгөөд аялал жуулчлалаас гадна байгаль орчин болон бусад олон ажил үүрэг хариуцдаг. Боловсон хүчин асар их дутмаг байгаа нь эндээс харагдаж байна.

Төсөвийн хувьд доорх хүснэгтэд үзүүлсэнчлэн маш хязгаарлагдмал байдаг.

Хүснэгт 4-2: Бүс нутаг тус бүрийн маркетинг, сурталчилгаатай холбоотой үйл ажиллагааны төсвийн байдал

Бүс нутаг	Маркетинг, сурталчилгаатай холбоотой үйл ажиллагааны төсвийн байдал
Улсын хэмжээнд	БОАЖЯ 2020 оны төсөв 3.2 тэрбум төгрөг (ойролцоогоор 128 сая иен). Үүний 30% (ойролцоогоор 38.4 сая иен) нь маркетинг, сурталчилгааны төсөв. 2021 оны төсөв 3.9 тэрбум төгрөг (ойролцоогоор 156 сая иен). Үүний 32% (ойролцоогоор 49.92 сая иен) нь маркетинг, сурталчилгааны төсөв .
Дорноговийн маршрут	Дорноговь аймгийн аялал жуулчлалын маркетинг, сурталчилгааны төсөв нь 2019 онд 3 сая төгрөг (120,000 орчим иен), 2020 онд 10 сая төгрөг (ойролцоогоор 400,000 иен), 2021 онд 4 сая төгрөг (160,000 орчим иен) байна.
Хархорины маршрут	Өвөрхангай аймгийн маркетинг, сурталчилгааны төсөв нь 2019 онд 71 сая төгрөг (ойролцоогоор 2.84 сая иен), 2020 онд 9 сая төгрөг (360,000 орчим иен), 2021 онд 69.9 сая төгрөг (2.8 сая орчим иен) байна. Архангай аймгийн маркетинг, сурталчилгааны төсөв 2019 онд 50 сая төгрөг (ойролцоогоор 2 сая иен), 2020 онд 216 сая төгрөг (ойролцоогоор 8.64 сая иен), 2021 онд 21 сая төгрөг (ойролцоогоор 840.000 иен) байна.
Улаанбаатар хот орчим	Улаанбаатар хотын аялал жуулчлалын маркетинг, сурталчилгааны төсөв 2019 онд 286 сая төгрөг (ойролцоогоор 11.44 сая иен) байсан. Аялал жуулчлалын газар нь төсвөө нэмэгдүүлэх хүсэлтийг Санхүүгийнхээ хэлтэст жил бүр тавьдаг боловч зөвшөөрдөггүй байна. Түүнчлэн Аялал жуулчлалын маркетингийн арга хэмжээний төсвийг албан ёсоор баталсан байсан ч хотын захиргааны өндөр албан тушаалтнууд оролцож, баталсан төсвийг бусад нэн тэргүүнд тавигдах төслүүдэд шилжүүлэх тохиолдол байдаг аж. Аялал жуулчлалын мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар аялал жуулчлалын мастер төлөвлөгөө байхгүй учраас аялал жуулчлалын газар зориулалтын төсвийг тогтмол шаардаж авч чадахгүй байгаа шалтгаан байх магадлалтай юм. Төв аймагт маркетинг, сурталчилгааны төсөв хуваарилагдаагүй.

Эх сурвалж: Бүс нутгийн аялал жуулчлалын мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагад үндэслэн судалгааны баг боловсруулав.

2) Маркетинг, сурталчилгааны стратеги байдаггүй

Энэхүү судалгааны зорилтот бүх бүс нутагт маркетинг, сурталчилгааны стратеги хараахан боловсруулагдаагүй байна. Улсын түвшинд үндсэн стратегийг тодорхойлоогүй улмаас бодит байдал дээр хувийн аялал жуулчлалын компаниуд тус тусдаа сурталчилгааг хийж байгаа юм. Иймд Монгол Улсын аж үйлдвэрийг төрөлжүүлэхийн тулд, юуны түрүүнд аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх стратегийг Засгийн газар хэлэлцэн тогтоож, хувийн хэвшлийнхнийг дэмжих нь зүйтэй.

(а) Зорилтыг тодорхойлох

Стратегийн зорилтуудын тухайд Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд "жуулчдын тоог нэг саяд хүргэнэ", "аялал жуулчлалын салбарын хөгжлийн түвшнийг Монголд зочилсон жуулчдын тоогоор хэмжинэ" хэмээн заасан байгаа боловч энэхүү зорилтын биелэлтийн хэмжүүрийг цаашид жуулчдын зарцуулсан мөнгөний хэмжээгээр тооцоолох ёстой. "2.8 Гадаадын жуулчдын чиг хандлага"-д жуулчдын Монголд хийх аяллын чиг хандлагад дүн шинжилгээ хийсэн бөгөөд жуулчдын үндэс угсаа, зорилго, сонирхол зэргээс нь шалтгаалж Монголд саатах хугацаа, аялалд зарцуулах мөнгөний хэмжээ харилцан адилгүй байна. Зуны улиралд жуулчдын ачаалал маш ихэсдэг ба хоноглох, отоглох газрууд дүүрэх тохиолдол их байдаг бөгөөд хүн ам цөөтэй Монгол улсын хувьд аялал жуулчлалын салбарын ажилчдын тоо цөөн, хог хаягдал, бохир ус цэвэрлэх чадвар тааруу гэсэн нөхцөл байдлыг харгалзахад зөвхөн жуулчдын тоог нэмэгдүүлэхэд анхаарах нь байгаль орчныг хамгаалах, цаашлаад тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэхэд учир дутагдалтай юм. Нэн тэргүүний зорилтыг нэг жуулчны зарцуулсан мөнгөний хэмжээгээр тодорхойлж, зорилтог бүлэг тус бүр, улирал тус бүрийн зорилтыг "жуулчны тоо × нэг хүний зарцуулсан мөнгөний хэмжээ" гэж тодорхойлох нь зүйтэй. ЖАЙКА-ийн аялал жуулчлалыг хөгжүүлэх хамтын ажиллагааг дэмжих бодлогод мөн "хүний тоо"-ноос "зарцуулсан мөнгөний хэмжээ" рүү шилжихийг уриалж, жуулчдын тоог нэмэгдүүлэх бус нэг хүнд ногдох аялал жуулчлалын хэрэглээний хэмжээг нэмэгдүүлэх аялал жуулчлалын хөгжлийг дэмжиж байна.

(b) Маркетинг, сурталчилгааны бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэх, сайжруулах тогтолцоо

Зорилтыг тодорхойлохоос эхлээд бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэх хүртэлх үйл явцад улс орон, бүс нутгийн хэмжээнд төдийгүй аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгч компани, байгууллага хүртэл (аялал жуулчлалын байгууламж, хоноглох, отоглох газар, аялал жуулчлалын компани гэх мэт) хамаарах юм. Гагцхүү тулгамдаж буй асуудал, бодлогын агуулга нь үйл ажиллагаа эрхлэгчдийн зорилго, чиглэл, цар хүрээнд хамаараад үл ялиг өөр байна. Орчин үеийн маркетинг, сурталчилгаанд МХХТ (ICT) нь чухал үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд энэ хандлага цаашид ч үргэлжлэх төлөвтэй байгаа юм. Гэтэл Монголын аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжийн ихэнх нь үйл ажиллагааны цар хүрээ, хүний нөөц багатай жижиг аж ахуйн нэгж. Тэр утгаараа эрчимтэй хөгжиж буй МХХТ-ийн салбарын мэргэжилтнийг эдгээр аж ахуйн нэгжид тогтмол ажиллуулна гэдэг нь бодит байдал дээр бараг боломжгүй зүйл. Тиймээс DMO⁵⁶ гэх мэтийн бүс нутгийн аялал жуулчлалын байгууллагуудад МХХТ-ийн мэргэжилтэн цөөн хэдэн хүнийг сурган ажиллуулж, эдгээр мэргэжилтнүүд аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгчдийн МХХТ-ийг хөгжүүлэх, дэмжихэд зангилаа төв болон ажиллах нь хамгийн тохиромжтой юм. Хүн ам цөөн, санхүүгийн эх үүсвэр дутмаг, орон нутаг боловсон хүчний хомсдолтой өнөөгийн нөхцөл байдалд ямархуу байдлаар ажиллавал илүү үр дүнтэй, өгөөжтэй байх талаар нухацтай хэлэлцэж үзэх шаардлагатай.

3) Монгол Улсын аялал жуулчлалын зах зээлд тулгарч буй асуудал

(а) Үнийн өрсөлдөх чадварын асуудал

Японы аялал жуулчлалын компаниудын дунд явуулсан санал асуулгын судалгаагаар Япон руу нислэгийг ганцхан МИАТ компани үйлддэг ба энэхүү монополь байдлаас үүдэн нислэгийн тийзийн үнэ өндөр байдгаас аяллын өртөг өндөр болдог нь Монгол улсад аялах төлөвлөгөө гаргахад бэрхшээлтэй байдаг гэж онцолсон байв. Энэ талаар тухайн үед БОАЖЯ-ны газрын дарга асан С.Баясгалангийн илтгэлд, Ерөнхий сайдын санаачилгаар зохион байгуулагдсан аялал жуулчлалын салбарын төлөөлөлтэй хийсэн уулзалтаар ч дурдагдсан бөгөөд нислэгийн тийзийн үнэ өндөр байгааг Монголын засгийн газар ойлгож байгаа юм. "Чингис хаан" Олон улсын нисэх онгоцны буудал ашиглалтад орсноор хуучин нисэх онгоцны буудалтай харьцуулахад хүчин чадал нь сайжрах тул нислэгийн тоо нэмэгдэж, тийзийн үнэ хямдарна хэмээн найдаж байна.

⁵⁶ Destination Management Organization (Аялал жуулчлалын бүс нутаг хөгжүүлэх маркетинг/менежментийн байгууллага)

(b) Аялал жуулчлалын талаарх мэдээлэл түгээлт дутмаг

Монгол улсад зочилж буй гадаадын жуулчдын дунд явуулсан санал асуулгын дүнгээс харахад Монголд очихоос өмнө Монголын талаарх мэдээлэл цуглуулахад их хүндрэлтэй байсан гэж хариулсан байна. Мөн энэ удаагийн Японы аялал жуулчлалын компаниудын дунд явуулсан санал асуулгын судалгаагаар Монголын талаарх мэдээлэл хомс байдаг нь хамгийн их хүндрэлтэй байдгийг нотолсон. Өөрөөр хэлбэл, Монголын аялал жуулчлалын асуудал хариуцсан байгууллагууд хангалттай, үнэн бодит мэдээлэл түгээж чадахгүй байна гэдгийг харуулж байгаа юм.

Аялал жуулчлалын талаарх мэдээллийг ихэвчлэн аялал жуулчлалын агентлагууд болон интернэтээс авдаг. Монгол улсын хувьд аялал жуулчлалын асуудал хариуцдаг төрийн байгууллагаас түгээдэг мэдээлэл бараг байдаггүй. БОАЖЯ-ны Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газар, яамны харьяа Аялал жуулчлалын хөгжлийн төв, Улаанбаатар хотын аялал жуулчлалын газар, мөн энэхүү судалгааны зорилтот бүс нутаг болох аймгуудын веб сайт руу орж Монголын аялал жуулчлалын талаарх англи хэл дээрх мэдээллийг хайсан боловч олдоогүй, цаашлаад монгол хэл дээрх мэдээлэл ч цөөхөн байв. Монголын аялал жуулчлалын тухай англи хэл дээр гарсан мэдээллийн ихэнх нь аялал жуулчлалын компаниудын түгээсэн мэдээлэл байдаг ба хэр найдвартай эсэх нь тодорхойгүй.

Монголд олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, ялангуяа Фэйсбүүк нь мэдээлэл түгээх, цуглуулах түгээмэл хэрэгсэл болж төр засгийн байгууллагууд ч өөрсдийн үйл ажиллагааны тухай мэдээллийг фэйсбүүкт тавьдаг. Гэвч Фэйсбүүкээр түгээх мэдээлэл нь аялах хүсэлтэй гадаадын жуулчны мэдээллийг системтэйгээр олж авах хэрэгцээг хангаж чадахгүй байгаа юм. Монголын аялал жуулчлалын талаарх мэдээллийг түгээдэг #feelMongolia гэж хаштаг байдаг боловч төдийлөн хүртээмжтэй биш бөгөөд олон нийтэд сайн танигдаагүй. Мэдээлэл нь системчлэгдээгүй, тогтмол бус тул аялал жуулчлалын талаар хангалттай мэдээлэл өгч, сурталчилж чадаж байгаа эсэх нь эргэлзээтэй байгаа юм.

Өнөөгийн нөхцөл байдлыг сайжруулахын тулд аялал жуулчлалын талаарх мэдээлэл түгээх бусад улс орнуудын аргаас суралцах нь үр дүнтэй байх болно. Японд Visit Japan аяны хүрээнд байгуулагдсан Японы Аялал жуулчлалын агентлаг нь зөвхөн веб сайт дээрээ гэхэд л 26 хэл дээр Японы аялал жуулчлалын цэгүүдийг танилцуулсан байдаг ба давхар Фэйсбүүк, Инстаграм зэрэг нийгмийн сүлжээ болон YouTube суваг ашиглан мэдээлэл түгээдэг.

Хонконгийн Аялал Жуулчлалын Ерөнхий Газрын веб сайт нь англи хэлнээс гадна 12 хэл дээр "харах", "сонсох", "идэх", "үнэрлэх", "хүрэх" гэсэн сэдвээр олон зураг, тайлбар тавьсан байдаг. Мөн нийгмийн сүлжээний Фэйсбүүк, Инстаграм, Твиттер, YouTube, Weibo, блог гэх мэт олон хуудастай. Камбож, Лаос зэрэг Азийн бусад орнууд ч мөн адилаар жуулчдыг татахын тулд ихээхэн хүчин чармайлт гаргаж байна.

Ихэнх гадаадын жуулчид интернэтээс мэдээлэл авдаг тул Монголд хамгийн ихээр зочилдог улс орнуудын хэлээр, эсвэл дор хаяж англи хэл дээр Монгол орны байгаль, түүх, соёл, аялал жуулчлалын газруудын тухай мэдээллийг төр засгийн байгууллага түгээх шаардлагатай. Гадаад хэл дээр мэдээлэл түгээж чадахгүй байгаагийн шалтгаан нь гадаад хэлээр ярьж бичиж чадахгүй байгаадаа биш, мөн ур чадвар байхгүйдээ ч биш, санхүүгийн эх үүсвэр, боловсон хүчний хомсдолд байгаа юм.

(10) Өвлийн аялал жуулчлалд тулгарч буй асуудал

Монголд ирдэг жуулчдын 70% нь 4-р сараас 10-р сарын хооронд жуулчилдаг. Ялангуяа жуулчлалын багц аяллууд нь 6-р сараас 8-р сар хүртэлх хоёр сарын хооронд төвлөрдөг. Зуны улиралд түр цагийн ажилд оюутнуудыг голдуу авч ажиллуулдаг. Тиймээс нийт ажилчдын тал хувийг эзэлдэг үндсэн ажилчид өвлийн сул зогсолтын нөлөөнд өртдөг. Өвлийн арга хэмжээ зохион байгуулах нь аялал жуулчлалын салбарын ашиг орлогыг жигдлэхэд чухал ач холбогдолтой болохыг Монголд ойлгож байна. Нэгэн сайн дурын байгууллага санал асуулга явуулж судалгаа хийсэн бөгөөд Монгол орны онцлог шинж чанартай, өрсөлдөх чадвартай гэж тооцогдохоор төслийн санал гаргахад амаргүй байна. Гэхдээ өвлийн аялал жуулчлалын талаар яригдаж, хэлэлцэгдэж эхэлсэн нь сайшаалтай хэрэг юм.

Улаанбаатар хотын аялал жуулчлалын байгууламжууд нь жилийн турш нээлттэй байдаг боловч Монголд ирэх жуулчдын тоо цөөрөхөөр эдгээр байгууламжаар үйлүүлэгчдийн тоо цөөрдөг нь тулгамдсан асуудал болоод байгаа билээ. Өвлийн улиралд хэрэгжүүлж болох "MICE" буюу ажил хэргийн аялал жуулчлалыг зохион байгуулах шаардлагатай байна. Мөн өвлийн арга хэмжээ нь бүс нутаг тус бүрээр өөр өөрийн онцлогтой байгаа боловч, тэмээний баяр, мөсний баяр гэх мэт ихэнх нь хоорондоо адил агуулгатай, өөр хооронд нь ялгахад хүндрэлтэй байгаа юм. Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар гадаад дотоодгүй хэлэлцүүлэг өрнүүлэн санал, санааг цуглуулж, төсөл болж хэрэгжихүйц саналыг урамшуулах, Монголд урих гэх мэт шинэ санаа, хөтөлбөрийг аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газар төлөвлөж, хэрэгжүүлж болох юм.

(11) Шинэ музей байгуулах, хөгжүүлэх стратеги, төлөвлөлтийн дутмаг байдал

1) Тараан байрлуулсан урлаг соёлын болон палеонтологийн үзмэрүүд

17-р зуунаас 18-р зууны эхэн үед нэр алдраа дуурсгасан Өндөр гэгээн Занабазарын урласан бурхад зэрэг дэлхийд бахархаж болох олон бүтээл музейд байдаг боловч хэд хэдэн музейд тарааж байрлуулсан байдгаас болоод гол нэртэй бүтээлүүдийг үзэхийн тулд Улаанбаатарын гурван ч газраар очих шаардлагатай нь их төвөг учруулдаг. Ямарваа нэгэн учир шалтгаан байгааг ойлгож байгаа боловч, зөвхөн Занабазарын бүтээлүүдээр сэдэвлэн төвлөрүүлсэн "Занабазарын музей"-г байгуулбал гадаадын жуулчид төдийгүй Монголын ард түмэн ч түүний агуу их авьяас билгийг мэдэж авах боломжтой болно.

"Үлэг гүрвэлийн музей" нь АНУ-д хууль бусаар экспортлогдсон үлэг гүрвэлийн олдворыг нийтэд таниулах гэсэн, нэг талаасаа улс төрийн зорилгоор 2013 онд байгуулагдсан. Монгол орон нь үлэг гүрвэлийн өлгий нутаг хэмээгддэг бөгөөд үнэ цэнэтэй үлэг гүрвэлийн олдвор олноор олдсон байдаг. Үлэг гүрвэлийн асуудал хариуцсан байгууллагуудын хувьд Шинжлэх Ухааны Академийн Палеонтологийн хүрээлэн, их дээд сургууль зэрэг хэд хэд байдаг бөгөөд Монгол улсын хувьд нэгдсэн байдлаар үлэг гүрвэлийн олдворыг хамгаалах, судлах тогтолцоо бүрдэж чадаагүй байна. Дэлхийд бахархаж болохуйц үнэт үлэг гүрвэлийн чулуужсан араг ясны нөөцтэй байгаа нь Монголын ард түмний хувьд бахархууштай зүйл бөгөөд үүнийг аялал жуулчлалын нөөц болгон бололцооныхоо хэрээр ашиглах хэрэгтэй юм. Улаанбаатарт шинэ хэлбэрийн аялал жуулчлалын үзмэрийн газар шаардагдаж байна. Шинэ аялал жуулчлалын байгууламж байгуулахаас илүүтэйгээр бусад оронд байдаггүй соёлын үнэт өвөө хамгаалж, олон нийтэд сурталчлах, судлах, цаашлаад Монгол үндэстний бахархлыг бэхжүүлэхэд ач холбогдолтой аялал жуулчлалын байгууламжийг бүтээн байгуулах шаардлага гэж болно.

2) "Аялал жуулчлалын нөөц"-ийг "Аялал жуулчлалын бүтээгдэхүүн" болгох

Энэхүү судалгаагаар жуулчид гайхамшигт байгальд сэтгэл хангалуун байдаг нь тодорхой байгаа боловч илүү өргөн сонголт дутагдаж байна. Энэ нь аялал жуулчлалын нөөц хомс байгаагаас бус "аялал жуулчлалын нөөц"-ийг "аялал жуулчлалын бүтээгдэхүүн" болгон боловсруулахгүй байгаа болон бүтээгдэхүүний талаарх мэдээлэл түгээлт хангалтгүй байгаагаар холбоотой.

(12) Боломжийг ашиглах практик шийдэл

Эцэст нь хэлэхэд, аялал жуулчлалын салбарын шийдвэрлэх шаардлагатай, тулгамдаж буй асуудлуудыг нэгтгэн, ил тод болгож байгаа нь Монголд аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжийг үгүйсгэж байгаа зүйл огт биш юм. Харин цаашид хөгжих өргөн боломжтой энэ салбарын асуудлыг шийдвэрлэхийг зорьж байгаа болно. Иймд амьдралаар шалгагдсан сайн практик туршлагыг нэвтрүүлж, нэвтрүүлснээ сайжруулан ашиглах нь чухал юм. Үүний зэрэгцээ жуулчдын урмыг хугалах, хүлээлтээс доогуур байх, жуулчдаас санал гомдол ирэх нь маркетингийн хувьд нөхөж баршгүй их хохиролд хүргэж болзошгүй тул, өнөөгийн нөхцөл байдлаа бодитоор тусгасан, үнэн зөв мэдээллийг түгээснээр, итгэл найдвар хүлээх замаар Монголд зочлох сонирхолтой жуулчдыг бий болгох ёстой юм.

Дараагийн 5-р бүлэгт аялал жуулчлалын боломж бололцоог дээд зэргээр ашиглан аялал жуулчлалыг хөгжүүлэх практикийн бодлогыг маршрут тус бүрээр санал болгон дэвшүүлнэ.

5-р бүлэг

Маршрут тус бүрийн аялал жуулчлалыг
хөгжүүлэх бодлого (төсөл)

5-р бүлэг Маршрут тус бүрийн аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого (төсөл)

5.1 Монгол Улсын аялал жуулчлалыг хөгжүүлэх ерөнхий бодлого / Хэтийн төлөв

2020 онд УИХ-аар батлагдсан "Алсын хараа 2050" бол Монгол улсын ойрын 30 жилийн төлөвийг тодорхойлсон урт хугацааны хөгжлийн бодлого юм. Тус баримт бичгийн тулгуур үндэслэл нь үндэсний нэгдмэл үнэт зүйлээ эрхэмлэх, Монгол үндэстний бахархал болон үндэсний хөгжлийн талаар тусгагдсан байна. Аялал жуулчлалын салбарыг "Бүс, орон нутгийн хөгжил" бүлэгт тодотгон гаргасан бөгөөд тухайн бүс нутгийн онцлогт тулгуурласан аялал жуулчлалыг хөгжүүлэх зарчмыг баримталсан байна.

"Алсын хараа 2050"-аас өмнө 2019 онд батлагдсан "Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого 2019-2026"-д аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогын зорилгыг "Хүрээлэн буй орчинд ээлтэй, нутгийн иргэдэд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлж, олон улсын аялал жуулчлалын зах зээлд Монгол Улсын өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд оршино" гэж заасан байна. Засгийн газраас шийдвэрлэх асуудлуудыг (1) аялал жуулчлалын салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгож, дэд бүтцийг хөгжүүлэх, (2) гадаад сурталчилгаа, маркетингийн ажлыг эрчимжүүлэх, (3) эрүүл ахуй, үйлчилгээний чанар, стандартыг сайжруулах, (4) хүний нөөцийн ур чадварыг дээшлүүлэх хэмээн тодорхойлжээ.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд жуулчдын тоог нэг саяд хүргэх зорилгыг тавьсан. Ковид-19 халдварт цар тахлын нөлөөгөөр Монгол орныг зорих жуулчдын тоо 2019 онд 570,000 байснаас 2020 онд аравны нэг болтлоо огцом буурч, аялал жуулчлалын салбар ихээхэн хохирол, шууд хүндрэлийг амссан. Аялал жуулчлал нь 2019 оны түвшинд эргэж хүртлээ ойролцоогоор 5-6 жилийн сэргэлтийг зарцуулах төлөвтэй байна.

Монгол орон нь өргөн уудам нутаг, үзэсгэлэнт байгаль, түүх уламжлалын баялаг өв сан, өнөөг хүртэл хадгалдагдсан нүүдлийн соёл иргэншил тэргүүтэн олон сонирхолтой, сэтгэл татахуйц аялал жуулчлалын нөөцтэй. Эдгээр нөөцийг хамгаалахад чухалчлан анхаарч, жуулчдыг хүлээж авах нийүүлэлтийн тогтолцоогоо боловсронгуй болгон, тав тухтай аялах орчин нөхцөл бүрдүүлж чадвал аялал жуулчлалын салбар ойрын ирээдүйд эрчимтэй хөгжих боломжтой орон юм. Монгол улсад аялал жуулчлалыг хөгжүүлэх нь зөвхөн эдийн засгийн ач холбогдолтой төдий зүйл биш юм. Учир н аялал жуулчлалаар дамжуулан олон улсын хэмжээнд Монгол Улсын талаарх ойлголт, имидж, сонирхлыг бататган тодорхойлж, улмаар нэр хүндийг нь өсгөхөд хувь нэмрээ оруулах болно.

Монгол Улсын дээрх бодлого, чиглэлд үндэслэн ЖАЙКА-гаас хэрэгжүүлэх ёстой ажлын үндсэн үзэл санааг доорх байдлаар тодорхойлж байна.

1. Аялал жуулчлалыг хөгжүүлэх нь улс орныхоо баялаг их түүх, соёл уламжлал, дэлхийн түвшний үнэ цэнтэй үлэг гүрвэлийн олдворууд болон бусад аялал жуулчлалын нөөц бололцоогоо илрүүлэн гаргаж, өөрийн эх орноороо бахархах үнэлэмж сэтгэлийг Монголын ард түмний дунд тэтгэн бадрааж, ийм хөгжлийг бүтээн байгуулах ажлын бодит үр дүн болно хэмээн үзэх.
2. Дэлхийн өнцөг булан бүрээс Монгол улсад зочлон ирэх аянчин гийчин юуны түрүүнд дээр дурдсан гайхамшигт өв сан, нөөцийг мэдрэн баясаж, аяллын таашаалыг хүртэж Монгол орны талаарх мэдлэг, ойлголт, сонирхолоо улам бататган, улмаар ийм сэтгэгдэл туршлагаасаа дэлхий дахинд дэлгэрүүлэн сурталчилж, олон улсад Монгол Улсын нэр хүндийг өсгөхөд чухал хувь нэмэр оруулах.
3. Үүний тулд Монгол Улсын байгаль-соёлын ховор нандин нөөц баялгийг хадгалан хамгаалах, цаашид тогтвортой ашиглах боломжоор хангахын сацуу гадаад, дотоодын жуулчдыг Монголд аятай тухтай, тайван амгалан аялах боломжийг бүрдүүлэх чиглэлээр алсын хараа болгон ажиллах.
4. Аялал жуулчлалыг эдийн засгийн гурван үндсэн хөгжлийн нэгэн тулгуур болгон хөгжүүлэх Монгол Улсын Засгийн газрын бодлогыг дэмжиж, ядуурлыг бууруулах тэргүүтэн Тогтвортой хөгжлийн зорилтуудыг (SDGs-Sustainable Development Goals) хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах.

5.2 Маршрут бүрийн аялал жуулчлалын хөгжлийн алсын хараа / хэтийн төлөв

Зорилтот маршрут тус бүрээр аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогыг нягтлан үзэж, давуу талыг ашиглан сул талыг даван туулах хэтийн төлөвийг тодорхойлохыг зорив.

5.2.1 Өмнөговийн маршрут

Аялал жуулчлалын нөөц, дэд бүтэц, эрх зүй/ хууль дүрэм, үйлчилгээ стандарт, мэдээлэл/ маркетинг үнэлгээний шалгуураас хамааруулан улсын болон орон нутгийн засаг захиргааны бодлого, хөтөлбөр, SWOT шинжилгээний үр дүнд үндэслэн судалгааны баг хөгжлийн доорх бодлого, хэтийн төлөвийг санал болгож байна.

Аялал жуулчлалын хөгжлийн алсын хараа	"Уудам онгон байгальд хүрснээр эх дэлхийн агуу гайхамшигийг мэдрэх аялал"-ыг бүс нутгийн хэмжээнд багцлан жуулчдад санал болгох
Зорилтот үйлчлүүлэгч	Гадаадын жуулчид (ялангуяа удаан хугацаагаар аялах боломжтой АНУ, Европын орнуудын иргэд, оюутан залуус)
Хэтийн төлөв	Үлэг гүрвэлийн үнэ цэнийг дээд зэргээр сурталчлан ашиглахын хамт нүүдлийн ахуй амьдралтай танилцах, ховор ан амьтдыг ажиглах зэрэг эвент, арга хэмжээг бий болгож, аялал жуулчлалын биет нөөцийг биет бус үйлчилгээ түвшин хүртэл өргөжүүлэх

1) **[Аялал жуулчлалын нөөц]** Үлэг гүрвэлийн олдвор, эртний хот балгасын туурь зэрэг өрсөлдөхүйц, үнэмлэхүй чадвахитай аялал жуулчлалын нөөцүүдээ дээд зэргээр оновчтойгоор ашиглах

Өмнөговь аймаг дах үлэг гүрвэлийн олдворууд, түүний байгаль соёлын орчин ахуй тэргүүтэн бол бусад улс орон, бүс нутгуудад тэр бүр дахин давтагдахгүй, өрсөлдөх чадвар маш өндөр аялал жуулчлалын үнэ цэнтэй нөөц юм. Монголын бусад бүс нутагтай харьцуулахад Өмнөговь аймаг нь аялал жуулчлалын нөөцийг хамгаалж, тогтвортойгоор хөгжүүлэхээр оролдож байгаа нутаг бөгөөд орон нутгийн засаг захиргаа, хувийн хэвшлийн хоорондын хамтын ажиллагаа нь харьцангуй үр дүнтэй байгаа. Тиймээс аялал жуулчлалыг хөгжүүлэх өнөөгийн бодлогыг хадгалан хөгжүүлэх нь чухал ажээ.

Цагаан Суварга бол Дундговь аймагт орших байгалийн үзэсгэлэнт газар гэдгээрээ гадны аялагчдын анхаарлыг ихэд татаж байна. Цагаан Суваргаас өмнө зүг 15 км -т орших эртний хадны сүг зургууд нь археологийн үнэт дурсгалуудад ордог билээ.

2) **[Аялал жуулчлалын нөөцийн ашиглалтын талаарх хууль/дүрэм]** Аялал жуулчлалын нөөцийг авран хамгаалах арга хэмжээг нэн яаралтай авч хэрэгжүүлэх шаардлагатай

Үлэг гүрвэлийн мөр, говийн ургамал байгаль, ан амьтан, хөрс шороо зэрэг нь түүх соёл, ургамал, биологийн хийгээд палеонтологийн үнэт баялаг, олдворууд болохын хамт хүн ба техникийн үйлдэл дунд тэсвэрлэн оршиход хүндрэлтэй, онгон эмзэг байдал нь нэн онцлог болно. Иймд цаашид жуулчдын тоо нэмэгдсэн ч үнэ цэнтэй атлаа эмзэг баялгийг хамгаалах, аялал жуулчлалд тогтвортойгоор ашиглан хөгжүүлэх нь хамгийн чухал асуудал юм. Ялангуяа аялал жуулчлалын ховор нандин нөөцийг хамгаалах, хадгалах чиглэлээр палеонтологич, зэрлэг ан амьтдын эрдэмтэн судлаач нартай нягт хамтран ажиллах ёстой. Баянзаг зэрэг газарт хамгаалалтын хашлага, аялах ажиглах зам корридор барих зэрэг зарим арга хэмжээг авч байгаа бөгөөд цаашид ч ийм үйл ажиллагааг үргэлжлүүлэх шаардлагатай.

Байгалийн нөөц баялгыг хамгаалах ажлыг үргэлжлүүлж, аялал жуулчлалынхаа суурь нөөц, давуу талуудыг хадгалах үйл ажиллагааг үр дүнд хүргэх ёстой. Ялангуяа Тусгай Хамгаалалттай Газар Нутагт (ТХГН) аялал жуулчлал хөгжүүлэх дэд бүтцийг байгаль орчныг хамгаалах бодлоготой нягт уялдуулах шаардлагатай. Тухайлбал, ТХГН-уудад орж гарах зам маршрут, түүний тэмдэг, тэмдэглэгээ, танилцуулга самбар, явган хүний замыг засч, тодотгож өгөх шаардлагатай.

Бэлчээрийн доройтлоос хамгаалахын тулд аялагчид замгүй газруудаар дураар явах, олон салаалахыг хязгаарлан зохицуулах хэрэгтэй. Ялангуяа ойлгомжтой, тодорхой замын тэмдэг,

тэмдэглэгээг байгальд ээлтэйгээр хийж, аялал жуулчлалын мэдээллийн төвийг хүртээмжтэйгээр ажилуулж, майхан ба гэрээр хоноглох зориулалтын газруудыг сайтар төлөвлөх нь зүйтэй.

- 3) **[Дэд бүтэц, хууль/дүрэм]** Аялал жуулчлалын дэд бүтцийг сайжруулж, ая тухтай аяллаар хангах

Эн тэргүүнд Даланзадгад хотын нисэх онгоцны буудлыг олон улсын зэрэглэлтэй болгон өргөжүүлэхийн тулд аймаг орон нутаг өөрөө улам идэвхтэй, санаачилгатай ажиллах шаардлагатай.

Даланзадгад хотоос Гурвантэс сум хүртэлх авто замыг хатуу хучилттай болгож чадвал, үлэг гүрвэлийн үнэт олдворт Хэрмэнцав болон аялал жуулчлалын гол зорих газрууд болох Ёлын ам, Хонгорын элс дамнасан уламжлалт аяллын маршрут илүү хялбар болж, салбарын цаашдын хөгжилд дэм болно. Даланзадгад хотоос Булган сум хүртэл, улмаар Өвөрхангай аймагтай холбосон хатуу хучилттай авто замыг тавьж чадвал Хархорин, Өмнөговийг тойрсон аяллын маршрутыг хөгжүүлэхэд дэд бүтцийн чухал алхам болно.

Дундговь аймагт аялал жуулчлалын чухал бүс нутаг, газруудтай холбогдсон хатуу хучилттай зам байдаггүй. Төв замаас 50 хүрэхгүй км -ийн зайтай орших Цагаан Суварга хүртэл хатуу хучилттай авто зам барих нь зүйтэй.

Улаанбаатар хотоос говийн нутаг руу автомашинаар зорчиж буй аялагчдад зориулж, замын дагуу дамжин өнгөрөх нэн чухал газар болох Мандалговь хот зэрэг газрууд хийгээд Даланзадгадаас аялал жуулчлалын зорин очих үзмэр газрууд хүртлэх зам зууртаа нийтийн бие засах газруудыг яаралтай суурилуулж, жуулчид сэтгэл амар, тав тухтай аялах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай. Үүнчлэн байгаль орчныг сүйтгэхээс урьдчилан сэргийлэх ёстой юм.

- 4) **[Аялал жуулчлалын нөөц, хууль / дүрэм, мэдээлэл / маркетинг]** Палеонтологийн аялал жуулчлалын нөөцийг хамгаалах чиглэлээр бусад орны туршлагаас суралцах талаар төрийн зүгээс хэрэгжүүлэх арга хэмжээ

Палеонтологийн аялал жуулчлалын нөөцийг хамгаалах зорилгоор, Дэлхийн өвд бүртгэлтэй Канад улсын үлэг гүрвэлийн цэцэрлэгт хүрээлэн, АНУ-ын үлэг гүрвэлийн мөр бүхий Сион үндэсний цэцэрлэгт хүрээлэн (2019 онд 4.48 сая орчим хүн үзэж сонирхсон ба 2017 оны ашиг орлого нь ойролцоогоор 10 сая ам. доллар байсан), Боливийн үлэг гүрвэлийн мөр бүхий Кал Орко палеонтологийн парк (жилд 120,000 орчим хүн үзэж сонирхдог) зэрэг палеонтологийн нөөц дээрээ тулгуурлан аялал жуулчлалыг хөгжүүлсэн улс орнуудын туршлагаас Засгийн газрын зүгээс зориудаар судлах нь зүйтэй. Өөрөөр хэлбэл тэдгээр газруудын үйл ажиллагаа, менежментийн арга барил, эдийн засгийн үр ашгийн талаар нарийвчлан судалж, туршлагыг нь нэвтрүүлж болно. Үүнийг гагц аймаг орон нутгийн захиргааны хүрээнд хэрэгжүүлэхэд учир дутагдалтай тул үндэсний хэмжээний төсөл, хөтөлбөр болгон хэрэгжүүлж, үүндээ үлэг гүрвэлийн олдворт газар болох говийн бүс нутгийн орон нутгийн засаг захиргаа, ард иргэд, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийг оролцуулсан хамтын үйл ажиллагаа явуулах нь зохистой.

- 5) **[Үйлчилгээ]** Үлэг гүрвэлийн олдвороос гадна үндэсний уламжлалт соёл урлаг, нүүдэлчин малчдын ахуй амьдралтай танилцах аялал, арга хэмжээг сонирхолтойгоор санаачлан хэрэгжүүлэх

Дэлхийд ховор үлэг гүрвэлийн аялал жуулчлалын нөөцийн зэрэгцээ нүүдлийн орчин ахуй, малчин айлын амьдралтай танилцах, ховор ан амьтдыг ажиглах, зураг авах зэрэг аяллуудыг төлөвлөх, тэмээний баяр зэрэг арга хэмжээг зохион байгуулах гэх мэтчилэн аялал жуулчлалын хувийн хэвшил, аймаг орон нутгийн аялал жуулчлалын газар, аялал жуулчлалын ТББ-уудын зүгээс хэрэгжүүлэхээр зүтгэж буй ажлууд байгаа. Цаашид олон улсын нисэх буудалтай болж чадвал “Говийн олон улсын марафон гүйлт” зэрэг шинэ арга хэмжээнүүдийг дэмжиж, аялал жуулчлалын салбараас аймагт оруулах нэмүү өртгийг нэмэгдүүлэх боломжтой. Дэлхийд дээгүүрт ордог ашигт малтмалын ордтой бүс нутаг тул, компанийн нийгмийн хариуцлагын (Corporate Social Responsibility) хүрээнд ивээн тэтгэсэн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, уул уурхайн аялал жуулчлалын чиглэлээр олон улсын хамтын нийгэмлэгийн үйл ажиллагаанд бодит хувь нэмэр оруулах боломжтой.


Ийм чиглэлийн арга хэмжээнд нутгийн иргэдийн оролцоо зайлшгүй шаардлагатай бөгөөд уламжлалт урлаг, Монгол гэрийн амьдралыг гадаадын иргэдэд таниулах зэрэг үйлчилгээг орон нутгийн иргэдээр үзүүлж таниулах тогтолцоог бүрдүүлж, бүс нутагтаа илүү ашиг тусаа өгөх аялал жуулчлалыг хөгжүүлэх шаардлагатай юм.

б) [Мэдээлэл / маркетинг] Гадаадын жуулчдыг татах маркетингийн стратеги

Хэдийгээр дотоодын аялагчдын тоо нэмэгдсээр байгаа боловч гадаадын хийгээд дотоодын жуулчдын хэрэглээ, зарцуулалтын хэмжээ асар их зөрөөтэй байдаг. Аймгийн аялал жуулчлалын газар, аялал жуулчлалын компаниудын дийлэнх нь өөрсдийн зорилтот хэрэглэгчдийг гадаадын жуулчид гэж үзэж байна. Орон нутгийн иргэдийн орлогыг сэргээн нэмэгдүүлэхийн тулд ч тус аймаг нь эхлээд гадаадын жуулчдыг хүлээн авах үйл ажиллагаагаа сэргээхэд анхаарлаа хандуулах нь зүйтэй болов уу.

Жуулчдыг хүлээж авах ажлыг нэмэгдүүлэхийн тулд, тус аймгийн аялал жуулчлалын нөөц, онцлогыг дэлхийд сурталчилан таниулж, мэдээлэл түгээх үйл ажиллагааг эрчимжүүлэх нь нэн чухал байна. Төр засгийн харьяалалын найдвартай эх үүсвэр бүхий цахим хуудасуудыг ашиглан чанарын өндөр түвшний дүрс бичлэг, мэдээллийг түгээх нь зүйтэй. Түүнчлэн Засгийн газраас баталгаажуулсан эрх бүхий зөвшөөрөлтэй аялал жуулчлалын компаниудын веб сайт бүхий холбоосыг ч ашиглаж болно. Монголыг зорих жуулчдын хувьд хамгийн бэрхшээлтэй зүйл бол найдвартай мэдээлэл олж авч чаддаггүй явдал юм. Тиймээс жуулчдыг хүлээж авах үйл ажиллагаагаа сэргээхийн тулд мэдээлэл түгээх үйл ажиллагааг бүх бололцоондоо тулгуурлан хэрэгжүүлэх шаардлагатай. Аймгийнхаа аялал жуулчлалын үзмэр, зорих газруудын тухай болон эвент, үйл ажиллагааны талаарх мэдээллийг монгол хэл, наад зах нь англи хэл дээр танилцуулсан цахим хуудсыг чанартайгаар хийх шаардлагатай.

Дээр дурьдсан бодлого, хэтийн төлөвийг хэрэгжүүлэх аялал жуулчлалын хөгжлийн схем зураглалыг доорх байдлаар харуулж байна.



Зураг 5-1: Аялал жуулчлалыг хөгжүүлэх схем зураг (Өмнөговийн маршрут)

5.2.2 Дорноговийн маршрут

Гадаадаас ирсэн жуулчдын хувьд сайн танигдаж хөгжөөгүй боловч төмөр замын дэд бүтцийг ашиглан төрөл бүрийн аяллыг хөгжүүлэх боломжтой хэмээн үзэж тус чиглэлийн аялал жуулчлалын хөгжлийн бодлого, хэтийн төлөвийг дараах байдлаар төлөвлөн санал болгож байна.

Аялал жуулчлалын хөгжлийн Алсын хараа	"Төмөр замаар явах говийн аялал"-ыг олон улсын чанарын түвшинд хүргэж, байгаль орчныг хамгаалахад хувь нэмэр оруулах.
Зорилтот үйлчлүүлэгч	Энергийн төв (Дотоодын жуулчид) Замын-Үүд (БНХАУ-ын жуулчид) Онгон байгалийн нөөц бүхий газрууд / Эртний хот, балгасын туурь (АНУ /Европын орнууд / Япон / БНСУ-ын жуулчид)
Хэтийн төлөв	Нутгийн иргэд, олон нийтийн оролцоотойгоор аялал жуулчлалын үйлчилгээний чанарыг сайжруулж, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх явдал болно. Цаашид Сайншанд хотоос Даланзадгад хот, Мандалговь хот хүртэлх аяллын хөтөлбөрийг өргөтгөн боловсруулж палеонтологийн олдвор, байгальтай танилцах аяллаар баяжуулах боломжтой.

- 1) **[Аялал жуулчлалын нөөц, мэдээлэл / маркетинг]** Төмөр зам дагуух аялал жуулчлалын нөөцийг хөгжүүлж, урт хугацааны аяллыг дэмжих

Чойр хотод түшиглэн, Чингис хааны удам боржигин угсааныхны төв, Боржигон өв соёлын тоглолтыг дэглэж, Азийн анхны сансрын нисгэгчдийн нэг төлөөлөл болох Монгол сансрын нисгэгчийн хөшөөг үзэх боломжтой юм. Мөн эртний хот балгасын туурь бүхий зүүн чиглэлийн аялал болон Их нартын БНГ-т үзэх, танилцах, ховор зүйлийн аяллын маршрутыг хөгжүүлж чадвал жуулчдын саатах хугацааг уртасгах боломжтой. Чойр хоттой харьцангуй ойрхон, үлэг гүрвэлийн олдворт газар болох Хүрэн дух, Хаялга нуур зэрэг ирээдүйд хөгжүүлэх боломжтой аялал жуулчлалын бусад нөөц газрууд ч байдаг.

Их нартын БНГ-аас баруун тийш Мандалговь хот хүрэх маршрут байдаг бөгөөд бусад аймагтай хамтран Чойр хотод буух төмөр замын аяллыг хөгжүүлэх боломжтой. Сайншанд холгүй байрлах Хамарын хийд нь дотоодын аялагчдад алдартай. Гэхдээ гадаадын жуулчдын сонирхлыг татахуйц аялал жуулчлалын өөр нөөцийг сонирхолтойгоор хөгжүүлэх шаардлагатай юм.

- 2) **[Аялал жуулчлалын нөөц, дэд бүтэц, үйлчилгээ]** Галт тэрэгний замаас салаалж говийн аялалд холбогдох аяллын сүлжээг байгуулах

Орос-Монгол-Хятад чиглэлийн Монголын төмөр зам дайран өнгөрдөг тул Дорноговийн маршрут нь Монголд аялал жуулчлалын онцгой өрсөлдөх чадвартай. Гэхдээ гадаадын иргэд нь замдаа галт тэрэгнээс буулгүйгээр Замын-Үүд боомтоос Бээжин хот хүртэл 30 цаг зарцуулаад дуусах тохиолдол олон. Тиймээс төмөр замын аялал хийнгээ Чойр хот болон Сайншанд хотод замдаа буудаллах, Монгол орноор саатан аялах төрөл бүрийн хөтөлбөрүүдийг хөгжүүлэхийг санал болгож байна. Ингэхийн тулд галт тэрэгний өртөөнөөс аялах газар, үзмэр хүртэлх аяллын үйлчилгээний сүлжээг бий болгох шаардлагатай. Улаанбаатар хот болон Өмнөговь аймгийн аялал жуулчлалын агентлагуудтай хамтран ажиллаж аялал жуулчлалын сүлжээ байгуулан, шинэ чиглэлийн бизнесийг хөгжүүлэхэд идэвхтэй оролцохыг дэмжих нь зүйтэй

- 3) **[Аялал жуулчлалын нөөц, дэд бүтэц, үйлчилгээ]** Төмөр замын өртөөнөөс зүүн ба баруун зүгт чиглэсэн зам тээврийн дэд бүтцийг салбарлуулан хөгжүүлэхийг дэмжих

Сайншанд хотоос 50 орчим км зайд оршдог Хамарын хийд нь дотоодын жуулчдад онцгой ач холбогдолтой хэдий ч гадаадын жуулчдын хувьд хаа сайгүй байх буддын сүм хийдийн нэг гэж л ойлгогддог тул тус хийдийн онцлог давуу талыг ойлгуулж мэдрүүлэхэд хүндрэлтэй байдаг. Тиймээс жуулчдыг замдаа Сайншанд хотод галт тэрэгнээсээ бууж сонирхолтойгоор аялуулах, үүний тулд баруун зүгт илүү баялагтайгаар сонирхолтойгоор аялуулж байгалийн үзэсгэлэнт газруудыг нэмж танилцуулах хөтөлбөрийг боловсруулах шаардлагатай.

Дорноговь аймагт Хонгил цав, Баянширээ зэрэг үлэг гүрвэлийн олдворт газар байдаг. Гэвч ер нь гадаадын жуулчид үлэг гүрвэлийн олдворт газраар аялахад Өмнөговь аймгийн Даланзадгад хот эсвэл Дундговь аймгийн Мандалговь хотоос баруун зүг рүү чиглэж явдаг бөгөөд Дорноговь аймгийн үлэг гүрвэлийн олдворт газрыг аялал жуулчлалын нөөц гэж үзэх нь ховор юм. Иймд Сайншанд хотоос үлэг гүрвэлийн олдворт газарт хэрхэн явах талаар замын мэдээллийг тодорхой болгож, байгаль орчинд ээлтэй отоглох газруудыг байгуулвал Дорноговь аймгийн үлэг гүрвэлийн

олдворт газарт жуулчдын сонирхолыг татах боломжтой болно.

Замын -Үүд орчмоос хирс, тапир, зэрлэг гахай гэх мэт 34 сая жилийн өмнөх хөхтөн амьтдын чулуужсан яс олноор олдсон байдаг бөгөөд үлэг гүрвэлээс өөр амьтдын чулуужсан олдворын талаар ч олж мэдэх боломжтой юм.

Сайншанд хотоос Мандалговь хот хүртэл 337 км-ийн зайтай ба замд боржин чулуун бүс нутаг болох “Их газрын чулуу” БНГ байрлана. Сайншанд хотоос Даланзадгад хот хүртэл 532 км болно. Одоо нүүрсний уурхай хүртэл төмөр зам тавих ажил хийгдэж байгаа. Зүүн-баруун чиглэлийн зам тээврийн дэд бүтцийг ашиглаж, цаашид зүүн баруун зүгт хөндлөн аялах боломжийг бүрдүүлэх нь зүйтэй юм.

- 4) **[Аялал жуулчлалын нөөц, дэд бүтэц, хууль /дүрэм]** Нийтийн ариун цэврийн газар, түр амралтын газрыг байгуулж, менежментийг хэрэгжүүлэх замаар байгаль орчныг хамгаалах

Дорноговийн маршрут нь хүний гар хүрээгүй аялал жуулчлалын арвин нөөц ихтэй боловч хот, сумын төвөөсөө гадна жуулчдад зориулсан цэвэрхэн бие засах газар, түр амрах цэг байдаггүй. Сайншанд хотоос Цагаан Суварга хүртэлх зам дагуу ч бие засах газар, түр амрах газар цөөн байдаг. Тэгш тал газар тул яг тогтсон нэг авто замгүйгээр дураараа зорчих машин цөөнгүй бөгөөд олон салаа зам үүсгэж, байгалийн үзэмж, газрын хөрсийг сүйтгэж байна. Нутгийн иргэд, олон нийтийг татан оролцуулж, аялал жуулчлалын газруудыг хамгаалах үйл ажиллагаанд оролцуулж, улмаар иргэдэд аялал жуулчлалын орлогыг нэмэгдүүлэх механизмыг бүрдүүлэх хэрэгтэй байгаа.

- 5) **[Аялал жуулчлалын нөөц, хууль / дүрэм, мэдээлэл / маркетинг]** Зорилтот жуулчдын бүлгийн хэрэгцээнд дүн шинжилгээ хийх

АНУ, Европын орнууд Япон, БНСУ, ОХУ, БНХАУ-аас ирсэн жуулчид нь өөр өөрийн онцлогтой. Дорноговийн маршрутын Замын-Үүдээр зорчдог аялагчдын ихэнх нь БНХАУ-аас ирсэн байдаг бөгөөд тэдний аяллын хэв маяг нь хямд хоол хүнс, бэлэг дурсгал гэх мэт хэрэглээнд төвлөрдөг. БНХАУ-аас ирсэн жуулчдын хэрэгцээг хангах маркетингийн стратеги боловсруулах шаардлагатай.

Их газрын байгалийн аялал жуулчлалын тухайд, аялал жуулчлалын нөөц, хүрээлэн буй орчныг хамгаалах үүднээс, зорилтот хэрэглэгчдэд чиглэсэн харьцангуй өндөр үнэтэй аяллыг төлөвлөх нь зүйтэй. Тодруулбал, хүн машин талхлаагүй онгон байгальтай үзэсгэлэнт газрууд руу ухамсар, ёс зүйн өндөр төлөвшилтэй жуулчдыг татах, тэдний сонирхол, зан үйлд чиглэсэн маркетингийн стратеги хэрэгжүүлэхийг санал болгож байна.

- 6) **[Хууль / дүрэм, мэдээлэл / үйлчилгээ]** Аялал жуулчлалын нөөцийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг нутгийн иргэд / олон нийтийг сургаж хөгжүүлэх

Улаанбаатар хотоос БНХАУ руу төмөр замаар зорчиж буй аялагчид болон Өмнөговь аймгийн чиглэлээс ирж буй аялагчдын аль нь ч Дорноговь аймаг дах аялал жуулчлалын үзмэр, газруудыг сонирхохгүй өнгөрөх нь элбэг. Учир нь тус аймгийн аялал жуулчлалын газрын талаарх мэдээлэл зорилтот аялагчдадаа хүрч чадаагүй байдаг. Тиймээс тус аймгийн иргэдийн ихэнх нь аялал жуулчлалын салбартай хамааралгүй, аялал жуулчлалаас шууд орлого олдоггүй. Дорноговь аймгийн сэтгэл татам, сонирхолтой газруудын талаарх мэдээллийг хангалттай, сайн түгээхийн тулд, эхлээд нутгийн иргэд өөрсдөө өөрийн аймгаасаа өөр тийш, аялал жуулчлал нэлээн хөгжсөн аймаг орон нутгуудаар зочлох, улмаар өөрт байгаа боломж онцлог, аялал жуулчлалын үнэ цэнийг мэдэрч ойлгох нь чухал юм. Бусад аялал жуулчлалын газрууд дах нийтийн бие засах газар, түр амралтын газруудыг үзэж, жуулчдын хэрэгцээг хангаж чадах үйлчилгээний чанаруудыг биечлэн үзэж суралцах нь чухал.

Мөн Дорноговийн маршрут дах аялал жуулчлалын суурь нөөцийг зөвхөн орон нутгийн засаг захиргаа, нутгийн иргэд хамгаалах боломжгүй тул үзэсгэлэнтэй газар нутаг, хүн төрөлхтний түүхэн дурсгалтай ховор, нандин газруудаа хадгалж хамгаалахын тулд Засгийн газарт санхүүгийн дэмжлэг үзүүлэх болон техникийн зөвлөлгөө хүсэх талаар тууштай ажиллаж, яаралтай арга хэмжээ авах шаардлагатай.

7) [Хууль/дүрэм, мэдээлэл/үйлчилгээ] Аялал жуулчлалын нөөцийг цэгцлэн, зохион байгуулж, үнэн зөв мэдээллийг түгээх

Дорноговийн маршрутад аялал жуулчлалын нөөц боломж арвин байгаа боловч, сурталчилгааны фото зургуудыг нь үзээд сонирхол төрсөн ч тухайн газрын тухай зөв мэдээлэл олж авахад хүндрэлтэй байдаг. Тус аймгийн мэдээлэл, сурталчилгааны төсөв нь хязгаарлагдмал байгаа нөхцөлд БОАЖЯ-нь гол үүрэг гүйцэтгэж, Дорноговийн аялал жуулчлалын цэгүүдийн зай, очиход зарцуулах цаг, бие засах газар, отоглох газар, зочид буудлын байршил зэрэг мэдээллийг тусгасан аялал жуулчлалын газрын зургийг боловсруулж, олон нийтэд түгээх нь чухал юм.

Төмөр замд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх схем зургийг дараах байдлаар харуулж байна.



Зураг 5-2: Аялал жуулчлалыг хөгжүүлэх схем зураг (Дорноговийн маршрут)

5.2.3 Хархорины маршрут

Хархорины бүс нутаг нь нийслэл Улаанбаатар хотоос 358 км зайтай, Монголын Зүүн ба Баруун чиглэлийг холбосон хатуу хучилттай төв замын дагуу байрладаг тул харьцангуй хялбар Монгол орны байгалийн үзэсгэлэн, түүх соёлын дурсгалт газруудыг нэг дор үзэж танилцах боломжтой аялал жуулчлалын бүс нутаг юм. Энэ нутагт ирсэн гадаадын жуулчдын сэтгэгдэл ч харьцангуй өндөр байдаг. Хөгжлийн алсын харааг дараах байдлаар тодорхойлж байна.

Аялал жуулчлалын хөгжлийн алсын хараа	Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлж, үйлчилгээний чанарыг сайжруулах замаар дэлхийн чанар, өвд нийцэхүйц аялал жуулчлалын зорих газрыг бий болгох.
Зорилтот үйлчлүүлэгч	Гадаадын жуулчид (богино, урт хугацааны)
Хэтийн төлөв	Нийслэл Улаанбаатар хотод ойр, үзэсгэлэнт байгаль, түүх, соёлын өв зэрэг аялал жуулчлалын нөөц ихтэй, цаашид хөгжих өндөр боломжтой аялал жуулчлалын зорих газар учраас жуулчдын тоо ч нэмэгдсээр байна. Дэд бүтцийг чанаржуулж, үйлчилгээг нь сайжруулж, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар дэлхийн өвийн түвшинд, чанартай аяллыг өндөр зэрэглэлд хүргэхийг зорих.

1) [Аялал жуулчлалын нөөц, үйлчилгээ, мэдээлэл / маркетинг] Янз бүрийн аяллын маршрутыг санал болгох

Хархорин нь Монголын эзэнт гүрний нийслэл байсан тул дотоодын аялагчид ихээр сонирхдог, цаашид гадаад, дотоодын жуулчдын сонирхолыг илүүтэй татах бүрэн боломжтой аялал жуулчлалын газар юм. Ялангуяа Улаанбаатар хотоос Хархорин хүртэл, цаашлаад Архангай

аймгийн Тэрхийн цагаан нуур хүртэлх замд аяллын үндсэн маршрут, сонирхолтой газрууд байдаг бөгөөд энэ зам дагуу төрөл бүрийн аяллыг хийхээр явдаг. Аялагчдын сонирхолд нийцүүлэн богино болон урт хугацааны аяллыг төлөвлөн явуулахад хялбар маршрут болой.

Улс болон Орхоны хөндийд байрлах 2 аймгийн засаг захиргаанаас маркетинг, сурталчилгааны стратегийг тууштай хэрэгжүүлбэл жуулчдын тоог хоёр дахин нэмэгдүүлэх нь тийм ч хэцүү биш гэж бодож байна. БНСУ-аас аль хэдийн 100,000 жуулчин ирсэн байгаа бөгөөд маркетинг, сурталчилгааг үр дүнтэй хэрэгжүүлснээр Японоос одоогоор улсын хэмжээгээр ердөө 25,000 жуулчин ирээд байгааг цаашид илүү нэмэгдүүлэх найдлагатай. Мөн жуулчдын шаардлагыг хангасан аяллын бүтээгдэхүүн (аюулгүй, амар тайван удаан хугацаагаар аялах боломжтой хөтөлбөр, сонирхол татахуйц эвент, арга хэмжээ, бэлэг дурсгалын зүйл)-ний төрөл чанарыг сайжруулж, зөвхөн жуулчдын тоог нэмэгдүүлэхэд биш, харин нэг хүнийн зарцуулах мөнгөний хэмжээг өсгөх замаар ашиг орлогыг өсгөж чадах юм.

2) **[Аялал жуулчлалын нөөц, үйлчилгээ, мэдээлэл / маркетинг]** Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар аялал жуулчлалын нөөцийг хамгаалах

Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх хамгийн суурь, чухал алхам бол хүний гар хүрээгүй онгон байгалийн өвийг чинад хамгаалж, хадгалах явдал юм. Үүний тулд аялах газрын хэрэглээний төлөвлөлт, орон зай, тэмдэглэгээг маш тодорхой, нягт, мэргэжлийн түвшинд хийх ёстой. Тухайлбал аялагчдын явах маршрут дагуу зам тавих, мэдээллийн самбар байрлуулах, авто машины зогсоол бэлтгэх, отоглох газрыг тодорхой тогтоож өгөх, хориглосон, хамгаалалтын хашлага суурилуулах зэрэг арга хэмжээг авах шаардлагатай. Хэдийгээр дархан цаазат газарт тодорхой журам тогтоосон байдаг ч отоглох газрын стандарт, зөвшөөрөлгүй, хориглосон үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг сайтар журамлах ёстой. Тулгамдаж буй дараагийн нэг асуудал нь боловсон хүчний дутагдал хийгээд дээрх үйл ажиллагаа явуулах санхүүгийн эх үүсвэрийн хомсдолт байдал юм. Аялал жуулчлалын орлогоор хамгаалалтын зардлаа нөхөж санхүүгийн мөчлөгийг тодорхойлохын зэрэгцээ мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах зайлшгүй шаардлага байна.

3) **[Дэд бүтэц, үйлчилгээ]** Дэд бүтцийг барьж байгуулахдаа тэдгээрийн засвар үйлчилгээ, арчилгааг хамтад нь төлөвлөх

Зам тээврийн дэд бүтцийг сайжруулж, жуулчдад амар амгалан, аюулгүй үйлчилгээг хангах үүднээс аялах газрууд болон түр амрах цэгүүдэд үйлчилгээний хэсэг, цогцолборуудыг барьж, нийтийн бие засах газрыг чанартайгаар ажилуулах хэрэгтэй. БОАЖЯ-наас хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зарим төслүүд байгаа тул Орхоны хөндийн бүс нутгийн аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэх нэгдсэн газрын зургийг гаргах ажлыг яаравчлах хэрэгтэй.

Түүнчлэн жуулчны нийтийн үйлчилгээний газруудын цэвэрлэгээ, арчилгаа, засвар үйлчилгээг хийх тодорхой эзэн, байгуулагуудыг тогтоож, хэрэгжүүлэх тогтолцоо, тэдгээрийн төсвийг тооцон гаргасан байх нь чухал. Бие засах газар зэрэг ариун цэврийн байгууламжууд нь арчилгаа, цэвэрлэгээ муу байвал тэр дор нь ашиглах боломжгүй. Иймд тогтмол цэвэрлэж арчлах, засварлах ажлыг цаг тухайд нь хийх менежментийн тогтолцоо хийгээд төсвийн эх үүсвэрийг бүрдүүлэх ёстой. Ковидын дараах шинэ нөхцөл дэх аяллын үйлчилгээний ариун цэвэр орчны талаарх шаардлага улам ч ихээр зайлшгүй тавигдана. Орон нутгийн нөхцөлд тохирсон, ашиглахад таатай, цэвэрлэхэд хялбар бие засах газрын дизайн шийдэлийн талаар хийгдсэн мэргэжилтнүүдийн судалгаа олон байдаг тул тэдгээрийг ашиглах нь зүйтэй.

4) **[Дэд бүтэц, үйлчилгээ]** Өвөрхангай аймгийн нисэх онгоцны буудлыг олон улсын нисэх буудал болгох

Одоогийн нисэх онгоцны буудлыг олон улсын нисэх буудал болгох нь Улаанбаатар хотын олон улсын нисэх буудалд ямар нэг хүндрэл гарах, хаагдах зэрэг онцгой нөхцөл байдлын үед тус үүргийг шилжүүлэн авч ажиллах нисэх буудлыг бэлтгэх үүднээсээ ч нэн чухал ач холбогдолтой. Монгол улсад олон улсын нисэх онгоцны буудал одоогоор ганцхан байгаа нь аялал жуулчлалын салбарын эрэлт хэрэгцээ талаасаа ч, цаашлаад үндэсний аюулгүй байдлын үүднээс ч анхаарууштай.

5) **[Үйлчилгээ, мэдээлэл / маркетинг]** Найрсаг дотно, зочломтгой зангаар дайлсан үйлчилгээг нэвтрүүлж, давтан ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх

Аялал жуулчлалын үзмэр газруудыг нэг удаагийн сэтгэл ханамж бүхий газар болон байнга ирэх хүслийг төрүүлэх газар гэж хоёр хувааж болно. Хархорины маршрут нь аялал жуулчлалын нөөц бололцоо, амралт сувиллын газруудын тоо зэргээс харахад дахин очих хүсэл төрүүлэх газрыг нэг болох боломжтой. Амралтынхаа өдрүүдийг байгалийн үзэсгэлэнт газарт тав тухтай өнгөрүүлэх аяллын эрэлтийг сайтар дэмжиж хөгжүүлэх нь зүйтэй. Халуун орны далайн эргийн амралтын газрууд, Альпийн нурууны амралтын газруудын адил тал нутаг, хөх тэнгэрийг ширтэн тайван амрах амралтын газруудыг байгуулж, үйлчилгээг нь сайжруулах замаар давтан ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх боломжтой.

6) **[Үйлчилгээ, мэдээлэл / маркетинг]** Ковид-19 халдварт цар тахлын дараах жуулчдын эрэлтийн өсөлтийг хангах бэлтгэл ажиллагаа

Ковид-19 халдварт цар тахлаас шалтгаалж уналтанд орсон аялал жуулчлалын салбарын сэргэлт хийгээд хэвийн байдлаараа хөгжих төлөвийг одоогоор баттай таамаглах аргагүй. Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын (UNWTO) таамаглалаас үзэхэд салбарын сэргэлт төлөвлөснөөс ч хойшлох магадлалтай байна. 2019 оны түвшиндээ хүртэл хамгийн наад талдаа 2025 он хүргэх төлөвтэй байна. Ямартаа ч эргэн сэргэх цагт жуулчдын тоо өсч, эрэлт нэмэгдэх магадлалтай байгаа бөгөөд үүнийг 2015-2019 онууд дах 146 хувьд хүрсэн өсөлтийн хувьтай тооцоолж үзвэл 5 жилийн дотор хоёр дахин өсөх таамаглалтай. Өөрөөр хэлбэл, 2019 онд 570 мянга байсан жуулчны тоо 2029 он гэхэд 1 сая хүнээс давах магадлал өндөр байгаа гэж хэлж болно. Цаашид улам бүр өсөх магадлалтай жуулчдыг хүлээж авах бэлтгэл ханган ажиллах нь чухал байна. Дээр дурдсан 1) - 5) -д заасан арга хэмжээг авснаар аялал жуулчлалын нөөцөө хамгаалж, өрсөлдөх чадвартай, эдийн засгийн үр ашигтай, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлж чадна хэмээн найдаж байна. Дээрх арга хэмжээг бодитоор хэрэгжүүлэхэд төрийн байгууллагууд болох БОАЖЯ, нийслэлийн болон орон нутгийн аялал жуулчлалын газрууд үүрэг оролцоо маш чухал. Өнөөгийн нөхцөлд хувийн хэвшлийн харуицлагатай, чадавхитай байгууллага өсөн хөгжих хүртэл төрийн байгууллагууд гол үүрэг гүйцэтгэж Монгол Улсын аялал жуулчлалыг хөгжүүлэх ёстой.

Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэхийн тулд менежментийн чадварыг сайжруулах зайлшгүй шаардлагатай бөгөөд үүнд төрөл бүрийн арга оролдлогуудыг турших, сайжруулах замаар аялал жуулчлалын чанар өгөөжийг дээшлүүлэх нь чухал. Дээрх бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэх аялал жуулчлалын хөгжлийн схем зургийг дараах байдлаар харуулж байна.



Зураг 5-3: Аялал жуулчлалыг хөгжүүлэх схем зураг (Хархорины маршрут)

5.2.4 Улаанбаатар хот орчмын маршрут

Нийслэл Улаанбаатар хот бол Монгол улсын хилээр нэвтэрч буй гадаадын иргэдийн 98 орчим хувь нь орж ирдэг үндсэн үүд хаалга юм. Улсынхаа нийгэм, эдийн засаг, соёл урлаг, эрдэм шинжилгээний төв болохын хамтаар жуулчид хөдөө орон нутаг руу аялалд гарахынхаа өмнө мэдэрдэг анхны сэтгэгдлийг төрүүлэгч хамгийн төвлөрсөн газар мөн. Улаанбаатар хотын аялал жуулчлалын байгууламж, үйлчилгээ нь, жуулчдад Монголын аялал жуулчлалын нөөц, түүх, гарал үүсэл, онцлогийн талаарх ойлголт өгөх, аяллын ерөнхий хэмнэл, биеэ авч явах ёс, дэг журмыг танилцуулахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

Тиймээс судалгааны баг, Улаанбаатар хот хийгээд хот орчмын аялал жуулчлалын хөгжлийн алсын хараа, хэтийн төлөвийг дараах байдлаар санал болгож байна.

Аялал жуулчлалын хөгжлийн алсын хараа	Аялал жуулчлалын үүд хаалга нь болж, Монголын түүх, уламжлал, соёл зэргийн талаарх мэдээллийг цогцлон түгээх, аялах дэг ёс, соёл, журмыг талаарх мэдлэгийг олгоход чиглэгдсэн аялал жуулчлалын байгууламж, үйлчилгээний багцыг бүрдүүлэх.
Зорилтот үйлчлүүлэгч	Гадаадын жуулчид (богино, урт хугацааны)
Хэтийн төлөв	Дэлхийд хосгүй өвөрмөц өв соёл, зан заншилтай Монголыг олон улсад таниулах, жуулчид Монгол улсаар аялах талаараа үндсэн, суурь мэдээлэл баримжааг олж авах, улсын аялал жуулчлалын төв болгон хөгжүүлнэ. Амьдралдаа ганц удаа ч болтугай Монголд очиж үзэхсэн гэж бодогдохоор аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг бэлтгэж, хавар, зун, намар, өвлийн аль ч улиралд очиж үзэх хүслийг маргаангүй төрүүлэх маркетинг стратегийг хэрэгжүүлэх.эх.

- 1) [Аялал жуулчлалын нөөц, үйлчилгээ, мэдээлэл / маркетинг] Зайлшгүй зочлон өнгөрөх аялал жуулчлалын төв болгон хөгжүүлэх

Жуулчид нь янз бүрийн төсөөлөл, хүлээлттэй аялах газрынхаа нисэх онгоцны буудалд бууж аяллын эхний өдрүүдээсээ эрх чөлөөг мэдрэхийн хамт тодорхой хэмжээнд биеэ барьж, тухайн орчиндоо танилцахад тодорхой хугацаа нөхцөл хэрэгтэй болдог. Монгол улсад хүрэлцэн ирж буй жуулчдад аяллын талаараа зайлшгүй мэдэх, анхаарах, суралцах зүйлсийн талаар болон аль нэг газарт заавал очиж үзэх хүслийг төрүүлэх аялал жуулчлалын нэгдсэн төвийг Улаанбаатар хотод бий болгох нь зүйтэй. Байгаль соёлын үнэт өв болон тэдгээрийн түүх, гарал үүслийг тайлбарлах, Монгол орны өнөөгийн нөхцөл байдлыг танилцуулах тэргүүтэн бодит байдлыг мэдэж авсны үндсэн дээр хүрээлэн буй орчныг хамгаалах тал дээр ч хэрхэн ёс зүйтэй, ногоон аялахыг дэмжин уриалах нь чухал.

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа хэд хэдэн музей байдаг боловч жуулчдын сонирхлыг бүхэлд нь татаж чаддаг эсэх нь эргэлзээтэй. Монголд ирэхгүй л бол үзэж харж чадахгүй, мэдрэх боломжгүй тийм зүйлсийг дэлгэн үзүүлж, байгаль орчин хамгаалал, аяллын үйлчилгээ, ёс зүйн талаар суралцах боломжийг олгосноор зөвхөн Улаанбаатарт төдийгүй бүх бүс нутагт үр нөлөөгөө үзүүлж чадна хэмээн тооцох хэрэгтэй. Музей үзэж сонирхсоны дараах мэдээлэл туршлага нь тухайн жуулчны сонирхсон аяллын маршрутаар аялахад дэм болохуйц байх нь зүйтэй.

Хүснэгт 5-1: Улаанбаатар хотын музейн жагсаалт

Музейн нэр	Музейн товч танилцуулга
Богд хааны ордон музей	Монголын хамгийн сүүлчийн Богд болох ҮШБ Богд хаан амьдарч байсан ордон
Монголын Үндэсний Музей	Чулуун зэвсгийн үеэс эхлээд ардчилсан хувьсгал хүртэлх үеийн Монголын түүх
Чойжин ламын сүм музей	Цамын баг, өмсгөл, хөгжим зэрэг шашин, соёл урлагийн олон үзмэрүүд байдаг
Г.К.Жуковын дурсгалын музей / Монгол Цэргийн музей	Монголын цэргийн түүх, Халхын голын дайны түүх, тэмдэглэл (Японы армитай хийсэн мөргөлдөөн)


Музейн нэр	Музейн товч танилцуулга
Үлэг гүрвэлийн төв музей	Улаанбаатар хотод үлэг гүрвэлийн олдворуудыг дэлгэн үзүүлж буй музей
Байгалийн түүхийн музей	Хаалттай байгаа тул зарим палеонтологийн олдворын үзэсгэлэнгээ түр Hunnu Mall -д гаргаж байгаа

2) [Аялал жуулчлалын нөөц, үйлчилгээ, мэдээлэл / маркетинг] Палеонтологи, үлэг гүрвэлийн олдворын давуу талыг бүрэн дүүрэн ашиглах

Дээр өгүүлсэнчлэн жуулчдын заавал очиж үзэх хүслийг төрүүлэх, аялал жуулчлалын үйлчилгээний төв болгоход дэлхийн хэмжээний ховор үнэ цэн бүхий үлэг гүрвэлийн олдворыг ашиглахыг санал болгож байна. Говиос олдсон үлэг гүрвэлийн олдворууд нь палеонтологийн шинжлэх ухаанд үнэтэй хувь нэмэр оруулсан төдийгүй энэ салбарын судалгаа шинжилгээнд шинэ нээлтийг авч ирсэн. Түүгээр ч зогсохгүй олон хүмүүст өнгөрсөн цагийн төсөөлөл дээр суурилсан адал явдлын мөрөөдөлд умбуулах аялал жуулчлалын үнэт нөөц юм.

Одоогийн үлэг гүрвэлийн музей нь хувийн компанийн хүчин чармайлтаар үлэг гүрвэлийн олдворыг нийгэд үзүүлэн таниулах газар болон үйл ажиллагаа явуулж байна. Нас хүйс харгалзахгүйгээр бүх хүмүүсийн сонирхолыг татах үлэг гүрвэлийн чулуужсан ясыг ашиглан үлэг гүрвэлийн тухай мэдлэг болон Монголын сонирхол татахуйц байдлын талаас гадна аялал жуулчлалын нөөцийг хамгаалах, аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах талаар санал болгох боломжтой. Түүнчлэн жуулчид хэрхэн биеэ авч явах, орон нутгийн соёлыг хүндлэх, ёс зүйтэй аялах талаар зааж сургах, хог хаягдлыг болон нийтийн бие засах газрыг арчилж цэвэрлэхэд тус дэм болох ногоон үйлс хандив цуглуулах гэх мэт үйл ажиллагааг явуулж болно. Дэлхийн үнэт өвийг хамгаалахад чиглэсэн сургалт, ухуулга сурталчилгааны газар болгож Монгол Улсын Засгийн газраас хариуцан удирдах “Үлэг гүрвэлийн музей”-г байгуулах нь зүйтэй юм. Дараах схем зурагт үлэг гүрвэлийн олдворыг үзэх маршрутын төслийг харуулж байна.

Одоогийн байдлаар үзэсгэлэнгийн танхим болон судалгааны лаборатори нь тус тусдаа байдаг бөгөөд үзэгчид, жуулчид үзмэрийн талаар сонирхож асуусан тохиолдолд, судалгааны байгууллагын мэргэжилтэн тэр дор нь очоод хариулах боломжгүй байдаг. Түүнчлэн үлэг гүрвэлийн олдворын үзэсгэлэнгээс олсон орлого ашгийг судалгаа эрдэм шинжилгээний ажилд зарцуулах боломжгүй юм. Тиймээс судалгааны хүрээлэн лабораторитой байрыг музейтэй залгаж бариад аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар судалгааны ажлыг санхүүжүүлж, палеонтологийн судалгааг тогтвортойгоор хөгжүүлэх нь зүйтэй.




Зураг 5-4: Үлэг гүрвэлийн олдворыг үзэх маршрут /төсөл/

3) [Хууль / дүрэм] ШУА, БОАЖЯ, БШУЯамдын салбар хоорондын хамтран ажиллагаагаар дамжуулан Олон улсын дэмжлэг авах

Монголын яам, агентлагууд нь босоо чиглэлийн удирдлагын тогтолцоотой учраас салбар хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд бэрхшээлтэй байдаг. Гэвч, үлэг гүрвэлийн музей нь судалгааны байгууллагын үүрэгтэйгээс гадна жуулчдыг татах гэсэн утгаараа БОАЖЯ, мөн шинжлэх ухааны мэдлэг, ёс зүйн боловсрол олгох гэсэн утгаараа боловсролыг хариуцсан БШУЯ ч хамтран оролцох шаардлагатай. Түүнчлэн барилгын төсөв, зээлийн эргэн төлөлт зэргийг хариуцах Сангийн яам ч хамаарах юм. Цаашлаад Өмнөговь, Мандалговь аймгийн засаг захиргаатай ч хамтран ажиллах шаардлагатай.

Ийм өргөн хүрээний оролцогч талуудын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд гадаадаас зөвлөгөө өгөх гуравдагч талын үүрэг чухал юм. Санхүүгийн туслалцаа үзүүлж, мэргэжилтэн илгээх Олон улсын хамтын ажиллагааг хэрэгжүүлсэнээр дотоодын босоо чиглэлд хуваагдсан байгууллагуудын нөлөөллийг шийдвэрлэх боломжтой болно. Япон улсын зүгээс ч идэвхтэй дэмжлэг үзүүлж, дэлхийн өвийг хамгаалах, аялал жуулчлалыг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулах нь зүйтэй юм.

Салбар хоорондын хамтын ажиллагааны төв болох музейн хөгжлийг хариуцах хороо, гадаад орнуудын хамтын ажиллагаа, дэмжлэгийн талаарх схем зургийг дараах байдлаар харуулж байна. Судалгаа, шинжилгээний байгууллага болох ШУА голлох үүрэг гүйцэтгэх ба ШУА-ын саналд үндэслэн БОАЖЯ нь музейн барилгын төлөвлөгөө, ашиглалтын төлөвлөгөөг боловсруулж, БШУЯ -тай хамтран түгээн дэлгэрүүлэх, ухуулан таниулах ажлыг хийхээр төлөвлөгөөнд тусгасан болно. Олон улсын байгууллага нь палеонтологийн мэргэжилтэн хоорондын хамтын ажиллагаа, барилгын төлөвлөлт, засвар үйлчилгээний талаар зааварчилгаа өгөх зэргээр хамтран ажиллах юм. Энэхүү мэдээлэл солилцоо болон үйл ажиллагааны спиралийг олон дахин давтан хэрэгжүүлсэнээр музейн үйл ажиллагааны чанарыг өндөр түвшинд хүргэх боломжтой болно.



Зураг 5-5: Яам дамнанас Музейн хөгжлийн хороо ба олон улсын хамтын ажиллагаа, дэмжлэгийг харуулсан схем зураг

4) [Хууль / дүрэм] Улаанбаатар хотын аялал жуулчлалын хөгжлийг тогтвортой болгох

Улаанбаатар хотын захирагч солигдсонтой холбогдуулан боловсон хүчин өөрчлөгдөж, бодлогод өөрчлөлт гарсан. Нийслэлийн аялал жуулчлалын дунд хугацааны хөтөлбөрийг яаралтай боловсруулж, хотын удирдлага өөрчлөгдсөн ч бодлого, хөтөлбөр нь хэвийн үргэлжлэх нөхцөлийг бүрдүүлэх нь Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд нэн чухал юм.

Нийслэлийн Аялал жуулчлалын газраас 2020 оны 12 -р сард гаргасан үйл ажиллагааны хөтөлбөр нь тулгарч буй бэрхшээлийг үнэн зөвөөр тодорхойлсон байгаа болно. Өөрөөр хэлбэл, эвент, арга

хэмжээ дутмаг, аялал жуулчлалын бүтээгдэхүүн хомс, үйлчилгээний чанар муу, мэдээлэл түгээлт хангалтгүй, МIСЕ зохион байгуулахгүй байгаа гэх мэт асуудлуудыг дурджээ. Засгийн газар болон Улаанбаатар хотын захиргаа хамтран, эдгээр асуудлыг шийдвэрлэх төлөвлөгөөг аль болох яаралтай боловсруулах шаардлагатай.

"Аялал жуулчлалын сан" -н үйл ажиллагааг сэргээж, аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэх, гадаад зах зээлд чиглэсэн мэдээлэл түгээлтийг сайжруулахад чиглүүлэх нь зүйтэй юм.

5) [Дэд бүтэц] Дэд бүтцийг хөгжүүлэх

Нийслэл хотын ойр орчимд аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэхдээ, улсын хэмжээний төсөл болгож хэрэгжүүлэх тохиолдол олонтаа байдаг. Дэд бүтцийг хөгжүүлэхэд хамгийн чухал асуудал бол олон улсын шинэ нисэх буудлыг ашиглалтад оруулах, нийтийн бие засах газрын тоог нэмэгдүүлэх, ногоон байгууламж, үндэсний цэцэрлэгт хүрээлэнг тохижуулах, явган хүний замыг хөгжүүлэх, үлэг гүрвэлийн музей байгуулах зэрэг юм. Японы Засгийн газрын дэмжлэгтэйгээр баригдсан олон улсын шинэ нисэх буудал нь 2021 оны 7-р сарын 4 -нд ашиглалтад орсон бөгөөд юуны өмнө нисэх буудлын үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэхийн тулд Ковид-19 халдварт цар тахлын дараа нислэг, чиглэлийг өргөжүүлэх бэлтгэл ажлыг хангах нь чухал. Үүний зэрэгцээ олон улсын нисэх буудлаас хотын төв рүү зорчдог төлбөртэй автобус (airport transfer), чөлөөтэй бууж, суух боломжтой жуулчдад зориулсан аяллын автобус (Hop on Hop out bus) , жуулчдын мэдээллийн төв зэрэг зүйл одоогоор байхгүй байгаа тул, цаашид бүрдүүлэх шаардлагатай юм.

Түүнчлэн төв зам дагуу аялал жуулчлалын үйлчилгээний цогцолбор (Мичи но Эки) барих, аялал жуулчлалын бүсэд нийтийн бие засах газрыг нэмж барих ажлыг жуулчид ихээр аялдаг Горхи-Тэрэлжийн БЦГ , Эрдэнэзуу сүмийн 20-30 байршилд улсын болон орон нутгийн төсвөөр хэрэгжүүлсэн байна. Жуулчдын амар амгалан, аюулгүй байдлыг хангах үүднээс нэн тэргүүнд эдгээрийг барих ёстой бөгөөд ялангуяа жуулчид ихээр зорчдог Улаанбаатар хотын ойр орчимд суурилуулах байршилыг яаралтай тодорхойлох шаардлагатай байгаа юм.

Улаанбаатар хотод ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн ховор. Ялангуяа зэрлэг шувуу, зэрлэг ан амьтдыг ажиглах байгалийн цэцэрлэгт хүрээлэн, явган аялал хийх зориулалттай явган хүний зам гэх мэт аялал жуулчлалын цэгүүдийг хөгжүүлэх нь зүйтэй юм. Богдхан уулын дархан цаазат газар нь экологийн үүднээс авч үзвэл хамгийн чухал газар боловч Зайсан толгойн нэг хэсэгт л зөвхөн явган хүний зам байдаг тул, хүмүүс явган хүний замаас гарч алхах зэргээр байгальд сөргөөр нөлөөлж байна. Богдхан уул орчмын биологийн олон янз байдлыг хангахын тулд богино, дунд, холын зайн явган аялал хийх замыг тодорхойлж, явган хүний зам тавих шаардлагатай байгаа болно.

Бусад маршрутын нэгэн адил жуулчид олноор очдог газруудад явган хүний зам тавих нь зүйтэй юм. Улаанбаатар хотын захын ойр орчимд Сэлбийн гол, Дунд гол орчмын явган хүний замыг сайжруулж чадвал гадаадын жуулчид төдийгүй хотын иргэдийн амарч зугаалах газар болох боломжтой. Ингэж тохижуулснаар хог хаягдлыг ялгаж хаях, орчноо хайрлах гэх мэт байгалийг хамгаалах сэтгэлгээг төлөвшүүлж, энэ нь тогтвортой аялал жуулчлалын хөгжилд хувь нэмэр оруулах юм (Монголын мэргэжилтнүүд Богдхан уулын тогтвортой аялал жуулчлалын мастер төлөвлөгөөг боловсруулж, Богдхан уулын байгаль экологийг хамгаалахад нэн тэргүүнд анхаарч, зохих аялал жуулчлалыг хөгжүүлэх санал тавьсан).

Монгол Улс руу нэвтрэх үүд хаалга болж байдгийг бодолцохын зэрэгцээ улсын төвийн бүс нутгийн онцлогт нийцсэн төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хөгжлийн бодлогыг схем зургаар харуулж байна. Үлэг гүрвэлийн музей байгуулах гэх мэт аялал жуулчлалын нөөцтэй холбоотой асуудлыг Монголын Засгийн газар болон холбогдох орон нутгийн засаг захиргаа хариуцах ба , ойр орчим дахь зочид буудал, зоогийн газар, зугаа цэнгэлийн газар гэх мэт үйлчилгээний цэгүүд байгуулах асуудлыг хувийн хэвшил болон ТББ-ууд хариуцна.



10

Зураг 5-6: Аялал жуулчлалыг хөгжүүлэх схем зураг (Улаанбаатар болон ойрын бүс)

5.3 Үйл ажиллагааны төлөвлөгөө (Action plan) /Төсөл/

5.3.1 Үйл ажиллагааны төлөвлөгөө (Action plan) -г хэрэгжүүлэх тэргүүлэх чиглэл

Судалгааны зорилтот бүс нутагт тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө (Action plan)-г боловсруулахдаа үндэсний болон орон нутгийн бодлого, төлөвлөгөөг сайтар харгалзаж үзэх шаардлагатай. Энэ бүлэгт танилцуулж байгаа үйл ажиллагааны төлөвлөгөө (Action plan)-д Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”, Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого болон бусад бодлогын баримт бичиг, тус бүрийн аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөөнд шууд болон шууд бус байдлаар тусгагдсан, эсвэл түүний үндсэн чиглэлтэй нийцэж байгаа асуудлуудаас судалгааны багийн тэргүүлэн шийдвэрлэх шаардлагатай гэж үзсэн асуудлуудыг сонгож, тэдгээрийг шийдвэрлэх арга хэмжээг тусгасан болно.

Энд дурдсан үйл ажиллагааны төлөвлөгөө (action plan)-г ахин сайтар судалж үзсэний үндсэн дээр ЖАЙКА-ийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх боломжтой хөтөлбөрийг төслийн санал болгон дараагийн бүлэгт оруулах болно. Ингэхдээ дараах зүйлсийг анхаарна. Үүнд, 1-т авто замыг сайжруулах (зам тавих, хатуу хучилттай болгох) тухайд улсын төлөвлөгөөнд тусгагдсан байгаа тул энэ хэсэгт зөвхөн төсөлд хамрагдаж буй орон нутгийн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд шаардлагатай хэсгийн тухай тусгасан бөгөөд энэ нь бусад авто замын бүтээн байгуулалт шаардлагагүй гэсэн үг биш юм. 2-т, энэ удаагийн судалгаанд хамрагдаж буй Хархорины бүс нутгийн тухайд, Монгол улсын БОАЖЯ болон АХБ хамтран төсөл хэрэгжүүлэхээр хэлэлцээрийн шатанд явж байгаа, мөн Германы хамтын ажиллагааны байгууллага (GIZ) нь соёлын өвийг хамгаалах чиглэлээр Орхоны хөндий орчимд хамтын ажиллагаа хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа гэсэн мэдээлэл байна. Тиймээс энэхүү бүс нутагт ЖАЙКА-ийн зүгээс хамтын ажиллагаа хэрэгжүүлэх тохиолдолд бусад хандивлагч орон, олон улсын байгууллагын хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаарх нарийн тодорхой мэдээллийг цуглуулах нь зүйтэй юм.

ЖАЙКА-ийн аялал жуулчлалын салбар дахь хамтын ажиллагааны үндсэн чиглэл, зорилго нь аялал жуулчлалын салбар дахь эдийн засгийн болон нийгмийн давуу тал нь хүлээн авагч орон болон бүс нутагт жигд бөгөөд тогтвортой байдлаар үр дүнгээ өгөхөд дэмжлэг үзүүлэх явдал бөгөөд дараах 4 зүйлийг багтаасан агуулгатай байна. Үүнд, 1-т аялал жуулчлалын салбарын хөгжлийн үндэс болох бодлого боловсруулах, 2-т аялал жуулчлалын нөөцийг хамгаалах, хөгжүүлэх, хяналт тавих, 3-т аялал жуулчлалыг хөгжүүлэх хүний нөөц болон байгууллагын чадавхыг сайжруулах, 4-т дэд бүтцийг төлөвлөх, бэхжүүлэх, хяналт тавих, зохион байгуулах чадварыг дээшлүүлэх гэсэн байгаа болно. Бодлого боловсруулалт нь улсын хэмжээнд хэлэлцэгдэх

асуудал бөгөөд энэ удаагийн тайлан нь зорилтот судалгааны бүсээр хязгаарлагдах тул энэ тухай дурдахгүй. Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх өөр нэгэн гол хүчин зүйл бол жуулчдын амар амгалан, аюулгүй байдлыг хангах явдал юм. Ялангуяа хөгжиж буй орнуудад энэ нь тун чухал бөгөөд ЖАЙКА-ийн хамтын ажиллагааны үндсэн чиглэлтэй ч мөн уялдаж байгаа тул энэ асуудлыг гол асуудал болгон дэвшүүлэн тусгасан болно. Эдгээрт үндэслэн төсөлд хамрагдаж буй орон нутаг дахь хамтын ажиллагааны агуулгыг дараах байдлаар ангилав.

Хүснэгт 5-2: Нэн тэргүүнд тавигдаж буй асуудлууд, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн хамтын ажиллагааны агуулгын санал

Ач холбогдол	Нэн тэргүүнд тавигдаж буй асуудлууд	Хамтын ажиллагааны агуулгын санал
Нэн чухал	Аялал жуулчлалын салбарыг удирдах тогтолцоог сайжруулах	Аялал жуулчлалын зөвлөлийг байгуулж, төрийн албан хаагч болон ТББ-ын чадавхийг нэмэгдүүлэх
Нэн чухал	Аялал жуулчлалын нөөцийг хамгаалах, хадгалах	Нөөцийг хамгаалах төлөвлөгөөг боловсруулах, тусгай хамгаалалттай бүс нутгийн хил хязгаарыг (явган хүний зам, тэмдэг тэмдэглэгээ) тодорхой болгох, отоглох цэг, майхан барьж хоноглох газрыг тогтоож өгөх, машины зогсоол тавих
Нэн чухал	Жуулчдын амар амгалан, аюулгүй байдлыг хангах	Шаардлага хангасан нийтийн бие засах газар, авто замын хатуу хучилт, аяллын танилцуулга самбар, отоглох цэг, майхан барьж хоноглох газар, машины зогсоол, замын тэмдэглэгээ, аялал жуулчлалын мэдээллийн төв, зам дагуух амралт, үйлчилгээний цогцолбор
Чухал	Маркетинг, сурталчилгааг бэхжүүлэх	Маркетинг, сурталчилгааны стратеги боловсруулахад дэмжлэг үзүүлэх (зорилгоо тодорхойлох, дүн шинжилгээ хийсний үндсэн дээр зорилтот бүлгийг тодорхойлох, бүс нутаг тус бүрийн өрсөлдөх давуу тал, онцлогийг нарийн тодорхой болгох, зорилтот бүлэгт хандсан мэдээллийн технологийг ашигласан бодит сурталчилгааны агуулгыг хэлэлцэж шийдвэрлэх, хэрэгжүүлэх)
Чухал	Дэд бүтцийг хөгжүүлэх	Авто замыг засах, зам дагуух түр амралт, үйлчилгээний цогцолбор, нийтийн бие засах газар, отоглох цэг, майхан барьж хоноглох газар, машины зогсоол
Хэвийн	Эвент хөгжүүлэх	Шинэ эвент, нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулах, хөгжүүлэх
Хэвийн	Аялал жуулчлалын бүтээгдэхүүн хөгжүүлэх	Аяллын шинэ чиглэл, цэг, тодорхой сэдэв бүхий зорилтот аяллыг бий болгох
Хэвийн	Нутгийн иргэдийн оролцоо (СВТ)	Гэр бааз ажиллуулах удирдамж, шинэ бүтээгдэхүүн боловсруулах (эсгий урлал, сүү сүүн бүтээгдэхүүн, чулуун болон модон эдлэл)

5.3.2 Судалгааны зорилтот бүс нутгуудад нийтэд нь хамаарах үйл ажиллагааны төлөвлөгөө (Action plan)

Дээрх Хүснэгт 5-2-д дурдсан хамтын ажиллагааны агуулгын саналын дагуу энэ удаагийн судалгаанд хамрагдаж буй бүс нутгуудад нийтэд нь хамаарах үйл ажиллагааны төлөвлөгөөг дараах байдлаар нэгтгэв. Дараагийн бүлэгт санал болгох төслийн саналыг ЖАЙКА-ийн хамтын ажиллагааны ямар схемийн хүрээнд хэрэгжүүлэх боломжтойг хэлэлцэхэд энэхүү судалгаанд хамрагдаж буй бүс нутгуудад нийтэд нь хамаарах асуудлуудыг хэлэлцэх нэн шаардлагатай юм.

Хүснэгт 5-3: Судалгааны зорилтот бүс нутгуудад нийтэд нь хамаарах үйл ажиллагааны төлөвлөгөө (Action plan)

Үйл ажиллагааны төлөвлөгөө (Action plan)
<p>(1) Аялал жуулчлалын салбарын удирдах тогтолцоог сайжруулах</p> <p>○ Аймаг тус бүрийн байгаль орчин, аялал жуулчлалын газар, зочид буудлын салбарт бизнес эрхлэгчид, ТББ, аялал жуулчлалын салбарын үйл ажиллагаа эрхэлдэг орон нутгийн иргэдийн оролцоотойгоор, харилцан мэдээлэл солилцдог аялал жуулчлалын зөвлөлийг байгуулах, үүнд шаардлагатай стандарт, үйл ажиллагааны чиглэлийг боловсруулж, эхлүүлэх. Ингэснээр хоорондын хамтын ажиллагаа уялдаа холбоотой болж, мэдээлэл солилцох тогтолцоог бүрдүүлэх.</p> <p>○ Аймгийн албан хаагч болон ТББ-ын ажилтнуудын бодлого боловсруулах, төлөвлөгөө хэрэгжүүлэх чадамжийг сайжруулахын тулд аялал жуулчлалын тухай үндсэн ойлголт, мэдлэгийг олгох, ноухауг эзэмшүүлэх сургалтыг явуулах.</p>
<p>(2) Аялал жуулчлалын нөөцийг хамгаалах, хадгалах</p> <p>○ Бүс нутгийн аялал жуулчлалын цэг болон цаашид аялал жуулчлалын цэг болох боломж бүхий үндэсний цэцэрлэгт хүрээлэн, тусгай хамгаалалттай бүс нутаг дах нөөцийн хадгалалтын байдлын тухай суурь мэдээлэл цуглуулах.</p> <p>○ Дээрх судалгаанд үндэслэн, аялал жуулчлалын нөөцийг хамгаалахын тулд жуулчдын алхах явган замыг тодорхой болгож, түүний дагуу явахад чиглүүлэх арга хэрэгсэл (тэмдэглэгээ, самбар) байрлуулах.</p> <p>○ Аялал жуулчлалын нөөцийг хамгаалахын тулд жуулчдын отоглох цэг, майхан барьж хоноглох газрыг тогтоож, машины зогсоол, ус, нийтийн бие засах газар зэрэг байгууламжийн тухай техникийн үзүүлэлтийг тодорхой болгож байгуулах.</p>
<p>(3) Жуулчдын амар амгалан, аюулгүй байдалыг хангах</p> <p>○ Аяллын зорилтот газар хүртэлх замд түр амрах цэг болон аяллын газрын ойр орчимд авто замын дагуух амралт, үйлчилгээний цогцолбор болон стандартад нийцсэн нийтийн бие засах газар зэргийг улсын төлөвлөгөөтэй уялдуулан байршлыг тогтоож, байгуулах. Нийтийн бие засах газрын техникийн үзүүлэлтийн хувьд гадаадын жуулчид ашиглахад тав тухтай байх, Монголын хүйтэн сэрүүн улиралд тохирсон, тогтмол ажиллуулах боломжтой байх шаардлагыг тавиж санал болгох.</p> <p>○ Аялал жуулчлалын цэг хүртэлх замын тэмдэглэгээ, самбар, тэдгээрийг байршуулах байрлал, тавигдах шаардлагын тухай санал боловсруулан хүргүүлэх, байрлуулах.</p>
<p>(4) Маркетинг, сурталчилгааны стратеги боловсруулах, хэрэгжүүлэх</p> <p>○ Маркетинг, сурталчилгааны стратегийн зорилтыг тодорхойлж, дүн шинжилгээ хийсэн үндсэн дээр зорилтот бүлгийг тодорхой болгох, бүс нутаг тус бүрийн өрсөлдөх давуу тал, онцлогийг нарийн тодорхой болгох, бүс нутаг тус бүрийн нөөц бололцоонд тулгуурлан, зорилтот бүлэгт хандсан мэдээллийн технологийг ашигласан бодит сурталчилгааны агуулгыг хэлэлцэж, хэрэгжүүлэх тогтолцоог бий болгох.</p>
<p>(5) Нутгийн иргэдийн оролцоо ба хүний нөөцийг бэхжүүлэх</p> <p>○ Аймаг болон шинээр байгуулагдах аялал жуулчлалын зөвлөлөөс орон нутгийн иргэдийн аялал жуулчлалын тухай мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн санал зөвлөмж боловсруулж, удирдамж өгөх.</p> <p>○ Аялал жуулчлалын үйлчилгээний салбарын ажилчдын (менежер, тогооч, зөөгч гэх мэт) чадавхийг сайжруулахад чиглэсэн сургалт зохион байгуулах.</p> <p>○ Гэр бааз ажиллуулагчдад удирдамж өгөх (байгаль хамгаалал, эрүүл ахуй, нийтийн бие засах газрын стандарт гэх мэт)</p>
<p>(6) Бусад</p> <p>○ Аялал жуулчлалын салбарын статистикийн тухайд, мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, цуглуулсан мэдээллийг нийтэд түгээх аргачлалыг боловсронгуй болгож, нэгдсэн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх.</p>

5.3.3 Маршрут тус бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөө (Action plan)

Судалгаанд хамрагдсан бүс нутаг тус бүрийн бодит асуудлуудыг шийдэхэд чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөгөөний саналыг дараах байдлаар харуулав. Техникийн хамтын ажиллагаа, буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл гэх мэт схемүүдийг зохистой ашиглах замаар аль болох олон асуудлыг шийдвэрлэх зорилготой боловч санхүүжилт хязгаарлагдмал бөгөөд алийг нь сонгож, ямар схемээр хэрэгжүүлэх талаар дараагийн бүлэгт тайлбарлах болно.

(1) Өмнөговийн маршрут

Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газар болон ТББ-уудын боловсруулсан 100 гаруй аялал жуулчлалыг хөгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө байдаг. Улс, аймаг хэрэгжүүлэх, аймаг болон эрдэм шинжилгээний байгууллагууд хэрэгжүүлэх, ТББ хэрэгжүүлэх гэх мэт хэрэгжүүлэгч байгууллага тус бүрээр нь зааж тодорхойлсон байгаа болно. Жагсаалтад маш олон төрлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн байгаа хэдий ч санхүүгийн эх үүсвэр нь тодорхойгүй зүйл их байна. Судалгааны багийн зүгээс нэн тэргүүнд хэрэгжүүлэх ёстой хэмээн үзэж буй төслүүдийг дараах байдлаар нэгтгэв.

Хүснэгт 5-4: Өмнөговийн маршрутын аялал жуулчлалыг хөгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө (Action Plan)

Сэдэв	Үйл ажиллагааны төлөвлөгөө (Action Plan)	Хэрэгжүүлэгч байгууллага
Аялал жуулчлалын нөөцийг хамгаалах, хадгалах	<p>① Хэрмэн цав болон бусад аймгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын байдлын нарийвчилсан судалгаа хийх, жуулчны явах зам, жим, мэдээллийн самбар, хамгаалалтын хашлага гэх мэт байгууламжийг суурилуулах төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх.</p> <p>② Аялал жуулчлалын цэгүүдийн хүрээлэн буй орчныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх (нийтийн бие засах газар, отоглох цэг, майхан барьж хоноглох зориулалтын талбай бэлтгэх, хамгаалалтын хашлага барих, чиглүүлэгч зам, тэмдэг, мэдээллийн самбар байрлуулах гэх мэт).</p> <p>③ Аялал жуулчлалын нөөцийн менежментийн хөтөлбөрийг боловсруулах (Тост, Тосон бумбын нурууны байгалийн нөөц газар, ховор ан амьтдыг үржүүлэх, нутагшуулах гэх мэт).</p> <p>④ Зарим тусгай хамгаалалттай газар нутгийн (ховор ан амьтдын амьдрах орчин) хамгаалалтын менежментийн ажил үүргийг орон нутгийн иргэдэд хүлээлгэх боломжийг судлах.</p>	<p>① БОАЖЯ, Аймаг, ТББ</p> <p>② ЗТХЯ, Аймаг, ТББ</p> <p>③ БОАЖЯ, Аймаг, ТББ, Мэргэжлийн байгууллагууд</p> <p>④ БОАЖЯ, Аймаг, ТББ</p>
Дэд бүтцийг хөгжүүлэх	<p>① Гурвансайхан нисэх онгоцны буудлыг олон улсын чанартай болгох (Засгийн газрын төлөвлөгөөнд тусгагдсан)</p> <p>② Гурвантэс чиглэлийн хатуу хучилттай замыг барьж дуусгах (Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөө 2020-2024-д тусгагдсан), Ёлын ам хүртэл хатуу хучилттай зам барих шаардлагатай (улсын төсөв)</p>	<p>① Засгийн газар, Аймаг</p> <p>② ЗТХЯ, Аймаг</p>
Жуулчдын амар амгалан, аюулгүй байдлыг хангах	<p>① Зам дагуу цогцолбор байгууламж ("Мичи но Эки буюу Замын өртөө"-ний монгол хувилбар) барьж байгуулах (Мандалговь, Говийн гуанз, Цогт-Овоо, Даланзадгад, Баяндалай, Булган, Цогтцэций, Ханбогд)</p> <p>② Нийтийн бие засах газар суурилуулах (Мандалговь, Баяндалай, Булган, Далан гол зэрэг газруудад тэргүүн ээлжээр)</p>	<p>① БОАЖЯ, ЗТХЯ, Аймаг, Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт</p> <p>② Дээрх ①-д заасан дээр нэмээд сумд</p>
Иргэдийн оролцоо, хүний нөөцийн хөгжил	<p>① Аялал жуулчлалын салбарын ажилчдад зориулсан "Зочлох үйлчилгээ"-ний сургалт зохион байгуулах.</p> <p>② Гэр бааз эрхлэгчид болон эрхлэхийг сонирхогчдод менежментийн сургалт зохион байгуулах (Ёлын амаас</p>	<p>① Аймаг, ТББ</p>

Сэдэв	Үйл ажиллагааны төлөвлөгөө (Action Plan)	Хэрэгжүүлэгч байгууллага
	бусад газарт гэр баазын үйлчилгээ дэлгэрүүлэх шаардлагатай). ③ Элбэг байдаг мана, гаргаам, угаат болор зэрэг чулуугаар бэлэг дурсгалын зүйл боловсруулах ур чадвар, техник технологийн сургалт хийх (ажиллаж эхэлсэн ажилчдыг санхүүжилт олгох). ④ Шинэ жуулчны мэдээллийн төвийг нутгийн иргэдээр удирдан ажиллуулах, аялал жуулчлалын мэдээллийн төв байгуулах (Хонгорын элс, Нэмэгтийн хонгил, Хэрмэн цав).	
Маркетинг, сурталчилгааг сайжруулах	① Маркетинг, сурталчилгааны стратегийг боловсруулах (зорилтыг тодорхойлох, дүн шинжилгээ хийсний үндсэн дээр зорилтот бүлгийг тодорхой болгох, бүс нутгийн зорилтот зах зээл дэх өрсөлдөх давуу тал, онцлогийг нарийн тодорхой болгосны үндсэн дээр мэдээллийн технологийг ашигласан бодит сурталчилгааны агуулгыг боловсруулж, хэрэгжүүлэх тогтолцоог бий болгох).	① Аймаг
Аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх	① Даланзадгай цэцэрлэгт хүрээлэн байгуулах (шувуу ажиглах бааз болгон хөгжүүлэх). ② Өмнөговийн музейн (2021 онд ашиглалтад орох төлөвлөгөөтэй) олон улсын стандартчилал ба менежментийн чадварыг сайжруулах.	① Аймаг, ТББ
Аялал жуулчлалын статистикийн мэдээллийг боловсронгуй болгох	① Аялал жуулчлалын салбарын статистикийн тухайд, мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, цуглуулсан мэдээллийг нийтэд түгээх аргачлалыг боловсронгуй болгож, нэгдсэн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх.	Аймаг, тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаа

(2) Дорноговийн маршрут

Хүснэгт 5-5: Дорноговийн маршрутын аялал жуулчлалыг хөгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө (Action Plan)

Сэдэв	Үйл ажиллагааны төлөвлөгөө (Action Plan)	Хэрэгжүүлэгч байгууллага
Аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулах	① Говьсүмбэр, Дорноговь аймгийн аялал жуулчлалын мастер төлөвлөгөөг боловсруулах (Энэ 2 аймгийн хувьд аялал жуулчлал нь харьцангуй шинэ салбар болох ба холбогдох талууд туршлага багатай тул иж бүрэн судалгаа хийх шаардлагатай) ② Аймгийн Засаг даргын дэргэд аялал жуулчлалын зөвлөл байгуулах ③ Аялал жуулчлалын бодлого хариуцсан мэргэжилтэн, ТББ-уудын чадавхийг бэхжүүлэх	Говьсүмбэр, Дорноговь аймаг
Аялал жуулчлалын нөөцийг хамгаалах, хадгалах	① Аймгийн аялал жуулчлалын нөөцийн талаарх суурь судалгааг хийж, менежментийн хөтөлбөрийг боловсруулах ② Хамарын хийд ба Энергийн төв дээр орчин үеийн нийтийн бие засах газар суурилуулах ③ Хамарын хийд ба Энергийн төв, Их нартын байгалийн нөөц газар зэрэг аялал жуулчлал хөгжиж эхэлсэн газруудад отоглох цэг, майхан	① Дорноговь, Говьсүмбэр аймаг ② БОАЖЯ, Дорноговь аймаг ③ Дээр заасан дээр нэмээд ЗТХЯ, Сум

Сэдэв	Үйл ажиллагааны төлөвлөгөө (Action Plan)	Хэрэгжүүлэгч байгууллага
	барьж хоноглох зориулалтын талбайг бэлтгэх, хамгаалалтын хашлага, чиглүүлэгч зам, тэмдэг, мэдээллийн самбар зэргийг байршуулах. ④ Аялал жуулчлалын зам дээр тэмдэг, мэдээллийн самбар суурилуулах (Машины хөдөлгөөний маршрутыг зохицуулах зорилготой) Зорилтот газар: Говийн бага дархан цаазат газар, Их наргын чулуу, Цонжин чулуу, Загийн ус, Эргэлийн зоо, Сүйхэнтийн чулуужсан ой, Чойрын Богд уул, Хэсэг байшинт, Олон байшинтын дурсгалууд)	
Дэд бүтцийг хөгжүүлэх	① Төв замаас аялал жуулчлалын цэг хүртэлх хатуу хучилттай авто зам барих	Улс
Жуулчдын амар амгалан, аюулгүй байдлыг хангах	① Нийслэлээс Чойр хот, Чойр хотоос Сайншанд, Замын-Үүд хүртэлх зам дагуу боловсон бие засах газрыг дор хаяж хоёр газар байгуулах ② Чойрын Богд уулын тусгай хамгаалалттай газар, Чойр, Хамарын хийд, Энергийн төв, Сайншанд, Их нарт зэрэг газарт орчин үеийн нийтийн бие засах газар байгуулах ③ Дээрх газарт жуулчдад зориулсан авто машины зогсоол, отоглох цэг, майхан барьж хоноглох зориулалтын талбайг гаргах	① БОАЖЯ, ЗТХЯ, Аймаг, Сум
Маркетинг, сурталчилгааг хөгжүүлэх	① Маркетинг, сурталчилгааны стратегийг боловсруулах (зорилтыг тодорхойлох, дүн шинжилгээнд үндэслэн зорилтот бүлгийг тодорхойлох, бүс нутгийн зорилтот зах зээл дэх өрсөлдөх давуу тал, онцлогийг нарийн тодорхой болгосны үндсэн дээр мэдээллийн технологийг ашигласан бодит сурталчилгааны агуулгыг хэлэлцэж, хэрэгжүүлэх тогтолцоог бий болгох)	① Аймаг
Аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх	① Аялал жуулчлалыг хөгжүүлэх менежмент, төмөр зам ашигласан аялал жуулчлалын бүтээгдэхүүн боловсруулах, аялал жуулчлалын газрын зураг бүтээх	Улаанбаатар Төмөр Зам, Аймаг, ТББ
Иргэдийн оролцоо	① Морь, тэмээн аялал хийх үйлчилгээ эрхлэх боломжтой малчдын жагсаалтыг гаргах, үйлчилгээ эрхлэхэд нь зөвлөгөө өгөх ② Ардын дуу хөгжим, бүжиг тоглох чадвартай мэргэжлийн уран бүтээлч, уран сайханч нарын жагсаалт гаргах ③ Хөмүүлээс бусад төрлийн бараа бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, ноолуур, үнэт чулуу боловсруулах, цагаан идээ, сүүн бүтээгдэхүүн боловсруулах, гэр бааз ажлуулах менежментийн зөвлөгөө өгөх	Аймаг
Хүний нөөцийн хөгжил	① Зочид буудал, ресторан, хөтөч, хэлмэрч, жолоочийн чадварыг дээшлүүлэх сургалт, хүнсний аюулгүй байдлын сургалт	Аймаг

Сэдэв	Үйл ажиллагааны төлөвлөгөө (Action Plan)	Хэрэгжүүлэгч байгууллага
Аялал жуулчлалын талаарх ойлголтыг гүнзгийрүүлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа	① Хамарын хийд, Баянзүрх уулнаас бусад, Их нартын ойр орчим, Замын-Үүдийн чөлөөт бүс, Чойрын Богд уулын ойр орчмын иргэд болон аж ахуй эрхлэгчдэд зориулж аялал жуулчлалын эдийн засгийн үр ашиг, аялал жуулчлалын үйл ажиллагаанд оролцох ач холбогдлын талаарх ухуулга, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа	Аймаг
Аялал жуулчлалын статистикийн мэдээллийг боловсронгуй болгох	① Аялал жуулчлалын статистикийн талаар мэдээлэл цуглуулах аргачлал, цуглуулсан мэдээллийг цэгцлээд, дүн шинжилгээ хийх, нийтийн хүртээл болгох аргыг тодорхойлох гэх мэт үйл ажиллагааны тогтолцоог бүрдүүлэх.	Аймаг

(3) Хархорины маршрут

Хүснэгт 5-6: Хархорины маршрутын аялал жуулчлалыг хөгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө (Action Plan)

Сэдэв	Үйл ажиллагааны төлөвлөгөө (Action Plan)	Хэрэгжүүлэгч байгууллага
Хэрэгжүүлэх тогтолцоо (аялал жуулчлалын салбар доторх хамтын ажиллагааг бэхжүүлэх)	① Аймгийн Засаг даргын дэргэд аялал жуулчлалын зөвлөл байгуулах (одоо байгаа зөвлөлүүдийг идэвхжүүлэх) ② Төрийн албан хаагчид болон ТББ-уудын төлөвлөгөө боловсруулах чадварыг сайжруулах	Архангай, Өвөрхангай аймаг
Аялал жуулчлалын нөөцийг хамгаалах, хадгалах	① Соёлын дурсгалт газрын хадгалалт, хамгаалалтын байдлыг судалж, газрын зураг боловсруулах ② Тусгай хамгаалалттай газар нутаг, аялал жуулчлалын цэгүүдэд машины зогсоол, отоглох цэг, майхан барьж хоноглох зориулалтын талбай байгуулах, хамгаалалтын хашлага чиглүүлэгч зам, тэмдэг, аялал жуулчлалын мэдээллийн самбар байрлуулах гэх мэт ③ (Дээрх①②-ыг GIZ болон АХБ-ны хамтын ажиллагаатай давхцуулахгүй байхыг анхаарах) ④ Дэлхийн өв "Орхоны хөндийн соёлын дурсгалт газар"-ын зорилтот бүсэд багтсан аялал жуулчлалын томоохон зам, маршрутуудад замын тэмдэг, мэдээллийн самбарыг нийтлэг болгон суурилуулах.	Соёлын яам, БОАЖЯ, Архангай, Өвөрхангай аймаг
Дэд бүтцийг хөгжүүлэх	① Хархорины нисэх онгоцны буудлыг хөгжүүлэх, олон улсын нисэх буудал болгох ② Хөшөө Цайдаас Зүүн-Баруун зүгийн төв зам хүртэлх замын хатуу хучилт (Өвөрхангай, Архангай аймгийг аялал жуулчлалын замаар нэвтрэх)	① Засгийн газар, Өвөрхангай аймаг ② Засгийн газар, хоёр аймаг
Жуулчдын амар амгалан, аюулгүй байдлыг хангах	① Боловсон бие засах газар суурилуулах (Эрдэнэ зуу, Хөшөө Цайдам, Өгий нуур, Орхон хүрхрээ, Хар балгас зэрэг аялал жуулчлалын гол цэгүүд)	① Өвөрхангай, Архангай аймаг ② ЗТХЯ, Аймаг, БОАЖЯ

Сэдэв	Үйл ажиллагааны төлөвлөгөө (Action Plan)	Хэрэгжүүлэгч байгууллага
	<p>② Аялал жуулчлалын томоохон цэгүүдэд замын тэмдэг, авто зогсоол, майхан барьж хоноглох зориулалтын талбай /устай/ байгуулах</p> <p>③ Жуулчны баазын зэрэглэлийг тогтоох (гэрчилгээ олгох), зэрэглэлийн дагуу үйлчилгээг сайжруулах хөтөлбөр боловсруулах</p>	③ Аймаг
Маркетинг, сурталчилгааг хөгжүүлэх	① Маркетинг, сурталчилгааны стратегийг боловсруулах (зорилтыг тодорхойлох, дүн шинжилгээнд үндэслэн зорилтот бүлгийг тодорхойлох, бүс нутгийн зорилтот зах зээл дэх өрсөлдөх давуу тал, онцлогийг нарийн тодорхой болгосны үндсэн дээр мэдээллийн технологийг ашигласан бодит сурталчилгааны агуулгыг хэлэлцэж, хэрэгжүүлэх тогтолцоог бий болгох)	Өвөрхангай аймаг, Архангай аймаг
Аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх	① Дотоодын жуулчдад зориулсан аялал жуулчлалын газрын зураг боловсруулах (олон нийтэд сайн танигдаагүй байгаа аялал жуулчлалын газруудын зар сурталчилгаа)	Өвөрхангай аймаг, Архангай аймаг
Бэлэг дурсгалын зүйл боловсруулах	① Эсгий болон сүүн бүтээгдэхүүний чанарыг сайжруулах зөвлөгөө өгөх, шинэ бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх боломжийг судлах	Өвөрхангай аймаг, Архангай аймаг
Иргэдийн оролцоо, хүний нөөцийн хөгжил	<p>① Гэр баазын менежмент ба зочлох үйлчилгээний талаар зөвлөгөө өгөх</p> <p>② Аялал жуулчлалын салбарын ажилчдад зориулсан сургалт</p> <p>③ Иргэдэд зориулсан соён гэгээрүүлэх үйл ажиллагаа болгон, орон нутгийн оршин суугчид, бага, дунд, ахлах сургуулиудад зориулсан аялал жуулчлалын тухай семинар, аялал жуулчлалын газрын зургийг хамтарч боловсруулах</p>	Өвөрхангай аймаг, Архангай аймаг
Аялал жуулчлалын статистикийг боловсронгуй болгох	① Аялал жуулчлалын статистикийн талаар мэдээлэл цуглуулах аргачлал, цуглуулсан мэдээллийг цэгцлээд, дүн шинжилгээ хийх, нийтийн хүргээл болгох аргыг тодорхойлох гэх мэт үйл ажиллагааны тогтолцоог бүрдүүлэх.	БОАЖЯ

(4) Улаанбаатар хот орчмын маршрут

Хүснэгт 5-7: Улаанбаатар хот орчмын маршрутын аялал жуулчлалыг хөгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө (Action Plan)

Сэдэв	Үйл ажиллагааны төлөвлөгөө (Action Plan)	Хэрэгжүүлэгч байгууллага
Бодлого/ Төлөвлөгөө	① Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх мастер төлөвлөгөөг шинээр боловсруулах (Богдхан уулын тогтвортой аялал жуулчлалын хөгжлийн судалгааг багтаасан болно)	Нийслэл хот

Сэдэв	Үйл ажиллагааны төлөвлөгөө (Action Plan)	Хэрэгжүүлэгч байгууллага
	<ul style="list-style-type: none"> ② “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийг сэргээж, үргэлжлүүлэх ③ Аялал жуулчлалын санг ашиглан нийслэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх 	
Аялал жуулчлалын нөөцийг хамгаалах, хадгалах	<ul style="list-style-type: none"> ① Аялал жуулчлалын нөөцийн менежментийн хөтөлбөрийг боловсруулах (Горхи-Тэрэлжийн эмх цэгцгүй, системгүй хөгжлийн өнөөгийн байдлын судалгаа, Богдхан уулын дархан цаазат газрын байгалийн үзэмж, ландшафыг хамгаалах арга хэмжээ) ② Богдхан уулын явган аяллын маршрутын засвар үйлчилгээ (нийтийн бие засах газар, отоглох цэг, майхан барьж хоноглох зориулалтын газар, хамгаалалтын хашлага, хөтөч зам, тэмдэг, мэдээллийн самбар гэх мэтийг байрлуулах) 	<ul style="list-style-type: none"> ① БОАЖЯ, Нийслэл хот ② Дээрхтэй адил
Дэд бүтцийг хөгжүүлэх	<ul style="list-style-type: none"> ① Сэлбэ гол, Дунд голын ойр орчимд явган хүний гүүр, зам тавих, самбар байрлуулах 	БОАЖЯ, Нийслэл хот
Жуулчдын амар амгалан, аюулгүй байдлыг хангах	<ul style="list-style-type: none"> ① Боловсон бие засах газар суурилуулах ② Авто машины зогсоол, отоглох цэг, майхан барьж хоноглох зориулалтын газар байгуулах ③ Хүнсний аюулгүй байдлын арга хэмжээний сургалт явуулах ④ Аялал жуулчлалын статистикийн аргаас суралцах ⑤ Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хот дотор тойрон аялах автобусны аяллыг хэрэгжүүлэх 	<ul style="list-style-type: none"> ① БОАЖЯ, Нийслэл хот ② Дээрхтэй адил ③ ЭМЯ ④ ҮСХ, Их дээд сургуулиуд
Маркетинг, сурталчилгааг хөгжүүлэх	<ul style="list-style-type: none"> ① Маркетинг, сурталчилгааны стратегийг боловсруулах (зорилтыг тодорхойлох, дүн шинжилгээнд үндэслэн зорилтот бүлгийг тодорхойлох, бүс нутгийн зорилтот зах зээл дэх өрсөлдөх давуу тал, онцлогийг нарийн тодорхой болгосны үндсэн дээр мэдээллийн технологийг ашигласан бодит сурталчилгааны агуулгыг хэлэлцэж, хэрэгжүүлэх, сайжруулах тогтолцоог бий болгох) 	<ul style="list-style-type: none"> ① Нийслэл хот
Аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх	<ul style="list-style-type: none"> ① Үлэг гүрвэлийн музей байгуулах, үйл ажиллагааны менежментийг бэхжүүлэх ② Өвлийн аялал жуулчлалын голлох үзмэрийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх ③ Туул гол дээр дэлхийн хамгийн урт байгалийн тэшүүрийн талбайг нээх ④ Тэгсгэм хүйтнийг амсах хямд аялал 	<ul style="list-style-type: none"> ① Соёлын яам, Палеонтологийн хүрээлэн ② Нийслэлийн аялал жуулчлалын газар
Бэлэг дурсгалын зүйлийн чанарыг сайжруулах	<ul style="list-style-type: none"> ① Бэлэг дурсгалын зүйлд дүн шинжилгээ хийх, үнэлэх (жуулчдын хэрэгцээ, үйлдвэрлэлийн хүчин чадал гэх мэт) ② Зорилтот бүлэгт тохирсон бүтээгдэхүүн боловсруулах, борлуулалтын аргуудад дүн шинжилгээ хийх, удирдамж, зөвлөгөө өгөх 	Нийслэл хот, ЖДҮ эрхлэгчдийн холбоо, Бэлэг дурсгалын зүйл үйлдвэрлэгчид

Сэдэв	Үйл ажиллагааны төлөвлөгөө (Action Plan)	Хэрэгжүүлэгч байгууллага
Хүний нөөцийн хөгжил	① Аялал жуулчлал хариуцсан төрийн албан хаагчдын чадавхийг дээшлүүлэх сургалт (Японд сургалтад хамруулах) ② Их дээд сургууль, мэргэжлийн сургуулийн багш нарын чадавхийг сайжруулах ③ Зочид буудал, рестораны ажилтнууд, хөтөч, хэлмэрч, жолооч нарын ур чадварыг дээшлүүлэх сургалт ④ Байгаль хамгаалах ажилчдад зориулсан хөтчийн сургалт	① Нийслэл хот ② Нийслэл хот, сургуулиуд ③ Нийслэл хот, холбогдох байгууллагууд ④ БОАЖЯ
Аялал жуулчлалын талаарх ойлголтыг гүнзгийлүүлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа	① Цаашид дотоодын аялагчид болж төлөвших хүүхдүүдэд зориулсан байгаль, аялал жуулчлалын сургалт (Монголын үзэсгэлэнт байгаль, соёлын өв, аяллын ёс зүйн сургалт, олон улсын хүүхдийн зуслан зэрэг боловсролын байгууламжийг шинэчлэх)	① Нийслэл хот, БШУЯ
Аялал жуулчлалын статистикийг боловсронгуй болгох	① Аялал жуулчлалын статистикийн талаар мэдээлэл цуглуулах аргачлал, цуглуулсан мэдээллийг цэгцлэх, дүн шинжилгээ хийх, нийтийн хүртээл болгох аргыг тодорхойлох гэх мэт үйл ажиллагааны тогтолцоог бүрдүүлэх.	Нийслэл хот, ҮСХ

6-р бүлэг

Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх
ЖАЙКА-ийн хамтын ажиллагааны
хөтөлбөрийн санал дэвшүүлэх

6-р бүлэг Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх ЖАЙКА-ийн хамтын ажиллагааны хөтөлбөрийн санал дэвшүүлэх

Аялал жуулчлалын салбарт өмнө хийгдсэн судалгаа болон маршрут тус бүр дэх аялал жуулчлалыг хөгжүүлэх саналыг нэгтгэн дүгнэж, Монголын аялал жуулчлалын хөгжилд хувь нэмэр оруулах зорилготойгоор ЖАЙКА-ийн хамтын ажиллагааны төслийн саналыг дэвшүүлэн гаргалаа. Ингэхдээ Япон улсын тусламж, хамтын ажиллагааны бодлоготой уялдуулан дараах гурван зүйлийн дагуу эрэмбэлж байна. Үүнд:

- ① Судалгаа хийгдсэн бүс нутгийн нөхцөл, хэрэгцээ, шаардлага
- ② Санал болгож буй төслийг хэрэгжүүлснээр аялал жуулчлалын салбарт оруулах хувь нэмэр
- ③ Орон нутгийн иргэд, олон нийт, засаг захиргаа болон аялал жуулчлалтай холбогдох талуудын идэвх санаачилга, хүсэл эрмэлзэл

【Товч тойм】

Улаанбаатар хотыг эс тооцвол орон нутгийн засаг захиргаанд аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн 1 хүн л байдаг ба мэргэжилтэн дутагдалтай байдаг учраас цаашид Япон улсын техникийн хамтын ажиллагааны төсөл болон олон улсын бусад төсөл хөтөлбөрүүд хэрэгжих явцад хүний нөөцийн хүчин чадал, мэргэжлийн туршлага чадамжийн хувьд бэрхшээлтэй болох нь энэ удаагийн судалгаагаар тодорхойлогдсон. Тиймээс ЖАЙКА-ийн хамтын ажиллагааны хөтөлбөрийг санал болгохдоо мэргэжлийн боловсон хүчний энэхүү хязгаарлагдмал байдлыг харгалзсан болно.

Түүнчлэн манай судалгааны зорилготой бүс нутгийн нэг болох Хархорин орчмын бүс нутагт олон улсын бусад байгууллагуудаас хэрэгжихээр төлөвлөгдөж буй байдлыг, тухайлбал Азийн хөгжлийн банк, Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг, Турк улсын Засгийн газрын хөтөлбөр зэрэг байгууллагуудаас хэрэгжүүлэх төслийн чиглэл санал болон 1999 онд ЖАЙКА-ийн судалгаагаар дэвшүүлсэн зарим ажлуудыг үргэлжлүүлэхээр төлөвлөж буй зэрэг нөхцөлүүдийг тус тус харгалзан үзсэн болно.

Өмнөговь, Дорноговь аймгийн бүсийн хувьд аялал жуулчлалын нөөц баялаг нь нэн эмзэг учраас түүнийг хамгаалах, жуулчдыг амар тайван, аюулгүй аялах нөхцөлөөр хангах, орон нутгийн иргэдийн оролцоог дэмжих зэрэг зорилгыг агуулсан цогц төслийг хэрэгжүүлж, улмаар цаашдын аялал жуулчлалыг хөгжүүлэх нэгэн загвар байхаар төлөвлөсөн.

Цаашилбал, гадаадын жуулчдын сонирхолыг ихээр татдаг байсан нийслэл хот дахь Байгалийн түүхийн музей 2013 онд татан буугдсанаас хойш үүнтэй ижил төрлийн музей одоогоор шинээр ашиглалтад ороогүй байгаа. Одоогийн “Үлэг гүрвэлийн музей” нь Монгол улсаас хууль бусаар хил давсан, АНУ-аас буцаж ирсэн үлэг гүрвэлийн олдворуудыг дэлгэн үзүүлэх, улс төрийн үзэл суртлын шинж нь давамгайлсан, оролцогч талуудын санал бүрэн нийцээгүй, үзмэрийн тоо хэмжээ ч хязгаарлагдмал учраас гадны жуулчдад олон улсын хэмжээний “Үлэг гүрвэлийн музей” хэмээн танилцуулахад учир дутагдалтай гэж үзнэ. Дэлхийд ховор нандин цуглуулга болох үлэг гүрвэлийн олдворт зориулсан музей байгуулах нь зөвхөн эдийн засагт эерэг нөлөө үзүүлээд зогсохгүй, судалгаа шинжилгээний орчин нөхцөлийг сайжруулах, нөөц баялгийг хамгаалах, мэдлэг боловсрол олгох, үндэсний бахархлыг бэхжүүлэх зэрэг олон талын ач холбогдолтой юм. Тиймээс дотоод гадаадын эрдэмтэд, судлаачдын зүгээс ийм төрлийн музей байгуулахын хэрэгцээ шаардлагыг ямагт чухалчилж, бодит ажил болгохыг хүсэмжилж ирсэн юм. Музей байгуулагдсанаар нийслэлд гадны жуулчдыг татах аялал жуулчлалын нэгэн бүтээгдэхүүн бий болно.

Мөн энэ удаагийн судалгааны өөр нэгэн үр дүн бол аялал жуулчлалын салбарын төрийн албан хаагчдын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх хэрэгцээ шаардлага нэн чухал болох нь харагдсан. Тухайлбал аялал жуулчлалын салбарын хөгжингүй орон болох Япон улсад энэ чиглэлийн үндсэн мэдлэг, туршлага олгох сургалтыг явуулж, улмаар Японы үйлчилгээний чанар хийгээд Япон улсад амжилттай үйл ажиллагаа явуулж буй Монгол гэр жуулчны бааз зэрэг бодит үйл ажиллагаатай танилцах нь чухал шаардлагатай гэж үзсэн.

Хүснэгт 6-1: ЖАЙКА-д санал болгох хамтын ажиллагааны төслийн жагсаалт

Хамрах хүрээ	Төслийн нэр, агуулга	Дэмжлэг үзүүлэх хэрэгцээ, шаардлага	Хөгжилд оруулах хувь нэмэр	Тухайн бүс нутгийн идэвх санаачилга
Улсын хэмжээнд	<p>Монгол улсын аялал жуулчлалыг тогтвортойгоор хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд үзүүлэх дэмжлэг (Ганцаарчилсан мэргэжилтэн илгээх)</p> <ul style="list-style-type: none"> • БОАЖЯ-нд Япон улсаас мэргэжилтэн илгээж, Монголын аялал жуулчлалын салбарын тулгамдсан асуудал (хууль эрх зүй, мэдээлэл түгээлт, хүний нөөц, бэлэг дурсгалын бүтээгдэхүүн, статистик мэдээлэл гэх мэт олон талын асуудал)-уудад чиглэсэн бодлого боловсруулахад зөвлөгөө өгнө. 	<ul style="list-style-type: none"> • Монгол улс нь аялал жуулчлалын салбарыг шинэ үе шатанд хөгжүүлэх зорилгоор Аялал жуулчлалын тухай хуулийг шинэчлэн найруулах зэрэг өөрчлөлтүүдийг хийхээр төлөвлөж байгаа болно. Япон улсын хувьд аялал жуулчлалыг эдийн засгийн нэгэн чухал салбар болгон хөгжүүлэх зорилт тавьж, олон төрлийн арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа. Япон улсын энэхүү туршлагаас суралцахад нь дэмжлэг үзүүлэх шаардлагатай. • Ковид-19-ын дараах үеийн салбарын хөгжлийн бэлтгэл ажлыг хангах шаардлагатай. 	<ul style="list-style-type: none"> • Монгол улс нь өөрт буй аялал жуулчлалын суурь нөөц баялагтаа тулгуурлан аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэх, төрийн байгууллагын зүгээс авч хэрэгжүүлэх хууль эрх зүй, мэдээлэл сурталчилгааны стратеги болон тэдгээрийн тулгуур болсон төрийн захиргааны байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх шаардлагатай. Үүний тулд аялал жуулчлалын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болох БОАЖЯ-ны бодлого, үйл ажиллагааг дэмжин чадавхижуулах нь Монголын аялал жуулчлалын тогтвортой хөгжлийн суурь чадамжийг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой гэж үзнэ. 	<ul style="list-style-type: none"> • БОАЖЯ нь аялал жуулчлалын салбарын өөрчлөлт, шинэчлэлтийн үйл ажиллагааг идэвхтэйгээр хэрэгжүүлж байгаа. Мөн 2021 оны 1-р сард томилогдсон шинэ Ерөнхий сайдын зүгээс ч аялал жуулчлалын салбарыг чухалчлан авч үзэхээ илэрхийлсэн.
Бүс нутгуудын хэмжээнд	<p>Говийн бүс нутаг дахь аялал жуулчлалын тогтвортой хөгжлийн загварыг боловсруулах төсөл (Техникийн хамтын ажиллагааны төсөл)</p> <ul style="list-style-type: none"> • Өмнөговь болон Дорноговийн маршрут дахь аялал жуулчлалын үнэт нөөцийг хамгаалан, жуулчдын амар тайван, аюулгүй байдлыг хангах замаар тогтвортой аялал 	<ul style="list-style-type: none"> • Говийн бүс нутаг нь, үлэг гүрвэлийн олдвор зэрэг эмзэг шинжтэй зайлшгүй хамгаалан тордох аялал жуулчлалын бүтээгдэхүүний нөөц ихтэй • Гадаад дотоодын жуулчны тоо нэмэгдсэнээр үүсэж болох байгаль орчны сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх шаардлагатай. • Орон нутгийн засаг захиргааны байгууллагууд нь хүний нөөцийн хувьд хязгаарлагдмал учраас бүс 	<ul style="list-style-type: none"> • Аялал жуулчлалын арвин их нөөц баялагтай хэдий ч тэдгээрийг зөв зохистой хамгаалж, хяналт тавьж чадахгүй байгаа. Тиймээс цаашид жуулчдын тоо нэмэгдэхийн хэрээр аялал жуулчлалын суурь нөөц баялаг доройтон муудах, бүтээгдэхүүний чанар буурах эрсдэл Монгол улсын бүх л газар нутагт нүүрлэж байгаа бөгөөд шийдвэрлэх шаардлагатай чухал асуудлуудын нэг юм. Энэ байдалд үндэслэн, төрийн 	<ul style="list-style-type: none"> • Энэхүү судалгааны тайланд дурьдсан Өмнөговь аймгийн ТББ нь аялал жуулчлалыг хөгжүүлэх, нөөц баялгийг хамгаалах тал дээр идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг байгууллага бөгөөд аймгийнхаа захиргаатайгаа ч нягт хамтран ажилладаг. Мөн ЖАЙКА-ийн төсөл хөтөлбөр дээр ч гэсэн хамтран ажиллах хүсэл эрмэлзэлтэй

	<p>жуулчлалыг хөгжүүлэхийг зорилго болгоно.</p> <ul style="list-style-type: none"> • Байгаль орчны төдийгүй аж үйлдвэрийн бусад салбарын тогтвортой байдлыг дээшлүүлэх зорилгоор аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн, эвент арга хэмжээг хөгжүүлэх, үүнд аялал жуулчлалын салбар дахь нутгийн иргэдийн оролцоог идэвхжүүлэхийг зорино. 	<p>нутгийн тогтвортой хөгжлийн нэгэн чухал тогтолцоо болох орон нутгийн иргэд, ТББ-ууд, хувийн хэвшлийн хамтын менежментийг аялал жуулчлалын нөөцийг хамгаалах, хөгжүүлэхэд оновчтойгоор хамруулах нь зүйтэй гэж үзсэн.</p>	<p>байгууллагуудаас гадна орон нутгийн иргэдийн оролцоог хангасан аялал жуулчлалын тогтвортой хөгжлийн загварыг боловсруулснаар, бусад бүс нутагт аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулах боломжтой.</p>	<p>байгаа. Эхний ээлжинд тус аймагт төслийг хэрэгжүүлвэл амжилттай загвар болох боломжтой гэж үзнэ.</p>
<p>Нийслэл орчимд</p>	<p>“Үндэсний үлэг гүрвэлийн музей” байгуулах төсөл</p> <ul style="list-style-type: none"> • Дэлхий дахины үнэт өв болох үлэг гүрвэлийн олдворыг үзүүлэн таниулах, судлах, боловсрол олгох зорилго бүхий Музей байгуулан ажиллана. • Монгол улс дэлхийд ховор үлэг гүрвэлийн олдворуудтай боловч олон улсын түвшний музей байдаггүй. Иймээс шинээр музей байгуулснаар гадаад дотоодын жуулчдыг татаж чадахуйц, өрсөлдөх чадвартай, өндөр үр өгөөжтэй аялал жуулчлалын бүтээгдэхүүнтэй болох юм. 	<ul style="list-style-type: none"> • Дэлхийн хүн төрөлхтөн хамтаараа хадгалж үлдээх үнэ цэнэ бүхий нэн ховор олдворыг судлах, хадгалж хамгаалах, жуулчид болон олон нийтэд үзүүлэн таниулах музей байгуулах нь гадаад дотоодын олон эрдэмтэн судлаачдын хүсэл зорилго юм. Мөн аялал жуулчлалын нөөц болгон ашиглах нь олдворын хамгаалалт, судалгаа шинжилгээний тогтвортой тогтолцоог бүрдүүлэхэд ч хувь нэмэр оруулна. • 1999 оны ЖАЙКА-ийн судалгааны тайланд ч мөн үлэг гүрвэлийн олдворын хадгалалт хамгаалалтын хөтөлбөр болон музейн талаар дурдсан байдаг. Музейн байгууламжийг барих боломж эрэлтийн талаар холбогдох этгээдийн зүгээс ЖАЙКА-д хандаж байсан болно. 	<ul style="list-style-type: none"> • Нийслэл хотын ойрын бүсэд гадаадын жуулчдын сонирхлыг татахуйц аялал жуулчлалын нөөц баялаг хомс тул Монголын бахархал болсон дэлхийд нэн ховор үлэг гүрвэлийн олдворуудыг дэлгэн үзүүлэх үйлчилгээний музей байгуулагдвал олон тооны жуулчдыг татах боломжтой. ЖАЙКА-ийн буцалтгүй тусламжаар 2010 онд баригдсан Хархорум музей нь Хархорины аялал жуулчлалын нэгэн чухал үзмэр болж, гадаадын олон жуулчдын сонирхлыг татсаар байна. Нийслэл Улаанбаатар хотод үлэг гүрвэлийн музейг байгуулснаар Хархорум дахь музейгээс илүү олон жуулчны сонирхлыг татаж, олон нийтэд дэлгэн харуулах нь Япон улсын тусламжийн бодит жишээ болох ач холбогдолтой юм. • Монголд аялах жуулчдын тоо нэмэгдэхийн хэрээр ийм түвшний 	<ul style="list-style-type: none"> • Палеонтологийн хүрээлэн үлэг гүрвэлийн музей байгуулахаар төлөвлөж байгаа бөгөөд бүх талын дэмжлэг авч хамтран ажиллах боломжтой.

			музейг үзэж сонирхох хүний тоо ч нэмэгдэх магадлалтай учраас цаашид ашигтай ажиллах боломжтой.	
Бүс нутгуудын хэмжээнд	<p>Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын маркетинг, мэдээлэл сурталчилгааг сайжруулах (Урт хугацааны мэргэжилтэн илгээх)</p> <ul style="list-style-type: none"> Орхоны хөндийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаанд, тухайн бүс нутгийн аялал жуулчлалын нөөцийг сурталчлах, таниулах ажлыг хийж гүйцэтгэнэ. 	<ul style="list-style-type: none"> Орхоны хөндийн аялал жуулчлалын нөөцийн талаар хангалттай мэдээлэл түгээгддэггүй, таниулах сурталчлах ажил хангалтгүй байдаг. 	<ul style="list-style-type: none"> Орхоны хөндийд олон тооны соёлын болон түүхэн өв, нүүдэлчин соёлын бодит байдал хэвээр хадгалагдан үлдсэн байдаг бөгөөд тэдгээрийг сурталчлан таниулах ажлыг бэхжүүлснээр жуулчдын тоог нэмэгдүүлэх, аяллын бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэх, хөдөө орон нутгийн аялал жуулчлалын салбар дахь нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх бололцоотой. 	<ul style="list-style-type: none"> Тус байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа болон харьяа нутгуудыг хамарсан зөвлөл зэрэг байгууллагуудтай хамтран мэдээлэл сурталчилгааг түгээх ажлыг эрчимжүүлэх боломжтой.
Тодорхой нэг бүс нутаг	<ul style="list-style-type: none"> Хархорин нисэх онгоцны буудлыг олон улсын нисэх буудал болгох мастер төлөвлөгөөний боловсруулалтыг дэмжих (Хөгжлийн судалгаа хэлбэрийн техникийн хамтын ажиллагааны төсөл) Аялал жуулчлалын гол зорих газрын нэг болох Хархорин дахь нисэх онгоцны буудлыг олон улсын нисэх буудал болгон хөгжүүлэх 	<ul style="list-style-type: none"> Гадаадын жуулчид голлон аялах газар болох Хархорины одоогийн нисэх онгоцны буудлыг олон улсын нисэх буудал болгон өргөтгөж, аялал жуулчлалын салбарын хөгжлийг эрчимжүүлэх. Монгол улсад одоогоор олон улсын нисэх онгоцны буудал ганц байгаа бөгөөд цаашдын аялал жуулчлалын хөгжил, нислэгийн аюулгүй байдлыг бататгах үүднээс хоёр дахь олон улсын нисэх онгоцны буудлыг барих шаардлагатай. 	<ul style="list-style-type: none"> Аяллын хөтөлбөрийг төрөлжүүлж, Хархориныг зорих жуулчдын тоог нэмэгдүүлэх, үйлчилгээний чанар ая тухыг хангах, улмаар нутгийн иргэдийн орлогыг өсгөхөд хувь нэмэр оруулна. 	<ul style="list-style-type: none"> Олон улсын нисэх буудал болгон өргөтгөх төсөл нь Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан байгаа. Хархорины аялал жуулчлалын салбарын оролцогч талуудын хүлээлт ч өндөр байгаа.

<p>Бүс нутгуудын хэмжээнд</p>	<p>Аялал жуулчлалын асуудал хариуцсан төрийн албан хаагчдыг Япон дахь сургалтад хамруулах</p> <ul style="list-style-type: none"> • БОАЖЯ, Улаанбаатар хот, энэ удаагийн судалгааны зорилтот бүс нутаг болох 6 аймгийн аялал жуулчлал хариуцсан төрийн албан хаагчдад зориулсан зорилтот сургалтыг Япон улсад зохион байгуулна. Сургалтын агуулганд Япон улсын аялал жуулчлалын бодлогын талаарх үндсэн мэдлэг, Япон улсад зочлон ирэх гадаадын жуулчдад үзүүлдэг үйлчилгээ, гадагш чиглэсэн маркетингийн мэдээлэл, сурталчилгааны чиг хандлага, аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдал болон тус салбарт Засгийн газар, орон нутгийн засаг захиргаанаас үзүүлдэг дэмжлэгийн талаар багтаасан байна. <p>Сургалтын агуулга болон үр дүнг харгалзсан үзсэний үндсэн дээр зөвхөн төрийн албан хаагч төдийгүй, Аялал Жуулчлалын Холбоо болон бусад ТББ-ын ажилчдыг хамруулна.</p>	<ul style="list-style-type: none"> • Монголын аялал жуулчлалын салбарын төрийн захиргааны ажилтан, албан хаагчдын мэргэжлийн мэдлэг, туршлага дутмаг байгаа нь энэхүү судалгаагаар тодорхой болсон. • Ялангуяа гадаад улс орнуудын бодит нөхцөл байдалтай очиж танилцсан төрийн албаны туршлагатай боловсон хүчин цөөн, аялал жуулчлалын хөгжлийн талаарх мэдлэг хязгаарлагдмал тул Япон улсын жишээн дээрх бодит үйл ажиллагаатай танилцаж, Монгол улсын бодлого чиглэлд тусган ажиллах үр дүнтэй гэж үзсэн. 	<ul style="list-style-type: none"> • Энэхүү судалгааны үр дүнгээс харахад, Монгол улсын аялал жуулчлалын салбарын бодлого, холбогдох төрийн байгууллагуудад тулгарч буй асуудлын нэг шалтгаан нь аялал жуулчлалын хөгжил нь маш олон салбарыг хамааруулсан сан, өргөн хүрээтэй байгаа нь илт. Япон улс нь, аялал жуулчлалын хөгжингүй орон болохын тулд анхааран хэрэгжүүлэх арвин туршлагатай. Тухайлбал, орон нутгийн хөгжлийн үндэс суурийг бэхжүүлэх, аялал жуулчлалыг тулгуур салбар болгон хөгжүүлэх, аялал жуулчлалын контентыг гадаад хэл дээр гаргах зэрэг Монгол улс өөрийн бодлого чиглэлээ боловсруулахад тус нэмэр болохуйц жишээ туршлагаас суралцах боломжтой. Тиймээс Японы аялал жуулчлалын бодлого, үйл ажиллагаа, тулгарч буй бэрхшээлийн талаар өргөн хүрээтэйгээр судлан, суралцаж Монголын холбогдох байгууллагуудын үйл ажиллагааг чадавхижуулахад хувь нэмэр оруулах ач холбогдолтой хэмээн үзэж байна. 	<ul style="list-style-type: none"> • Монгол улсын Засгийн газар болон аймгуудаас хүсэлт ирсэн болно.
-------------------------------	--	---	--	---

Эх сурвалж: ЖАЙКА судалгааны баг

7-р бүлэг

Төслийн санал дэвшүүлэлт

7-р бүлэг Төслийн санал дэвшүүлэлт

6-р бүлэгт санал болгосон төслийн саналуудын товч агуулгыг доор танилцуулж байна.

Хүснэгт 7-1: Төслийн санал 1

Төслийн дугаар	01 (Ганцаарчилсан мэргэжилтэн илгээж)	
Төслийн нэр	Монгол улсад тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогыг дэмжих	
Зорилго	Хамрах бүс нутаг	
Аялал жуулчлалын засаг захиргааны байгууллагуудад ажиллаж байсан эсвэл аялал жуулчлалын салбарын практик туршлагатай мэргэжилтнийг Япон улсаас илгээж, БОАЖЯ-ны АЖБЗ Газрын тулгамдаж буй асуудлуудын талаар зөвлөгөө өгч ажиллан, салбарын хөгжилд хувь нэмэр оруулах	Улсын хэмжээнд	
	Үр шимийг хүртэгч талууд	
	Шууд хүртэгч тал: БОАЖЯ	
	Шууд бус хүртэгч тал: АЖХТ болон бусад	
Үндэслэл, төслөөс хүлээгдэх үр дүн		
<p>Сүүлийн жилүүдэд Монголын дотоодын аялагчдын тоо огцом өссөн төдийгүй, 2019 онд гадаадаас ирэх жуулчдын тоо 2016 онтой харьцуулахад 27 хувиар өсч 580 мянгад хүрсэн үзүүлэлттэй байна. Эдийн засгийн үзүүлэлтийн хувьд ч гэсэн 2019 онд ДНБ-ий 6 хувийг бүрдүүлж болсон нь уул уурхайн салбараас хэт хамааралтай байдлаас зайлсхийж, эдийн засгийг төрөлжүүлэхээр зорьж буй Монгол улсын хувьд аялал жуулчлал нь эдийн засгийн голлох салбарын нэг байх боломжтой хэмээгдэж байна. 2021 оны 7 сард Япон улсын хөнгөлөлттэй зээлээр баригдсан олон улсын нисэх онгоцны шинэ буудал ашиглалтад орсноор аялал жуулчлалын салбар улам их анхаарал татаж байгаа хэдий ч Ковид-19 цар тахлын улмаас тус салбар томоохон цохилтод ороод байна. Тиймээс цар тахлын дараах үеийн Монголын аялал жуулчлалыг аль болох хурдан хугацаанд тогтвортойгоор сэргээх шаардлага тулгараад байна.</p> <p>Монгол улсын Засгийн газар аялал жуулчлалыг хөгжүүлэх үүднээс дэд бүтэц (авто замыг хатуу хучилттай болгох гэх мэт) -ийг сайжруулахад анхаарахын зэрэгцээ Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчлэлт зэрэг томоохон бодлого, эрх зүйн өөрчлөлтийг хийхээр зорьж байна. Монгол улсын аялал жуулчлалын салбарт тулгамдаж байгаа асуудал нь хууль эрх зүйгээс гадна гадаадын жуулчдыг хүлээн авах аялал жуулчлалын дэд бүтэц, аялал жуулчлалын бизнес эрхлэгчдийг бэлтгэх, удирдамж зааварчилгаа өгөх, аялал жуулчлалын талаарх мэдээлэл сурталчилгаа, аялал жуулчлалын бүтээгдэхүүний чанар хөгжүүлэлт, мөн тус салбарын статистик мэдээлэл зэрэг олон талт асуудлууд байгаа. Эдгээр Аялал жуулчлалын хөгжлийн тулгамдсан бүхий л асуудалд Японы туршлага дээр суурилсан зөвлөгөөг аялал жуулчлалын төрийн захиргааны төв байгууллагуудад (БОАЖЯ болон АЖХТ) өгч, бодлого боловсруулах чадавхийг бэхжүүлснээр цар тахлын дараах үеийн Монголын аялал жуулчлалын хөгжлийн бэлтгэл ажлыг хангахад хувь нэмрээ оруулж чадах юм.</p>		
Үйл ажиллагааны агуулга		
<p>Дараах асуудлуудын талаар санал дэвшүүлэхийн зэрэгцээ, тодорхой арга хэмжээ авахад чиглүүлэх удирдамж заавар, зөвлөгөөг өгнө.</p> <ol style="list-style-type: none"> 1. “Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр баримтлах бодлого 2019-2026”-г хэрэгжүүлэх (Тодорхой хөгжлийн стратеги боловсруулах гэх мэт)-тэй холбоотой үйл ажиллагаа 2. Гадаад улс орнууд, жуулчдад чиглэсэн мэдээлэл сурталчилгааны өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийх, улсын болон орон нутаг, хувийн хэвшлийн түвшинд хэрэгжүүлэх мэдээлэл сурталчилгааны үйл ажиллагаа 3. Гадаадын жуулчдын амар тайван, аюулгүй аялах орчин нөхцөлийг сайжруулахад чиглэсэн аялал жуулчлалын дэд бүтэц, түр буудаллах цэг, бие засах газар зэргийг байгуулах төлөвлөгөөний боловсруулалт 4. Аялал жуулчлалын нөөц баялаг, байгаль орчныг хамгаалахад чиглэсэн арга хэмжээ. Гуравдагч хөрш орнуудаас, тэр тусмаа Япон улсаас ирэх жуулчдыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулахуйц аялал жуулчлалын бүтээгдэхүүн (аяллын маршрут, өвлийн аялал жуулчлал, бэлэг дурсгалын зүйл гэх мэт)-ийг хөгжүүлэх боломжийг судлах. Аялал жуулчлалын статистикийн мэдээллийн тулгамдсан асуудалд дүн шинжилгээ хийж, илүү бодитой нарийвчилсан, нийтэд хүртээмжтэй аялал жуулчлалын статистик мэдээлэл цуглуулах аргачлалын талаар судлах 		

Хөрөнгө оруулалт (Япон тал)		Хөрөнгө оруулалт (Монгол тал)
Аялал жуулчлалыг хөгжүүлэх салбарын мэргэжилтэн илгээх 1 хүн	<Мэргэжилтний үйл ажиллагааны зардал>	<БОАЖЯ> Төслийн хамтрагч байгууллага болох Ажиллах өрөөгөөр хангах
● иен	● иен	
Хэрэгжүүлэгч байгууллага		Хэрэгжүүлэх хугацаа
БОАЖЯ		2 жил
Шаардагдах нөхцөл		
Ковид-19 цар тахлын дэгдэлт намжсан байх		
Анхаарах зүйлс		
Энэхүү төслийн саналд ганцаарчилсан мэргэжилтэн илгээх тухай тусгасан хэдий ч, гүйцэтгэх ажил үүргийн даалгавар хийгээд Япон талын нөөц бололцоо зэргийг харгалзан, энэ бүлэгт санал болгосон төслийн санал 5, эсвэл төслийн санал 2-той хамтагтан техникийн хамтын ажиллагааны төсөл болгон хэрэгжүүлэх талаар авч хэлэлцэж болно.		

Эх сурвалж: ЖАЙКА судалгааны баг

Хүснэгт 7-2: Төслийн санал 2

Төслийн дугаар	02 (Техникийн хамтын ажиллагааны төсөл)
Төслийн нэр	Говийн бүс нутаг дахь аялал жуулчлалын тогтвортой хөгжлийн загварыг боловсруулах төсөл
Зорилго	Хамрах бүс нутаг
<p>Төр болон орон нутгийн иргэдийн хамтын оролцоотойгоор аялал жуулчлалын нөөц баялгийг хамгаалах, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх загварыг бий болгох</p> <p>(Уг загвараар дамжуулан “Өргөн уудам үзэсгэлэнт байгаль, үлэг гүрвэлээр дамжуулан эх дэлхийтэй танилцах аялал”-ыг дэлхийн өнцөг булан бүрээс ирэх жуулчдад олгох.)</p> <ol style="list-style-type: none"> 1) Аялал жуулчлалын нөөц баялгийг хадгалах, хамгаалах 2) Жуулчдын амар тайван, аюулгүй байдлыг хангах (жижиг хэмжээний байгууламж байгуулах) 3) Аялал жуулчлалын маршрут, замуудын талаарх сурталчилгаа, мэдээлэл түгээлтийг сайжруулах 4) Орон нутгийн иргэдийн оролцоог дээшлүүлэх, хүний нөөцийг бэлтгэх 5) Эвент арга хэмжээг хөгжүүлэх 6) Шинэ аялал жуулчлалын бүтээгдэхүүн хөгжүүлэх 	<p>1-р үе шат Өмнөговь аймаг, Дундговь аймаг</p> <p>2-р үе шат Дорноговь аймаг, Говьсүмбэр аймаг</p> <p>Үр шим хүртэгч талууд</p> <p>Техникийн ур чадвар дамжуулах:</p> <p>Шууд үр шим хүртэгч тал:</p> <ol style="list-style-type: none"> 1) БОАЖЯ 2) Холбогдох аймгууд <p>Шууд бусаар үр шим хүртэгч тал:</p> <ol style="list-style-type: none"> 1) Соёлын Яам 2) ЗТХЯ 3) Аялал жуулчлалын компаниуд 4) ТББ / Орон нутгийн иргэд 5) ШУА-ийн Палеонтологийн Хүрээлэн
	Үндэслэл, төслөөс хүлээгдэх үр дүн

амаргүй. Тиймээс дээр дурдсан асуудлуудыг шийдвэрлэхийн тулд зорилготой бүс нутгийг жишиг болгох зорилгоор төсөл хэрэгжүүлж, Монгол дахь аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэх загварыг бий болгох нь зүйтэй. Судалгааны үр дүн (аялал жуулчлалын нөөц баялгийн хэмжээ, аялал жуулчлалыг хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж буй байдал зэрэг)-д үндэслэн эхний ээлжинд Өмнөговь, Дундговь аймагт нэгдсэн цогц байдлаар төсөл хэрэгжүүлэх ба эдгээр аймгууд нь харилцан мэдээлэл, туршлага солилцон, уялдаа холбоотойгоор ажиллах юм. Улмаар төслийн үр дүнд бий болсон аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэх жишиг загварын тухай мэдээллийг бусад бүс нутагт ч түгээж, тухайн нутагт энэхүү загвар төслийг хэрэгжүүлэхийг санал болгоно. Хэрэв боломжтой гэж үзвэл бий болгосон загварыг ашиглан Дорноговь, Говьсүмбэр аймагт мөн адил төслийн 2-р үе шат болгон хэрэгжүүлэх саналыг дэвшүүлж байна. Дорноговь аймаг нь шашин мөргөл, оюун санааны холбогдолтой энергийн төв зэрэг газруудаараа дотоодын жуулчдын сонирхлыг тагдаг ч, аялал жуулчлалын бүтээгдэхүүний төрөлжилт талаасаа бүрэн хөгжөөгүй байгаа тул, сайжруулах асуудлуудыг судлан цэгцлэхийн зэрэгцээ нөөцийг хамгаалах ажлыг хэрэгжүүлэх шаардлагатай байгаа. Говьсүмбэр аймгийн хувьд сонирхол татахуйц үндэсний уламжлалт нөөц баялаг арвинтай бүс нутаг хэдий ч, энэ удаагийн судалгааны хугацаанд газар дээр нь очиж судалж, мэдээлэл цуглуулж чадаагүй тул төслийн хүрээнд илүү нарийвчлан судлах нь зүйтэй.

Энэхүү төслөөр дэд бүтэц, мэдээлэл маркетинг, эвент арга хэмжээний төлөвлөлт, соёл урлагийн үзүүлэн тоглолт зэрэг олон талын үйл ажиллагааг нэгэн зэрэг хэрэгжүүлж, хоорондын уялдаа холбоог сайжруулж, туршлага солилцуулна. Энэ нь хэрэгжүүлэгч талуудын өөр хоорондын үйл ажиллагааны талаар ойлгох ойлголтыг нэмэгдүүлэхээс гадна, хамтын үр дүнг гаргах байдлаар аялал жуулчлалын чанар болон тоон үзүүлэлтийг дээшлүүлэх үр дүн төслөөс хүлээгдэх болно.

Үйл ажиллагааны агуулга

1. Нэгдсэн цогц арга замаар хэрэгжүүлэх төслийн зураг төсөл боловсруулах
 - Төслийн удирдах хороог байгуулах
 - Зорилготой бүс нутаг болох Өмнөговь, Дундговь аймагт төсөлд хамруулах аялал жуулчлалын газруудын жагсаалт гарган дүгнэлт хийж, шийдвэрлэх
 - Төслийн агуулгыг тодорхойлох, ажлын хэсгийг бүрдүүлэх гэх мэт
2. Төсөл хэрэгжүүлэх
 - Аялал жуулчлалын нөөц баялгийг хадгалах, хамгаалах (ажлыг удирдах) тогтолцоог бүрдүүлэх, удирдах байгууллагын төсөв санхүүжилт болон менежментийн төлөвлөгөөг боловсруулах
 - Аялал жуулчлалын нөөц баялгийг хадгалан хамгаалах зорилготой явган хүний зам, замын тэмдэглэгээ, хамгаалалтын хайс, бие засах газар байгуулах (Жишиг загвар болгон барьж байгуулах бага хэмжээний байгууламж)
 - Аялал жуулчлалын нөөц баялгийн талаарх мэдээллийг цэгцлэх, сурталчилгааны төлөвлөгөө гаргах, аяллын газрын зураг хийх, мэдээлэл түгээх (вэб хуудас)
 - Өнөөг хүртэл зохион байгуулагдаж байсан соёл урлагийн болон бусад эвент арга хэмжээний талаарх мэдээллийг судалж дүгнэх, шинэ эвент арга хэмжээг санаачлан туршилтаар зохион байгуулах
 - Дотоодын бусад аялал жуулчлалын бүс нутагтай (Хархорин гэх мэт) харилцан танилцах аялал хийх, санал солилцох
 - Жендерийн болон аюулгүй ажиллагааны талаар сургалт зохион байгуулах
 - Япон улс дахь сургалт зохион байгуулах
3. Төслийн үр дүнд бий болсон тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх загварыг дүгнэн, түүнийг бусад бүс нутагт хэрэгжүүлэхэд чиглэсэн санал дэвшүүлэх



Хөрөнгө оруулалт (Япон тал)

- <ЖАЙКА-ийн зөвлөх>
- Багийн ахлагч/Аялал жуулчлалын хөгжил
 - Дэд бүтэц 1
 - Дэд бүтэц 2

<Гэрээгээр гүйцэтгүүлэх ажлын зардал>

Туршилтын төсөл

Дэд бүтэц=50,000,000 иен (Шаардлагатай тохиолдолд хэсэгчлэн хуваах боломжтой)

Хөрөнгө оруулалт (Монгол тал)

- Төслийн хамтрагч байгууллага болох
- Төслийн оффисоор хангах

<ul style="list-style-type: none"> - Аялал жуулчлалын маркетинг - Мэдээллийн технологи, контент бэлтгэл - Эвент арга хэмжээ төлөвлөлт, зохион байгуулалт - Олон нийтийн оролцостой хөгжил, жендерийн асуудал - Төслийн зохицуулагч <p>70MM+Томилголын зардал+Монгол дахь ажилтны зардал+Бусад зардал=245,000,000 иен</p>	<p>Аялал жуулчлалын газрын зураг, контент бэлтгэл, эвент арга хэмжээ, соёл урлагийн тоглолтын бэлтгэл, тоглолтын зардал гэх мэт=5,000,000 иен (Шаардлагатай тохиолдолд хэсэгчлэн хуваах боломжтой)</p> <p>Дотоодод сургалт зохион байгуулах=5,000,000 иен</p> <p><Японд сургалт зохион байгуулах> 4 хүн=10,000,000 иен</p>	
245,000,000 иен	70,000,000 иен	
Хэрэгжүүлэгч байгууллага		Хэрэгжүүлэх хугацаа
БОАЖЯ Төсөлд хамрагдах аймгуудын БОАЖТ		4 жил
Шаардагдах нөхцөл		
Ковид-19 цар тахалын дэгдэлт намжсан байх		
Анхаарах зүйлс		
<p>Зөвлөх мэргэжилтнийг тасралтгүй илгээж, ээлж дараатайгаар Монголд тогтмол ажиллуулахаар төлөвлөх нь зүйтэй. Төслийн хүрээнд байршуулах хамгаалах хашлага, самбар, тэмдэг тэмдэглэгээг нэгдсэн нэг хэв загвараар хийж, орчин тойрны өнгө үзэмжийг алдагдуулж сүйтгэхгүй байхад сайтар анхаарч үзэх шаардлагатай. Гэрээгээр гүйцэтгүүлэх ажлыг багцлан хувааж, тухайн орон нутгийн хувийн хэвшил, аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан гүйцэтгүүлэх ба ингэснээр техникийн ур чадварыг орон нутгийн компани, хувийн хэвшилд дамжуулах боломж ч бүрдэх юм. Мөн урсгал засварын зардал зэргийг ч төслийн санхүүжилтээр зохицуулах хэрэгтэй.</p> <p>Эвент, арга хэмжээ төлөвлөлтийн тухайд, нөхцөл байдлаасаа хамааран Улаанбаатар хот дахь мэргэжлийн аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан хамтран ажиллах замаар орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжид заавар, зөвлөгөө өгөн чиглүүлэн ажиллах боломжтой.</p> <p>Мэдээллийн технологи, контент бэлтгэх ажлын тухайд Монголд зөвлөх мэргэжилтэн авч ажиллуулах эсвэл зайнаас удирдан чиглүүлэх, сайн дурын ажилтан илгээх гэх мэтээр тохирох аргыг хэлэлцэж сонгох.</p>		

Эх сурвалж ЖАЙКА судалгааны баг

Хүснэгт 7-3: Төслийн санал 3

Төслийн дугаар	03 (Төслийн зээл)	
Төслийн нэр	“Үндэсний үлэг гүрвэлийн музей” байгуулах төсөл	
Зорилго	Хамрах бүс нутаг	
<p>Дэлхий нийтийн өв болох үлэг гүрвэлийн олдворыг тогтвортой судалж, хамгаалах тогтолцоог бүрдүүлж, байгаль орчныг хамгаалах аялал жуулчлалын ёс зүйг сургах төв болох Үлэг гүрвэлийн музейг барьж байгуулах</p> <ol style="list-style-type: none"> 1) Музей барих 2) Судалгааны төвийг барих 3) Орчныг цэцэрлэгт хүрээлэн болгон тохижуулах 4) Өмнөговь аймагт салбар судалгааны музей байгуулах 	Төв аймаг	
	Үр шим хүртэгч талууд	
	<p>Шууд үр шим хүртэгч тал:</p> <ol style="list-style-type: none"> 1) Соёлын Яам 2) ШУА-ийн Палеонтологийн хүрээлэн 3) БШУЯ <p>Шууд бус үр шим хүртэгч тал:</p> <ol style="list-style-type: none"> 1) Монгол улсын иргэд 2) Гадаадын жуулчид 3) Дэлхийн палеонтологич эрдэмтэн судлаачид 4) БОАЖЯ 	
Төслийн үндэслэл, агуулга		
<p>Дэлхийд нэн ховорт тооцогддог маш сайн хадгалагдан үлдсэн үлэг гүрвэлийн олдвор бүхий газрууд Монгол улсад нэлээдгүй байдаг. Үлэг гүрвэлийн бүтэн биеийн араг яс, өндөг, хөлийн мөр гэх мэт ховор олдворууд олдсон бөгөөд эдгээр нь шинжлэх ухааны үнэ цэнэтэй нээлт, судалгаа, шинжилгээнд ихээхэн хувь нэмэр оруулж байна. Үндэсний үнэт эрдэнэ ч гэж хэлж болох олон талын нөөц боломжийг агуулсан эдгээр үлэг гүрвэлийн олдворуудыг улс орноо хүчирхэгжүүлэхэд (шинжлэх ухаан, боловсрол, соёл, эдийн засгийн салбарт ашиглах гэх мэт) ашиглаж чадаагүй байна.</p> <p>2013 оныг хүртэл Улаанбаатар хот дахь “Байгалийн Түүхийн Музей” нь гадаад дотоодын жуулчдын зорин очдог чухал үзвэрийн газар байсан боловч барилга нь хуучирч муудсаны улмаас хаагдсан. Одоогоор ШУА-ийн Палеонтологийн хүрээлэн нь нисэх онгоцны буудлын ойролцоох “Хүннү Молт”-д үлэг гүрвэлийн араг ясны үзмэрийг багахан хүрээнд дэлгэн үзүүлж байна. Мөн Улаанбаатар хотын үлэг гүрвэлийн музейд АНУ-аас будаж ирсэн, хууль бусаар хил давсан үлэг гүрвэлийн араг ясны үзмэр тавигдсан байдаг ч, үзмэрийн тоо маш цөөн, мэргэжлийн хүмүүсийн тайлбар ч дутагдалтай.</p> <p>ШУА-ийн Палеонтологийн хүрээлэн нь Дэлхий нийтийн өв болох үлэг гүрвэлийн олдворыг хамгаалах, судлах зорилгоор шинэ нисэх буудлын ойролцоо музей, судалгааны төвийн барилга бүхий байгууламжийг барихаар төлөвлөж байна. Гэвч үлэг гүрвэлийн музейг барьж байгуулах, удирдан ажиллуулах туршлага байхгүй тул, энэ ажлыг хэрэгжүүлэхэд гадаадын техник технологи болон санхүүгийн дэмжлэг зайлшгүй шаардлагатай. Монгол улс дангаараа дэлхийн жишигт хүрэх үлэг гүрвэлийн музейг барьж байгуулах нь амаргүй ажил бөгөөд нөгөөтэйгүүр бэлтгэл бүрэн хангагдаагүй байхад аялал жуулчлал эрчимжин жуулчид ихэссэнээр дэлхий нийтийн өв баялаг устаж үгүй болох аюултай юм.</p> <p>Тиймээс ШУА-ийн Палеонтологийн хүрээлэнгийн боловсруулсан Үлэг гүрвэлийн музей, судалгааны төвийн цогцолбор байгуулах ТЭЗҮ-д үндэслэн дэлхий нийтийн өв болох үлэг гүрвэлийн олдворыг үзүүлж таниулах, судлах зорилго бүхий Үлэг гүрвэлийн музейг байгуулах шаардлагатай гэж үзэж байна. Палеонтологийн хүрээлэн нь судалгааны байгууллага тул музейн үйл ажиллагааг боловсронгуй болгож, ашиг орлоготой ажиллуулах тал дээр бусад яамдтай хамтран ажиллах шаардлагатай. Иймээс төслийн бэлтгэл судалгааны үеэр БОАЖЯ-тай музейг ашигтай ажиллуулах тал дээр, Соёлын яам болон БШУЯ-тай байгаль орчны болон аялал жуулчлалын ёс зүйн боловсрол зэрэг таниулах, сурталчлах тал дээр хамтран ажиллах боломжийг судалж үзнэ.</p> <p>Хамтын ажиллагааны бэлтгэл судалгаанд хамрагдах эсэх нь тодорхойгүй ч, үлэг гүрвэлийн олдворын өлгий нутаг болох Өмнөговь аймагтай хамтран, тус аймагт шинээр байгуулагдах музейтэй шинжлэх ухааны үүднээс болон аялал жуулчлалын бизнес хөгжүүлэх тал дээр хамтран ажиллах тодорхой үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах санал дэвшүүлнэ.</p> <p>Үлэг гүрвэлийн олдвор нь дэлхий нийтийн өв гэдэг утгаараа, баригдаж ашиглалтад орох Үлэг гүрвэлийн музей болон Японы холбогдох их дээд сургууль, түүнчлэн бусад олон улсын байгууллага хоорондын хамтын ажиллагааны боломжийг судалж үзэх шаардлагатай. Ялангуяа Японы үлэг гүрвэлийн нэртэй судлаачид Монголын</p>		

Палеонтологийн хүрээлэнгэй ойр дотно харилцаатай, хамтран ажилласаар ирсэн бөгөөд 1990-ээд оноос хойш Үлэг гүрвэлийн музей байгуулах талаар санал солилцож ирсэн түүхтэй.

Үйл ажиллагааны агуулга

- (1) Үйл ажиллагааны үндэстэл ба хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, судлах
- (2) Үйл ажиллагааны зорилго ба хамрах хүрээг судлах (байгууламжийн төлөвлөгөө, тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлт, тоо хэмжээ гэх мэт)
- (3) Хөнгөлөлттэй зээлийг хэрэгжүүлэх тогтолцоо, төслийг удирдах, хяналт тавих тогтолцоог судлах
- (4) Ерөнхий зураг төсөл боловсруулах (байгууламж ба тоног төхөөрөмжийн төлөвлөгөө, хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх ажлын зардлын тооцоолол, шаардлагагай зөвшөөрөл авах, хүрээлэн буй орчин болон нийгэмд үзүүлэх нөлөөллийн судалгаа, байгалийн нөхцөл байдлын тухай судалгаа, дэд бүтцийн судалгаа)
- (5) Төслийг хэрэгжүүлэхэд анхаарах зүйлс (худалдан авах аргачлалыг судлах, хөнгөлөлттэй зээлийг буцаан төлөлт хийх асуудлыг шинжлэх, дүн шинжилгээ хийх, зураг төслийг өөрчлөхөд бүрпүүлэх)
- (6) Ашиглалт ба өгөөжийн үзүүлэлтийг судлах
- (7) Бусад төсөл болон донор байгуулагагай хамтран ажиллах талаар санал болгох
- (8) Хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг судалж боловсруулах
- (9) Хөнгөлөлттэй зээлтэй хослуулан хэрэгжүүлэх техникийн хамтын ажиллагааг санал болгох талаар судлах

Палеонтологийн хүрээлэнгийн одоогийн байдлаар төлөвлөж буй Үлэг гүрвэлийн музейн барилга байгууламжийн бүтэц зохион байгуулалт болон ерөнхий төлөвлөлт нь дараах байдалтай байна.

Байрлал: Төв аймаг (Улаанбаатар хотын ойр орчим)

Үзэсгэлэнгийн хэсэг: 5500м²

Судалгаа, шинжилгээний хэсэг: 2280м²

Олдвор цуглуулах, хадгалах хэсэг: 5350м²

Боловсрол сургалт, танин мэдэхүйн хэсэг: 960м²

Бусад: 2110м²

Барилгын ерөнхий төлөвлөлт

Хамрах талбайн хэмжээ: 10000м² (Барилга 5400м², Автомашины зогсоол 1000м², Цэцэрлэгт хүрээлэн 2000м² багтана)

Байгууламж доторх зам: Явган хүний зам 500м×2м, Авто зам 300м×8

Нийт талбайн хэмжээ: 16200м² (90×60×3 давхар)

Япон улсын Фүкүи муж дахь үлэг гүрвэлийн музей нь үзэсгэлэнгийн хэсэг (4500м²), тусгай үзэсгэлэнгийн танхимтай бөгөөд музейн нийт газрын хэмжээ 30000м², барилгын нийт талбайн хэмжээ нь 15000м² юм. Мөн барилгын ажилд 9 тэрбум 150 сая иен, үзмэрийн засварын ажилд 3 тэрбум 100 сая иен буюу нийтдээ 14 тэрбум орчим иен (холбогдох үзүүлэн материалын зардал, тоног төхөөрөмж суурилуулах зэрэг зардал багтана)-ийг зарцуулсан байна. Тус музейг анх байгуулахдаа жилд 400 мянган хүн зочилж үзнэ хэмээн тооцоолжээ. Эхний жилд 250 мянга байсан үзэгчийн тоо 2018 он гэхэд 930 мянгад хүрч, өдгөө Фүкүи муждаа хамгийн их жуулчдыг татдаг газруудын нэг болоод байна. Улмаар одоогийн байгууламжийн багтаамж нь хүрэлцэхгүй болж эхэлсэн тул Фүкүи мужаас 9 тэрбум 390 сая иений нэмэлт төсөв гаргаж, музейг өргөтгөхөөр төлөвлөж байна. (Эх сурвалж: 2019.01.21-ний Фүкүи сонин)

Монгол улсад ирэх жуулчдын тоо 2015 онд 390 мянга байсан нь 2019 онд 580 мянгад хүртэл жилд дунджаар 10.5 хувийн өсөлттэй явж ирсэн. Нөгөөтэйгүүр дэлхийн аялал жуулчлал 2019 онд байсан түвшинд хүртэл эргэж сэргэхэд 5-6 жил шаардлагагай гэгдэж байгаагаас үзэхэд 2026 оноос эхлээд 2019 оны өсөлтийн хувь хэмжээтэй адил жилд 10

хувиар өснө гэж тооцоолбол монголд ирэх жуулчдын тоо 2030 он гэхэд 1 саяыг давах болно. Улмаар 2030 онд гадаадын жуулчдын 20 хувь буюу 200 мянган хүн музей үзнэ гэж тооцоолбол, нэг хүний орох тасалбар 20 ам доллар, нийтдээ 4 сая ам долларын орлого орно гэж таамаглаж болно. Одоо хаагдсан байгаа “Байгалийн Түүхийн Музей”-г олон гадаадын жуулчид очиж үздэг байснаас харахад нийт жуулчдын 20 хувийг шинэ музей руу татна гэдэг нь биелэх боломжтой тоо юм. Мөн бэлэг дурсгалын зүйлийн борлуулалт, музейг үзсэнээс улбаалан Өмнөговь зэрэг бусад бүс нутгууд руу аялах аяллууд нэмэгдэх боломж зэргийг аваад үзсэн ч гэсэн эдийн засгийн үр дүн өндөртэй юм.

Түүнчлэн эдийн засгийн үр дүнгээр хязгаарлагдахгүй, шинжлэх ухааны мэдлэг, ёс зүйтэй аялах боловсрол олгох, цаашлаад дэлхийн өв болох олдворуудыг хамгаалах зэрэг ач холбогдлыг аваад үзвэл музейн үнэ цэнэ нь дотоодын ашиг орлогын хувь хэмжээ төдийгөөр хэмжигдэх боломжгүй юм. Олдвор олдсон газар гэдгээр нь Монгол улсад зөвхөн тэдгээрийг хамгаалах ажлыг даагах бус, дэлхий нийтээрээ хамтран хамгаалах нь зохистой хэмээн үзэж байна.

Хөрөнгө оруулалт (Япон тал)		Хөрөнгө оруулалт (Монгол тал)
<p><ЖАЙКА-ийн зөвлөх></p> <ol style="list-style-type: none"> 1) Багийн ахлагч / Музейн үйл ажиллагааны төлөвлөлт 2) Барилга байгууламж төлөвлөлт / зураг төсөл 3) Барилгын зураг төсөл (цахилгаан) 4) Барилгын зураг төсөл (тоног төхөөрөмж, цэвэр бохир ус, эрүүл ахуй) 5) Барилгын материал төлөвлөлт (дэвшилтэт инженерчлэл, нано технологи, байгаль орчны инженер, нийгмийн дэд бүтэц) 6) Барилгын материал төлөвлөлт (амин судлалын шинжлэх ухаан) 7) Музейн үйл ажиллагааны менежмент, хяналт 8) Санхүүгийн төлөвлөлт 9) Боловсрол сургалт төлөвлөлт (шинжлэх ухаан, аяллын үеийн соёл) 10) Худалдан авалт төлөвлөлт / үйл ажиллагааны зардал тооцоолол 11) Эдийн засаг санхүүгийн дүн шинжилгээ 12) Байгалийн нөхцөл байдлын тухай судалгаа / орчны нөлөөллийг анхаарах <p>40MM=140,000,000иен</p>	<p><Гэрээгээр гүйцэтгүүлж ажил гэх мэт></p> <p>Орчны нөлөөллийн үнэлгээ</p> <p>Хөрсний шинжилгээ</p> <p><Япон дахь сургалтын зардал></p>	<p><Соёлын Яам> <ШУА-ийн Палеонтологийн хүрээтэн></p> <p>Төслийн хамтрагч байгууллага болох</p> <p>Төслийн удирдах хороонд оролцох</p> <p>Төслийн оффисоор хангах</p> <p>Музей барих газрыг авах</p>
140,000,000иен	10,000,000иен	
Хэрэгжүүлэгч байгууллага		Хэрэгжүүлэх хугацаа
<p>Сангийн яам БОАЖЯ, Холбогдох аймгийн ЗДТГ Соёлын яам ЗТХЯ ШУА-ийн Палеонтологийн хүрээтэн</p>		<p>Бэлтгэл судалгаа: 1 жил орчим</p> <p>Барилгын ажил: 3 жил 6 сар орчим</p> <p>(Анхаарах зүйлс хэсэг дэх хуваариас нарийн мэдээллийг харна уу)</p>
Шаардагдах нөхцөл		
Ковид-19 цар тахлын дэгдэлт намжсан байх		

Анхаарах зүйлс

“Үндэсний үлэг гүрвэлийн музей”-тэй холбоотой хамтын ажиллагааг хэрэгжүүлэх төлөвлөгөө

Төсөл	Жил	1 дэх жил	2 дахь жил	3 дахь жил	4 дэх жил	5 дахь жил	6 дахь жил	7 дахь жил	8 дахь жил	9 дэх жил
"Үндэсний Үлэг Гүрвэлийн музей"-н барилгын төслийн бэлтгэл судалгаа [Иений хөнгөлөлттэй зээлтэй холбогдох техникийн тусламж]			■		E/N Тендер					
"Үндэсний Үлэг Гүрвэлийн музей" барилгын төсөл [Иений хөнгөлөлттэй зээлийн төсөл]					Барилгын ажил			Нээлт		
03 Богино хугацааны палентеологич мэргэжилтэн илгээх					■	■	■	■	■	
Музейн удирдлагыг хариуцах урт хугацааны мэргэжилтэн илгээх								■		
Музейн дижиталчлал хариуцах мэргэжилтэн илгээх							■			
Музейн палеонтологийн олдворыг бүртгэх ажлыг хариуцах мэргэжилтэн илгээх							■			
02 "Говийн бүс нутаг дахь аялал жуулчлалын тогтвортой хөгжлийн загварыг боловсруулах төсөл" [Техникийн хамтын ажиллагааны төсөл]			■							

Эх сурвалж: ЖАЙКА судалгааны баг

Хүснэгт 7-4: Төслийн санал 4

Төслийн дугаар	04 (Ганцаарчилсан мэргэжилтэн илгээх (урт хугацааны))	
Төслийн нэр	Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын маркетинг, зар сурталчилгааг сайжруулах	
Зорилго	Хамрах хүрээ	
Хархорины бүс нутгийг жуулчдын сэтгэлийг татах аялал жуулчлалын газар хэмээн өргөнөөр сурталчилж, танин мэдүүлэх үйл ажиллагааг дэмжих	Өвөрхангай аймаг, Архангай аймаг	
	Үр шим хүртэгч талууд	Технологи, ур чадварын дамжуулалт: 1) Орхоны хөндийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа 2) БОАЖГ 3) Аялал жуулчлалын холбоо 4) Аймгийн захиргааны албан хаагчид 5) Аялал жуулчлалын компаниуд
Үндэслэл, төслөөс хүлээгдэх үр дүн		
<p>Хархорины бүс нутаг нь Монголын эртний эзэнт гүрний нийслэл болох Хархорин, халуун рашаан бүхий Хужирт, Орхоны хүрхрээ, дэлхийн өвд бүртгэгдсэн Орхоны хөндий гэх мэт соёлын болон байгалийн өв, нүүдлийн соёлтой харьцангуй хялбархан танилцах боломжтой бүс нутаг тул, дотоод, гадаадын жуулчид ихээр сонирхож, олноор зочилдог. Төрийн бодлогын хүрээнд “Орхоны хөндийн бүс нутгийн аялал жуулчлалын стратеги-2020” болон “Орхоны хөндийн байгалийн цогцолборт газрын менежментийн төлөвлөгөө 2017-2021”-г боловсруулж аялал жуулчлалын маркетинг, сурталчилгааны стратегийг тодорхой болгох, маркетингийн төлөвлөгөө боловсруулах гэж мэт үйл ажиллагаагаар дамжуулж энэхүү салбар дахь зах зээлийн хүрээг нэмэгдүүлэхийг зорин ажиллаж байгаа боловч жуулчдад зориулсан тогтвортой мэдээллийн эх сурвалж, бааз байхгүй байна.</p> <p>Жуулчдад зориулсан веб сайт, аялал жуулчлалтай холбоотой мэдээллийн сан нээгдсэн байгаа боловч одоогийн байдлаар ашиглах боломжгүй байна. Цаашид тогтвортой аялал жуулчлалын хөгжлийг дэмжихийн тулд аялал жуулчлалын газруудын тухай мэдээллээр тогтмол хангах, сурталчлах нэн шаардлагатай.</p> <p>ЖАЙКА-аас мэргэжилтэн илгээнээр маркетинг, сурталчилгааны бодлого боловсруулах суурь тогтолцоог төрийн байгууллагад бүрдүүлэх боломжтой болох ба ингэснээр бүс нутгийн аялал жуулчлалын газрын жуулчдын сэтгэл, сонирхлыг татах чадавх нэмэгдэж, дэлхийн аялал жуулчлалын зах зээлд танигдах үр дүнтэй байх болно.</p>		
Үйл ажиллагааны агуулга		
<ul style="list-style-type: none"> - Маркетингийн эрэлт хэрэгцээг тодорхойлох - Сурталчилгааны материал бэлдэх - Гадаад зах зээл рүү чиглэсэн веб сайт нээх, мэдээллээр хангахад дэмжлэг үзүүлэх - Олон нийтэд мэдээлэл түгээх байнгын веб сайтыг бий болгох, видео контент боловсруулах - Олон нийтийн сүлжээг ашигласан сурталчилгааны практик хэрэглээг нэвтрүүлэх - Аялал жуулчлалын салбарт ажиллагсад зориулсан сургалт зохион байгуулах 		

Хөрөнгө оруулалт (Япон тал)		Хөрөнгө оруулалт (Монгол тал)
Аялал жуулчлалын маркетинг, сурталчилгааны чиглэлээр мэргэшсэн мэргэжилтэн илгээх 1 хүн	Үйл ажиллагааны зардал	<Аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газар> Ажлын байраар хангах
Хүлээн авах байгууллага		Хэрэгжүүлэх хуваарь
Орхоны хөндийн байгалийн цогцолборг газрын хамгаалалтын захиргаа		2 жил
Шаардагдах нөхцөл		
Ковид-19 цар тахлын дэгдэлт намжсан байх Аймаг тус бүрийн маркетинг зар сурталчилгааны санхүүгийн эх сурвалж баталгаажсан байх Харилцан хамтран ажиллах тогтолцоо бүрдсэн байх		
Анхаарах зүйлс		
Мэргэжилтэн нь зөвхөн тогтоосон ажил буюу аялал жуулчлалын маркетинг, зар сурталчилгааг хөгжүүлэхэд чиглэсэн ажлыг хийж гүйцэтгэх нь зүйтэй. Мөн тухайн ажлаа гүйцэтгэхийн тулд дүрс бичлэгт засвар хийх боломжтой компьютер гэх мэт тоног төхөөрөмж шаардлагатай тул ЖАЙКА-аас ханган хэрэглүүлэх шаардлагатай.		

Эх сурвалж : ЖАЙКА судалгааны баг

Хүснэгт 7-5: Төслийн санал 5

Төслийн дугаар	05 (Хөгжлийн судалгаа хэлбэрийн Техникийн хамтын ажиллагааны төсөл)
Төслийн нэр	Хархорин нисэх онгоцны буудлыг олон улсын нисэх буудал болгох мастер төлөвлөгөөний боловсруулалтыг дэмжих
Зорилго	Хамрах бүс нутаг
Хархорин нисэх онгоцны буудлыг олон улсын нисэх буудал болгох мастер төлөвлөгөөг боловсруулснаар агаарын тээврийн аюулгүй байдлыг сайжруулах, аялал жуулчлалын салбарын үйлчилгээг сайжруулах, валютын орлогыг нэмэгдүүлэх, улмаар Монгол улсын тогтвортой аялал жуулчлалын хөгжилд хувь нэмэр оруулах	Хархорины маршрут (Өвөрхангай аймаг)
	Үр шим хүртэгч талууд
	Шууд үр шим хүртэгч тал: 1) ЗТХЯ 2) ИНЕГ 3) Аймгийн захиргаа
Үндэслэл, төслөөс хүлээгдэх үр дүн	
<p>Хархорины маршрут бол Улаанбаатар хотоос харьцангуй ойр, гадаад дотоодын жуулчдын зорин очих дуртай, аялал жуулчлалын хамгийн өрсөлдөх чадвар өндөртэй нутгуудын нэг юм. 2004 онд Дэлхийн соёлын өвд бүртгэгдсэн Орхоны Хөндийн соёлын дурсгалт газар болон байгалийн олон нөөц баялагтай төдийгүй, уламжлалт түүх соёлоороо ч жуулчдыг анхаарлыг ихээхэн тагдаг.</p> <p>Аялал жуулчлалын үйлчилгээ өргөжин, дотоодын жуулчид ч ихээр зорин очдог газар боловч шууд нислэг байдаггүй тул машинаар удаан хугацааг (5 цаг) зарцуулж очихоос өөр сонголт байдаггүй. “Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр баримтлах бодлого 2019-2026”-д Өвөрхангай аймгийн нисэх онгоцны буудлыг олон улсын нисэх буудал болгох ажил тусгагдсан байна.</p> <p>Азийн Хөгжлийн Банкнаас хэрэгжүүлж буй “Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх” төслийн 3 дугаар үе шатыг Архангай болон Өвөрхангай аймгуудад хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа тухай БОАЖЯ мэдээлсэн. Тус төслийн 1, 2 дугаар үе шатанд, бусад аймгуудын мастер төлөвлөгөө, аялал жуулчлалын хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах, спортын төв, жуулчны гудамж, мэдээллийн төв, автомашины зогсоол, нийтийн бие засах газар, авто зам, отолгох цэг зэргийг байгуулах замаар дэд бүтцийг сайжруулах, түүнчлэн тусгай хамгаалалттай бүс нутгийн байгаль хамгааллын ажлууд хийгдэх төлөвтэй байна. Хэрэв тус төслийн 3 дугаар үе шат Архангай болон Өвөрхангай аймагт хэрэгжих тохиолдолд аялал жуулчлалын мастер төлөвлөгөө боловсруулах, дэд бүтцийн асуудлуудыг шийдвэрлэх зорилготой төрөл бүрийн төслүүд хэрэгжих магадлалтай байна.</p> <p>Нөгөөтэйгүүр судалгааны багийн Хархорины маршрутын алсын хараанд тусгасан “Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар Дэлхийн өвийн аяллыг өндөр түвшинд хүргэхийг зорих” ажлыг хэрэгжүүлэхийн тулд, Хархорин нисэх онгоцны буудлыг олон улсын нисэх буудал болгох нь томоохон үүрэг гүйцэтгэнэ. Өөр орноос Улаанбаатар хотоор дамжилгүй шууд Хархоринд ирэх боломжтой болбол аялагчдын хувьд маш амар хялбар болох учир Хархорин нисэх онгоцны буудлыг олон улсын нисэх буудал болгох ажлын төлөвлөлт, хэрэгжилтийг яаравчлах нь зүйтэй. Хархорин хот нь Дэлхийн өв болох Орхоны Хөндийн түүх соёлын дурсгалт газарт оршихын зэрэгцээ Монголын эзэнт гүрний нийслэл Хархорум хот байсан гэдгээрээ гадаадын жуулчдын сонирхлыг татаж чаддаг аялал жуулчлалын газар юм. Хархорин хот нь олон улсын нисэх буудалтай болж, гадаад орнуудаас шууд Хархоринд ирэх боломжтой болсноор Монгол улсын гадаадын жуулчдыг хүлээж авах хүчин чадал өргөжиж, төвлөрлийг сааруулах үр дүнтэй. Түүнээс гадна Улаанбаатар хотын олон улсын нисэх буудалд ямар нэгэн асуудал гарсан үеийн нөөц нисэх буудал болгох үүднээс ч гэсэн нэн шаардлагатай. Монгол улсад олон улсын нисэх буудал ганцхан байх нь үндэсний аюулгүй байдал талаасаа ч асуудалтай гэж үзэж байна.</p> <p>Засгийн газрын бодлогын баримт бичгүүдэд хэд хэдэн аймгуудын нисэх буудлыг олон улсын чанартай болгох талаар тусгагдсан байгаа хэдий ч, тэдгээрийн санхүүгийн эх үүсвэр тодорхойгүй байгаа юм. Засгийн газрын зүгээс олон улсын нисэх буудал болгох аймгуудын дэс дарааллыг хэрхэн төлөвлөж байгаа зэргээс шалтгаалан бодитоор хэрэгжихэд удаан хугацаа шаардагдах магадлалтайгаас гадна тулгарч буй асуудал ч их байгаа юм.</p> <p>Ийм нөхцөлд байдлыг харгалзан, Монгол улсын төлөвлөж буй дотоодын нисэх буудлыг олон улсын чанартай болгох ажлын хүрээнд, Хархорины нисэх буудлыг олон улсын чанартай болгох мастер төлөвлөгөөг боловсруулахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор Японоос мэргэжилтнийг илгээж, техникийн ур чадварыг дамжуулах нь зүйтэй юм.</p> <p>Мэргэжилтэн нь холбогдох яамд болон аймгийн засаг захиргааны байгууллагатай хамтран ажиллаж, техникийн ур чадварыг дамжуулахын сацуу Хархорин нисэх буудлыг олон улсын нисэх буудал болгох мастер төлөвлөгөөг боловсруулна. Ингэснээр цаашид дотоодын нисэх буудлыг олон улсын чанартай болгох төслийг саад бэрхшээлдгүй</p>	

хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах гэсэн үр дүнтэй байх болно.

Үйл ажиллагааны агуулга

1 дэх жил:

1. Өмнөх мэдээллийг цуглуулах, одоо ашиглагдаж буй нисэх онгоцны буудлын талаар судалгаа хийхэд зөвлөх
 - Өнөөг хүртэл хийгдсэн холбогдох судалгааны тайланд дүн шинжилгээ хийх
 - Одоо байгаа мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийх
 - Одоо ашиглагдаж буй нисэх онгоцны буудлын тухай судалгаа хийх (Нисэх буудлын барилга байгууламж, хүрээлэн буй нийгмийн болон байгалийн орчин, зам тээврийн нөхцөл байдал)
2. Нисэх онгоцны буудлыг олон улсын нисэх буудал болгох мастер төлөвлөгөөг боловсруулах (Япон улсаас судалгааны баг илгээх)
 - Агаарын тээврийн эрэлт хэрэгцээг судалж, хэтийн тооцоолол гаргах (зорчигчдын урсгал, ачаа тээшний ложистик)
 - Шинээр төлөвлөгдөж буй нисэх буудлыг байгуулах стандартыг боловсруулах
 - Одоо ашиглагдаж буй нисэх онгоцны буудлыг засаж сайжруулах, өргөтгөн ашиглах боломжийн талаар судлах

2 дахь жил:

3. Сургалт зохион байгуулах
 - Холбогдох албаныханд дотоодын сургалт зохион байгуулах
 - Холбогдох албаныханд Япон улс дахь сургалт зохион байгуулах
4. Хүрээлэн буй орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийн тухай
 - Хүрээлэн буй орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийг анхаарах тал дээр техникийн дэмжлэг үзүүлэх
 - Хүрээлэн буй орчинд үзүүлж буй нөлөөллийг үнэлэх тал дээр техникийн дэмжлэг үзүүлэх
5. Нэгдсэн үнэлгээ, зөвлөмж гаргах

Хөрөнгө оруулалт (Япон тал)

<ЖАЙКА-ийн зөвлөх>
 - Нисэх онгоцны буудлын мэргэжилтэн
 ●ММ+Томиололын зардал+Бусад зардал зэрэг=●иен

●иен

<Мэргэжилтний үйл ажиллагааны зардал>
 <Монгол талыг Японд урих зардал>
 Япон дахь сургалт●хүн=●иен
 <Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил>
 Дотоодын сургалт=●иен

●иен

Хөрөнгө оруулалт (Монгол тал)

Төсөл хэрэгжүүлэх Монголын хамтрагч тал
 Төслийн оффисоор хангах

Хэрэгжүүлэх байгууллага

ЗТХЯ
 Өвөрхангай аймгийн захиргаа

Хэрэгжүүлэх хугацаа

2 жил

Шаардагдах нөхцөл

Монгол улсын Засгийн газар Хархорин нисэх онгоцны буудлыг олон улсын нисэх буудал болгох төсвийг баталгаажуулсан, төлөвлөгөөг тодорхой болгосон байх
 Ковид-19 цар тахлын дэгдэлт намжсан байх

Анхаарах зүйлс

УИХ-ын дэд дарга, УИХ дахь Монгол-Туркийн парламентын бүлгийн дарга Т.Аюурсайхан, Бүгд Найрамдах Турк Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Зафер Атешийг хүлээн авч уулзах үеэр, УИХ-ын дэд дарга “Хархоринд нисэх буудал барих асуудалд хамтран ажиллахыг хүсэж байна” хэмээсэн бөгөөд үүний хариуд элчин сайд “Иргэний агаарын тээвэр зэрэг салбарт хамтын ажиллагаагаа урагшлуулах сонирхолтой байна” гэсэн хариулт өгсөн тухай мэдээлэл гарсан.

Эх сурвалж: <https://www.montsame.mn/en/read/267408#> (2021.06.28)

Эх сурвалж ЖАЙКА судалгааны баг

Хүснэгт 7-6: Төслийн санал 6

Төслийн дугаар	06 (Техникийн хамтын ажиллагааны тусгайлсан хөтөлбөр (Япон дахь сургалт))	
Төслийн нэр	Аялал жуулчлалын асуудал хариуцсан төрийн албан хаагчдад зориулсан аялал жуулчлалын салбарын Япон дахь сургалт	
Зорилго	Хамрах бүс нутаг	
<p>Аялал жуулчлалын хөгжлийг эдийн засгийн өсөлтөд чухал гэж үздэг Монгол улсын хувьд холбогдох яам, агентлаг зэрэг улсын байгууллагад ажиллаж буй ажилтан (аялал жуулчлалын асуудал хариуцсан төрийн албан хаагч) болон аймгийн засаг захиргаанд ажиллаж буй аялал жуулчлалын асуудал хариуцсан төрийн албан хаагчдад, Япон улсын аялал жуулчлалын хөгжлийн өнөөгийн байдал, тогтвортой аялал жуулчлал хөгжүүлэх тухай цогц мэдлэг, үндсэн чадварыг эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулах хэрэгцээ шаардлага нэн өндөр байна. Ингэснээр аялал жуулчлалын салбарын хөгжилд хувь нэмэр оруулахын зэрэгцээ харилцан мэдээлэл солилцох нөхцөлийг бүрдүүлж, Монгол, Япон 2 орны хооронд найрсаг харилцаа, аялал жуулчлалын салбарын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулна.</p>	<p>Нийслэл Улаанбаатар хот ба холбогдох 6 аймаг (Өмнөговь, Дундговь, Дорноговь, Говьсүмбэр, Архангай, Өвөрхангай)</p> <p>Үр шим хүртэгч талууд</p> <p>Шууд үр шим хүртэгч тал: БОАЖЯ, Нийслэлийн Аялал жуулчлалын газар, холбогдох 6 аймгийн БОАЖГ гэж мэт газраас сургалтад оролцох ажилтнууд</p> <p>Шууд бус үр шим хүртэгч тал: БОАЖЯ, Нийслэлийн Аялал жуулчлалын газар, холбогдох 6 аймгийн БОАЖГ гэж мэт сургалтад оролцох ажилтнуудын харьяа яам, агентлаг зэрэг улсын байгууллагууд</p>	
	Үндэслэл, төслөөс хүлээгдэх үр дүн	
	<p>БОАЖЯ-а аялал жуулчлалын бодлого, хууль зүйн орчин, хөгжлийн төлөвлөлт, гадаад харилцаа, сурталчилгаа зэрэг өргөн хүрээтэй асуудлыг цөөн тооны ажилтан хариуцан ажилладаг. Аймгийн түвшинд аялал жуулчлалын асуудал хариуцсан ганцхан ажилтан байдаг бөгөөд эдгээр ажилтнуудын аялал жуулчлалтай холбоотой мэдлэг, ур чадвар хангалтгүй гэж үзэж байна. Цаашид аялал жуулчлалын тухай хууль болон бусад аялал жуулчлалтай холбоотой хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулснаар бие даасан Аялал жуулчлалын агентлаг байгуулагдаж магадгүй бөгөөд одоо ажиллаж буй ажилтнуудын аялал жуулчлалын мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлж, боловсон хүчнийг дахин сургах нь нэн чухал юм.</p> <p>Ялангуяа орон нутгийн аялал жуулчлалын асуудал хариуцсан ажилтан нь гадаадын улс орнуудын жишгээтэй танилцаж, суралцсан туршлага дутмаг, аялал жуулчлалын салбарын талаар ойлголт сул байгаа тул эдгээр ажилтнуудад Японы төр болон орон нутгийн засаг захиргаанаас хэрэгжүүлж буй аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого, жуулчдад зориулсан үйлчилгээ, мэдээлэл сурталчилгааг хэрэгжүүлэх төлөвлөгөөний талаар танилцуулахын зэрэгцээ зочид буудал гэх мэт аялал жуулчлалын үйлчилгээний газруудаар очиж үзэх боломж олгох шаардлагатай юм. Япон орны өнөөгийн байдлыг өөрийн биеэр үзэж танилцсан мэдлэг туршлагаа өдөр тутмын ажилдаа ашиглах замаар ажлынхаа үр бүтээмжийг дээшлүүлэх боломжтой гэж үзэж байна. Танилцах аяллын үеэр Монгол улстай найрамдалт харилцаатай Японы орон нутгийн засаг захиргаагаар зочлон, цар тахлын улмаас зогсонги байдалд ороод байгаа хамтын ажиллагааг цаашид сэргээж идэвхжүүлэх талаар санал солилцох уулзалтыг зохион байгуулахыг хүсэж байна.</p>	
Үйл ажиллагааны агуулга		
<p>【Аялал жуулчлалын салбарын Япон дахь сургалт】</p> <p>Уг сургалт нь танхимын лекц, газар дээр нь очиж үзэж танилцах хөтөлбөр, сургалтын аялал гэсэн хэсгээс бүрдэнэ. Сургалтын гол сэдвүүд нь дараах болно.</p> <ol style="list-style-type: none"> 1) Аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого ба аялал жуулчлалын салбар 2) Аялал жуулчлалын хөгжил ба байгаль орчин, аялал жуулчлалын нөөцийн хамгаалалт зэрэгцэн орших тухай 3) Музей зэрэг аялал жуулчлалын байгууламжийн үйл ажиллагаа, сурталчилгааг хийх бодит жишгээ (музейд шаардлагатай үзмэрийг цуглуулах, цэгцгэх, хадгалах, үзмэрт тавих, боловсрол сургалтад ашиглах бодит аргачлалын сургалт) 		

4) Япон улсын жижиг дунд зочид буудал ба Монгол гэр жуулчны бааз (Точиги мужийн “Тэнгэр виллаж” болон бусад), Үлэг гүрвэлийн музей (Фүкүи муж) зэрэг байгууламжийг үзэж танилцах аялал	
5) Монгол улстай найрамдалт харилцаатай Японы орон нутагт зочлох	
Хөрөнгө оруулалт (Япон тал)	
Хоёр талын нисэх онгоцны зардал Байр, хоолны зардал Аяллын даатгал Сургалт лекцийн төлбөр Нисэх онгоцны буудлаас тосож авах ба хүргэж өгөх зардал Орон нутгийн аяллын зардал	
< Япон дахь сургалт > Богино хугацааны сургалтад хамрагдах хүний тоо: 10 хүн/ жилд • БОАЖЯ • Аялал жуулчлалын хөгжлийн төв • Нийслэлийн Аялал жуулчлалын газар • Холбогдох 6 аймгийн БОАЖГ Үүн дээр нэмээд Монголын аялал жуулчлалын холбоо болон бусад төрийн бус байгууллагуудаас энэхүү сургалтад оролцох тал дээр зөвшилцөх	<Сургалтын зардал>
●исн	●исн
Хэрэгжүүлэх байгууллага	
【Санал болгож буй хамтран ажиллах байгууллагууд】 Японы Зам Тээврийн яам Аялал жуулчлалын газар Хоккайдо Их сургуулийн Аялал жуулчлалын дэвшилтэт судалгааны төв Хоккайдо Их сургуулийн Олон улсын мэдээлэл, сурталчилгаа, аялал жуулчлалын сургууль	
Хэрэгжүүлэх хугацаа	
Давтамж: Жилд 1-2 удаа Сургалтын хугацаа: 3 долоо хоног	
Шаардагдах нөхцөл	
Шалгуур: 1) Одоогийн байдлаар Засгийн газар болон төрийн байгууллагад ажилладаг байх ба мэргэжлээрээ 3-аас дээш жил ажилласан байх 2) Зарчмын хувьд 40 наснаас доош байх 3) Бусад орны соёлтой холбоотой үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог байх	
Гадаад нөхцөл	
Ковид-19 цар тахлын дэгдэлт намжсан байх	
Анхаарах зүйлс	
Энэхүү төслийн саналыг 01 дугаартай “Монгол улсын тогтвортой аялал жуулчлалын бодлогын мэргэжилтэн илгээх” төслийн саналтай хамтаар техникийн хамтын ажиллагааны төслийг хэрэгжүүлэх боломжтой ба үр дүнтэй гэж үзэж байна.	

Эх сурвалж: ЖАЙКА судалгааны баг

8-р бүлэг

Япон улсын орон нутгийн засаг захиргааны байгууллага хийгээд судалгааны зорилтот бүс нутгийн иргэд, олон нийт хоорондын хамтын ажиллагааны талаар дэвшүүлэх санал

8-р бүлэг Япон улсын орон нутгийн засаг захиргааны байгууллага хийгээд судалгааны зорилтот бүс нутгийн иргэд, олон нийт хоорондын хамтын ажиллагааны талаар дэвшүүлэх санал

8.1 Хамтын ажиллагааны өнөөгийн байдал

Монгол улсын орон нутгийн засаг захиргааны байгууллагатай найрамдалт харилцаатай, эгч дүүс хот мөн “Токио 2020” олимп, паралимпын наадмын хүрээнд Японы Засгийн газраас хэрэгжүүлж буй “Хост таун” хөтөлбөрт хамрагдсан Японы орон нутгийн засаг захиргааны байгууллагад асуулгын хуудас илгээж, хоёр орны орон нутгийн засаг захиргааны байгууллага хоорондын харилцаа, хамтын ажиллагааны өнөөгийн байдлын талаарх мэдээллийг цуглуулсан болно. Энэхүү судалгаанд хамрагдсан байгууллагуудыг доорх жагсаалтаар харуулав.

Хүснэгт 8-1: “Хост таун” хөтөлбөрт хамрагдсан болон эгч дүүс хотын харилцаа, найрамдалт харилцаатай орон нутгийн засаг захиргааны байгууллагууд, консулын газрын жагсаалт

А. “Хост таун” хөтөлбөрт хамрагдсан болон эгч дүүс хотын харилцаа, найрамдалт харилцаатай орон нутгийн засаг захиргааны байгууллагууд			
No.	Япон Улсын орон нутгийн засаг захиргааны байгууллага	Монгол Улсын орон нутгийн засаг захиргааны байгууллага	“Хост таун” хөтөлбөр (спортын төрөл)
A-1	Аомори мужийн Имабэцу хот	...	Туялзуур сэлэм
A-2	Ибараки мужийн Сакурагава хот	...	Буудлага Спорт
A-3	Ибараки мужийн Широсато хот	...	Каратэ
A-4	Ибараки мужийн Намэгата хот	...	Хүндийн өргөлт
A-5	Токио хот Мүсашимүраяма хот	Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэг	Сүмо бөх г.м чиглэлээр хамтын ажиллагаа
A-6	Нийгата муж	...	Пара-Байт харваа
A-7	Нийгата мужийн Нийгата хот	...	Пара-Байт харваа
A-8	Нийгата мужийн Цүбамэ хот	...	Пара-Байт харваа
A-9	Нийгата мужийн Госэн хот	Улаанбаатар хотын Чингэлтэй дүүрэг	Пара-Байт харваа
A-10	Нийгата мужийн Нагаока хот	...	Пара-Байт харваа
A-11	Нийгата мужийн Яхико тосгон	Төв аймгийн Эрдэнэ сум	Пара-Байт харваа
A-12	Нагано мужийн Саку хот	Улаанбаатар хотын Сүхбаатар дүүрэг	...
A-13	Шизүока муж	Дорноговь аймаг, Сэлэнгэ аймаг	...
A-14	Шизүока мужийн Изүноүни хот	Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэг	Жүдо бөх, Параспорт
A-15	Шизүока мужийн Яйзү хот	Улаанбаатар хотын Чингэлтэй дүүрэг	Чөлөөт бөх, паралимпын хөнгөн атлетик, сагсан бөмбөгийн 3х3 төрөл, пара таеквондо
A-16	Шизүока мужийн Шимада хот	...	Боксын Спорт
A-17	Айчи мужийн Оказаки хот	...	Байт харваа
A-18	Осака мужийн Изүмисано хот	Төв аймаг	Хөнгөн атлетик (марафон гүйлт)
A-19	Хёого мужийн Тоёоока хот	Баянхонгор аймгийн Богд сум (харилцаа түр зогссон)	...
A-20	Тоттори муж	Төв аймаг	...
A-21	Нагасаки мужийн Мацүүра хот	Өвөрхангай аймгийн Хужирт сум (харилцаа тасалдсан байгаа)	...
A-22	Ойта мужийн Уса хот	...	Таеквондо
A-23	Миязаки мужийн Мияконожо хот	Улаанбаатар хот	Чөлөөт бөх
В. Консулын газрын жагсаалт			
No.	Консулын газрын нэр		
B-1	Саппоро хот дахь Өргөмжит консулын газар		
B-2	Осака дахь Ерөнхий Консулын газар		
B-3	Нийгата хот дахь Өргөмжит консулын газар		
B-4	Нагояа хот дахь Өргөмжит консулын газар		
B-5	Токүшима дахь Өргөмжит консулын газар		
B-6	Фүкүока дахь Өргөмжит консулын газар		
С. Бусад (А болон В гэс бусад орон нутгийн засаг захиргааны байгууллага)			
No.	Япон Улсын орон нутгийн засаг захиргааны байгууллага	Монгол Улсын орон нутгийн засаг захиргааны байгууллага	
C-1	Хоккайдо муж		
C-2	Хоккайдо мужийн Саппоро хот		
C-3	Хоккайдо мужийн Такикава хот	Өвөрхангай аймаг	
C-4	Хоккайдо мужийн Мүкава хот	(Шинжлэх ухааны академи Палеонтологийн хүрээлэн: Хамтын ажиллагааны гэрээ)	
C-5	Ишикава муж		
C-6	Ойта муж		
C-7	Окинава муж		
C нэмэлт	Шига муж	(Хөвсгөл нуур болон Бивако нуур: Хамтын ажиллагааны төсөл)	
C нэмэлт	Хоккайдо мужийн Асахикава хот	(ЖАЙКА Өвсний үндэс хөтөлбөр: Хүйтэн бүс нутаг дахь хот байгуулалтын технологийг сайжруулах төсөл)	

(Тайлбар) Зарчмын хувьд “Хост таун” хөтөлбөрт дан ганц орон нутгийн засаг захиргааны байгууллага бүртгүүлж ёстой боловч, Нийгата мужийн хувьд "Нийгата муж болон Нийгата хот, Цүбамэ хот, Госэн хот, Нагаока хот, Яхико тосгон" нь хамтран Пара-Байт харвааны “Хост таун”-аар бүртгүүлсэн. Гэсэн хэдий ч орон нутгийн засаг захиргаа бүрийн харилцаа буй хүн, мөн хамтын үйл ажиллагааны чиглэл ч өөр өөр тул тус бүрт нь судалгаа хийж, энэхүү жагсаалтад тус тусад нь (А-6-аас А-11 хүртэл) дугаарлаж оруулсан болно.

Дээрх санал асуулгад хариу ирүүлсэн 30 орон нутгийн засаг захиргааны байгууллага, 5 консулын газрын мэдээлэлд үндэслэн дараах дүн шинжилгээг хийв (2021 оны 2-р сарын 26-ны байдлаар). Зарим консулын газрын хувьд тухайн орон нутгийн засаг захиргааны талаарх мэдээллээс гадна, консулын газрын өөрсдийн хэрэгжүүлж буй хамтын ажиллагааны тухай мэдээллийг мөн ирүүлсэн байна.

Сүүлийн жилүүдэд орон нутгийн засаг захиргааны байгууллага хоорондын харилцаа өргөжин тэлж байна. “Токио 2020” олимп, паралимпын наадмын хүрээнд Японы Засгийн газраас хэрэгжүүлж буй “Хост таун” хөтөлбөрт бүртгүүлснээр Монгол улстай хамтын ажиллагааг шинээр эхлүүлж байгаа орон нутгийн засаг захиргааны байгууллага ч байгаа бөгөөд өнөөг хүртэл Монгол улстай харилцаа, хамтын ажиллагаатай байсан орон нутгийн засаг захиргаа “Хост таун” хөтөлбөрт бүртгүүлсэн тохиолдолд ч байгаа юм.

Энэхүү судалгаанаас харахад эгч дүүс хотын харилцаа / найрамдалт харилцаатай (эсвэл харилцаатай байсан) 12, “Хост таун” хөтөлбөрт бүртгэгдсэн 18 орон нутгийн засаг захиргааны байгууллага байна. Эдгээр орон нутгийн засаг захиргааны байгууллагын хамтын ажиллагааны гэрээ байгуулсан үе болон харилцаа тогтоох болсон шалтгааны талаар санал асуулгын хариултад үндэслэн доорх хүснэгтээр нэгтгэн харуулав.

Хүснэгт 8-2: Эгч дүүс хотын харилцаа / найрамдалт харилцаатай орон нутгийн засаг захиргааны байгууллагын жагсаалт (хамтын ажиллагааны гэрээ байгуулсан он, харилцаа тогтоох болсон шалтгаан)

Япон Улсын орон нутгийн засаг захиргааны байгууллага	Монгол Улсын орон нутгийн засаг захиргааны байгууллага	“Хост таун” хөтөлбөр (спортын төрөл)	Гэрээний төрөл	Гэрээ байгуулсан он/сар/өдөр	Гэрээ байгуулснаас хойшхи хугацаа	CIR/Монгол ажилтан	Харилцаа тогтоох болсон шалтгаан
Нагасаки мужийн Мацуура хот	Өвөрхангай аймгийн Хужирт сум (харилцаа тасалдсан байгаа)	-	Эгч дүүс хот	1991/7/27	30		Монголын эзэнт гүрэн Япон руу довтолсон үеийн түүхтэй холбоотойгоор харилцаа үүссэн
Хёого мужийн Тобёока хот	Баянхонгор аймгийн Богд сум (харилцаа түр зогссон)	-	Найрамдалт харилцааны гэрээ	1994/10/9	27		Хуучин Осакагийн Гадаад хэлний дээд сургуулийн монгол хэлний ангийн оюутнуудаар дамжуулж харилцаа үүссэн. "Тантогийн Торгоны замын төлөвлөгөө"
Тоттори муж	Төв аймаг	-	Найрамдалт харилцааны санамж бичиг	1997	24	CIR	Дайны дараа Монголд нас барсан Тоттори мужийн гаралтай Япон цэргүүдийн булшиг эргэх, үлдэгдэл ясыг цуглуулахаар Монголд очсон Тоттори мужийн төлөөлөгчид Төв аймгийн Засаг даргад бараалхаж, Тоттори мужид зохиох экспод Монголоос урлагийн баг илгээхийг хүссэнээс үүдэлтэй
Миязаки мужийн Мияконохо хот	Улаанбаатар хот	Чөлөөт бөх	Найрамдалт хотын харилцаа	1999/11/22	22	CIR	"Монголд салхин цэвэрлэгч станц бэлэглэх холбоо", Мияконохо Косэн зэрэг хувийн хэвшил хоорондын хамтын ажиллагаа үргэлжилж байна
Нагано мужийн Саку хот	Улаанбаатар хотын Сүхбаатар дүүрэг	-	Найрамдалт хот	2008/8/4	13		Хоёр орны засгийн газар Япон дахь Монголын жил(2006)", "Монгол дахь Японы жил(2007)"ийг зарласан. Агаарын бөмбөлгийн фестиваль
Шизуока муж	Дорноговь аймаг, Сэлэнгэ аймаг	-	Хамтын ажиллагааны гэрээ	2011/7/29	10	Монгол ажилтан	Мужийн Захирагч Монголтэй харилцахыг хүссэн бөгөөд Япон хэлтэй Дорноговь аймгийн Засаг даргатай(тэр үеийн) найрсаг харилцаа тогтоосноос үүдэлтэй
Осака мужийн Изумисано хот	Төв аймаг	Хөнгөн атлетик (марафон гүйлт)	Найрамдалт хот	2013/7/27	8	CIR	Төв аймагт олон улсын шинэ нисэх онгоцны буудал ашиглалтад орох бөгөөд 2 хот хоёулаа олон улсын нисэх онгоцны буудалтай хот гэдгээрээ ижил төстэй
Шизуока мужийн Изуноүни хот	Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэг	Жудо бөх, Параспорт	Хамтын ажиллагааны гэрээ	2015/8	6	CIR	Осака хот дахь Монгол Улсын Ерөнхий консул Изуноүни хотод зочилж, хотын даргатай үулсэн. Дараа нь Сонгинохайрхан дүүргийн засаг дарга Ерөнхий консулаар дамжуулан Изуноүни хотын даргад захидал хүргүүлснээр харилцаа эхэлсэн
Нийгата мужийн Яхико тосгон	Төв аймгийн Эрдэнэ сум	Пара-Байт харваа	Найрамдалт харилцаа	2016/8/9	5		Мэргэжлийн Сүмогийн Монгол бөхчүүд санал тавьж, Элчин сайдын яам танилцуулсан
Шизуока мужийн Яйзу хот	Улаанбаатар хотын Чингэлтэй дүүрэг	Чөлөөт бөх, паралимпын хөнгөн атлетик, сагсан бөмбөгийн Эх3 төрө	Хамтын ажиллагаа	2018/8/8	3	Монгол ажилтан	Өмнө нь харьцаатай байсан Биешин тамир, спортын газрын даргын санаачилгаар харилцаа үүссэн
Хоккайдо мужийн Такикава хот	Өвөрхангай аймаг	-	Найрамдалт харилцааны тунхаглал	2018/9/23	3	CIR	Мэргэжлийн Сүмогийн их аварга Хақхо аялал жуулчлалын элч болж, "Монголд будаа тариалах" мөрөөдлөө хэрэгжүүлэхээр хөдөө аж ахуйн дадлагажигчдыг хүлээн авч эхэлсэн
Токио хот Мүсашимүраяма хот	Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэг	Сүмо бөх г.м чиглэлээр хамтын ажиллагаа	-	2021 онд гэрээ байгуулах төлөвлөгөөтэй	2(2018-)		Хоёр талын бага ангийн сурагчдын дунд сүмо бөхийн тэмцээн зохион байгуулсан г.м. Элчин сайдын яам танилцуулсан

Эх сурвалж: Судалгаанд хамрагдсан орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хийсэн ярилцлага, асуулгад өгсөн хариулт


(Тайлбар) Эгч дүүс хотын харилцаа / найрамдалт харилцаатай 12 орон нутгийн засаг захиргааны байгууллагаас хариу ирүүлсэн 11 орон нутгийн засаг захиргааг жагсаав. Токио хотын Мүсашимүраяма хот энэ жил /2021 он/ хамтын ажиллагааны гэрээ байгуулахаар төлөвлөж байгаа тул жагсаалтад багтаасан болно.

Хүснэгт 8-3: “Хост таун” хөтөлбөрт бүртгүүлсэн орон нутгийн засаг захиргааны байгууллагын жагсаалт (Спортын төрөл, бүртгүүлсэн жил, бүртгүүлэх болсон үндэслэл, шалтгаан)

Япон Улсын орон нутгийн засаг захиргааны байгууллага	“Хост таун” хөтөлбөр (спортын төрөл)	“Хост таун” д бүртгүүлсэн он	Монгол Улсын орон нутгийн засаг захиргааны байгууллага	CIR/ Монгол ажилтан	“Хост таун” д бүртгүүлэх болсон үндэслэл, шалтгаан
Аомори мужийн Имабэцу хот	Тяулзуур сэлэм	2016	...	CIR	Тяулзуур сэлэмний спортын хот
Ибараки мужийн Сакурагава хот	Буудлага Спорт	2017	...		Буудлагын дасгалжуулагч нь Сакурагава хотын иргэн
Ибараки мужийн Ширасато хот	Каратэ	2018	...		Монгол Улсыг дэмжиж тусалдаг NPO-ийн үйл ажиллагаа
Ибараки мужийн Намэгата хот	Хүндийн өргөлт	2019	...	Монгол ажилтан	МҮОХ-ны хүсэлтээр хувь хүн зүүчилсэн
Токио хот Мүсашимүраяма хот	Сүмо бөх г.м чиглэлээр хамтын ажиллагаа	2017	Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэг		Элчин сайдын яам танилцуулсан
Нийгата муж	Пара-Байт харваа	2016	...		
Нийгата мужийн Нийгата хот	Пара-Байт харваа	2016	...		
Нийгата мужийн Цүбамэ хот	Пара-Байт харваа	2016	...		Нийгата муж танилцуулсан
Нийгата мужийн Госэн хот	Пара-Байт харваа	2016	Улаанбаатар хотын Чингэлтэй дүүрэг		...
Нийгата мужийн Нагаока хот	Пара-Байт харваа	2016	...		Их дээд сургууль, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа
Нийгата мужийн Яхико тосгон	Пара-Байт харваа	2016	Төв аймгийн Эрдэнэ сум		Мэргэжлийн Сүмогийн Монгол бөхчүүдтэй харилцаатай
Шизүока мужийн Изүноүни хот	Жүдо бөх, Параспорт	2016	Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэг	CIR	Ерөнхий консул танилцуулсан
Шизүока мужийн Яйзү хот	Чөлөөт бөх, паралимпийн хөнгөн атлетик, сагсан бөмбөгийн 3х3 төрөл, пара таеквондо	2016	Улаанбаатар хотын Чингэлтэй дүүрэг	Монгол ажилтан	Мужийн идэвхтэй ажиллагаа, мөн тус хотод чөлөөт бөх хичээллэдэг хүн олонтой
Шизүока мужийн Шимада хот	Боксын Спорт	2017	...	Монгол ажилтан	Иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагаа
Айчи мужийн Оказаки хот	Байт харваа	2019	...		Их дээд сургууль, найрамдлын нийгэмлэгүүд зуучилсан
Осака мужийн Изүмисано хот	Хөнгөн атлетик (марафон гүйлт)	2017	Төв аймаг	CIR	Найрамдалт хотын харилцаагаа хөгжүүлэх зорилгоор
Ойта мужийн Үса хот	Таеквондо	2018	...		Мэргэжлийн Сүмогийн Монгол бөхчүүдтэй харилцаатай
Миязаки мужийн Мияконожо хот	Чөлөөт бөх	2016	Улаанбаатар хот	CIR	Хувийн хэвшлийн хамтын ажиллагаа

Эх сурвалж: Судалгаанд хамрагдсан орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хийсэн ярилцлага, асуулгад өгсөн хариулт

Дээрх эгч дүүс хотын харилцаа / найрамдалт харилцаатай орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын хамтын ажиллагаа үргэлжилж байгаа хугацаа, Гадаад харилцааны ажилтан(CIR) /Монгол ажилтан байгаа эсэхийг дараах графикаар харьцуулан харуулав.



Эх сурвалж: Судалгаанд хамрагдсан орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хийсэн ярилцлага, асуулгад өгсөн хариулт

Зураг 8-1: Хамтын ажиллагаа үргэлжилж байгаа хугацаа



Эх сурвалж: Судалгаанд хамрагдсан орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хийсэн ярилцлага, асуулгад өгсөн хариулт

Зураг 8-2: Гадаад харилцааны ажилтан(CIR) /Монгол ажилтан байгаа эсэх

Орон нутгийн засаг захиргааны байгууллага хоорондын харилцаа тогтоох болсон шалтгааныг төрлөөр ангилж доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 8-4: Харилцаа тогтоох болсон шалтгаан

Харилцаа тогтоох болсон шалтгаан
·Төрөлх орон нутгаа сэргээн хөгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд 90-ээд оны эхээр Монгол улстай харилцаа, хамтын ажиллагааг эхлүүлсэн [Мацүүра хот, Тоёоока хот]
·Дайны дараа Монголд хоригдож байгаад нас барсан Япон цэргүүдийн булшийг эргэх, булшны үлдэгдлийг цуглуулах зорилготойгоор Монголд очсон [Тоттори муж]
·Орон нутгийн их дээд сургуулиуд, хувийн хэвшил хоорондын харилцаа, хамтын ажиллагаа, материаллаг эд зүйлсийн дэмжлэг туслалцаа [Мияконожо хот, Тоёоока хот]
·Засгийн газар, Элчин сайдын яам, консулын газрын санаачилгаар хамтын ажиллагааг эхлүүлсэн [Сакү хот, Изүнокүни хот, Мүсашимүраяма хот]
·Засаг дарга болон орон нутгийн засаг захиргааны байгууллагын санаачилгаар хамтын ажиллагааг эхлүүлсэн [Шизүока муж, Изүмисано хот]
·Мэргэжлийн сумогийн Монгол бөхчүүдээр дамжин холбоо харилцааны эхлэл тавигдсан [Яхико тосгон, Такикава хот, Мүсашимүраяма хот]

Эх сурвалж: Судалгаанд хамрагдсан орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хийсэн ярилцлага, асуулгад өгсөн хариулт

<Голлох хамтын ажиллагаа болон хамтын ажиллагаа нь тогтвортой орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын жишээ>

Эгч дүүс хотын харилцаа / найрамдалт харилцаатай болон “Хост таун” хөтөлбөрт бүртгүүлсэн орон нутгийн засаг захиргааны байгууллагын хэрэгжүүлж буй хамтын ажиллагааг ангилж, доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 8-5: Орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын хэрэгжүүлж буй голлох хамтын ажиллагаа

Эгч дүүс хотын харилцаа/найрамдалт харилцаатай орон нутгийн засаг захиргааны байгууллага	Албан ёсны айлчлал, иргэд/залуучуудын солилцоо (харилцан айлчлал), соёлын солилцоо (яармаг / үзэсгэлэн), Сургалт / боловсрол, материаллаг эд зүйлсийн дэмжлэг, туслалцаа, аялал жуулчлал
“Хост таун” орон нутгийн засаг захиргааны байгууллага	Спортын солилцоо, урьдчилсан бэлтгэлийн бааз, соёлын солилцоо (яармаг, нөхөрсөг уулзалт), материаллаг эд зүйлсийн дэмжлэг, туслалцаа

Эх сурвалж: Судалгаанд хамрагдсан орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хийсэн ярилцлага, асуулгад өгсөн хариулт

Таван жилээс дээш хамтран ажиллаж буй орон нутгийн засаг захиргааны байгууллагын хамтын ажиллагааны гэрээ байгуулах болсон шалтгаан, хамтын ажиллагааны голлох чиглэл, үйл ажиллагааг доор нэгтгэн үзүүлж байна.

(1) Нагасаки мужийн Мацүүра хот ба Өвөрхангай аймгийн Хужирт сум (одоогоор хамтын ажиллагаа түр зогссон)

1) Харилцаа тогтоох болсон шалтгаан

Нагасаки мужийн Мацүүра хот Такашима аралын Коозаки далай эргээс Монголын эзэнт гүрэн Япон руу 2 дахь удаагаа довтолсон үеийн (1281) олдвор олдсон юм. 1974 онд олдсон тэрхүү олдвор нь Хувилай хааны эзэнт гүрний цэргийн дээд тушаалтан, жанжид хэрэглэж асан гэгдэх "Зэс тамга" бөгөөд үүнтэй уялдуулан 2 орны орон нутаг хоорондын хамтын ажиллагааг эхлүүлэхээр шийдсэн. Такашима хотын дарга Монгол Улсаас Япон улсад суугаа Элчин сайдын яаманд зочилж санал тавьснаар, 1991 оны 7-р сард Хархорум хот байдаг Өвөрхангай аймгийн Хужирт сумтай эгч дүүс хотын харилцааг байгуулсан байна.

2) Хамтын ажиллагааны голлох чиглэл, үйл ажиллагаа

- 1989 оны 6-р сард “Төрөлх хот хөгжлийн төсөв”-өөр Олон улсын хамтын ажиллагааны сан байгуулж, иргэд солилцооны хөтөлбөрийн анхны төлөөлөгчдийг Монгол руу илгээсэн. Хотын жимс тариалалтын ашгаар төсвөө бүрдүүлэн, иргэд солилцооны хөтөлбөрийн төлөөлөгчдийн багийг (дунд, ахлах ангийн сурагчдыг оролцуулан) жил бүр Монгол руу илгээж байв. 2000 он хүртэл нийт 8 удаа иргэд солилцооны хөтөлбөрийн төлөөлөгчдийг илгээсэн бөгөөд нийт 90 хүн Монголд зочилжээ.
- 1992 оны 11-р сард Хужирт сумын дарга болон сумын ИТХ-ын дарга Такашимад анх удаа айлчлав.
- 1993 оны 5-р сард “Монгол тосгон”-ы нээлтийн ёслол болов (Хужирт сумын дарга болон бусад холбогдох хүмүүс, Монгол ардын дуу бүжгийн хамтлаг оролцов).
- 1994 оны 11-р сард Анхны Монгол наадмыг зохион байгуулав (Хужирт сумын орлогч дарга, Тамгын газрын дарга хүрэлцэн ирсэн).
- 2000 оны 7-р сард Иргэд солилцооны хөтөлбөрийн төлөөгчдийн 8 дахь удаагийн баг Монгол улсад айлчилсан ба төлөөлөгчид Монгол улсын Ерөнхийлөгчид бараалхав.
- 2003 оны 11-р сард Такашима дахь Монгол Тосгон байгуулагдсаны 10 жилийн ойн баяр ёслол болов.
- 2009 оны 11-р сард Такашима Монгол наадамд Японы мэргэжлийн сумо бөхийн Их аварга Хакүхо оролцож, олон тооны жуулчид ирэв
- 2013 оны 9-р сард Такашима дахь Монгол Тосгоны 20 жилийн ойн баяр ёслол болов

*Түүнээс хойш харилцаа тасалдсан бөгөөд хамтын ажиллагааг дахин сэргээхэд зуучилж өгөх талаар Япон дахь Монгол Улсын Элчин сайдын яаманд хүсэлт тавиад байна.

Эх сурвалж: Судалгаанд хамрагдсан орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хийсэн ярилцлага, асуулгад өгсөн хариулт

(2) Хёого мужийн Тоёока хот болон Баянхонгор аймгийн Богд сум (одоогоор хамтын ажиллагаа зогссон)

1) Харилцаа тогтоох болсон шалтгаан

1985 онд Осакагийн Гадаад Судлалын Их Сургуулийн (одоогийн Осакагийн их сургууль) монгол хэлний ангийн оюутнууд Монголын хөдөө аж ахуйн талаар судалгаа хийхээсээ өмнө Японы хөдөө орон нутгийг судлахаар болж, тухай үед "Тантогийн Торгоны замын төлөвлөгөө" -г сурталчилж байсан Танто тосгон /өнөөгийн Тоёока хот/-ыг сонирхон очиж үзсэн байна. Түүний дараа Осакагийн Гадаад Судлалын Их Сургуулийн Монгол багшийг Танто тосгонд урьж авчран, "Монгол хоол хийх аргыг заах" мөн "Нүүдэлчдийн соёлыг танилцуулах" зэрэг арга хэмжээ зохион байгуулснаас гадна, Монголоос газар тариалангийн чиглэлийн залуу дадлагажигчдыг хүлээн авч байсан. 1990 онд Япон-Монголын хамтарсан нүүдлийн мал аж ахуйн бүс нутгийг судлах “Товь төсөл”-д Танто тосгоны хөгжлийг хариуцсан ажилтан анх удаа оролцжээ. 1992 онд Монголын Засгийн газрын холбогдох хүмүүс Танто тосгонд зочилсон бөгөөд дараа жил нь Танто тосгоноос "Япон Монголын найрамдлын баг" Монгол улсад анх удаа айлчилж, түүнээс хойш ойролцоогоор 2 жилд нэг удаа харилцан айлчилж байжээ.

1994 оны 10-р сарын 4-11 ны хооронд Танто тосгонд болсон "Ой мод, цөлийн тухай олон улсын симпозиум

ба хөгжмийн наадам"-д оролцохоор Баянхонгор аймгийн Богд сумын дарга тус тосгонд зочилсон бөгөөд Тантао тосгоны даргатай найрамдалт харилцааны гэрээнд гарын үсэг зурсан. 1996 оны 11-р сард Япон-Монголын үндэсний музейг Тантао тосгонд байгуулсан.

2) Хамтын ажиллагааны голлох чиглэл, үйл ажиллагаа

Өнөөдөр Богд сумтай харилцаа солилцоо байхгүй. Улаанбаатар хотод төвтэй “Монгол-Тоёока Торгон замын найрамалын нийгэмлэг”-тэй харилцдаг.

Хүснэгт 8-6: Тоёока хотын хүүхдийн солилцооны хөтөлбөр

«Тоёока хотын хүүхдийн солилцооны хөтөлбөр» 2018 он хүртэл	
12 удаа илгээсэн	Нийт 127 хүн
14 удаа хүлээж авсан	Нийт 95 хүн

Эх сурвалж: Судалгаанд хамрагдсан орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хийсэн ярилцлага, асуулгад өгсөн хариулт

(3) Тогтори муж ба Төв аймаг

1) Харилцаа тогтоох болсон шалтгаан

Дайны дараа Монголд олзлогдож байгаад нас барсан Тогтори мужийн гаралтай Япон цэргүүдийн булшийг эргэх, шарилийг чандарлан нутагт нь буцаахаар Тогтори мужийн ИТХ-н төлөөлөгчид 1994 онд Монголд очсон. Энэ үеэр Төв аймгийн Засаг даргад бараалхаж, Тогтори мужид зохион байгуулах гэж байсан “Сан-Ин Юмэ Минато” экспод Монголоос урлагийн хамтлаг илгээхийг хүссэнээр хамтын ажиллагаа эхэлсэн ажээ. Түүний дараа хоёр талын төлөөлөгчдийн баг харилцан айлчилдаг болсон бөгөөд 1997 онд зохион байгуулагдсан дээрх экспод Төв аймаг үзэсгэлэн гаргаж, мөн тэр жилдээ "Япон улсын Тогтори муж ба Монгол улсын Төв аймаг хооронд найрамдалт харилцаа тогтоох санамж бичиг"- т гарын үсэг зурж, албан ёсны харилцаа, хамтын ажиллагаа эхэлсэн.

2) Хамтын ажиллагааны голлох чиглэл, үйл ажиллагаа

- Төв аймгийн оюутан залууст зориулсан тусгай тэтгэлгийн хөтөлбөр /Тогтори их сургуульд элсэн орсон/
- Залуучуудын солилцооны хөтөлбөр /Тус мужийн ахлах сургуулийн сурагч Төв аймагт зочилж, ахлах ангийн Япон хэл сурч буй сурагчидтай харилцаж, гэрээр нь зочлон, монгол ахуй соёлтой танилцдаг/
- Эмнэлэг, эрүүл мэндийн салбарын хамтын ажиллагаа /Төв аймгийн эмч нарыг дадлагажигчаар хүлээн авахын зэрэгцээ, Тогтори мужийн эмнэлгийн мэргэжилтнийг Төв аймагт илгээж, мэргэжлийн заавар, зөвлөгөө өгөх зэргээр ажиллуулж байна/
- Захиргааны ажилтаны практик сургалт /Төв аймгийн захиргааны ажилтнуудыг Тогтори мужид хүлээн авч сургалт зохион байгуулдаг/
- Хөдөө аж ахуйн салбарын хамтын ажиллагаа /Төв аймгийн хөдөө аж ахуйн мэргэжилтнүүдийг Тогтори мужийн Хөдөө аж ахуйн их сургуульд хүлээн авч сургалтад хамруулах/

Эх сурвалж: Судалгаанд хамрагдсан орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хийсэн ярилцлага, асуулгад өгсөн хариулт болон Тогтори мужийн албан ёсны цахим хуудас <https://www.pref.tottori.lg.jp/dd.aspx?menuid=37632>

(4) Миязаки мужийн Мияконожо хот ба Улаанбаатар хот

1) Харилцаа тогтоох болсон шалтгаан

1992 оны 12-р сард Монголын цөөн сурагчтай сургууль, малчин өрхийг гэрэл цахилгаантай болгохын тулд бага оврын салхин цахилгаан станц бэлэглэх зорилготойгоор "Монголд салхин цахилгаан станц бэлэглэх холбоо" байгуулагдсан. 1993 оны 8-р сар, 1994 оны 8-р сард тус холбооны гишүүд Монголд айлчилсан. Тэр үеэр Мияконожо хотын даргын илгээсэн захидлыг Улаанбаатар хотын Засаг дарга, Өмнөговь аймгийн Даланзадгад хотын дарга, ШУТИС-ийн захирал нарт тус тус хүргэжээ. 1995 оны 3-р сард Мияконожо Технологийн Үндэсний Коллеж (Мияконожо Косэн) болон Монгол улсын Шинжлэх Ухаан Технологийн

Их Сургуулийн хооронд эрдэм шинжилгээний солилцооны гэрээг байгуулсан. Түүнээс хойш жил бүр иргэд хоорондын солилцоо явдаг болжээ. 1999 оны 9-р сард Мияконожо хотын ИТХ-ын ээлжит хуралдаанаар Улаанбаатар хоттой найрамдалт харилцаа тогтоох шийдвэрийг баталсан ба Улаанбаатар хотын захирагч 1999 оны 11-р сарын 22-нд Мияконожо хотод айлчилж, найрамдалт харилцааныг эргээнд гарын үсэг зурсан.

2) Хамтын ажиллагааны голлох чиглэл, үйл ажиллагаа

- Албан ёсны айлчлал

2002 оноос хойш хоёр хотын дарга, орлогч дарга, ИТХ-ын дарга, дэд дарга нар 2 жил тутамд 1 удаа харилцан айлчлал хийдэг болсон.

- Гадаад харилцааны ажилтан (CIR) /Монгол ажилтан/ хүлээн авах

- Залуучуудын солилцоо, харилцан айлчлал

- Чөлөөт бөхийн солилцоо, хамтын ажиллагаа

Монголын чөлөөт бөхийн баг тамирчид болон Японы олимпын тамирчдыг урьж "Монгол-Японы чөлөөт бөхийн найрамдалт арга хэмжээ" зохион байгуулж байна.

- Миязаки үүлдрийн үхрийн махны гадаад борлуулалтын сувгийг өргөжүүлэх

Япон улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам нь жил бүр зохион байгуулдаг Эзэн хааны төрсөн өдрийн хүлээн авалтын үдэшлэгт Мияконожо хотод үйлдвэрлэсэн Миязаки үүлдрийн үхрийн махаар зочдоо дайлдаг. Мөн Улаанбаатар хот дахь Япон хоолны ресторануудад амгалгаат худалдааг зохион байгуулж, сурталчилж байна.

(5) Нагано мужийн Сакү хот ба Улаанбаатар хотын Сүхбаатар дүүрэг

1) Харилцаа тогтоох болсон шалтгаан

2006 онд "Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ой" тохиосонтой холбогдуулан Япон, Монгол хоёр орны Засгийн газар 2006 оныг "Япон дахь Монголын жил", 2007 оныг "Монгол дахь Японы жил" болгон зарласан. Энэ жилүүдэд хоёр орны холбогдох байгууллагууд, найрамдлын нийгэмлэгүүд найрамдал, хамтын ажиллагааны олон төрлийн үйл ажиллагаа төлөвлөж, зохион байгуулсан юм. Японы Парламентын гишүүд болон бусад холбогдох хүмүүсээс бүрдсэн Япон, Монголын найрамдлын жилийг зохион байгуулах хорооноос "Агаарын бөмбөлөгийн фестиваль"-аар Япондоо алдартай хотуудын нэг болох Сакү хотод агаарын бөмбөлөг болон нисгэгчдийг Монголд илгээхийг хүссэн. Олон улсын хамтын ажиллагаанд хувь нэмэр оруулах, мөн Сакү хотыг сурталчлах зорилгоор тус хотоос агаарын бөмбөлөг болон нисгэгчдийг хоёр жилийн турш Монголд илгээсэн.

2015 оны 8-р сарын 4-нд Улаанбаатар хотын захиргааны байранд Улаанбаатар хотын Засаг дарга, Япон Улсаас Монгол улсад суугаа Элчин сайд, Сакү хот-Монголын найрамдлын нийгэмлэгийн гишүүдийг байлцуулан найрамдалт харилцаатай хотын гэрээг байгуулсан. Гэрээнд гарын үсэг зурах уг ёслолд Япон талаас Сакү хотын захирагч Д.Миүра, хотын ИТХ-ын дарга Э.Нишина, Монгол талаас Сүхбаатар дүүргийн Засаг дарга А.Амарсайхан, дүүргийн ИТХ-ын дарга С.Багхуяг нар оролцсон ажээ.

2) Хамтын ажиллагааны голлох чиглэл, үйл ажиллагаа

Хүний нөөцийг хөгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн айл өрх болон малчин айл өрхүүдэд зочилж амьдарч үзэх гэх мэт үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. 2010-2019 он хүртэл 10 удаа хэрэгжсэн энэ үйл ажиллагаа 2020 онд "Ковид-19" халдварт цар тахалаас болж цуцлагджээ.

Мөн Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн хүүхдүүдэд Японы соёл, зан заншлыг таниулж ойлгуулах, нөхөрлөлийг нь гүнзгийрүүлэхийн тулд Сакү хотод хүлээн авдаг. Хүүхдүүд Япон айлд амьдарч, дунд сургуулийн хичээлд сууж үзэх, сургуулийн сурагчидтай уулзалт зохиох зэргээр Японы соёл, амьдрал, зан үйлтэй танилцдаг байна.

(6) Шизүока муж ба Дорноговь аймаг болон бусад

1) Харилцаа тогтоох болсон шалтгаан

2010 оны 8-р сард Шизүока мужийн захирагч Монгол улсад айлчлах үедээ Дорноговь аймгийн Засаг дарга П.Ганхуягтай уулзаж санал бодлоо солилцсон. 2010 оны 10-р сард Дорноговь аймгийн Засаг дарга Шизүока мужид айлчилсан ба 11-р сард Монгол улсын Ерөнхийлөгч Япон улсад айлчлах үеэр Дорноговь аймагтай хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурсан. 11-р сард Монгол улсын тэргүүн хагагтай /ерөнхийлөгчийн гэргий/ Шизүока мужийн Хорт хавдар судлалын төвд зочилсон. Энэ айлчлалын үеэр тэргүүн хагагтайн санаачлан байгуулсан "Итгэл" Хавдаргүй Монгол Үндэсний сангай хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зуржээ. 11-р сарын 19-ний өдөр Японы "Тэйхинкан" Төрийн Зочны Өргөөнд Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийг байлцуулан, Засаг дарга Х.Кавакацу, Засаг дарга П.Ганхуяг нар хоёр талын хамтын ажиллагааны тухай санамж бичигт гарын үсэг зуржээ.

2) Хамтын ажиллагааны голлох чиглэл, үйл ажиллагаа

2011 он

- Албан ёсны төлөөлөгчид Монгол улсад айлчилж, Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газар дээр найрамдлын гэрээг байгуулсан (7/29) (113 хүн).
- Дорноговь аймгийн багш нар, ахлах ангийн сурагч солилцооны хөтөлбөрийн талаар хэлэлцэхээр Шизүока мужид хүрэлцэн ирсэн (3 хүн).
- Монголоос Шизүока муж руу аялал жуулчлалын багийг илгээсэн (нийт 3 групп, 65 хүн).

2012 он

- Дорноговь аймгийн эдийн засаг, бизнесийн төлөөлөгчид Шизүока мужид айлчилсан (20 хүн).
- Мужийн ИТХ-ын даргаар ахлуулсан мужийн иргэд солилцооны төлөөлөгчид Монголд айлчилсан (48 хүн).
- Мужийн бүс нутгийн хөгжлийн төвийн ерөнхийлөгч Яногоор ахлуулсан найрамдлын хамтын ажиллагааны төлөөлөгчид Монголд айлчилж, Японы соёлын өдөрлөгт оролцсон.
- Дорноговь аймгийн ахлах ангийн сурагчдыг хүлээн авсан (30 сурагч + 2 багш).

2013 он

- Мужийн Засаг даргаар ахлуулсан мужийн иргэд солилцооны 129 хүнтэй төлөөлөгчид Монголд айлчилсан.
- Дорноговь аймгийн Засаг дарга тэргүүтэй төлөөлөгчид Шизүока мужид айлчилсан (15 хүн).
- Дорноговь аймгийн дунд сургуулийн сурагчид Шизүока мужид айлчилсан (Шизүока-Монголын найрамдлын нийгэмлэг) (20 сурагч + 1 багш).

2014 он

- Мужийн Засаг даргын орлогч Такагаар ахлуулсан эдийн засаг, бизнесийн хамтын ажиллагааны төлөөлөгчид Монголд айлчилсан (17 хүн).
- Дорноговь аймгийн ахлах ангийн сурагчдыг хүлээн авсан (50 хүн).
- Дорноговь аймгийн Засаг дарга тэргүүтэй төлөөлөгчид болон дунд сургуулийн сурагчид Шизүока мужид айлчилж, орон нутаг хооронд найрамдлын гэрээ байгуулсны 3 жилийн ойд зориулсан арга хэмжээг зохион байгуулсан (28 хүн).
- Нишпондайра зочид буудалд аймгийн Засаг дарга нартай санал солилцох уулзалтыг зохион байгуулсан (22 хүн).

2015 он

- Токиогийн олимпод оролцох тамирчдын бэлтгэл хийх талаар Эрүүл мэнд, спортын яамтай батламж бичигт гарын үсэг зурсан (4 хүн).
- Мужийн Засаг дарга тэргүүтэй төлөөлөгчид Монголд айлчилж танилцуулга, сурталчилгаа хийсэн (56 хүн).
- Монгол улсын БСШУЯ-тай боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах тухай санамж бичигт гарын үсэг зурсан.
- Мужийн ахлах ангийн сурагчид Монголд айлчилсан (35 хүн).
- Монгол улсын БСШУЯ-ны төрийн нарийн бичгийн дарга тэргүүтэй төлөөлөгчид Шизүока мужид айлчилсан бөгөөд хоёр талын цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцсон (9 хүн).
- Дорноговь аймгийн Засаг дарга тэргүүтэй төлөөлөгчид болон дунд сургуулийн сурагчдыг муждаа хүлээж авсан. (Засаг дарга тэргүүтэй 10 төлөөлөгч, дунд сургуулийн 20 сурагч).
- Монголын паралимпын хорооны дарга мужийн Засаг даргад бараалхаж, Яйзү хотод айлчлан, хоттой танилцсан (2 хүн).

2016 он

- Мужийн Засаг дарга тэргүүтэй төлөөлөгчид Монголд айлчилж, танилцуулга, сурталчилгаа хийсэн (104 хүн).
- Дорноговь аймагт зохион байгуулагдсан Найрамдалт харилцаа байгуулсны 5 жилийн ойн ёслолд оролцсон.
- Монгол улсын БСШУЯ-тай боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах тухай санамж бичигт гарын үсэг зурсны 1 жилийн ойн арга хэмжээнд оролцсон.
- Монгол улсын БСШУЯ болон Шизүока Их Сургуулийн хооронд Монгол улсаас Шизүока Их Сургуульд оюутан хүлээн авах тухай батламж бичигт гарын үсэг зурсан.
- Мужийн ахлах ангийн сурагчид Монголд айлчилсан (35 хүн).
- Шизүока Их сургууль болон Шизүока мужийн Их сургуулийн захирал зэрэг их дээд сургуулийн удирдлагууд Монгол улсын 5 их дээд сургууль, ахлах сургуулиар зочилж, мужийн их дээд сургуулиудад ирж суралцах боломж нөхцөлийн талаар танилцуулсан.
- 2016 оны 6-р сард Япон-Монголын Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр (ЕРА) хүчин төгөлдөр болсонтой уялдуулан "Шизүока мужийн Гадаад худалдааны орчин" сэдэвт уулзалт семинарыг ХХААХҮЯ-тай хамтран зохион байгуулсан.Тус мужаас 3 компани, 2 байгууллага оролцож, Монголын 5 компанитай бизнес уулзалтыг хийсэн аж. Японы бизнесийн соёл, ёс зүйн тухай танилцуулах зорилготой аж ахуйн нэгжийн менежментийн зөвлөх мэргэжилтэн зөвлөгөө өгөх уулзалтыг мөн зохион байгуулсан.
- Монгол улсын Сэлэнгэ аймагтай хөдөө аж ахуйн салбарт хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурсан.
- Дорноговь аймгийн ахлах ангийн сурагчдыг хүлээн авсан.

2017 он

- Мужийн Засаг дарга тэргүүтэй төлөөлөгчид Монголд айлчилж, танилцуулга, сурталчилгаа хийсэн (120 хүн).
- Мужийн ахлах ангийн сурагчид Монголд айлчилсан (25 хүн).
- Дорноговь аймгийн ахлах ангийн сурагчдыг хүлээн авсан.

2018 он

- Мужийн Засаг дарга тэргүүтэй төлөөлөгчид Монголд айлчилж, танилцуулга, сурталчилгаа хийсэн (160 хүн).
- Монгол улсаас ахлах ангийн сурагчид (40 хүн) хүрэлцэн ирж, мужийн ахлах ангийн сурагчидтай нөхөрсөг уулзалт хийх зэрэг арга хэмжээг зохион байгуулсан.
- Улаанбаатар хотод төвтэй агаарын тээврийн "Хүннү Эйр" компанийн захирал Шизүока мужид айлчилсан. Тэрээр дараа жилийн зун Фүжисан Шизүока нисэх онгоцны буудлаас захиалгат нислэг үйлдэхээр төлөвлөж байгаа тухайгаа мужийн Засаг даргад танилцуулав.

2019 он

- Мужийн бүс нутгийн гадаад харилцааны газрын даргаар ахлуулсан төлөөлөгчид Монголд айлчилсан (жуулчидыг оролцуулаад 160 орчим хүн). Ахлах сургуулийн сурагчдын баг (25 хүн) нь Дорноговь аймаг болон Монгол улсын бусад ахлах ангийн сурагчидтай нөхөрсөг уулзалт зохион байгуулж, нутгийн соёл, зан заншилтай танилцжээ.
- Монгол улсаас ахлах ангийн сурагчид (38 хүн) Японд зочилж мужийн ахлах ангийн сурагчидтай нөхөрсөг уулзалт хийх зэрэг арга хэмжээг зохион байгуулсан.
- Тус мужийн 37 бизнес эрхлэгчдээс бүрдсэн эдийн засаг, бизнесийн төлөөлөгчид Монголд айлчилж бизнес удирдлагын семинар зохион байгуулсан (165 хүн оролцсон). Мөн Япон хэлтэй их, дээд сургуулийн оюутнуудыг Японд ажилд зуучлах зорилгоор хамтарсан ярилцлагыг зохион байгуулсан (340 хүн хамрагдсан).

2020 он

- Монгол улсын багш сурган хүмүүжүүлэгчид, боловсрол, сургалтын төвийн захирлууд, Дорноговь аймгийн боловсрол, соёл урлагийн газрын даргатай цахим уулзалт зохион байгуулсан.
- Дорноговь аймгийн сурагчдад Шизүока мужаас сурагчийн цүнх бэлэглэсэн (бэлэг хүлээлгэн өгөх ёслолыг цахимаар хийж, цүнхийг шуудангаар явуулсан).
- Сэлэнгэ аймгаас ирсэн ур чадварын дадлагажигчдын сургалт эхэлсэн

Эх сурвалж: Шизүока мужийн материал "Шизүока муж болон Монгол улс хоорондын хамтын ажиллагааны ололт амжилт 20210212"

(7) Осака мужийн Изүмисано хот ба Төв аймаг

1) Харилцаа тогтоох болсон шалтгаан

1997 онд Изүмисано хотын Изүмисано эмнэлэг шинэ эмнэлгийн байранд нүүж орох болсонтой холбогдуулан хуучин эмнэлэгтээ ашиглаж байсан ор, эмнэлгийн тоног төхөөрөмж гэх мэт 100 орчим эмнэлгийн тоног төхөөрөмж, хэрэгслийг Монгол улсын 1-р эмнэлэгт хандивласнаар Монгол улстай хамтын ажиллагаагаа эхлүүлсэн юм. Төв аймагт 2021 оны 7-р сарын 4-д олон улсын шинэ нисэх онгоцны буудал ашиглалтад орсон бөгөөд 2 хот хоёулаа олон улсын нисэх онгоцны буудалтай хот гэдгээрээ ижил төстэй болсон юм. Монгол-Японы харилцааг дэмжих “Түншийн холбоо” нийгэмлэгээс Төв аймгийг санал болгосон үе нь тус хот хөрш орнуудын орон нутгийн засаг захиргаатай хамтарч ажиллах боломжийг хайж байсан чухал цаг үетэй таарснаараа онцлог юм. Өөрөөр хэлбэл Изүмисано хотын Ринку тауныг эмнэлэг, эрүүл мэндийн тусгай бүс болгосон, Кансай олон улсын нисэх онгоцны буудлын ашиглалтыг сайжруулах, тус хотыг далайн чанадад сурталчлах, жуулчдыг татах, мөн бусад улс оронтой соёлын харилцаатай болох зорилготой их ажил өрнөж байсан үе юм. 2013 оны 2-р сард Изүмисано хотын дарга Төв аймагт айлчилсан. 2013 он нь Изүмисано хот байгуулагдсаны 65 жилийн ой, Төв аймаг байгуулагдсаны 90 жилийн ой тохиосон жил байсан тул, 2013 оны 7-р сард болсон Төв аймгийн 90 жилийн ойн баяраар 2 аймгийн найрамдалт харилцааны гэрээнд гарын үзэг зурж, хамтын ажиллагаагаа эхлүүлсэн. 2013 оноос хойш боловсрол, спорт, соёлын салбарт хамтын ажиллагаа явуулж, боловсон хүчний солилцоо хийж ирсэн. Төв аймагтай найрамдалт хотын харилцаагаа хөгжүүлж, Монгол улстай хамтын ажиллагаагаа улам бүр

гүнзгийрүүлэх зорилгоор “Хост таун” хөтөлбөрт хамрагдахаар зорьж, Монгол улсын марафон гүйлт, хөнгөн атлетикийн тамирчид байрлаж, бэлтгэл хийх “Хост таун” хотоор 2017 оны 7-р сарын 7-ны өдөр бүртгүүлсэн юм.

2) Хамтын ажиллагааны голлох чиглэл, үйл ажиллагаа

○ Төв аймагтай хэрэгжүүлж буй хамтын ажиллагаа

- Гадаад харилцааны Монгол ажилтан(CIR) хүлээн авч ажиллуулах: Төв аймгаас ирсэн гадаад харилцааны ажилтан нь 2 талын хамтын ажиллагаатай холбоотой үйл ажиллагааг зохицуулах, орчуулах, мөн хотын сургуулиуд дээр очиж Монгол соёлыг танилцуулах, хотын захиргаанаас гаргадаг сонин сэтгүүлд Монгол орны тухай бичиж нийтлэх зэрэг ажлыг хариуцан явуулдаг. (2014 оноос хойш).
- Дунд сургуулийн сурагчдыг Монголд илгээх (хотын Боловсролын хорооноос хэрэгжүүлж буй үйл ажиллагаа): 2014-2019 он хүртэл жил болгон тус хотын дунд сургуулиудаас төлөөлсөн 10 сурагчийг Төв аймагт илгээсэн бөгөөд Монголын аж амьдрал, соёлтой танилцаж, орон нутгийн дунд сургуулийн сурагчидтай нөхөрсөг уулзалт зохион байгуулсан.
- Арга хэмжээнд оролцох: Төв аймгийн Засаг даргын орлогч тэргүүтэй төлөөлөгчид 2018 онд Изүмисано хот байгуулагдсаны 70 жилийн ойд зориулсан арга хэмжээнд ирж оролцсон.

○ “Хост таун” хөтөлбөр

- Урьдчилсан бэлтгэлийн баазад тамирчдыг хүлээн авах: Монгол улс нь өвлийн улиралд маш хүйтэн, гадаа бэлтгэл хийх нь хүндрэлтэй байдаг тул 2017 оноос эхлэн Монгол улсын марафон гүйлтийн тамирчдыг тус хотод хүлээн авч, бэлтгэл (нэг сар орчим) хийлгэж байна.
- 2017 онд 8, 2018 онд 10, 2019 онд 8 тамирчин (дасгалжуулагч ороод) тус тус хүлээн авч бэлтгэл хийлгэсэн юм. Бэлтгэлийн үеэр ойр орчмын бүс нутагт зохион байгуулагдсан "KIX Senshu International Marathon" зэрэг марафон гүйлтийн тэмцээнд оролцож, “Хост таун” хөтөлбөрийг сурталчилсны зэрэгцээ хүүхдийн цэцэрлэгийн марафон гүйлтэд зочноор оролцох, бага сургуулийн сурагчидтай уулзалт зохион байгуулах, дунд сургуулийн хөнгөн атлетикийн клубтэй хамтарсан бэлтгэл хийх зэргээр хотын иргэдтэй хамтран төрөл бүрийн үйл ажиллагаанд оролцсон.
- 2020 оны бэлтгэлийг 2-р сарын 9 нөөс 3-р сарын 17-ны хооронд хийхээр төлөвлөж байсан боловч бэлтгэлийн үеэр "Ковид-19" халдварт цар тахал тархаж, Монгол руу буцах нислэг зогссон тул тамирчид харьж чадахгүй болсон юм. Иймээс бэлтгэлийн хугацааг сунгаж, Монголоос түр нислэг ирж тамирчид буцаж чадах болтол буюу 6-р сарын 11-ны өдөр хүртэл бэлтгэл хийлгэсэн ба энэ хугацаанд тамирчдыг зөөх, бэлтгэлийн гутал, өдөр тутмын хэрэгцээт зүйл, уураг худалдан авахад нь дэмжлэг үзүүлэх зэргээр ажилласан.
- Монголын хөнгөн атлетикийн холбооны урилгаар нийслэл Улаанбаатар хотод зохион байгуулагдах Олон улсын марафон гүйлтийн тэмцээнд 2017 оноос жил бүр нэг тамирчдыг илгээсэн.

Эх сурвалж: Судалгаанд хамрагдсан орон нутгийн засаг захиргааны байгууллагагай хийсэн ярилцлага, асуулгад өгсөн хариулт

(8) Шизүока мужийн Изүнокүни хот ба Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэг

1) Харилцаа тогтоох болсон шалтгаан

2013 оны 8-р сард Осака хот дахь Монгол Улсын Ерөнхий консул Шизүока мужийн захирагчид бараалхсан ба улмаар Изүнокүни хотод зочилж, хотын даргатай уулзсан. Дараагийн жилийн 7-р сард Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга Ерөнхий консулаар дамжуулан Изүнокүни хотын даргад захидал хүргүүлснээр харилцаа эхэлсэн. Хэд хэдэн харилцан айлчлал, уулзалт хэлэлцээний дараа 2015 оны 8-р сард Сонгинохайрхан дүүрэгтэй найрамдалт харилцаа тогтоох санамж бичигт гарын үсэг зурсан. Мөн Токиогийн олимпод оролцох Монголын жүдо бөхийн үндэсний шигшээ багийн тамирчдын бэлтгэл хийх тухай санамж бичигт гарын үсэг зурсан болно. Тамирчид нь 2017 оноос Японд болох олон улсын тэмцээний үеэр Изүнокүни хотод байрлаж, бэлтгэл хийхийн зэрэгцээ хотод зохиогдсон өсвөр насныхны жүдо бөхийн тэмцээнд оролцох, сургуулиудаар зочилж сурагчидтай нөхөрсөг уулзалт зохиох зэргээр үйл ажиллагаа явуулсан.

2) Хамтын ажиллагааны голлох чиглэл, үйл ажиллагаа

2015 он

- Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга М.Чинболд тэргүүтэй 11 хүн Изунокүни хотод айлчилсан. Монгол Улсаас Осака хот дахь Ерөнхий консул Ч.Куланда хотын даргад бараалхаж, хоттой танилцсан.
- Шизүока мужийн урилгаар Монгол Улсын Эрүүл мэнд, спортын дэд сайд тэргүүтэй төлөөлөгчид айлчилсан. Токио 2020 олимпод оролцох тамирчдын урьдчилсан бэлтгэлийн бааз болохоор нэрээ дэвшүүлж буй Изунокүни хотод зочилж, жүдо бөхийн шигшээ багийг хүлээн авах талаар ярилцаж, барилга, байгууламжтай танилцсан.
- Хотын Засаг даргын орлогч, аялал жуулчлалын хэлтсийн дарга, хотын хамтын ажиллагааны хэлтсийн дарга нар Монгол улсад айлчилж, "Токио 2020 олимпод оролцох жүдо бөхийн тамирчдын урьдчилсан бэлтгэлийн бааз болох" "Сонгинохайрхан дүүрэгтэй найрамдалт хотын харилцаа байгуулах" тухай санамж бичгийн талаар хэлэлцсэн.тухай санамж бичгийн талаар хэлэлцсэн.

2016 он

- Хотын дарга, ИТХ-ын дарга болон захиргааны ажилтан нийт 6 хүн Монгол улсад айлчилж, "Токио 2020 олимпод оролцох жүдо бөхийн тамирчдын урьдчилсан бэлтгэлийн бааз болох" тухай санамж бичигт гарын үсэг зурсан.
- Хотын дарга, ИТХ-ын дарга зэрэг нийт 6 хүн Сонгинохайрхан дүүрэгт зочилж, "Сонгинохайрхан дүүрэгтэй найрамдалт хотын харилцаа байгуулах" тухай санамж бичигт гарын үсэг зурсан.
- Хотын дарга, ИТХ-ын дарга, ИТХ-ын гишүүн, хотын захиргааны ажилтан зэрэг нийт 7 хүн захиалгат нислэгээр Монголд очиж Сонгинохайрхан дүүрэгт зочилсон. Мөн дунд сургуулийн сурагчдын гадаадад хийх анхны сургалтын хүрээнд, тус хотын дунд сургуулийн 4 сурагч, 1 багш нийт 5 хүн айлчилсан бөгөөд хотын иргэдийн төлөөлөгч 9 хүн мөн энэ үеэр уг дүүрэгт зочилсон.

2017 он

- Хотын захиргааны 2 ажилтан болон гадаад харилцааны Монгол ажилтан нийт 3 хүн Сонгинохайрхан дүүрэгт зочилж, албан ёсны айлчлалын төлөөлөгчид болон дунд сургуулийн сурагчдын багийн солилцооны талаар харилцан ярилцаж, санамж бичиг солилцжээ. Мөн хөдөө аж ахуйн салбарын холбогдох газруудаар явж танилцан, техникийн туслалцаа үзүүлэх талаар ярилцсан. Хотын захиргааны 2 ажилтан болон гадаад харилцааны Монгол ажилтан Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яаманд зочилсон.
- Боловсролын хорооны дарга, хотын ИТХ-ын дарга, хотын ИТХ-ын гишүүд, хотын захиргааны 4 ажилтан нийт 7 хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид Монгол улсад айлчилсан. Дунд сургуулийн сурагчдын гадаадад хийх 2 дахь сургалтын хүрээнд, тус хотын дунд сургуулийн 2 сурагч, 1 багш айлчилсан бөгөөд хотын иргэдийн төлөөлөгчид 7 хүн мөн энэ үеэр уг дүүрэгт зочилсон.

2018 он

- Хотын дарга, хотын ИТХ-ын дарга, гишүүд, хотын захиргааны 4 ажилтан болон гадаад харилцааны Монгол ажилтан зэрэг 8 хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид Монгол улсад айлчилсан.
- Дунд сургуулийн сурагчдын гадаадад хийх 3 дахь сургалтын хүрээнд, тус хотын дунд сургуулийн 20 сурагч, 1 багш мөн айлчилсан.

2019 он

- Хотын дарга, ИТХ-ын дарга, гишүүд, хотын захиргааны 6 ажилтан болон гадаад харилцааны Монгол ажилтан зэрэг 10 хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид захиалгат нислэгээр Монгол улсад айлчилсан. Спортын агентлагтай Токио 2020 олимп, паралимптой холбоотой албан бичигт гарын үсэг зурах ёслол болжээ. Дунд сургуулийн сурагчдын гадаадад хийх 4 дэхь сургалтын хүрээнд, тус хотын дунд сургуулийн 18 сурагч, 2 багш, мөн хотын иргэдийн төлөөлөл 9 хүн айлчилсан.

Эх сурвалж: Судалгаанд хамрагдсан орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хийсэн ярилцлага, асуулгад өгсөн хариулт

(9) Нийгата мужийн Яхико тосгон ба Төв аймгийн Эрдэнэ сум

1) Харилцаа тогтоох болсон шалтгаан

2015 оны 8-р сард Яхико Шинто шашны сүмийг нүүлгэн шилжүүлсний 100 жилийн ойн баяр болсон бөгөөд энэ үеэр сүмд Сумогийн шинэ дэвжээ нээгдэж, нээлтийн ёслолын ажиллагаа болсон. Энэхүү ёслолд Мэргэжлийн Сумо бөхийн их аварга Харүмафүжи, озэки Тэрүнофүжи зэрэг Монгол бөхчүүд оролцжээ. Тэр үед Монгол бөхчүүд өөрсдийн эх орон Монгол болон Японы хоорондох гүүр болохыг хүсэж байгаагаа илэрхийлсэн нь хамтын ажиллагааны эхлэл болсон. Дараа нь Монголын Элчин сайдын яамнаас Эрдэнэ сумтай харилцаа тогтоохыг санал болгосон.

2) Хамтын ажиллагааны голлох чиглэл, үйл ажиллагаа

2016 он

- Яхико Монголын найрамдлын нийгэмтэг байгуулагдсан. Япон Улсад суугаа Монгол Улсын Элчин сайд, мужийн Гадаад харилцааны монгол ажилтан нар Яхико тосгонд зочилж, бага сургуультай танилцсан.
- Яхико тосгоны боловсролын хорооны дарга болон тосгоны Засаг даргын Тамгын газрын ерөнхий хэлтсийн дарга Эрдэнэ сумд айлчилсан.
- Яхико тосгоны Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын ерөнхий хэлтсийн дарга, дунд сургуулийн захирал, дунд сургуулийн 6 сурагч (айлчлахыг хүссэн 20 сурагчаас 6 нь) Эрдэнэ суманд зочилсон.
- Яхико тосгонд Монголын өдөрлөгийг зохион байгуулсан. Монгол гэр барьж тосгоны иргэдэд сонирхуулсан бөгөөд мөн Монгол ардын хувцас түрээслэж, морин хуурын тоглолт хийх зэргээр Монголын соёлыг сурталчилсан байна. Энэ үеэр Монголд айлчлаад ирсэн дунд сургуулийн сурагчид Эрдэнэ суманд зочилсон тухайгаа танилцуулсан.

2017 он

- Бага оврын насос бүхий гал унтраах машин (галын машин) нэгийг Эрдэнэ сумд хандивласан. Энэ үеэр газар дээр нь мэргэжлийн заавар зөвлөгөө өгөхөөр тосгоны Засаг даргын Тамгын газрын ерөнхий хэлтсийн дарга болон гал түймэртэй тэмцэх газрын 2 ажилтан Эрдэнэ суманд зочилсон.
- Эрдэнэ сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын 2 ажилтан, бага дунд ангийн 6 сурагч Яхико тосгонд айлчилсан. Бага, дунд ангийн сурагчид Япон айлд зочилж, хонож үзсэн (homestay) байна .
- Яхико тосгонд Монголын өдөрлөгийг зохион байгуулсан.

2018 он

- Яхико тосгоны Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын нэг ажилтан, дунд сургуулийн дэд захирал, дунд сургуулийн 6 сурагч (айлчлахыг хүссэн 14 сурагчаас 6 нь) Эрдэнэ суманд айлчилсан. Дунд сургуулийн сурагчид Монгол айлд зочилж, хонож үзсэн (homestay) байна.
- Яхико тосгонд Монголын өдөрлөгийг зохион байгуулсан.

2019 он

- Яхико тосгонд Монголын өдөрлөгийг зохион байгуулсан.
- Эрдэнэ сумын Засаг дарга, Засаг даргын амгын газрын 2 ажилтан, сургуулийн захирал, дунд ангийн 5 сурагч Яхико тосгонд айлчилсан. Дунд ангийн сурагчид Япон айлд зочилж, хонож үзсэн (homestay) байна .

Эх сурвалж: Судалгаанд хамрагдсан орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хийсэн ярилцлага, асуулгад өгсөн хариулт

8.2 Хамтын ажиллагаанд тулгарч буй асуудлууд

Орон нутгийн засаг захиргааны байгууллагуудаас ирүүлсэн хариултад үндэслэн, хамтын ажиллагаанд тулгарч буй асуудлуудыг ангилан дараах графикаар харьцуулан харуулав.



Эх сурвалж: Судалгаанд хамрагдсан орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хийсэн ярилцлага, асуулгад өгсөн хариулт

Зураг 8-3: Хамтын ажиллагаанд тулгарч буй асуудал

Олон засаг захиргааны байгууллагаас дурдсан асуудлын талаар бодит хариултаудыг доор харуулав.

(1) Хэл нэвтрэлцэхгүй бэрхшээл

"Хэл нэвтрэлцэхгүй бэрхшээл (хоёр талын аль аль нь англиар ярьж чаддаггүй, Монгол хэлний орчуулагч цөөхөн байдаг)" (Нийгата мужийн Цүбамэ хот гэх мэт) гэсэн асуудал хамгийн их хөндөгдсөн байгаа бөгөөд 22 орон нутгийн засаг захиргааны байгууллагын 6 нь ингэж хариулжээ.

(2) Төсөв

Ялангуяа "Хост таун" хөтөлбөрт хамрагдаж буй орон нутгийн засаг захиргааны байгууллагын тухайд, хамтын ажиллагаанд улсаас олгох төсөв нь "Токио 2020 олимп, паралимпын дараа багасаж, хотын иргэд хамтын ажиллагаа, солилцооны хөтөлбөрт оролцох тохиолдолд зардлыг өөрсдөө гаргах, мөн Монголоос зочид хүлээн авахтай холбоотой зардлыг шийдэх гэх мэт санхүүгийн бэрхшээл тулгарч болзошгүй"(Шизүока мужийн Яйзү хот) зэрэг бодит бэрхшээлийн талаар хөндөгдсөн.

(3) Залгамж чанар алдагдах

Монголын талаас тулгамдсан асуудал бол улс төрийн нөхцөл байдлаас шалтгаалан хариуцан ажиллаж байсан ажилтнууд, албан тушаалтнууд ойр ойрхон өөрчлөгддөг учраас үйл ажиллагааны тасралтгүй бөгөөд залгамж чанар алдагдахад хүрдэг гэсэн бэрхшээлийг дурджээ. Тодорхой жишээ дурдвал, "Монголын улс төр тогтворгүй, засаг захиргааны ажилтнууд ойр ойрхон солигдож, ажлаасаа гардаг нь хүндрэлтэй. Дараагийн хүндээ ажлаа тайлбарлаж, хүлээлгэж өгдөггүй учраас хамтын үйл ажиллагаа тасалдаад байдаг нь маш бэрхшээлтэй" (Шизүока муж) гэсэн байна.

(4) Сургалт, дадлагын үр дүн тааруу

"Солилцооны хөтөлбөр болон Япон дахь сургалтаар сурч мэдсэн зүйлээ орон нутагтаа очоод хэрэгжүүлэх, хөгжүүлэх тал дээр бэрхшээл их тулгардаг. Хөдөө аж ахуйн дадлагажигчаар Японд сургалтад оролцсон хүмүүс нутагтаа буцаад хөдөө аж ахуйн салбарт ажиллахаа больсон тохиолдол гардаг. Хамтын ажиллагааг үр дүнтэй, тасралтгүйгээр цаашид хэрхэн яаж үргэлжлүүлэх вэ гэдэг асуудал тулгарч байна (Тогтори муж)." гэж хариулсан орон нутаг ч байгаа бөгөөд сургалт, хүний нөөцийн хөгжлийг үр дүнтэй холбох нь хүндрэлтэй гэж онцолсон байна.

<Монгол улсын төр засаг, орон нутгийн засаг захиргаанаас хүсэх зүйл>

Дээрх орон нутгийн засаг захиргааны байгууллагуудаас цаашид хамтын ажиллагаагаа хөгжүүлэхийн тулд "Монгол Улсын Засгийн Газар, орон нутгийн засаг захиргаанаас хүсэж, хүлээж байгаа зүйлээ нэрлэнэ үү" гэсэн асуултад хариулсан байдлыг дараах хүснэгтээр харуулж байна.

Хүснэгт 8-7: Монгол Улсын Засгийн Газар, орон нутгийн засаг захиргаанд гаргах санал хүсэлт

Бодлого	Бодлогын залгамж чанарыг хадгалах, чиглэл/төлөвлөгөөг боловсруулж санал болгох, иргэд хоорондын солилцоог идэвхжүүлэх
	хувийн хэвшил хоорондын харилцааг өргөжүүлэх, хоёр орны орон нутгийн засаг захиргааны харилцан үр өгөөжтэй харилцааг хөгжүүлэх
Төсөв	Санхүүгийн дэмжлэг үзүүлэх (орчуулагчийн зардал гэх мэт)
Хүний нөөц	Хүний нөөцөөр хангах, орчуулагч бэлтгэх, хамтын ажиллагаа хариуцдаг боловсон хүчнийг тогтворжуулах
Мэдээлэл	Харилцаа холбоог сайжруулах, мэдээллээр хангах
Дэд бүтэц	Агаарын тээврийн үйлчилгээг сайжруулж (шууд нислэг), аялал жуулчлалын байгууламжид стандарт тогтоох, стандартад нийцүүлэн тохижуулах

Эх сурвалж: Судалгаанд хамрагдсан орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хийсэн ярилцлага, асуултад өгсөн хариулт

Нэг бус орон нутгийн засаг захиргааны байгууллагаас ирсэн бодит хариултыг дор харуулав.

(1) Боловсон хүчний асуудал

"Монгол Улсын Засгийн Газар, орон нутгийн засаг захиргаанаас хүсэж, хүлээж байгаа зүйлээ нэрлэнэ үү?" гэсэн асуултад "Орчуулагчаар хангах" (Нийгата мужийн Цүбамэ хот), "Монгол, Япон хэл мэддэг боловсон хүчин хомс байгаа нь хоёуланд нь тулгарч байгаа асуудал. Тиймээс, Төв аймаг болон Тоттори мужийн хоорондох гүүр болох боловсон хүчнийг бэлтгэх шаардлагатай гэж бодож байна" (Тоттори муж) гэх мэт хүний нөөцийг сайжруулахыг хүссэн санал хүсэлт их байна.

(2) Мэдээллээр хангах

Хамтарч ажиллаж байгаа хугацаа нь харьцангуй богино бөгөөд цаашид хамтын ажиллагаагаа өргөжүүлэхийг хүсэж буй орон нутгийн засаг захиргааны байгууллагын хувьд, холбогдох мэдээ, материал хомс байдаг нь их бэрхшээлтэй байдаг хэмээн дурдсан байна. Тодруулбал "Өөрсдийн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд жишээ болохоор мэдээлэл, тухайлбал бусад найрамдалт харилцаатай орон нутгуудын талаарх мэдээ, материал их чухал, хэрэгцээтэй байна. Ялангуяа, жижиг хот, тосгонууд хоорондоо хэрхэн хамтарч ажилладаг талаар мэдэхийг хүсэж байна" (Аомори мужийн Имабэцу хот), "Японоос өөр ямар улс оронтой харилцаа холбоотой байдаг тухай мэдээлэл авмаар байна" (Айчи мужийн Оказаки хот) зэрэг "Мэдээллээр хангах" талаар санал хүсэлт их ирсэн байна.

(3) Тогтвортой бодлого

"Монголын Улсын Их Хурлын болон НИТХ-ын сонгуультай холбогдуулан Засгийн газар, Засаг дарга нар солигдонгуут ихэнх засаг захиргааны удирдлагууд солигдож, олон ажилтнууд ажлаасаа гарчихдаг тул хэрэгжиж байсан хамтын ажиллагаа зогсонги байдалд орж, өнөөг хүртэл хөгжүүлж ирсэн харилцаа, хийж байсан ажлууд маань тасалдахад хүрсэн" (Хоккайдо мужийн Асахикава хот), "Одоогийн байдлаар Өвөрхангай аймгийн Хужирт сумтай холбоо тасарсан ба харилцаатай байсан Хужирт сум ямар байдалтай байгааг мэдэх ямар ч боломжгүй байна. Монгол улсын дотоод байдал болон Хужирт сумын засаг захиргааны байр суурь, нөхцөл байдлыг мэдэх хүсэлтэй байна" (Нагасаки мужийн Мацүүра хот) гэх мэт хариулт нь дээр дурдсан "тулгамдсан асуудалууд"-ын нэг болох боловсон хүчний тогтворгүй байдал гэх агуулгатай давхцаж байна.

<Бусад орон нутгийн засаг захиргаанд өгөх зөвлөгөө>

"Цаашид Японы бусад орон нутгийн засаг захиргаа Монгол улстай харилцаа тогтоох, хамтын ажиллагаа хэрэгжүүлэх тохиолдолд анхаарвал зохих зүйлсийг нэрлэнэ үү" гэсэн асуулгад хариулсан 4 орон нутгийн засаг захиргааны хариултыг дараах хүснэгтээр харуулж байна.

Хүснэгт 8-8: Цаашид Японы бусад орон нутгийн засаг захиргаа Монгол улстай харилцаа тогтоох, хамтын ажиллагаа хэрэгжүүлэх тохиолдолд анхаарвал зохих зүйл

Япон Улсын орон нутгийн засаг захиргааны байгууллага	Цаашид Японы бусад орон нутгийн засаг захиргаа Монгол Улстай харилцаа тогтоох, хамтын ажиллагаа хэрэгжүүлэх тохиолдолд анхаарвал зохих зүйл
Нийгата мужийн Яхико тосгон	Монголын талтай холбоо барих, харилцан ярилцах тохиолдолд Монголтой холбоотой байдаг орчуулагч, аялал жуулчлалын компаниар зуучлуулж байхыг зөвлөж байна. Шууд харилцах тохиолдолд хариу их удаж ирэх гэх мэт цаг их ордог.
Шизүока мужийн Изүнокүни хот	Нарита нисэх онгоцны буудлаас тогтмол нислэгтэй мөн Японтой 1 цагийн л зөрүүтэй байдаг зэрэг нь хоёр орны хооронд зорчиход хялбар. Монголчууд Япон хүнд элэгсэг, найрсаг ханддаг мөн гадаад төрх нь Япон хүмүүстэй төстэй байдаг тул амархан дотносдог. Хамтын ажиллагааны үеэр холбоо тасрах, аливаа асуудалд хариу өгөхгүй удах, цагийг нь тулгаж байж шийдвэр гаргадаг зэрэг дутагдлууд гардаг тул, энэ байдлыг бодолцсоны үндсэн дээр ажлын арга барилаа харилцан тохиролцох шаардлагатай.
Осака мужийн Изүмисано хот	Англи хэлээр ярьдаг орнуудтай харьцуулахад хэл нэвтрэлцэхгүй бэрхшээл түгээмэл байдаг тул гадаад харилцааны Монгол ажилтантай байх эсвэл монгол хэлээр ярих чадвартай өөр ажилтантай байвал харилцаа холбооны асуудлыг зохицуулахад хялбар. Мөн Монгол хүмүүс далайн гаралтай хүнсний бүтээгдэхүүн (ялангуяа түүхий загас, дун, хавч гэх мэт) бараг хэрэглэдэггүй, ихэнхдээ махан хоол иддэг тул хүлээн авалтын үед болон мөн айлд зочлох үед үүн дээр анхаарах нь зүйтэй. Түүнчлэн хоолоо ихэвчлэн зөвхөн давсаар амталдаг тул чихэр амттай хоол (сукияки гэх мэт) зэргийг нэг их таашаадаггүй. Харин амтаа өөрөө тохируулж болдог шарсан мах (якинику), халуун тогоо (шабу-шабу) зэрэг хоол Монгол хүнд их таалагддаг.
Миязаки мужийн Мияконожо хот	Монголын зан үйл, ёс заншил болон 2 орны харилцааны түүхийн талаар урьдчилан сурч мэдсэн байх.

Эх сурвалж: Судалгаанд хамрагдсан орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хийсэн ярилцлага, асуулгад өгсөн хариулт

"Харилцах, хэл нэвтрэлцэх" нь тулгарч буй бэрхшээл хэмээн 4 орон нутгийн засаг захиргаа хариулсан бөгөөд энэхүү асуудлын шийдэл болгож "Гадаад харилцааны Монгол ажилтан (CIR) / болон Монгол хэл мэддэг ажилтан ажиллуулах" (Изүмисано хот), "Тухайн орон нутагтай холбоотой байдаг орчуулагч, аялал жуулчлалын компаниудаар зуучлуулах"(Яхико тосгон) гэх мэтчилэн тодорхой зөвлөгөөнүүдийг өгсөн байна.

8.3 Цаашдын хамтын ажиллагаа өргөжүүлэх боломж

Монголын орон нутгийн засаг захиргаатай хамтын ажиллагаагаа өргөжүүлэн хөгжүүлэх цаашдын төлөвлөгөөний талаарх Японы орон нутгийн засаг захиргааны байгууллагуудаас ирүүлсэн хариултыг дараах хүснэгтээр харуулж байна. Дарааллын хувьд эхлээд эгч дүүс хотын харилцаатай (харилцах төлөвлөгөөтэй хотыг оруулаад) бөгөөд "Хост таун" хөтөлбөрт давхар хамрагдсан орон нутгийн засаг захиргааны байгууллага, дараа нь зөвхөн "Хост таун" хөтөлбөрт хамрагдсан орон нутгийн засаг захиргааны байгууллага, эцэст нь бусад орон нутгийн засаг захиргааны байгууллага гэж эрэмбэлсэн болно.

Хүснэгт 8-9: Монгол улсын орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хамтын ажиллагаагаа өргөжүүлэн хөгжүүлэх цаашдын төлөвлөгөө

Х/А-ны ангилал	Япон Улсын орон нутгийн засаг захиргааны байгууллага	Монгол Улсын орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хамтын ажиллагаагаа өргөжүүлэн хөгжүүлэх цаашдын төлөвлөгөө	Товч агуулга
Эгч дүүс/ Хост таун	Токио хот Мүсашимураяма хот	2021 ондоо багтааж эгч дүүс хотын гэрээг байгуулахаар төлөвлөж байна. Гэрээ байгуулсны дараа соёл, спорт дээр суурилсан харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх болно.	Соёл, спортын харилцааг хөгжүүлэнэ
Эгч дүүс/ Хост таун	Нийгата мужийн Яхико тосгон	Цаашдаа ч жил бүр хэрэгжүүлдэг харилцан айлчлалын хөтөлбөрөө үргэлжлүүлнэ. Хүүхдүүдийг Монгол Япон айлд харилцан зочлуулж, хоёр орны соёл, уламжлал, аж ахуйтай танилцуулна. Түүнчлэн 2 талын дунд сургуулиудын цахим харилцааг хөгжүүлэхээр зорьж байна.	Урьдын адил харилцан айлчилна
Эгч дүүс/ Хост таун	Шизуока мужийн Изунокүни хот	Хариу ирээгүй	
Эгч дүүс/ Хост таун	Шизуока мужийн Яйзү хот	Одоо хэрэгжүүлж буй хамтын ажиллагаагаа үргэлжлүүлнэ. Мөн "Токио 2020" олимпын наадмын үргэлжлэл (өв залгамжлал) болгож хамтын ажиллагааны шинэ чиглэл, үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаар холбогдох байгууллагуудтай хэлэлцэх болно.	Олимпын наадмын өв болгож төрөл бүрийн харилцааг хөгжүүлэнэ
Эгч дүүс/ Хост таун	Осака мужийн Изумисано хот	Төв аймагтай найрамдалт хотын уламжлалт харилцаатай, мөн Хост таун хотын хөтөлбөр хэрэгжүүлж байгаа хотын хувьд Олимпын дараа ч харилцаагаа үргэлжлүүлж, найрамдлаа гүнзгийрүүлэхийг хүсэж байна. Хоёр тал хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэхийг хүсэж байгаа бөгөөд хэрэгжүүлэх боломжтой төсөл хөтөлбөр байвал хамтран ажиллах болно.	Хэрэгжүүлэх боломжтой төсөл, хөтөлбөрт хамтран ажиллана
Эгч дүүс/ Хост таун	Миязаки мужийн Мияконожо хот	Цаашид хүүхэд, залуучуудын солилцоо зэрэг иргэд хоорондын харилцаагаа үргэлжлүүлэхээс гадна, сургууль, иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшил хоорондын эрдэм шинжилгээ, судалгааны хамтын ажиллагааг хөгжүүлэхээр зорьж байна. Хост таун хотын хөтөлбөр хэрэгжүүлэх тухайд өнгөрсөн хугацаанд 2 удаа (2018 оны 2 сар, 2019 оны 2 сар) зохион байгуулсан "Монгол Японы чөлөөт бөхийн нөхөрсөг уулзалт" -ыг (3 дахь удаа) үргэлжлүүлэх ба мөн Токиогийн Олимпод оролцох Монголын чөлөөт бөхийн тамирчдыг урьж, арга хэмжээ зохион байгуулах төлөвлөгөөтэй байна.	Иргэд хоорондын харилцааг үргэлжлүүлэхээс гадна, эрдэм шинжилгээ, судалгааны хамтын ажиллагааг хөгжүүлэнэ
Эгч дүү	Нагано мужийн Саку хот	Төлөвлөгөө байхгүй.	Төлөвлөгөө байхгүй
Эгч дүү	Шизуока муж	Цаашид Монгол Улстай эдийн засгийн салбарт хамтын ажиллагааг өргөжүүлэхээр төлөвлөж байна. Удаан хугацаагаар мэргэжилтэн томилон ажлуулах замаар коворкинг системийг нэвтрүүлэх.	Эдийн засгийн салбарт хамтын ажиллагааг өргөжүүлэнэ
Эгч дүү	Тоттори муж	Хоёр мужийн музей, номын сан хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар хэлэлцэж байна.	Музей, номын сан хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэхээр хэлэлцэж байна
Эгч дүү	Хоккайдо мужийн Такикава хот	Такикава хотын хэрэгжүүлж буй дадлагажигч хүлээн авах төсөл нь 2021 онд дуусна. 2015 оноос хойш Такикавагийн Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг нь ЖАЙКА-ийн "Өвсний үндэс" техникийн хамтын ажиллагааны төслөөр дамжуулан Монгол Улсын хөдөө аж ахуйн салбарыг дэмжиж тусалсаар ирсэн бөгөөд 2020 оноос энэ салбарт Төв аймагтай хамтын ажиллагаа эхлэх юм. Мөн Өвөрхангай аймгаас ур чадварын дадлагажигчдыг хүлээн авахаар төлөвлөж байна (2020 оноос хүлээж авах ёстой боловч "Ковид-19" халдварт цар тахлын тархалтын нөлөөгөөр хойшлогдсон).	Хөдөө аж ахуйн салбарт дэмжлэг тусалцаа үзүүлэнэ
Эгч дүү (түр зогссон)	Хёого мужийн Тоёоока хот	Хамтын ажиллагааны хэтийн төлөвлөгөөг боловсруулах үе шатан дээр явж байгаа тул нарийн тодорхой зүйлүүдийг хэлэх боломжгүй байна. Ирээдүйд Монголын залуучууд Японы нийгмийн янз бүрийн салбарт амжилттай ажиллах боломж, бололцоог нэмэгдүүлэхийн тулд, ямар чиглэлийн харилцаа, хамтын ажиллагаа тохиромжтой болох, мөн ямар бодлого хөтөлбөр шаардлагатайг зөвхөн манай хот төдийгүй Монголтой харилцаа холбоотой байдаг Японы бүх л байгууллага, хувь хүн адилхан эрэлхийлж байдаг болов уу.	Төлөвлөгөөг боловсруулах үе шатан дээр явж байгаа
Эгч дүү (түр зогссон)	Нагасаки мужийн Мацүүра хот	Харилцаа холбоогоо дахин сэргээхээр зохицуулж байна.	Харилцаагаа дахин сэргээхээр зохицуулж байна
Хост таун	Аомори мужийн Имабэцү хот	Түялзуур сэлэмний спортоос өөр хамтын ажиллагаатай салбар өнөөгийн байдлаар байхгүй байна. Уг нь хамтын ажиллагааны гэрээнд соёл, аялал жуулчлал, эдийн засаг, аж үйлдвэрийн салбарын гэх мэт өргөн хүрээний хамтын ажиллагааг тусгасан байгаа боловч аялал жуулчлал, эдийн засаг, аж үйлдвэрийн салбар дахь хамтын ажиллагаа хэрэгжээгүй байна. Цаашид олон чиглэлээр хамтын ажиллагаагаа өргөжүүлэн хөгжүүлэх хүсэл сонирхолтой байгаа ч тодорхой хөтөлбөр, төлөвлөгөө хараахан гараагүй байна.	Хамтын ажиллагаагаа өргөжүүлэн хөгжүүлэх хүсэл сонирхолтой байгаа ч тодорхой хөтөлбөр, төлөвлөгөө хараахан гараагүй байна
Хост таун	Ибараки мужийн Сакурагава хот	Олимпын дараа хамтын ажиллагаа хэрхэн үргэлжилж, хөгжих вэ гэдэг асуудал тодорхойгүй хэвээр байна	Төлөвлөгөө байхгүй
Хост таун	Ибараки мужийн Широсато хот	Одоохондоо төлөвлөгөө байхгүй.	Төлөвлөгөө байхгүй

Хост таун	Ибараки мужийн Намэгата хот	Олимпын наадамтай уялдаатайгаар эхэлсэн хамтын ажиллагааг үргэлжлүүлэн, цаашид улам өргөжүүлэн, хоёр улсын иргэд хоорондын төдийгүй эдийн засаг, худалдаа, соёлын харилцааг хөгжүүлэх сонирхолтой байна. Монголын орон нутгийн засаг захиргааны байгууллагатай найрамдалт харилцаатай хот болох талаар одоогоор Япон дахь Монгол Улсын ЭСЯ-тай	Цаашдын хамтын ажиллагааг хэлэлцэж байна
Хост таун	Нийгата мужийн Нийгата хот	Монгол улсын иргэд болон тамирчидтай харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх.	Монгол улсын иргэд, тамирчидтай харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлнэ
Хост таун	Нийгата мужийн Цүбамэ хот	Байт харваагаар дамжуулан цаашдаа ч "Токио 2020" олимпын өв болгон харилцаагаа үргэлжлүүлэх төлөвлөгөөтэй.	"Токио 2020" олимпын өв болгон харилцаагаа үргэлжлүүлнэ
Хост таун	Нийгата мужийн Нагаока хот	"Токио 2020" олимп, паралимпийн наадмын үеэр, мөн наадмын дараа ч бага дунд сургуулиудад солилцооны хөтөлбөр, соёл уламжлал танилцуулах үйл ажиллагаа явуулахаар төлөвлөж байна.	Олимпын наадмын дараа ч солилцооны хөтөлбөр, соёл уламжлалыг танилцуулна
Хост таун	Шизуока мужийн Шимада хот	Эгч дүүс сургуулиудынхаа харилцаан дээр суурилан цаашид олон чиглэлээр хамтын ажиллагаагаа хөгжүүлэх төлөвлөгөөтэй.	Эгч дүүс сургуулиудынхаа харилцаан дээр суурилан хөгжүүлнэ
Хост таун	Айчи мужийн Оказаки хот	2026 онд Ази тивийн спортын наадам Айчи мужид зохиогдох тул байт харвааны төрлөөр хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэхээр төлөвлөж байна.	Спортоор дамжуулан хамтарч ажиллана
Хост таун	Ойта мужийн Уса хот	"Токио 2020" олимпын наадмын өмнөхөн буюу 2021 оны 7-р сард Монголын тамирчид ирж байрлах төлөвлөгөөтэй байгаа.	Олимпын наадмын өмнөхөн Монголын тамирчид ирж байрлана
Бусад	Хоккайдо муж	Монгол Улстай харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлж байгаа гол байгууллага болох Хоккайдо-Монголын эдийн засгийн харилцааг дэмжих нийгэмлэгтэй хамтран ажиллаж, цаашдаа олон төрөл чиглэлээр харилцаагаа хөгжүүлнэ.	Олон нийтийн байгууллагатай хамтран ажиллана
Бусад	Хоккайдо мужийн Саппоро хот	Улаанбаатар хотод хийх бүтээн байгуулалтын ажлуудад Хоккайдо муж болон Саппоро хотын бизнес эрхлэгчдийн туршлага, мэдлэг чадвар, технологийг нэвтрүүлэх замаар хамтран ажиллана. Цаашдаа дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг авах арга хэмжээнүүдэд Улаанбаатар хоттой хамтран ажиллахаар төлөвлөж байна.	Техникийн хамтын ажиллагаа
Бусад	Хоккайдо мужийн Мүкава хот	Хувийн хэвшил (компани) хоорондын эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар орон нутгийн хөгжилд тус нэмэр болох.	Хувийн хэвшилтэй хамтран ажиллана
Бусад	Ишикава муж	Олон нийтийн байгууллага болох Ишикава-Монголын найрамдлын нийгэмлэг нь идэвхитэй үйл ажиллагаа явуулж байгаа боловч мужийн орон нутгийн засаг захиргааны байгууллага болон Монгол Улсын орон нутгийн засаг захиргааны байгууллага хооронд хэрэгжүүлсэн харилцаа, хамтын ажиллагааны хөтөлбөр хараахан байхгүй.	Хэрэгжүүлсэн харилцаа, хамтын ажиллагааны хөтөлбөр хараахан байхгүй.
Бусад	Ойта муж	Одоохондоо төлөвлөгөө байхгүй.	Төлөвлөгөө байхгүй
Бусад	Окинава муж	Одоохондоо тодорхой төлөвлөгөө байхгүй.	Төлөвлөгөө байхгүй
Бусад	Шига муж	Бивако нуур, Хөвсгөл нуур хоорондын эрдэм шинжилгээ, судалгааны болон иргэд хоорондын харилцааг хөгжүүлэхийн зэрэгцээ нуур, намгархаг газрын үнэ цэнийг олон улсад таниулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх сонирхолтой.	Эрдэм шинжилгээ, судалгаа болон иргэд хоорондын харилцааг хөгжүүлнэ
Бусад	Хоккайдо мужийн Асахикава хот	Одоохондоо төлөвлөгөө байхгүй.	Төлөвлөгөө байхгүй
Өргөмжит консул	Нагоя хот дахь Өргөмжит консулын газар	"Ковид-19" халдварт цар тахлын халдварын эсрэг авсан арга хэмжээнүүдийн үр дүнг харгалзан Монгол Улсад бүцэлтгүй тусламж үзүүлэх, Монгол-Японы анагаах ухаан, шүдний анагаах ухааны форумд бэлтгэх ажлыг үргэлжлүүлэх. Монгол улсаас өвчтөн хүлээн авах ажлыг үргэлжлүүлнэ. Өвчтөн хүлээн авах тогтолцоог сайжруулахын тулд хамтран ажиллах эрүүл мэнд, эмнэлгийн байгууллагын тоог нэмэгдүүлэхээр төлөвлөж байна.	Дэмжлэг, туслалцаа үзүүлэх, өвчтөн хүлээн авах ажлаа үргэлжлүүлнэ
Өргөмжит консул	Токушима дахь Өргөмжит консулын газар	Шикоку дахь Өргөмжит консулын газрынхаа үйл ажиллагааны хүрээнд хамтын ажиллагааг өргөжүүлэхээс гадна шаардлагатай бол хоёр орны орон нутгийн засаг захиргааны байгууллага хоорондын гүүр болж ажиллахыг хүсэж байна.	Хоёр орны орон нутгийн засаг захиргааны байгууллага хоорондын гүүр болно
Өргөмжит консул	Фүкүока дахь Өргөмжит консулын газар	Цаашид Монгол Улстай харилцах, хамтын ажиллагаагаа хөгжүүлэхэд мэдээллийн урсгал + иргэдийн урсгал + бизнесийн зуучлал + бизнес семинар зэргийг төлөвлөх шаардлагатай. Жишээлбэл иргэдийн урсгалыг өргөжүүлэхийн тулд аялал жуулчлалын үйл ажиллагааг тогтворжуулах нь чухал юм. Ялангуяа Кюсюгийн бүс нутагт Хубилай хааны эзэнт гүрний үлдээсэн үл мөртэй танилцах, халуун рашаанд орох гэж мэт Монгол жуулчдыг татахаар аялал жуулчлалын нөөц их байдаг. Мөн техникийн хамтын ажиллагааг хөгжүүлэх үүднээс Монголын аж үйлдвэрийн хувьсгалд хувь нэмэр оруулах үйл ажиллагааг системтэйгээр төлөвлөх шаардлагатай байна.	Бизнесийн болон техник, технологийн ийн хамтын ажиллагааг хөгжүүлэх

Эх сурвалж: Судалгаанд хамрагдсан орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хийсэн ярилцлага, асуулгад өгсөн хариулт

Эгч дүүс хотын харилцаатай орон нутгийн засаг захиргааны байгууллагын ихэнх нь цаашид хамтын ажиллагаагаа "хөгжүүлэх", "үргэлжлүүлэх", "өргөжүүлэх" төлөвлөгөөтэй байхад зөвхөн "Хост таун" хөтөлбөрт хамрагдсан орон нутгийн засаг захиргааны байгууллагууд "төлөвлөгөө байхгүй", "тодорхой бус" гэсэн хариулт өгсөн нь Токио олимп дууссаны дараа хамтын ажиллагаа нь цаашид хэрхэх нь тодорхой бус байгааг илтгэж байна.

“Хост таун” хөтөлбөр, эгч дүүс хотын харилцаа / найрамдалт харилцаанаас өөр байдлаар Монгол улстай хамтран ажиллах боломжтой эсэх талаарх асуултад хариулсан байдлыг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 8-10: Монгол улстай цаашид хамтран ажиллах боломж (“Хост таун” хөтөлбөр, эгч дүүс хотын харилцаа / найрамдалт харилцаанаас гадна)

Япон Улсын орон нутгийн засаг захиргааны байгууллага	Монгол Улстай цаашид хамтран ажиллах боломж (“Хост таун” хөтөлбөр, эгч дүүс хотын харилцаа / найрамдалт харилцаанаас гадна)
Ибараки мужийн Намэгата хот	Биеийн тамир, спортын салбарт хамтран ажиллах (Монголын баг тамирчдын бэлтгэлийн бааз болох).
Нийгата мужийн Яхико тосгон	Аж үйлдвэржилтэд чиглэсэн хамтын ажиллагаа. Энэ чиглэлийн хамтын ажиллагааны төлөвлөгөө одоохондоо байхгүй ч хөдөө аж ахуйн салбарт хамтран ажиллах сонирхолтой байна.
Шизүока мужийн Яйзү хот	Тус хотын аж ахуйн нэгж, компаниуд Худалдаа аж үйлдвэрийн танхимаар дамжуулан ажиллах хүч, хүний нөөцийн солилцооны хөтөлбөр хэрэгжүүлснээр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа хөгжих боломжтой. Үүний үр дүнд хоёр улсын харилцаа улам гүнзгийрч, цаашид хүн ам цөөрч, ажиллах хүчний хомсдол үүсэх Яйзү хотын хувьд ч үр өгөөжтэй хамтын ажиллагаа байх магадлалтай.
Осака мужийн Изүмисано хот	Хоёр тал хамтран ажиллах хүсэлтэй бөгөөд хэрэгжүүлэх боломжтой төсөл хөтөлбөр байвал хамтран ажиллах боломжтой гэж бодож байна.
Миязаки мужийн Мияконожо хот	Хувийн хэвшил, олон нийтийн байгууллагууд PR, сурталчилгааг хийж, өөрсдийн төрөлжсөн бүтээгдэхүүн, нэрийн барааг зарж борлуулах гэх мэт. Мөн аялал жуулчлалын агентлагуудтай хамтран аялал жуулчлалын түр зохион байгуулах (HIS агентлаг Улаанбаатар хотод салбартай).

Эх сурвалж: Судалгаанд хамрагдсан орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хийсэн ярилцлага, асуулгад өгсөн хариулт

<Монгол улстай харилцаа, хамтын ажиллагаатай Японы орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын онцолж буй Монгол хүн, монгол орны сайхан чанар>

Орон нутгийн засаг захиргааны байгууллагуудаас ирүүлсэн хариултаас "Монгол хүн, монгол орны сайхан чанар" -ыг онцолсон хэсгийг түүвэрлэн, дараах хүснэгтэд нэгтгэв.

Хүснэгт 8-11: Монгол хүн, монгол орны сайхан чанар

Япон Улсын орон нутгийн засаг захиргааны байгууллага	Монгол хүн, Монгол орны сайхан чанар
Аомори мужийн Имабэцү хот	Цаг агаар нь их тааламжтай сайхан газар санагдсан
Нийгата мужийн Яхико тосгон	Сүмо бөх, үзэсгэлэнтэй сайхан байгаль
Нагано мужийн Саку хот	Тайван амгалан, нөхөрсөг, элэгсэг дотно зан чанар
Шизүока муж	Харилцан итгэлцэж, хамтран ажиллах боломжтой, цаашид хөгжих асар их боломжтой орон
Шизүока мужийн Изүноүкүни хот	Газарзүйн хувьд харьцангуй ойрхон, Япон хүмүүст элэгтэй, нөхөрсөг, найрсаг
Шизүока мужийн Яйзү хот	Монгол хүмүүс амархан дотносог, зочломтгой, гэгээлэг, итгэмтгий зан чанартай. Өвөрмөц сайхан байгальтай, өргөн дэлгэр тал нутагтай, нүүдэлчин, малчны соёл уламжлал өнөөг хүртэл өвлөгдсөн
Шизүока мужийн Шимада хот	Морин хуур, өвөрмөц соёл, шууд нислэг, цагийн зөрүүгүй гэх мэт
Осака мужийн Изүмисано хот	Амархан найз нөхөр болж чаддаг нөхөрсөг зан чанар, найрсаг байдал, УБ хотын дэлгүүр, худалдааны төв, өргөн уудам, үзэсгэлэнт байгаль, байгалийн үзэмжит ландшафт, ирээдүйн эдийн засгийн хөгжлийн боломж ихтэй
Хёого мужийн Тоёоока хот	Япон хүмүүстэй харилцан мэдрэмжээрээ ойлголцдог, дотносог, нэг уулзсан хүнээ хэзээ ч мартдаггүй, дурсан санаж байдаг. Ахмад настан, найз нөхөд, холын зочноо хүндэтгэх соёл. Япончуудын хувьд гээгдээд байгаа үнэт зүйлийн тухай ойлголтыг хадгалсан хэвээрээ байгаа
Тоттори муж	Газарзүйн хувьд ашигтай байрлалтай, нүүдлийн соёл иргэншил нь хэвээр хадгалагдсан, ард олон нь сайхан сэтгэлтэй, элэгсэг, нөхөрсөг, хамтын ажиллагаанд их идэвхтэй, сэтгэлээсээ оролцдог. Сүмо бөх. Зочломтгой зан (Монголд зочлох үед уламжлалт соёл иргэншилтэй танилцуулж, тал нутагтай танилцах боломж олгодог)
Нагасаки мужийн Мацүүра хот	Түүх талаасаа сонирхолтой
Ибараки мужийн Широсато хот	Азийн орон, Японд элэгтэй
Ибараки мужийн Намэгата хот	Харьцангуй ойрхон, гадаад байдлаараа төстэй, найрсаг, сүмо бөх, Япон хэл сурдаг хүн их
Токио хот Мүсашимүраяма хот	Сүмо бөх, үзэсгэлэнт байгаль
Нийгата мужийн Цүбамэ хот	Нөхөрсөг, Японы соёлоос суралцахаар их хичээдэг
Токушима дахь Өргөмжит консулын газар	Нөхөрсөг, хүүхдүүд нь гэнэн цайлган, хичээл зүтгэлтэй, зах зээл цаашид хөгжих боломж их, сүмо бөх
Хоккайдо мужийн Мүкава хот	Японд ойрхон, үлэг гүрвэлийн судалгааг илүү хөгжүүлэх боломжтой
Ойта муж	Сүмо бөх
Хоккайдо мужийн Асахикава хот	Өргөн уудам, үзэсгэлэнт байгаль

Эх сурвалж: Судалгаанд хамрагдсан орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хийсэн ярилцлага, асуулгад өгсөн хариулт

Дээрх хүснэгтээс Японы орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын Монгол улстай харилцахдаа мэдэрсэн "сайхан чанар"-ыг дараах байдлаар ангилав.

(1) Амархан ойртон дотносог зан чанар

Япон хүмүүст элэгтэй, нөхөрсөг, найрсаг, зочломтгой байдал, ахмад настан, найз нөхөдөө хүндэтгэлтэй ханддаг явдал зэрэг Монгол үндэстний зан чанартай холбоотой хариулт их (24 хариулт) байв.

(2) Японтой найрсаг харилцаатай

"Хамтын ажиллагаанд их идэвхтэй, сэтгэлээсээ оролцдог", "Япон хэл сурч байгаа хүн олон байдаг", "Японы соёлыг сурч мэдэхийг их хичээдэг" зэрэг хариулт их байсан бөгөөд 2 талын хамтын ажиллагаанд Монгол хүмүүс сэтгэлээсээ ханддаг байдал нь Японы орон нутгийн засаг захиргаатай хамтран ажиллахад эерэг нөлөөлж байгааг эндээс харж болно (4 хариулт).

(3) Монголоос сурах юм их байна

"Япончуудын хувьд гээгдээд байгаа үнэт зүйлийн тухай ойлголтыг хадгалсан хэвээрээ байгаа нь сайхан санагдсан" (Хёого мужийн Тоёоока хот), "Одоогийн Япон хүүхдүүдээс тэр бүр олж хардаггүй гэнэн цайлган, чин сэтгэлээсээ хандлагыг мэдэрдэг" (Токушима муж дахь Өргөмжит консулын газар) гэх мэт хариултаас харахад, хамтран ажиллах явцдаа Япончууд Монголчуудаас суралцах харилцан өгөөжтэй харилцаа тогтсон байхыг харж болно.

(4) Бусад

"Үзэсгэлэнтэй сайхан байгаль, тааламжтай цаг агаар" (6 хариулт), "Өвөрмөц түүх, соёл (нүүдлийн соёл иргэншил, морин хуур)" (4 хариулт), "Газарзүйн байрлалын давуу тал (адилхан Азийн орон, Японд харьцангуй ойрхон, цагийн зөрөө байдаггүй)" (7 хариулт) гэх мэт хариулт ч олон байв. "Монгол улсын зах зээл, эдийн засаг нь илүү ихээр хөгжих боломжтой" гэж дурдсан орон нутгийн засаг захиргааны байгууллага (3 хариулт) ч байгаа бөгөөд хамтын ажиллагаа нь цаашид илүү өргөжин хөгжинө гэсэн хүлээлттэй байгааг эндээс харж болох юм.

Нийгата мужийн орон нутгийн "Санжо Шинбун" сонины 2018 оны 9-р сарын 17-ны өдрийн дугаарт "Төв аймгийн Эрдэнэ сумын 4 шөнө 5 өдрийн аялал ⑪" гэсэн нийтлэл гарсан бөгөөд энэхүү нийтлэлээс Яхико тосгоны дарга Кобаяаши Тоёохикогийн хэлсэн үгийг доор иш татан онцолж байна.

"Эрдэнэ сумтай найрамдалт харилцаа тогтоосон нь үндсэн гурван шалтгаантай. Тодруулбал Монгол улс нь ховор металл зэрэг эрдэс баялгийн арвин их нөөцдөө тулгуурлан эдийн засаг нь хөгжиж байгаа орон, алс хэддээ Нийгата нисэх онгоцны буудал руу тогтмол нислэг хийдэг болбол Монголоос ирэх жуулчдын тоог өсгөх боломжтой, түүнчлэн Яхико тосгоны хүүхдүүдийг гадаад харилцаа, хамтын ажиллагаанд оролцуулах гэсэн үндсэн зорилготой юм. Нийгата нисэх онгоцны буудлаас 4 цаг нисээд л Монголд очих боломжтой. Нийгата муж Монгол руу гарах гарц болох тул хамтран ажиллахад ч илүү хялбар байх болох юм. Монгол улс эдийн засгийн чадамжтай улс орон болсны дараа Монголтой харилцаа, хамтын ажиллагаа хэрэгжүүлэх нутаг орны эрэлт хэрэгцээ ихсэх магадлалтай тул, аль болох эртнээс харилцаа холбоо тогтоож, хамтран ажиллах нь чухал" хэмээн онцолжээ.

8.4 Аялал жуулчлалын салбар дахь хамтын ажиллагаа, цаашдын төлөвлөгөө

Монгол улстай аялал жуулчлалын салбарт харилцаа, хамтын ажиллагаа байсан, эсвэл төлөвлөгөөтэй гэж хариулсан Японы орон нутгийн засаг захиргааны байгууллагын хамтын ажиллагааны бодит агуулга ба цаашдын төлөвлөгөөний талаар доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 8-12: Аялал жуулчлалын салбар дахь хамтын ажиллагааны ололт амжилт, цаашдын төлөвлөгөө

Япон Улсын орон нутгийн засаг захиргааны байгууллага	Аялал жуулчлалын салбар дахь хамтын ажиллагааны ололт амжилт	Аялал жуулчлалын салбар дахь хамтын ажиллагааны цаашдын төлөвлөгөө
Шизуока муж	Жил бүр МИАТ ТӨХК-ийн (хувийн агаарын тээврийн компанийн онгоцыг 2 удаа) захиалгат нислэгээр мужийн иргэд болон хамтын ажиллагааны багийг Монгол улсад зочлуулдаг. Монгол улсын аялал жуулчлалын холбооны гишүүдийг хүлээн авч, аялал жуулчлалын солилцоо, хамтын ажиллагаа явуулж байсан. Мөн Монголоос жуулчид Шизуока мужид ирэх үед санхүүгийн тусламж үзүүлж ирсэн.	Уламжлалт хамтын ажиллагаагаа үргэлжлүүлнэ.
Шизуока мужийн Изунокүни хот	Монгол орноор аялах аяллын тогтсон төлөвлөгөө байдаггүй. Гэхдээ Изунокүни хотын найрамдалт хот хоорондын харилцааны нийгэмлэгийн үйл ажиллагааны хүрээнд жил бүр хотын иргэдийн төлөөлөгчдийг Монголд аялуулж ирсэн.	Монгол руу аялах боломжтой болох үед хотын иргэдийн аяллын багийг Монголд айлчлуулах, дунд сургуулийн сурагчдын танилцах сургалтыг Монголд хэрэгжүүлэх зэрэг үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх болно.
Шизуока мужийн Яйзу хот	2018 онд Яйзу хотын “Хост таун хөтөлбөр сурталчлах зөвлөл” Монгол Улсад айлчлах болсонтой холбогдуулан, Монгол орноор аялах сонирхолтой иргэдийг (2 иргэнээс хүсэлт ирсэн) мөн айлчлуулсан. Айлчлалын үеэр Яйзу хоттой найрамдалт харилцаатай Улаанбаатар хотын Чингэлтэй дүүрэгт, Олимпын хороо зэргээр зочилж, жуулчны баазын гэрт хонож үзсэн юм.	Одоохондоо төлөвлөгөө байхгүй
Осака мужийн Изүмисано хот	Төв аймагт зохиогддог “Тал нутгийн Монгол” олон улсын марафон гүйлтийн тэмцээнд оролцох аяллыг, төрөлх хотдоо татвар төлсний урамшуулал болгож бэлэглэж байсан бөгөөд урамшуулалд хамрагдсан иргэд энэхүү марафонд оролцож байсан. Энэ үйл ажиллагаа одоо зогссон байна.	"Ковид-19" халдварт цар тахал тархсаны улмаас Монгол руу явах тогтмол нислэг үйлдэгдэхээ больсон тул, Засгийн газрын захиалгат нислэгээр зорчихоос өөр Монголд очих аргагүй болоод байна. Монгол улс халдвар тархвараас урьдчилан сэргийлэхийн тулд Япон улсаас илүү хатуу арга хэмжээ авч байгаа бөгөөд энэ арга хэмжээг хэзээ суллах, хэзээ Монгол оронд зочилж болох нь тодорхой бус байгаа энэ үед аялал жуулчлалын салбарт харилцаа, хамтын ажиллагаа төлөвлөхөд хүндрэлтэй байна.
Нагасаки мужийн Мацүүра хот	Монголын нүүдлийн соёлоор сэдэвлэж, Монголыг санагдуулам тал нутагт гэр, ресторан мөн халуун рашаан байршуулсан "Такашима Монгол тосгон" -г байгуулсан. (2016 оны 11-р сараас хойш хаалттай байгаа)	Одоогоор аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах төлөвлөгөө байхгүй.
Хоккайдо мужийн Асахикава хот	2011 оны 9-р сарын 15-нд "Таван Богд Групп"-ийн Ерөнхийлөгч Ц.Баатарсайхан Асахикава хотын аялал жуулчлалын төлөөлөгчөөр томилогдсон	Одоохондоо төлөвлөгөө байхгүй
Токушима дахь Өргөмжит консулын газар	1. Токушима мужийн Худалдаа аж үйлдвэрийн танхим зохион байгуулсан 2. Үндэсний өсвөр үеийнхний бейсболын тэмцээнд Монгол хүүхдүүд ирж оролцсон 3. Япон Монголын өсвөр үеийнхний бейсболын тэмцээнийг Монголд зохион байгуулсан 4. Төрийн соёрхолт Д.Сосорбарам гавьяатаар ахлуулсан Монголын дуу бүжгийн хамтлаг Токушима, Кочи муж болон Анан хот зэрэг газар 4 удаа тоглолт хийсэн	1.Токушима мужийн засаг даргын тамгын газар, мужийн Засаг дарга, Анан хотын ИТХ-ын гишүүн, Токушима хотын ИТХ-ын гишүүн, муж, хотын хамтарсан танилцах аялал 2. Цаашид Шикокүгийн дөрвөн мужийн хамтарсан аялал жуулчлалыг төлөвлөж байна
Фүкүока дахь Өргөмжит консулын газар	Аялал жуулчлалын томоохон компаниуд үнэтэй байдаг тул Монголын жижиг, дунд аялал жуулчлалын компаниудтай хамтран аяллын тур (аялал жуулчлалын бүтээгдэхүүн) төлөвлөж байна. Мөн Японд аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулдаг групп компаниар энэ аялал жуулчлалын бүтээгдэхүүнээ борлуулах, сурталчлах системийг бүрдүүлээд байна.Энэхүү бизнесийн үйл ажиллагааны гол зорилго нь, хоёр орны жижиг, дунд аж ахуй нэгж эрхлэгчдийн эдийн засгийн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх явдал юм. Аялал нь Монголын янз бүрийн аялал жуулчлалын газруудаар аялахын чатуу Монголын сайн сайхныг өөрийн биеэр мэдэрч туршиж үзэх агуулгатай байна.	Хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойг тохиолдуулан Кюүшү болон Монгол Улсад гүн гүнзгий холбоотой 13-р зууны түүхийг дахин судлах хөтөлбөрийг төлөвлөж байна. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд Фүкүока хотын харьяа түүхэн дурсгалт газар, хөшөөг сэргээн засварлах ажлыг эхлүүлээд байна. Түүний дотор өнгөрсөн жил Цүшима хот, Ики хот, Мацүүра хотууд хамтран зохион байгуулсан Монголын эзэнт гүрний довтолгооны чуулга уулзалтад оролцсон бөгөөд цаашид аялал жуулчлалын чиглэлээр хамтран ажиллахаар, шинээр аялал жуулчлалын маршрут боловсруулж байна. Монгол Улсад шинэ нисэх онгоцны буудал ашиглалтад орсноор Фүкүока хот-Улаанбаатар хот хооронд тогтмол нислэг хийдэг болбол аялал жуулчлалын салбар улам илүү хөгжинэ гэж найдаж байна.
Хоккайдо мужийн Саппоро хот	Байхгүй	<Дэлхийн өвлийн хотын дарга нарын холбоо> ны 2021 оны чуулганаар аялал жуулчлалын бодлогын судалгааны практик түвшний хэсэг зохион байгуулахаар төлөвлөж байна. Улаанбаатар хот оролцох эсэх нь тодорхойгүй байна.
Хоккайдо мужийн Мүкава хот	Байхгүй	Үлэг гүрвэлийн чулуужсан олдворыг хайх аяллын хөтөлбөр төлөвлөх
Ибараки мужийн Намэгата хот	Одоохондоо байхгүй	Цаашид хэрэгжүүлэх боломжтой эсэхийг судалж үзнэ
Нийгата мужийн Цүбамэ хот	Аялал жуулчлалын салбар дахь хамтын ажиллагаа байхгүй	Цаашид хэрэгжүүлэх боломжтой эсэхийг судалж үзнэ
Хоккайдо мужийн Такикава хот	Аялал жуулчлалын салбар дахь хамтын ажиллагаа байхгүй	Ахлах сургууль, коллежийн оюутнуудад зориулсан суралцах аялал зохион байгуулахаар хэлэлцэж байна
Тоттори муж	Аялал жуулчлалын салбар дахь хамтын ажиллагаа байхгүй. Гэхдээ Тоттори мужийн аялал жуулчлалын мэдээллийг Монгол хэл дээр цахимгаар түгээдэг	Тоттори мужийн аялал жуулчлалын талаарх мэдээлэл бүхий товхимлыг Монгол хэлээр энэ жилдээ багтаан гаргахаар төлөвлөж байна

Эх сурвалж: Судалгаанд хамрагдсан орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хийсэн ярилцлага, асуулгад өгсөн хариулт

Өнгөрсөн хугацаанд аялал жуулчлалын салбарт хамтын ажиллагаа байсан уу гэсэн асуултад “байсан” хэмээн хариулсан байгуулга нь 32-оос 8 буюу 25 хувийг эзэлсэн.



Эх сурвалж: Судалгаанд хамрагдсан орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хийсэн ярилцлага, асуултад өгсөн хариулт

Зураг 8-4: Аялал жуулчлалын салбарт хамтын ажиллагаа байх эсэх


Дээрх асуултад "байсан" гэж хариулсан орон нутгийн засаг захиргааны тодорхой үйл ажиллагааг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 8-13: Аялал жуулчлалын салбарт хамтран ажилласан жишээ

Аялал жуулчлалын салбарт хамтран ажилласан жишээ
• Мужийн иргэдээ Монголд зочлуулах, Монголын аялал жуулчлалын холбооны багийг хүлээн авах, аялал жуулчлалыг дэмжих төсөв [Шизүока муж]
• Хотын иргэдийн аяллын багийг Монголд айлчлуулах, дунд сургуулийн сурагчдын гадаадад хийх танилцах сургалтыг Монголд хэрэгжүүлэх [Шизүока мужийн Изүнокүни хот]
• Хотын иргэдийн аяллын багийг Монголд аялуулах, [Шизүока мужийн Яйзү хот]
• “Тал нутгийн Монгол” олон улсын марафон гүйлтийн тэмцээнд оролцох аялал (төрөлх хотдоо татвар төлсний урамшуулал бэлэг) [Осака мужийн Изүмисано хот]
• Такашима Монгол Тосгон (2016 онд хаагдсан) [Нагасаки мужийн Мацүүра хот]
• Соёлын солилцоо (Монголын дуу бүжгийн чуулгын концерт)
• Спортын солилцоо (Япон, Монголын өсвөр үеийнхний бейсболын тэмцээнийг Японд болон Монголд зохион байгуулагддаг) [Токүшима дахь Өргөмжит консулын газар]
• Асахикава мужийн Аялал жуулчлалын элчин сайдаар монгол хүнийг томилсон [Хоккайдо мужийн Асахикава хот]
• Тоттори мужийн аялал жуулчлалын мэдээллийг Монгол хэл дээр цахимаар түгээдэг [Тоттори муж]

Эх сурвалж: Судалгаанд хамрагдсан орон нутгийн засаг захиргаатай хийсэн ярилцлага, асуултад өгсөн хариулт

Цаашид Монгол улстай аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах төлөвлөгөө байгаа эсэхийг тодруулахад судалгаанд хамрагдсан 32 орон нутгийн засаг захиргааны 3 нь "байна", 3 нь "судална", 22 нь "байхгүй" гэж хариулжээ.



Эх сурвалж: Судалгаанд хамрагдсан орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хийсэн ярилцлага, асуултад өгсөн хариулт

Зураг 8-5: Аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах цаашдын төлөвлөгөө

Дээрх асуултад "байна, үргэлжлүүлнэ" эсвэл "судална" гэж хариулсан орон нутгийн засаг захиргааны (болон "Бусад" гэсэн ангилалаас Тоттори муж, Саппоро хотын) төлөвлөгөөний агуулгыг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 8-14: Аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах цаашдын төлөвлөгөөний агуулга

Аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах цаашдын төлөвлөгөөний агуулга	
•Мужийн иргэдээ Монголд зочлуулах, Монголын аялал жуулчлалын холбооны багийг хүлээн авах, аялал жуулчлалыг дэмжих төсвөө үргэлжлүүлэх [Шизүока муж]	
•Хотын иргэдийн аяллын багийг Монголд айлчлуулах, дунд сургуулийн сурагчдын гадаадад хийх танилцах сургалтыг Монголд хийх уламжлалт ажлуудаа үргэлжлүүлэх [Шизүока мужийн Изүнокүни хот]	
• Ахлах сургууль, коллежийн оюутнуудад зориулсан суралцах аялал зохион байгуулахаар хэлэлцэж байна. [Хоккайдо мужийн Такикава хот]	
• Мужийн болон хотын хамтарсан танилцах аялал, Шикокүгийн дөрвөн мужийн хамтарсан аялал жуулчлалыг төлөвлөж байна [Токүшима дахь Өргөмжит консулын газар]	
• <Дэлхийн өвлийн хотын дарга нарын холбоо> ны Аялал жуулчлалын бодлогын судалгааны группийг бүрдүүлэхээр төлөвлөж байна [Хоккайдо мужийн Саппоро хот]	
• Тоттори мужийн аялал жуулчлалын талаарх мэдээлэл бүхий товхимлыг Монгол хэлээр гаргахаар төлөвлөж байна [Тоттори муж]	
• Үлэг гүрвэлийн чулуужсан олдворыг хайх аяллын хөтөлбөр төлөвлөх талаар хэлэлцэхийг санал болгож байна [Хоккайдо мужийн Мүкава хот]	
• Цаашдын төлөвлөгөөг хэлэлцэх шатандаа явж байна [Нийгата мужийн Цүбамэ хот, Ибараки мужийн Намэгата хот]	

Эх сурвалж: Судалгаанд хамрагдсан орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хийсэн ярилцлага, асуултад өгсөн хариулт

<Монголд аялаад ирсэн хүмүүсийн санал сэтгэгдэл, зөвлөгөө>

"Солилцоо, хамтын үйл ажиллагааны хүрээнд Монгол улсад зочилж аялахад төрсөн сэтгэгдэл, тулгарсан бэрхшээл, сайжруулбал зохих зүйл юу вэ" гэсэн асуултын хариултыг ангилан цэгцэлж, дараах хүснэгтээр харуулж байна (хэд хэдэн хариулт)

Хүснэгт 8-15: Монголд аялаад ирсэн хүмүүсийн санал сэтгэгдэл, зөвлөгөө (ялангуяа аялал жуулчлалын тухайд)

Салбар	Агуулга	Хариултын тоо
Хүрээлэн буй орчин/ Дэд бүтэц	Автозам муу (орон нутаг)	5
	Замын түгжрэл их (УВ)	3
	Агаарын тээвэр хангалтгүй бөгөөд үнэтэй	3
	Агаарын бохирдол (УВ)	3
	Зам тээвэр муу, цаг их зарцуулдаг (орон нутаг)	2
	Олон улсын шинэ нисэх онгоцны буудалд ихээхэн найдвар тавьж байна	1
Аялал жуулчлалын нөөц	Бие засах газрыг сайжруулж хөгжүүлэх	4
	Аялал жуулчлалын байгууламж цөөн	1
	Аялал жуулчлалын байгууламжид стандарт тогтоох, стандартад нийцүүлэн тохижуулах	1
	Wi-Fi интернэт орчныг бүрдүүлэх	1
Үйлчилгээ, мэдээлэл	Бэлэг дурсгалын зүйлсийн борлуулалтыг сайжруулах (байрлах, хоноглох газрын бэлэг дурсгалын дэлгүүрүүд)	1
	Үйлчилгээний чанарыг сайжруулах (Нисэх онгоцны буудлын үйлчилгээний ажилтнуудыг чанаржуулах)	2
	Аюулгүй байдал, эрсдлийн менежмент (орон нутаг)	2
	Аялал жуулчлалын үйлчилгээний цэг байгуулах	1
	Туршлагатай хөтөч бэлтгэх	1
	Орчуулагч бэлтгэх	1
Бусад	Аялал жуулчлалын даатгал бий болгох	1
	Уур амьсгалын ялгаатай байдал, хүйтэн, тоосорхог	2
	Хоол хүнс, эрүүл ахуйн талын ялгаатай байдал, эрүүл мэнддээ анхаарах хэрэгтэй байдаг	2
	Бусад жуулчдын боловсон бус зан авир	1
	Хүн хоорондын харилцаа болон соёл, боловсролын ялгаа	1

Эх сурвалж: Судалгаанд хамрагдсан орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хийсэн ярилцлага, асуултад өгсөн хариулт

Японы орон нутгийн засаг захиргааны солилцоо, хамтын ажиллагааны хүрээнд Монгол улсад айлчлах үедээ дэд бүтэц тоног төхөөрөмжтэй холбоотой асуудлаар сэтгэл ханамжгүй байсан нь судалгаагаар гарчээ. Тэд авто зам муу, замын түгжрэл их, агаарын тээвэр хангалтгүй бөгөөд үнэтэй, бие засах газар хөгжөөгүй байсан гэх зэргээр хариулсан байна.

<Харилцаа, хамтын ажиллагаа нь Монголд зорчих жуулчид нэмэхэд нөлөөлсөн эсэх>

"Монгол улстай хамтран ажилладаг болсноос хойш Монгол руу явах жуулчдын тоо өссөн эсэх, аялал жуулчлалын салбарт хамтын ажиллагаа эергээр нөлөөлсөн эсэх" талаар асуухад ихэнх орон нутгийн засаг захиргаа "Мэдэхгүй" эсвэл "Онцны нөлөө байхгүй" гэж хариулсан байна. Тодорхой хариулт өгсөн гурван орон нутгийн засаг захиргааны хариулт дараах байдалтай байна.

Хүснэгт 8-16: Хамтын ажиллагаа нь аялал жуулчлалын салбарт нөлөө үзүүлсэн эсэх

Япон Улсын орон нутгийн засаг захиргааны байгууллага/ Консулын газар	Монголын аялал жуулчлалд орон нутаг хоорондын хамтын ажиллагааны үзүүлсэн нөлөө
Шизүока муж	Ихээр нөлөөлсөн.
Тоттори муж	Төв аймгаас ирсэн хүүхэд, залуучуудыг хүлээн авч байрлуулж байсан Япон айлын гэр бүл Монголд зочилсон жишээ байгаа. Мөн мужийн орон нутгийн засаг захиргааны байгууллагад гадаад харилцааны Монгол ажилтан томилсон зэрэг Монгол Улстай явуулж буй харилцаа, хамтын ажиллагаагаа өргөжүүлсээр байна. Цаашид аялал жуулчлалын салбар дахь хамтын ажиллагаагаа
Фүкүока дахь Өргөмжит консулын газар	Монголд очих жуулчдын тоо нэмэгдэнэ гэж бодож байна. Итгэлтэйгээр танилцуулж болох найдвартай Монголын аялал жуулчлалын компани олширвол өрсөлдөөн бий болж харилцаа, үйлчилгээ сайжрах байх гэж найдаж байна

Эх сурвалж: Судалгаанд хамрагдсан орон нутгийн засаг захиргааны байгууллагагай хийсэн ярилцлага, асуулгад өгсөн хариулт

Шизүока муж "Ихээр нөлөөлсөн" гэж хариулжээ. Хамтын ажиллагаа эхэлснээс үүдэн жил бүр захиалгат нислэг үйлдэж, Шизүока мужийн төлөөлөгчид Монголд айлчилж байна. Шизүока мужийн санаачилгаар тус мужийн Изүнокүни, Яйзү болон бусад хотуудаас Монголтой харилцан айлчилж, хамтын ажиллагаа нь өргөжиж байгаа юм.

8.5 Хамтын ажиллагааны талаар санал дэвшүүлэхэд анхаарах зүйлс

(1) Хүн хоорондын харилцаа, итгэлцэл чухал

Харилцаа, хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэхэд, монгол хэлний орчуулгын чадвартай боловсон хүчин бэлтгэх, Монгол талаас хамтын ажиллагааг хариуцах ажилтны тогтвортой байдал чухал гэдгийг орон нутгийн засаг захиргааны олон байгууллагууд онцолж байна. Хүн хоорондын харилцаа, итгэлцэл нь хамтын ажиллагааг үргэлжлүүлэх, хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой гэдэг нь судалгаагаар нотлогдож байгаа болно. Монгол гаралтай ажилтан болон Монголоос томилогдон ирсэн гадаад харилцааны ажилтан (СIR) ажиллаж байгаа орон нутгийн засаг захиргааны байгууллагын хамтын ажиллагаа нь харьцангуй сайн явагдаж байна (Тоттори муж, Шизүока муж, Мияконожо хот, Изүмисано хот, Яйзү хот, Изүнокүни хот г.м).

(2) "Ковид-19" халдварт өвчний цар тахлын улмаас "Хост таун" хотуудын харилцаа зогссон

2020 онд "Ковид-19" халдварт өвчний цар тахлын улмаас харилцан айлчлал хийх боломжгүй болсон. Ялангуяа Токио 2020 олимп, паралимпод оролцох Монголын тамирчдын урьдчилсан бэлтгэлийг хийлгэж, үүнийг эхлэл болгон хамтын ажиллагаа хөгжүүлэх төлөвлөгөөтэй байсан "Хост таун" хотуудын хувьд харилцаа, хамтын ажиллагаа бараг зогссон. Монголын тамирчид Японд ирж бэлтгэл хийх нь хотын иргэдтэй харьцах, нөхөрлөх чухал боломж байсан бөгөөд үүнгүйгээр харилцаа, хамтын ажиллагаа өрнүүлэхэд бэрхшээлтэй. Энэхүү судалгааг хийж байсан үед буюу 2021 оны 3-р сарын 20-нд Токио 2020 олимп, паралимп үзэх зорилготой гадаадын жуулчидыг хүлээж авахгүй гэдгийг албан ёсоор шийдсэн бөгөөд "Хост таун хөтөлбөрийн удирдамж"-ийн 1-р зүйлд заасан "Токио 2020 олимп, паралимпын наадмыг зохион байгуулснаар олон тамирчид, үзэгчид зочлон ирэх ба үүнийг эхлэл болгон, орон нутгийн засаг

захиргааны байгууллага болон наадамд оролцогч улс орон, бүс нутаг хооронд иргэд, эдийн засаг, соёлын харилцаа, солилцоог хөгжүүлэхийн зэрэгцээ, орон нутгийг сэргээн хөгжүүлнэ" гэсэн зорилт бодит биеллээ олох боломжгүй болсон. Судалгаа хийсний дараа буюу 2021 оны 5-р сараас хойш төлөвлөгдөж байсан Монголын тамирчдыг “Хост таун” хотуудад хүлээн авч бэлтгэл хийлгэх үйл ажиллагааны ихэнх нь цуцлагдсан (Ибараки мужийн Сакурагава хот, Широсато хот, Аомори мужийн Имабэцү хот, Шизүока мужийн Изүнокүни хот, Айчи мужийн Оказаки хот, Нийгата мужийн Цүбамэ хот, Осака мужийн Изүмисано хот г.м).

(3) Олимп, паралимпоос үл хамааран харилцаагаа хөгжүүлэх хүсэлттэй орон нутаг бас байна

Судалгааны зорилтот бүс нутаг болох Монголын орон нутгийн засаг захиргааны байгууллага болон Японы орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах ирээдүйн боломжийн тухайд, тэдний идэвх санаачилга, хүсэл эрмэлзэл чухал хүчин зүйл юм. “Хост таун” хөтөлбөрт хамрагдахаас өмнө Монголын орон нутгийн засаг захиргааны байгууллагатай харилцаж байсан Японы орон нутгийн засаг захиргааны хувьд олимп, паралимпоос үл хамааран хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэхээр төлөвлөж байгаа нь судалгаанаас харагдаж байна (Яхико тосгон, Шизүока муж, Тоттори муж, Изүмисано хот, Саку хот гэх мэт). “Хост таун” хотууд олимп, паралимпын дараа хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэх төсвийг хэрхэн яаж бүрдүүлэх вэ гэдэг асуудал тулгамдаж буй нь судалгаанд оролцсон хэд хэдэн орон нутгийн засаг захиргааны хариултаас харагдаж байна. Хамтын ажиллагааны тухай санал боловсруулж дэвшүүлэхэд, Монголын орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хийх гэж буй хамтын ажиллагаанд Японы орон нутгийн засаг захиргааны байгууллагаас чухал ач холбогдол өгөх нь зайлшгүй шаардлагатай.

(4) Хоёр улсын орон нутаг хоорондын харилцаа, солилцооны үйл ажиллагаа нь аялал жуулчлалын салбар дахь хамтын ажиллагаа болж хөгжөөгүй байна

Дээрх нөхцөл байдалд үндэслэн аялал жуулчлалын салбарын хамтын ажиллагааны талаар санал боловсруулахдаа “Хост таун” хөтөлбөрт хамрагдахаас өмнө, угаас хамтын ажиллагааг хөгжүүлж ирсэн орон нутаг болон “Хост таун” хөтөлбөрт хамрагдаж хамтын ажиллагаагаа эхлүүлэн, цаашид ч хамтын ажиллагаагаа хөгжүүлэх хүсэл эрмэлзэл, идэвх санаачилгатай орон нутгийн засаг захиргаанд тулгуурлан санал боловсруулах нь зохимжтой гэж үзэж байна. Гэхдээ олон жилийн харилцааны туршлагатай орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын солилцооны үйл ажиллагаа нь тэр бүр аялал жуулчлалын салбарын хамтын ажиллагаа болж хөгжөөгүй байна. Цаашид ч энэ чиглэлээр хамтын ажиллагаагаа хөгжүүлэх орон нутгийн засаг захиргаа цөөн байгаагаас үзэхэд, богино хугацаанд хэрэгжүүлэх үр дүнтэй хамтын ажиллагааны санал дэвшүүлэхэд тун хэцүү юм.

Японы орон нутагтай харилцаж ирсэн хамгийн арвин туршлагатай Улаанбаатар хотын Аялал жуулчлалын газрын Бодлогын хэлтсийн даргаас авсан ярилцлагаар (2021 оны 6-р сарын 4) “Аялал жуулчлалын салбарт Японы орон нутагтай хамтран ажиллаж байсан уу?” гэсэн асуултад тодорхой орон нутгийн засаг захиргааны нэр дурьдагдаагүй. БНСУ-ын Жежу арлаас гаралтай “Олле” хэмээх явган аяллын маршрутыг боловсруулж аялах арга хэмжээг Улаанбаатар хотод зохион байгуулж байсан бөгөөд “Кюүшүү олле” “Мияаги олле”-тэй адил арга хэмжээ гэж үздэг хэмээсэн. Гэхдээ хамтран ажиллагч нь БНСУ-ын КОЙКА (Korea International Cooperation Agency) болон Жежу хотын Аялал жуулчлалын газар юм. 2019 онд зохион байгуулсан арга хэмжээнд БНСУ-аас 70-аад жуулчид оролцсон боловч Японы Мияаги муж, Кюүшүү бүсээс оролцож, хамтран ажилласан тохиолдол байгаагүй.

(5) Олон засаг захиргааны байгууллагаас хүүхэд залуучуудын солилцооны хөтөлбөр хэрэгжүүлдэг

Нэлээд хэдэн орон нутгийн засаг захиргааны байгууллага (Тоттори муж, Мияконожо хот, Саку хот, Изүмисано хот, Изүнокүни хот, Яйзү хот, Яхико тосгон гэх мэт) хүүхэд, залуучуудын (дунд, ахлах ангийн сурагчдыг оролцуулаад) харилцан айлчлалыг тогтмол хэрэгжүүлж байна. Монголд айлчлаад ирсэн дунд сургуулийн сурагчдын сэтгэгдэл нийлэгдэж байгаа бөгөөд “Энэхүү Монголоор аялах ховор завшаан тохиолдсныг мартахгүйгээр өдөр тутмын аж амьдралаа өнгөрүүлэх бодолтой”, “Монголоос Японыг гадаадын орноос харах харцтай болсон. Монголд очсон нь үнэхээр сайхан туршлага болсон”, “Монголд очсон туршлагаа ашиглан цаашид янз бүрийн зүйлд идэвхтэй оролцох бодолтой”, “Монголд очоод хэл нэвтрэхгүй ч сэтгэлээр ойлголцож болно гэдгийг сурсан”, “Өөрийн дээдлэх үнэт зүйлийн цар хүрээ тэлсэн”, “Өөрийн нүдээр харж, үнэртэж, чимээ сонсож, хоолыг нь идэж, гар хүрэх гэсэн туршлага надад нандин эрдэнэ болно” гэх зэргээр харилцан айлчлал нь тухайн хүүхдийн боловсрол, хүмүүжилд чухал ач

холбогдолтой гэдгийг харуулж байна. Хойч үеийг үүрч явах хүүхдүүдийн солилцоо нь урт хугацаанд орон нутгийн тогтвортой хамтын ажиллагаанд хувь нэмэр оруулна хэмээн найдаж байна.

8.6 Японы орон нутгийн засаг захиргаа болон судалгааны зорилтот бүс дахь олон нийтийн хамтын ажиллагааны санал

Монгол улсын аялал жуулчлалын салбарт тулгамдаж буй зарим асуудлыг шийдвэрлэх зорилгоор 6 -р бүлэгт санал болгосон төсөлтэй уялдуулан орон нутгийн хамтын ажиллагааны саналыг дэвшүүлж, улмаар цаашид хэрэгжүүлэх боломжийн талаар судлахад хувь нэмэр оруулахыг хүсч байна. Түүнчлэн аялал жуулчлалын тогтвортой хөгжлийг тусгал болгосон үзэл баримтлалаар санал болгож буй нь 9 -р бүлэгт тайлбарлах “Монгол дахь Дэлхийн бөмбөрцөгийн ирээдүйн төлөө хүүхдүүдийн чуулга уулзалт” санаачилга юм. “Монгол дахь Дэлхийн бөмбөрцөгийн ирээдүйн төлөө хүүхдүүдийн чуулга уулзалт” санаачилга нь Японы орон нутгийн засаг захиргаанаас хэрэгжүүлэх хүүхэд залуучуудыг Монгол улсад илгээх төслийн ач холбогдлыг ард иргэдэд ойлгуулж, түүнд оролцох хүсэлтэй хүмүүсийн тоог нэмэгдүүлэхэд концепц болгож ашиглах боломжтой. Харилцаа солилцооны арга хэмжээг хамтын ажиллагааны төсөл болгон хөгжүүлэхэд удаан хугацаанд үйл ажиллагааны туршлагаа хуримтлуулах шаардлагатай байна. “Монгол дахь Дэлхийн бөмбөрцөгийн ирээдүйн төлөө хүүхдүүдийн чуулга уулзалт” санаачилгын зорилго нь судалгааны зорилтот бүс дахь ард иргэд үүнийг хүлээн авч, тасралтгүй үйл ажиллагаа үргэлжлүүлэн явуулах замаар аялал жуулчлалын урт хугацааны тогтвортой хөгжилд хүргэхэд оршино.

<Санал болгосон төсөлтэй уялдуулсан орон нутгийн хамтын ажиллагааны санал>

- (1) “Гөвийн бүсийн аялал жуулчлалыг хөгжүүлэх загвар төсөл”-тэй уялдуулсан орон нутгийн хамтын ажиллагаа

Тус төсөл нь Өмнөговь, Дундговь, Дорноговь, Говьсүмбэр аймгийг зорилтот бүс болгож байна. Японд Шизүока муж нь Дорноговь аймагтай өргөн цар хүрээтэй хамтын ажиллагааны туршлагатай бөгөөд Дорноговь аймагтай харилцаа тогтоосны 10 жилийн ой тохиож буй 2021 оныг “Шизүока монгол жил” хэмээн зарлаж, төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулж байна. Цаашид ч үргэлжлүүлэн хамтран ажиллах найдлагатай. Өнгөрсөн хугацаанд “Өвсний үндэс техникийн хамтын ажиллагааны төсөл” -ийн хүрээнд “Ус ариутгах татуургын менежментийн чадавхийг сайжруулах төсөл” -ийг хэрэгжүүлсэн бөгөөд ус, бохирын инженерүүдийг илгээж, байгаль орчны боловсролын байдалтай танилцаж байсан туршлагатай. Санал болгож буй төслийн үйл ажиллагааны хүрээнд Японд сургалт, танилцах аялал хийхээр төлөвлөж байгаа бөгөөд тухайн үед, жишээлбэл Шизүока мужид очиж, аялал жуулчлалын нөөцийг хамгаалах арга зам, гол авто зам дагуу байгуулагдсан үйлчилээний цогцолбор болон бусад байгууллагатай танилцаж, сурталчилгаа, маркетинг, арга хэмжээ төлөвлөж зохион байгуулах, жуулчны газрын зураг боловсруулах зэрэг ноу-хау эзэмшүүлэхэд хамтран ажиллах боломжтой хэмээн үзэж байна.

- (2) “Монголын үндэсний үлэг гүрвэлийн музей” байгуулах төслийн бэлтгэл ажилтай холбоотой орон нутгийн хамтын ажиллагаа

Хоккайдо мужийн Мүкава хот “Үлэг гүрвэлийг ашигласан хотын хөгжил” бодлогыг хэрэгжүүлж байгаа бөгөөд 2020 оны 9-р сард ШУА-ийн Палеонтологийн хүрээлэнтэй хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурсан. 2019 онд Токио хот дахь Үндэсний шинжлэх ухааны музейд зохион байгуулагдан олон үзэгчдийг татсан “Dinosaur Expo 2019” үзэсгэлэнд “Мүкава Луу (kamuyasaurus japonicus)” -ийн сэргээсэн араг яс (хуулбар) дэлгэгдсэн. Үүнийг бүтээсэн Gobi Support Japan ХХК нь Монголын үлэг гүрвэлтэй холбоотой бизнест гүнзгий оролцдог бөгөөд 2017 оноос Мүкава хотод урлангаа байгуулан ажиллуулж байгаа. Мүкава хот нь 2018 оноос эхлэн “MUKAWA Dinosaur Adventure” чулуужсан яс малтлага хийх туршилтын аялал төлөвлөж зохион байгуулж байгаа зэрэг үлэг гүрвэлийг аялал жуулчлалын нөөц болгон жуулчдыг татах зорилгоор ашиглаж ирсэн. Монгол улстай үлэг гүрвэлийн чулуужсан ясын судалгааны сэдвээр эрдэм шинжилгээний солилцоо хийж байгаа бөгөөд хувийн хэвшлийг оролцуулан орон нутгийн хөгжлийг эрчимжүүлэх талаар идэвхтэй ажиллаж байна. Нэмж дурдахад Японы үлэг гүрвэлийн судалгаа нь өргөн цар хүрээ, сүлжээтэй байдаг. Японы Палеонтологийн Нийгэмлэгийн 2021 оны ээлжит эрдэм шинжилгээний бага хурлыг 2021 оны 7-р сарын 2-оос 4-ний хооронд Окаяма Шинжлэх Ухааны Их Сургуулиас удирдан онлайнаар зохион байгуулсан бөгөөд “Монгол үлэг гүрвэлийн судалгааны фронт” гэсэн сэдвээр симпозиум зохион байгуулагдан Монгол улсын ШУА-н Палеонтологийн хүрээлэнгээс судлаачид оролцсон. Монгол улсад үлэг гүрвэлийн музейг байгуулахад Японы үлэг гүрвэл судлаачдын

сүлжээ хамтран ажиллах найдлагатай.

- (3) Аялал жуулчлалын асуудлыг хариуцсан төрийн албан хаагчдад зориулсан сургалттай уялдуулсан орон нутгийн хамтын ажиллагаа

Төслийн саналд дурьдсанчлан, Монгол улсын холбогдох яам, агентлагууд болон судалгааны зорилтот бүс дэх аялал жуулчлалын асуудлыг хариуцсан төрийн албан хаагчдыг Япон улсад урьж сургалтад хамруулахад Монгол улстай харилцаа тогтоосон Японы орон нутгийн засаг захиргаанд зочлох нь тулгамдсан асуудлуудыг харилцан ойлголцоход ач холбогдолтой юм. Мөн Токиогийн олимп, паралимпийн дараа солилцооны үйл ажиллагаа нь тодорхойгүй байгаа “Хост таун” хотын захиргаанд солилцоо хийх шинэ боломж олгоход нөлөө үзүүлнэ гэж бодож байна. Түүнчлэн хүйтэн бүс нутгийн аялал жуулчлалын дэвшилтэт бүс болох Хоккайдод зочлох нь өвлийн улиралд аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогыг боловсруулахад хувь нэмэр оруулна гэж найдаж байна.

<“Монгол дахь Дэлхийн бөмбөрцөгийн ирээдүйн төлөө хүүхдүүдийн чуулга уулзалт” санаачилгатай уялдуулсан орон нутгийн хамтын ажиллагааны санал>

- (1) “Эх Дэлхий Хүүхдийн Хотхон”-ы ой бий болгохтой холбоотой орон нутгийн хамтын ажиллагаа

Хүүхдүүдэд эх дэлхийн байгаль орчныг хайрлан хамгаалах дадал зуршил бий болгоход чиглэсэн ойжуулах ажлын хүрээнд Японы орон нутгийн захиргааны байгууллагуудаас Монголд айлчлах хүүхдүүдийг мод тарих аянд оролцохыг уриална. Хэрэгжүүлэх арга хэлбэрийн хувьд, тухайлбал судалгааны зорилтот бүс болох Өмнөговь аймгийн “Аялал жуулчлалыг хөгжүүлэх хэтийн зорилт 2019-2029”-д Даланзадгад хотын Даланзадгай цэцэрлэгт хүрээлэнг хөгжүүлэх төлөвлөгөө тусгагдсан бөгөөд энэхүү төлөвлөгөөтэй хамтран ажиллах боломжтой. Тус аймгаас төсөвлөн, хэрэгжүүлэх байгууллага нь нутгийн иргэдийн зохион байгуулалттай ТББ бөгөөд иргэдтэй хамтран ажиллах эрэлт хэрэгцээ ч байна. Японы орон нутгийн засаг захиргаанаас Өмнөговь аймагт хүүхдүүдийг илгээсэн жишээ байдаггүй тул урьдчилан тус аймагт хүлээж авах тогтолцоо бий болгох шаардлагатай юм.

- (2) Монгол дахь Дэлхийн бөмбөрцөгийн ирээдүйн төлөө хүүхдүүдийн чуулга уулзалтыг зохион байгуулахтай холбоотой орон нутгийн хамтын ажиллагаа

Японы орон нутгийн олон засаг захиргаанаас хэрэгжүүлж буй бага дунд, ахлах ангийн сурагчдыг оролцуулсан хүүхэд, залуучуудын харилцан айлчлал, гадаад дахь сургалтын төслүүдийг илүү утга өгөөжтэй болгох үүднээс “Монгол дахь Дэлхийн бөмбөрцөгийн ирээдүйн төлөө хүүхдүүдийн чуулга уулзалт”-ыг зохион байгуулахтай уялдуулахыг санал болгож байна. Хоёр улсад зохион байгуулах хорооны бүтцийг бий болгосноор солилцоо, хамтын ажиллагаанд оролцох хүний нөөцийн бааз суурийг өргөжүүлэхэд хувь нэмэр оруулна гэж найдаж байна.

- (3) Олон улсын сурагчдын аяллын солилцоог дэмжих

Орон нутгийн засаг захиргаанаас явуулж буй хүүхэд, залуучуудыг харилцан айлчлал, солилцоог хөгжүүлэх замаар Монгол улсад сурагчдын аялал хийх боломжийг эрэлхийлнэ. Үүний тулд “Эх Дэлхий Хүүхдийн Хотхон”-ы ой байгуулах аян (мод тарих) болон Монгол дахь Дэлхийн бөмбөрцөгийн ирээдүйн төлөө хүүхдүүдийн чуулга уулзалттай уялдуулна. Энэхүү солилцооны үйл ажиллагааг хувийн хэвшил, ТББ-тай хамтран ажиллах боломж болгон ашиглаж, Монголын дунд сургуулийн сурагчдыг Японы орон нутгийн засаг захиргаанд хүлээн авахаар болбол энэ нь харилцан өгөөжтэй солилцооны үйл ажиллагаа болж, аялал жуулчлалыг дамжуулан орон нутгийг хөгжүүлэх шинэ загвар болох боломжтой хэмээн үзэж байна.

9-р бүлэг

Ковид-19 цар тахлын дараах үеийн аялал
жуулчлалын салбарын дүн шинжилгээ,
ЗӨВЛӨМЖ

9-р бүлэг Ковид-19 цар тахлын дараах үеийн аялал жуулчлалын салбарын дүн шинжилгээ, зөвлөмж

9.1 Ковид-19 цар тахлын дараах Дэлхийн аялал жуулчлалын хэтийн төлөв

Ковид-19 цар тахлын дэлхийн аялал жуулчлалд үзүүлэх нөлөө нь зөвхөн эдийн засаг төдийгүй, хүмүүсийн амьдралын хэв маяг, хоорондын харилцаанд хүртэл өөрчлөлт авчирч байна. Хүн төрөлхтөнд хэдэн зуун жилд нэг удаа тохиолдох асар их өөрчлөлтийн энэ үед, аялал жуулчлалыг ч дахин үнэлж дүгнэх хэрэгтэй болж байна. Дэлхийн аялал жуулчлалын мэргэжилтнүүд Ковид-19 цар тахлын дараах аялал жуулчлалд томоохон өөрчлөлт гарна хэмээн таамаглаж байгаа. Мэргэжилтнүүдийн зарим нь харьцангуй эерэг өөрчлөлтүүд гарна гэж таамаглаж байхад энэ салбарыг тэр чигээрээ хувиран өөрчлөгдөнө гэж таамаглах мэргэжилтэн ч байгаа юм. Мэргэжилтнүүдийн дэвшүүлж буй таамагт нийтлэг байгаа зүйл бол (1) Дэлхий даяарших үйл явц хэзээ ч зогсохгүй, хүний төрөлхтний сонниуч зан чанар ч хэзээ ч арилахгүй тул аялал жуулчлал цаашид ч эрчимтэй хөгжинө гэдгийг онцлонгоо 2) Ковид-19 цар тахлын нөлөөгөөр аялал жуулчлалын нөхцөл байдал үндсээрээ өөрчлөгдсөн тул, цоо шинэ хэлбэрээр хөгжих болно гэж байгаа юм.⁵⁷ Ковид-19 цар тахлын улмаас хүмүүс удаан хугацаагаар аялах, хоорондоо хэт ойртох, бөөгнөрөл үүсгэх зэрэг нь хязгаарлагдах болж, эрүүл мэнд, эмнэлэг, эмчилгээг урьд өмнөхөөсөө илүү сонирхох болсон гэж мэргэжилтнүүд онцолж байгаа юм. Иймээс, Ковид-19 цар тахлын дараах аялал жуулчлалыг хөгжүүлэхдээ доорх зүйлийг анхаарч үзэх хэрэгтэй.


- ① Тав тух, аюулгүй байдлыг хангахгүй бол өндөр настай жуулчдыг нэмэгдүүлэхэд хэцүү болно. Ялангуяа, халдварт өвчний тархалт намжаагүй байгаа улс орнууд болон халдвар хамгааллын зохих арга хэмжээ авахгүй байгаа орнуудыг зорих газар болгон сонгохгүй байх магадлалтай.
- ② Сүүлийн жилүүдэд алдартай аялал жуулчлалын газруудад жуулчид хэт их зорчсоноос ачаалал нь хэтэрч байсан. Цар тахлаас шалтгаалж хэт бөөгнөрлөөс зайлсхийх үүднээс алдартай газруудыг зорих жуулчдын тоо буурч магадгүй юм.
- ③ Ихэнх орны иргэд цаашдаа гадаад улс руу аялах бус дотоодын ойрхон, аюулгүй аяллыг сонгох хандлага түлхүү байна.
- ④ Олон газрыг тойрдог хөдөлгөөнт аялал хийхээсээ илүү нэг газар тайван амрах, ресорт амралтын газрын (эсвэл тусгай сэдэвтэй аялал) аялал нэмэгдэх хандлагатай байна.
- ⑤ Ковид-19 цар тахлын дараа зах зээлийн өрсөлдөөн ширүүсэх төлөвтэй байгаа тул одоогоос эхлэн бэлтгэл ажлыг хангаж, гадаадын жуулчдыг хүлээн авах аялал жуулчлалын орчныг сэргээн хөгжүүлэх төлөвлөгөөг гаргах шаардлагатай байна.

9.2 Монголын аялал жуулчлалын хэтийн төлөв

1) Гадаадын жуулчдын тооны өөрчлөлт, цаашдын таамаглал

2015-2019 онд Монгол орныг зорих гадаадын жуулчдын тоо тогтвортойгоор өсөж байсан боловч 2020 онд Ковид-19 халдварт цар тахлын нөлөөгөөр 2019 оны жуулчдын тооны аравны нэг болглоо огцом буурсан байна. Дэлхийн аялал жуулчлалын байгууллага (UNWTO)-ын COVID-19 RESPONSE-оос харахад 2020 онд жуулчдын тоо хамгийн их буурсан улс бол Монгол улс бөгөөд 2019 онтой харьцуулахад 89 хувиар буурчээ (Эх сурвалж: UNTWO Tourism Dashboard). ЭЗХАХБ -аас гаргасан таамаглалаас харахад дэлхийн жуулчдын тоо 2019 оны түвшинд хүрж эргэн сэргэх нь хамгийн хурдандаа 2024 оноос хойш байх төлөвтэй байна. Тиймээс 2025 оноос хойших жуулчдын тоог 2015-2019 оны жуулчдын тооны дундаж өсөлтийг ашиглан туршилтын тооцоо хийж үзсэн бөгөөд үр дүнг доорх хүснэгтэд харуулж байна.

⁵⁷ Foreign Policy's The Future of Travel After the Coronavirus Pandemic, June 13, 2020



Эх сурвалж: Үндэсний статистикийн хорооны статистик мэдээлэлд үндэслэн судалгааны баг боловсруулав

Зураг 9-1: Гадаадын жуулчдын тооны өөрчлөлт болон 2030 он хүртэлх таамаглал

Ковид-19 цар тахлын өмнөх 2015-2019 онуудад гадаадын жуулчдын тоо жилд дунджаар 10.5%-иар өсөж байжээ. Дэлхийн аялал жуулчлалын байгууллага (UNWTO) нь дэлхийн аялал жуулчлал 2019 оны түвшинд хүрч эргэж сэргэгэл дор хаяж 4 жил шаардагдана хэмээн үзэж байгаа болно. Дэлхий даяараа эрүүл мэнддээ санаа зовних хандлагатай болсон энэ цаг үед Ковид-19 цар тахал анх дэлгэрсэн орны хажууд байдаг, эмнэлэг, эмчилгээний чанар тийм ч өндөр биш Монгол улсын хувьд илүү их цаг хугацаа шаардагдаж ч магадгүй. Ковид-19 цар тахлын нөлөө нь 2008 оны дэлхийн эдийн засгийн хямралаас хамаагүй илүү ноцтой юм. Дэлхий даяар аялал жуулчлалын салбарын үйл ажиллагаа зогсоод байгаа энэ үед, цар тахлын дараах үеийн стратегийг боловсруулж, Монгол орныг хэрхэн яаж жуулчдын сэтгэлийг татахуйц сонирхолтой орон болгох вэ гэдгээс Монголын аялал жуулчлалын ирээдүй шалтгаална гэж хэлж болно.

2) Дотоодын жуулчдын тооны өөрчлөлт

Монголд сүүлийн жилүүдэд дотоодын жуулчдын тоо хурдацтай нэмэгдэж байгаа юм. Цар тахлын нөлөөгөөр дотооддоо аялах хүмүүсийн тоо цаашид ч ихсэх хандлага ажиглагдаж байгаа боловч Монголын хувьд арай өөр шалтгаан бас байгаа болно. Статистик, тоо мэдээлэл хангалттай байхгүй болохоор зөвхөн гол аялал жуулчлалын газрын тодорхой бүс нутагт аялсан хүний тоогоор тооцоолсон дараах хүснэгтээс, сүүлийн жилүүдэд дотоодын жуулчдын тоо хэр эрчимтэй өсөж байгааг харж болно. Ковид-19 цар тахлын халдвар тархалт намжмагц дотоодын жуулчдын тоо цаашид улам нэмэгдэх төлөвтэй байна.

Хүснэгт 9-1: Судалгааны зорилгот бүс нутаг дахь гол аялал жуулчлалын газрын жуулчдын тооны өөрчлөлт

Аялал жуулчлалын газар		Харьцуулсан жил, ирсэн жуулчдын тоо	2019 онд ирсэн жуулчдын тоо
Говь Гурвансайхан БЦГ	Гадаадын жуулчид	2015 он 14,982	42,132
	Дотоодын жуулчид	2015 он 5,257	12,955
Хамарын хийд	Гадаадын жуулчид	2013 он 2,500	2,182
	Дотоодын жуулчид	2013 он 40,200	67,838
Эрдэнэ Зуу Хийд	Гадаадын жуулчид	2019 он 27,919	(2020) 326
	Дотоодын жуулчид	2019 он 31,950	(2020) 33,195

Эх сурвалж: Судалгааны баг

Аялал жуулчлалын салбарын татварын орлого 2019 онд 570,000 орчим гадаадын жуулчдаас ойролцоогоор 7.3 тэрбум төгрөг (2.65 сая орчим ам.доллар) байна. Хэдийгээр 2020 онд 5.2 тэрбум төгрөг болж буурсан ч гадаадын жуулчдын тоо 1/10 болж буурсантай харьцуулахад аялал жуулчлалын орлого төдийлөн буураагүй байгаагийн гол шалтгаан нь дотоодын жуулчдын тоо эрс нэмэгдсэнтэй холбоотой юм. Мөн 2021 оны 4-р сарын 30-ны байдлаар 1.4 тэрбум төгрөг байна (Улаанбаатар хотын Аялал жуулчлалын бодлогын хэлтсийн даргатай хийсэн ярилцлага).

9.3 Ковид-19 цар тахлын дараах Монголын аялал жуулчлалын дүн шинжилгээ, зөвлөмж

1) Монголын томоохон зах зээл болон Ковид-19 цар тахлын дараах үе

Монголд аялахаар ирдэг гадаадын жуулчдыг улсаар нь авч үзвэл БНХАУ 29.2%, ОХУ 24.6%, БНСУ 17.5% байгаа ба энэ 3 улс нийт дүнгийн 71.3%-ийг эзэлж байна. Үүн дээр Японы 4.2%-ийг нэмбэл энэ 4 улс нийт дүнгийн 2/3ийг эзлэх юм⁵⁸. Орон нутгийн аялал жуулчлалын агентлагуудын хувьд ашиг өндөртэй, ихэнхдээ урт хугацаагаар аялдаг Европын орнууд, АНУ зэрэг орнуудаас ирэх жуулчид нийлээд нийт дүнгийн 10% -иас бага байгаа болно. Зах зээлийг тэлэх үүднээс авч үзвэл, хүн амын тоотой нь харьцуулахад цөөн тооны жуулчид ирж байгаа Япон болон газарзүйн хувьд ойрхон Зүүн Өмнөд Азийн орнуудаас ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх, урт хугацаагаар аялдаг барууны орнуудаас жуулчдыг татах нь чухал юм. Нөгөөтэйгүүр, Монголд ирдэг жуулчдын бараг тал хувь нь 40-өөс дээш насны хүмүүс байдаг ба энэ насны жуулчид цар тахлын дараа гадаадын аяллын чиглэлийг сонгохдоо болгоомжтой хандана гэж таамаглаж байгаа болно. Ресорт хэлбэрийн аялал жуулчлалын газар ихтэй Зүүн Өмнөд Ази болон Номхон далайн орнууд Монгол улсын өрсөлдөгч болох төлөвтэй байгаа юм. Зөв, зохистой мэдээллийг түгээх, хямд үнээр үйлчлэх, амар амгалан, аюулгүй байдлыг хангах зэргээр өрсөлдөх чадварыг бэхжүүлэх шаардлагатай юм.

2) Дотоодын аялал жуулчлалын хөгжил, тулгамдаж буй асуудлууд

Ковид-19 цар тахлын үед ч дотоодын аялал жуулчлал нь эрчимтэй хөгжиж байгаа ба цар тахлын дараа улам өргөжих төлөвтэй байна. Монголын дотоодын жуулчид ихэвчлэн аялал жуулчлалын агентлаг ашиглахгүйгээр өөрсдөө майхнаа авч аялдаг тул, орон нутгийн эдийн засагт оруулах хувь нэмэр нь тийм ч их биш юм. Гэвч өнөөг хүртэл аялж чадаагүй өөрийн орны алдартай дурсгалт газруудаар зочилж, соёл уламжлалтайгаа танилцаж буй нь маш их ач холбогдолтой. Дотоодын жуулчдын дийлэнх нь өөрсдөө аяллаа зохион байгуулдаг. Үүнд, аялал жуулчлалын агентлагууд ашиг багатай дотоодын жуулчдад зориулсан аяллын бүтээгдэхүүн бэлтгэж гаргадаггүй, мөн байгалийн цогцолборг газар, дархан цаазат газарт майхнаа барьж хоноглоход зохих ёсоор нь журамлаж зохицуулдаггүй, тухайн орон нутагт тав тухтай, сэтгэл амар буудаллах газар байдаггүй гэх мэт олон хүчин зүйл нөлөөлж байна. Дотоодын жуулчид орон нутгийн эдийн засагт орлого бага оруулдаг гэдгээс гадна, жуулчдын тоо хурдацтай нэмэгдэж байгаагаар холбогдуулан бие засах газрын асуудал болон байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн талаар ч санал гомдол ирж эхэлж байна. Нийтийн бие засах газар барих, отоглох цэг, майхан барьж хоноглох газрыг тогтоох зэрэг арга хэмжээг нэн даруй авч, гадаад дотоодын жуулчид тав тухтай, аюулгүй аялах боломжтой тогтолцоог бүрдүүлэхгүй бол Ковид-19 цар тахлын дараа аяллын зорих газарт сонгогдох өрсөлдөөнд ялагдах эрсдэлтэй юм.

3) Дэлхийн аялал жуулчлал сэргэх үе болон Монгол улс

Oxford Economics нь 2024 онд дэлхийн аялал жуулчлал 2019 оны түвшинд хүрч сэргэнэ гэж мэдээлсэн боловч энэ нь 2020 оны сүүлээр (Ковид-19 цар тахал тогтворжиж) дэлхийн аялал жуулчлал аажмаар сэргэж эхлэх, 2021 оноос бага багаар сэргэнэ гэж тооцоолсон үр дүн юм. Гэвч Ковид-19 цар тахлын нөхцөл байдал 2021 онд ч хүнд хэвээр байна. Ялангуяа Монголд 2021 оны эхэн үеэс халдвар авсан хүмүүсийн тоо хурдацтай нэмэгдсэн. Ийм нөхцөл байдлыг харгалзан үзвэл Монголын аялал жуулчлалын салбар сэргэх нь бусад орноос ч хожуу байх магадлал өндөр байна.

4) Монгол дахь “Дэлхийн аялал жуулчлал”-ын хэтийн төлөв

Харамсалтай нь 2021 оны 7-р сарын байдлаар Монгол улс Ковид -19 цар тахлын халдвар тархалтын түвшнээр дэлхийд нэг, хоёрдугаарт бичигдэж байна. Тиймээс хэдийгээр олон улсын шинэ нисэх буудал ашиглалтад орсон гэсэн сайн мэдээ байгаа ч цаашид яах нь Монгол улс халдварт өвчнийг дарж чадах эсэхээс хамаарч байна. Түүнчлэн Монгол улс дээрх ① - ③ т ямар арга хэмжээ авах нь цар тахлын дараах Монголын аялал жуулчлалын хөгжлийн түлхүүр болох юм. Нийслэл Улаанбаатар хотод ажил хэргийн аялал жуулчлал болох МІСЕ-ийг хөгжүүлэхээр зорьж байгаа боловч Ковид -19 цар тахлын нөлөөгөөр МІСЕ -ийн зохион байгуулах арга хэлбэр ч өөрчлөгдөж, онлайнаар зохиогддог болж байна. Олон улсын хамтын ажиллагаанд хувь нэмэр оруулах, зохион байгуулагч оронд эдийн засгийн үр ашигтай гэх

⁵⁸ Үндэсний Статистикийн Хороо 2019

мэтийн MICE -г зохион байгуулах ач холбогдол алдагдахад хүрээд байгаа юм.

Ковид -19 цар тахлын халдварын нөхцөл байдалд үндэслэн Монголын аялал жуулчлалын тав тух, аюулгүй байдал, хил гаалиар нэвтрэх талаарх мэдээлэл гэх мэтийг гадаадын аялал жуулчлалын агентлагуудад цаг алдалгүй түгээх хэрэгтэй байгаа юм. Тэрчлэн Монголын аялал жуулчлалын талаар төсөөлөл өгөх мэдээллийг цацах зэрэг ажлыг өрнүүлэх, хилийн орох гарах хориг тавигдсан үед аялал жуулчлалын агентлаг, агаарын тээврийн компаниудтай хамтарсан сурталчилгааг хийх, аялал жуулчлалын агентлаг, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах замаар гадаадын жуулчдын тоог нэмэгдүүлэх арга хэмжээ авах шаардлагатай байна.

9.4 Ковид -19 цар тахлын дараах үед чиглэсэн зөвлөмж

- 1) Ковид -19 цар тахлын дараах аялал жуулчлалын салбарыг сэргээх, аялал жуулчлалын салбарт ажиллагсдыг дэмжих тогтолцоог бүрдүүлэх

Аялал жуулчлалын салбар нь Монгол улсын ДНБ -ий 6 -аас дээш хувийг (2019 он) бүрдүүлж буй учраас Засгийн газраас тогтоосон эдийн засгийн гурван тулгуур болж хөгжих магадлал өндөр юм. Гэвч нөгөө талаасаа Ковид -19 цар тахал мэт нөхцөл байдал үүссэн тохиолдолд хамгийн ихээр эдийн засгийн хохирол амсах салбаруудын нэг юм. Ажилгүй болсон 80,000 гаруй хүн, үйлчлүүлэгчээ алдсан зочид буудлууд, сул зогсож байгаа хөтөч, хэлмэрч зэрэг хүмүүст төрөөс үзүүлж буй тусламж, дэмжлэг хангалтгүй байна хэмээн холбогдох хүмүүс үзэж байгаа аж. Энэ тухайгаа 2021 оны 2-р сард Ерөнхий сайдын санаачилгаар зохион байгуулагдсан аялал жуулчлалын уулзалтын үеэр тус салбарынхан илэрхийлсэн байна. Иймд, цаашид иймэрхүү ноцтой халдварт өвчин дахин давтагдана гэж үзвэл, татварын орлогын тодорхой хувийг аялал жуулчлалыг дэмжих, хамгаалах сан болгон хуримтлуулж, аялал жуулчлалын дэд бүтцийг сайжруулах болон онцгой нөхцөл байдлын үед аялал жуулчлалын салбарын эдийн засгийг аврах арга хэмжээнд ашиглах төсөв болгох нь зүйтэй юм. Сангийн үйл ажиллагааг шинээр байгуулахаар төлөвлөж буй Аялал жуулчлалын агентлаг хариуцан ажиллаж, хуримтлалын сангийн хөрөнгийн зарцуулалтыг зохицуулах нь зүйтэй. Засгийн газар нь бүхий л шатандаа хувийн хэвшлүүдтэй хамтран ажиллаж, ирээдүйд бэлтгэхийн зэрэгцээ, жуулчид, бизнес эрхлэгчид, аж ахуй нэгжүүдийн итгэлийг сэргээх, эрэлтийг өдөөх, аялал жуулчлалын салбарыг сэргээн босгохын тулд аялал жуулчлалыг сэргээх стратеги боловсруулах шаардлагатай байгаа болно.⁵⁹ Өөрөөр хэлбэл Засгийн газрын гүйцэтгэх үүрэг маш чухал юм.

- 2) Ковид -19 цар тахлын дараах зах зээлийн стратегийг боловсруулах

Монгол улс нь, өвлийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн хөгжүүлэхэд хүндрэлтэй цаг уурын нөхцөлтэй. Түүнчлэн 2020 онд Монголд ирсэн гадаадын жуулчдын тоо өмнөх оныхоос 90 гаруй хувиар буурсан, Ковид -19 цар тахлын халдварын түвшин 2021 онд дэлхийд хамгийн өндөр түвшинд хүрсэн зэрэг Ковид -19 цар тахлын нөлөөнд хамгийн ихээр өртсөн орнуудын нэг болж байна. ЭЗХАХБ болон Дэлхийн аялал жуулчлалын байгууллага нь цаашид вакцинжуулалтаар Ковид -19 цар тахлын тархалтыг хумих боломжтой гэж үзвэл, дэлхийн жуулчдын тоо 2019 оны хэмжээнд эргэж сэргэхэд дөрвөн жил орчим хугацаа шаардагдана гэж үзэж байна. Гэвч аялал жуулчлалын салбарын өнөөгийн нөхцөл байдал харьцангуй хүнд байдалд байгаа Монгол улсад аялал жуулчлалыг сэргээхэд илүү их цаг хугацаа шаардагдах төлөвтэй байна. Ковид -19 цар тахлын нөлөөгөөр цаашид хүмүүсийн аялал жуулчлалд хандах хандлага эрс өөрчлөгдөх төлөвтэй байгаа тул Монгол улсын хувьд, дотоод гадаадын зах зээлд чиглэсэн маркетингийн арга барил, жуулчдын шинэ хэрэгцээг хангах арга хэрэгсэлдээ сайтар дүн шинжилгээ хийж, төр болон хувийн хэвшил хүчээ нэгтгэн хамтран ажиллах замаар шинэ үед нийцсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх шаардлага үүсэж байна. Гадаадын жуулчдын сонирхол, хэрэгцээ, онцлогийн талаар Монгол Банк, Монголын Аялал Жуулчлалын Хөгжлийн Төвөөс хийсэн судалгаа болон мэргэжилтнүүдийн хийсэн судалгааны тайлан байдаг. Эдгээрт үндэслэн цар тахлын дараах шинэ үеийн Монголын аялал жуулчлал ямар байх ёстойг тодруулах шаардлагатай. Жуулчдын амар амгалан, аюулгүй байдлыг хангах (хүрээлэн буй орчныг сайжруулах, мэдээлэл түгээх), аялал жуулчлалын салбарын дижиталчлалыг түргэтгэх асуудлыг нэн тэргүүнд шийдвэрлэх ёстой мэт санагдана.

- 3) Хөгжлийн бодлогыг тооноос чанар руу хандуулах

⁵⁹ OECD Policy Responses to Coronavirus(COVID-19) Rebuilding tourism for the future, Dec.14,2020

Гадаадаас ирэх жуулчдын тоо цөөрнө гэдэг нь аялал жуулчлалын орлого буурна гэсэн үг боловч Монгол улсын хувьд хөгжөөгүй байгаа салбарыг шинээр хөгжүүлэх замаар аялал жуулчлалын салбарын ашгийг нэмэгдүүлэх боломжтой. Жишээлбэл, (1) Бэлэг дурсгалын бүтээгдэхүүнийг хөгжүүлэх. Төлөвлөхгүйгээр олон бүтээгдэхүүн үйлдвэрлэж, дэлгүүрт өрж тавьсан ч борлогдохгүй. Сайн борлогдох бүтээгдэхүүн яаралтай хөгжүүлэх шаардлагатай. (2) Тусгай сонирхолтой хүмүүсийг зорилтот зах зээл болгосон аялал жуулчлалыг хөгжүүлэх нь чухал. Жишээлбэл, Япон хүмүүсийн санаачилгаар эхэлсэн хээр тал дахь марафонд оролцох, өргөн уудам хээр талд агаарын бөмбөлгөөр нисэж үзэх гэх мэт хөтөлбөртэй аяллыг төлөвлөх, мөн түүнчлэн үлэг гүрвэл, уулын ургамал, цэцэг, зэрлэг ховор ан амьтад, эрвээхэй, загасчлал, буддын шашин гэх мэт тодорхой сэдэвт чиглэсэн аяллын төлөвлөгөөг гадаадын аялал жуулчлалын агентлагтай хамтран хөгжүүлэх боломжтой юм. Японд загасчлах дуртай хүмүүс олон байдаг ч Монголд тул загас барьж болохыг мэддэг хүн цөөхөн. Мэдээллийг хангалттай түгээх маш чухал юм. (3) Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр илүү идэвхтэй ажиллах ёстой. Жишээлбэл, дэлхийд хамгийн урт байгалийн тэшүүрийн талбай байгуулах гэх мэт анхаарал татах сэдэвтэй аялал жуулчлалын бүтээгдэхүүн хөгжүүлэх нь зохистой юм.



Талын марафон



Агаарын бөмбөлгөөр нисэх



Загасчлал (тул загас)



аялал

Уулын ургамал, цэцэг ажиглах

9.5 “Монгол дахь Дэлхийн бөмбөрцөгийн ирээдүйн төлөө хүүхдүүдийн чуулга уулзалт” санаачилга

~ Монгол улсыг дэлхийн хүүхдүүдийн найрсаг харилцаа, солилцооны төв болгох нь ~

Даяаршил нь дэлхий дахинд хүн болон эд бараа, мөнгө, техник технологи, мэдээллийн чөлөөт урсгал бүхий Дэлхийн Их Солилцооны эринг бий болгосон. Өөрөөр хэлбэл дэлхий ертөнц улам жижигхэн болж, хүмүүс бие биетэйгээ улам ойр харилцах боломжтой болсон.

Технологийн хөгжил дэвшлийн ачаар хүмүүсийн амьдралын хэв маяг өөрчлөгдөж, дундаж наслалт нэмэгдэж байна. Мөн ард иргэдийн амьдралын амар хялбар тав тухтай байдал сайжирч, үр бүтээмж дээшлэн, хүн хоорондын харилцах арга, ажиллах хэв маяг ч ихээхэн хөгжин өөрчлөгдөөд байна.

Нөгөөтэйгүүр дэлхий дахинд уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны сүйрэл, агаарын бохирдол, үйлдвэрийн хог хаягдал, хүн амын огцом өсөлт, хоол хүнс, байгалийн нөөц баялагийн хомсдол, баян ядуугийн ялгаа зэрэг дэлхий бөмбөрцөгийг хамгаалахад шийдвэрлэх ёстой маш олон асуудал тулгараад байна.

Ковид-19 цар тахал нь дэлхийн улс орнууд нэгдэн нийлж хамтдаа тэмцэхгүй бол шийдвэрлэх боломжгүй гэдгийг бидэнд тод томруунаар мэдрүүллээ. Мөн Дэлхийн бөмбөрцөг болон амьд организмын гарал үүсэл, Мянгань Хөгжлийн Зорилгууд зэрэг суурь үндэснээс шийдвэрлэх ёстой асуудлын талаар бидэнд нэгийг бодогдуулсан. Ковид-19 цар тахлын дараах эрин үед бид эх дэлхийд хамтдаа оршин амьдарч явахыг ухамсарлан ойлгох болж байгаа мэт санагдана.

Доор заасны дагуу 2022 онд Монгол улс Япон улс хоорондын дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойд тохиолдуулан Монгол, Япон хамтарч Монгол улсыг “Дэлхийн хүүхдүүдийн найрсаг харилцаа, солилцооны төв болгоё” гэсэн санаачилга юм. “Хүүхэд, Дэлхийн бөмбөрцөг, Ирээдүй” гэсэн концепцийн дагуу Ковид-19 цар тахлын дараах эрин үед эрэгцүүлэн бодох нэгэн санал болгож дэвшүүлнэ.

(1) Ирээдүйг авч явж үргэлжлүүлэх хүүхдүүдийн төлөө

Дэлхий дээрх бүхий л улс орон, хүмүүс хамтдаа хүчээ нэгтгэхгүй бол шийдвэрлэх боломжгүй асуудлуудын үр нөлөөг ирээдүйг авч явах хүүхдүүд хамгийн ихээр амсах болно.

Дэлхий дахины хүүхдүүд маань Ковид-19-ийн дараах эрин үед хэрхэн амьд явах ёстой вэ?

Сурагчдын аялал зэрэг арга хэмжээгээр хүүхдүүд Монголд цугларч, бүгдээрээ бодож ярилцах тавцанг бий болгох нь “Монгол дахь Дэлхийн бөмбөрцөгийн ирээдүйн төлөө хүүхдүүдийн чуулга уулзалт” санаачилга юм.

Олон янзын соёл, улс орны онцлог нөхцөл бүхий хүүхдүүд өөр хоорондын үзэл бодол, үнэт зүйлсийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, харилцан бие биенээ хүндэтгэн, харилцаа, хамтын ажиллагаагаа хөгжүүлж чадваас түүний үр дүнд шинэ соёл бий болж, улмаар хүүхдүүдийн ирээдүй болон дэлхийн энх тайванд хувь нэмэр оруулна гэж найдаж байна.

Хүүхдүүдийн хувьд гадаадад аялах нь тухайн орны байгаль, соёл, амьдралын хэв маяг, зан заншил зэргийг сурч мэдэх, улс орнуудын ялгаа, хүмүүс хоорондын учрал, шүтэн барилдлага гэх мэт олон шинэ нээлтэй учрах гайхалтай сайхан боломж болно. Ийм туршлагаар дамжуулан өөрийгөө болон эх орон, олон янзын үндэстэн угсаатан, эх дэлхийн талаарх ойлголт танин мэдэхүйг шинэчлэх завшаан болох нь дамжиггүй.

(2) Дэлхийн бөмбөрцөгийн "өнгөрсөн", "одоо", "ирээдүй"-г Монголд мэдрэх

Аугаа их байгалийн үзэсгэлэнт орон болох Монголын зах нь үл харагдах тэнгэрийн хаяа, өргөн уудам тал нутгийн дунд, хязгааргүй үргэлжлэх одот тэнгэрийн дор хүүхдүүд маань байгалийн гайхамшигт үзэмжийг мэдрэнгээ, дэлхийн гарал үүслийн тухай бодолцон эрэлхийлэн "Хүн төрөлхтөн бид хаанаас ирж, хаашаа явж байна вэ?" гэдэг тухай өөр хоорондоо ярилцах нь хүүхдүүдэд хүн төрөлхтөн, дэлхий бөмбөрцөг, эх байгаль, хүрээлэн буй орчинтой холбоотой олон янзын асуудлын талаарх мэдлэг ухамсраа дээшлүүлэх үнэ цэнэтэй туршлага болох бөгөөд цаашлаад "дэлхийн ирээдүй"-д анхаарлаа хандуулах, сонирхоход хөглөх болно.

Азийн төвд, далайн түвшингээс дээш 1500 метрийн өндөрлөг газар орших Монгол бол олон гол нуур бүхий уулархаг бүс, говь цөл, уудам тэгш тал нутаг зэрэг тус бүр өөрийн онцлог үзэмж бүхий байгалийн баялагтай орон юм. Жилийн дөрвөн улирлаас хамаарсан халуун хүйтний ялгаа ихтэй, эх газрын эрс тэс уур амьсгал нь ч сонирхол татахуйц байдаг. Түүнчлэн Монгол бол үлэг гүрвэлийн олдвороор дэлхийд тэргүүлэгч орнуудын нэг бөгөөд ховор сонин амьтад ч олноор амьдардаг, онгон дагшин байгальтай, агуй гайхамшигт орон юм. Хүүхдүүдийн төсөөлөн бодох, сэтгэх чадварыг хөглөх нь гарцаагүй.

Монголчууд эрт дээр үеэс нүүдлийн мал аж ахуй эрхэлж ирсэн бөгөөд уламжлалт амьдралын хэв маяг одоо цагт зарим талаар хувьсан өөрчлөгдсөн боловч, урьдын адил байгалийн ивээлийг хүртэж, байгаль эхээ дээдлэн хүндэлж, дөрвөн улирлын өөрчлөлтөд дасан зохицож амьдарсаар ирсэн. Үүнийг үзэж мэдрэх нь хүүхдүүдийн цаашдын амьдралд юугаар ч орлуулашгүй нандин зүйл болох нь тодорхой.

Монгол бол хүүхдүүд хамтдаа цуглан эх дэлхий, хүн төрөлхтний өнгөрсөн ба одоо үеийг мэдэрч, ирээдүйн тухай эргэцүүлэн бодоход хамгийн тохиромжтой газар юм. Дэлхийн "өнгөрсөн", "одоо", "ирээдүй" -г мэдрэх боломжтой газар бол яахын аргагүй Монгол юм.

Монголд аялсан хүүхдүүд Японд буцаж ирснийхээ дараа эцэг эх, гэр бүл, найз нөхөд, нутгийн хүмүүст Монголд тохиолдсон сонин сайхан туршлагаа ярьж хуваалцах болно. Монголын гайхамшигт байгалийн

өөрийн биеэр мэдэрч үзсэн хүүхдүүд дахин зочлохыг хүсэх нь дамжиггүй. Мөн насанд хүрсэн хойноо ч дахин Монгол руу аялах, монголтой холбоотой байхыг хүсэх болно. Монголд тийм их увидас бий.

(3) Монголд Хүүхдийн “Эх Дэлхий Хүүхдийн Хотхон”-ыг байгуулах хөтөлбөр

2022 онд Япон улс Монгол улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойг тохиолдуулан “Монгол дахь Дэлхийн бөмбөрцөгийн ирээдүйн төлөө хүүхдүүдийн чуулга уулзалт” санаачилгын хүрээнд Япон Монголын хамтарсан “Эх Дэлхий Хүүхдийн Хотхон” -ыг байгуулах хөтөлбөрийг санал болгож байна. Ялангуяа Япон, Монгол хоёр улсын Засгийн газраас 2022 оныг “Хүүхэд залуучуудын найрамдал, солилцооны жил” болгон тогтоож, дурсгалт үйл ажиллагаа хэрэгжүүлж эжлүүлнэ.

Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд Япон, Монголын Засгийн газар, парламентийн зүгээс идэвхтэй хамтран ажиллах хүсэлт гаргана.

Үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг дор дурдав.

① “Эх Дэлхий Хүүхдийн Хотхон” байгуулах төлөвлөгөө

1) “Эх Дэлхий Хүүхдийн Хотхон”-ы ой (цэцэрлэгт хүрээлэн)

Дэлхийн хүүхдүүд мод тарьж цэцэрлэгт хүрээлэн байгуулах хөдөлгөөн,

2) Байгаль дунд дэлхийн хүүхдүүд цуглан нөхөрлөж хамтдаа цагийг өнгөрөөх байгууламжийг байгуулах (Үлэг гүрвэлийн музей, отоглох кемп, буудаллах байр, сургалтын төв, спорт болон соёлын ордон гэх мэт)

② “Монгол дахь Дэлхийн бөмбөрцөгийн ирээдүйн төлөө хүүхдүүдийн чуулга уулзалт”-ыг зохион байгуулах

1) Дэлхийн бөмбөрцөгийн ирээдүйн төлөө хүүхдүүдийн бага хурал зохион байгуулах

2) “Дэлхийн бөмбөрцөгийн ирээдүйн төлөө хүүхдүүдийн чуулга уулзалт”-ыг зохион байгуулах (Спорт, соёл, урлаг, дуу хөгжим, мэдээллийн технологи, робот, бүтээл бүтээх зэрэг салбар бүрийн уралдаан тэмцээн, солилцооны арга хэмжээ)

③ Олон улсын сурагчдын аяллыг хөгжүүлэх

1) Дэлхийн улс орнуудаас сургуулийн шугамаар танилцах аялалаар ирэх сурагчдыг хүлээн авч Монгол оронтой танилцах, монгол хүүхдүүдтэй танилцаж нөхөрлөх арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлэх,

2) “Эх Дэлхий Хүүхдийн Хотхон”-ы ой байгуулах аян (мод тарих) болон “Дэлхийн бөмбөрцөгийн ирээдүйн төлөө хүүхдүүдийн чуулга уулзалт”-тай уялдуулах,

3) Монгол хүүхдүүдийг олон улсын сурагчдын аяллын солилцооны арга хэмжээнд оролцуулах тогтолцоог бий болгох,

4) Япон улс Монгол улс хоорондын дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ой тохиох 2022 онд хоёр улсын эгч дүүс хотуудыг түшиглэн, Японы орон нутгийг хөгжүүлэх ажлын хүрээнд “Япон, Монголын хүүхэд залуучуудын найрамдал, солилцооны жил”-ийн арга хэмжээг хэрэгжүүлнэ.

10-р бүлэг

Монголын аялал жуулчлалын семинарын
агуулга

10-р бүлэг Монголын аялал жуулчлалын семинарын агуулга

Энэхүү судалгааны үр дүнд үндэслэн Монголын аялал жуулчлалын семинарыг дараах агуулгаар зохион байгуулсан. Үүнд:

Төв	2021 оны 9-р сарын 9 (Пүрэв) 14:00~15:00 (япон цагаар)
Зохион байгуулсан хэлбэр	Цахимаар
Ашигласан программ	Zoom вебинар
Газар	Эй-Пи Шинагава анекс “Q” танхим (Токио хотын Минаго дүүргийн Таканава 3-23-17 Шинагава центр билдинг 1F • B1F)
Бүртгүүлэгчийн тоо	107 хүн (Харьяалал: АЖ-ын компани, Японы орон нутгийн засаг захиргаа, Монголд суугаа Японы аж ахуйн нэгжийн төлөөлөл болон бусад)
Оролцогчийн тоо	94 хүн
Семинарын Зорилго	Судалгааны зорилгот бүс дахь аялал жуулчлалын сурталчилгаанд хувь нэмэр оруулах
Хөтөлбөр	14:00 Нээлийн үг ЖАЙКА-ийн Зүүн болон Төв Азийн газрын дарга Тайжи Назазато 14:05 Үндсэн илтгэл (асуулт хариулт 10 минут) “Монгол улсын аялал жуулчлалын тогтвортой хөгжлийн талаарх бодиг мэдээ мэдээлэл, тоо баримтыг цуллуулж, нөхцөл байдлыг нэгтгэн дүгнэх судалгаа”-ны багийн ахлагч, Монгол Улсад суугаа Япон Улсын онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд асан Такэнори Шимизү 14:55 Хаалтын үг ЖАЙКА-ийн Зүүн болон Төв Азийн газрын Зүүн Азийн хэлтсийн дарга Ёшиито Якю 15:00 Семинар өндөрлөх
Илтгэлийн агуулга	1. Монгол улсын байршил, ерөнхий танилцуулга 2. Монгол Японы харилцааны өнөөгийн байдал, харилцан зорчигчийн байдал 3. Монгол руу аялах аяллын онцлог, давуу тал, судалгааны зорилгот бүс дахь гол аялал жуулчлалын цэгүүд (1) Нийслэл УБ ба түүний ойр орчмын бүс нутаг (2) Хархорин хот орчим (3) Өмнөговийн бүс (4) Дорноговийн бүс 4. Судалгааны зорилгот бүсийн аялал жуулчлалын планыг санал болгох 5. Тусгай сонирхолт аяллын талаар 6. Монголын аялал жуулчлалын агент компаниуд, тусгай сонирхолт аялалаар дагнасан компани
Семинарын тухай зар мэдээлэл хүргэсэн аргачлал	• Японы Аялал Жуулчлалын Холбоо (JATA) -н гишүүн компаниуд • АЖ-ын мэдээлэл цацдаг “Трэйвэл Вишн” цахим хуудас • Тус судалгаанд хамрагдсан орон нутгийн засаг захиргааны байгууллагууд • Монгол дахь ХАУТ-р дамжуулан Монгол дахь Японы аж ахуйн нэгжүүдэд тус тус зар мэдээ хүргэсэн.


Семинарын дараа семинарт оролцогчдоос дараах сэтгэгдлийг хүлээж авсан (түүвэрлэн оруулав).

- Маш сонирхолтой семинар байлаа. Аялал жуулчлалын нөөц баялагтай цэг хүртэл очиход хялбар болбол Монголд илүү олон жуулчид ирэх боломжтой юм шиг санагдсан. Японоос Монголд ирэх нь урьдынхаас хамаагүй амар болсон гэж би боддог.
- Цаашид жуулчдын тоог нэмэгдүүлэхийн тулд олон агаарын тээврийн компаниуд нислэг үйлддэг болгож, зардлаа бууруулахыг хүсч байна.
- Монгол улсыг хайрлах сэтгэл шингэсэн, сонсоход таатай, аядуу зөөлөн ярианд нь татагдаж, Монголын тухай үзэл

бодол, сэтгэгдэл, сонирхол маань эрс өөрчлөгдсөн семинар байлаа. Гайхамшигтай семинар зохион байгуулсанд баярлалаа. Дараагийн удаа дахин зохиогдвол заамал оролцохыг хүсч байна.

- Би аяллын мэдээллийн веб сайтад Монголыг хариуцахаар шинээр томилогдсон бөгөөд маш олон үнэ цэнэтэй зүйлийг сурч мэдэж авлаа. Өргөн уудам байгальтай танилцах боломжтой Монгол улс нь аялалаар зорих газрын хувьд маш сэтгэл тагам сайхан санагдсан. Хөдөө орон нутаг руу явах зам нь амаргүй юм шиг санагдсан ч, тэр нь ч бас өөрөө дурсамжтай аялал юмуу гэж бодсон.
- ЖАЙКА -ийн судалгааны үр дүнгийн талаар илүү их мэдээлэл сонсохыг хүсч байлаа.
- Автомашинаас өөр тээврийн хэрэгсэлгүй бол зам нь хагуу хучилттай байлаа ч гэсэн 5 цаг явна гэвэл хэцүү байх да гэж санагдсан. Замдаа үзэх харах юмтай, тэндээ амарч завсарлаад явж болдог болвол зүгээр байхаа.
- Семинараар дамжуулан Монголын аялал жуулчлалын талаар арай өөр өнцгөөс олж харж чадсан бөгөөд семинарын агуулга маш сонирхолтой, үнэ цэнэтэй хичээл байв. Эндээс сурсан мэдсэнээ хойшдын Монгол улстай хийх харилцаа холбооны ажилдаа жишээ аван ашиглах болно.

<Цахимаар мэдээлэл цацсан танхим>



▲ Семинарын самбар



▲ Багийн ахлагчийн илтгэл



▲ Нээлтийн үг



▲ Цахим семинарын бэлтгэл ①



▲ Цахим семинарын бэлтгэл ②



▲ Хаалтын үг